

**Б.Цоожчулуунцэцэг**

**ТҮҮХ БҮТЭЭСЭН 90 ЖИЛ-  
ТӨМӨРБУЛАГ СУМ**

**2015 он**

## Зохиогчийн үг

Энэхүү номоо “Түүх бүтээсэн 90 жил” хэмээн нэрлэсэн нь учиртай. Учир нь хэн нэгэн хүн түүхийг зохиодоггүй. Харин ард түмэн өөрсдийнхөө амьдрал тэмцлээр, алдаа оноогоор, баяр жаргал, гуниг зовлонгоор түүхийг бүтээж байдаг. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын зуун зуун дамнасан түүхийг Төмөрбулагчууд өөрсдийнхөө амьдрал тэмцлээр бүтээсэн учраас номоо би зоригтойгоор “Түүх бүтээсэн 90 жил” хэмээн нэрлэсэн хэрэг.

Харамсалтай нь Төмөрбулагчуудын олон зууны тэртээх ахуй амьдрал, соёл зан заншил ололт амжилтыг нарийн судлаж, дэлгэрэнгүй бичиж үлдээсэн түүхийн эх материал мэдээ сурвалж бидний үед хадгалагдаж үлдсэнгүй. Тэр ч бүү хэл сүүлийн 90 жилийн түүх ч тун бүрхэг байна. Түүхийг бүтээсэн ахмадууд он цагийн эрхээр цөөрч, архивт хадгалагдаж байсан бичиг баримтууд устаж алга болжээ.

Өнгөрсөн 90 жилийн хугацаанд Төмөрбулаг сумын түүх, иргэдийн ахуй амьдралын талаар өгүүлсэн дэлгэрэнгүй түүхийн ном хэвлэгдэж байгаагүй бөгөөд тус сумын 80 жилийн ойгоор хэвлэгдсэн зохиолч Жүгдэрнамжилын Үржгэрийн “Бүтээлч үйл, баатарлаг үйлстэн хэзээ ч мартагдахгүй” хэмээх түүхийн хураангуй ном, Чулууны Жаргалсайханы “Миний нутгийн бахархал Төмөрбулаг түүхэн цомогоос...” ном өнөөдөр бидэнд үлдсэн хамгийн том баримт, материал болон хадгалагдаж байна. Тиймээс энэхүү номыг бүтээхийн тулд Төмөрбулаг суманд өдгөө ажиллаж амьдарч байгаа 20 гаруй хүнийг номын зөвлөл болгон нэгтгэж, салбар бүрээс мэдээ материал цуглуулж, өнгөрсөн 90 жилийн түүхийг нэгэн номын хуудсанд багтаах гэж чадан ядан хичээлээ.

Гэхдээ энэхүү номонд нэр нь ороогүй, баатарлаг үйлс, гавьяа зүтгэл нь дурьдагдаагүй олон хүн үлдэж хоцорсон байх вий гэсэн болгоомжлол ном бүтээгчдийн санааг чилээсээр байгаа гэдгийг дурьдаж, эрхэм уншигч танаас юун түүрүүнд хүлцэл өчье. Бидний өмнө Төмөрбулаг сум байгуулагдсны 90 жил харин ард маань зуу, зуунаар тоологдох он цаг хүлээж байна. Тиймээс энэхүү номонд нэр нь дурьдагдаагүй үлдсэн хүмүүсийн тухай мэдээ материалыг бидэнд ирүүлэхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Басхүү Төмөрбулагчуудын түүхийн ном бүтээх санал санаачлага гаргасан тус сумын ИТХ, Засаг даргын тамгын газар, Засаг дарга Бат-Очирын Ганзоригт гүн талархал илэрхийлье.

Баянмөнхийн Цоожчулуунцэцэг

## Эмхтгэсэн Б.Цоожчулуунцэцэг

### Номын зөвлөл

-Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганзориг-Сумын засаг дарга  
Нарийн бичгийн дарга П.Оюунчимэг-Сургуулийн захирал

### Гишүүд

Ш.Наранхүү-1-р багийн Засаг дарга  
Н.Бямбачулуун-2-р багийн Засаг дарга  
Л.Батсайхан-4-р багийн Засаг дарга  
Д.Одбаяр-4-р багийн Засаг дарга  
Т.Эрдэнэбат-5-р багийн Засаг дарга  
Ц.Бямбадорж-ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга  
Г.Нямханд-ЗДТГ-ын дарга  
А.Амаржаргал-Цэцэрлэгийн эрхлэгч  
Ч.ЦэцэгмааЭрүүл мэндийн төвийн дарга  
Б.Шүрэнцэцэг-Сочлын төвийн эрхлэгч  
Д.Түмэндэмбэрэл-Ахмадын хорооны дарга  
Б.Энхжаргал-Соёлын төвийн хөгжмийн багш  
Т.Тэрбиш-МЭҮТ-ийн дарга  
Л.Амарбат-Архивын эрхлэгч  
Улаанбаатар хотын нутгийн зөвлөл  
Орхон аймгийн нутгийн зөвлөл  
Дархан-Уул аймгийн нутгийн зөвлөл  
Мөрөн сумын нутгийн зөвлөл

Мэндчилгээ  
УИХ-ын гишүүд

Нутгийн зөвлөл



Өнөөдөр Төмөрбулаг суманд маань тоонот гэрийнхээ өрхийг татаж, төрдөө бүл нэмсэн 1204 өрхийн 4316 иргэн ажиллаж амьдарч байна. Тэдний дунд тохойг нь өргөн золгох 270 гаруй ахмад настан амьдарч, бидний ирээдүй хойч үе болсон 1538 хүүхэд сурч боловсорч, өсч торниж байна. Мал сүргийн маань тоо энэ жил 219,901 толгойд хүрч, ноолуурын чанараараа Монголд төдийгүй дэлхийд гайхагдаж байгаа “Эрчмийн хар ямаа” шилмэл сүргийн цөм Төмөрбулаг сумын иргэдэд өгөөж буянаа харамгүй өгч, нутгийн зон олон ашиг шимт малынхаа буянаас жилд дөрөв орчим тэрбум төгрөг хүртэж байна. Манай сумын хөдөлмөрч олон ажил үйлсээрээ сүүлийн хоёр жил дараалан аймагтаа тэргүүн эгнээнд бичигдэж байгаа билээ.

Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу, хожмоо Цэцэрлэгмандал уулын аймгийн Наранжаргалант уулын хошуунаас тасарч, Төмөрбулаг сум тулгаа тулан бууриа зассанаас хойш өдгөө түүхт 90 жилийнхээ ойтой золгож байна.

Бид сумынхаа хөгжил цэцэглэлт, үр хүүхдийнхээ сайн сайхан амьдрах ирээдүйн төлөө хамтын хүчээр их бүтээн байгуулалтыг бий болгон, эрх үүргээ ухамсарлан иргэн бүрийн оролцоог нэн тэргүүнд чухалчилж ирээдүйгээ сайн сайхан гэгээлгээр төсөөлж хөгжилд хүрэх чиг хандлага боломжоо тодорхойлж, зорилго тэмүүлэлтэй ажилласнаар үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Өвөг дээдсээс уламжлан үлдээсэн түүх соёл, үе үеийн эрдэмтэн мэргэд хүчит бөхчүүд уяачид, малчид хөдөлмөрийн сайчуудаараа бахархан үйлс замналыг нь үр хойчдоо хэлж ярих бичиж тэмдэглэн үлдээх нь нэн чухал байна.

Нутгийн уугуул суугуул иргэд малчид хөдөлмөрчин ард түмэндээ эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөе.

*Сайн үйлс дэлгэрэх болтугай.*

**ЗАСАГ ДАРГА**

**БАТ-ОЧИРЫН ГАНЗОРИГ**

# ᠶ



Тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн болон холбогдох бусад хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд орон нутгийн хөгжлийн бодлого чиглэлийг 4 жилээр тодорхойлсон ИТХ-ын үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг боловсруулан батлуулж, түүнийг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулж, шинэчлэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлагдсан орон нутагт хэрэгжүүлэх бодлого,

чиглэлүүдтэй болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, холбогдох бусад дээд шатны байгууллагаас гаргасан бодлого шийдвэрүүдтэй уялдуулан хэрэгжүүлж, нутгийн захиргааны болон бусад байгууллагуудтай харилцан холбоотой хамтран ажиллаж байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутаг, иргэд сонгогчдын эрх ашиг, сонирхлыг дээдлэн тэдний өмнө тулгамдаж буй нэн даруй шийдвэрлэх шаардлага бүхий ажил, асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, иргэдэд төрийн ажил үйлчилгээг шуурхай чанартай хүргэж ажиллах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, зохион байгуулан, иргэд сонгогчид, хурлын төлөөлөгчдийн гаргасан саналуудыг дэмжин, иргэдийн нийгмийн оролцоог сайжруулах замаар сум орон нутагт хүний хөгжлийг ханган, нутаг орноо хөгжүүлэх бодлого зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. 2012-2016 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаа нь улс эх орны хувьд өөрчлөлт, шинэчлэлт бүтээн байгуулалтыг авчирсан, орон нутагт төсөв санхүүгийн эрх мэдлийг нэмдэгдүүлж, “Том төрөөс ухаалаг төр рүү” бодлогыг эхлүүлсэн, шууд ардчиллын зарчмыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоог дээшлүүлсэн, төрийн албаны шинэчлэлтийг хэрэгжүүлсэн онцлог жилүүд болж байна.

Сум орон нутгийн хувьд анх удаа “Сумын хөгжлийн төлөвлөгөө”-г иргэдийнхээ оролцоотой боловсруулж батлууллаа. Мөн сум байгуулагдсаны 90 жилийн ойгоо хөгжил, дэвшил, амжилт бүтээлээр дүүрэн тэмдэглэж буй түүхэн үйл явдал энэ бүрэн эрхийн хугацаанд тохиож байна. Сайн үйлс дэлгэрэх болтугай.

**СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫНДАРГА Г.БЯМБАСҮРЭН**

## ЭХЛЭЛ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Төр, үр хоёр минь мөнх оршиг

*Хотогойдын Шадар ван Чингүнжав.*

# ХОТОГОЙДУУДЫН ТҮҮХ СУДЛАЛ



Монгол орон нь эртнээс нааш хүн төрөлхтөн амьдран сууж, төр улсаа байгуулж, дэлхийн соёл иргэншилд өөрийн хувь нэмрийг оруулж ирсэн нүүдэлчин ард түмний өлгий билээ. Тэр ч утгаар манай газар нутаг дээр балар эртний хүмүүсийн ул мөр, анхны төрт улсуудын соёлын улбаа болсон хэдэн мянгаар тоологдох дурсгал хадгалагдаж байна.


1970 оноос эхлэн монголын бараг бүх аймгийн нутгаар хайгуул судалгаа эрчимтэй явуулж чулуун зэвсгийн болоод хүрэл, төмөр зэвсгийн түрүү үе, Хүннү гүрэн, Түрэгийн хаант улс, Уйгар, Кидан, Монгол гүрний түүхэнд холбогдох бууц суурин, булш бунхан, буган хөшөө, хүн чулуун хөшөө, гэрэлт хөшөө, хадны зураг, эртний бичээс зэрэг олон мянган дурсгалыг илрүүлэн олж шинжлэн судалж ирсэн ч Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд археологийн нарийн судлагаа өнөөдрийг хүртэл хийгдээгүй байна. Гэхдээ энэ л газар анхны хүй нэгдлийн байгууллын үеийн хүмүүсийн амьдарч байсан оромж байх магадлалтай хүрэнгэж харалсан агуй, цонж хадны ёроол зэрэг ул мөр тус сумын нутаг Шивэрт, Агтын гол, Хөх эрэг, Бүгсийн ам зэрэг газарт дайралдах ба газар тариалан эрхэлж байсан бололтой ор мөр, суваг шуудуу Бүгсийн гол, Тариат, Бүгдгээний сав нутагт хадгалагдан үлджээ.

Нутгийнхан “Тэнгэрийн сум” гэж нэрлэх хүрэл зэвсгийн үеийн холбогдолтой элдэв хэлбэрийн эд зүйлс ч олдоно. Хэдийгээр Төмөрбулаг сумын нутагт эртний судлал, түүх угсаатны зүй, хүн судлалын талаар зориудын төвлөрсөн судалгаа хийгдэж, шинжилгээ, дүгнэлт гараагүй боловч Бүгсийн гол, Тээлийн хойд эх, Зуна гол, Дөш, Агт, Тэлээ, Нарийний ам, Бүгдгээнд одоогоос 1500-2300- гаад жилийн өмнөх Уйгур, Түрэгийн хаант улсын үеийн шинж тэмдэгтэй элдэв бичигт хад, чулуун хөшөө, хадны сүг зураг, хиргисүүр, булш бунхан элбэг тохиолдоно.

Төмөрбулаг сумын нутагт эртний Монгол овог, аймаг оршин тогтнож, аж төрөн амьдрахын зэрэгцээ, дайтаж тулалдаж байсныг Зуна голын хавьд буй 190 см өндөр буган хөшөө, Жаргалант, Цагааны сийлбэртэй хад, голын эх, уулын хормойд байрлах элдэв хэлбэрийн хиргисүүр, хөшөө чулуу, Хүннүгийн үеийн бололтой булшнууд, улар бууц зэрэг нь гэрчилнэ. Харамсалтай нь тус сумын нутаг дээр байх хиргисүүр, чулуун хөшөө, буган хөшөө, хадны сүг зураг булш бунханг өнөөдрийг хүртэл нарийн судлаж үзээгүй байна.

Ойролцоогоор II мянган жилийн тэртээ зэсийг хорголжин тугалгатай холин хайлж, хүрэл гэдэг нийлэг төмөрлөгийг гарган авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр эхлэж байсан хүрэл зэвсгийн үеийн гол дурсгал болсон дөрвөлжин булш, хиргисүүр, буган хөшөө тус сумын нутагт элбэг байдаг. Хөвсгөлийн нутаг нь 13-р зууны үед Монголын эзэнт гүрний улсын хувь эзэмшилд, 14, 15 зуунд өрнөд халхад 16-р зууны үед Батмөнх даян хааны отгон хүү Гэрсэнз жалайр хун тайжид харьяалагдаж байжээ.

Өнөө үеийн Монгол угсаатныг бүрдүүлж буй олон угсаатны бүлгүүдийн томоохон төлөөлөгч бол Хотогойдууд. Төмөрбулаг сумын нийт иргэдийн 80 орчим хувийг хотогойд ястнууд бүрдүүлдэг гэсэн албан бус судлагаа бий. Мөн тус сумын нутаг дэвсгэрийн тухай бичихийн тулд хотогойдуудын түүхийг сөхөхгүй байхын аргагүй юм. Түүхийн шар хуудсанд өөрийн гэсэн нэрээ үлдээсэн Хотогойдуудын тухай эртний түүх сурвалж бичигт ч мөн тод дурьдсан байдаг. “Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж”, “Хаадын үндэсний хураангуй Алтан товч”, Саган сэцэний ‘Эрдэнийн товч’, Жамбын “Асрагч нэртийн түүх” зэрэг Монголын түүхийн тулгар



бичгүүдэд Хотогойдыг захирч байсан ноёдын угсаа залгамжлал, тухайн угсаатан бүрэлдэх түүхэн цаг үеийн тухай өгүүлсэн байдаг бол Монголын томоохон түүхчин Галдан туслагчийн ‘Эрдэнийн эрхи’-д 18-р зууны дунд үед Хотогойдыг бүрдүүлж явсан зургаан отгуудыг шадар жанжин Чингүнжавыг баригдсаны дараа хэнд ямар отгоос таслаж өгснийг мэдэж болохуйц мэдээ байдаг.

Хотогойдуудын түүхэнд шууд болон дам байдлаар хамаарах сурвалж нь 1779 онд хэвлэсэн ‘Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, хотон аймгийн ван, гүнүүдийн илтгэл шаштир’ юм. Энэхүү түүхэн эх сурвалжийн 53, 60, 61, 63, 64, 67, 79 дүгээр дэвтэрт Хотогойдын түүхэнд болсон зарим үйл явдал, Хотогойдын таван хошууг захирч байсан тайж ноёдын улс төрийн үйл ажиллагааны тухай, тэдний нутагшилт, тархацын талаарх мэдээ байдаг. Манжийн төрөөс 1817 онд зохиосон “Гадаад Монголын төрийн засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”, “Хааны бичсэн биеэр дайлж өрнө, умрын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг” буюу -Энх-Амгалан хааны бодлогын бичиг”, “Дайчин улсын магад хууль”,

“Зарлигаар тогтоосон Монгол Улсын шаштир”, ‘Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг’ зэргээс Хотогойд төдийгүй тухайн цаг үеийн Монголын нийгмийн харилцааны асуудал, ерөнхий дүр төрхийг харж болохоор байна.

Тодруулж хэлбэл, Манжийн эрхшээлийн болон Богд хаант Монгол Улсын үеийн албан түүх, хуулиуд нь тухайн судалгааны ажилд холбогдох баримт, эх мэдээг өгч чадсан төдийгүй эдгээрт Хотогойдын угсаа, түүх, хошуу ноёдын намтар, үйл ажиллагаа, үе залгамж, зарим түүхэн үйл явдлуудыг багтаасан нь тэдний засаг захиргаа, нийгмийн байгууллагыг лавшруулан судлахад ач холбогдолтой юм. Монгол Улсын түүхийн төв архивт хадгалагдаж буй 18-20-р зууны эхэн үед хамаарах Манж, Монгол баримт бичигт Хотогойдын хошуудаас Улиастай чуулгантай харилцсан нугалбар, өдрийн тэмдэгт, дээш өргөн явуулсан бичиг, зарим бүрэн бус хүн, мал, жасын хөрөнгийн тоо, бүртгэл, татвар хураасан данс, уг хошууныхан хятад худалдаачидтай худалдаа хийж өр тавьсан тухай, хошуу захирагч ноёдыг зам мэнд явуулах тухай өргөсөн бичиг, нутгийн хилийн цэс, ноёдын угийн бичиг зэрэг нь чухал тулгар хэрэглэгдэхүүн болж өгсөн юм.

19-р зууны сүүл үед зохиогдсон ‘Засагт хан аймгийн олон засаг хошууны түүх’ хэмээх жижиг гар бичмэл нь Хотогойдын хошуудын түүх, ноёдын уг эх, зарим түүхэн хэрэг явдал, газар нутгийн цэс, өртөө харуул, хүн ам, малын тоо зэргийн талаар тун чухал мэдээг өгүүлсэн сурвалж гэж үзэж байна. Уг сурвалжид анх таван Хотогойд, гурван Олхонуд хэмээх нэр гардаг билээ. Манжийн эрхшээлийн үеийн албан түүх, хууль эрхээс гадна Богд хаант Монгол Улсын үеийн албан түүх, хууль эрх зүйн баримтууд хотогойдуудын түүхийг судлахад гол үүрэг гүйцэтгэнэ. 1914-1919 онд зохиосон “Зарлигаар тогтоосон Монгол Улсын шаштир”, “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” зэргээс Хотогойдын төдийгүй тухайн цаг үеийн Монголын нийгэм, эдийн засаг, угсаа соёлын харилцааны асуудал, ерөнхий дүр төрхийг харж болохоор байна.

## *Хотогойдуудын угсаа гарвал, газар нутаг*


Хотогойдуудын угсаа гарвалын тухай маш олон таамаглал бий. Оросын алдарт жуулчин, судлаач Г.Н.Потанин “Очерки северно-западной Монголий” хэмээх бүтээлдээ Хотогойдыг Өмнөд Сибирт оршдог Түрэг угсааны “Хайдут” буюу “Гайту” овогтой угсаа гаралын хувьд нэг түүнээс салбарлан гарсан хэмээн тайлбарлажээ. Тэгвэл Оросын судлаач Г.Е.Грум-Гржимайло дээрх саналыг аялдан дагаж “... “Хото-Гайт” нь баруун Монголчуудад хамаарагдах бөгөөд тэгэхдээ мянган зэрэг баруун Монголчуудыг тэр бас Монголжсон Түрэгүүд гэж үздэг тул Хото-гайтууд мөн л тэрхүү ясны бөлөгт (түрэг) тооцогдно.” гэж бичжээ. Харин доктор Д.Гонгор “Халх товчоо” бүтээлийнхээ тэргүүн дэвтэрт,

“... Хотогойдыг хойд зүгээс нүүдэллэн ирсэн ийм учраас “Хойт-

гойд” гэсэн үг сунжирснаас Хотогойд нэр үүссэн.” гэж үзсэн байна. Тэрчлэн С.Пүрэвжав “Хотогойдын угсаа гарал ба түүхийн асуудал” хэмээх бүтээлдээ, “... Хотогойд нь Ойрадаас тухайлбал түүний нэг аймаг болох Хойдоос гаралтай тул уг нэр томъёо нь ч гэсэн бас, хойд хэмээх язгуураас үүссэн бололтой. Ойрадын хойд нар Халхын хойд хязгаараар нутаг сэлгэн суурьших болсон ХҮИ зууны үеэс Халхчууд тэдний баруун Монголжуу өвөрмөц хэл аялгуу зэрэг зарим гойд ялгавартай талыг нь харгалзан “хойд гойд” гэж хочлонгуй нэрлэсэн нь хожим сунжирсаар Хотогойд болон хувирсан бололтой.” гэжээ. Мөн угсаатан судлаач Х.Нямбуу, түүх судлаач Б.Цэрэл нар “Хотгойдууд ойрад, урианхай нартай ойр зэргэлдээ байсан, XVI зууны сүүл үеэс эхлэн халхчуудын дунд 300 гаруй жил хутгалдан суусан халхжсан ойрад болно” гэжээ. Гэтэл доктор С.Чулуун “... одоогийн Хотогойд нь Ойрад, зүүн монгол, Хөх нуурын монголчууд холилдсоны үр дүнд бүрэлдэн тогтсон аймаг” гэж үзжээ. Ямартай ч хотогойдуудыг судлаж үзсэн эрдэмтэн мэргэд Хотогойдуудын угсаа гарвалын талаар нэгдсэн нэг байр суурьтай болж чадаагүй байна. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул, нэрт эрдэмтэн, хотогойд судлаач С.Пүрэвжав “Хотгойдын угсаа гарвал ба түүхийн асуудлууд ном бичиж гаргасан юм. 16-19-р зууны үеийн хотгойдуудын тухай судласан энэхүү бүтээлд хотогойдуудын тухай маш сонирхолтой мэдээ, мэдээллүүд агуулагдаж байна. С.Пүрэвжав тэргүүтэй эрдэмтэд “дөрвөн ойрад” ба хотогойдуудын өвөг дээдсийн хоорондын учир холбогдлийг олохоор эрэл хайгуул хийсэн ч нэгдсэн нэг дүгнэлтэнд хүрч чадсангүй. Монголын түүхэнд ойрад хэмээх нэр бүр 13-р зууны үеэс мэдэгдэх болсон бөгөөд Монголын нууц товчоонд “Дайчуд, татар, ойрд, наймны ноёд нийлж, 1201 онд Эргүнэ мөрний хөвөөн дээр Жамухыг Гүр хаанд өргөмжилсөн” тухай дурьдсан байдаг. Үүнээс харахад ойрд нь нь бие даасан аймгийн холбоог хараахан байгуулаагүй боловч нөлөө бүхий аймаг байсан бололтой. 18-р зууны үед тод үсгээр бичигдсэн Гаван Шаравын “Дөрвөн ойрдын хаадын намтар” хэмээх бүтээлд “Дөрвөн ойрдууд нь нэгдүгээрт өөлд, хоёрдугаар нь хойд баатууд, гутаар нь барга буриад, дөтгөөр нь дөрвөд, зүүнгар, торгууд хэмээх мөн. Барга буриад нь монгол, орос хоёрт шингэв. Хойд нь хотон, зүүнгар хоёрт шингэв” хэмээн өгүүлжээ. Үүнээс улбаалан эрдэмтэн С.Пүрэвжав хотогойдуудын эртний өвөг дээдэс болох баруун монголчууд хойд буюу өөлд нь 13-р зуунаас өмнө Байгал нуур ба түүний баруун өмнө этгээдээс Эрчис мөрөн хүртэлх асар уудам нутагт тархаж, нүүдлэн аж төрж, ан гөрөө, мал аж ахуй эрхлэж байсан гэж үзжээ. Тэрээр өөлдүүдийн аман яриа, аялгуу зэргийг судлаж, Төмөрбулаг суманд амьдарч байсан ахмад настан Галбаа, Бүрэнтогтох сумын ахмад настан Цогт-Очир тэргүүтэй хотогойд хөгшчүүдтэй уулзан тэмдэглэл хөтлөн үлдээсэн бөгөөд “Хотогойдууд нь ойрад, өөлдүүдээс гаралтай, тэдний домог болон хэл зүй зарим хэллэг аялгуу үүнийг гэрчилнэ” хэмээн батлан бичжээ. Түүнтэй уулзсан ахмад настнууд “Манай хотогойдын жинхэнэ хэл яриа өөлдөд бий. Бид халхаар яриад өөрсдийнхөө эртний хэлийг мартсан” хэмээн ярьж байсныг ч тэмдэглэн үлдээсэн байна. С.Пүрэвжав одоогийн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Бүрэнтогтох суманд судлагаа хийж тэдний хэллэгэнд баруун монгол аялгуу үлэмж хэмжээгээр байгааг

тогтоожээ. Мөн хотогойд аялгууны үгсийн сан нь ойрад аялгууны үгсийн сантай тохирдог, орчин цагийн монгол хэлний харьяалахын тийн ялгалын ын, ийн дагаварыг хотогойд, өөлдүүд аман ярианд хэрэглэхдээ аан, буюу аа-гаар дууддаг гэдгийг харьцуулан судласан байна. Жишээлбэл Бадгын гэсэн үгийг хотогойд, өөлд, ойрадууд адилхан Бадгаан хэмээн дууддаг гэдгийг судлаж, олон үгээр жишээ татжээ. Хотогойдууд нь угсаа гарал, овгийн бүрэлдэхүүнээс гадна хэл зүйн болон аман аялгууны хувьд цэвэр халх биш бөгөөд ойрад-халхын завсрын шинжтэй болохыг эрдэмтэн Б.Я. Владимирцов судлан “...Бүх талаас нь үзвэл хотогойд аман аялгуу нь Халх-Ойрадын аялгуу хутгалдсаны дүнд буй болсон холимог аялгуу юм. Чингэж хутгалдах явц нэлээд эрт буй болсон бололтой” гэжээ. Үүнийг Монголын эрдэмтэн Ж.Цолоо судлан “...авиа зүйн болон хэлний зүйн талаасаа цэвэр халх биш, өвөрмөц шинжтэй бөгөөд тухайлбал захчин, урианхай аялгуутай төстэй хэмээн дүгнэжээ” Мөн хотогойдуудын дундуур 19-20-р зууны заагаар аялсан эрдэмтэн Г.Н.Потанин Хотогойдуудыг халх бус болохыг ажигласан ба өөрийнхөө тэмдэглэлд “...тэдний байр байдлыг ажиглавал баруун халх монголчуудтай адил харагдах бөгөөд хэрэв зээ монгол хэл мэддэг байсан бол хэлний хувьд адил төстэйг ч нэгэн адил олж үзэх байсан буй за” гэжээ. Харин Манжийн төрийн зохиосон Илтгэл шастирт “...Хотогойдын газар нь Халхын адгийн захад орхигджээ, Баруун этгээд нь Өөлдөд ойр, умарт этгээдэд Орост ойр буюу. Тэдний зан байдал цахар дүртэй... Хотогойд хэдий засагт ханы харъяат мөн боловч үнэхээр өөр нэгэн аймаг билээ” гэжээ. Уг мэдээ нь Хотогойдыг халхаас ямар нэгэн байдлаар өөр, зан төрх, угсаа гаралтайг илэрхийлж байна.

Хотогойд нь овгийнхоо бүрэлдэхүүний хувьд ч гэсэн эртний дөрвөн ойрад, мянгад, өөлдүүдтэй тун төстэй байгааг тогтоосон байна. Жишээ нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүдийн овгийн нэрсийн зонхилох хэсэг нь хотогойдуудтай тохирч байсныг судласан байна. Эрдэнэбүрэн сумын өөлдүүдийн дунд чорос, шармонгол, бичээч, тоос, халиугчин, хөхийнхөн, цагаан ба хар хойд, авгас, хэрдэг гэх мэт овгууд бий. Тэгвэл 1755-1757 онд Чингүнжавын тусгаар тогтнолын бослогын үед хотогойдод тоос, халиугчин, шарнууд, мянган буюу мянгад овог байжээ. Одоо ч Төмөрбулаг Арбулаг, Цэцэрлэг зэрэг сумдад цөөн тоотой мянгад овог үлдсэн гэдгийг судлаачид тогтоосон байна. Мөн Энх-Амгалангийн 32 онд халхын Ахай дайчин Банди гэгч ноёноос манжийн хаанд өргөх бичиг барьж, “ Миний бие хүүхэд, эм албатаа цөм өөлдийн Лувсанринчин нарт дээрэмдүүлэв” хэмээн бичсэнийг баримт болгож, Хотогойдын ноён Лувсанринчинг өөлд хэмээн зүгээр нэг нэрлээгүй. Харин хотогойдуудын угсаа гарвалыг дайруулан өөлд хэмээн өгүүлсэн хэмээн С.Пүрэвжав тэргүүтэй эрдэмтэд үзжээ. Мөн Засагт хан аймгийг үндэслэгч Засагт хан Лайхуур ойрадтай Имил голын адагт тулалдсан мэдээ “Алтан товч” зохиолд буй. Чухамхүү энэ үеэс Засагт хан Лайхуур хойдуудыг дөрвөн ойрадаас таслан авч, өөрийн эзэмшилд нийлүүлэн, үеэл дүү Убаши хун тайждаа захируулсан нь хожим хотогойд нэртэй болсон гэсэн таамаг дэвшүүлжээ.



### Хотогойдуудын овог, отог

Эрдэмтэн мэргэдийн олж тогтоосноор энэ сумын нутагт хэрдэг шарнууд, халиучин, хиргис, барчууд, буриад, бэсүд, их мэргэд, нохой тавагт, хар сүрэгтэн, онход, үхэр онход, хонин онход, зэлмэн, боржигон, бүргэд, зэрэг 20-иод овог лав байх учиртай гэнэ. Хотогойдын Мэргэн гүний хошуу буюу одоогийн Төмөрбулаг суманд өндрийнхөн, долоон сувайхан, бүргэд авхайхан, чорос, мянгад зэрэг овгууд амьдарч байсан бөгөөд нэг овог 20-30 орчим айл өрхтэй байсан байна. Харин Далай гүний хошуу буюу Төмөрбулаг, Бүрэнтогтох, Бүрэн сумдад халиугчин, бүргэд, тогоруутан, хиргэс, оймууд, хариад, ушиг, хуриад, онход, үхэр ба хонин онход зэрэг овгууд оршдог байжээ. Үүнээс бүргэд овог нь одоогийн Төмөрбулаг сумын Тал булагийн ам, Хуриад нь Урт, Бургастаар нутагладаг байсан гэдгийг эрдэмтэн С.Пүрэвжав өөрийн бүтээлд маш тод дурьджээ. Хамгийн олон хүн амтай бөгөөд их нутаг хамаардаг нь халиугчин. Энэ овгийнхон Төмөрбулаг сумын нутаг Бүгсийн амнаас Бүрэнтогтох сумын Цагаан бургас хүртэлх газар нутагт амьдарч байж. Мөн Бүгсийн голын дундаас Сангийн далай хүртэлх өргөн уудам газар нутагт онход буюу онгуд овгийнхон амьдардаг байсан бөгөөд эрдэмтэн С.Пүрэвжав “Төмөрбулаг сумын хүн амын 1/5 хувийг энэхүү онгуд буюу онходынхон эзэлнэ” гэж дурьджээ. Онход гэсэн энэхүү ургийн овогтой хүмүүс Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумаас гадна дархад ястан нутагладаг Ренчинлхүмбэ, Улаан-Уул, урианхай нар амьдардаг Чандмань-Өндөр, халхчууд амьдардаг Рашаант зэрэг сумдаас гадна Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Чойбалсан, Баян-Өлгийн урианхай нарын дотор ч амьдардаг аж. Рашаант суманд амьдардаг онгуд буюу онход овгийнхон өөрсдийгөө Чингүнжавын бослогын үеэр ирсэн Улайр баатрын удам угсаа хэмээн ярьцгаадаг аж. Үүнээс улбаалан эрдэмтэн С.Пүрэвжав эртний 17-р зууны үед Зүүн Сибирь, Байгалийн өмнөд этгээдэд Ангар мөрний эрэг

дагуух нутгуудаар сэлгэн суурьшиж байсан Онгуд аймгийнхан өнөөгийн Төмөрбулаг зэрэг сумдад амьдарч буй онгуд овгийнхонтой холбоотой байж магадгүй гэдэг сонирхолтой таамгийг мөн дэвшүүлжээ.

### Шарнууд

Энэ бол нилээд том овог бөгөөд бараг бүх аймгийн нутагт бий. Шарнууд гэдэг нь нэгэн зүйлийн чонын нэр ажээ. Эрдэмтэн С.Шагж “Энэ амьтан шар өнгөтэй, ердийн чононоос бага, үнэгнээс том” гэжээ. Шарнууд чононоос айн бэмбэгнэж, эрт цагт аргадан онгончилсон нь овгийн нэр болсон бололтой.

### Хэрдэг

Төмөрбулагаас гадна энэ овог Цэцэрлэг, Цагаан-Уул суманд бий. Мөн Тагнын Тува нарын дотор ч бас байдаг. Хотгойдууд Тува нарыг эзэмдэн захирч байх үед Хэрдэгийн зарим нь Тува нарын дотор орсон бололтой.

### Буриад

Монголын эртний овог бололтой. Домог яриагаар бол Байгаль нуурхавиас үүсч гараад нүүдэллэн ирсэн гэж үздэг. 13-р зууны үед Чингисийн хүү Зүчийн байлдан дагуулах аян дайны үед суурьшиж үүссэн байж болох юм.

### Тоос

Монгол сурвалж бичгүүдэд Тогус, Тогос хэмээн нэрийдэгдсэн энэ овгийн нэрийг эдүгээ Монголчууд Тоос хэмээн дуудах болжээ. Судлаачид энэ овгийг Тось, Тос, Тогос, Тагуз, Тагусы, Тосит гэх зэргээр бүртгэжээ. Өгүүлэн буй овгийг Уйгурын дотор байсан Тогуз нарын үр удам хэмээн тэмдэглэсэн байх агаад профессор А.Очир, түүхч С.Чулуун нар энэ саналыг дэмжсэн нь бий.

Оросын эрдэмтэн О.Долгих Тагусы нэртэй овог XVIII зуунд Сибирийн Тубалар аймагт, Тосит овог тундрын Энцүүд нарын дунд байдаг гэжээ. Мөн В.В.Радлов умард Алтайн Татарчуудын дунд Тогуз нэртэй овог байдаг тухай тэмдэглэсэн бол 1957 оны хүн амын тооллогоор Алтайчууд дунд Тогус овгийн 497 хүн байсныг бүртгэсэн байна. Хотогойдын эрх баригсад Тува, Алтайчуудын зарим хэсгийг нь эрхэндээ оруулан алба авч байсан тухай мэдээ сэлт тааралддаг бөгөөд тэр үед Тоос нарын нэлээд хэсэг нь Хотогойдод харъяалагдан улмаар нэгэн гол отог нь болж өгөөн бололтой. Манж нар Хотогойдын гол хошууг бутарган хэд хэдэн хошуу зохиоход Тоос нь Эрдэнэдүүрэгч вангийн хошуу, Ахай бээлийн хошуунд хуваагдсан байна. 1931 оны засаг захиргааны шинэ зохион байгуулалтаар Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд Тоос нэртэй нэгэн баг байгуулж байсан бол XX зууны дунд үеэр Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Арбулаг, Цэцэрлэг, Түнэл, Тосонцэнгэл, Их-Уул сумдад Тоос овгийнхон бүртгэгджээ. Тэгэхээр энэхүү Тоос овгийнхон Монголжсон Уйгур гаралтай отог байх магадлалтай юм.



## Халиучин

Аливаа үндэстэн угсаатны дунд эрхлэх ажил үйлээрээ нэрийдэгдсэн овог цөөнгүй бий. Тухайлбал Адуу+чин, гөрөө+чин, хэрэм+чин гэх зэргээр овог үүсгэсэн байдаг. Усанд сэлдэг Суусарын аймгийн үслэг жижиг араатныг халиу хэмээнэ. Халиучин нарын угсаа гарлын тухайд судлаачид Тувагаас Монголд бус Монголоос Тувад шингэсэн овог хэмээн үзсэн нь бий. Харин судлаачид энэ нь Хотогойд ястанд шингэн орсон Түрэг гаралтай овог гэдэг таамаг дэвшүүлжээ. Нэгд, судлаачид Хөвсгөл нуурын умар дахь Тува нарын дотор Хасут хошуунд XVII зууны үед Халиучин овгийнхон байсныг тэмдэглэсэн байдаг. Халиучин нар анхан Мянгадын хамтаар Далай засгийн хошууг бүрдүүлж байснаа Мянгадуудыг Ховд голын сав дагуу нүүсний хойно дангаараа нэгэн хошууг бүрэлдүүлэх болжээ. Энэхүү хошууны нутаг дахь Сангийн далай нуур, Бүгсийн гол, Хар хоргон гол, Ачин булаг зэрэг газруудад гол төлөв нутаглан суух аж. Эдүгээ Халиучин отгийнхон Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Арбулаг, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Түнэл, Шинэ-Идэр, Галт сумдад оршин сууж байна.

**Шэжнүүд:** Энэ отгийн тухай мэдээ сэлт нэн хомс юм. Шижнүүд, Цээжнүүд, Шэжнүүд гэх зэргээр түүхэнд тэмдэглэгджээ. Профессор А.Очир энэхүү отогийг XI зууны үед үүссэн Сиджуит аймгаас гаралтай гээд анхан нэрийн үндэс нь Шижин байгаад яваандаа Шээжин болсон. Энэхүү Шээжин овгийнхон XVII зууны эхэн үед баруун тийш нүүдэллэн явсаар Хотогойдууд дунд орж нутагласанаар Шээжин отог үүссэн гэсэн байна. “... Дүүрэгч вангийн хошуунд 1930-аад оны үед Цээжнүүд нэртэй баг байгуулагдаж байсан нь энэ отгийн нэрний улбаа байж болох юм.” гэж эрдэмтэн С.Чулуун “Хотогойдын зургаан отгийнхны угсаа-хамаадлын асуудалд” номондоо дурьджээ.

**Мянгад:** Хотогойдын энэхүү отог нь Хойдын Их мянган отог мөн бололтой. Сурвалжид өгүүлснээр Хойд аймаг нь Алаг гулз, Өл түмэн, Их мянган, Цагаан туг гэсэн дөрвөн том овгоос бүрэлдэх аж. Энэ тухай Монголын түүхийн тулгуур сурвалжийн нэг “Эрдэнийн эрхи”-д,

“... Их мянган овогтой Хойд нь угтаа Дөрвөдийн харъяат бөгөөд Тарвагатайн газар нутагшжээ. Хойд хүмүүн Их мянган овогтон мөн” хэмээсэн бол тэд өөрсдийгээ “бид Өөлдөөс гаралтай. Одоо Халх аялгуугаар ярьдаг болсон. Бид их мянганы үр угсаа, хожим Халх газар ирж суусан юм” гэх зэргээр ярилцдаг байсан тухай С.Пүрэвжав, Ж.Цолоо нар тэмдэглэн үлдээжээ. Хэдийгээр XIII зууны үед Ойн иргэд дунд Мянган гэх овог тэмдэглэгдсэн байх авч түүхчид энэ отогийг Хойдын их мянган овог мөн гэдэгтэй санал нийлдэг. Тэгээд ч Мянгадууд хожим нүүдэллэхдээ Ойрадууд дунд нутагласан байдаг. Дээр өгүүлсэн XVII зууны үеийн Халх Ойрадын дайны үед Хойдын их Мянган овгийнхон голдуу хүн ам Халхад шингэн орж Хотогойдын Мянгад отгийг бий болгосон бололтой.

**Их, бага Хотогойд:** Энэ отгийг талаар эрдэмтэн А.Очир “... XVIII зууны дунд үеийн Хотогойдыг бүрдүүлж явсан томоохон отог юм. Их, бага Хотогойд хэмээх хоёр отог нь угтаа их, бага Хотогойдууд хэмээх овгоос үүдэлтэй бололтой.” гэж эрдэмтэн “Хотогойдын угсаа-хамаадлын асуудалд” бүтээлдээ дурьджээ.

## Хотогойдын Алтан ханууд

Эрдэмтдийн үзэж буйгаар Хойд аймгийн хэсэг нь Халхын Засагт ханы мэдэлд багтах болсон нь 16-р зууны эцэс үед хамаарагдана. Өөрөөр хэлбэл, Ашихай дархан хун тайжийн ач хөвгүүн Лайхурын үед Халх-Ойрадын хооронд болсон хэд, хэдэн дайны явцад Ойрадын хойд аймгийн заримаас таслан захирсан бололтой. Лайхурын үеэс өмнө Халхын дунд Хотогойдын нэр ер дурьдагддаггүй. Тиймээс тэднийг 16-р зууны сүүл үеэр л Халхын баруун гарт харьяалагдан захирагдах болсон гэсэн саналыг зарим эрдэмтэн дэвшүүлдэг. Харин эрдэмтэн Д.Гонгор “Гэрсэнзийн хатан Их Тайху хөвгүүддээ Халхыг хувааж өгөх тэр үед Хотогойдууд нь Саму Буймад өмч болон очсон Урианханы дотор багтаж явсан байж магадгүй” гэж үзжээ. Ямартай ч Ойрадын нэг аймаг болсон Хойд аймгийн зарим хэсэг нь 17-р зууны эцэс үеэр Халх-Ойрадын үймээний үеэр Засагт ханы мэдэлд орж улмаар Ашихай дархан хун тайжийн дэд хөвгүүн Түмэндарь хотогур дайчингийн удмынханд захирагдах болжээ. Түүний хөвгүүн Шолой убаши буюу “Алтан хан”-ны үед Хотогойд нэрээр ихэд алдаршсан юм. Сурвалжид энэ үеэс Ашихай дарханы мэдэлд очсон Үнэгэд, Жалайрын хойчис нь “таван Хотогойд”, “гурван Олхонуд” хэмээгдэх болжээ. Эрдэмтэн С.Пүрэвжав таван Хотогойдыг Шолой убашийн таван хөвгүүнтэй холбон тайлбарласан бөгөөд Халхын засагт ханы харьяанд шилжсэн Хойдууд түүхэн хөгжлийн явцад халхчуудтай холилдон хотогойд хэмээх нэгэн угсаатны бүлэг үүсгэсэн гэж үзсэн байна. Алтан хан Шолой убашийн үед Хотогойдууд Ойрад-Халхын алинд ч хамаарахгүйгээр оршиж, Хотогойдын улс, Хотогойдын газар, Хотогойдын хан гэх зэргээр нэр түүхийн бичигт дурьдагдаж эхэлдэг бөгөөд тэд ихэд хүчирхэгжиж байжээ. Энэ үеэс л Хотогойдын ард түмэн өөрсдийгөө “би Халх”, “би Ойрад хүн” гэхээсээ илүү би Хотогойд хүн хэмээх болжээ. Өөрөөр хэлбэл угсаатан өөрийгөө ухамсарлан үзэх сэтгэлгээ бүрэлдэн тогтож чадсан байна. Хотогойдын түүхэнд гурван Алтан хан тодрон гарсан бөгөөд энэ нь Шолой увш, Омбо-Эрдэнэ, Лувсанринчин нар юм. Засагт ханд харьяалагдах болсон Хотогойдууд Халхын Засагт хан аймгийн баруун ба баруун хойд хэсгээр Хөвсгөл нуураас Увс нуур хүртэлх өргөн уудам нутагт нутаглаж байв. Алтан ханы захиргааны улс 17-р зууны эхээр нилээд хүчирхэгжин нутгийн зах нь зүүн зүг Сэлэнгэ, Тамирын эх, баруун хойш Алтай, Красноярск, умар зүг Тагна уул хүрч байжээ. Энэ үеэс зах нийлэн орших болсон Тува Урианхай, Енисейн хиргис зэрэг овог аймгуудыг уулгалан довтолж, зарим үед алба бариулж, тэдний заримаас олзлон Хотогойд дотор суулгах ч явдал байлаа. Ойрад, хотгойдууд Баруун Монголд ноёрхохын төлөө тэмцэлдэн хотгойдууд ойрадуудыг баруун тийш шахсан боловч 17-р зууны дундаас хотгойдуудын хүч буурчээ. Хотгойдын улсыг Халхын гурван ханлигийн дараах дөрөв дэх ханлиг гэж үздэг. Алтан хан х өөрсдийн ханлиг улсыг бий болгон төв Азийн улс төрийн амьдралд Засагт ханаас үл хамааран бие даан оролцож байв. Манжийн төрийн албаны түүх “Зарлигаар тогтоосон гадаад Монгол, Хотон ван гүнгүүдийн Илтгэл шаштир”-т,

“... Хотогойдын газар нь Халхын адгийн захад орхигджээ. Баруун этгээдэд нь Өөлдөд ойр, умарт этгээдэд Орост ойр буюу. Тэдний зан

байдал нь Цахар дүртэй ... Хотогойд хэдий Засагт ханы харъяат мөн боловч үнэхээр өөр нэгэн аймаг билээ.” [“Зарлигаар тогтоосон гадаад Монгол, Хотон ван гүнгүүдийн Илтгэл шаштир” УТНС гар бичмэл 63-р дэвтэр]

хэмээсэн нь тэднийг өвөр Монголын Цахар аймгийн адил эрэмгий зоригтой, Манжийн эсрэг байнга тэмцэж байдгийг нь илтгэн харуулсан явдал юм.

### ***Алтан хан Шолой увш***

Засагт хан аймгийг үндэслэгч засагт хан Лайхуур ойрадтай Имил голын адагт тулалдсан мэдээ “Алтан товч” зохиолд буй. Чухамхүү энэ үеэс Засагт хан Лайхуур хойдуудыг дөрвөн ойрадаас таслан авч, өөрийн эзэмшилд нийлүүлэн, үеэл дүү Убаши хун тайждаа захируулсан гэж түүхчид үздэг. Хотогойд аймгийн үүслийг тавьсан Шолой увш хунтайж Гэрсэнз жалайр хунтайжийн ахмад хөвгүүн Ашихай дархан хунтайжийн 2-р хүү Түмэндара дайчингийн хүү. Тэрээр өөрийн хойд дахь улсыг бэхжүүлэн Засагт ханы ёс төдий захиргаанаас гарахыг байнга эрмэлзэж, Орос улстай албан ёсны харилцаа холбоо тогтоож байжээ. “Монголын Увш хунтайжийн тууж” хэмээх ташаа нэрээр алдаршсан “Дөрвөн Ойрад Монголыг дарсан тууж” хэмээх эртний зохиолд Алтан хан Шолой увшийн талаар дэлгэрэнгүй өгүүлдэг.

### ***Алтан хан Омбо-Эрдэнэ***

Хотогойдуудыг 1628-1655 оны хооронд Шолой убаши хунтайжийн ахмад хүү Омбо-Эрдэнэ хунтайж захирч байжээ. Омбо-Эрдэнэ хунтайж төрийн эрхийг авангуутаа гадаад байдлаа бэхжүүлэх, Орос улстай харилцаагаа сэргээж, худалдаа арилжаа хийхийг чухалчилахын сацуу Алс дорнод Манж чин гүрэнгэй эв эетэй байхыг хичээж байсан тухай эрдэмтэд тэмдэглэжээ. Тэрээр 1631 онд Оросын захын хот Томскийн захиргаанд элч зарж, Цахарын хааны довтолгооноос хамгаалж өгөх хүсэлт тавьж байсан байна.


### ***Алтан хан Лувсанринчин***

1655 оны үед Хотогойдыг захирсан Лувсанринчин Засагт хан аймгийн хан Норовын ахмад хөвгүүн Ванчин мэргэнийг ширээнээс буулгаж, уулгалан довтолсноор халх, хотогойдын хооронд мөргөлдөөн үүсч, сүүлдээ халхын ихэнхийг хамарсан дайн тулаан үүссэн гэж түүхчид үздэг. Халхын ноёд Лувсанринчингийн эсрэг босч, тэрээр баруун зүг дутаасан, Ойрадын Сэнгэ ханд баригдаж, Галдан хаантай эв эвдэрч, хожим Манжийн хаанд дагаар орсон гэсэн мэдээг түүхч С.Пүрэвжав тэмдэглэжээ.

### ***Хотогойдуудын гадаад харилцаа***

Хотогойдууд бие даан Ойрад болон Орос улстай харилцаж, элч төлөөлөгчөө илгээж, мөн тэдний элч нарыг хүлээн авч байжээ. Хотогойд нь XVI зууны эцэс XVII зууны эхээр Халхын Засагт хан аймгийн нутгийн баруун хойд этгээд Хөвсгөл нуураас Увс нуур өнгөрөх өргөн зурвас газар нутагшин суусан бөгөөд энэ газар нь тухайн үед нэлээд чөлөөт нутаг байжээ. Хотогойдыг захирагч Шолой уваш хунтайж (1567 - 1627) нь өргөн удам газар

эзэмшин, эдийн засгийн хувьд ихээхэн хүчирхэгжиж ирэх сацуу Халхын баруун гарын тэргүүлэгч, үеэл ах Лайхурын мэдлээс гарч толгой даах бодлого явуулсан бөгөөд түүний нутгийн хил хязгаар нь зүүн тийш Сэлэнгэ, Тамирын эх баруун зүг Алтай, Красноярск хүрч байжээ. Хотогойдын энэ биеэ даасан байдлыг тэр цагт нутгаа тэлж байсан Орос улс ихээхэн сонирхож Шолой уваш хунтайжтай холбоо тогтоон, түүгээр дамжин Мин улстай харилцах дөт замыг эрэлхийлж, нөгөө талаар монголчуудтай найрсаг харилцаатай байж, Орос Монголын завсар бүхий түрэг аймгуудыг эрхшээлдээ оруулах бодлого барьж байлаа. Тэрээр Монголд нөлөөлөхийн тулд Хотогойдын ноёдыг “Алтан хан” хэмээн өргөмжлөн, тэднийг



өөртөө татах оролдлого хийж байв. Мөн Шолой уваш хунтайж ч гэсэн хөршлөн орших Орос улстай худалдаа хийх Монголын бусад улс аймагтай тэмцэх тэмцэлдээ Оросыг түшиг болгох эрмэлзэлтэй байв. Чухам иймээс Орос улс Хотогойд хоёр элч солилцон холбоо тогтоожээ. Монгол-Оросын харилцааны эхлэлийг Хотогойдыг захирч байсан, түүхэнд Алтан хаад хэмээн нэрлэгдсэн Шолой, Омбо-Эрдэнэ, Лувсанринчен нарыг эхлүүлсэн хэмээн албан ёсоор үздэг. Монголын умард хэсэгт нутаглах Хотогойдууд нь 17-р зууны монголын түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсний нэг хэсэг нь умард хөрш Орос оронтой улс төр, эдийн засаг, соёлын харилцааны эх суурийг тавьсан энэ явдлыг судлаачид өндөр үнэлдэг юм. Энэ үед умраас Оросын цагаан хаант улс Дорно зүгт хаяа тэлэн Сибирь, Алс Дорнодод орж ирэх болсон ба оросын хаанаас Монголчуудтай харилцахыг хүсэж ялангуяа тухайн үед хүчирхэгжээд байсан Шолой убаши хун тайжтай харилцаа тогтоох, болбол Орост алба бариулах, өөрийн түшээц, хараат орон болгохыг зорьж элч төлөөлөгч удаа дараа илгээх болов. Шолой убаши ч Ойрадуудтай байлдахад түшиг болгох, мөн худалдаа эдийн засгийн харилцаа тогтоох зэрэгт Орос улсыг ашиглахыг зорьж, элч нарыг найрсаг угтан авдаг байжээ. Гэхдээ Шолой убаши өнгөн дээрээ Орос улсын эзэн хааныг хүндэтгэн үзэж буй мэт түүний ивээлд орж, цалин пүнлүү хэргэм зэргийг нь хүртэхэд бэлэн буйгаа илэрхийлж байвч үнэн хэрэг дээрээ өөрийгөө эзэн хааны хэмжээнд тавьж байжээ. Оросын түүхийн архивт хадгалагдаж буй баримтаас үзэхэд Алтан хаад нь Оросын дорно зүгийн гол харилцагч нь болж байжээ. Жишээ нь хятадаас ногоон цайг Сибириэр дамжуулан авч, анх орос орныг

цайтай танилцуулсныг гэрчлэх баримт Оросын архивт өнөөдөр хадгалагдаж байна. Түүхэнд тэмдэглэгдсэнээр Шолой Убаши 1606 оноос эхлэн Орос улстай найрамдалт харилцаа тогтоохоор өөрийн элчийг Москва руу илгээж байжээ. Энэ үеийг Орос Монголын хооронд албан ёсны харилцаа тогтоосон он гэж түүхчид үздэг. Хотогойдын Алтан хан Шолой Убаши 1618 онд Орос элч илгээж, түүнээс ойрадтай тэмцэх тухайлбал хамтын хүчээр Хархултай байлдах, цэрэг зэвсгийн тусламж үзүүлэхийг хүсэж, Сибирийн хотуудтай худалдаа арилжаа хийхийг чухалчилж байгаагаар илэрхийлж байжээ. Гэвч Москвагийн улс Шолой Убашийн энэхүү хүсэлтэнд ихээхэн болгоомжилж, “Их эзний ивээлд орвол түүнийг дайснаас хамгаална” гэдгээ мэдэгдсэн байна. Гэвч хотогойдын хан Оросын мэдэлд очихоос татгалзаж, Орос улс Алтан хаанаас ихэд болгоомжлон 1623 онд хязгаарын Тобольск хотын эрх баригч нарт “Алтан хаантай харилцахыг, Сибирээс галт буу гадагш гаргахыг хатуу хориглож байсан баримтууд Оросын түүхийн архивт хадгалагдан үлджээ.

### *Хотогойдуудын тэмцэл*

Хотогойдыг захирсан Чингисийн угсааны ноёдууд эрт (1587 онд) ойрадуудад ялагдсан ялагдлынхаа өшийг аван өрнөд Монголыг нэлд нь өөрсдийн эрхшээлд оруулан газар нутаг албат иргэдийнхээ тоог нэмэгдүүлж сүр хүчээ бадруулах үүднээс 1620 оны үед ойрадтай нэлээд олон удаа дайтжээ. Ойрад-Хотогойдын эдгээр эвдрэл хямрал нь гагцхүү 1634 онд Ойрадын төрийн толгойд суусан Хархулын хүү Баатар хунтайж, 1630 онд Хотогойдын Шолой уваш хунтайжийн орыг эзлэн суусан Бадам-Эрдэнэ хунтайж (Омбо-Эрдэнэ)-ийн үед нэлээд удаан хугацаанд намжиж байсан авч 1657 онд Ойрадын хаан Сэнгэ Хотогойдыг цэрэглэн дайрч, Хотогойдын цэргийг даржээ. Үүний дараа Ойрадын хаан ор суусан Галдан бошигт, урьд Ойрадад олзлогдсон Лувсан тайж (Лувсан-ринчен хунтайж) -ийг суллаж дагуулж Халхад нөлөөгөө ахиулахын тулд Засагт хантай найрсаг холбоо тогтоохын үүднээс Засагт ханы мэдэлд өвөг дээдэст захирагдаж явсан Хотогойдыг Засагт ханы мэдэлд өгснөөс хойш өөрөө бусдыг захирах буюу тэдний хараанаас ангид байх эрмэлзэл бүхий Хотогойд ноён Лувсанринчен Засагт хан болон ойрадын Галдан бошигт нарын аль алинтай нь үл тохирон 1685-86 оны үед хэсэг албатаа дагуулан Хөхнуур Амдууд зайлан одож, 1686 онд Манжид шурган орсон бөгөөд 1690 онд Өвөр монголын нутаг Улаанбудан гэдэг газар манж ойрадын хооронд болсон их тулалдаанд манжийн талд орон, Галдан бошигттой байлдаж байсан бөгөөд 1696 онд Манжийн цэргийн хуаранд өвчнөөр нас барж түүний дагуулж аваачсан Хотогойдын 1000 гаруй албат иргэдийн зарим нь сарниж, нэг хэсэг нь 1709 онд нутагтаа эргэн иржээ. Энэ түүх бол ойрадын баруун зүгт Тарвагатайн газар шилжснээс хойш тэдний нэгэн хэсэг нь Халхын эзэмшил болж байсан үеийн явдал бөгөөд тэр цагт Ойрадуудын Хойд нар Увс Ховдын газар зонхилон нутаглаж Халхчуудтай холилдон байршсан нэгэн чухал түүхэн үе болно. Энэ үеийн Зүүнгарын улсын бүрэлдэхүүнийг Манжийн тэнгэр тэтгэсэн хааны (1716-1795) сургаалд “Зүүнгарын Дөрвөн Ойрад гэгч Чорос аймаг, Дөрвөд аймаг, Хошууд аймаг, Торгууд аймаг мөн. Хойд

бол угаас дөрвөд аймагт хавсрагджээ. Хожим торгууд аймаг Орост дагасан учир тийнхүү Хойдыг нэг аймаг болгов” гэжээ. Харин Халхын Засагт хан аймгийн харьяат хойд (Хотогойд) нь мөнөөхөн Шолой уваш хунтайжийн хөвгүүн Гэндэнг 1786 онд болсон Хүрэн бэлчирийн чуулган дээр засаг ноён болгосноор хошуу болжээ. 1688 онд Галдан бошигт Халхыг довтлоход Гэндэн тайж харьяатаа авч Сэлэнгэ мөрөнд зайлан сууж, 1694 онд Чин улсад дагаар ирсэнд төрийн бэйл болгожээ. Энэ үед Гэндэн бэйлийн үр сад Бүүвэй бэйл, түүний хүү Банди бэйлийн хүү Шадар ван Чингүнжавын харьяат Хотогойдод Халиучин, Тоос, Их Хотгойд (хойд), Бага Хотгойд (хойд), Шээжнүүд, Мянган (мянгад) зэрэг овог отог байсан байна. Шадар ван Чингүнжав 1737 онд хошууны засаг Банди бэйлийг залгамжилсан боловч 1757-1758 онд Халхад гарсан эрх чөлөөний зэвсэгт тэмцлийг толгойлсон тул, түүнийг цаазаар аваачин, хошуу засгуудыг Чингүнжавын дүү Эринчингийн удмаас тавьж, Чин улсад үнэнч зүтгэсэн эсэхээр нь зэрэг хэргэм хүртээжээ. Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу нь Хотогойдын гол хошуу бөгөөд түүнээс салбарлуулан тасалж таван хошуу болгосон ажээ. Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу 1918 оны байдлаар өрх 1428, хүн ам 4179 байжээ. Энэ хошууны хүн амын дотор башгид хэрдэг, мянгад, хотогойд, хигис, цувдаг, тоос, орхид, дархад, боржгин, мудар (матар), онход зэрэг овгууд байдаг байна. Ийнхүү Хотогойд нь ХҮГ зууны сүүл үеэс халхчуудтай хутгалдан сууж, түүхийн элдэв шалтгаанаар өөлд, урианхай зэрэг яс овогтой холилдон бүрэлдэж халхажсан ойрад (хойд) удмын ард болно.

Хотогойдууд олон удаа хэд хэдэн томоохон нүүдэл хийсэн, Халх-Ойрадын хооронд болсон дайнд нэлээд өртөж байж. Дайн тулалдааны төв талбарт нутагладаг, төвөөс ихээхэн зайдуу оршдог байсан Хотогойдууд 20-р зууны эхэн үед олон сүм хийдээ устгуулсан, архивын баримт бичгүүдээ хувьсгалын эсэргүү үзэлтнүүдэд шатаалгасан зэрэг шалтгаануудаас болж тэдний талаарх мэдээлэл ховор, хомс байгаа юм.

### *Хотогойдуудын Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, байр суурь*

18-20-р зууны эхэн үеийн Монголчуудын угсаа соёл, нийгэм аж ахуй, улс төрийн түүхийн хөгжилд хотогойдууд онцгой үүрэг гүйцэтгэсэн гэж судлаачид үздэг. Хотогойдууд нь 17-р зуунаас хойш 20-р зууны эхэн хүртэлх богино хугацаанд Монголын нийгэм-улс төр, соёлын түүхэнд өөрийн гэсэн ул мөрөө үлдээж бахархалт түүхийг бүтээж чадсан ард түмэн билээ. Орос-Монголын харилцааг үндэслэж, Монголын тусгаар тогтнолыг умараас хамгаалах, Орос зүгээс гарах хилийн элдэв маргаан, зөрчлөөс сэргийлэн харуул, өртөөний албыг сайн гүйцэтгэж байв. Ялангуяа 20-р зууны эхнээс Халх Монголчууд тусгаар тогтнолоо тунхаглан зарлах үед уг тэмцэлд хотогойдууд маш идэвхтэй оролцож өөрсдийн хувь нэмрээ оруулж байсан нь баримтаас тодорхой байна. Жишээлбэл, Жалханз хутагт, Ерөнхий сайд Дамдинбазар Монголын баруун хязгаарыг чөлөөлөхөд тэргүүлэн оролцож, монгол төрийн ерөнхий сайдын албыг нэр төртэй хийж байв. Хотогойдууд нь Монголын соёл, шашны түүхэнд тодорхой ул мөрөө үлдээж чадсан олон сайхан жишээ бий. Тухайлбал,

Тэсийн хүрээ, Жалханз хутагтын хүрээ, Мөрөнгийн хүрээ, Бүгсийн хүрээ зэрэг шашин соёлын томоохон хүрээ хийдэд умар зүгийн олон угсаатнуудаас хүрэлцэн ирж шашны ном соёлд суралцан Тува, Буриад зэрэгтээ очиж соёлыг түгээж байсан баримт олон байна.

### **Хотогойд нэрийн учир**

“Хойдын уг эх нь (Хотогойд) Явган мэргэний үр, Хойдын Хутуга бэхийн хүү Иналчид Чингис хаан охин Цэцэйхэнийг өгсөн. Иналчийн ах Төрөлчид Зүчийн охин Хулуйханыг өгсөн” гэж “Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж” зохиолд өгүүлдэг. Хойдууд нэг хэсэгтээ Ойрадыг бараг бүхэлд нь төлөөлсөн байдалтай их нөлөөтэй аймаг байжээ. Тэгэхээр Хойд бол жинхэнэ ойн иргэн буюу ойрадын язгуурын аймаг мөн гэж эрдэмтэд үздэг. Хойд болон Хотогойд гэдэг нэр хэдий үеэс сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэх болсон бэ гэдэг асуулт олны анхаарлыг татдаг. XIII-XIV зууны үед Явган мэргэн нь Дөрвөн ойрадын чуулганы хан болсоны дараагаар Ойрад аймгийн нэрийг Хойд аймаг хэмээн сольж нэрлэсэн гэж судлаачид үздэг бөгөөд Явган мэргэн гэдэг нэр нөлөө бүхий хүн байж байгаад Аригбөх, Хайду нарын тэмцлийн үед алагдсан болох нь нотлогддог. Явган мэргэнээс хойш Хойд аймаг Ойрадын чуулганд голлох аймаг болон нэг хэсэгтээ байжээ. Саган сэцэний “Эрдэний товч”-д “найман мянган хойд” гэж дурьдагдсан байдаг. Мөн Баатар Увшийн “Дөрвөн Ойрадын түүх” хэмээх шаштирт “хойдын их мянган гэдэг улс явсан” гэж бичсэн байдаг. Хотогойд хэмээх нэрийн үүсэл гарал, утга учрыг эрдэмтэд 19-р зууны сүүл үеэс л янз бүрээр тайлбарласаар ирсэн. Тэдгээр эрдэмтдийн судалгааны үр дүнг харьцуулан үзэх нь хотогойд нарын угсаа гарлыг тодорхойлоход бас нэг шижим болох юм. Хотогойд нар 16-р зууны үеийн эцсээс түүхэнд нилээд томоохон байр суурь эзэлж байсан тухай өмнө нэгэнт өгүүлсэн билээ. Хотогойд нэрийн учир хамаадал, үүсэл гаралын талаар эрдэмтдийн дунд үндсэн хоёр чиглэл байна. Үүнд:

а. Хотогойд нь Хото-Гайту буюу монголжсон түрэг гаралтай угсаатан гэж үзсэн ба Г.Н.Потанин уг саналыг анх тавьсан. Тэрээр “... Гайту нь Өмнөд Сибирь хавьд байдаг ба мөн Енисейн мөрний эх Урен голын орчимд өөрсдийгөө Хайдутууд гэж нэрлэдэг омог бий” гэжээ. Мөн Конбаловт Хайдыпар, Кандык, Кастрендэд Кайденг нэртэй овгууд буйг тэмдэглээд Хотогойдыг тэдэнтэй холбон тайлбарлахыг оролдсон байна. Энэ саналыг эрдэмтэн Грумм-Грижимаило дэмжиж Хотогойдуудыг түрэг ястны бүлэгт хамааруулан авч үзжээ. Эдгээр эрдэмтэд энэ саналыг дэвшүүлэхдээ нэрийн учир холбогдлыг хөөж, харин түүнийг бүрэлдүүлж буй овгийн бүтэц зэрэг зүйлийг анхаарсан нь бага юм.

б/. Тэгвэл нэг хэсэг эрдэмтэд Хотогойд хэмээх угсаатны нэр Дөрвөн Ойрад, түүний бүрэлдэхүүнд байсан Хойд аймгаас үүсэлтэй бөгөөд эндэс Хойд+гойд гэдэг нэр үүссэн гэж үздэг. Энэ үзлийг монголын эрдэмтэд хүлээн зөвшөөрч дагасан байна.

16-р зууны сүүлээр Ойрадаас Хойд аймгийн нэг хэсэг олзлогдон нүүн ирж Засагт ханы хойд талаарх халхуудтай холилдон суужээ. Халхууд тэднийг Хойд+гойдууд буюу онцгойдууд зэргээр ялган нэрлэснээс уг нэр

үүссэн гэдэг. Халхуудтай холилдон суух болсон хойдуудыг дөрвөн Ойрадын үндсэн хойдуудаас ялгахын тулд Хойд+гойд, онцгой+хойд гэж нэрлэсэн гэж үзжээ. Нөгөө нэг хэсэг нь Хойдуудыг халхчууд хэл соёл, зан заншил, соёлын хувьд онцлогтой тул өөрсдөөсөө тусгайлан онцгойлж гойдлон тийнхүү нэрлэсэн гэж үзсэн байх юм. Ямартай ч хотогойдуудын нэрийн талаархи хоёр дахь санал нь Хойд аймагтай холбоотой нь ажиглагдаж байна.

Хойд+гайт буюу Хотгайтууд гэсэн нэрээс үүссэн гэж Хотогойдын ахмад настнууд ярилцдаг аж. Гэхдээ уг нэр 18-р зууны дунд үеэр болсон шадар ван Чингүнжавын эхлүүлсэн тэмцэлтэй хоблообтой гэж үзэх эрдэмтэд ч цөөнгүй. Тэд Хотогойдууд Манжийн эсрэг тэмцэл хийж, Зүүнгарын хаан Галдан бошигттой байлдаж, хөрш орших халхчуудад баахан гай тарьсан тул Хойт+гайт нэрийг гуйвуулан хочлож байсан гэж тайлбарладаг. Түүх судлаач Б.Цэрэл “...Хотогойд нэр нь Хойд+гойд, Хойд+гайт ч биш харин Халхын баруун хойд, Засагт ханы хойд талаар нутагласан Хойдуудыг Халхчууд Хойд+хойдууд гэж нэрлэсэн” гэж үзжээ. Ийнхүү эрдэмтэн судлаачид Хотогойд нэрийн [этноним], гарлын талаар янз бүрийн санал таамаг дэвшүүлжээ.

Үүнээс гадна баруун Монголын аман аялгуунд хонийг “хой” буюу “кой” хэмээн нэрлэх бөгөөд хойдууд нь халхын Засагт ханы араар нутаглахад тэд эрхлэх аж ахуйн хувьд хониор нэн баян байсан мэдээ сурвалжид мэр сэр тааралдана. Энэ баримтан дээр үндэслэн “хой” буюу хонь гэсэн үгэнд уугуул аймгийн нэр” хойд”-ыг нийлүүлэн хотохойд хэмээх нэр үүссэн болов уу гэж үзэх эрдэмтэд цөөнгүй бий. Тэд хой+т+хойд=хотохойд хэмээн үүссэн. Хонь бүхий хойд аймгийнхан гэсэн утгатай нэр. Учир нь халхууд угтаа хэл соёл, гарал, үүсэл нэгтэй хойдуудыг зах залган нутаглах болсноор харь хүмүүс мэт гойдлон нэрлэх бололцоогүй. Харин эрхлэх аж ахуйн онцлогоор нь хамаатуулан нэрлэсэн гэж тайлбарладаг. Өдгөө ч тэдэнтэй хил залгаа орших халхууд хонин хотогойдууд хэмээн хочлон нэрлэдэг гэдгийг тэд иш баримт болгодог аж.

## **ХОТОГОЙДЫН ШАДАР ВАН ЧИНГҮНЖАВ**

Хотогойдын шадар ван Чингүнжав 1710 онд одоогийн Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Сангийн далайн Биндэртийн өвөр гэдэг газар Хотогойдын Засаг ноён бэйл Бандийн ууган хүү болон төрсөн.

Энэ үеэр Ар халх манжийн эрхшээлд бүрэн орсон байв. Чингүнжавын дээд өвөг Чингис хааны удмын хиад боржигон овгийн Батмөнх даян хааны отгон хүү Гэрсэнз Жалайр хун тайж ажээ. Ар халх манжийн эрхшээлд орохоос өмнө Гэрсэнз Жалайр хун тайжийн ахмад хөвгүүн Ашихай хун тайжийн 2-р хүү Түмэндарь дайчны ахмад хүү Шолой уваш хунтайж /1567-1627/ Хотогойд аймгийг захирч, Хотогойдууд 1587-1800 он хүртэл Ойрад /зүүн гар улс/ ар халхын хоорондын харилцаанд чухал байр эзэлж байв. Хотогойд нь ар халхын хойд захад Увс, Хөвсгөл нуурын хооронд өргөн уудам нутаг эзэмшиж байв. Газар нутгийн байршлийн хувьд Монголын хаадын



ордноос алс зайдуу байв. Энэ үед оросын хаант улс хил хязгаараа өргөтгөн тэлсээр Хотгойдын нутгийн захад тулж иржээ. Иймээс Хотгойдууд Монголын бусад аймгуудаас түүрүүлж 1616 онд оростой харилцаж эхлэв. Энэ байдлаа ашиглан Шолой Уваш Хунтайж өөрийгөө алтан хан гэж нэрлэн бие даан үйл ажиллагаа явуулдаг байв. Шолой Уваш Хунтайжийн орыг түүний хүү Омбо-Эрдэнэ 1630 онд өвлөн суув. 1655 онд Хотогойдын хаан Омбо-Эрдэнэ хунтайж Манжийн хаанд дагаар орж Халхын баруун гарын хошууны нэгэн засаг ноён болжээ. Омбо-Эрдэнэ хунтайжийг түүний хүү Лувсанринчин залгамжлав. Тэрээр Засагт хан болон Ойрадуудтай тохиролцдоггүй учир Хөх нуурт оргон зайлжээ.

1686 онд Манжийн оролцоотой болсон халхын ноёдын “Заг Байдрагийн Хүрэн бэлчирийн чуулганаар Халхын Засагт хан аймгийн харъяанд Шолой уваш хунтайжийн ахмад хөвгүүн Дай-Эрдэнэ хунтайжийн хөвгүүн Гэндэнг Хотогойдын засаг ноён болгов.” Гэндэн 1694 онд манжид дагаар орж “Төрийн бээл” цол хүртсэн байна. Хотогойдын ноёдоос Гэндэнгийн авга ах Лувсанринчин 1686 онд манжид дагаар орж 1690 онд Галдан бошгот манжийн хаан нарын “Улаан бодон”-гийн тулалдаанд манжийн талд байлдаж байжээ. Ийнхүү Хотогойдын ноёд дээдсээс гурван хүн Манжид дагаар орсон учир бусад нь бүгд манжийн хааны харъяат болов. Гэндэн Бээлийн орыг түүний өргөмөл хүү Бүүвэй Бээл, ач Банди Бээл нар залгамжлав. Банди Бээл 1737 онд нас барж, түүний хүү Чингүнжав эцгийн орыг залгамжлав. Чингүнжавыг засаг ноён төрийн бээл болох үед ар халх дахь манжийн ноёрхол хүчээ авч, Ойрадыг байлдан эзлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх түшиц газар болгох бодлого явуулж байв. Манж нар Чингүнжавыг өөртөө татахын тулд хэргэм зэргээр шагнаж, Засагт хан аймгийн туслагч жанжнаар томилж байв. Гэвч Чингүнжав хэргэм зэрэг, албан тушаалд хууртагдсангүй, манжийн эсрэг тэмцэж байлаа. Хойдын ван Амарсанаа, Хотогойдын шадар ван Чингүнжав, Өмнөд хорчиний эфү Сэвдэнбалжир нар элч довтолгон урьдаас үгсэн тохирсноор Манжийн эсрэг тэмцлээ 1755 онд эхлэж Монгол түмний гурван жилийн эх оронч их тэмцлийг өрнүүлсэн юм. Дараа жил нь Чингүнжавын цэрэг Хиагт, Их хүрээнд бугшсан Манж цэргийг уулгалан дайрч, улмаар тэр жилийнхээ намрын дунд сарын эхээр Их хүрээнд чуулахаар тогтжээ.

Шадар ван Чингүнжав Хан голоос мянган цэрэгтэйгээр алба хаян Халх

нутгаа зорин довтолгож, улмаар манжийг эсэргүүцэн бослого гаргасан ийн учиртай. Түүний эх оронч тэмцлийг Халх түмэн төдийгүй, II Жавзундамба хутагт, Түшээт хан Ямпилдорж, Засагт хан Балдир, Сэцэн хан Манибадир, Сайн ноён Дэчинжав, гүн Дамиран зэрэг нөлөө бүхий хүмүүс дэмжиж, эр цэрэг, унаа хөсөг, зэр зэвсэг, хүнс хоол зэрэг ар хангалтын хэрэгтэй бүхнээр сэлбэн туслаж байв. Ар халхад хүчээ авч буй энэ бослогын тухай дуулсан Манжийн хаан бослогын гол удирдагчийн хүчийг салган ганцаардуулах аргыг сүвэгчлэн, Халхын бүх ноёдод Чингүнжавыг даруй барихыг зарлиг болгож, Улиастайн жанжнаар Чин ван Цэнгүнжавыг томилж, их цэргийг авч Чингүнжавын цэргийг дарж, түүнийг барихыг даалгажээ. 1760 оноос Бүрэн Тэнгэрийг тэтгэсний 16 онд Манжийн хаан “Чингүнжав доорд ардыг дураар тавьж, харуул харж, зүүн гарын хотон ард лугаа худалдаа хийлгэж урианхайн газарт нүүж суухад хүргүүлсэн нь маш осол тул сул үзэшгүй, тэр ч байтугай тусгайлан тушаагаад барьж хүргэхээр ирүүлэх лам Жамцанг хүргэж ирсэнгүй уйлхайлж шалтагласан нь миний хишгийг ихэд үтгээрхжээ” хэмээн түүнийг буруутгасан тухай баримтууд үлджээ.

1757-1758 онд Халхад гарсан эрх чөлөөний зэвсэгт тэмцлийг толгойлсон тул, түүнийг цаазаар аваачжээ. Эрх чөлөөний тэмцэлд босч, харамсалтайгаар ялагдал хүлээн амиа алдсан Чингүнжавт зориулан Хотогойд, Мянгад, Хойд нар 1750-иад оны орчим зохиосон домогт дууг өнөө хүртэл маргалгүй үе уламжлан дуулсаар ирснийг Оросын шинжээч А.М. Позднеев тэмдэглэн авч “Монгол аймгуудын ардын аман зохиолын дээж” хэмээх бүтээлдээ нийтлүүлжээ.

Тэр уулын оройд  
Мандсан чиг нараа  
Тэр бүгдийг тэргүүлсэн  
Шадар жанжин хөөрхий  
Гунан зээрд морийгоо  
Унасан чиг болоосой  
Гурван түмэн цэргүүдээ  
Дагуулсан чиг болоосой  
...Харцага шувууны зулзага нь  
Шибэргэн гүйцэж ниснэ  
Хамгийг дагуулаад мордсон  
Шадар жанжин хөөрхий  
...Үүлэн өнгөтэй хөх нь  
Бээжин хотод сойгоостой  
Үйлэндээ ташуураад мордсон  
Шадар жанжин хөөрхий... гэсэн гуниг харуусал нэвт шингэсэн нэгэн

дуу хоёр зуун жил Хотогойд түмний дунд ам дамжигдан дуулагдсаар байна.

### *Манжийн үеийн хотогойд хошууд...*

Манж нар Хотогойдын шадар ван Чингүнжавын бослогыг дарсныхаа дараа Хотогойдуудыг хуваан бутаргах явдлыг улам эрчимжүүлж, нэмж гурван хошуу байгуулсан байна. Хотогойдууд нь Тоос, Халиучин, Шэжнүүд, Их Хотогойд, Бага Хотогойд, Мянгад гэсэн үндсэн зургаан

отогтой бөгөөд тэднийг бутарган хошуу зохиохдоо ч мөн энэ зургаан отгоор нь хувааж, Чингүнжавын төрлийн хүнд хариуцуулан өгчээ. Энэ үед аль хошуудад ямар отог зонхилсон талаарх мэдээ сэлтийг судласан түүхч С.Чулуун “Дүүрэгч ван Вамбуудоржид их, бага Хотогойд отгийг бүтнээр нь, Тоос отгийн хагастай өгч Дүүрэгч вангийн хошууг, тайж Дашпунцагт Тоосын талыг нь өгч Ахай засгийн хошууг, Доржцэдэн, Цэвэгжав хоёрт Мянгад, Халиучин отгийг өгч Мэргэн засаг, Далай засгийн хошууг тус тус байгуулсан гэжээ.

### ***Хотогойдын хошууд***

Хотогойдууд нь Засагт хан аймагт таван хошуунд хуваагдан Хотогойд таван хошуу хэмээгдэн явжээ.

#### **1. Эрдэнэ дүүрэгч вангийн хошуу:**

Чингүнжавын хошууны гол нутгийг тусгаар тогтнолын төлөөх бослогыг даралцагч Вамбуудоржид Жүн ван цол өргөн захируулсан байна.

#### **2. Цогтой вангийн хошуу:**

Шолой уваши хунтайжийн ахмад хүү Омбо-Эрдэнийн хүү Лувсанринчин, түүний хүү Намринчимбогийн албат нь Цогтоо вангийн хошууны эхлэл болж өгчээ.

#### **3. Ахай бэйлийн хошуу:**

Ахай бэйлийн хошууг 1757 онд Эрдэнэ дүүрэгч вангийн хошуунаас таслан Дорж дай хунтайжийн дэд хүү Гэндэн бэйлийн дэд хүү Тувагийн хүү Дашпунцагийн албат дээр тулгуурлан байгуулсан байна.

#### **4. Далай гүний хошуу:**

Ашихай дархан хунтайжийн дэд хүү Түмэндара дайчингийн хүү Шолой увш хунтайжийн дэд хүү Дорж дай хунтайж, түүний хүү Гэндэн бэйлийн дөтгөөр хүү Шагжаад байгуулсан гавъяаг нь үнэлж Эрдэнэ дүүрэгч вангийн хошуунаас тасдан өгсөн албат нь 1724 оны үеэс Далай гүний хошуу гэгдэх болжээ. Манжийн үед Халхын өрнө замын баруун гарын баруун этгээдийн хошуу хэмээгдэн нутгийн хил нь зүүн зүг Нарийн Дөлбөр, баруун зүг Хар хоргон голын булаг, өмнө зүг Чацарт, умар зүг Ачин булаг тус тус хүрч байв. Богд хаант Монгол улсын үед Засагт хан аймгийн Далай гүний хошуу хэмээн нэрлэгдэж, Өвөр Баруун, Ар баруун, Ар зүүн, Өвөр зүүн гэсэн дөрвөн отогтой байсан байна. Далай гүний хошуу 1911 оны байдлаар 84 өрх, 234 хүн амтай байсан бол 1918 оны И.М.Майскийн мэдээгээр 654 өрх 1848 хүн амтай, 29 сүм хийдэд 735 лам нар шавилан сууж байсан мэдээ байна. 1923-1931 оны үед Хантайшир уулын аймгийн Бүрэнтогтох уулын хошуу хэмээн нэрийдэгдэж байсан бөгөөд 1924 онд Бөгдгөөн хан уулын хошуутай нийлэн 1929 онд Наранжаргалант уулын хошуутай нэгджээ. Энэ хошуу одоогийн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Бүрэнтогтох сум болжээ. Далай гүний хошууг Шагжаг, Доржцэдэн, Цэдэвдорж, Шагдаржав, Доржжав, Төгсдэлгэр, Базаррагчаа, Доржпалам тэргүүтэй ноёд үе улиран захирч байв.

#### **5. Мэргэн гүний хошуу:**

Шолой Увш хунтайжийн 3-р хөвгүүн Лувсандаш Мэргэн дайчингийн ахмад хөвгүүн Увашийн ахмад хүү Цэвэгжавт албат таслан сум үл хүрэх

албаттайгаар нэгэн хошууг 1756 онд байгуулан өгсөн нь Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу юм. Манжийн эрхшээлийн үед Халхын дундад зүүн гарын баруун этгээдийн засаг улсад туслагч гүнгийн хошуу хэмээгдэж байсан зүүн зүгт хар бургас, өмнө зүг цагаан бургас, баруун зүг Чандаган тал, умар ба баруун хойд зүг Их тахил, зүүн өмнө зүг Баянзүрх, баруун өмнө зүгт Сэлэнгэ мөрөн хүрэх нутагтай байв. Богд хаант Монгол улсын үед Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу хэмээн нэрлэгдэж нэг сумтай байв. Хантайшир уулын аймгийн Бөгдгөөн хан уулын хошуу гэгдэж байгаад 1931 оноос Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд нэгджээ. Мэргэн гүний хошууг Цэвэгжав, Батжаргал, Чойсүрэн, Жамбал, Гүндорж, Баянжаргал нар үе улиран захирч байв. Мэргэн гүний хошуу нь нутаг дэвсгэрийн хэмжээ багатай тул “Алд хүрэхгүй нутагтай, арваас илүүгүй албаттай” хэмээн хочлон нэрлэдэг байсан гэнэ.

#### **Төмөрбулаг сумын ард иргэд ба Далай гүн, Мэргэн гүнгийн хошуу**

Ийнхүү Хотогойдууд үүсэн бий болсноосоо хойш түүхэн янз бүрийн шалтгаанаар Монголын олон нутагт суурьшсан бөгөөд Завхан аймгийн Баянхайрхан, Баянтэс, Тэс, Асгат, Нөмрөг, Тэлмэн сумд бүтнээр Түдэвтэй сумын Ойгон нуур баг мөн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Бүрэнхаан, Хатгал, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Их-Уул, Бүрэн, Тосонцэнгэл, Түнэл, Мөрөн, Баянзүрх, Арбулаг, Бүрэнтогтох, Төмөрбулаг сумдад бөөнөөр оршин сууж байна. Мөн түүнчлэн Архангай аймгийн Их тамир, Говь-Алтай аймгийн Баян-Уул, Шарга, Тонхил, Дорнод аймгийн Матад, Халх гол, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Увс аймгийн Баруунтуруун, Зүүнхангай, Хяргас, Малчин, Наранбулаг, Ховд аймгийн Дөргөн, Дуут, Хэнтий аймгийн Хэрлэн, Завхан аймгийн Алдархаан, Шилүүстэй, Цагаанчулуут зэрэг сумдад Хотогойд, Хотогойлог гэх овгууд бүртгэгдсэн байна. “Очир.А, Сэржээ.Ж “Монголчуудын овгийн лавлах” УБ., 1998 тал 20-32” Дээрх овгийн байдлаар бүртгэгдсэн Хотогойдууд нь түүхийн янз бүрийн шалтгаанаар тэдгээр ястны дунд шингэж, улмаар өөрийн уул овгоо мартан аймгийнхаа нэрээр Хотогойд хэмээн овоглож буй бололтой. Энэ баримтаас харахад Төмөрбулаг сумын түүх Далай гүн, Мэргэн гүнгийн хошууны түүхтэй салшгүй холбоотой бөгөөд ард иргэдийн удам судрыг судлахын тулд ч гэсэн энэхүү хоёр хошууны түүхийг эргэн харах шаардлагатай болж байгаа юм. Тодруулбал одоогийн Төмөрбулаг сум Хувьсгалаас өмнө баруун урд талаараа Мэргэн гүний хошуунд харьяалагдаж, нутгийн үлдсэн хэсэг Далай гүний хошуунд багтаж байсан байна.

### ***Далай гүний хошуу***

Манжийн хааны зарлигаар 1694 онд байгуулагдаж, Засаг ноён нь тохоон томилогдсон Хотогойд хошуу нь Засагт хан аймгийн бүрэлдхүүнд багтаж, эртнээс аймагтаа голлох үүрэгтэй байсан гэдэг. Далай гүний хошууны хилийн цэс нь Дашдэрчин уулнаас хойш Бүгсийн голын ар талаар өгсөж Сангийн далайн зах хүрээд, түүний зүүн урд талаар тойрон Асгатын рашааны баруун хойд талаар өрлөж, Онгон уулыг хярлан, Их-Уулын баруун талаар оройлж Хөх Хөтөлийн булангаар Дэлгэр мөрөн гол хүрч, голоор



уруудаж Олон голын бэлчир хүрээд урд нуруугаар дамжин Дашдэрчин уул хүрч байжээ. Далай гүний хошуу дөрвөн багтай байжээ. Өвөр баруун баг нь Сангийн далайн Сантаас нааш Шонхортын өвөр, Бургуул, Дааган, Бүгсийн хүрээнээс дээших газар. Төв нь Бургуулийн дуган хавьд, Өвөр зүүн баг нь Бүгсийн хүрээнээс доошх газар, төв нь Тээлийн дуган хавьд, Ар зүүн баг нь Төмөртэйгээс доош Мөрөнгийн сав нутаг Жилжиг, Цагаан бургас ордог. Төв нь Зосын дэнжийн дуган, Ар баруун баг нь Төмөртэйгээс дээш Могой, Загзуу, Хөх Хөтөл хүртэлх газар, төв нь Загзуугийн дуган хавьд байв. Дээрх зохион байгуулалтаас үзэхэд Далай гүний хошууны ихэнх нутаг өнөөдрийн Төмөрбулаг сумын нутаг дэвсгэрийг бүрдүүлж байгаа юм. Далай гүний хошууны ард иргэд Тогоруутан, Оймод, Халиучин, Бичээчийнхэн, Хэрдэг, Мянгад, Онход, Дайчууд, Баргууд, Зэлмэн, Урианхай гэх мэт олон омогт хуваагдаж байжээ. Далай гүний хошуу үүссэн цагаасаа эхлэн багийн зохион байгуулалттай болж, тус бүртээ захирагчтай байсан бөгөөд Өвөр зүүн баг нь гар урчууд сайтай учир эмээл, гэрийн мод цоож, гоёлын зүйл урлаж, хүрээнд оруулан зардаг байсан гэнэ. Ар зүүн баг нь анчид сайтай, тэр ч бүү хэл тусгай хүмүүсээр халиу маллуулж, бас агнадаг байжээ. Харин ар баруун баг нь газар тариалан түлхүү эрхлэдэг, Өвөр баруун баг нь адуу үхэр сайтай байсан тухай түүхийн зарим сурвалж бичигт тэмдэглэгдэн үлджээ

Далай гүний хошуу захирагч ноёдын удам судрыг XIII зуунаас эхтэй гэж үздэг. Батмөнх даян хаан (1464-1517) нь Мандуул хааны дүү Баянмөнх жононгийн хөвгүүн бөгөөд Чингис хааны 15-р үеийн ач, 7 настайдаа 1470 онд хаан ширээнд сууж, Монголын түүхэнд хамгийн олон жил буюу 47 жил хаан төр барьсан байна. Даян хааны 11 хөвгүүний отгон хөвгүүн нь Гэрсэнз жалайр хунтайж, түүний ахмад хөвгүүн нь Ашихай дархан хунтайж, түүний дэд хөвгүүн нь Түмэндарь дайчин, түүний ахмад хөвгүүн нь Шолой Убаш хунтайж, түүний 3 дугаар хөвгүүн Дорждай ноён, түүний ахмад хөвгүүн бэйл Гэндэн, түүний 2 дугаар хөвгүүн гүн Сунгарав, түүний

4 дүгээр хөвгүүн гүн Шагж (Шагжаабаатар) гэж бичигдсэн байдаг. Далай гүний хошуу нь угтаа Шагжаагийн “Засаг улсад туслагч гүн” цол олгосон байдаг.

*Далай гүний хошууны ноёдын хэргэм зэрэг залгамжилсан байдлыг жагсаан үзүүлбэл:*

1. Шагж нь 1724-1737 онд хэргэм зэрэг залгамжилж, Шадар ван Чингүнжавын хошуунд захирагдсан сул гүн яваад 1737 онд бие өвчилсөн учир өөрчилжээ.
2. Доржцэдэн (Шагжийн ахмад хөвгүүн, Засаг улсад туслагч гүн байсан) 1737-1764 онд хэргэм зэрэг залгамжилжээ.
3. Цэдэвдорж (Доржцэдэнгийн ахмад хөвгүүн, Засаг улсад туслагч гүн байв) 1764-1803 онд хэргэм зэрэг залгамжилжээ.
4. Шагдаржав (Цэдэвдоржийн ахмад хөвгүүн, Засаг улсад туслагч гүн байв) 1803-1848 онд хэргэм зэрэг залгамжилжээ.
5. Доржжав (Шагдаржавын 4-р хөвгүүн, Засаг улсад туслагч гүн байв) 1848-1859 онд хэргэм зэрэг залгамжилжээ.
6. Төгсдэлгэр (Тө гүн) (Доржжавын 4-р хөвгүүн, Засаг улсад туслагч байв) 1861-1886 онд хэргэм зэрэг залгамжилжээ.
7. Базаррагчаа (аав жанжин ноён) 1886-1915 онд хэргэм зэрэг залгамжилж, Төгсдэлгэрийн ахмад хөвгүүн, Засаг улсад туслагч гүн, Богд хаанаас 1911 онд түшээ гүнгийн зэрэг үе улиран Далай цол шагнав.
8. Бага жанжин ноён Доржпалам (Базаррагчаагийн ахмад хөвгүүн, Засаг улсын түшээ гүн) 1915-1922 онд хэргэм зэрэг залгамжилжээ.
9. Содномванчиг (Базаррагчаагийн 2-р хөвгүүн, Засаг улсад туслагч гүн) 1922-1923 онд хэргэм зэрэг залгамжилжээ.

1724 онд бий болгосон Засагт хан аймгийн цэргийг захирах туслагч жанжны тушаалд Далай гүний хошуу ноёд Цэдэвдорж (1785-1803), Гүн Базаррагчаа (1912-1915), Гүн Доржпалам (1918-1920) нар тохоон томилогдон ажиллаж байв.

Содномванчиг нь Далай гүний хошууны сүүлчийн ноён бөгөөд 1923 онд засаг ноёдын ёсыг устгахад Хошууны засаг даргаар сонгогдож байжээ.

Содномванчиг ноён Ховдод цэргийн сургуульд явж суралцсан боловч биеийн эрүүл мэнд муудаж буцаж ирсэн бөгөөд бичиг, цэргийн эрдэмд сайн, түвшин төлөв зантай энэ ноён нэгэн үе аймаг, улсын шүүхэд эх зохиогч -бичээч зэрэг алба хашиж байгаад 1932 онд өвчний учир таалал төгсөж, шарилыг нь Талбулагт оршуулсан гэдэг.

Содномванчиг буюу нутгийнхны нэрлэж заншсанаар Сомоо ноёны хатан Цагаан овогтой Аюушаас 1930 оны төмөр морин жилд төрсөн хүү Дуйнхаржав нь Далай гүний угсаа залгамжилсан ноёдын сүүлчийн удам угсааны ганц хүн билээ.

Тайж, ноёдын удам судраас жийрхэн цэрвэж байсан үеийн шаардлагаар Дуйнхаржав нь хойт эцэг Даньдгайсүрэнгээр овоглож, сургууль соёлын мөр хөөх боломжтой болж, олон жил хууль, шүүхийн байгууллагад идэвх зүтгэл гарган ажилласныг үнэлж төр, засгаас “Хөдөлмөрийн хүндэт медаль” -аар 2 удаа, ойн медалиуд, хуулийн тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнажээ.

## Далай гүний хошууны Бүгсийн хүрээ

### Бүгсийн хүрээ. Дашгэндүнжамбалин хийд

Засагт хан аймгийн Далай гүний хошуунд 17-р зууны дунд үеэс тус хошууны өвөр зүүн багийн Дэмчигжав тэргүүнтэй хэдэн лам гомнамжин гэдэг хурлыг үе үе хурж байсан гэдэг. Тухайн үед олон газраар явж юм үзэж ном эрдэм сурсан Шагжбаатар гэдэг нутгийн хүн Баруунзуу /Төвд/-аас зурмал, цутгамал олон бурхан, ном судрууд залж ирж, Дэмчигжав тэргүүтэй лам нарын хурал хурж байсан гэрт байрлуулан залжээ.

Шагжбаатар бол нутаг усандаа шарын шашин дэлгэрүүлэхэд буянтай үйлс бүтээсэн төдийгүй Засагт хан аймгийн Далай гүний анхны ноён болж байсан түүхэн хүн. Төдөлгүй Бүгсийн голын сав газар Жаргалантын амнаа /Хожим жасаа толгой гэж нэрлэх болсон газар/ цогчин дацан байгуулж цогчин хурал хурж эхэлсэн байна. Ийнхүү гал луу жил буюу 1736 онд Бүгсийн хүрээ гэж алдаршсан Дашгэндүнжамбалин хийд үүсжээ. Одоогийн Төмөрбулаг сумын төвийн хойд талд дээрх Жасаа толгой гэдэг газар байдаг нь ном жасаа хурж эхэлсэн хүрээний түүхтэй холбоотой бөгөөд мөн энэ орчинд хошуу тамгын газар байдаг байсны учир “тамгын жалга”, “тамгын дэнж” ч хэмээн нэрийдэж байв.

Шинэ үүссэн цогчин хийд тэргүүн хамбаараа Дэмчигжав ламыг өргөмжилжээ. Энэ бүс нутагт шарын шашин дэлгэрэхэд бурхан хамба хэмээн алдаршсан энэхүү тойн Дэмчигжав лам томоохон үүрэг гүйцэтгэжээ. Цогчин дацан нь сүсэгтнүүдийн дэмээр гэр дуганаа модон дуганаар сольж, бурхан тахил, лам нарын тоо аажимаар нэмэгдэж байв. Түүхэн хөгжлийн явцдаа Дашгэндүнжамбалин хийд хошуу нутгийн хил дээс дотроо хоёр удаа буйр сэлгэн нүүж Хаахайн сайраас Чандмань Цогбадрах уулын өвөр бие Тал булгийн аманд Бүгсийн голын дэнж дээр суурьших болсноор Бүгсийн хүрээ хэмээн алдаршжээ. Энд хүрээ суурьшаад хүрээний дунд цогчин дуганыг голлуулан түүний зүүн талд чойрын, баруун талд жүдийн дуганууд тэдгээрийн ар эгнээнд баруун талаасаа мамбын сахиусны, майдарын, диваажингийн, дуйнхорын дугануудыг байрлуулан анхны найман дуганыг босгожээ.

Хүрээний төв дунд байрласан дээрх сүмүүдийг “Дотуур хүрээ” гэж нэрлэж байв. Энэ дотуур хүрээнээс дөрвөн зүг рүү хүрээний гаднах гороо хүртэл өргөн гудамж гаргаж хүрээг дөрвөн хэсэгт хуваан хэсэг тус бүрт жасуудын болон лам нарын байрлах хашаа байшингууд байжээ. Хүрээний эргэн тойрны дэвсгэр газрыг гадуур хүрээ гэж нэрлэнэ. Хүрээг ноёны, ламын, хамбын, дуйнхорын гэж дөрвөн аймаг болгон хувааж аймгийн дугануудыг аймаг тус бүрийн дэвсгэрт босгожээ.

Ноёны аймагт хошууны өвөр зүүн багийн, ламын аймагт ар баруун багийн, хамбын аймагт өвөр баруун багийн, дуйнхорын аймагт ар зүүн багийн лам нар тус, тус сууж байв. Хүрээний сүм дуган дацан хурал жилээс жилд нэмэгдэн зохион байгуулалтын хувьд өргөжиж, 1930-аад оны үед 15-н сүм дуган, 3 суварга, маанийн 20 гаруй том хүрд, 16 жасын байшинтай, ном барлах бархан, лам хуваргуудын суух 200 гаруй хашаа байшин бүхий

томхон хүрээ болсон байжээ. Хүрээний лам хуваргуудын тоо ч өсч XIX зууны сүүлч XX зууны эхэн үеэр нийт лам хуврагын тоо 1000 гаруй болж байсан байна. Зөвхөн 1930-аад оны үед 800-гаас 900 лам энэ хүрээнд шавилан сууж байв. Хүрээ нь сүсэгтэн олны өргөл айлтгал жандагийн хөрөнгөөр ихээхэн бэхжиж хөрөнгө мал арвижиж байлаа.

Хүрээний 16 жасаас хамгийн баян нь диваажингийн жас байсан бөгөөд 2000 гаруй хонь 300-аад бод малтай байсан ба бусад жасууд нь 500- с дээш толгой малтай болсон байв. Дашгэндүнжамбалин хийд анх байгуулагдсан 1735 оноос 1938 оныг хүртэл 203 жилийн дотор 20 хамба үе залгамжлан сууж байжээ. Өвөр зүүн багийн харьяат, бурхан хамба хэмээн алдаршсан Дэмчигжав хамба хамгийн эхний хамба нь байсан бол хамгийн сүүлчийн хамба нь ар зүүн багийн харьяат Да хүрээний Дашчоймболын гавьж Галсанзундуй хамба байжээ.

## Цогчин дуган

Цогчин дацангийн тэргүүлэх бүрэлдхүүн нь тэргүүн хамба лам, цорж лам, даа лам нараас гадна аймаг бүрээс томилогдсон дөрвөн ловон лам, дөрвөн дэмч, цогчны хоёр гэсгүй, хоёр ширээ унзад, аймаг бүрээс суусан найман гүрэм уншигч нараас бүрэлдэж ажиллах бөгөөд тэд зөвлөлдөн хүрээний бүх ажлыг зохицуулж байв. Цогчин өдөр бүр байнгын тогтмол хуралтайгаас гадна жил бүрийн өвөл зун тус бүр найм хоног цогчин “Эхийн хурал” хурж, 14, 15-ны өдрийн их ерөөлөөр номоо дуусгадаг байж. Мөн жилд хоёр удаа Дорчин гэдэг хурал хурж сор зална. Жил бүрийн зуны дунд сард маанийн бүтээл, зуны адаг сард гэлэн, гэцэлүүдийн 45 хоногийн хайлан хурлууд болж байв. Мөн зуны эхэн сард шунхан барын ганжуур хурж байжээ.

## Чойр дацан

Гандандаржаалин. 1831 онд байгуулагдсан энэ дацанд лянх домьг зуны адаг сарын шинийн 3-нд, лхав домьг намрын адаг сарын 22-нд, лам чойм зодыг өвлийн ихэн сарын 25-нд, жүс домьг өвлийн дунд сарын 15-нд хурдаг байжээ. Мөн энэ дацанд жил бүрийн зун гавжийн дамжааны зургаан өдрийн их хурал болж, гурван хүн гавжийн дамжаа барьдаг байв. Чойрын гол сахиус нь Гомбо, Янсан, Ядам бурхад байв.

## Мамба дацан

Пунцагшампалин. 1864 онд байгуулагдсан Мамбын гол шүтээн нь Оточ, Авид бурхан ба гол сахиус нь дамжин байжээ. Тус дацангаас Гэндэн, Пэрэнлэй, Шадав, Лувсан, Сандан нарын олон маарамбууд төржээ.

Дуйнхар-Ивамдиганчойнхорлин. Тус дацан 1843 онд байгуулагдсан одон орон зурхайн ухаан судалдаг байжээ. Хаврын адаг сард Сачиг гэдэг томоохон хурал хийж дуйнхорын бурхныг гайхамшигтай урлан, жанхар хийж бүтээгээд дүлцэн болгож Бүгсийн голын усанд өргөдөг байж. Энэ дацангаас Лувсандаржаа зээрэмбэ, Шанж зээрэмбэ нараас гадна Очир, Загд, Төмөр, Жадамбаа зэрэг олон арван зурхайчид төрж гаржээ.



## Жүд дацан-Шадавдаржалин

1848 онд байгуулагдсан. Жүдийн дацанд агийн ухааныг сайн судалсан, Чойрын гүн ухааныг дүүргэж гавж болсон лам нар аграмбын дамжаа барьж байв. Жүд дацангаас Намжил, Гүржав, Дамба, Данзан зэрэг олон аграмма төржээ.

### Диваажин-Ганданпилжээлин

1876 онд байгуулагдсан, Жамсран бурхан тахиж, Найданжүдэг чог хурдаг байжээ.

### Майдар-Ганданчойнхорлин

1903 онд Лүндэг хансар лам санаачлан байгуулсан. Энд Майдарын хурлыг улирал бүр, мөн Жамбын чого, Бурхан багшийн чого, шамбалын ерөөл зэрэг олон ном хурдаг байв.

### Гүнрэг-Гандансэвжидлин

1907 онд байгуулагдсан. Гүнрэг бурхныг тахиж, улирал бүр Гүнрэгийн хурал хурна.

### Намжлан-Хансарлин

1918 онд Жамсран шанзоб лам санаачлан бүтээсэн, Энд цагийн хурал хурж Улаан сахиус, Жамсран тахидаг байжээ.

### Гандан-Шунсран сүм

1912 онд уулын Лүндэг хамба бүтээлгэсэн ба цагийн хурал хурна,

### Гол сахиусны дугана

Энэ сүмд Далай гүний хошууны гол сахиус Дамжин чойжил бурхныг залж тахина. Өдөр бүр сахиусаа тахихаас гадна намрын эхэн сарын 7,9, өвлийн адаг сарын 27.29-ний өдрүүдэд сахиусын их тахилгын хурал хийдэг байжээ.

## Дөрвөн аймгийн сүмүүд

Аймгуудын хурал улирал бүрт тус, тусын аймагт харьяалагдсан бүх лам нар оролцож хийнэ. Өвлийн дунд сард аймаг тус бүрт даншигийн хангал хурдаг бөгөөд мөн “Арван хангал” бурхдыг тахиж 3 өдрийн хурал хурна, Өвлийн адаг сарын битүүний оройгоос Балданлхам бурхныг шөнийн турш тахиж хоноод шинийн нэгний өглөө үүрээр Цэдэр хурж тэндээ золгодог байв. Тус хүрээнд зуны дунд сарын шинийн 3-нд 108 баг бүхий бүрэн хэмжээний цам гардаг байсан ба өвлийн эхэн сард сор залдаг байжээ. Бас жил бүрийн намрын эхэн сарын 15-нд Майдар эргэх ёслол болж байв. Хүрээний дацан сүм дуган бүрт Энэтхэг, Төвд болон өөрийн урчуудын урласан уран чамин хийц бүхий олон арван бурхад байжээ. Мөн дуган сүмүүд нь гадна талдаа алтан шармал ганжир, бодь гөрөөс, хонхнууд дотор талдаа торго хоргой дурдангаар хийсэн дүг, лавир зэрэг уран гоёмсог зүйлсээр чимэглэгдсэн байв. Бүгсийн хүрээ нь их хэмжээний ном судрын өв сантай байжээ. Чойрын дацанд Нартан барын Ганжуур 108 боть, Данжуур 242 боть, Цанидын таван гүн ухааны судрууд Жүдийн дацанд аг, тарнийн, Мамбын дацанд анагаах ухааны олон ном судрууд залагдаж байв. 1930-аад оны үеэс эхэлсэн нам төрийн бодлого шийдвэрээр сүм хийдийн оршин тогтнох байдал улам бүр хүндэрч 1931 оны намраас



Бүгсийн хүрээний мяндаг тушаалтан зарим лам нарыг баривчлан, сүм дуган дацангуудыг битүүмжлэн хурал ном хурах боломжгүй болжээ. Харин 1932 оны сүүлчээс шинэ эргэлтийн бодлого хэрэгжиж эхэлсэний үр дүнд тус хүрээний үйл ажиллагаа сэргэж эхэлжээ. Гэвч 1937 оноос дахин сүм хийдийн эсрэг харгис арга хэмжээ авч явуулсны үр дагавраар лам нар олноороо баривчлагдан, дацан хурлууд бүр мөсөн хаагджээ, 1938 оны 11-р сард тус хүрээнд үлдсэн цөөхөн лам нар Домын жавчаа гэдэг хурлыг сүүлчийн удаа хураад сүм дуганаа бүрэн хаажээ, Эзгүй хоцорсон хүрээний сүм дуган, эд хогшлыг хураан зөөж, бурхан, ном судар, тахилын хэрэглэлийг эвдэн шатааснаар 1938 оны эцэс гэхэд 200-аад жилийн түүхтэй Бүгсийн хүрээ мөхжээ. 1990 оноос Бүгсийн хүрээг дахин сэргээх нөхцөл бүрдсэн ба энэ үеэр Бүрэнтогтох, Төмөрбулаг сумын ард олны дэмжлэгээр иргэн С.Сэнгээ, Агваан, О.Төмөрбаатар, С.Доржсүрэн, Б.Дашзэвгэ нарын зохион байгуулснаар 1992 оны 8-р сарын 12-нд хуучин Бүгсийн хүрээний Цогчин дуганы туурин дээр Цогчин Дашгэндүнжамбалин сүмээ нээж цогчин хурал хуржээ, Нээлтийн анхны хуралд урд үед Бүгсийн хүрээний лам байсан Д.Дамба /ловон ламаар/, С.Готов /унзадаар/ сууж Мятав, Сосор, Гэндэн, Мандшир, Дашдаваа, Цагаан, Дамдинжав, Сэнгээ нар ном хурж байжээ. Гэвч сүүлийн жилүүдэд байнга сууж ном хурах ламгүй, сүсэгтэн олны хөлөөс зайдуу, дуганы халаалтын асуудал шийдэгдээгүй зэргээс үйл ажиллагаа нь зогсож, зөвхөн жилийн дүйцэн өдрүүдэд 1-2 удаа Мөрөн болон ойрын сумдаас лам нар цуглан хурал хурах болжээ. Одоогийн байдлаар энэхүү хүрээний туурь буюу сэргээгдсэн Цогчин сүм нь Төмөрбулаг сумын 4-р багийн нутаг сумын төвөөс баруун тийш 30 орчим км-т Тээл багийн төвийн доод талд Ганц модны булан гэдэг газар Бүгсийн голын хойд эргээс 800 орчим метрт байна. Туурийн хойт талд Арслант овоо, зүүн талд Дашдэрчин уул, баруун талд нь Дөшхайрхан уул

бий. Уг Цогчин сүмийн өмнөд талаас авсан хэмжилтээр хойд өргөрөгийн N 490 17.60' зүүн уртрагийн E 0990 55.195' солбицолд байна. Тууриас зүүн хойш 300 орчим метр газарт Дашдэрчин уулын өвөр бэлд 3 метр өндөр бодь суварга босгосон ба шинэ сүмийн зүүн урд 30 орчим метр зайд 1,5 метр өндөр пайлуур чулуун дээр Бүгсийн хүрээг сэргээсэн 1992 оны 08-р сарын 12-ны үйл явдлыг худам монгол бичгээр тэмдэглэжээ.

Оршин тогтносон 200 гаруй жилийн хугацаанд Дашгэн-дүнжамбаалжин хийдэд дарах 20 хамба залгамжлан суужээ.

1. Дэмчигжав хамба (анхны хамба) Төвдөд суралцсан Өвөр зүүн багийн хүн

2. Балжий хамба - Өвөр зүүн баг
3. Лувсангомбо хамба - Өвөр зүүн баг
4. Гунгаадорж хамба - Өвөр зүүн баг
5. Лувсаншарав хамба - Ар баруун баг
6. Агвааншарав хамба - Өвөр зүүн баг
7. Зундуй хамба - Өвөр баруун баг
8. Ламжав хамба - Өвөр зүүн баг
9. Хайдав хамба - Өвөр зүүн баг
10. Лувсандаржаа хамба - Ар баруун баг
11. Лүндэв хамба - Ар зүүн баг
12. Лувсанбалдан хамба - Ар баруун баг
13. Ишжамц хамба - Өвөр баруун баг
14. А.Лхасүрэн хамба - Бүгдгээний хошуу
15. Чогдон хамба - Өвөр зүүн баг
16. Шаравжамц хамба - Өвөр зүүн баг
17. Загд хамба - Өвөр баруун баг
18. Балжир хамба - Өвөр зүүн баг
19. Лодон хамба - Өвөр зүүн баг
20. Галсанзунлуй хамба - Ар зүүн баг

Багуудын нутгийн тойм гэвэл, Өвөр, баруун баг нь Сангийн далай, Асгат, Шонхортын Өвөр, Бургуул, Дааганаас Бүгсийн хүрээ хүртэлх нутаг, төв нь Бургуулийн дуган байсан.

Өвөр зүүн баг нь Бүгсийн голын ар, өвөр тал хүрээнээс доошлоод Олон голын бэлчир хүрнэ. Төв нь Тэлээгийн дуган хавьд байсан.

Ар зүүн баг нь Булгийн дөрөлжөөс доош Төмөртий, Цагаанбургас, Жилчиг хүртэл, Төв нь Зостын дэнж.

Ар баруун баг нь Булгийн дөрөлжөөс дээш Могой, Загзуу, Хөх хөтлийн булан, Хөх цав хүрнэ. Төв нь “Загзуу”-гийн дуган хавьд тус тус байжээ.

### ***Мэргэн гүний хошуу***

Шолой Увш хунтайжийн 3-р хөвгүүн Лувсандаш Мэргэн дайчингийн ахмад хөвгүүн Увашийн ахмад хүү Цэвэгжавт албат таслан сум үл хүрэх албаттайгаар нэгэн хошууг 1756 онд байгуулан өгсөн нь Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу хэмээн нэрлэгдэж байсан тухай дээр дурьдсан. Энэ хошууны газар нутаг: Зүүн зүгт Хар бургас, өмнө зүг Цагаан бургас, баруун зүг Чандаган тал, умар ба баруун хойд зүг Их тахил, зүүн өмнө зүг

Баянзүрх, баруун өмнө зүгт Сэлэнгэ мөрөн хүрэх нутагтай байв. 1757 онд байгуулагдсан гэх Мэргэн гүний хошуу нь Манжийн ноёрхлын үед (1681-1911) Халхын өрнө замын дундад зүүн гарын баруун этгээдийн хошуу гэж нэрлэгдэж байжээ. Богд хаант Монгол Улсын (1911-1921) болон Ардын засгийн анхны жилүүдэд “Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу” хэмээн нэрлэж, нэг сумын хэмжээнд хүрэхгүй бага хошуу байсан учир цэргийн албанд таван эрийг дайчлан гаргаж байв.

Хошууны ноёдын удам угсааг түүх шастирт дараах байдлаар тэмдэглэжээ. Гэрсэнз жалайр хунтайжийн ахмад хөвгүүн Түмэндарь дайчин, түүний ахмад хөвгүүн Шолой Убаш хунтайж, түүний 3 дугаар хөвгүүн Хантуудай (Дорждай ноён), түүний хөвгүүн бэйл Гэндэн (Лувсан дай ноён) түүний 2 дугаар хөвгүүн Сунгарав, түүний хоёрдугаар хөвгүүн Лувсандаш мэргэн дайчин, түүний ахмад хөвгүүн дөтгөөр зэргийн тайж Уваш. түүний ахмад хөвгүүн гүн Цэвэгжав гэж тэмдэглэн үлдээжээ.

***Мэргэн гүний хошуу байгуулагдсан үеэс хошуу захирч байсан ноёдын нэр, хэргэм зэргийг жагсаавал,***

1. Цэвэгжав 1756 -1757 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Урианхай нартай байлдаж яваад суманд өртөн шархдаж өөд болсон. Манжийн хаан гавьяаг нь үнэлж, гүн цолоор нэхэн шагнажээ.

2. Батжаргал 1757 - 1781 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Цэвэгжавын ахмад хөвгүүн бөгөөд Засаг улсад туслагч гүн залгамжилжээ. Тэрбээр сайн задач, хур бороо оруулж, ган тайлдаг арга ухааны номтой хүн байсан гэдэг.

3. Чойсүрэн 1781- 1807 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Тэрбээр Батжаргалын ахмад хөвгүүн бөгөөд Засаг улсад туслагч гүн залгамжилжээ.

4. Жамбал 1807-1854 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Чойсүрэнгийн ахмад хөвгүүн, Засаг улсад гүн залгамжилсан, 1852-1853 онд Засагт хан аймгийн цэргийн туслагч жанжин байжээ.

5. Гунгаадорж 1854-1878 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Жамбалын ахмад хөвгүүн, Засаг улсад туслагч гүн залгамжилжээ.

6. Баянжаргал 1878-1922 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Гунгаадоржийн ач хөвгүүн, Засаг улсад туслагч гүн залгав. 1909-1912 онд Засагт хан аймгийн цэргийг захирах, туслагч жанжны тушаалд байв. 1911 онд Богд хаанаас Түшээ гүнгийн зэрэг үе улирах мэргэн цолоор шагнагджээ.

7. Лут-Очир 1822- 1923 онд хэргэм зэрэг залгамжилжээ. Базаррагчаагийн хөвгүүн, тайж хошуу ноёныг залгамжилжээ.

### ***Мэргэн гүний хошууны Бүгдгээний хүрээ***

Хөвсгөл аймаг Төмөр булаг сум Бүгдгээний хүрээ нь хуучин Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу буюу одоогийн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын 3-р багийн нутаг, сумын төвөөс баруун хойш 53 км газарт Бүгдгээний эх хэмээх газар уг хүрээ төвхнөж байжээ. Хүрээний туурийн хойд талд Хан уул өмнөд талд нь Индэрт уул баруун талд нь Бүгдгээний гол урсана. Тууриас гол дагуу дээш гурван километр Чандмань уулын оройд тахилгат лусын овоо бий. Бүгдгээний хүрээний үүсэл гарлын талаар Засагтхан аймгийн хүрээ хийдийн түүхэнд дараах байдлаар тэмдэглэсэн байна. Тэнгэрийг тэтгэсний 22-р (1757) онд Цогчин хурлыг үүсгэн тогтоожээ.

Сайшаалт Ерөөлтийн 10-р (1805) онд гүн Чойсүрэнгийн үед хайлан хурал, Төр- Гэрэлтийн 3-р (1823) онд гүн Жамбалын үед Майдарцам, Чоймпрол Мамбын хурлыг тогтоожээ. Бүрэн засагчийн 5-р (1866) онд гүн Гунгаадоржийн үед Гүнрэг хурал үүсгэн тогтоож, Бадаргуулт төрийн 11-р (1885) онд гүн Баянжаргалын үед Ганжуур хурал, Доотүдэв хурал, олноо өргөгдсөний 8-р (1918) онд Цанид хурлыг тус тус үүсгэн байгуулж, байжээ. Одоо уг хүрээний туурин дээр 5-6 сүм дуган байгууламжийн туурь байна. Бүгдгээний хүрээ нь Балданлхам сахиустай байсан бөгөөд нийт 200 гаруй ламтай 108 цам гарч Майдар, Ганжуур эргэдэг, ойролцоох Бүгсийн хүрээ, Жалханзын хүрээ, Мөрөнгийн хүрээнүүдтэй ном хаялцдаг эрдэм чадалтай лам нар олонтой байжээ. Тус хүрээ нь 1937 оны хаврын сүүл зуны эхээр хаагдаж томоохон лам нар нь баривчлагдан, доод, дунд лам нарыг нь хүчээр хар болгосноор хүрээ хийд эзгүйрэн хаагдаж улмаар 1940-өөд оны эхээр хоосорсон дуган сүмийг нураажээ. Бүгдгээний хүрээ нь Бүгсийн хүрээний дагуур (харьяа) хүрээ учир Бүгсийн хүрээний хамба харьяалдаг байжээ.

### **Далай гүний хошуу, Мэргэн гүний хошууны нийгэм эдийн засгийн байдал**

Далай гүний хошуу газар нутгийн хувьд өргөн, хүн ам харьцангуй олонтой ч амьдрал ахуй хүнд байжээ. Хотогойдуудын тэмцэл хөдөлгөөнийг дарсныхаа дараа Манжийн хаанаас бодлогоор алба гувчуурыг их татаж байсан гэдэг мэдээ түүхэнд бий. Улиастайн манж амбан өөрийнхөө хэрэглэлд өдөр бүр 30 жин чимэг, 30 ширхэг хурганы арьс, авдаг болж, үүнийг гүйцээж өгөхгүй бол оронд нь өдөр бүр 60 лан мөнгөний торгуул оноож байсан гэдэг. Далай гүний хошуу үүссэн цагаас эхлэн багийн зохион байгуулалттай болж тус бүртээ захирагчтай байсан бөгөөд Өвөр зүүн баг нь гар урчууд сайтай учир эмээл, гэрийн мод, тооно, цоож, гоёлын зүйл урлаж, албан татвар, өр төлбөр өгөх, бусдад худалдах нь давуутай байв. Жишээ нь Агт, Дөшийн голынхон




“гяраг” бүсийг онцгой сайн нэхэж хүрээнд оруулан худалддаг байв. Ар зүүн баг нь анчид сайтай, тусгай хүмүүсээр халиу маллуулж, бас агнадаг байснаас “халиучны баг” гэж нэршсэн, алба гувчуур, арилжаа худалдаанд ангийн үс зонхилж байжээ. Ар баруун баг нь газар тариалан түлхүү эрхэлдэг, Өвөр баруун баг нь адуу үхэр гэсэн бод мал сайтай байсан учир энэ онцлогтоо түшиглэн хошууны албан татвар, худалдаа наймаанд амуу тариа, адуу үхэр голлон өгч байв. Багийн захирагч нар нь хошуу тамга, багийн орлого, зарлага, албан татвар авч, хошуу тамганд хураалгах, албан өртөөний ажил хариуцахаас гадна түшмэл, бичээчийн хэрэгсэл бэлтгэх, пүүсийн өр төлбөр төлүүлэх, шашны хурлын өргөл барьц, манж цавын зүйлийг хураах зэрэг ажлыг хариуцаж, үүнийгээ тулган тушаах аргаар хэрэгжүүлдэг байв. Мөн тушаал биелүүлэхгүй бол банздах, жанчих эрхтэй

байжээ. Далай гүний хошууны зохион байгуулалт гэвэл 4 багтай байжээ. Гэвч Улсын төв архивт дээрх хоёр хошуутай холбоотой баримт мэдээлэл тун ховор байх бөгөөд Даашинхүүгийн пүүст өр тавьсан тухай Далай гүний хошууны ноёны өрийн бичиг, мөн Мэргэн гүний хошууны ноён Баянжаргал тус пүүст өр тавьж, буцааж төлсөн тухай баталгааны бичиг гэх мэт тун цөөхөн зүйл хадгалагдаж байна. Даашинхүүгийн пүүс өрөө авахдаа “Хаврын бариа”, Намрын өр төлбөр” гэж жилд хоёр удаа авдаг, өрх бүрээс жилд 2 төлөг авдаг байсан гэдэг тоог зохиолч Ж.Жүгдэрнамжил өөрийнхөө номонд дурьдсан байна.



Архивт байгаа дээрх бичгүүдийг сонирхуулах үүднээс хуулбарлаж авсан бөгөөд энд Далай гүний хошууны ноёны тамганы дардас үлдсэн нь сонирхол татаж байсан юм.



## Ардын засгийн үеийн Төмөрбулаг сум

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

# АРДЫН ЗАСГИЙН ҮЕИЙН ТӨМӨРБУЛАГ СУМ

/1918-1930/

Үндэсний эрх чөлөөний хувьсгал гарч, 1921 онд Ардын хувьсгал ялснаар Монголчууд олон зуун жилийн дарлал мөлжлөгөөс салж, шинэ амьдралтай золгож, Монголын нийгэм тэр чигээрээ өөрчлөгдөн шинэчлэгдсэн. Энэхүү түүхэн өөрчлөлт, шинэчлэлт Хотогойдын хошуудыг тойрсонгүй, дайрч гарсан юм. Өнөөгийн Төмөрбулаг сумын нутаг дэвсгэр болох Засагт хан аймгийн Далай гүний хошуу, Мэргэн гүний хошуу нь 1918 оны тоо бүртгэлийн мэдээнд дараах байдлаар бүртгэгджээ.

Далай гүний хошуу нь өрх 654, эрчүүд хөвгүүд 1848 (үүнээс тайж 54, хамжлага ард 208, лам банди 735, чөлөөт ард 128), эмс охид 1689 бүгд хүн ам 3537 байжээ.

#### Далай гүний хошууны мал сүрэг 1918 онд

№	Малын төрөл	Сүм хийдийн жас-29	Ноёны сан-1	Харъяат ардын өрх-654	Дүн
1.	Адуу	1064	240	8103	9407
2.	Тэмээ	10	3	375	388
3.	Үхэр	1558	86	9404	11048
4.	Хонь, ямаа	15415	293	42413	58121
5.	Бүгд	18047	622	60295	78964

Харин Мэргэн гүний хошуу нь 1918 оны тоо бүртгэлийн мэдээгээр өрх 152, эрчүүд хөвгүүд 290 (үүнээс тайж 30, хамжлага ард 83, лам 78, албат ард 95, сул чөлөөт ард 4), эмс охид 348 бүгд 638 хүн амтай байжээ.

#### 1918 оны байдлаар Мэргэн гүний хошууны мал сүрэг

№	Малын төрөл	Сүм хийдийн жас-29	Ноёны сан - 1	Харъяат ардын өрх - 654	Дүн
1.	Адуу	1	41	189	231
2.	Тэмээ			9	9
3.	Үхэр	92	47	548	687
4.	Хонь, ямаа	401	146	3998	4545
<b>Бүгд</b>		494	234	4744	5472

## ***МАН-ын үүр байгуулагдав***

Монгол оронд өөрчлөлт авчирсан 1921 оны хувьсгал, Ардын засгийн бодлого алс тэртээх хотогойд иргэдэд ч хүрч байлаа. 1922 онд Далай гүний хошуунд намын 17 дугаар үүрийг байгуулж даргаар нь Жигжид жононг сонгож, 1922 оны 7 дугаар сард Мэргэн гүний хошуунд “Цэцэрлэгийн ам” гэдэг газар нэг гэр барьж, намын үүрийг 24 гишүүнтэй байгуулж, 18 дугаар үүр гэж тогтжээ.

Намын үүрийн хурлаар малын тоо, цэрэг татлага, өртөө, сумангийн алба залгуулах зэрэг асуудлыг хошууны тамгын түшмэлийн хамт хэлэлцэн шийдвэрлэж, ядуу лам нарын дунд бичиг үсгийн бүлгэм байгуулж, бичиг зааж байжээ. 1924 онд хуралдсан намын 4 дүгээр их хуралд тус сумын харьяат Луузангийн Шагдарсүрэн, 5 дугаар их хуралд Зундуйн Цэдэнсодном, мөн Даньдгай нар оролцсон байна. Намын 17 дугаар үүрийн гишүүн тус сумын Агтын голоор нутагтай эмэгтэй Дэмчигийн Гүнсэн нь 1927 онд МАХН-ын 6 дугаар их хуралд төлөөлөгчөөр оролцжээ. 1931 онд Төмөрбулаг сумын хэмжээнд бичиг үсэг мэдэх 36 хүн бүртгэгдсэний дотор эрэгтэй 34, эмэгтэй 2, намын гишүүн 17, эвлэлийн гишүүн 8 байжээ. Бичиг үсэг мэддэг хүмүүсийн дотор хошуу ноён байсан Б.Содномваанчиг, тайж А.Найдансүрэн, Т.Дамдинжав, Ж.Санжмятав, Д.Пунцагаа, эмэгтэй Д.Гүнсэн, Д.Жавзан нар орж байв. Ардын хувьсгалын 10 жилийн ойгоор 1931 онд МАХН-д сайн дураар элсүүлэх хөдөлгөөн өрнөхөд тус сумаас Цумбаан Даньдгайсүрэн, Жамцын Дадьхүү, Зундуйн Цэдэнсодном, Лувсангийн Түмэн, Цэгмэдийн Гэлэг, Алтангэрэлийн Найдансүрэн (тайж), Дагвын Санж-Ёндон, Жигмэдийн Санжмятав, Мунаагийн Цагаанаа нарын 30 гаруй хүн элсчээ.

## ***Засаг захиргааны байгууллагыг шинэчлэн зохион байгуулж, Хантайшир уулын аймаг байгуулагдлаа***

Ардын хувьсгал ялснаас хойш Монгол улсад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд хэд, хэдэн томоохон өөрчлөлт хийжээ. Ардын засгийн газраас 1923 онд Монгол улсын нутгийн захиргааны дүрэм “Их шавийн захиргааны дүрэм, “Ховдын захиргааны дүрэм, Дарьганга захиргааны дүрэм гэх мэт дүрмүүдийг батлаж, 1923- 1925 онд засаг захиргааны нэгжүүдийг өөрчлөн зохион байгуулсан байна. Ардын засгийн газраас 1923 оны 3 дугаар сарын 5- нд гаргасан “Монгол улсын нутгийн засаг захиргааны дүрэм”-д “Монгол улс үүнээс хойш аймаг, хошуу, сум, баг, арван гэр гэсэн таван шатны нэгжээс бүрдэнэ” гэж заажээ. Мөн “Монголын олон засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”-ийг батлан гаргаснаар улсын Засгийн байгууллагыг ардын хурлын хэлбэрээр бэхжүүлэх шийдвэр гарав. Өөрөөр хэлбэл, энэ нь Засаг ноёдын ёсыг устгаж, ард олныг орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажилд татан оролцуулах эхлэл болсон юм.

Монгол улсын нутаг дэвсгэрийг 1691 оноос 1923 он хүртэл 4 аймагт хувааж байсныг болиулж, 1923 онд Ардын засгийн газраас аймгуудыг уул, усны нэрээр нэрлэх шийдвэр гарчээ. Олноо өргөгдсний 13-р он, аравдугаар сарын шинийн 9-нд Ардын засгийн газраас “Дотоод яамнаас дөрвөн аймгийн чуулган дарга нарт тамгын үсэгт уулын нэр оруулан үйлдүүлж, албан бичигт уулын нэр хэрэглэхийг зарлигдсан байна. Ингэснээр Хотогойдын хошууг захирч байсан Засагт хан аймгийг Хантайшир уулын аймаг хэмээн нэрлэх болжээ. Энэ дагуу Далай гүний хошууг 1923 оноос Хантайшир уулын аймгийн Бүрэнтогтох уулын хошуу гэж байгаад 1929 онд Цэцэрлэг-Мандал аймгийн Наранжаргалант уулын хошуу гэгдэх болжээ. Энэ хошуу нь 1931 онд Төмөрбулаг, Бүрэнтогтох сум болжээ. Харин Мэргэн гүний хошуу нь 1923-1924 онуудад Хантайшир уулын аймгийн Бүгдгээн хан уулын хошуу гэгдэн “Зүүн нуур” хэмээх нэг сум болж явжээ. 1924 онд сумын нэрийг “Баянзүрх” гэж нэрлэн хошуу даргад давхар хариуцуулж байгаад 1925 оны 7 сард Бүрэнтогтох уулын хошуунд нэгтгэсэн бөгөөд энэ нь 1931 онд Төмөрбулаг сумын 3, 4-р баг болжээ. 1924 онд дээрх хошуудын Ардын төлөөлөгчдийн хурлаас Бүрэнтогтох уулын хошууны даргаар Донжоо Товуу захирагч, Бүгдгээн хан уулын хошууны даргаар Балгансүрэн нарыг сонгож, хуучин багуудыг сум болгов.

Бүрэнтогтох уулын хошуунд Өвөр зүүн багийг Уранхайрхан сум болгож даргаар нь Дамдинмээрэн, Ар баруун багийг Хунцан сум болгож даргаар нь Очир захирагч, Өвөр баруун багийг Дашдэрчин сум болгож даргаар нь Ядам занги, Ар зүүн багийг Баянцог сум болгож даргаар нь Доной мээрэнг сонгож, Бүгдгээн хан уулын хошуунд Баянзүрх гэдэг нэг сумтай зохион байгуулж, хошуу даргад давхар хариуцуулсан байна.

Ардын засгийн газрын 1925 оны 5 сарын сарын 29-ний өдрийн тогтоолоор хүн ам цөөнтэй, газар нутаг багатай, жижиг сумдыг нэгтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авагдсанаар 1925 оны 7-р сард Бүгдгээн хан уулын хошууг Бүрэнтогтох уулын хошуутай нэгтгэн хошууны бүх албан хэргийг Донжоо Товуу захирагчид шилжүүлэн өгчээ.

Тухайн үеийн Бүрэнтогтох уулын хошууны Уранхайрхан, Баянцог, Баянзүрх сум бүхэлдээ одоогийн Төмөрбулаг сумын нутаг дэвсгэрийг хамарч байсан тул 1925 онд Төмөрбулаг сум үүссэн гэж үздэг.

### Сумын нэршил, газар нутгийн хил

Төмөрбулаг сумын түүхийг эргэн сурвалжилж үзэхэд маргаантай, ээдрээтэй олон асуудал, нэр томъёо гарч ирдэг. Тиймээс Төмөрбулаг сумын нутаг дэсгэрт оршиж байсан Засагт хан аймгийн Далай гүний хошуу, Мэргэн гүний хошууны өмнөх болон хойших нэршлийг хүснэгтээр үзүүлье.


Манжийн үед	Олноо өргөгдсөн Монгол улсын үед	Ардын Засгийн үед	1923-1925 оны үед	1930-аад оны үед	1931 оны зохион байгуулалтаар
<b>Мэргэн гүний хошуу</b> Халхын өрнө замын дундад зүүн гарын баруун этгээдийн хошуу	Мэргэн гүний хошуу	Хантайшир уулын аймгийн Бөндгөн хан уулын хошуу	1923 онд “Зүүн нуур”, 1924 онд “Баянзүрх” гэж нэрлэгдэн хошуу даргад давхар хариуцуулж байсан.	Цэцэрлэг мандал аймгийн Наранжаргалант уулын хошуу	Хөвсөл аймгийн Төмөрбулаг сумын 3, 4-р баг
<b>Далай гүний хошуу</b> Халхын өрнө замын баруун гарын баруун этгээдийн хошуу	Далай гүний хошуу	Хантайшир уулын аймгийн Бүрэнтогтох уулын хошуу	Өвөр зүүн багийг Уранхайрхан сум, Ар баруун багийг Хунцан сум, Өвөр баруун багийг Дашдэрчин сум Ар зүүн багийг Баянцог сум.	Цэцэрлэг мандал аймгийн Наранжаргалант уулын хошуу	Хөвсөл аймгийн, Бүрэнтогтох, Төмөрбулаг, Арбулаг, Бүрэн,

1930 онд засаг захиргааны шинэ өөрчлөлжээ. Тухайн үед хүн амын бүртгэлийг аймаг хошуу бүрээр гаргаж, хүн амын тооллого хийжээ. 1930 онд Цэцэрлэг мандал аймгийн Наранжаргалант уулын хошуу 6397 эрэгтэй хүнтэй, үүнийг 3040 нь лам, харин 8480 эмэгтэй хүнтэй гэж архивын аримтанд хадгалагдаж байна.

Гэвч удалгүй 1931 онд хуралдсан Улсын 16-р бага хурлаар аймгуудыг шинэчлэн зохион байгуулах шинэ шийдвэр гарчээ. Бага хурлын тэргүүлэгчид ба Засгийн газраас 13 аймаг байгуулах шийдвэр гарч, Хөвсгөл аймгийг байгуулж, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Бүрэнтогтох сумдыг байгуулжээ. Одоогийн нутаг дэвсгэрийн цав (хил) нь 1935 оны үеийн анхны үйлдсэн зурагтай ойролцоо харагддаг. Гэхдээ энэ хугацаанд дээд газрын шийдвэр гэдгээр нутаг дэвсгэрийг баримжаагүй томсгох, аль эсвэл жижигрүүлэх зэрэг үйлдэл хийсний улмаас сумын газар нутагт өөрчлөлт орж байжээ. МАХН-ын Төв Хороо, Сайд гарын зөвлөлийн шийдвэрээр 1956 оны сүүлээр сумдыг томруулахад хөрш зэргэлдээ орших Зүрх, Бүрэнтогтох

сумыг Төмөрбулагтай нэгтгэн, төвийг нь Төмөрбулагт төвлөрүүлэн, “Бүрэнтогтох” гэж нэрлэж байв. 1959 оны эхээр хэт томруулсан сумдаа жижигрүүлэхэд Зүрх, Бүрэнтогтох, Төмөрбулагийг хуучин байрлалаар нь сэргээн, Бүрэнтогтох, Төмөрбулаг сумын дундаас Тээл сум (одоогийн Тээл баг)-ыг үүсгэжээ. Улмаар 1960 оны 3 дугаар сард Тээл нь Бүрэнтогтох сумтай нийлж, 1973 онд эргээд Төмөрбулаг суманд нэгдсэн зэрэг олон өөрчлөлтийн үед тус сумын нутаг дэвсгэрийн хил тодорхой бус байв.

Харин эдүгээ Төмөрбулаг сум нь “Нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” АИХ-ын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн 75 дугаар зарлигаар тогтоосон хилийн цэсийг баримталж буй. Энэ зарлиг нь 1974 онд үйлдсэн зургийг баримталсан болов уу гэлтэй, тоот, өндөрлөг, хилийн цэс нь одоогийнхтой таарч байгаа юм. Сумын эдэлбэр нутгийн хилийн цэс нь (цагийн зүүний дагуу) Могойн даваа, Төмөртийн нуруунаас эхэлж, Цагаанбургасын даваа, Агтын даваа, Эрчмийн нуруу уруудан, Гахайн давааны ам уруудаж Дэлгэрмөрөн голын хойд эргээр Гурван голын бэлчир хүрч, Идэр голын их савын зүүн эргээр өгсөж, Хөхөөний үзүүрээр гарч, Хөхөөний уул (Хөөнгийн нуруу), Бүгдгээний голын бэлчир, Урт булгийн эхний даваа, Улаан хад, Тал булгийн эхний даваа цонж, Тээлийн нурууг хяраж, Тээлийн нуруу, Дашдэрчингийн овоо (Дэлийн нуруу), Хаахайн сайрын адгаар Бүгсийн гол хүрч, Бож, Жөнхөн, Могойтын таг, Шар хадны дөрөлж, Ялбант уулаар дамжин эхний цэг Могойн даваа хүрдэг байна. Энэ бол Төмөрбулаг сумын хэн ч халдашгүй дархан хил, зарлигаар баталгаажсан нутаг дэвсгэр юм.



## ***Тэнхим нээгдэв***

1922 оны 8 дугаар сарын 14-нд гарсан Засгийн газрын шийдвэрийн дагуу хошуудад 1923 оноос эхлэн тэнхим нэртэй анхны сургуулиуд байгуулагдаж эхэлсэн бөгөөд 1926 онд Бүгдгээн хан уулын хошууны дэргэд тэнхим хэмээх сургууль байгуулагдаж 10 гаруй хүүхэд ном үзэж байв. Засгийн газрын 1927 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолын дагуу 1928 оны 8 дугаар сард Бүгсийн хүрэн дээр “Шинэ наймаа” гэдгийн хашаанд дарга-сургагч Борбаатарын удирдлагаар 25 сурагчидтай тэнхим байгуулагджээ. Энэ тэнхимд монгол цагаан толгой, тоо бодлого, түмэн бодисын ухаан зэрэг хичээлийг Буриад багш Балдандорж, Бэх-Очир нар зааж, эмчээр нь маарамба Жигжидийн Галай ажиллаж байжээ. Харамсалтай нь энэ тэнхим 1932 оны эсэргүү бослогын уршгаар тарж бутарч байсан боловч Төмөрбулагт суманд шинэ цагийн боловсролын байгууллагын анхны хуудсыг нээж чадсан юм.

Энэ тэнхимд сурагцагсдаас Шанжийн Чулуунбаатар Ардын цэрэгт алба хааж ахмад цолтой халагдаад, Улаанбаатар хотод насан эцэс хүртлээ автомашины жолоочоор ажилласан байна. Мөн Сонинхүүгийн Дамбадаржаа бүхий л амьдралаа төмөр замтай холбож, УБТЗ-ын 1 дүгээр орлогч дарга хүртэл алба хашиж байсан бөгөөд эдүгээ энх тунх амьдарч байна. Сандуйн Пүрэвжав (1923-1991) түүхийн ухааны доктор, профессор, Монголын түүх судлал болон түүхчдийг бэлтгэхэд хувь нэмэр оруулсан нэрт эрдэмтэн байсан аж. Үүнээс гадна МУ-ын Ерөнхи сайд С.Баярын аав нэрт эрдэмтэн Л.Санжааг мөн танхимын сургалтаар боловсрол олж авсан гэдэг баримт мэдээлэл бий.

## ***Эвлэлийн үүр байгуулагдлаа***

Тус суманд анхны эвлэлийн үүрийг 1923 оны 11 дүгээр сард Ц.Даньдгайсүрэн, И.Намжилжав, П.Ням, Дамдинсүрэн нарын 10 гаруй гишүүнтэй байгуулж даргаар нь Цумбаан Даньдгайсүрэнг сонгосон гэж Жанцангийн Рагчаа дурдатгалдаа тэмдэглэжээ. Хуучин хошуудын нэрийг газар нутгийн нэрээр нэрлэх болж засаг захиргааны шинэчлэлт хийгдсэний дараа хошуу бүрт эвлэлийн үүрийг өргөтгөн зохион байгуулсан байна. 1924 оны зун Бүрэнтогтох уулын хошуунд эвлэлийн үүрийг 15 хүнтэй байгуулж, даргаар нь Чадрабал, орлогч даргаар Пунцагаа, нарийн бичгийн даргаар Махсүх нарыг сонгосон байхад, Бүгдгээн хан уулын хошуунд эвлэлийн 48 дугаар үүрийг 23 гишүүнтэй байгуулж, даргаар нь дархан Гончигийг сонгожээ.

## ***Хоршоо байгуулагдав***

Харилцан туслалцах хоршооны Хөвсгөл аймаг дахь анхны нэгжүүдийн нэг, Мөрөнгийн хүрээнд байгуулагдсан хоршооны 22 дугаар ангийн 7 салбарын нэг нь 1926 онд тус сумын Тал булагийн аманд Бүгсийн хүрэн дээр байгуулагдсан байна. Ардын хурлаар хоршоо байгуулах тухай хэлэлцээд гишүүн бологсдоос 50 мөнгөний татвар авч, нийтдээ 1000 гаруй төгрөгний хувь хөрөнгөтэй байгуулагдсан Эд хэрэглэгчдийн анхны хоршооны даргаар

Банзрагч гэгчийг сонгожээ. Энэ нь тус сумын орчин цагийн худалдааны байгууллагын эх суурь байв.

## ***Хошууг татан буулгалаа***

Хуучин засаг ноёдын ёсыг халж засаг захиргааны нэгжийг шинэчлэн байгуулах ажил нилээд бэрхшээлтэй тулгарч, нутаг дэвсгэр, хүн амын онцлог байдал саналыг харгалзан, хошуудыг нэгтгэх, салгах, шинээр сум байгуулах үйл явц нилээд удаан үргэлжилсэн байна. Бүрэнтогтох уулын хошуу нь 1929 он хүртэл Хантайшир уулын аймагт харьяалагдаж байгаад улмаар тус аймгийн нутгийг бүхэлд нь Цэцэрлэг мандлын аймагт, харьяалуулахад Наранжаргалант уулын хошуунд хамрагдах болж хэд хэдэн сумдыг шинээр байгуулсан байна. БНМАУ-ын 4-р Их хурал хуралдаж, “Аймаг хошуудын нэрийг өөрчлөх, эдийн засаг ба, ард түмний одоогийн хөгжил зэрэг байдлыг харгалзан тохируулсан аймгийн зохион байгуулалтыг хийх тогтоол гарчээ. Ардын Сайд нарын зөвлөл, Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 5-р тогтоолд үүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний үндсэн дээр орон нутгийн засаг захиргааны газар нутаг, эдийн засаг, зан заншлыг нь харгалзан үндэсний хошуу байгуулах, бусад хошууг татан буулгах ажлыг 1931 оны 2 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 16 хүртэл явуулсан байна. Энэ дагуу Улсын бага хурлын шийдвэрээр 1931 оны дөрөвдүгээр сарын таванд таван хошууг бүх сумдтай нь татан буулгаж, шинээр байгуулагдах болж, сумын захиргааг Хөвсгөл аймгийг байгуулах түр хороонд харьяалуулсан байна. Аймгийн анхдугаар хурал Хатгалд хуралдаж, Хөвсгөл аймгийг байгуулсан тогтоол гаргажээ. Энэ тогтоолын дагуу 1931 онд анх Хөвсгөл аймгийг 107,2 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 24 сум, 439 хороотой, 17431 өрхтэй, 69206 хүн амтай, 1,2 сая гаруй толгой малтай байгуулсан юм. Ийнхүү Засагт хан аймгийн Цэцэрлэг мандал уулын аймгийн Наранжаргалант хошууг татан буулгаж Арбулаг, Бүрэн, Бүрэнтогтох, Их-Уул, Төмөрбулаг сум болгон хуваажээ. Хуучин хошууны бүрэлдэхүүнд байсан Уранхайрхан, Баянцог, Жаргалант (Баянзүрх) сумдын Ардын төлөөлөгчдийн хурлыг 1931 оны 3 дугаар сард Төмөрбулагийн хажууд 3 гэр барьж хуралдуулан Төмөрбулаг сумыг 9 багтай зохион байгуулж, сумын даргаар Хангинаа хэмээх Ядамжав, нарийн бичгийн даргаар шүдгүй хэмээх Пэрэнлэй нарыг сонгожээ.

## ***Анхны хамтрал байгуулагдав***

1931 онд тус сумын 9-р багийн арав гаруй өрх нэгдэж Тэлээгийн аманд хамтрал байгуулж, даргаараа Лувсангийн Түмэнг сонгожээ. Энэ хамтрал 1932 онд Тэлээгийн амны дуган дээр төвлөрч, жин тээж, газар хагалж байсан гэх мэдээ баримт байна. Гэвч тус хамтрал удалгүй үйл ажиллагаагаа зогсоож, 1932 оны 8-р сард “Зүүний нугалаа завхралыг засах, “Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр хэлэлцсэн Хөвсгөл аймгийн намын бага хурлын шийдвэрээр бүрэн таржээ.

### Феодалын хөрөнгийг хураав

МАХН-ын VII Их хурлын дараахан МАХН-ын Төв хороо, Засгийн газарт хаягласан “маш нууц” тодотголтой Коминтерний 2/452 тоот захидал иржээ. Түүн дотор феодалын хөрөнгийг хураах ажил эхлүүлэхийг сануулаад хэрхэн хийх талаар жич зааварчилгаа өгнө гэсэн байв. Удалгүй зааварчилгаа нь ирж, 1929 онд Феодалын хөрөнгө хураах ажлыг эрхлэх төв комисс байгуулан даргаар нь Х.Чойбалсанг тавиад, долдугаар сарын 13-нд ажлынх нь төлөвлөгөөг баталсан гэдэг баримт бий. Энэ дагуу феодалын хөрөнгийг хурааж, ядуу аж ахуйтанд шилжүүлэн өгөх, ядуу дунд ардаас авах татварын хэмжээг багасгах шийдвэр гаргажээ. Энэ шийдвэр нь ядуу дорд ардын улс төр, нийгмийн идэвхийг өрнүүлж, хошуудад байгуулагдсан тусгай комиссын ажилд ардууд идэвхтэй оролцож байлаа. Төмөрбулаг суманд ч энэ ажил өрнөжээ. Гэхдээ нэр нь феодал боловч, өмч хөрөнгийн хувьд том баячууд байгаагүй учир хөрөнгө хураах ажил нүсэр хүнд болоогүй байна.

#### 1930 онд тус сумын чинээлэг ардуудын хөрөнгө мал хураасан байдал (төгрөгөөр)

№	Нэр	Мал (төгрөгөөр)	Эд хогшил (төгрөгөөр)
1.	Бизьяагийн Зайсан	291	362
2.	Бизьяагийн Шарав	526	90
3.	Базаррагчаагийн Содномванчиг	250	468
4.	Өндөр хэмээх Даньдгай	214	204
5.	Даньдгайн Бат-Очир	1304	163

### Нэгдлүүд байгуулагдав

Тус сумын 2,3-р багийн иргэн Р.Даваа, Н.Дамбадаржаа, Д.Данаа Д.Ёндон, Ч.Ёндон тэргүүтэй 13 өрхийн 17 хүн нийлж 1939 оны дөрөвдүгээр сарын 15-нд “Шинэ амьдрал” нэгдлийг байгуулжээ. Мөн Төмөрбулаг сумын 1-р багийн Ц.Дашгэндэн, М.Чадраабал, Дондов тэргүүтэй 18 хүн хуралдаж, 1938 онд “Оч” нэгдлийг байгуулж, даргаараа Ц.Дашгэндэнг сонгожээ. Тус нэгдэл 86 гэсэн дугаарыг аймгаас авсан бөгөөд тухайн үед 2000 төгрөгийн зээл авч, тариа тарьж, гэрийн мод, хусан тооно хийж эхэлжээ. Тэр үед Бүрэнтогтох сумын 4-р багийн иргэд мөн санаа зорилгоо нэгтгэн “Саруул зам” нэгдэл байгуулж, даргаараа Оршихын Бадарчийг сонгожээ. Тариатын “Шинэ-Амьдрал” нэгдэл анх 3000 төгрөгийн зээл авч, 11 га газарт арвай тарьж, нэгдлийнхээ ажлыг эхлүүлжээ. Аж ахуйн хувьд бэхжиж эхэлж байсан боловч, гишүүд нь Бүгсийн голоос Тариатын аманд төвлөрч байсан нэгдлийнхээ ажилд очихоос бэрхшээж, сумын намын үүр захиргаанд удаа дараа асуудал тавьж байсан тул 1939 оны арванхоёрдугаар сард болсон нэгдлийн гишүүдийн хурлаар шинэ зохион байгуулалт хийж байсан байна.

### Хэлмэгдүүлэлт эхлэв

1930 онд хуралдсан Улсын 6 дугаар их хурал “... шашин сүм хийдийг хүчтэй эсэргүүцэх, лам нарын дотор дээд, доод анги гэсэн ялгавартай бодлого явуулах” -ыг заасны дагуу орон нутгийн хошууны хүрээ хийдийн жас бүрт олон мянган төгрөгийн татвар ноогдуулан, сүм дуганыг албадан хаах зэргээр сүсэгтний сүсэг бишрэлийг хавчих явдал гарч байжээ. Дацан, жасууд албан татварыг төлж дийлэхээ больж, мал хөрөнгөө өгч дуусаад эцэстээ сүм, дуганыхаа бурхан, тахил, эд хогшлыг худалдаж, татвар төлж байжээ. Мөн хүрээний мяндаг тушаалтай лам нарыг 1931 оны намраас эхлэн баривчилж, аймгийн төв Хатгалд аваачин хорьж, гэр байшин, эд хогшлыг нь битүүмжлэн лацдаж байв. Үүний уршгаар хүрээний дацан, хурлууд хурал номоо хурах боломжгүй болж дуган сүмээ түр хаахад хүрч байжээ.

Ж.Үржгэрийн Төмөрбулаг сумын тухай түүхэн номонд дурьдснаар их баривчилгааны эхлэл нь 1922 онд Бүгсийн хүрээний Жамсран шанзовыг баривчилж, егүүтгэснээр эхэлсэн байна. Цэрэн тайжийн хүү Жамсран шанзов нь алс баруун хязгаарын Да лам Дамбийжаад нэгэн бичгийг Агтын эхний Рэнцэн “хаалгач” гэдгээр явуулсан гэдэг. Рэнцэн нь Улиастайд архи ууж согтууран үг алдсан тул архиар шахаж унаган, уг бичгийг авч хуулбарлаад буцааж өвөрт нь хийснээр уг хэрэг дэгдэж, Хувьсгалын эсэргүү Дамбийжаатай холбоотой гэдгээр Жамсран шанзов баривчлагдаж цаазлагджээ.

1931 оны үед Цэрэн тайжийн хүү Лхамсүрэн, туслагч Барамсай тайж, Гомбосүрэн дүүрэгч (тайж), Чойсүрэн цорж нарын мяндаг тушаалтай олон лам ноёд баривчлагдан, тэр үеийн аймгийн төв Хатгалд хүргэгдсэн боловч ихэнх нь буцаж ирээгүй гэдэг. Баривчлагдаад сураггүй болсон эдгээр лам хувраг, ноёд мөн 1932 оны эсэргүү бослогын үеэр амь үрэгдсэн хүмүүсийн тухай хамба лам Готов дурсан өгүүлсэн нь номын хуудсанд үлджээ. Тэрээр “1922-1931 оны үед баривчлагдаж сураггүй алга болсон Хайдав гэлэн, Чойсүрэн цорж, Балган цорж, Бадарч лам, Чогдон ранжин, Цэрэннамжил аграмба, Цамбасүрэн тойн, 1932 оны бослогын үед амь үрэгдсэн Зэвэг унзад, Готов гэлэн, Хайдав гэлэн, тагжгар Балган, өвгөн Мөнхөө, Ишээнар, Бизьяагийн Дамдинжав, Чадраа зайран, хонх Лувсан, анчин Лавдаа, Шаадайсүрэн, Зэвгээ, Наваанцагаач, түүний хүү Лхамсүрэн, Сэндэн нарын зэрэг олон хүн байсан” гэжээ. Буян номын мөр хөөж, зон олондоо ач тус хүргэх ариун тангарагтаа үнэнч байсан шашны мяндаг тушаалтнууд цөм эсэргүү болж, “японы тагнуулд элсэцгээсэн” хэрэгт оржээ. Бүрэн бус мэдээгээр тус сумаас 200 шахам лам, хар хүмүүс хэлмэгдэлд өртөж баривчлагдснаас 1998 оны байдлаар 147 нь цагаатгагдсан гэсэн дүн мэдээтэй байна. Цагаатгагдсан 147 хүний 117 нь цаазаар авагдсан бөгөөд үлдсэн 27 нь шоронд ял эдэлсэн гэх боловч амьд эргэж ирсэн 7-8 хүн байжээ. Хэлмэгдсэн хүмүүсийн дотор маарамба 10, аграмба 16, гавьж 30, гэсгүй, унзад, ловон, жирийн лам бүгд 42, тайж 9, цэргийн албан хаагч 4, энгийн хар хүн 18, бусад хүмүүс 15 байжээ.



## 1932 оны эсэргүү бослого

1931 оны есдүгээр сард Хөвсгөл аймгийн Баянголын хүрээний аграмба лам Цэрэнжав Мөрөнгийн хүрээний том лам анги Дамдин, Жалханзын хүрээний лам Самдан нар хувьсгалын эсэргүү бүлэг зохион байгуулж улмаар Асгатын хүрээний гүрэмч лам дүвчин Самбууд эсэргүү бослого бэлтгэж гаргах үүрэг өгч 1931 оны 11-р сард нууц хурлаараа хэлэлцэн хувьсгалын эсэргүү цуурхал тараах, хүрээ хийдүүдийн хооронд холбоо барих, зэвсэг цуглуулах ажлыг Жалханзын хүрээний хувилгаан лам Гунаажавт хариуцуулж, Мөрөн, Асгат, Тэс, Бүгсүй, Бугат, Бух, Хялганатын хүрээний дээд ангийн лам нарт тус тусын хүрэн дээр эсэргүү бослого гаргах үүрэг өгсөн байна.

Дээрх хүмүүс 1932 оны нэгдүгээр сард Самбуу дүвчингээр толгойлуулсан штаб байгуулж бүрэлдэхүүнд нь Рашаантын хүрээний гавьж лам Сандандоржийг орлогчоор, Асгатын ловон лам Шагдарыг улс төр шашин шүтлэгийн ахлагчаар, Жалханзын хүрээний хувилгаан лам Гунаажав, Баруун асгатын хүрээний Чойжил нарын бүрэлдэхүүнтэй байгуулж энэ хуралд Цэрэнжав, Дамдин нар биеэр байлцан, бослогыг 1932 оны зуны дунд сарын 15-нд 300-аас доошгүй цэрэгтэйгээр эхлэхийг Дүвчин Самбууд даалгажээ. Энэ дагуу 1932 оны 4 сарын 11-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хялганатын хүрээнд 100 гаруй лам, ардууд зэвсэглэн босож сум, хамтралын төвийг дайран довтолсноор энэхүү зэвсэгт бослого эхэлсэн байна. Босогчид Рашаантын хүрээг эзлэн “Очирбатын яам” нэртэйгээр бослогын төвийг Чойжин Эрэгдэндагва, Тайж Дандар, залан Жамсрандорж нарын бүрэлдэхүүнтэй зохион байгуулж, лам, ардуудыг дайчлан “шар цэрэг” гэж нэрлэн аравт, тавьт, зуутын зохион байгуулалттай зохион байгуулж эхэлсэн байна. Бослого маш хурдан тархаж олон тооны сум, хамтралын төв бүхий өргөн уудам нутагт тархсан байна. Босогчид бороохой, ташуур, цахиур болон бусад олон төрлийн галт зэвсгүүдээр зэвсэглэсэн байсан бөгөөд сум, хамтралын төвүүдийг эзлэн, байшин барилга зэргийг устгаж, албан хаагч, идэвхитэн болон жирийн малчдыг хүртэл харгис аргуудаар тамлан зовоож, алж байсан гашуун мэдээ түүхийн шар хуудсанд үлджээ. Босогчид Хөвсгөл аймгийн төв Мөрөнг довтолж эзлэх зорилго тавьж байжээ. Төмөрбулаг сумын Бүгсийн хүрээнд л гэхэд 500 хүнээс бүрдсэн босогчид бөөгнөрч, цэргийн зохион байгуулалт хийж тохиолдсон хүмүүсийг хүчээр өөрийн цэрэгт дайчилж байжээ. Тэд шар цэргийн хүзүүнд цагаан зангиа зүүж, цэргийн анги салбарууддаа цагаан ногоон хоёр өнгийн туг хэрэглэх журмыг тогтоож байжээ. 1932 оны 4 дүгээр сарын сүүлчээр бослогынхон Олон голын бэлчир, Бүгсийн амаар ирж ардуудыг айлган сүрдүүлж, улмаар Төмөрбулаг сумын төвхнөж эхэлж байсан захиргаа, улсын худалдааны салбар, хамтралын бичиг, эд хогшлыг устгаж, сумын дарга Пүрэвжалын гэргий, намын гишүүн Найдансүрэн, хамтралын ажилчин Махсүх нарын амь насыг бүрэлгэжээ. Тэлээгийн хамтралын дарга байсан Лувсангийн Түмэн босогчдод баригдаж дээрэмдүүлсэн боловч оргож амь гарсан байна. Босогчид гол өгсөн Бүгсийн хүрээнд ирээд хүмүүсээ хэдэн чиглэлээр Бүгсийн гол, Шар хөндий тийш явуулан 18-аас дээш насны бүх эрэгтэйчүүдийг цахиур буу, сэлэм, бороохойгоор зэвсэглэн албадан босгож байлаа. Мөн Бүгсийн хүрээний хоршоо, тэнхим, хамтралын мал

хөрөнгийг сүйтгэн, ноосон сангийн олон мянган төгрөгийн эд хогшил, барааг устгажээ. Энэ талаар Д.Жамба номондоо “Босогчид Тээлийн хамтралын 250 гаруй адуу, 5000 гаруй бог малыг уналга, хоол хүнсэндээ хэрэглэж байсан” хэмээн дурьдсан байдаг. Тэр ч байтугай Бүгсийн хүрэн дээр “шар цэргийн наадам” хүртэл хийж бослогын нэг удирдагч Готов заан гэгч бөхийн барилдаанд түрүүлж байсан хэмээн бичжээ. 1932 оны дөрөвдүгээр сарын 16-нд Улсын бага хурал, Засгийн газрын тэргүүлэгчдийн хамтарсан онц хуралдаанаар “Хөвсгөл аймагт гарсан хувьсгалын эсэргүү бослогын тухай” Дотоодыг хамгаалах газрын илтгэлийг сонсоод, Хөвсгөл аймагт гарсан эсэргүү бослогыг богино хугацаанд дарж, ард түмний тайван байдлыг хангах арга хэмжээ авахаар мөн газрын тусгай хорооноос хөнгөн пулемот, винтов, гранатаар зэвсэглэсэн байлдааны тусгай отряд гаргаж 1932 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатараас илгээжээ. Босогчдийг дарах отряд 1932 оны дөрөвдүгээр сарын 29-нд Бүгсийн хүрээнд байсан дайсантай долоон цаг байлдаж, эсэргүү цэргээс 30 гаруй хүн алагдаж нэлээд хүн шархадсан. Бүгсийн хүрээг алдсан босогчид Мөрөн голын урьд талд Цагаан бургас, Загзууд очиж 1000 гаруй хүний хүчийг хуралдуулж, Хөвсгөл аймгийн Мөрөн хотыг эзлэхийг зорьж байсан тухай Д. Цэрэнбалжирын “1932 оны зэвсэгт бослого” түүхэн номонд тэмдэглэгджээ.

Бослогыг дарахад эрэлхэг зориг гаргасан тус сумын харьяат Бэлэгтийн Галсан Байлдааны гавьяаны нэгдүгээр зэргийн одонгоор шагнагдаж, Жанцангийн Рагчаа, Жадамбын Жамба, Базархүүгийн Даваа нар Засгийн газрын болон аймгийн шагнал хүртсэн байна.

Ж.Рагчаа нь 1932 оны бослогыг дарах партизан Дооровын Дашзэвгийн отрядад оролцон Домбуу Хавчуу, Рашаантын Хүрээ, Загзуу Жалханзын хүрээ, Бүгсийн хүрээ, Архангайн Жаргалант зэрэг газраар тулалдаж явсан бөгөөд “Очирбатын яам”-ыг устгахад партизан О.Лувсанжамбаагийн хамт биечлэн оролцжээ. Үүнийг гэрчлэх баримт нь Хөвсгөл аймгийн дарга Наваан, орлогч дарга, цэргийн хэлтсийн дарга Бумандэмбэрэл нарын гарын үсэгтэй 1932 оны 10 сарын 3-ны өдөр олгосон 01 тоот үнэмлэх бичигт 11 удаагийн тулалдаанд оролцож байсныг тэмдэглэсэн баримт юм. Мөн Монгол улсын Ерөнхий сайд П.Гэндэн, нарийн бичгийн дарга Өлзий-Очир нарын үсэгтэй 1933 оны 3 дугаар сарын 18-ны өдөр олгосон 28 тоот үнэмлэх бичигт Ж.Рагчаагийн гавьяа зүтгэлийг тэмдэглээд 14402 номертой бярдан буу нэгийг сумны хамт шагнаж байсан байна.

Бослого хөдөлгөөнийг дарсны дараа бослогын хөлд тарж үрэгдсэн сумын захиргаа, хоршоо худалдааны байгууллагыг сэргээн шинэчлэх, зүүнтний алдаа завхралыг залруулах, шинэ эргэлтийн бодлогын мөн чанарыг олон түмэнд таниулах зэрэг ажлыг сумын нам, эвлэлийн гишүүд, идэвхтнүүд ард олны дэмжлэгтэйгээр явуулж байлаа.

## Сумын захиргааг шинэчлэн байгуулав

Эсэргүү бослогын хөлд өртсөн сумын захиргааг сэргээн байгуулж, удирдах бүрэлдэхүүнийг шинэчлэх зорилгоор 1932 оны 10 дугаар сарын 14-нд Цагаан бэлчирт 61 хүн хуралдаж, Төмөрбулаг сумын захиргааг дахин байгуулж, даргаар нь Готовын Дамдинсүрэнг сонгон, сумын төв Жаргалантын амны дэнж дээр суурин төвлөрөх болжээ.

### **Хувь нийлүүлэгчдийн хоршоог байгуулав**

1933 оны хоёрдугаар сард Төмөрбулаг сумын урд талд Адууны бууц гэдэг газар 70-аад хүн хуралдаж, сумын хувь нийлүүлэгчдийн анхны хоршоог байгуулан даргаар нь Цумбаан Даньдгайсүрэн, нягтлан бодогчоор Өмбө, түүхий эдийн эрхлэгчээр Дамдинсүрэн, нярав худалдагчаар Дагвын Санж-Ёндон нарыг сонгосон байна. Мөн 1934 онд Улсын худалдааны нэгэн салбар Бүгсийн хүрэн дээр төвлөрч түүний салбар хэсгүүд Жаргалант Бүгсийн амаар буй болж, эд бараа борлуулан мал, түүхий эд авдаг байжээ. Бүгсийн хүрээнд байгуулагдсан салбар худалдааны төлөөлөгчөөр О.Чогсом, худалдагчаар Сан-Ян-Ир гэх хятад иргэн ажиллаж байсан баримт байна.

### **Хүн эмнэлэг байгуулагдлаа**

1937 онд сумын хүн эмнэлгийн санитарчаар Жалтавын Дамбасүрэн ажиллаж эхэлжээ. 1938 онд улсаас төсөв хөрөнгө гаргаж, хүн эмнэлгийн салбарыг хоёр хүний орон тоотой болгожээ. 1938 оны аймгийн яамны тайланд “Төмөрбулаг сумын хүн эмнэлгийн санитарч Ж.Дамбасүрэн жилд 756 хүнд эмнэлгийн тусламж үзүүлж ард олны эрэлт хүсэлтийг ханган сайн ажилласан” хэмээн дурьджээ.

### **Лам нарын артель байгуулав**

Хүрээ хийдэд шавилж байсан лам нар сайн дураараа хар болж, эхэлжээ. 1934 онд л гэхэд хүрээнд сууж байсан 120 хүүхдийн 50 орчим хувь нь сайн дураараа хар болон монгол бичигт суралцаж эхэлсэн байна. Хүрээ хийд дээр сууж байсан лам нарыг нэгтгэн 1937 онд лам нарын артель байгуулжээ. Тухайн үед Бүгсий, Бүгдгээний хүрэн дээр шавилан сууж байгаад хар болсон лам нарыг энэ артельд нэгтгэсэн байна. Энэ артельд 14 мужаан, 11 дархан, 3 будагчин нэгдэн ажилласан бөгөөд Хөвсгөл аймагт тухайн үедээ гар үйлдвэрлэлийн гурван артель байгуулагдсны нэг нь Төмөрбулаг суманд үүд хаалгаа нээж байсан юм.

### **Малын санитарч ажиллаж эхлэв**

1933 онд мал эмнэлэгийн явуулын групп ирж, сумын иргэдийн малыг үзлэгт хамруулан угаалга, туулга хийж, эмчилгээ оношилгоо явуулж байжээ. Мөн онд тус сумын малын санитарчаар Тамшаа хэмээх Шарав ажиллаж эхэлснээр мал эмнэлгийн үндэс суурь тавигджээ. 1939 оноос мал эмнэлгийн салбар хоёр орон тоотой болжээ.

### **1939 оны Халх голын дайн**

Японы цэрэг тус улсын Зүүн хязгаар Халхын голын хавиар довтолж эхлүүлсэн зарлаагүй дайнд Төмөрбулаг сумын харьяат олон цэрэг эрс оролцож, эх орноо батлан хамгаалах үйлсэд хоёргүй сэтгэлээр зүтгэж, гавьяа байгуулж явсан юм. Тус сумын харьяат Дамбын Намсрай, Батын Ганжууржав, Шагдарын Гаваа нар “Байлдааны гавьяаны улаан тугийн одон”-гоор, Монхорын Ишзана, Жанцангийн Дашдаваа, Өлзийбаярын Сономжамц нар “Алтан гадас одон”-гоор, Бавуугийн Хярваа, Хамбын Дашсүрэн, Дашийн Банзрагч нар Халх голын байлдааны медалиар шагнагдаж байв.

## **ТӨМӨРБУЛАГ СУМЫН БААТАРЛАГ ХӨВГҮҮД**

### **ЛХҮНРЭВИЙН ДАВААДОРЖ**

БНМАУ-ын баатар, зоригт хилчин Л.Даваадорж Төмөрбулаг сумын “Донхорын эх” гэдэг газар Аюушийн хүү болон мэндэлжээ. 20 настайдаа цэргийн албанд мордож алс баруун хязгаарын Ховд аймгийн “Буданчийн хөх толгойн” заставт хилчин байлдагч болсон байна. Улс орны маань дархан хилийг зөрчин удаа дараа зэвсэгт халдлага хийж байсан дайсны эсрэг Монголын эрэлхэг дайчид хилчид удаа дараа цохилт өгч байсан бөгөөд 1948 оны 7 дугаар сарын эхний өдрүүдэд Баруун харгайтад томоохон тулалдаан болжээ. Зэвсэглэсэн 130 хүн дайрсан тэрхүү тулалдаанд хөнгөн пулемётын наводчик Л.Даваадорж нөхдийн хамт хориглон тулалдсаны эцэст ганцаар амьд үлджээ. Тэрбээр дайсанд амьд олзлогдохгүйн тулд тэсрэх бөмбөг бүсэндээ хавчуулан дэлбэлж, эх орныхоо төлөө алтан амиа өргөжээ.



### **ДУГАРЫН ГУНГАА**

Тэрбээр 1916 онд Төмөрбулаг сумын нутаг Хаахайн сайр гэдэг газар төржээ. Эх орноо батлан хамгаалах, бүтээн байгуулах үйлст байлдагчаас генерал, гавьяат нисэгч, Улсын баатар болтлоо хүчин зүтгэсэн энэ хүн 1934 онд сайн дураараа цэргийн албанд мордож, улмаар 1935-1937 онд нисэхийн сургуульд суралцан төгсч, багш нисэгч мэргэжил эзэмшжээ. 1939 оны Халх голын дайны дундуур Зөвлөлтийн сөнөөгч онгоцны сургалт дүүргэж, Монголын нисэх хүчний түүхэнд анхны сөнөөгч онгоцны салбар байгуулагдахад салбарын даргаар томилогдож, улмаар 1942 онд нисэх хорооны эскадрелийн даргаар шилжин ажиллаж байжээ. 1944-1947 онд Баруун хязгаарт нисэх отрядын орлогч даргаар байлдааны үүрэг гүйцэтгэж байсан Д.Гунгаа нь Монголын нисэх хүчний түүхийн эхний 50 жилийн турш ашиглагдаж байсан бүх загварын Р-1, Р-5, И-15,16, АН-2, ПО-2, ИЛ-12,14 зэргийг эзэмшин нислэг үйлдэж байжээ. Тэрээр 1939, 1945 оны байлдаан, 1944-1947 оны Баруун хязгаарын хилийн тулалдаанд оролцож, тайван цагт Иргэний агаарын харилцааны газрын даргаар ажиллаж байхдаа нийт 15 мянган цаг тэнгэрт дүүлэн нисэж, 2 сая км агаарын зам туулжээ. “Сүхбаатарын



одон”, “Байлдааны гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Алтан гадас” одонгоор хоёр удаа шагнагдаж байсан Д.Гунгаа “Монгол улсын гавьяат нисгэгч”, Хошууч генерал цолоор хүртэж байсан бөгөөд АИХ-ын депутатаар сонгогдож байлаа. Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн Д.Гунгааг 2009 онд Улсын баатар цолоор шагнагдсан юм.

### ЦЭГМИДИЙН ЖАМЬЯН

Автономит Монгол улсын үед тус улсын өмнөд хязгаарт хятадын хар цэрэгтэй байлдаж явсан, 1921 оны Хувьсгал мандах үед баруун хязгаарыг цагаантнаас чөлөөлөх байлдаанд Хатанбаатар Магсаржавын удирдлагаар амь хайргүй тулалдаж явсан Ардын хувьсгалын партизан Цэгмидийн Жамьян нь энэ нутгийн уугуул хүн юм. Түүнийг “...Хятадын хар цэрэгтэй 10 гаруй удаа тулалдаанд орж эрэлхэг тулалдсан хэмээн тэргүүн зэрэг олгож, 200 сумтай винтов бугаар шагнагдсан” тухай дурсамж бий. 1917 онд цэргээс ирээд ах нарын хамт ан гөрөөгөөр амь зууж, нутгийнхан түүнийг “Булгийн хар бууч” хэмээн дууддаг байжээ. Ц.Жамьян 1921 оны 3-р сарын сүүлчээр Осорын Лувсанжамбаатай уулзаж, винтов буутай нутгийн 15 анчныг элсүүлэн орон нутгийг нь түйвээж байсан 60 гаруй цагаантантай тулалдан, 24-ыг нь устгаж, хошуу захирагч Донжоо Товууг суллан авч байсан түүхээ өөрийнхөө дурсамждаа бичсэн байдаг.

### ДУГАРЫН ГАРАМЖАВ

1921 оны Ардын хувьсгалын партизан. Тэрээр 23 насандаа Ардын Хатанбаатар Магсаржавын цэрэгт орж, Улиастайд цагаантны эсрэг тулалдаж, хурандаа Вандановыг баривчлах, цэргүүдийг нь буулган авахад биечлэн оролцож явсан түүхэн гавьяатай хүн юм. Тэрбээр Ардын цэрэгт алба хааж, жирийн байлдагчаас Зүүн хязгаарын Дарьгангын 35 дугаар тусгай морьт хорооны штабын дарга хүртэл дэвшин алба хааж байв.




### ШАГДАРЫН ГАВАА

Тус сумын 7 дугаар багийн иргэн Шагдарын Гаваа Ардын цэргийн 6 дугаар дивизийн 17-р морьт хорооны 2 дугаар суманд албаа эхэлжээ. 1939 оны 5 дугаар сарын сүүлчээр олон удаагийн тулалдаанд оролцож, зарим үед бүслэгдэж, бүслэлтийг сэт цохиж, халуун амь, бүлээн цусаа умартан тулалдаж явсан олон эрэлхэг дайчин, мэргэн буучийн нэг нь Гаваа байсан юм. Түүний эх орныхоо тусгаар тогтнолын төлөө байгуулсан гавьяа зүтгэлийг нь төр засгаас үнэлж, “Байлдааны гавьяаны улаан тугийн одон”, ойн медалиудаар шагнасан байна.

### БАТЫН ГАНЖУУРЖАВ

Б.Ганжууржав 20 настайдаа цэргийн албанд мордож, Матадын 8 дугаар дивизийн их бууны дивизоны 2 дугаар батарейд их бууны наводчикаар ажиллаж байв. 1939 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Халх голыг гаталж,


Хайлаастын голын зүүн талд япончуудтай хүч үзэн тулалдсан нь Ганжууржавын хувьд мартагдсан аргагүй дурсгалт, бас дайчин нөхдөөрөө бахархах үйл явдал болжээ. Батарейд хүч нэмэгдүүлэхээр эх оронч Ч.Дугаржавын 23 дугаар морьт хороо ирж, 8 дугаар дивизийн дарга, хурандаа Нянтайсүрэн, дивизионы дарга, ахмад Готов, батарейн дарга, ахлах дэслэгч Ц.Цэгмид нарын тушаалаар дайсны өөдөөс гал нээж, бараг бүхэл бүтэн суманг устгасан байна.



7 дугаар сарын сүүлчээр маршал Х.Чойбалсан, Ч.Дугаржав нар галын шугаманд ирж Ганжууржав тэргүүтэй 7 байлдагч, дарга нарт “Байлдааны гавьяаны улаан тугийн одон” гардуулжээ. Эх орны эрэлхэг хүү Ганжууржав дайн дуустал том, жижиг олон тулаанд оролцож, удаа дараа амьд хэл олзолж байсан гэдэг.


### БАВУУГИЙН ХЯРВАА

Тэрбээр 1916 онд төржээ. 1936 онд Ардын цэргийн 5 дугаар корпусын 14 дүгээр морьт хорооны танк эсэргүүцэх 45 мм-ийн бууны салаанд наводчик хийж байжээ. 1939 онд 14 дүгээр морьт хорооны хоёр тасаг Баянтүмэнд бөмбөгдүүлсний дараа шууд Халх голын дайны талбарт очиж, Хөх өндөр, Дархан уулын хориглолтонд дайн дуустал тулалдахдаа Япончуудыг тасаг, салаагаар нь олзолж байжээ. Цэрэгт байхдаа Монгол бичиг сурсан Б.Хярваа 1939 оны 10 дугаар сард халагдаж ирмэгц бага сургуулийн багш нарын курст суралцсан байна. Улмаар 1940 онд сумынхаа бага сургуулийн босгын чулууг тавилцаж, анхны багшаар нь ажиллажээ. Тэр цагаас хойш ахмад дайчин Хярваа 40 гаруй жил улсад алба хашжээ.



### ДӨШИЙН БАНЗРАГЧ

Д.Банзрагч идэр залуудаа эр цэргийн албанд мордож, Халх голд дарийн утаа үнэртэж, эх орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэж явсан ахмад дайчдын нэг. Тэрээр цэргийн албанаас ирмэгц нутаг усандаа мал маллан суурьшижээ. Тэрээр “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдаж байсан байна. Мөн АИХ-ын депутатаар сонгогдож байсан Д.Банзрагч аймаг, сумынхаа олон удаагийн аварга малчин цол хүртэж явжээ.



**МОНХОРЫН ИШЗАНА**

Агтын голын унаган хүү 19 насандаа эр цэргийн албанд мордсон бөгөөд 1939 онд Улсын баатар П. Чогдонгийн командалсан хилийн отрядын Хэрээ уулын заставт алба хааж байхдаа зэвсэглэн улсын хил зөрчин орж ирсэн тагнуулуудтай халз тулалдан, онч мэргэн хараа, уран арга мэхийг хэрэглэн буулган авч байсан аж. Эрэлхэг дайчны эх орныхоо төлөө байгуулсан гавьяа зүтгэлийг төр засаг үнэлэн “Алтан гадас” одонгоор шагнажээ. Тэрбээр цэргээс халагдсныхаа дараа мал маллаж байгаад 1955 онд жолооч болж, тээврийн байгууллагад 30 гаруй жил ажиллахдаа “Осолгүй манлай жолооч” алдар хүндийг хүртжээ.



**ӨЛЗИЙБАЯРЫН СОНОМЖАМЦ**

Ахмад дайчин Ө.Сономжамцыг мото буудлагын ангид алба хааж байхад нь Халх голын дайн эхэлжээ. Тэрбээр галын тэргүүн шугамд байж, Япончуудтай тулалдаж явсан байна. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1939 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 60 дугаар тогтоолоор үүргээ онц гарамгай биелүүлсэн байлдагч Ө.Сономжамцыг 731 тоот “Алтан гадас” одонгоор шагнасан тухай үнэмлэх бичигт Улсын Бага Хурлын дарга Бумцэнд, нарийн бичгийн дарга Баяр нар гарын үсгээ зурсан байдаг. Ө.Сономжамц цэргээс халагдаж ирснийхээ дараа Бүрэн сумын 11 дүгээр багийн дарга, агент зэрэг ажил хийж байжээ.



**ДАЛХААГИЙН РАГЧАА**

1925 онд Бүгдгээнд төрсөн. Сумандаа манаач, галч, улаач зэрэг ажил хийж бага насаа өнгөрөөжээ. Д.Рагчаа 1945 онд цэргийн албанд мордож, Улсын баатар Л.Дандарын командалсан 5 дугаар морьт дивизийн байлдагч болон Жанчхүү, Хөх хотыг чөлөөлөхөд оролцож явсан байна. Д.Рагчаагийн энх тайван, тусгаар тогтнолын төлөө тэмцэж явсан баатарпаг гавьяаг үнэлж “Бид ялав”, Зөвлөлтийн “Японыг ялсны төлөө” медаль, “Жуковын Медаль” болон Зэвсэгт хүчний, Ардын хувьсгалын ойн медалиудаар шагнасан байна.



**ГАЛАЙН ШАРАВЖАМЦ**

Агтын голын унаган хүү 20 настайдаа ардын цэргийн албанд мордож, цэргийн мал эмнэлгийн 1 жилийн курст суралцан төгссөнийхөө дараа морьт цэргийн хороо, суманд малын бага эмчээр ажиллаж байжээ. Г.Шаравжамц морьт хороотойгоо Өвөр монголын Долнуур, Жэхэ хотуудыг чөлөөлөх тулалдаанд оролцож явсан ахмад дайчин юм.

1947 онд ахлагч дэслэгч цолтой Г.Шаравжамц цэргийн албанаас халагдаж мэргэжлийнхээ зам мөрийг хөөн Хөвсгөл, Булган, Дорнод аймагт малын бага эмчээр ажиллажээ. Түүхийн нэгэн гэрч болсон энэ ахмад дайчин Монгол-Зөвлөлтийн ялалтын медалиуд, Чойбалсангийн “Мэргэн буудагч” тэмдгэр шагнуулжээ.



**САМДАНГИЙН ЖАДАМБАА**


1919 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Цагаан бургас гэдэг газар малчин ард Самдангийн гэрт ууган хүү болон төрсөн. 1951 оноос эхлэн Дорнод Аймгийн Захиргаа, засвар бааз, Барилга, Тээврийн Удирдах Газарт гагнуурчин, салбарын дарга, механикч, мөн Биеийн тамир Спорт хороонд дарга зэрэг ажлуудыг хийж явсан.

Цэргийн Ерөнхий Суруулийн их бууны ангийг онц дүнтэй суралцан төгсөж, 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайнд амь биеэ үл хайрлан галын фронт дээр тулалдаж явсан бөгөөд 1939 оны 7 сарын 9-нд Байлдааны хүндэт медалиар дараа нь “Халхын гол”, ойн медалиуд мөн бусад хүндэт шагналуудаар удаа дараалан шагнуулсан. 1950 онд Чойбалсан хотын 2-р спартикадаар урт, өндрийн харайлт, гүйлтийн төрлөөр оролцон түрүүлж, улсын рекорд тогтоож байжээ.



**САМДАНГИЙН ЧОЙЖОО**

1921 онд одоогийн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг “Бургаст” гэдэг газар малчин ард Самдангийн 2-р хүү болон төржээ. Бага насандаа эцэг эхийн гар дээр өсөж, 1943 онд 21 насандаа цэргийн албанд мордож, 1947 онд халагджээ. Тэрээр Цэргийн албыг Халх голын ...дугаар отрядад хилчин холбоочноор хааж, чөлөөлөх дайнд оролцож явсан ахмад дайчин юм. Цэргийн албанаас орон нутагтаа буцаж очоод малчин болж, эхнэр авч амьдрах хугацаандаа 12 хүүхдээ өсгөн хүмүүжүүлсэн юм. 1959 онд




тус сумын “Давшилт” нэгдэлд гишүүнээр элсэн зохих хэмжээний малаа нэгдэлд нийгэмчилж байсан. Энэ хугацаанд сумын “Сайн малчин” цол тэмдгээр шагнагдаж байсан. С.Чойжоо нь 1963 оноос эхлэн Төмөрбулаг сумын үйлдвэр бригадын ажилчин болж, дархан мужааны ажлыг хослон хийж байжээ.

**ДОЛГОРЫН ГЭЛЭГСЭНГЭ**

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд 1924 онд төрсөн. 1944 онд ардын цэрэгт татагдаж морин өртөөгөөр олон хоног явж Бөхөг түргэний гол каринтинд суралцан улмаар 1944 оны 8-р сарын 15-нд тангараг өргөөд Баянцагааны 23 дугаар отрядын 2-р суманд хуваарилагджээ.

Тэрээр 1944 онд отрядын төвд пулементын дамжаа төгсөж, түрүүч цол авсан бөгөөд 1945 оны чөлөөлөх дайнд оролцож, “Бид ялав” медалиар шагнуулжээ. Энэ хүн цэргээс халагдаж ирэхдээ Давшилт нэгдлийн буюу Төмөрбулаг суманд анхны машин ЗИС-5 гэдэг модон кабинтай машиныг жолоодон авчирч байсан түүхтэй. Тэрээр нэгдэлд жолоочоор 30 гаруй жил ажиллаад 1983 онд тэтгэвэрт гарчээ.



**ЁНДОНГИЙН БАТ-ОЧИР**

1945 оны чөлөөлөх дайнд оролцож явсан ахмад дайчин Ё.Бат-Очир нь мал маллах арга ухаанаараа олныг дагуулж, шинэ үеийн анхны мянгат малчин болж байжээ.




**ЧАДРААБАЛЫН ДАЯНДОРЖ**

Хуульч мэргэжилтэй. Хууль цаазны дунд сургууль, МУИС-ийн хуулийн ангийг төгссөн. Ардын армийн дэд хурандаа. Бүгдгээний голын уугуул Ч.Даяндорж 1945 оны чөлөөлөх дайнд оролцож явсан ахмад дайчин бөгөөд 1949 оноос Ардын армийн анги нэгтгэлүүдэд улс төрийн орлогч, 1958 оноос Хөвсгөл, Булган аймгийн шүүхийн дарга, 1962 оноос Цэргийн тусгай шүүхийн орлогч даргаар 1983 он хүртэл ажилласан ахмад хуульчийн нэг юм. Төр, засаг түүний гавьяа, зүтгэлийг үнэлж “Байлдааны гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одонгоор шагнажээ.



**ОРШИХЫН БАТНАСАН**

Төмөрбулаг сумын бахархал болсон эх орны чөлөөлөх дайны ахмад дайчдын нэг, ууган нэгдлийн анхны гишүүдийн төлөөлөл Оршихын Батнасан 1910 онд Шинэ-Идэр сумын нутаг Зүүн нуурын Бөөн мод хэмээх газар малчны бор гэрт айлын ууган хүү болон төржээ. Оршихынх дөрвөн хүү, гурван охинтой байжээ. О.Батнасан айлын том хүү болохын хувьд хар багаас нутгийн чинээлэг айлын мал маллах, бусдыг дагаж жин тээвэр хийх зэргээр аав ээжийн амьдрал ахуйд дэм нэмэр болдог байв.



Тэрээр, эрийн цээнд хүрч 1932 онд дүү О.Батдэлгэр, О.Баттөр нарын хамт эр цэргийн албанд морджээ. Тэр үед эр цэргийн албыг таваас доошгүй жил хашдаг цаг юмсанж. О.Батнасан 1939 оны дайнд оролцож Матадын 25 дугаар морьт хорооны унаа морьд маллаж, улмаар эх орноо хамгаалахаар Тамсагбулагийн чиглэлээр Цагаан хэрэм хүртэл чөлөөлөх дайнд нөхдийн хамт мөр зэрэгцэж шатахуун түгээх дамжин өнгөрүүлэх цэг дээр түгээгчээр ажиллаж байсан гэдэг. Дайсны онгоц шатахуун түгээх цэгийн ойролцоо бөмбөгдөхөд богино хугацааны дотор зузаан шороогоор өнгөлөн далдалтаар хамгаалалт хийж гавьяа байгуулсан учир “Бид ялав” медалиар энгэрээ мялаасан байна. Харамсалтай нь дүү О.Баттөр дайсны хордуулсан худгийн уснаас мэдэлгүй балгаж амь насаа алдсан гэдэг.

О.Батнасан цэргийн албаа хааж нутаг усандаа ирснээс хойш хувиараа мал маллаж байгаад 1956 онд Бүрэнтогтох сумын Тээл багийн нутагт байгуулагдсан “Саруул зам” нэгдэлд бүх малаа нийгэмчлээд гишүүнээр элссэн байна.

**ЗАГДСАМБАРЫН БАТБААТАР (1959-1989)**

Түймэр эсэргүүцэн хамгаалах агаарын харуулын албанд зүтгэж явсан энэ залуу Төмөрбулаг сумын Бадгын голд төржээ. Тэрээр 16 настайдаа шүхрийн албанд орсон бөгөөд спортын 1 дүгээр зэрэгтэй тамирчин байлаа. Харамсалтай Загдсамбарын Батбаатар 1989 оны 5 дугаар сарын 29-ны өдөр Ханх сумаас нисч Хатгал сууриныг дайран ой хээрийн түймрийн эргүүлийн албыг гүйцэтгэж явахдаа Арбулаг сумын “Урд гялаа” гэдэг газар албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алджээ. Албан үүргээ гүйцэтгэж яваад хүн ардынхаа төлөө залуу халуун насаа зориулсан энэ залууг “Байлдааны гавьяаны одон”-гоор нэхэн шагнасан байна.



**ГУРАВДУГААР БҮЛЭГ****ТӨМӨРБУЛАГ  
СУМЫН ТҮҮХ***/1930-1960/*

Эсэргүү бослого дарагдаж, Халх голын байлдаанд Монголчууд ялалт байгуулсан он жилүүдийн дараа хөдөө орон нутагт малын тоо толгойг өсгөх, ашиг шимийг нэмэгдүүлэх, худаг ус, хашаа саравч, хадлан тэжээл базааж их ажил өрнөж байлаа. 1940 он гэхэд Төмөрбулаг сум ардчилсан үндсэн дээр байгуулагдсан төр захиргаа, нам, олон нийтийн байгууллагатай, 9 баг, 878 өрх, 2610 хүн амтай, үүнээс 617 нь монгол бичиг мэддэг, 73 хүн ямар нэг шатны сургуульд суралцсанаас бага сургуульд 63, дунд сургуульд 3, худалдааны техникумд 2, ХАА-н техникумд 2, хүн эмнэлгийн техникумд 2, сарын курст 1 хүн суралцаж, сумын хэмжээнд орос хэл мэдэх 1 хүн байжээ.

Бүгд 96509 толгой малтай болж, 1935 оныхоос 13 хувиар, бичиг мэдэгчид бараг дөрөв дахин тус тус өссөн байна.

**Фронтод туслах аян**

Дайн тулааны хүнд цаг байсан ч тус сумын малчид 1941 онд малаа өмнөх оныхоос 11 хувиар өсгөж, 107449 толгойд хүргэсэн байна. Зөвлөлтийн улаан армид туслах, эх орон даяар өрнөж байсан хөдөлгөөнд Төмөрбулагчууд нэгдэж, их хэмжээний хандив, мөнгө, адуу мал бэлэглэжээ. Зөвхөн 1943 оны 2 дугаар сар гэхэд 14894 төгрөг хуримтуулж явуулсан байна.

Тус сумын 5 дугаар багийн ард Лувсанцэрэн 800 төгрөг, морь 1, 3 дугаар багийн Хуушааны Намсрай 1500 төгрөгийн үнэтэй өөрийн хайртай хурдан морь, 7 дугаар багийн Чадраабалын Жамсран 7 морь, 8 дугаар багийн Ядамсүрэнгийн Галиндэв 8 морь гэх мэтээр бэлэглэж, 1944 он гэхэд тус сум 1100 морио фронтод илгээж байв.

Аймгийн яамны 1943 оны ажлын тайланд “Төмөрбулаг сумын артелийн оёдолчин эмэгтэй Өнжийн Батсүх жилийн нормоо 387 хувь, мужаан Анжгаа хэмээх Ядамсүрэн 288 хувь, Ядамын Нямаа 229 хувиар, М.Банзрагч 216 хувиар тус тус биелүүлж, фронтод бэлэг барьсан тухай дурьджээ. Тухайн үед сумын иргэд ажлын цагаа сунган, өдөрт 10-12 цаг ажиллаж байлаа.

Төмөрбулаг сум мал бэлтгэлийн 1945 оны төлөвлөгөөт даалгаврыг ханган биелүүлж, үхрийн мах 84.6 тн, хонины мах 472.9 тн, ямааны мах 273.1 тн, бүгд 833.6 тн мах бэлтгэн нийлүүлсэн байна. Мөн цэргийн агтанд 106, махны агтанд 174 адуу бэлтгэн өгч байв.

**1945 оны чөлөөлөх дайн**

“1945 оны чөлөөлөх дайн нь дэлхийн дайныг төгсгөх чухал ач холбогдолтой байсан, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж чадахгүй басамжлагдаж байсан монголчууд энэ дайнд оролцсоноор ялагч гүрнүүдийн эгнээнд жагссан. Чухам энэ дайнд оролцсоны дүнд Хятадууд Гадаад Монголын бүрэн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болсон юм” гэж түүхчид үздэг. Тэгвэл энэхүү чөлөөлөх дайнд тус сумын иргэд ч оролцож, баатарлаг гавьяа байгуулсан юм. Ахмад дайчин, Алтан гадас одонт Монхорын Ишзана, ахмад дайчин Донойн Чулуун, Ганьдийн Жигжид, Галайн Шаравжамц, Ядамсүрэнгийн Жаамаа, Гэндэнгийн

Дамдин, Долгорын Гэлэгсэнгээ, Оршихын Батдэлгэр, Ё.Бат-Очир, Д.Рагчаа, Олцойны Цогбадрах, Паалааны Банди, Самдангийн Чойжоо, Гэндэнгийн Дамдин, Даваасүрэнгийн Жамсран, Далхаагийн Далай, Паньдийн Лхагваа Ёндонгийн Бат-Очир, Тогтохын Ишдорж, Зэгвийн Чимэдрагчаа, Цогзолын Лосол, Оршихын Чулуун нарын зэрэг олон эрс энэ дайнд оролцож явжээ. Үүнээс гадна Төмөрбулагчууд дулаан хувцас, хувийн бэлэг бэлтгэхийн хамт улсын тэргүүний анчин 6 дугаар багийн ард Бүргэдийн Чимэд-Очир, Ерөөлтийн Жүгдэр, 7 дугаар багийн иргэн Өлзийн Сүрэн, Бумбуудайн Жүгдэр нарын зэрэг анчид гөрөөс, гахайн мах, ангийн үс, арьс бэлтгэн фронтод илгээж байсан байна.

### Улсын сайн малчдын зөвлөгөөн болов

1940 онд Улсын сайн малчдын анхдугаар зөвлөгөөнд тус сумаас Цэдэнгийн Цэрэнсүрэн, 1943 оны II зөвлөгөөнд Жүгдэрийн Цэрэнсүрэн, Загдын Ланжуу, 1950 оны III зөвлөгөөнд 9 дүгээр багийн ард Дамчаагийн Дарамжав, 1955 оны IV зөвлөгөөнд 6 дугаар багийн ард Ерөөлтийн Жүгдэр нар шалгаран оролцож, “Улсын сайн малчин” цол тэмдэг, Ц.Цэрэнсүрэн, Ж.Цэрэнсүрэн, Д. Дарамжав нар “Алтангадас одон”-оор З.Ланжуу, Е.Жүгдэр нар Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдаж байжээ. Энэ үед тус сумын иргэн Ж. Цэрэнсүрэн 1000 малтан болох амлалт авч, энэхүү амлалтаа биелүүлжээ. 1943-1945 онд тус сумын амьжиргааны үндэс мал сүрэг 17561 толгой малаар хорогдож, 1945 онд 89888 толгой мал тоолуулж байсан мэдээ байна.

### Бага сургууль байгуулагдав

Төмөрбулаг суманд үйл ажиллагаа явуулж байсан бичиг үсгийн зуны түр сургуулийг 1940 онд ардын бага сургууль болгон шинэчилжээ. Энэхүү Бага сургууль нь 1940 оны 9 дүгээр сарын 1-нд нэгдүгээр ангийн хоёр бүлэгт 60 сурагчтайгаар хичээлээ эхэлсэн бөгөөд анхны захирал нь Ишбалын Давааням, багш нь Бавууны Хярваа нар байжээ. Ахмад багш, өндөр настан Б.Хярваа “Бага сургуулийг цулгүй газар, бүхнийг шинээр барьж босгон байгуулах болсон.



Бүгсийн хүрээн дээрээс хоёр хуучин модон байшин, шургааган хашаа, таван гэрийн модон шал зэргийг нутгийн ард Очоохүү, Шар Даваа нарын хамт үхэр тэргээр олон хоног зөөж, сумын төвд авчирсан. 60 хүүхдээ бүрэн дотуур байранд оруулахын тулд таван гэр, хичээл хийх хоёр гэр бүгд долоон гэр шаардагдаж байлаа. Гэрийн модыг Барамсай гэгч өвгөн төхөөрч өгсөн. Нэг ширхэг эсгийг ардуудаас 20 төгрөгөөр худалдан авч байлаа. Ардууд сайн дураар эсгий ачаад л ирдэг байсан. Угаалгын байр, гал тогоо, түлээ бэлтгэх зэрэг ажлыг багш, захирал адилхан оролцож байж амжуулсан. Аймгаас 20 мянган төгрөгийн төсөв, хөрөнгө өгсөн” хэмээн дурсан ярьжээ. Бага сургуульд монгол бичгийн цагаан толгой,

тоо бодлого, үг хөгжил, биеийн тамир, жагсаал тактикийн сургууль, зураг зэрэг хичээл зааж, хичээлээ үдээс хойш бататган давтлага хийдэг байжээ. Тухайн үед дайны хүнд хэцүү цаг байсан тул харандаа, бэх, дэвтэр ховор, тэмээний хоргол шатааж чихэртэй холиод бэх хийдэг, хог дээрээс бал түүдэг, барааны ороолт цаас үдэж дэвтэр хийдэг байсан тухай Төмөрбулаг сумын түүхэн номонд тэмдэглэсэн байна.

Сургуулийн анхны захирал Ч.Давааням, багш Б.Хярваа нар 50-60 төгрөг, комендант Д.Бат-Очир, галч Долгор нар 30-40 төгрөгийн цалинтай байжээ.

### Бага сургууль анхны төгсөлтөө хийв

1944 онд 52 сурагч анхны төгсөлтөө хийж сурлага сайтай хүүхдүүд бичиг үсгийн багш болох, зарим нь курст суралцаад эргээд сургуульдаа багшилж байв. Тус сургуулийн сурагч байсан Оршихын Гун-Аа, Л.Цэндээжи, Нордовын Аюушжав, Дэжээгийн Дэнсээхүү, Батдэмбэрэлийн Дамба, Өвгөний Мажиг, Доншавагийн Аюушжав, Жамьянжавын Дамдиндорж, цэргээс ирсэн Сүрэнгийн Гомбо, Сүхийн Сэнгээ нар 1946-1950 онуудад сумын бага сургуульд багшилж, Маналжавын Ойдов гэдэг хүн комендатаар ажиллаж байв.

### Газар тариалангийн ажил эрчимжлээ

Дайны жилүүдэд хүнсний нөөцөө арвижуулах зорилгоор нутгийн ардууд суваг, шуудуу татаж халтар арвай, улаан буудай тариалах ажилд санаачлага гарган ажиллаж байсан олон баримт байдаг. 1943 оны үед 8 дугаар багийн ард Паньдийн Сэрээтэр (олондоо Аньдий гуай гэж нэрлэгдсэн) Жаргалантын голын дээд хэсгээс шуудуу татаж ус урсгах зураг хийж, уг ажлаа нутгийн хэсэг ардуудын хамт хийж гүйцэтгэжээ. Энэ шуудуугаар сумын төвийн дээд талын ногооны талбайг усжуулж байсан бөгөөд хожим сумын мод цэцэрлэг услах болжээ. Мөн нэгдүгээр багийн ард Гомбодоржийн Мижид, Д.Гомбоо нар Бүгсийн голоос ус урсгах зорилгоор Цагаан толгой давуулан шуудуу татаж байсан байна. Дайны хүнд жилүүдэд сумын даргаар Ж.Рагчаа, Н.Лосол, Наваан, Чойжилсүрэн, Далхаа, нарийн бичгийн даргаар Дашзэвгэ, Минжүүр, Ц.Батмөнх, намын үүрийн даргаар Л.Гүнчин-Иш, Д.Долгорсүрэн, Б.Сэнгээ нар ажиллаж байжээ.

### Шинэ үсгийн бүлгэмүүд байгуулагдав

Монгол бичгийг халж, бүх нийтээр шинэ (кирилл) үсэгт сурах хөдөлгөөн өрнөж байсан жилүүдэд энэ суманд 1942 оноос залуучуудыг бичиг үсэгт сургах 15-30 хүнтэй бүлгэм хичээллэж, улмаар давтан ба шинээр сургах гэсэн үе шаттай сургалт зохион байгуулж байлаа. Сумын анхны шинэ бичиг үсгийн багшаар 5 дугаар багийн ард Балжирын Бэгз ажиллаж байжээ. 1942-1954 оныг дуустал 1096 хүнийг давтан буюу шинээр бичиг үсэгт сургаж, тус сумын насанд хүрсэн хүний бараг 90 гаруй хувь нь бичиг үсэгт тайлагдаж байсан баримт байна. Бичиг үсэгт сургах багш нарт тэр үеийн боловсролтой олон хүнийг дайчлан оролцуулж, баг бүрт бүлгэм хичээллэж байсан ба сумын төвийн шинэ үсгийн багшаар Уваан Сэнгээ 1948 онд ажиллаж байсан тухай баримт байдаг.

## ***Улаан булан барив***

Тус сумын иргэд хөрөнгө хуримтлуулан “Улаан булан” барих шийдвэр гаргаж, 1946 онд Ёргоон Цанжид тэргүүтэй хэсэг мужаан барилгыг эхэлж улмаар 1947 онд ашиглалтанд оруулжээ. Төмөрбулаг сумын улаан булангийн анхны эрхлэгчээр Сүхийн Хуушаан ажиллах болсноор соёл урлагын байгууллагын үндэс суурь тус суманд тавигдсан юм.

## ***Сумын артель өргөжин тэлэв***

1940-өөд оны дунд үе гэхэд сумын артель аж ахуй зохион байгуулалтын хувьд нилээд бэхжиж, ард түмний өргөн хэрэгцээний эд зүйл үйлдвэрлэхийн хамт бээлий, дах, дэгтий, цэрэг дээл, орос эмээл зэргийг чанар, хийц сайтай хийж фронтод илгээж байв. Энэ үед артелийн даргаар шар Дармаа, Чойжилсүрэнгийн Лхамсүрэн, Дамбын Шарав, ня-бо-гоор Гүндсамбуу, Чадраабалын Мандшир нар ажиллаж, оёдолчин Өнжийн Батсүх “Улсын ударник” цолоор шагнагдан, мужаан Ядамсүрэн, Я.Нямаа, М.Банзрагч нар дайны үед норм төлөвлөгөөгөө 288- 216 хувиар биелүүлж байв.

## ***Сүү тосны завод байгуулав***

Сумын сүү тосны заводыг 1946 онд байгуулж, анхны жилдээ 133 мянган литр сүү хүлээн авч, 5.5 тн тос боловсруулж байсан бол 1951 онд 624.7 мянган литр сүү хүлээн авч, 28.1 тн цөцгийн тос боловсруулан, 3523 үнээг саалинд хамруулж байв. Сумын сүү тосны заводын анхны дарга мастер нь Цумбаагийн Даньдгайсүрэн, туслах нь Жигжид гэгч хүн ажиллаж байжээ. Сүү тосны заводын анхны мэргэжилтнүүдийн нэг Лхамсүрэнгийн Банзад 1948 онд мастер цолны болзол биелүүлж байжээ. Тухайн үед сүү хүлээн авах тасгуудыг Ноён хошуу, Жаргалантын ам, Тариат, Бүгдгээн, Бүгсийн ам зэрэг газруудад 1-2 багийн дунд байрлуулж, үнээг зохион байгуулалттайгаар саалинд хамруулж байжээ. Авто хөсгийн зам нээгдээгүй шахам байхад 1940 оны сүүлчээр тус сумын 6 дугаар багийн харьяат “Өнхрүүлэг” хэмээх жолооч Жамбаа “ЗИС-5” машинаар сумын төвд ирж цөцгийн тос тээвэрлэж байжээ.

## ***Морин өртөөг халав***

1949 онд улс даяар морин өртөөг халж, улмаар авто өртөө байгуулсан нь сумын түүхэнд том үйл явдал болжээ. 1949 оны 10 дугаар сард тус сумын 7 дугаар багийн харьяат, жолооч Санжмятавын Лхагважав модон хаалгатай” ГАЗ-51” машинаар шуудангийн авто үйлчилгээг анх сумандаа хүргэж ирж байжээ.

## ***Харилцаа холбооны шинэ шугам тавигдлаа***

1950 оны зун, намар сумын 6, 7, 8 дугаар багийн ардууд голлосон 21 хүн, 10 шар тэрэгтэй утасны шон мод авч бэлтгэх, нүх ухах ажил хийж, 12 дугаар сарын 30-нд годон шугам буюу нэг гинжтэй шугам ашиглахад бэлэн болж, сумын төвд Мятавын хувийн жижиг байшинд “МБ” маркийн аппаратт суурилуулснаар орчин цагийн харилцаа холбооны байгууллага

Төмөрбулаг суманд үүдээ нээжээ. Холбооны салбарын анхны эрхлэгчээр Дулдуйтын Лувсан гэгч хүн ажиллаж байсан байна.

## ***Эрчмийн оргил нэгдэл байгуулагдав***

1956 оны хоёрдугаар сарын 10-нд Дөшийн аманд Чогсом гэдэг айлд Н.Лосол, Я.Сосорбарам, тэргүүтэй 24 өрхийн 42 хүн цуглаж, хүн бүр 15-20 төгрөг цуглуулж, аминыхаа малын 50 хувийг нийгэмчилж, 250 толгой малтайгаар Дөшийн “Эрчмийн-Оргил” нэгдлийг байгуулжээ. Тус нэгдэл 1956 онд найман га-д эрдэнэшиш, арвай тариалж, нэгдлийн гишүүн Ц.Гун-Аажав, Б.Шарав нар тэмээн хөсгөөр давс, түлээ тээвэрлэж байсан байна.

## ***Нэгдэлжих хөдөлгөөн эрчимжлээ***

Улс ардын аж ахуйг хөгжүүлэх 1947-1952, 1953-1954 зэрэг таван жилийн төлөвлөгөөт жилүүдэд тус сум аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэхжиж байлаа. 1950-аад оны дундуур эрч хүчээ авч байсан нэгдэлд олноор элсэж малаа нийгэмчлэж эхэлжээ. 1950 онд Төмөрбулаг сум улсад үхрийн мах 205.7 тн, хонины мах 187.7 тн, ямааны мах 78.7 тн буюу 10086 толгой мал улсын бэлтгэлд тушаан ердийн хөсгийн тээвэрт 96 морь, 58 тэмээ, 144 шар хөдөлгөж байв. 1950 онд сумын өрхийн тоо 816, нийт хүн ам 2109, мал сүрэг 85129 толгой байв. 1950 оны мал өсгөх төлөвлөгөөг 24 өрх бүх төрлөөр нь өсгөж биелүүлж байжээ. Сумын мал сүрэг 1952 онд 100 мянга давж, сумын захиргаанд орлогч даргын орон тоо буй болжээ. 1950 онд 307.2 мянган төгрөгийн бараа татан авч борлуулж байсан сумын Эд хэрэглэгчдийн хоршоо нь 1952 оны байдлаар 515 хувь нийлүүлсэн гишүүнтэй, баг бүхэнд суурин болон ганзагын агенттай болж, малчдын гар дээрх ноос, арьс шир, түүхий эдийг төвлөрүүлэн бэлтгэдэг системтэй болж, мал тууварлах, жин тээвэрт малчдыг гэрээгээр оролцуулж, ард олныг өргөн хэрэгцээний бараагаар ханган үндсэн үүргээ биелүүлж байлаа.

## ***Худалдаа бэлтгэлийн анги байгуулагдав***

1959 онд Эд хэрэглэгчдийн хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн гуравны хоёрыг улс худалдан авч, худалдаа бэлтгэлийн анги гэгдэх болсноор материаллаг бааз, үйлчилгээний нэр төрөл, хүрээ өргөжин, 23 орон тоотой ажиллах болсон байна.

## ***Гар үйлдвэрийн артелиг татан буулгав***

Төмөрбулаг суманд үйл ажиллагаа явуулж, байсан сумын гар үйлдвэрийн артелиг 1950 онд аймгийн шийдвэрээр татан буулгаж, Мөрөнгийн артельтэй нийлүүлжээ.

## ***Анхны сонгуулийг зохион байгуулав***

1951 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Ардын Их Хурлын сонгуулийг сонгуулийн шинэ системийн үндсэн дээр анх удаа явуулж, Төмөрбулаг сумын тойрогт нэр дэвшсэн БНМАУ-ын Хоршоодын Төв Холбооны дарга Маандарийн Лувсанцэрэнгийн төлөө Төмөрбулагчууд саналаа 100 хувь өгч, АИХ-ын анхны депутатаар сонгожээ. 1952 оны 10 дугаар сарын 19-нд орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын сонгууль явагдахад Хөвсгөл аймгийн Ардын хурлын анхны депутатаар тус сумын 2 дугаар



багийн малчин Бямбаагийн Надмид, 3 дугаар багийн малчин Дэжид, сумын дарга Жамсрангийн Цэрэндорж нар сумаа төлөөлж сонгогджээ.

Аймагт алба хааж байсан тус сумын харьяат, аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга агсан Доншавгийн Цэрмаа, аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дарга байсан Дамдины Дашхүү, Аймгийн цэргийн Хэлтсийн туслах байсан Сүхийн Готов нар өөр тойргуудаас аймгийн анхны депутатаар сонгогдож байжээ. Мөн Төмөрбулаг сумын депутатаар 30, багийн депутатаар 63 хүнийг сонгож байжээ. Сумын нарийн бичгийн дарга байсан Чойжилсүрэнгийн Доржпалам, багийн дарга Сүхийн Өлзийбаяр, Донойгийн Чулуун, Навааны Балдан, Цогзолын Лосол, Лувсандоржийн Дорж, Жамбын Пүрвээ, Н.Лосол, Шатраагийн Лхамжав сумын анхны хурлын депутатаар сонгогдож байжээ.

### **1931-1959 ОН ХҮРТЭЛ ТӨМӨРБУЛАГ СУМЫН БАГИЙН ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮСИЙН НЭР**

1 дүгээр багийн даргаар: Яйчил, Жүгдэрийн Гэндэн, Бунжиган Лувсанбалдан, Лувсангийн Баадай, Донойн Чулуун

2 дугаар багийн даргаар: Дамбын Гунгаа, Авирмэдийн Ядамсүрэн, Жамбын Пүрэв, Шошийн Гончиг,

3 дугаар багийн даргаар: Хуушааны Намсрай, Жамбаа, Жансамын Шагдарсүрэн, Навааны Гэлэгпил,

4 дүгээр багийн даргаар: Дагвын Санж-Ёндон, Лувсангийн Ёндонжамц, Навааны Балдан,

5 дугаар багийн даргаар: С.Гомбожав, Чойсүрэнгийн Лхамсүрэн, Дамбын Шарав, Балжирын Бэгз, Алтангэрэл

6 дугаар багийн даргаар: Жигмэдийн Санжмятав, Янжингийн Дашдаваа, Зундуйн Очирбат, Цогзолын Лосол, Монхорын Ишзана, Ядамын Чулуунбат, Даньдгайсүрэнгийн Дуйнхаржав,

7 дугаар багийн даргаар: Балжирын Дамдинсүрэн, Цэндийн Дамдинжав, Бавууны Баадай, Даваасүрэнгийн Жамсран, Шагдарын Балдан, Дайлаагийн Гомбодорж,

8 дугаар багийн даргаар: Зундуйн Цэдэнсодном, Б.Дүвчин, Бат- Очир, Дөшийн Банзрагч, Сүхийн Өлзийбаяр, Долгорын Лханаажав, Номпэйн Шанж

### **Эрчмийн Оргил нэгдэл байгуулав**

Тариатын “Шинэ-Амьдрал”, Бүгсийн “Оч” Тээлийн “Саруул зам” нэгдлүүд тухайн үед байгуулагдаад байлаа. 1956 оны 2 дугаар сарын 10-нд Номпэйн Лосол, Ядамжавын Сосорбарам нарын санаачлагаар тэр үеийн 5, 6, 7 дугаар багийн иргэд болох Н.Лосол, Сосорбарам, И.Галиндэв, Б.Шарав, Д.Гомбодорж, Ш.Готов, Д.Дуйнхаржав, М.Ишзана, Я.Чойдог, Д.Банзрагч, А.Луузан, Ж.Чанцал, Я.Баадай, П.Бадарч, П.Базарсад Ш.Даваахүү, Д.Сундуй, Ц.Гунаажав, М.Гомбо, Х.Шарав, Д.Дарьсүрэн, Н.Халтайхүү, Ч.Намсрай, С.Маньдир, Д.Хас, Д.Гарьд, Т.Хоролжав, Ч.Бавуу, Ч.Даньдгай, П.Дарьсүрэн нарын зэрэг хүмүүс Дөшийн аманд О.Чогсомын хуралдаж, “Эрчмийн оргил” нэгдлийг байгуулан, даргаараа Номпэйн Лосолыг

сонгожээ. Нэгдэл байгуулахад 24 өрхийн 42 хүн оролцож, хүн бүр 15-20 төгрөгөөр дундын сангаа үүсгэж 250 малтай 15 тэрэг шартайгаар ажлаа эхэлж, давс тээх, Агтын аманд тариа тарих, Дөшийн аманд нэгдлийн төв байгуулахаар тогтжээ. “Эрчмийн оргил” нэгдэл мал сүргээ Донхорын Хөх толгойн орчимд таван суурь болгон зохион байгуулж, хоёр хашаа, дөрвөн өрөө дүнзэн байшин барьж, нэгдлийн төвийг төвхнүүлж эхэлжээ. 1956 онд найман га-д эрдэнэшиш, арвай тариалж, нэгдлийн гишүүн Ц. Гунаажав, Б.Шарав нар тэмээн хөсгөөр давс, түлээ тээвэрлэж байжээ.

### **“Давшилт” нэгдэл байгуулагдав**

Улсын сайн малчин Дамчаагийн Дарамжавын санаачлагаар 9 дүгээр багийн Д.Дарамжав, Дөшийн Банзрагч, Жамсрангийн Гэлэгжамц, Шанжийн Дашбалжир, Дамдинсүрэнгийн Дашдэмбэрэл, Лувсандоржийн Дорж, Жамсрангийн Дэндэв, Мангаагын Жанцан, Очирын Лхамсүрэн, Хожоогын Магсар, Дуламын Мишиг, Пүрэвийн Ням, Дамдины Шатарбал, Сүрэнгийн Шатраа, Дамдины Чаврайч, Чогсомын Цагаач нарын 16 өрхийн хүмүүс Тэлээгийн сайрын аманд, Дарамжавын хуралдаж Хөдөө аж ахуйн нэгдэл байгуулан нэгдлээ “Давшилт” гэж нэрлэн даргаар нь Лувсандоржийн Доржийг, орлогч даргаар Жамсрангийн Гэлэгжамц, ня-бо-гоор Шанжийн Дашбалжир нарыг сонгожээ. Энэ хуралд дээрх өрхийн 32 хүн тус бүр 25-50 төгрөг нийлүүлж, нийт 1200 төгрөгийн дундын мөнгөн сан, 500 гаруй малтайгаар ажлаа эхэлжээ. Энэ хуралд сумын намын үүрийн дарга Дашбалын Жамба оролцсон байна.

### **Нэгдлүүдийг нийлүүлэв**

1955 оны гуравдугаар сард Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн тэргүүний сайчуудын анхдугаар их хурал Улаанбаатар хотод болж, энэ хуралд “Шинэ амьдрал” нэгдлийн дарга Пүрэвцэрэнгийн Дашмягмар, Жамбын Пүрэв нар оролцсон байна.

Тус суманд шинэ тутам байгуулагдсан нэгдлүүд нь эдийн засгийн хүчин чадал дорой, хөрөнгө, хүн хүчний дутагдалтай, гишүүд нь тархай бутархай зэрэг нь сумаас төвлөрүүлж удирдан зохион байгуулахад бэрхшээл учирч байлаа. “Шинэ амьдрал”, “Оч” нэгдлүүд 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаад “Оч” нэгдлийн гишүүдээс “Шинэ амьдрал” нэгдэлтэйгээ нийлж ажиллах санал гарсныг “Шинэ амьдрал”-ынхан хүлээн авч 1956 оны хавар нэгджээ. Мөн “Эрчмийн оргил” нэгдлийн гишүүдийн хурал болж, Мөнхийн Дашдэлэг, Я.Сосорбарам нарын зэрэг гишүүдийн саналаар тэр үеийн 5,6,7 дугаар багийг хамарч байсан “Эрчмийн оргил” нэгдэл зэргэлдээ орших “Саруул зам” нэгдэлтэйгээ 1957 оны 10 сард нийлсэн юм. “Саруул зам” нэгдэл нь 982 толгой малтайгаар 1952 оны 6 дугаар сарын 22-нд байгуулагдснаас хойш 6 жил болоход аж ахуй зохион байгуулалтын хувьд нилээд бэхжсэн байв. Тус сумын 4-р багийн Балдан, Ж.Готов, нарын 20-иод өрхийн хүмүүс Бүгдгээнд 1958 оны эхээр хуралдаж, ХАА-н “Ирээдүйн зам” нэгдлийг байгуулж, даргаараа сумын намын хорооны орлогч дарга байсан Жунайн Готовыг сонгожээ. Энэ нэгдэл нь удалгүй “Саруул зам”, “Давшилт” нэгдлүүдэд шилжин нийлсэн ажээ. ХАА-н



Сумын анхны багийн дарга нар.

нэгдлүүдийг өөрсдийн саналаар нь нэгтгэн томруулж, эдийн засгийн хүчин чадлыг бэхжүүлэх талаар дээд газрын заалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр “Шинэ амьдрал”, “Давшилт” нэгдлийн гишүүдийн төлөөлөгчдийн хамтарсан хурал сумын төвд 1958 оны 1 дүгээр сарын эхээр болж, хоёр нэгдлээ нийлүүлж, сумын төвд төвлөрөх саналаа илэрхийлсэн тогтоол гаргаж, аймагт явуулсныг хянан үзээд, аймгийн ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны 1958 оны нэгдүгээр сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолоороо “Шинэ амьдрал”, “Давшилт” нэгдлүүдийг нэгтгэж, нэгдлийн нэрийг “Давшилт” хэмээн тогтоон, нэгдлийн даргаар 30 настай Халтмаагийн Бямбааг баталсан байна. Энэ үед хоёр нэгдэл нийлээд 142 өрхийн 16-гаас дээш насны 395 гишүүнтэй байжээ. 1957 оны жилийн эцсийн эдийн засгийн тоо бүртгэлийн данс тайлангаар 8383 толгой малтай байлаа. 1955 онд хуралдсан МАХН-ын 13 дугаар их хурлаас ардын аж ахуйтныг сайн дурын зарчмын үндсэн дээр ойрын гурван жилд үндсэнд нь хоршооллож дуусгах нь зүйтэй гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажил орон нутагт 1958-1959 онд далайцтай өрнөж, тус сумын айл өрх толгой дараалан гол усаараа, багаараа нэгдэн нийлсээр 1959 оны намар гэхэд Төмөрбулаг сумын иргэд бүхэлдээ ХАА-н нэгдэлд орсон байв.

1958 оны 7 дугаар сард “Давшилт” нэгдлийн хамгийн анхны автомашин болох 3 тоннын даацтай “ЗИС-5” ирснийг жолооч Долгорын Гэлэгсэнгэ барьж байжээ. 1959 оны эцэст “Давшилт” нэгдэл 37,1 мянган толгой малтай, нэг сая гаруй төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, хамтын том аж хуй болж, хөдөлмөр зохион байгуулалтаа өөрчлөн МАА-н туслах үйлдвэрлэлийн нэг бригадтай болжээ. Ингэж нэгдлээ томруулан зохион байгуулснаар ХАА-н нэгдлийг цаашид аж ахуй зохион байгуулалтын талаар бэхжүүлэх, улсаас төвлөрсөн нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, машин тоног төхөөрөмж нэвтрүүлэн хүчин чадлыг гүйцэд ашиглах, нэгдлийн гишүүдэд хүргэх хүн эмнэлэг, худалдаа, соёл, ахуй үйлчилгээний хүрээг өргөтгөн сайжруулах боломж нөхцөл бүрдсэн байна.

## Гурван сумыг нийлүүлэв

МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр 1956 оны сүүлчээр сумдыг томруулахад зэргэлдээх Зүрх, Бүрэнтогтох Төмөрбулаг сумдыг нэгтгэн Төмөрбулаг сумын төвд төвлөрүүлэн Бүрэнтогтох гэж нэрлэжээ. Бүх нийтээрээ нэгдэлжих хөдөлгөөн ид өрнөж байсан 1958 оны үед энэхүү Бүрэнтогтох суманд “Давшилт”, “Идрийн долгио”, “Саруул зам”, “Дэлгэрмөрөн”, “Ундрал”, “Их хүч” гэсэн зургаан нэгдэл харьяалагдаж байв. Тухайн үед “Давшилт” нэгдэл улсаас уртын зээл 3000, богинын зээл 400 төгрөг, “Саруул зам” нэгдэл 3000 ба 1000 төгрөгийн зээл тус, тус авч байжээ.

## Сумын засаг захиргааг дахин шинэчлэн зохион байгуулав

Тухайн үед 2-3 багийн дунд газар нутгийн харьяаллаар үүсэн байгуулагдсан жижиг нэгдлүүдийг аж ахуй, зохион байгуулалтын хувьд нэг сумаас удирдахад бэрхшээлтэй, тээвэр, холбооны зардал их гарч, цаг хугацаа ч алдаж, удирдлагын хамрах хүрээ хэт нүсэрдэж байжээ. Энэ байдлыг аймгийн удирдлагууд харгалзан үзэж, хуучин байрлалаар нь Төмөрбулаг, Бүрэнтогтох, Зүрх сум болгон хуваажээ. Улмаар Төмөрбулаг, Бүрэнтогтох сумдын дундаас Тээл сумыг шинээр байгуулан “Саруул зам” нэгдлийн төвд төвлөрүүлсэн байна. Гэвч дахин шинэ зохион байгуулалт хийж Тээл сумыг 1960 оны 3 дугаар сард Бүрэнтогтох сумтай нийлүүлжээ.

## “Давшилт” нэгдэлд нэгдэв

1959 он гэхэд жижиг нэгдлүүд өөрсдөө дотроо нэгдэх үйл явц үндсэндээ дуусч, сум бүр нэг нэгдэлтэй байхаар шийдвэрлэжээ. 1959 оны хоёрдугаар сард сумдын Ардын депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга бөгөөд ХАА-н нэгдлийн ерөнхий хорооны дарга гэсэн нэг удирдага бий боллоо. Энэ зохицуулалтаар төр, аж ахуйн ажлыг нэг хүн хариуцах болж, улмаар багуудыг татан буулгаж, нэгдлийн бригадын даргыг төрийн захиргааны үүрэг гүйцэтгэгч болгосон байна. Цэргийн алба хашиж байгаад намын урилгаар ХАА-н нэгдэлд ажиллахаар ирсэн Р.Хүрэлбаатар сум нэгдлийн даргаар 1959 оны зургадугаар сараас ажиллаж эхэлсэн байна. Энэ үеэс сумын захиргааны байр, орон сууц, унаа зэрэг бүхий л зардлыг ХАА-н нэгдэл үндсэндээ хариуцаж, сумын дарга нэгдлийг удирдах болжээ. н Төмөрбулагчууд “Давшилт” нэгдэлд нэгдэж, сумын төр захиргаа, олон нийтийн байгууллагууд нь бүхий л үйл ажиллагаагаа нэгдлийн үйлдвэрлэлд зохицуулан зохион байгуулах, хүн амын соёл боловсролын түвшинг дээшлүүлэх, хамтын хөдөлмөрийн давуу талыг амьдрал дээр харуулахад чиглэгдэж байлаа. 1960 оны эхээр Төмөрбулаг сумын мал 48186, үүнээс “Давшилт” нэгдэл 37076 толгой малтай болжээ.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ****ТӨМӨРБУЛАГ  
СУМЫН ТҮҮХ**

/1960-1990/

**“Давшилт” нэгдлийн туслах  
үйлдвэрлэлийн бригад**

Нэгдлийн дэргэдэх туслах үйлдвэрлэлийн бригад 1960-аад онд байгуулагджээ. Туслах үйлдвэрлэлийн бригад нь барилга, малын хашаа саравч барих, засварлах, шавар шохой хийх, дархан мужааны ажил зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байсан байна. Мөн хөрөө рам ажиллуулж, дүнз, банз бэлтгэх, drank зүсэх, түлээ бэлтгэж байжээ. Үүний зэрэгцээ сумын талхны цех нь туслах үйлдвэрлэлийн бригадад харьяалагдаж байжээ. Тэд өөрсдийн хийсэн бүтээгдэхүүнийг өөрсдийнхөө мухлагаар дамжуулан зарж борлуулж байсан бөгөөд нэгдэлд хаана ажиллах хүчин дутагдаж байна, тэнд очиж ажилладаг бүтээлч хамт олон байжээ. Туслах үйлдвэрлэлийн анхны ажилтнуудаас дурьдвал мужаанаар Рагчаа, Р.Ренчин, Таарцаг, Бадраа, Г.Сундуй, Б.Лувсанцэрэн тэргүүтэй уран гартнууд ажиллаж байжээ. Мөн Г.Болд, Явгаан, Бат-Очир, С.Дэмбэрэл, Г.Насанбуян, Р.Ёндонжамц, Р.Зундуйжамц, Г.Цэнд-Аюуш, Л.Лхаасүрэн, Г.Ренчин, Ж.Цэрэн, Хандаа, Б.Үржгэр, Д.Тэрбиш, Л.Оюун, М.Дорж, Г.Дуламсүрэн тэргүүтэй олон хүн гар нийлэн ажиллаж байжээ. Тус бригад 1975 онд нэгдлийн есөн машины граж, нэгдлийн захиргааны контор, хоёр айлын орон сууц, худалдаа бэлтгэлийн ангийн хоёр дүнзэн склад, нэгдлийн агуулахууд, 800 тонны багтаамжтай тэжээлийн чулуун агуулах, хуучин хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барьж, ашиглалтанд оруулсан байна. Туслах үйлдвэрлэлийн бригадын даргаар Ж.Нямаа, Гомбожав, Ичинхорлоо, Г.Билэгдэмбэрэл, П.Банзрагч, тоо бүртгэгчээр Гомбодорж, Ш.Дашбалжир, Л.Ванчин, Ж.Нямаа, Ёндон, Ж.Баасанжав, Б.Үржгэр, Бямбаа, Д.Наранцэцэг, Л.Цэнд-Аюуш тэргүүтэй олон хүн ажиллаж байсан байна. Мөн нэгдлийн талхны цехэд Бадам, Хүрлээ, З.Болд, Л.Данаасүрэн нар ажиллаж байжээ. Нэгдлийн туслах үйлдвэрлэлийн бригадын орлого 1970 онд нэгдлийн мөнгөн орлогын 23 хувийг бүрдүүлж байсан тоо баримт түүхийн хуудсанд үлджээ. Зөвхөн 1971 онд гэхэд энэ хамт олон 132,9 мянган төгрөгийн борлуулалт хийж байжээ. Мөн 1977-1978 онд гэхэд л 32 мянган тонн талх үйлдвэрлэж, 26 мянган ширхэг тоосго цохиж, 200 тонн хужир давс татаж, цоож, гэрийн мод бэлтгэж, зуух яндан хийж борлуулж байсан нь нэгдлийн эдийн засагт том нөлөө үзүүлж байсан байна.

**Давшилт нэгдэл өргөжин тэлэв**

Нэгдлийг бэхжүүлэхийн тулд улсаас төвлөрсөн хөрөнгө оруулах, хөнгөлөлттэй зээл олгох зэргээр дэмжин тусалж байсны үр дүнд “Давшилт” нэгдлийн аж ахуй, нийгэм соёлын салбарт барилга байгууламж нэмэгдэж, мал сүргийн тогтвортой өсөлтийг хангахад зориулан хашаажуулах, бэлчээр усжуулах, хадлан тэжээл бэлтгэхэд урьд үзэгдээгүй ахиц дэвшил гарлаа. Эдгээр жилүүдэд сумын төвд нэгдлийн туслах үйлдвэрийн салбарууд болох Талхны газар, Сүү тосны завод, Цахилгаан станц, Шатахуун түгээгүүрийн цэг, хөрөө рам, Зочид буудал, Гуанз, Автограж зэргээс гадна арван жилийн дунд сургууль, хүний их эмчийн салбар, мал эмнэлгийн тасаг, тооцооны касс, хүүхдийн цэцэрлэг, ясли, эхчүүдийн амрах байр, цаг уурын харуул,

клуб, номын сан, кино цэг, төрөл бүрийн барааны дэлгүүр зэрэг улсын байгууллагууд төвлөрөн ажиллах боллоо.

### Усны харуул байгуулагдав

1963 оны 11 сараас Бүгсийн голын усны явуулын харуулыг томилж ажиллуулж эхэлжээ. Эхний үед энэ харуулын ажлыг Мөрөнгөөс хүн ирж гүйцэтгэж байсан бөгөөд 1965 онд Хөвсгөл аймгийн ус цаг уурын товчооны даргын 14 тоот тушаалаар мөн оны наймдугаар сарын нэгнээс суурин харуул ажиллуулах болсон байна. Тус сумын анхны усны харуулаар Сольхүүгийн Базаррагчаа томилогдон иржээ. Тус харуулын албанд Дорж, Б.Тогтох, С.Базаррагчаа, Г.Дашдорж, Данаажав, Ч.Бадраа, Г.Эрдэнэ-Очир, Ч.Бадраа, Ж.Жаргалдулам, Буянхишиг, Я.Мөнх-Эрдэнэ, Баянцэнгэл зэрэг хүмүүс ажиллаж байсан байна.

### Эм борлуулах агент

1964 онд тус суманд эм борлуулах агентыг томилж, Лүндэнгийн Цог гэдэг хүнд энэ ажлыг хариуцуулж өгчээ. Гэвч 1973 он гэхэд бие даасан эмийн сан байгуулсан бөгөөд эрхлэгчээр нь Данзан, Цэдэнсодном, Цэрэнбадам, Т.Даваасүрэн тэргүүтэй хүмүүс ажиллаж байжээ.

### Ахуй үйлчилгээний цэг

Хөвсгөл аймгийн НААҮГ-ын даргын 1975 оны зургадугаар сарын 2-ны өдрийн тушаалаар Төмөрбулаг суманд Ахуй үйлчилгээний цэг байгуулжээ. Анхны эрхлэгчээр Өвгөний Халтар, оёдолчноор Бэгзийн Хишгээ, Оюун нар ажиллаж, гэрээрээ оёдол хийж ажлаа эхэлжээ. 1983 онд үсчин, гуталчин, засварчин нэмэгдэж, таван хүний орон тоотойгоор ажиллаж эхэлсэн байна. Тус ахуй үйлчилгээний цэг 1988 он гэхэд Ахуйн үйлчилгээний төв болтлоо өргөжжээ.



Жамбын Оюун  
Анхны оёдолчин

Бэгзийн Хишгээ  
Анхны оёдолчин



Р.Нансалмаа эрхлэгчтэй ахуй үйлчилгээний цэгийн хамт олон



Цэрэнханд эрхлэгчтэй ахуйн үйлчилгээний төвийн хамт олон

### Барилга байгууламжууд баригдав

1971-1989 он хүртэл аймгийн нэгдэл дундын үйлдвэрийн барилгачид, дунд сургуулийн хичээлийн болон 80 хүүхдийн дотуур байр, хүн эмнэлэг, клуб, холбооны салбар, 2 давхар контор, ясли- цэцэрлэг, ахуй

үйлчилгээний төв, орон сууц, уурын зуух, төрөл бүрийн барааны дэлгүүр, 2 дугаар бригадын төв, улсын үржлийн фермийн барилга байгууламжийг барьжээ. Үүний үр дүнд сумын төв орчин үеийн тохилог, соёлтой суурин болж, өнгө үзэмж нь эрс дээшлэн үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрсөн төв болон хөгжиж эхэлжээ. 1960 -аад оноос хойш Төмөрбулаг сумын хөгжил, дэвшлийг “Давшилт” нэгдэлгүйгээр төсөөлөх аргагүй болж, шинээр үүсч байгуулагдан, өргөжин тэлж байгаа улсын албан байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний цэг салбарууд нь нэгдэл гэдэг нэгэн том айл өрхийн гишүүдийн тусын тулд үйлчлэх чиглэл зорилготой ажиллах болжээ.

### “Давшилт” нэгдлийн бүтээн байгуулалтын он жилүүд...

Нэгдэлжих хөдөлгөөн ялсны дараа 1960 онд Төмөрбулаг сум 45815 толгой, үүнээс “Давшилт” нэгдэл 39113 толгой малтай болж, МАА-н гурван бригад, туслах үйлдвэрийн нэг бригад, газар тариалангийн нэг хэсэгтэй, үнээний дөрвөн ферм, бог малын 77, бод малын 13 суурьт зохион байгуулагдсан байв. 1960-1961 онд Тариатын аманд 205 га-д арвай буудай, Жаргалантад 5 га-д төмс, Бүгдгээнд 50 га-д малын тэжээл тариалан өндөр ургац авч, Мөрөнгийн гурилын үйлдвэрт үр тариа нийлүүлэхийн хамт арвай, төмсийг гишүүддээ хувааж өгч, ургацын баяр хийж байжээ. УААА, соёлыг хөгжүүлэх III 5 жилийн төлөвлөгөөний эхний жил буюу 1961 онд сум 46713 толгой мал тоолуулж, мал өсгөх төлөвлөгөөг 2.3 хувиар тасалж байсан бол 1965 онд урьд оныхоо малыг таван төрөл дээр нь өсгөн 2079 толгой малаар нэмэгдүүлж ажлаараа аймгийн уралдаанд 3 дугаар байр эзлэн диплом, мөнгөн шагналаар шагнагдаж байлаа. 1964 онд “Давшилт” нэгдэл өөрийн хөрөнгө анхны МТЗ-5 трактор авсныг Циенгийн Лхачин эзэмших болж, ЖЭС-60 дизель хөдөлгүүр суурилуулан анхны моторчноор Оршихын Дорж ажиллаж байв.

Мал маллагааны уламжлалт арга ажиллагааг шинжлэх ухааны дэвшил, ололттой хослуулан шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлсний үрээр мал аж ахуйгаас орох мөнгөн орлогын хэмжээ 1965 онд 118.5 мянган төгрөг буюу 1960 оныхоос 39.6 хувиар өслөө.

1965 онд нэгдлийн нийт мөнгөн орлогын 61 хувь буюу 615.8 мянган төгрөгийг гишүүдийн хөдөлмөр, өдрийн хөлсөнд олгосон нь 1961 оныхоос 178.8 мянган төгрөгөөр нэмэгдэж байжээ.

1961 онд нэг хөдөлмөр өдөрт 3.74 төгрөг олгож байсан бол 1965 онд 5.20 төгрөг болон өсч, 1965 онд 417 өрх, 1245 гишүүнтэй, 1.5 сая төгрөгийн үл хуваагдах фонд, 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 1 сая төгрөгийн орлоготой тухайн үедээ л томоохонд тооцогдох аж ахуй болтлоо хөгжжээ.

1960-аад оны эхэн үеэс нэгдлийн гишүүд малчдын хөдөлмөр зүтгэлийг урамшуулан дэмжиж байсны нэг баримт Хөвсгөл аймгийн АДХГ захиргааны даргын 1960 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 12 тоот захирамжаар “Үнээ бүрээс саах сүүний гарцыг нэмэгдүүлж, амжилт гаргасан “Давшилт” нэгдлийн саальчин Ядамын Даваасүрэн, Думаагийн Чимэд нарыг аймгийн АДХГ захиргаа, намын хорооны баярын бичиг, үнэ бүхий зүйлээр, Төмөрбулаг сумын малчин Мангааны Жанцан нь 1960

онд төл бойжуулахад амжилт гаргасан тул аймгийн АДХГ захиргааны шагналаар тус тус шагнах шийдвэр гарч байжээ.

Төлөвлөгөөт IV таван жилд (1966-1970) сум нэгдлийн МАА-н материаллаг бааз бэхжиж, мал сүргийг отроор таргалуулах бүх нийтийн аян зохиож, шилмэл хэсгийн суурь зохион байгуулах, зааз ангилалтыг шинжлэх ухааны үндэстэй хийх, халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, төллөх болон нэг настай малын хариулга, мал маллагааг сайжруулах, хашаа саравч, хадлан өвс тэжээлийг нэгдсэн журмаар бэлтгэх зэрэг ажилд хөрөнгө хүчээ төвлөрүүлэн ажиллаж байв. 1970 онд сум 60516 толгой малтай болж, “Давшилт” нэгдэл 1966 онд байсан мал сүргээ 7249 толгойгоор өсгөн, хээлтэгч малын эзлэх хувийн жин 7.4 хувь нэмэгджээ.

Нэгдлийн малчид энэ үед малын ашиг шимийг бүрэн гүйцэд ашиглах талаар уралдаанд авсан үүргээ биелүүлэхээр ажиллаж, “Давшилт” нэгдэл улсад МАА-н бүтээгдэхүүн давуулан нийлүүлснээс 1966 онд 56 мянга, 1969 онд 228.7 мянган төгрөгийн нэмэгдэл шагнал авчээ. Мөн ноос, ноолуур, сүү тосны чанарыг ахиулахад ахиц гарч, 1969 онд улсад тушаасан бүх ноолуурын 63 хувийг 1, 2 дугаар зэрэгт тэнцүүлж байсан бол энэ тоо 1970 онд 70.2 хувь болтлоо өсөж, энэ таван жилд ноолуураас олох орлого 22 хувь өсчээ.

1966-1970 онуудад бод, бог малыг Бүгдгээн, Сангийн далай чиглэлд зохион байгуулалттай оторлох болж, зарим нутгийг өвөлжөө, зуслангийн нөөц бэлчээр гэсэн хуваариар гарган ашиглах болов. Энэ таван жилд 120 мянган төгрөгийн зээл авч, 130 гаруй хашаа барьснаар бүх мал 1-2 ээлжийн хашаатай болжээ. 1970 онд Худалдаа бэлтгэлийн ангийн 80 мянган төгрөгийн төсөвтэй агуулахыг аж ахуйн аргаар, 25 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг нэгдлийн хөрөнгөөр барьж, нэгдэл бригадын төвийг тохижуулахад оролцохын хамт эмээл, тооно, цоож, гэрийн мод, зуух зэрэг төмөр, модон эдлэлүүд хийж байв.

“Давшилт” нэгдэл 1965 онд нэг сая төгрөгийн мөнгөн орлоготой байсан бол 1975 онд 2.6 сая, 1985 онд 4.5 сая, 1988 онд 5.3 сая, 1990 онд 5.5 сая төгрөг болтлоо өсжээ.

Тэр хэмжээгээр нэгдэлч малчдын ахуй амьдрал дээшилж, нэгдлийн материаллаг бааз бэхжиж байв. VIII таван жилийн төлөвлөгөөний эхний жилүүд болох 1982-1983 онуудад МАА-н үйлдвэрлэлд 1000 гаруй нэгдлийн гишүүд ажиллаж, 656 өрхийн 529 нь хүлээн авагч, 521 нь номын сан, оёдлын машинтай болсон байна.

1960-аад оны эхнээс улсын хөрөнгө хүчээр уст цэгийн хайгуул ашиглалтын өрөмдлөг явуулсны үр дүнд тус сумын бэлчээр, төв сууринд 1988 онд тэр үеийн ханшаар дөрвөн сая төгрөгийн өртөгтэй гүн өрмийн худаг 25, богино яндант худаг 43, бүгд 68 уст цэг ажиллаж, хүн малыг усаар хангаж байв. Хамгийн анхны мэргэжлийн гидротехникчээр 1978 онд Доржийн Алтангэрэл томилогдон ирж ажиллажээ.

## Бүрэн бус дунд сургууль байгуулж, Хүний их эмчийг салбартай болов

Төмөрбулаг сумын бага сургууль 1972 онд бүрэн бус дунд сургууль болон өргөжиж, наймдугаар анги хүртэлх сурагчдийг сургаж эхэлсэн байна. 1972 оны наймдугаар сард шинэ байр ашиглалтанд орж 8-н жилийн сургуулийн анхны захиралаар Д.Дамба, хичээлийн эрхлэгчээр Д.Мишингээ, багш нараар Буянсанжаа, Халтмаа, Хандмаа, Лусмаа, Ичинхорлоо, Ө.Мажиг, Г.Долгорсүрэн, О.Нямсүрэн, Ц.Янжинхүү, А.Баттулга, Ц.Дэмчиг, Банзрагч, Ядамсүрэн, Б.Нямбуу, Д.Лхагважав, Д.Чулуунхүү, Ж.Дүгэрсүрэн, Г.Лханаа нар ажиллаж байв. Сумын хүн эмнэлгийн салбар нь 1972 онд Хүний их эмчийн салбар болон өргөжиж, анхны их эмчээр Дашдорж, анхны түргэн тусламжийн машин авч, жолоочоор Д.Балжинням ажиллаж эхэлжээ.

Захирал, багш  
Д.МишингээЗахирал, багш  
Д.Дамба

## Сумын тооцооны касс байгуулагдав

1975 онд аймгийн банкны хэлтсийн даргын тушаалаар Сумын тооцооны кассыг байгуулжээ. Тус тооцооны төвийн эрхлэгчээр Бадмаагийн Батбаяр, нярваар Дамдинсүрэнгийн Чулуун нар ажиллаж эхэлжээ. Тус тооцооны төв 1975 оны хоёрдугаар сарын 3-ны өдөр анхны гүйлгээгээ хийж, 1192 төгрөг оруулжээ.

## Хөх ямааны суурь бий боллоо

Эрт дээр үеэс Эрчмийн нурууны өвөр Бүгсийн голын сав дагуух уулархаг, хад асгатай нутгаар ардууд ноолуур сайтай хар хөх зүсмийн ямаа өсгөн үржүүлж байжээ. Үүнийг шилж сонгон анх “хөх ямааны суурь” нэртэйгээр зохион байгуулж, тус сумын 2-р багийн малчин П.Лунхаанд хариуцуулсан байна. Энэхүү хөх ямааны суурь өдгөөгийн “Эрчим” омогийн хар ямааны шилмэл сүрэг бүрдэх үндэс суурь нь байсан юм. Нутгийн шилмэл омгийн энэ ямаан сүрэгт шилэлт сонголт хийж, үржүүлсний үрээр “Эрчим” хэмээх ноолуур сайтай шилмэл сүрэг бий болж, улмаар улсын үржлийн ферм байгуулжээ. Тухайн үед Баян-Өлгий аймгаас ухна авчран зохиомол хээлтүүлэг хийж, ямаанд шилэлт сонголт явуулан, үржлийн ямааг ялгаж байжээ. Эрдэмтэн мэргэд судалгаагаа лавшруулан хийсний үрээр ноолуурын гарц, чанарыг тогтоон “Эрчим” гэдэг нутгийн шилмэл омгийн ямааны улсын жишиг тогтоож мөрдүүлсэн байна.

## **Сумаараа VI таван жилийн гавшгайч хамт олон болов**

1Төмөрбулаг сумынхан 1980-аад онд МАА-н салбараас жилд 1600 тн мах, 67.5 тн ноос, 7.6 тн ноолуур бэлтгэн, 87 хувийг 1, 2 дугаар зэрэгт тушаадаг байв. Мөн 500 шахам мянган литр сүү хүлээн авч 30.4 тн цөцгийн тос үйлдвэрлэдэг байлаа. Нэгдлийн туслах үйлдвэрын бригад жилд 32.9 тн талх, 4.2 тн цагаан идээ үйлдвэрлэж, 16 автомашин, 11 трактортай, Дизель станц, хөрөө рам ажилладаг байв.

Байгалийн хадлан 2.9 тн, ногоон тэжээл 300 тн-ийг бэлтгэж, 200 тн багсармал тэжээл үйлдвэрлэн хэрэгцээгээ хангадаг, хүмүүс хамтарч ажил амьдралаа өөд татах, харилцан соёлжих, уриан дор бүх нийтийг хамарч байсан социалист хөдөлмөрийн хөдөлгөөн суманд өрнөж, 1976 онд Социалист хөдөлмөрийн бригад 20, Социалист хөдөлмөрийн төлөө бригад 8, залуучуудын гавшгайч бригад 2, МАА-н бригад 1 байгуулагдаж, үүрэг амлалт авч үүнийгээ амжилттай биелүүлжээ. Сумын нийт мал сүрэг байнга өсч, 1970 онд 60516 толгой малтай байсан бол 1975 онд 96310, 1980 онд 101861, 1985 онд 110326, 1990 онд 110370 толгой малтай болж байжээ. 1973 онд Бүрэнтогтох сумын Тээл бригад Төмөрбулаг суманд нэгдсэн тул малын тоо 1973 онд 91504 толгой болж өссөн тоо баримт байна. Төмөрбулаг сум 1978 онд социалист уралдаанд аймагт 5 дугаар байр эзэлж, аймгийн нам захиргаа, МХЗЭ, ҮЭ-ийн байгууллагын жуух бичгээр, 1980 онд бүх ард түмний социалист уралдаанд амжилт гаргаж сумаараа VI таван жилийн гавшгайч хамт олон болж, дурсгалын тэмдэг, МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв хорооны баярын бичгээр, 1980,1983 оны ажлаар тус сум аймагт 3 дугаар байр эзэлж, тус бүр 1500 төгрөг, намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, МҮЭ, МХЗЭ-ийн байгууллагын баярын бичгээр, 1982 онд соёл урлагийн салбарт амжилт гаргасан учир БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Соёлын яамны сайд Дондогийн Цэвэгмэдийн гарын үсэгтэй итгэмжлэхээр тус тус шагнагдаж байжээ. Төмөрбулаг сумын АДХ-ын гүйцэтгэх захиргаа 1987 онд аймаг, сум, хот хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаадын дунд зарласан болзолт уралдаанд 2 дугаар байр эзэлж, баярын бичиг, 600 төгрөгөөр тус тус шагнуулж байжээ.

Нэгдлийн гишүүд хамт олныг ажил үйлсээрээ үлгэрлэн байж амжилт бүтээлийн эзэд болсон олон алдартнууд МАА-н үйлдвэрлэлд ажиллаж байв. Монгол улсын Хөдөлмөрийн баатар, улсын хошой аварга П.Цагаач ямаан сүргийг олон жил тогтвортой маллаж, эм ямааны дундаж амьдын жинг 57 кг (зарим нь 64 кг ч) хүргэж байв. БНМАУ-ын залуу аварга малчин ямаачин Б.Батмөнх аймгийн хошой аварга ямаачин П.Лунхай нар ямаан сүргийн ач буянаар сум нэгдлээ алдаршуулсан билээ.

БНМАУ-ын аварга хадланч эмэгтэй Ч.Цэрмаа, аймгийн 4 удаагийн аварга хоньчин Д.Банзрагч, аймгийн хошой аварга малчин Х.Ням-Очир, аймгийн аварга тууварчин А.Хишигдорж, И. Ганболд, Махдиваа, мянгат саальчин Д.Дулмаа, Ж.Оюунчимэг, аймгийн аварга саальчин Я.Надмид, фермийн эрхлэгч Ө.Зундуй нарын зэрэг аймаг, улсад алдар нэр нь түгсэн

сайчууд олон байлаа. Тус сумын иргэн Чойжилсүрэнгийн Лхамсүрэн ХЗЭ-ийн үүрийн дарга, зэргэлдээ сумдад нэгдэл, сум-нэгдлийн дарга, 1969-1973 онд Төмөрбулагт сум-нэгдлийн даргын албыг хашиж байжээ. Тэрээр АИХ-ын депутатаар сонгогдож, төр засгаас “Алтан гадас одон”, “Хөдөлмөрийн хүндэт” болон ойн медалиудаар шагнагдаж байв. Нэгдлийг үүсгэн байгуулж бэхжүүлэхэд олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байсан Сүрэнгийн Рагчаа, Жамбын Пүрвээ, Лувсандоржийн Дорж, Чойжилсүрэнгийн Лхамсүрэн, Дамбын Жамьянсүрэн, Сүхийн Өлзийбаяр, Номпэйн Лосол, Донойн Чулуун, Мягмарсүрэнгийн Чадраабал, Цамбажавын Дашгэндэн, Пунцагийн Цог, Лувсангийн Баадай, Бунжиган Лувсанбалдан, Ядамжавын Сосорбарам, Навааны Дамбаравжаа, Гомбын Замбал, Пүрэвийн Жамц нарын олон хүний ажил амьдрал энэ нэгдлийн түүхтэй салшгүй холбоотой юм. Энэ үед Х.Бямбаа, Н.Самбуу, Р.Хүрэлбаатар, Д.Чулуун, Ц.Дорж, Л.Нанжийсүрэн, Ч.Лхамсүрэн, С.Чимэддорж, Т.Батбаяр, Б.Шарбанди, Н.Мижиддорж зэрэг олон дарга нар “Давшилт” нэгдлийг удирдан ажиллаж байлаа.

### **Малаа 2.2 хувь өсгөх зорилт тавив**

“Давшилт” нэгдлийнхэн 1979 онд малаа 2,2 хувь өсгөх зорилт тавьж, 1989 онд энэ зорилтоо биелүүлж, 100 гаруй мянган толгой малтай болсон байна. Энэ үед Давшилт нэгдэл хашаа барих, төлөвлөгөөг 131 хувь, сүү тос, ээдэмцэр, мах бэлтгэх төлөвлөгөөг 100-109 хувь, түүхий эдийн 51 нэр төрлийн зүйлээс 50 нэрийн зүйлийг 100-200 хувь биелүүлж байжээ. Ж.Цэрэннадмид, Д.Догсмаа, З.Лхагважав зэрэг 64 төлчин төлөө МАХН-ын Төв хорооны 9-р бүгд хурлаас заасан заалтаас илүү бойжуулж, Я.Надмид аймгийн хошой аварга саальчин болж, Ё.Долгорсүрэн, Ш.Сосорбарам, Д.Чанцал, Л.Одгор нарын 32 хүн сүүнийхээ төлөвлөгөөг жилээр биелүүлж, сумын “Энх төлтөн” цолоор 14 хүн, “Мэнд сүрэгтэн”-ээр 80 гаруй хүн шалгарчээ.

### **Ямааны улсын Үржлийн ферм байгуулагдав**

Төмөрбулаг сум 1985 онд нийт 110326 толгой малтай байсны 80 гаруй хувь нь “Давшилт” нэгдлийн мал байлаа. Тус нэгдэл малаа 7 хэсэг, 180-200 суурьт зохион байгуулж, ямааны улсын үржлийн фермтэй болжээ. Тус сумын хоёрдугаар багийн нутагт байгуулагдсан Ямааны улсын үржлийн ферм дээр улсын төсвөөс хөрөнгө мөнг гарган, бригадын төвийг тохижуулж, мөн эрдэмтдийн баг ажиллаж, ямааг ялган ангилж байжээ.

### **Малаа төрөлжүүлэв**

Тус нэгдэлд Ямааны улсын үржлийн ферм байгуулагдах үед дараах байдлаар малаа төрөлжүүлжээ. Хонио Агт, Жаргалант, Тээл, Баян-Айраг, Дөшид, үхрийг Тээл хэсэгт төрөлжүүлж эхэлсэн байна.1986-1988 онд Х.Батмөнх улсын аварга, Х.Ням-Очир ашиг шимийн аймгийн хошой аварга, А.Хишигдорж, Михдаваа нар аймгийн аварга тууварчин, Д.Дулмаа, Ж.Оюунчимэг нар мянгат саальчин болж байжээ.



### Эрчим омогийн ямаа

Эрчим омгийн үржлийн сүрэг байршдаг Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын II багийн малчид олон жилийн турш хөх болон бусад зүсмийн ямаа үржүүлж байжээ. 1970 оноос эхлэн галбир, ноолуурын гарц сайтай ямааг ялган Төмөрбулаг сумын “Давшилт” нэгдлийн II бригадад суурилж, орон нутгийн үржлийн хэсэг байгуулан ажиллуулсан. Нутгийн ямааг “өөр дотор нь” цэврээр үржүүлж байсан боловч 1979 онд Горно-алтай үүлдрээс ухна авч ирж хээлтүүлэгт ашигласнаас ямаан сүрэг эрлийзжин, ноолуурын гарц нэмэгдсэн ч түүний ширхэг уртсаж, голч мэдэгдэхүйц бүдүүрсэн байв. 1985 онд Улсын үржлийн албаны мал зүйч Ц.Даваасүрэн сумын бүх ямаанд үзлэг хийж, 1986 онд II бригадад нутгийн ямааны Улсын үржлийн фермийг 17 мянга шахам ямаа, 4 мянга гаруй бусад төрлийн малтайгаар байгуулжээ. 1986-1996 онд Н.Надмид уул сүрэгт судалгаа хийж, мөн жил бүр үржлийн сүрэгт анги, хувьсын ангилалт, суурь сүрэг зохион байгуулах, ухна, эм ямаанд тохируулан сонголт хийх ажлыг аймгийн Үржил селекцийн станц, сумын мал аж ахуйн мэргэжилтнүүдийн оролцоотойгоор гүйцэтгэж, сүрэгт явуулах үржил селекцийн ажлыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байлаа. 1986-1996 онд явуулсан үйлдвэрлэл-эрдэм шинжилгээний ажлын дүнд:

1. Ямааны тохиромжтой хэвшлийг тогтоож, ойт хээрийн уулархаг нутгийн нөхцөлд зохилдсон бие томтой, арвин ноолууртай, хар зүстэй үржлийн сүрэг бий болгож, үржлийн ухна бойжуулан борлуулах болсон.

2. Сүрэгт зохион явуулах шилэн сонголт, үржлийн зориулалтаар ямаа борлуулах ажлыг зохицуулах улсын стандартыг нутгийн шилмэл “Эрчим ямаа” УСТ 4018-87, УСТ 4018-93 нэртэйгээр батлуулан мөрдсөн. Нутгийн шилмэл ямааны тодорхойлолтыг гаргаж, ХААИС, МААЭШХ-гийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ХААҮЯ-ны сайдын тушаалаар “Эрчим” нэртэй бие даасан омгоор батлуулсан байна. Нутгийн ямааг шилэн сонгож, түүний ашиг шим, үржлийн чанарыг бататгах, өсгөн үржүүлэх, үндсэн сайжруулагч бэлтгэж үр дүнтэй ашиглахад мал зүйч Б.Шарбанди, аймгийн ҮСС-ийн хамт олон, мал зүйч Б.Наранчулуун, Хөдөлмөрийн баатар, ямаачин П.Цагаач, аварга малчин П.Лунхаа, фермийн дарга П.Банзрагч, мал аж ахуйн мэргэжилтэн Ц.Давааням нарын олон мэргэжилтэн малчин их үүрэг гүйцэтгэжээ. Эрчим ямаа манай орны өндөр уул, ойт хээрийн бүсийн байгаль, цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохицсон, тэсвэр сайтай, галбирын согоггүй, чийрэг бие цогцстой, эвэр туруу сайтай, өргөн гүн цээжтэй, биерхэг, богиновтор чацтай, хар зүстэй. Нягт зузаавтар арьстай, үсэн бүрхүүл нь сахлаг хар хүрэн өнгийн хялгас, бараан саарал, цайвар саарал өнгийн, нарийн ширхэгтэй уян, зөөлөн ноолууртай. Гэдэс хөлний ноолууржилт хангалттай, хялгас ноолуураа давж ургасан байдаг. “Эрчим” ямааны галбирыг судалсан дүн, УСТ 4018-93 зэрэг материалыг үндэслэн, түүний биеийн үндсэн хэмжээг доор дурдсанаар тогтоожээ. Үүнд:

Бүдүүн ухны сэрвээний өндөр 68,0, хондлойн өндөр 69,5, биеийн ташуу урт 72,0, цээжний өргөн 20,5, цээжний гүн 34,0, цээжний бүслүүр 88,0, хондлойн өргөн 16,0, шилбэний бүслүүр 10,0 см, бүдүүн эм ямааны сэрвээний өндөр 62,0, хондлойн өндөр 63,0, биеийн ташуу урт 67,0, цээжний өргөн 16,0, цээжний гүн 30,5, цээжний бүслүүр 85,0, хондлойн өргөн 16,0, шилбэний бүслүүр 8,0 см байна.

Эрчим ямааны жин хавар: дунджаар бүдүүн ухных 45,0 кг, бүдүүн эм ямааных 31,0 кг, борлон ухных 24,0 кг, охин борлонгынх 20,0 кг, намар: дунджаар бүдүүн ухна 58,0 кг, эм ямаа 45,0 кг, шүдлэн ухна 37,0 кг, охин шүдлэн 35,0 кг байна.

Эрчим ямаа намрын жингээр говь, тал хээр, хангайн уулархаг нутгийн ямаанаас 1,8-5,9 кг-аар давуу байдаг.

Эрчим эм ямааны намрын амьдын жинг насаар судлахад 1,5 настайдаа 35,0 кг, 2,5 настайд 39,0 кг, 3,5 настайд 43,0 кг, 4,5 настайд 44,0 кг; 5,5 настайд 46,0 кг, 6,5 настайд 47,0 кг байна.

Эрчим ямаа өвөл, хаврын улиралд намрын жингийнхээ 22,0-26,0%-ийг алдаж онд орно.

Эрчим ямааны арьс дунджаар 2017 мкм зузаан бөгөөд далны хэсэгтэй харьцуулахад хонгоных 14,77%, хүзүүнийх 7,13% илүү зузаан, хээлийнх 19,2%, хондлойнх 1,48% нимгэн байна.

Эпидермисийн давхраа дунджаар 23,65 мкм, арьсны нийт зузааны 1,19%-ийг эзэлнэ. Түүний үнэмлэхүй зузаан биеийн хэсгүүдэд жигд үзүүлэлттэй байна. Тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан бүдүүн ухны ноолуурын гарц дунджаар 350,0 г, бүдүүн эм ямааных 285,0 г, борлон ухных 250,0 г, охин борлонгийнх 230,0 грамм байна.

**Эрчим ямааны ноолуурын чанарын зарим үзүүлэлт**

Үзүүлэлт	Ухна		Эм ямаа	
	дал	гуя	дал	гуя
Нийт үсэнд эзлэх ноолуурын хувь	44,80	37,73	41,26	32,38
Ноолуурын голч, мкм	14,37±0,4	13,98±0,37	14,48±0,14	14,73±0,14
Ноолуурын жинхэнэ урт, см	9,32±0,81	8,48±0,61	7,11±0,65	6,10±0,61

Бусад омгийн ямаатай харьцуулахад эрчим ямаа махан ашиг шим сайтай, бүдүүн эм ямааны гулуузны жин бусад омгийнхоос 3,7-5,2 кг буюу 22,0-32,3%, нядлагын гарц 3,0-5,0%, махлаг чанар 0,2-0,7 кг-аар тус тус давуу байна. Махны химийн бүрэлдэхүүнийг 38-р хүснэгтэнд үзүүлэв.

Махны химийн ерөнхий найрлага нас, хүйснээс хамаарч ялимгүй ялгаатай, дунджаар чийг 57,63-63,53%, уураг 16,15-17,51%, тос 18,23-25,56%, үнс 0,92-0,94 хувь, махны илчлэг 10124-12724,5 кДж байна хэмээн тогтоожээ.

**“Давшилт” нэгдэл 50 жилийнхээ ойг тэмдэглэв**

Давшилт нэгдэл 50 жилийнхээ ойг амжилт бүтээлээр дүүрэн угтав. Сумын хэмжээгээр 102,7 мянган толгой малтай, нэгдэл 80,6 мянган малтай байжээ. 1988 онд мөнгөн орлого 5,3 сая, ашиг 169,4 мянган төгрөгдолоон хэсэг, 184 суурь, улсын ямааны үржлийн церм болон туслах үйлдвэрлэлийн бригадтай байлаа. Жилдээ 1600 тонн мах, 67,5 тонн ноолуур, 30,4 тонн



цөцгийн тос бэлтгэж байжээ. Мөн улсын ямааны үржлийн ферм энэ үед 21 мянган ямаатай, зуун эхээс 85 төл бойжуулж, 5,1 тонн ноолуур бэлтгэж байсан байна. Байгалийн хадлан бэлтгэж, 300 тонн ногоон тэжээл, 200 түнн багсармал үйлдвэрлээж байжээ. Үүнийг хонин толгойд шилжүүлбэл нэг малд 29,8 кг тэжээл оногддог гэсэн тооцоо гарч байжээ.

**Тарваганы ходоод бэлтгэж байв**

Тус нэгдэл жилдээ олон зуун ширхэг тарваганы ходоод бэлтгэж, хатааж, ядарч доройдсон малын сувилалд хэрэглэдэг байсан байна. Нэгдэл мал өсгөх боломжтой, аминдаа цөөн малтай иргэдэд малаа худалдаж, 1986-1988 онд л гэхэд 360 малыг иргэдэд боломжит үнээр зарж борлуулсан байна.

**800 тонн тэжээлийн агуулах барив**

Сумын төвд 800 тонн тэжээл хадгалах зориулалт бүхий чулуун агуулахыг барьж ашиглалтанд өгч байжээ.

**Шагналд 160 гаруй мянган төгрөг зарцуулжээ**

Тухайн үед нэгдэл жилдээ 160.000 мянган төгрөгийг социалист уралдааны урамшуулалд зарцуулдаг, нэг малчин жилдээ 3.2 сая төгрөгийн хөдөлмөр өдрийн хөлс авдаг байсан хэмээн тус сумын 50 жилийн ойд зориулсан “Давшилт нэгдлийн алхаа” товхимолд өгүүлжээ.



## ТӨМӨРБУЛАГ СУМЫН АВТО ГРАЖ

Төмөрбулаг суманд анх техник нь модон кабинтай ЗИЛ5, кабингүй МТЗ 5 трактор ирж, орчин цагийн техник технологи, авто тээвүэр хөгжих үндэс суурь тавигджээ. Тус суманд анхны жолоочоор олондоо



“Олгой шаш” гэж нэрлэгдсэн Д.Жүгдэрнамжил, “хашир ягаан” гэх Гэлэгсэнгээ, “халаа” Д.Лхамжав, “хааз Жамжээ” гэж нэрлэгдсэн Жигжид, Д.Агваан, Ц.Төртогтох, Ч.Доржпалам М.Дорж нар ажиллаж байжээ. Мөн анхны тракторын жолоочоор Ж.Баатар, Ц.Гомбожав, Р.Дамдинсүрэн, Д.Төвд, Д.Цэдэн-Иш нар ажиллаж байжээ. Б.Дэмчигдорж нарын ахмад тээвэрчид механикжуулагчид ажиллаж байв. 1975 онд тус суманд аж ахуйн хөрөнгөөр есөн машины граж барьж, 1976 онд тус сум нэгдэлд анхны хагас механикжсан салаа байгуулагдсан юм. Тухайн үед найман ширхэг ЮМЗ-6 трактор, чиргүүлтэй Зил-130 автомашин ирснээр сумын авто техник өргөжин тэлжээ. Сумын авто тээврийн оргил үеийг 1988 он гэж тооцож болох юм. Тухайн үед 43 трактор, 37 автомашинтайгээр ард иргэдэд тээдрийн үйлчилгээ үзүүлж байжээ. Нэгдлийн ХАА-н авто гражийн Ерөнхий инженер, авто механикчаар Гичигганам, Мөнхжаргал, Л.Бямбасүрэн, Д.Түмэнжаргал Я.Түвшинжаргал нар ажиллаж байжээ. Авто гражид нийтдээ 80 гаруй автомашин техник харьяалагдаж, техник болгонд нэг ачигч ажиллаж байсан юм. Энэ авто граж 160 гаруй ажилтантай, сумын томоохон албан байгууллагын нэг байжээ. Тус хамт олон улирал, хагас жилээр ажлаа дүгнэж, хөдөлмөрийн аваргуудаа шалгаруулж, алдаршуулж байсан бөгөөд Д.Лхамжав хоёр удаа, Д.Марку хоёр удаа, Л.Бямбасүрэн нэг удаа, Д.Түмэнжаргал гурван удаа, тээврийн аварга жолоочоор шалгарч байжээ. Мөн сумын аварга механикжуулагчаар Ц.Эрдэнэ гурван удаа,

Р.Дамдинсүрэн таван удаа шалгарч байв. Үүний зэрэгцээ сумын депутатаар Р.Дамдинсүрэн хоёр удаа, Л.Бямбасүрэн нэг удаа тус тус сонгогдож байжээ.

Үүнээс хойш машин техник олширч 3 ширхэг ЗИЛ130, 4 ширхэг ГО353, 4 ширхэг А691, 3 ширхэг УА3469, 1 ширхэг Марк164 нэмж нэгдлийн дарга, намын үүрийн дарга, хүн эмнэлэг, мал эмнэлэг тус бүр машинтай болж, сүү зөөдөг ГА353, малын тэжээлийн ГА351 машиныг ажиллуулж ирсэн.

1. Д.Гэлэгсэнгээ
2. Д.Ламжав-Олон нийтийн байцаагч
3. Л.Бямбасүрэн-Авто тээврийн 85 жилийн ойн медаль, сумын 3 удаагийн аварга, сумын депатутын 1 удаагийн аварга, Монгол Улсын Осолгүй манлай жолооч шагнал авсан.
4. Т.Дунгар
5. Д.Мархүү-Осолгүй Манлай жолооч
6. Жамжаа
7. Ц.Төртогтох-Ардын хувьсгалын 50, 60, 70, 80 жилийн ойн медаль, ХАА-н жуух бичиг, Алтан од медаль, Монголын Улаан Загалмайн хүндэт тэмдэг,
8. Д.Балжинням
9. Ч.Буяндэлгэр
10. Г.Батдорж
11. Д.Түмэнжаргал
12. Д.Ганболд
13. Жамьяанжав
14. Ш.Ганболд
15. Д.Бүрэгдээжанцан
16. Санжаа
17. Ц.Мөнх-Очир
18. Болд
19. Д.Сэрээтэр
20. Б.Бааска
21. Сэрээтэр
22. Ж.Төмөрбаатар
23. Б.Шаш
24. Ш.Цэдэв зэрэг олон жолооч нар ажиллаж байлаа.

*Авто гражийн ахмад ажилчид*



**Ядамсүрэнгийн Түвшинжаргал**  
1987-1993 онуудад Сумын авто гражийн ХАА-н Ерөнхий механикчаар ажиллаж байсан.



**Долгорын Гэлэгсэнгээ**    **Рагчаагийн Сэрээтэр**    **Даваагийн Жүгдэрнамжил**    **Халтарын Жаамаа**    **Балжирын Шаш**    **Лодойн Бямбасүрэн**



**Магсарын Дорж**    **Гомбын Жигжид**    **Гончигын Батдорж**    **Дагвын Мархүү**    **Ичинхорлоогийн Буяндэлгэр**    **Цэний Төртогтох**



**Өвгөний Балжинням**    **Дамдинсүрэнгийн Жамбаа**    **Доржийн Лхамсүрэн**    **Лхамжавын Батбаяр**    **Пүрэвийн Дорж**    **Дагвын Балжинням**



**Дашдаваагийн Цоодол**    **Сосорын Мөнх-Очир**    **Дамдинсүрэнгийн Түмэнжаргал**    **Сундуйн Батдэмдэмбэрэл**    **Гэлэгжамцын Дунгар**    **Ж.Дагшүү**

**ТӨМӨРБУЛАГ СУМЫН АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

Суманд 1960-аад оны эхээр Артель нэртэйгээр нэг цэгт төвлөрсөн үйлдвэрлэл эрхэлж байгаад 1975 онд ахуй үйлчилгээний цэг нэртэйгээр 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр анхны эрхлэгчээр Ө.Халтар, оёдолчноор Б.Хишгээ, Оюун нар ажиллаж байсан.1983 онд ахуй үйлчилгээний төв нэртэйгээр үсчин, гуталчин, оёдол, эсгүүр, жолооч, зурагчин, борлуулагч гэсэн орон тоотойгоор нилээд олон хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байсан. Ахуй үйлчилгээний төвд З.Цэрэнханд, С.Нямжав, Г.Алтанцэцэг, Ү.Цэцэгээ, Т.Зүмбэрэлдорж, Ц.Отгон, Ц.Отгон, Д.Цэвээннамжил, Д.Нарангэрэл, Ц.Сайнжаргал, Д.Цээсүрэн, Ч.Энхцэцэг, Д.Нямсүрэн, Б.Амаржаргал, Д.Цэрэнсоль, Р.Бямбаа, Ж.Энэбиш, Д.Лхамсүрэн, Ж.Ганбаатар, С.Дулмаа нар ажиллаж байсан.



Сумын ахуйн үйлчилгээний хамт олон 1990 он

Тус суманд 1992 онд хувьчлал явагдсанаас хойш ахуй үйлчилгээний нэгдсэн төв хувьд гарч ажиллахгүй болсон ба одоо энэ чиглэлийн үйлдвэрлэл зөвхөн өрхийн хэмжээнд явагдаж байна.Сүүлийн жилүүдэд ард иргэдэд хэрэгцээт бүтээгдэхүүнийг нийлүүлэх, залуу үед мал маллах арга ухааныг зааж сургах, гэр ахуй болон үндэсний хувцас үйлдвэрлэх бүх төрлийн хувцасны засвар үйлчилгээ, бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэх, шүр сувсан урлал, мод модон эдлэлийн тавилга, блокны үйлдвэрлэл, шахмал түлшний үйлдвэрлэлийг бий болгож ажлын байр нэмэгдүүлж байна. Тус сумын хэмжээнд ЖДҮ эрхлэгч нийт 25 иргэн 3 хоршоонд санхүүгийн дэмжлэг болгож Сум хөгжүүлэх сангаас 2013 онд нийт 254,400,000 төгрөгний зээлийг олгосон байна.Суманд жижиг дунд үйлдвэрлэл нь цех болон өрхийн үйлдвэрлэлийн хэмжээнд явагдаж байна. Жил бүр аймаг, сумандаа жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр өрхийн үйлдвэрлэгчдийг үзэсгэлэн худалдаанд оролцуулж ирсэн ба 2013, 2014 онд аймгийн шилдэг үйлдвэрлэгч байгууллагаар шалгарсан амжилттай байна.

**Ахуй үйлчилгээний салбарын ажилчдын түүх намтар**

**З.Цэрэнханд** нь 1964 онд Галт сумын нутаг Ханан хад гэдэг газар төрсөн. Бага насаа эцэг эхийн гар дээр өнгөрүүлж байгаад 1954-1965 онд Мөрөнгийн 10 жилийн сургуулийг төгссөн. 1965-1966 онд төв дэлгүүрт худалдагч хийж байгаад 1966 онд Хүрэлбаатартай гэр бүл болж 6 хүүхэд төрүүлж өсгөж хүмүүжүүлсэн байна. 1966-1969 онд Хөвсгөл аймгийн шүүхийн нарийн бичгийн даргаар ажиллаж, 1969-1974 онд Шинэ-Идэр сумын худалдаа бэлтгэлийн ангид худалдагч, нярав, 1974-1978 онд соёлын төвийн эрхлэгч, Давшилт нэгдлийн тооцооны нягтлан бодогч, 1978-1982 онд Галт сумын 10 жилийн дунд сургуульд нярав, 1982-1985 онд санхүү тасагт нягтлан бодогч, 1985-1995 онд нийтийн ахуй үйлчилгээний төвийн эрхлэгч, Хөдөлмөр хоршооны захирлын ажлыг хийж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан. Төр улсдаа 39 жил албан ажил ба сонгуульт ажил хийж байх хугацаандаа МХЗЭ-н Ажилчин залуу” алтан медаль, АХ-ын 60, 70, 80 жилийн ойн медаль, ахмадын байгууллагын “Хүндэт медаль” нийгмийн ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны Хүндэт тэмдэг, Аж үйлдвэрийн яамны Хүндэт жуух, 2012 оны Өрхийн шилдэг үйлдвэрлэгч шагналуудаар шагнагдаж байв.Одоо 1, 5-р багийн ахмадын зөвлөлийн даргын ажлыг хийж байна.



**Г.Цэцэгээ** нь 1965 онд Мөрөн сумын 10 жилийн сургуулийг дүүргэсэн. 1973 онд 8-р ангиа төгсөж Ахуй үйлчилгээний комбинатад илгээлтийн эзэнээр очиж оёдолчноор ажилласан.Мөн оройн сургуулиар 10-р ангийг дүүргэсэн.Ахуй үйлчилгээнд ажиллаж байх хугацаандаа сар, жилийн ажлын төлөвлөгөөг давуулан биелүүлж байсан. Ажил хөдөлмөрийг минь үнэлж Ү-р таван жилийн гавшгайч, МХЗЭ-ийн төв хорооны залуу гавшгайч мөнгөн медаль, МХЗЭ-ийн төв хорооны жуух бичгээр, 2011 онд Ахуй үйлчилгээний 80 жилийн ойн медаль, 2014 онд сумын ахмадын хорооноос өрх гэрийн үйлдвэрлэл, сургагч оёдол оёх мэтгэгч медалиар тус тус шагнагдсан.

**Д.Цэвээннамжил** нь 1948 онд төрсөн. 1966 онд Ц.Төртогтохтой гэр бүл болж 9 хүүхэд төрүүлж өсгөсөн. 1970 онд ЕБС-д тогооч, угаагч, 1972-1983 онд Давшилт нэгдэлд цэвэрлэгч, 1983-1992 онуудад нийтийн ахуй үйлчилгээнд оёдолчноор ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарсан. Ажил хөдөлмөрийг минь үнэлж Алдарт эхийн I II-р эхийн одон, Төрийн хүндэт соёмбо, АХ-ын 50, 60, 70, 80-н жилийн ойн медаль, Эх орон гэр бүл эмэгтэйчүүдийн холбооны тэмдгээр шагнагдсан.



**ТӨМӨРБУЛАГ СУМЫН ХУДАЛДАА БЭЛТГЭЛ АНГИ**

Тус суманд 1953 онд анх Эд хэрэглэгчдийн хоршоо нэртэй хоршоог байгуулж байжээ. Тус хоршоо нь морин өртөө, ердийн хөсгийн жин тээж Хатгал Улаанбаатар хотоос хүнс болон төрөл бүрийн ахуй хэрэглээний бараагаар сумын



Худалдаа бэлтгэлийн ангийн хамт олон. 1990 он



Худалдаа бэлтгэлийн ангийн хамт олон. 1990 он

иргэдийг хангаж байлаа. 1959 онд Сумын худалдаа бэлтгэлийн анги байгуулагдан Мөрөн дамжлага баазаас бараа авч МАА-н түүхий эдийг төлөвлөгөөгөөр бэлтгэн нийлүүлж байжээ. Худалдаа бэлтгэлийн анги нь сумын хөдөөгийн малчдад 9 агентын үйлчилгээгээр, төвийн иргэдэд бараа, хүнсний дэлгүүрээр худалдааны үйлчилгээг хүргэж ирсэн.Худалдаа бэлтгэлийн анги нь 1990 оны байдлаар 48 орон тоотой, 14 суурин, 1 явуулын цэг ажиллаж, 5 жилийн төлөвлөгөөтэй уялдуулан социалист уралдааны өрсөлдөөнтэй, социалист хөдөлмөрийн төлөө бригадын болон жинхэнэ бригадын хамтын хөдөлмөрийн давуу талыг харуулан аймагт тэргүүний худалдаа бэлтгэлийн ангийн хамт олон болж шагнагдаж байсан.Энэ хамт олны дунд ажиллаж байсан дарга худалдагч, нягтлан бодогч, агент, манаач, ажилчдаас дурьдахад Ц.Даньдгайсүрэн, А.Ядамсүрэн, Д.Дунгар, Ч.Дорж, Ч.Бадраа, Г.Мөнхбаяр, Д.Түмэндэмбэрэл, И.Ганбаатар, Ө.Халтар, Х.Энхжаргал, Д.Даваасүрэн, С.Одхүү, Ш.Наранцэцэг, Д.Авирмэд, Д.Төмөр-Очир, Ч.Түмэндэмбэрэл, Х.Дагвадорж, Агвааншарав, Лувсанзундуй, С.Доржоо, И.Буяндэлгэр, Д.Цэрмаа, Ч.Даваасүрэн, Цэнд-Аюуш, З.Баатар, Циен, Р.Янжин,



Худалдаа бэлтгэлийн 90 жилийн ой.



Кассин Х.Энхжаргал  
Сумын төв дэлгүүр

Цогбадрах, Г.Дашбямбаа, Дамбадаржаа, А.Баясгалан, Д.Цэрэндорж, Д.Уламбаяр, Ё.Дашмягмар, Д.Зоригт, Лосол, Ц.Цагаач, М.Бямбачулуун, Р.Равдандорж, Б.Оюун, Г.Баяр, Г.Ганжуур, Оюунцэцэг, Д.Эрдэнэцэцэг, Аюурзана,

А.Машбат, Ж.Дорждаян, Ж.Сүхбаатар, С.Баргадь, Дашдаваа, Ранз, Дашравдан, Б.Дондов, Ж.Хөрөнгөө, Д.Мөнхбат, Чмэд, Бямбаа, Батцэнгэл, Дэлгэрдалай, Ц.Лхагвасүрэн, Дашмягмар, Эрдэнэхүү, Р.Саранцэцэг, Ж.Чойжилсүрэн, Б.Дашбалжир, Ё.Хоролсүрэн, Д.Ганхуяг, Б.Лэгшигдорж, Ж.Лхагважав зэрэг олон хүмүүс ажиллаж байсан.Худалдаа бэлтгэлийн ангийн жилийн бараа гүйлгээ 3 сая 560 мянган төгрөг, ном борлуулалт 26 мянган төгрөгт хүрч 45 тн талх үйлдвэрлэж байжээ.Жилд 1 сая 200 мянган төгрөгийн 40 гаруй нэрийн бэлтгэлийн зүйлийг бэлтгэн улсад нийлүүлж байсан. Худалдаа бэлтгэлийн ангийн хамт олон нь хөдөлмөрчид, албан байгууллагыг өргөн хэрэглээний бараагаар хангахын хамт түүхий эд бэлтгэлийн ажлыг төвлөрүүлэн зохион байгуулах, арьс шир давслах цех, талх үйлдвэрлэх зэрэг үйлчилгээ үйлдвэрлэл хослуулан явуулдаг томоохон байгууллага байсан.1990 онд хувьчлал явагдаж худалдаа бэлтгэлийн анги татан буугдсанаас хойш иргэд хувиараа ганзагын наймаа эрхлэх болсон.

Одоо суманд хүнсний дэлгүүр 26, нийтийн хоолны газар 5, талх нарийн боовны цех 2, баар 1, супер маркет 3 ажиллаж байна.Эдгээр үйлчилгээний газарт нийт 75 иргэд ажиллаж байна. Төмөрбулаг сум нь нийт 4316 хүн амтай. Тэдгээр нь хүнс болон өргөн хэрэглээний бараагаар хүн ардаа тогтмол үйлчилж байна.

**Худалдаа бэлтгэл ангид ажиллаж байсан ахмад ажилтнууд**



**И.Ганбаатар нь 1945 төрсөн.** 1962 онд ХБ ангид манаач, ачигч цэвэрлэгч хийж байгаад 1964 онд Худалдаа бэлтгэлийн түр курсэд 3 сараар суралцаж төгсөж ирээд ХБА-д түүхий эдийн эрхлэгчээр 1972 оныг хүртэл ажилласан.1972 онд цэргийн албанд татагдаж цэргээс халагдаж ирээд 1983 оныг дуустал ажиллаад 1984-1992 оныг түүхий эдийн эрхлэгчээр ажилласан.Нийт худалдаа бэлтгэл ангид 21 жил ажилласан. Худалдаа бэлтгэлийн Яамны хүндэт жуух бичиг алтан медалиар шагнуулж байсан.

Г.Мөнхбаяр нь 1948 онд төрсөн. 1964 онд 16 насандаа Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд гишүүнээр элсч 1969 он хүртэл аав ээжтэйгээ хамт малчнаар, мөн Нэгдлийн хүнс бүтээгдэхүүний мухлагийн худалдагч, Давшилт нэгдлийн буудлын үйлчлэгчээр ажилласан. Г.Мөнхбаяр нь 1969



оны 5-р сараас 1992 он хүртэл тус сумын Худалдаа бэлтгэлийн ангид Хүнс барааны дэлгүүрийн худалдагчаар 23 жил тасралтгүй ажилласан бөгөөд энэ хугацаанд санаачлагчийн гэрчилгээгээр шагнуулсан. Худалдаа бэлтгэлийн оны аваргаар 4 удаа, Худалдаа бэлтгэлийн яамны жуух бичиг, V, VI, VII, VIII-р таван жилийн гавшгайч цол тэмдгээр шагнуулж, сумын АДХ-ын сонгуулийн 13, 18, 24-р тойргийн депутатаар сонгогдож байв. Ардын хувьсгалын 60, 70, 80, 90-н жилийн ойн медаль 1986 онд Төрийн шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль”, Худалдааны 90 жилийн ойн медаль, Хөвсгөлийн бахархал тэмдгээр шагнагдаж байв. Давшилт нэгдэл болон Худалдааны байгууллагад нийт 28 жил ажилласан ахмад ажилтан юм.

Д.Авирмэд нь 1933 онд Төмөрбулаг суманд төрсөн. Тэрээр 19 наснаасаа өөрийн эцэг худалдагч П.Дүвчингийн хамт сумын Хоршоонд дагалдангаар ажиллаж байгаад 1953 оноос “Хоршоо”-нд ажилчнаар орж 1987 он хүртэл Худалдаа бэлтгэлийн ангид худалдагч, агент, түүхий эдийн нярав, Давшилт” нэгдэлд нярав зэрэг ажлыг тасралтгүй 34 жил хийж байсан. Улс, төр нийгэмдээ олон жил үр бүтээлтэй ажиллаж, нутаг усандаа нэр хүндтэй хөдөлмөрч, жилийн бараа гүйлгээний төлөвлөгөө нормоо ямагт 100 хувь биелүүлдэг ажилсаг тэргүүний ажилтан байсныг нь үнэлж, “5 жилийн гавшгайч, “Зуун хувьтан” агент, Ардын хувьсгалын 60 жилийн ойн медалиар шагнагдаж байжээ.

**Улсын тэргүүний анчид**

Төмөрбулаг сумаас ажил үйлээсээрээ тэргүүлэн Улсын зөвлөгөөнд оролцож байсан Улсын тэргүүний анчид



Дамбаагийн Чулуун    Гомбын Дорж    Ерооволтийн Жүгдэр    Чойдоржийн Сүхзагд    Тумбааны Жүгдэр



Даваагийн Дэмбэрэл    Паньджунай Лунхаа    Дамбарав-жаагийн Ламжав    Сүхийн Өлзийбаяр    Пүрэвийн Цэвээндорж



**ТАВДУГААР БҮЛЭГ**

# ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙГЭМД ШИЛЖСЭН ТӨМӨРБУЛАГ СУМ

/1990-2010/

## **Зах зээлийн нийгэмд шилжсэн Төмөрбулаг сум**

1990 оны 3 сарын 7-9-ны хооронд Монголын Ардчилсан Холбооны гишүүд өлсгөлөн зарласнаар МАХН-ын Төв хорооны улс төрийн товчоо огцорч нийгмийн улс төрийн тогтолцоог шинэчлэх үйл ажиллагааны эхлэл тавигджээ. 1990 оны долдугаар сард Монголын анхны ардчилсан сонгууль болж, ардчилал тогтсон. Үүнээс хоёр жилийн дараа 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталж, Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн нийгэмд эргэлт буцалтгүй шилжсэн түүхтэй. Энэхүү өөрчлөлт шинэчлэлт Төмөрбулаг суманд ч гэсэн өрнөж байсан юм. 1990 онд Монгол Улсын Бага Хурал “Өмчийн тухай хууль”, 1991 онд “Өмч хувьчлах тухай хууль”-иудыг дараалан батлан гаргажээ. Эдгээр хуулиадад “Нэгдэл, хоршооллын дундын өмчийг хувьчлахад төр оролцох ёсгүй, харин нэгдэл бүр бүх гишүүдийнхээ хурлаар шийдвэрлэнэ” гэж заасан юм. Үүний дагуу ХАА-н нэгдлийг өөрчлөх үйл явц өрнөж эхэллээ. Төмөрбулаг сумын “Давшилт” нэгдэл 1990 онд 1000 гаруй өрхтэй, мал аж ахуйн 7 хэсэг, 190 суурийн 80.2 мянган малтай, ямааны улсын үржлийн ферм, туслах үйлдвэрийн бригадыг нэгтгэсэн 11 сая 972 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 5.5 сая төгрөгийн мөнгөн орлоготой томоохон аж ахуйн нэгж зэх зээлийн нийгэмд анх хөл тавьж байжээ.

### **Сумын төвд улс төрийн суулт зохион байгуулагдав**

1990 оны наймдугаар 20-нд АДХ-ыг сонгох 16 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган чуулж, сумын АДХ-ын тэргүүлэгчдийн дарга бөгөөд гүйцэтгэх захиргааны даргаар Ч.Сандагдоржийг дахин сонгож ажиллуулах боллоо. Анхдугаар чуулган хуралдах үеэр Ардчилсан холбоо хөдөлгөөний дэмжигч тус сумын хэсэг иргэд 9 зүйлийн өргөх бичиг барьж, сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааг бүрэлдэхүүнээрээ огцрохыг шаардаж байв. Тэмцэл хөдөлгөөн эрчимжиж, 1990 оны арваннэгдүгээр сарын 1-нд сумын төвд цуглаан болж, урьдчилан анхааруулах суулт хийсэн бөгөөд цуглаанд оролцогчид дөрвөн үндсэн зүйлийг шаардсан өргөх бичиг өгчээ. Үүний хариу болгон сумын АДХ-ыг сонгох 16 дахь удаагийн сонгуулийн ээлжит бус чуулганыг 1990 оны арванхоёрдугаар сарын 20-нд хуралдуулж АДХ-ын гүйцэтгэх захиргааны удирдах бүрэлдэхүүнийг хэвээр байлгах эсэхэд хүн тус бүр дээр санал хураалт авч шийдвэрлэсэн байна. Чуулганаар сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч.Сандагдорж, орлогч дарга Ч.Лхагвасүрэн, санхүү тасгийн дарга Ч.Жаргалсайхан нарыг өөрсдийн хүсэлтээр нь үүрэгт ажлаас чөлөөлсөн байна. Чуулган зохион байгуулалтын асуудал хэлэлцсэн боловч сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргын урьдчилан судалж бэлтгээгүй учир сонгож чадалгүй, орлогч даргаар Б.Балдандорж, санхүү тасгийн даргаар М.Цэрэнбалжид нарыг сонгож, нарийн бичгийн даргаар Ц.Батбаярыг хэвээр үлдээж байжээ. 1991 оны хоёрдугаар сарын 5-нд сумын

АДХ-ын 16 дахь удаагийн сонгуулийн хоёрдугаар чуулганыг хуралдуулж сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар Л.Цэдэнсодномыг сонгосон байна.

### ***АДХ-г татан буулгав***

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар орон нутагт аймаг, сум гэсэн хоёр шаттай бүтэц байсныг аймаг, сум, баг гэсэн гурван шаттай болгов. 1992 оны наймдугаар сарын 21-нд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль батлагдан гарч АДХ-ын гүйцэтгэх захиргааг татан буулгав. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг сонгох анхны сонгууль 1992 оны аравдугаар сард болж, засаг захиргааны байгууллагын шинээр зохион байгуулсан байна. Баг бүр сумын хурлын төлөөлөгчөөр сонгох хүмүүсийнхээ нэрийг багийн иргэдийн нийтийн хурлаараа шийдэх, олонхийн санал авсан хүнийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлыг төлөөлөгчөөр сонгон илгээж байх журмын дагуу сумын хурлын сонгуулийн 25 тойрог байгуулж дээр дурьдсан журмаар таван баг, нам эвслийн төлөөлөгчдийг өрсөлдүүлэн 25 төлөөлөгч сонгосон байна. Шинээр сонгогдсон ИТХ-ын 25 төлөөлөгч анхдугаар хуралдаанаа 1992 оны есдүгээр сарын 2-нд сумын клубт хийхэд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд малчин 6, баг сумын хүний бага эмч 2, малын бага эмч 2, багийн дарга 2, багш 2, сумын захиргааны ажилтан 3, өндөр настан 2 орсон байв. Төлөөлөгчдийн хамгийн өндөр настай нь 4-р багийн малчин Жүгдэрнамжил, хамгийн залуу нь сургуулийн захирал 27 настай Д.Бат-Эрдэнэ нар байлаа. Иргэдийн төлөөлөгчдийн анхдугаар хуралдаанаар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн даргаар Д.Түмэндэмбэрэл, орон тооны нарийн бичгийн даргаар Ц.Батбаяр, тэргүүлэгч гишүүнээр С.Давааням, Д.Бат-Эрдэнэ, Ч.Доржпалам нарыг сонгов. Засаг даргад Лосолын Цэдэнсодномын нэрийг санал болгож, ИТХ-д өргөн барьснаар сумын Засаг даргаар сонгосон байна. Сумын ИТХ-ын анхдугаар хурлаас аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр Л.Цэдэнсодном, хүний их эмч С.Баярмаа, сургуулийн захирал Д.Бат-Эрдэнэ нарыг сонгожээ. Ийнхүү тус суманд анхны орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал байгуулагдсанаар иргэд, төр орон нутгаа удирдах үйл хэрэгт оролцох эрхээ хууль ёсоор баталгаажуулсан байна.

Шинээр томилогдсон сумын Засаг дарга тамгынхаа газрыг 14 орон тоотойгоор зохион байгуулж, Тамгын газрын даргаар С.Цогтоо, Засаг даргын орлогчоор Ч.Жаргалсайхан нарыг томилжээ. Тамгын газарт татварын болон хөдөлмөр нийгэм хангамжийн алба хамрагдан аппаратыг бүрэлдүүлж байсан бөгөөд 1993 оны аравдугаар сараас татварын алба нь Засаг даргын тамгын газрын бүрэлдэхүүнээс гарч, нэгдмэл арга зүйн үндсэн дээр нэгдсэн удирдлагатай, ажил төрлийн хувьд биеэ даасан хэлбэрээр ажиллах болжээ. Сумын татварын албаны анхны улсын байцаагчаар Ш.Хүрэлбаатар ажиллаж байв. Сумын даатгалын алба нь сумын гүйцэтгэх захиргааны санхүү тасгийн бүрэлдэхүүнд байснаа 1991 онд аймагт байгуулагдсан Монгол даатгал компанийн салбар болон тус суманд байгуулагдаж, даатгалын анхны төлөөлөгчөөр Ч.Жаргалсайхан, 1994 оноос Ч.Сүмбэрэлдорж ажиллаж байсан ба даатгалын алба нь сумын

иргэдийн эд хогшил, мал зэргийг 1994 оноос зохион байгуулалттай даатгалд хамруулж, нийт иргэдийн 93 хувийг эрүүл мэндийн даатгалтай болгож, дэвтэр олгон төлбөр тооцоо хийж байлаа. Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар Ч.Лхагвасүрэн, хөдөлмөр нийгмийн даатгалын байцаагчаар Т.Энхтуяа, соёл олон түмэн хүн ам зүйн асуудал эрхэлсэн байцаагчаар Ж.Болдбаатар нар ажиллаж байв.

### ***“Саруул зам” нэгдэл***

Тухайн үед буюу 1991 оны 1 дүгээр сард Тээл бригадын гишүүн Д.Магван, Г.Алтангэрэл, Д.Батдэмбэрэл, Д.Гүндсамбуу, О.Төмөрбаатар, Д.Жүгдэрнамжил, П.Цэвээнлхазал, Ж.Батхүү нар “Давшилт” нэгдлийн зөвлөл, аймаг, сумын захиргаанд өргөх бичиг барьж, бие даасан “Саруул зам” нэгдэл байгуулах санал санаачлага гаргасан байна. 1991 оны нэгдүгээр сард “Давшилт” нэгдлийн бүх гишүүдийн хурлаар туурга тусгаар нэгдэл болох гэсэн Тээл бригадын малчдын хүсэлтийг ёсоор болгож, шинээр үүсч байгуулагдсан “Саруул зам” нэгдэлд мал, хөрөнгө шилжүүлэн өгөх болжээ. 1991 оны хоёрдугаар сарын 8-нд “Саруул зам” нэгдлийн бүх гишүүдийн хурал болж, нэгдлийн даргаар В.Нямсүрэнг сонгосон байна. “Давшилт”, “Саруул-Зам” нэгдэл тус бүрээс томилогдсон комисс 1991 оны гуравдугаар сарын 29-нд мал, хөрөнгө хуваах ажлыг зохион байгуулж, адуу 4213, үхэр 3650, хонь 12.246, бүгд 20109 толгой мал, хоёр сая 648 мянган төгрөгийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийг “Саруул зам” нэгдлийн 204 өрхийн 800 гаруй гишүүдэд хувь болгон өгчээ. 1992 оны хоёрдугаар сард бүх гишүүдийн хурлаар “Саруул зам” ББХ компани байгуулж, захирлаар нь В.Нямсүрэнг сонгосон байна. 1993 оны есдүгээр сард “Саруул зам” компанийн захирлаар Балсаагийн Чулуунбат нөхөн сонгогджээ. “Саруул зам” компани 1994 онд 12.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, 219 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байжээ. “Саруул зам” нэгдлийнхэн 1995 оны байдлаар 8.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 5.5 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө бүхий 11.2 сая төгрөгийн дүрмийн сантай, 623 гишүүд 123 өрхөд түрээсээр өгч маллуулж байгаа 5300 толгой малтай, үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг, мал эмнэлгийн салбар, мужаан цех, орбит-РМ станцын тоног төхөөрөмж зэргийг өөрсдийн хөрөнгөөр барьж байгуулсан байна.

### ***“Давшилт” компани***

1991 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн “Давшилт” нэгдлийн бүх гишүүдийн хурлаар хувьцаат компанийг үүсгэн санаачлагчид өөрсдийн хувь хөрөнгөө нэгтгэж хувь нийлүүлсэн “Давшилт” хувьцаат компани байгуулан, ерөнхий захирлаар Бямбажавын Шарбанди сонгогджээ.

“Давшилт хувьцаат” компани анх байгуулагдахдаа 1743 гишүүнтэй, 12 сая 968 мянган төгрөгийн дүрмийн сантай, үүнээс үлдсэн хөрөнгө 11 сая 155 мянган төгрөг, эргэлтийн хөрөнгө 1 сая 576 мянган төгрөг, санхүүгийн бусад актив 236.6 мянган төгрөгтэй байв. “Давшилт” компани 1993 оны байдлаар нийт хувьцаа эзэмшигч 873 гишүүний үндсэн хөрөнгө 3 сая 184, эргэлтийн хөрөнгө 2 сая 506, мөнгөн хөрөнгө 111.9 мянга бүгд 5 сая 303

мянган төгрөгийн хөрөнгөд түшиглэн худалдаанд зуучлах, нөөц бололцоо ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулснаар жилийн турш 24 сая 712 мянган төгрөгийн борлуулалт хийж, 24 сая 186 мянган төгрөгийн өртөг, зардал тооцон, 536.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байв. Мөн эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл, албан татвар, ашиг орлогын татвар зэрэг гурван төрлийн татвар болох 488.4 мянган төгрөгийг сумын төсөвт оруулж байлаа. 1993 онд ноогдол ашигт 148.4, 1994 оныход 376 мянган төгрөгийн бараа материал, үнэ бүхий зүйл олгожээ. Энэ нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нэг хувьцаанд 17 төгрөг 68 мөнгө ноогдож байна гэсэн үг юм. Компани хол, ойрын зах зээлээс 50 гаруй нэр төрлийн 7.2 сая төгрөгийн өргөн хэрэгцээний бараа материал авчирч борлуулсан байна. 1994 оны байдлаар “Давшилт” бүрэн бус хариуцлагатай компани 5 сая 81 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 2 сая 918 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 69 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, бүгд 8 сая 62 мянган төгрөгийн дүрмийн сантай байв. Цаашид эсгий, эсгий гутлын болон ноос, ноолуур угаах, самнах жижиг үйлдвэр шинээр байгуулах, мужаан оёдлын цехийг өргөтгөн ажиллуулсны үр дүнд жилд 16-20 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 3.5-4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллах зорилт тавиад зарим тоног төхөөрөмжөө суурилуулж эхлээд байлаа.

### **“Наран толгой” нэгдэл**

Ямааны үржлийн фермийн малчид хөдөлмөрчдийн санал хүсэлтийг 1991 оны арван нэгдүгээр дүгээр сарын 7-нд “Давшилт” нэгдлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар Ямааны улсын үржлийн фермийг бие даасан нэгдэл болгон тусгаарлах нь зүйтэй гэж шийдэв. Энэ ёсоор нэн даруй “Давшилт” нэгдлээс шинээр үүсч байгаа “Наран толгой” нэгдлийн 130 өрх, 598 гишүүдийн хувь хөрөнгө болгон тэмээ 31, адуу 742, үхэр 229, хонь 978, ямаа 11286 бүгд 13266 толгой мал, 1 сая 829 мянган төгрөгийн үндсэн ба эргэлтийн хөрөнгийг шилжүүлэн өгчээ. Гэвч 1991 оны арванхоёрдугаар сард үүсгэн санаачлагчид бүх гишүүдийн хурлаар “Наран толгой” хувьцаат компанийг байгуулж, захирлаар нь Д. Цагаанбаатарыг томилжээ.

### **Хувьчлал явагдлаа**

Тус суманд шинээр үүссэн гурван нэгдэл нэн удалгүй тус бүрдээ хувьчлал явуулах журмаа хэлэлцэн баталж, БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хууль, өмч хувьчлалын хуулийн дагуу үүсгэн байгуулагчдын санаачлагаар хувьцаат компанийн зохион байгуулалтанд орж, хувьчлал эрчимжиж эхэллээ. Хувьцаат компанийн хувь нийлүүлсэн гишүүд их, бага хувьчлалын эрхийн бичигтээ тааруулан мал, хөрөнгөө авч бие даасан ардын аж ахуйтан болсоор байв. Нэгдлийн өмч хувьчлалд түүний гишүүн өрх, ам бүлээс гадна нэгдэлд үйлчилж байсан албан байгууллагын ажилчид, албан хаагчдын гэр бүл, түүнчлэн өөр аймаг, суманд суугаа боловч нэгдэлд анх малаа нийгэмчлэн ажиллаж байсан өндөр настнууд зэрэг 3000 шахам хүн хамрагдаж, хувь хүртжээ.

БНМАУ-ын аж ахуйн нэгдлийн хууль, түүнийг хэрэгжүүлэх журмын дагуу тус суманд 1992 оны нэгдүгээр сараас 1993 оны аравдугаар сар хүртэлх хугацаанд бүрэн бус хариуцлагатай хоршоо 10, хувиараа эрхлэх аж ахуй 11, байгуулагдан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахаар улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ авсан байна. Эдгээрээс нэлээд нь энэ хугацаанд үйлдвэрлэл эрхэлж чадалгүй улсын бүртгэлээс хасагдаж, 1995 оны дөрөвдүгээр сарын 1-ний байдлаар ББХК- 3, ББХХ-6, ХЭАА-5 нь үйлдвэрлэл явуулж байв. Үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд нь “Давшилт”, “Саруул-зам”, “Нарантолгой” ББХК, “Жаргалант”, “Хөдөлмөр”, “Эрчим”, “Чандмань”, “Хайрхан”, “Таван эрдэнэ” ББХА, “Асгат”, “Эрчим”, “Үржил”, “Урандөш”, “Олон булаг” ХЭАА үйл ажиллагаа эрхлэж байжээ.

### **Жаргалант хоршоог байгуулав**

Сумын худалдаа бэлтгэлийн анги нь Жаргалант ББХ хоршоо болон шинэчлэгджээ. Гэвч 1990 онд 48 ажилтантай, 40 гаруй нэр төрлийн түүхий эд цуглуулж бэлтгэдэг байсан энэ байгууллагын үйл ажиллагаа зогсонги байдалд оржээ. Суманд үйл ажиллагаа явуулж байсан 45 тонн талх барьдаг хүчин чадалтай талхны цех, нэгдлийн үед баригдсан 50 тонн-ын тэжээлийн агуулах хувьчлагдан, үйл ажиллагаагаа бүрэн зогсоожээ.

### **12 жилийн сургууль байгуулагдав**

Сумын дунд сургууль 1988-1989 оны хичээлийн жилд 700 гаруй сурагчтай, 34 багш, 43 ажилтантай, уурын төвлөрсөн халаалттай байсан бол 1990-1994 оны үед 350 сурагчтай, 21 багш, 18 ажилчинтай болж, найман жилийн дунд сургууль болон статус нь өөрчлөгдөөд байсан юм. Харин өнөөдөр энэ сургууль дахин өргөжиж, Ерөнхий боловсролын 12 жилийн сургалтанд шилжээд үйл ажиллагаагаа явуулж байна.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ**

# ӨНӨӨГИЙН ТӨМӨРБУЛАГ СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД...

/2014-2015/

**Сумын хүн ам**

Сумын хүн ам бүрэлдэхүүний хувьд хотогйдууд зонхилох бөгөөд цөөвтөр халхууд амьдардаг. Хүн амын нийгмийн бүтэц нь малчин, сэхээтэн, албан хаагчид бөгөөд дөрвөн хүн тутмаас нэг нь ямар нэгэн сургуульд суралцаж байна. Сумын нийт хүн ам ихээхэн залуужиж хүн амын цэвэр өсөлт сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна. Хүн амын дийлэнх хэсгийг хүүхэд залуучууд эзэлж байна.

Тус сум нь . хүн амтай. Үүнээс

- эмэгтэй -
- эрэгтэй-
- 0-5 насны хүүхэд-
- 6-16 насны хүүхэд-
- Нийт хүүхэд-
- өндөр настан-
- хөдөлмөрийн насны-
- Нийт хүн амаас ажиллагсад-,,,,,,,үүнээс:
- Эмэгтэй-..
- Эрэгтэй-
- Оюутан-

Засаг захиргааны нэгж

Тус сум нь 1925 онд байгуулагдсан бөгөөд одоо Цог-Өндөр, Нарийн, Бүгдгээн, Тээл, Жаргалант гэсэн 5 багаас бүрдэнэ.

**Дэд бүтэц**

Эрчим хүчний төвийн нэгдсэн сүлжээнд хамрагдсан ба үүрэн телефоны үндэсний оператор MobiCom, Skytel, Юнител, Монголын цахилгаан холбоо компанийн үүрэн холбоо болон суурин утасны сүлжээнд тус холбогдсон. Айл өрх албан газрууд Микомын өндөр хурдны интернетийн сүлжээнд холбогдсон. Сумын холбооны салбарын интернет кафе нь интернетийн үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ канон,принтер,скайнер,факсаар иргэдэд үйлчилж байна.

Мөн телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг хүлээн авдаг.

**Эдийн засаг**

Эдийн засгийн тэргүүлэх чиглэл нь мал аж ахуй юм. Сумын нийт өрхийн 87.9 хувь буюу 824 өрх айл мал аж ахуй эрхлэн амьдардаг. Мал аж ахуйн үйлдвэрлэлээс жилд дундажаар ноос 58.7 тонн, ноолуур 35.2 тонн, арьс шир 14580 ширхэгийг авч ашигладаг. Мал аж ахуйн салбар уламжлалт мал аж ахуйн аргаар хөгжиж ирсэн. 1998 оноос хойш манай сумын малын тоо 2002 он хүртэл тогтмол өсч байгаад 2002 онд буурч, 2003 оноос 2009 он хүртэл мөн өссөн. Харин 2010 онд өмнөх оноос 35762 толгойгоор буурсан байна. 2011 оноос хойш жигд өссөн байдалтай байна.

Мал аж ахуй

2014 оны жилийн эцсийн мал тооллогоор



- Тэмээ-
- Адуу-
- Үхэр-
- Хонь-
- Ямаа-

бүгд - толгой малтай.

Тус сум нь ... малчин өрхтэй. 2014 оны жилийн эцсийн мал тооллогоор бүгд-.....толгой малтай. Төмөрбулаг сум нь 2009 онд 34 мянгат малчнаар аймагтаа тэргүүлж байсан. 2012 онд 10 мянгат малчинтай байсан бол 2013 оны жилийн эцсийн мал тооллогоор 20 мянгат малчинтай болсон. Үүнээс 2000-т малчин нэг байна. Тус суманд Эрчим омгийн хар ямааны үүлдрийг 1989 онд бий болгож одоог хүртэл өсгөн үржүүлж, түүхий эдийг нь авч ашиглаж байна. Нийт малын бүтцийг хувиар авч үзвэл:

Тэмээ - 0,1%, адуу -3%, үхэр -5%, хонь-38%, ямаа-54% байна. Сумын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй юм.

Сумын мал аж ахуйн талаар баримтлах бодлогыг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн. Сүүлийн жилүүдэд малын үүлдэр угсааг сайжруулах ажилд анхаарч, мах сүүний чиглэлийн “Дархадын ууцан сүүлт” хонь, “Хогоргын улаан монгол” үүлдрийн үхрийг өсгөн, малынхаа чанарыг сайжруулахаар ажиллаж байна. Тус сумын малчдын сэтгэлгээнд өөрчлөлт орж, мал аж ахуйг чанаржуулах, эрчимжүүлэх талаар ахиц гарч байна. Сум хөгжүүлэх сангаас эрчимжсэн МАА-г хөгжүүлэх чиглэлээр гурван аж ахуйн нэгжид 27.0 сая, зургаан малчинд 56.0 сая төгрөгийн зээл олгож, сүүний чиглэлийн өндөр ашиг шимт үхэр үржүүлэн фермерийн аж ахуйн эхлэл тавигдсан. Сумын ИТХ-аар “Малжуулах хөтөлбөр”-ийг батлуулан, цөөн малтай, малгүй өрхийг малжуулах зорилгыг төсөвт тусган ажиллаж байна. 2014 онд 38.9 сая төгрөгийг малжуулах хөтөлбөрт зарцуулахаар батлагдсан. Мөн Орон нутгийн хөгжлийн сангаас малчид иргэдийн саналыг сумын хөгжлийн бодлоготой уялдуулан нэгдүгээр багт өвс тэжээлийн фондтой болох хөдөөгийн гурван багт мал угаалгын ванн барих ажлуудыг хэрэгжүүлэхээр ИТХ-аас баталсан байна.


Мал аж ахуйн салбарын гол түшиц болсон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилтын хүрээнд, 2004 оноос хойш 11 инженерийн хийцтэй худагт их засвар хийх, гүн өрмийн таван худаг шинээр гаргах, “Тогтвортой амьжиргаа-2” төслийн хүрээнд энгийн уурхайн худаг гурвыг шинээр гаргаж, найман худагт их засвар хийсэн. Мөн дөрөвдүгээр багт “Хадлангийн талбай нөцөөлөх” төсөл хэрэгжүүлжээ. Суманд өвс тэжээлийг татан авчрах, малчдад хүргэх тээврийн зардлын сантай болсон байна.

### Төмөрбулаг сумын газар нутаг

Тус сумын нутаг дэвсгэр нь манай гаригийн өргөрөгийн 48, 50 уртрагийн 100 хэмийн огтлолцсон дөрвөлжин дотор тэмдэглэгдсэн байдаг. Сумын эдэлбэр нутгийн хилийн цэс нь (цагийн зүүний дагуу) Могойн даваа, Төмөртийн нуруунаас эхэлж, Цагаанбургасын даваа, Агтын даваа, Эрчимийн нуруу уруудан, Гахайн давааны ам уруудаж Дэлгэрмөрөн голын хойд эргээр Гурван голын бэлчир хүрч, Идэр голын их савын

зүүн эргээр өгсөж, Хөхөөний үзүүрээр гарч, Хөхөөний уул (Хөөнгийн нуруу), Бүгдгээний голын бэлчир, Урт булгийн эхний даваа, Улаан хад, Тал булгийн эхний даваа цонж, Тээлийн нурууг хярлаж, Тээлийн нуруу, Дашдэрчингийн овоо (Дэлийн нуруу), Хаахайн сайрын адгаар Бүгсийн гол хүрч, Бож, Жөнхөн, Могойтын таг, Шар хадны дөрөлж, Ялбант уулаар дамжин эхний цэг Могойн даваа хүрдэг байна. Төмөрбулаг сум нь баруун болон хойд талаараа Бүрэнтогтох, зүүн хойд талаараа Түнэл, зүүн талаараа Тосонцэнгэл, урд талаараа Шинэ- Идэр сумтай хил залган оршдог. Тус сум нийт 2,510 км<sup>2</sup> газар нутагтай, үүнээс 1,950 км<sup>2</sup> нь бэлчээр болно. Сумын төв Жаргалант нь Бүгсийн голын ойролцоо, аймгийн төв Мөрөнгөөс урагш 75 км, нийслэл Улаанбаатараас 714 км зайд байрлана. Тус сумын төв нь далайн төвшинөөс дээш 1790 м өргөгдсөн Жаргалантын голд байрладаг.

Сумын нутагт Эрчим, Дашринчен, Баянзүрх, Бүгсийн өндөр уулс Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Бүгсий, Бүгдгээн, Жаргалант, Нарийн, Хавчуу зэрэг том гол мөрөн байдаг. Агт, Тал булаг, Дөш, Чулуут, Шар хөндий зэрэг үржил шимт өргөн уудам тал хөндийтэй. Торц, Шивэрт, Номт зэрэг элдэв өвчин эмгэгт сайн алдартай рашаануудтай. Бүгдгээний цутгалан, Олон голын бэлчир зэрэг сонин тогтоцтой, байгалийн үзэсгэлэнт газруудтай. Сумын нутагт сайн чанарын чулуун нүүрстэй Жилчигбулгийн нүүрсний орд газар байдаг. 1999 оноос энэ ордыг ашиглаж эхэлсэн бөгөөд чулуун нүүрс, занар, жонш, хүрмэн чулуу, төмрийн хүдэр, зэс, цайрын хүдэр, зэрэг ашигт малтмалаар арвин боловч геологи хайгуулын судалгаа хийж нөөцийг нь нарийн тогтоогоогүй байна.



1974 онд Ардын Их хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор Төмөрбулаг сумын газар нутгийг дээрх байдлаар баталжээ.

- о Нутаг дэсгэр 252172 га
- о Хот суурин 316.4 га
- о ХАА-н эдэлбэр газар 94728.3 га
- о Тариалан 303.0 га
- о Ойн сан 56697.0 га
- о Усан сан 288.0 га
- о Зам 240.0 га
- о Хадлан 16750.0 га

### **Газар зүйн байрлал**

Тус сумын нутаг нийтдээ уулархаг, томоохон уул, нурууд нутгийн дөрөв орчим хувийг эзэлдэг. Нийт нутгийн 56697 га талбайг ой эзэлдэг бөгөөд 90 шахам хувьд хар мод ургахын зэрэгцээ хус, хайлаас, бургас, даль, сурнаг, улиас, улаан бургас, алтан харгана зэрэг мод, модлог ургамлаар баялаг. Тус сумын Бүгсийн голын дагуух болон Эрчимийн нурууны орчмын газар нутаг нь “Төв Азийн геоморфологийн их муж”-ын “Хангайн муж”-ын “Булнайн дэд муж”-д хамаарагдаж байна. Далайн түвшинээс дээш 1790 метрийн өндөрт өргөгдсөн. Хамгийн өндөр цэг Дашдэрчин далайн түвшнээс дээш 2556м, хамгийн нам дор цэг нь Олон голын бэлчир нь далайн түвшнээс дээш 1148 метрийн өндөрт өргөгдсөн. Уул зүйн хувьд нутгийн ихэнх хэсэгт хэрчигдэл ихтэй дундаж өндөр уулс зонхилох бөгөөд Эрчимийн нуруу, Дашдэрчингийн нуруу орчимд дунд зэрэг хэрчигдэлтэй дундаж өндөр уулс тархсан байдаг. Хотгор, гүдгэрийн морфологи хэв шинжийн хувьд нам уул /д.т.д 1500-2000/, өндөрлөг тал ба цав толгод /д.т.д 1000-1500м/ гэсэн хоёр төрөл зонхилно. Тус сум нь далайн төвшнөөс дээш 1780 м өргөгдсөн байна. Монгол орны нутаг дэвсгэрийг томоохон голуудын сав газрыг харгалзан 29 усны сав газарт хуваасан бөгөөд Төмөрбулаг сумын газар нутгийн ихэнх хэсэг нь Дэлгэр мөрөн, зарим хэсэг нь Идэр голын сав газарт хамаарагддаг. Газрын гадаргын хувьд асга чулуугаар хучигдсан усны хагалбар уулс, эгц хажуутай гүн хавцал, галт уул, мөстлөгийн гаралтай хотгор гүдгэр түгээмэл юм. Байгалийн ландшафтын хувьд тус муж нь бусад мужтай харьцуулахад ихээхэн нарийн бүтэцтэй бөгөөд Хангайн өндөр уулархаг хэсэгт ян сарьдгийн ландшафтын зэрэгцээ бушилз ургасан уулын нуга нэлээд дэлгэрчээ.

### **Бэлчээр, газар**

Сумын газар нутаг нь 192667.2 га бэлчээрийн талбайтай. Хонин толгойд шилжсэнээр ... толгой мал, сумын бэлчээрийн даац 86700 хонин толгой мал багтах боломжтой. Бүгсий, Бүгдгээн гэсэн томоохон хоёр голын ай сав, өөрөөр хэлбэл, Хангайн нурууны салбар Эрчим, Бүгсийн нурууны хоорондох уул тал, ар өврийн жалга судаг, нуга, хөндий, хоолой, бэл, олон хөндийн голын сав газраар нүүдэллэн, таван хошуу малаа маллаж, ан гөрөө авлан аж төрж, баян буурал хангайнхаа хишиг буяныг хүртэн, цай сүүнийхээ дээжийг байгаль дэлхийдээ өргөн шүтэн биширсээр үе уламжлан эдүгээ хүрчээ. Бүгдгээн, Бүгсийн голын сав дагуу өвс ургамал жигдэрсэн үржил шим сайтай өргөн хөндийтэй, хөндийн хоёр

талаар ой модоор бүрхэгдсэн уул нуруудтай, голын сав дагуудаа малын хужир, мараа долооцтой, тал хээрийн бэлчээр голлосон учир бүх төрлийн малд тохиромжтой юм. Харин хужиртай нуур цөөрөм ховор учраас Зүүн нуур, Ачмаг, Эрхэл, Сангийн далай, Дөрөө нуураас хужир, шүү бэлтгэж тээвэрлэдэг уламжлалтай. Эрчмийн нурууны өвөр талын голын хөндийн уул, гүвээ толгод нь буурцагт ургамал, агь бутуул голлосон бэлчээртэй тул бог малын тарга хүчинд тохиромжтой байхад, Бүгсийн голын урд тал, Бүгдгээн, Олон голын бэлчир хүртэлх уулархаг хэсэг нь адуу, сарлаг, ямаанд ээлтэй гэж нутгийн иргэд үздэг. Тус сумын Агт, Дөш, Бадаг, Донхор, Жаргалантын бэл замд ямар ч үед цас тогтдоггүй аж.

### **Хөрс**

Төмөрбулаг сумын газар нутаг нь хөрс-био уур амьсгалын мужлалтаар “Хангайн муж”-д хамаарагдана.

Судалгаа явуулсан нутаг дэвсгэрт дараах хэв шинжийн хөрс тархсан байна. Үүнд:

- Уулын цэвдэгт-тайгын хөрс
- Уулын ширэгт-тайгын хөрс
- Уулын хар шороон хөрс
- Уулын хүрэн хөрс зонхилсон байдаг.

### **Ургамал**

#### **Ургамлын нөмрөгийн үндсэн шинж**

Ургамал газарзүйн мужлалаар тус сумын нутаг Хангайн уулын ойт хээрийн хушууны умарт хангайн уулын ойт хээрийн тойрог (Грубов, 1982) -т багтана. Энэ сумын нутаг ерөнхийдөө уулархаг боловч уулт ойт хээрийн районд хамаарагддаг, далайн түвшнээс дээш 2400-2600м өндөр уулс бий. Шинэсэн ой зонхилох бөгөөд хуш-шинэснээс бүрдсэн холимог ой ургана. Өвслөг ургамал элбэг. Нутгийн ихэнх хэсэгт жижиг үетэн - алаг өвс зонхилсон ургамлан нөмрөгтэй бөгөөд уулсын болон уулын хажуугийн хүрэн хөрст газраар үетэн - алаг өвс давамгайлдаг.

Монгол орны ойн ерөнхий шинж төлөвтэй адилаар уулын араар шинэсэн ой, уулын өврөөр уулын хээр тохиолдоно. Уулын хээрүүд зүйлийн бүрэлдэхүүний хувьд ихээхэн олон янз байдаг. Уулсын хоорондын өргөн хөндий, тэгш тал газраар хялгана - алаг өвс, хялгана - үетэн - алаг өвст болон ботуулыг, алаг өвс -үетэнт бэлчээр зонхилно. Түүнчлэн Монгол оронд эрс ховордсон нөмрөгт банздоо, хонин арц, ягаан мүгээ ямаан сэрдэг, үхэр дэгд, өлчир дэгд, байгаль банздоо, эмийн бамбай, сибир алтанхундага, монгол алтан хундага, ягаан цээнэ, ацан ажигана зэрэг олон ховор нандин ургамал ургадаг. Төрөл бүрийн бутлаг буюу модлог ургамал тархаж, алтан гагнуур, алирс, арц, бавран, багваахай, бамбай, банздоо, башга, боролзгоно, бэр цэцэг, ванжингарав, ганга, гишүүнэ, гөгөсгөнө, далан хальс, даль дэгд, жамьянмядаг, зогдор өвс, зээргэнэ, мягмансанжаа, сөд, сүүт, таван салаа, тарваган шийр, халгай, харгана, хиаг, хонгорзул, хунчир, хурган чих, цээнэ, чонын элэг, шаваг, хонлин, яргуй зэрэг эмийн 100 шахам ургамал ургадаг.

### Ойн ургамал

Эндхийн ойд зонхилох төрлийн мод бол шинэс /*Larix sibirica* / ба нутгийн баруун хэсгээр хуш /*Pinus sibirica*/ ургана. Мөн эдийн засгийн ач холбогдолтой олон төрлийн бутлаг ургамалаас нэрс, аньс /*Vaccinium uliginosum*, *V. vitis-idaea*/, улаалзгана /*Ribes rubrum*/, чонын элэг /*Lonicera altaica*/ зэргийг нэрлэж болно. Ойн хөрсөнд хойд тайгын экосистемийн төлөөлөл болох олон төрлийн ургамал ургана. Үүнд ягаан цээнэ /*Raoufia anomala*/, умардын ягжаа /*Linnaea borealis* фото/, мөн олон төрлийн хөвдийг тоочиж болох юм. Тайгын экосистемийн өмнөд хязгаар нь Хангайн бүстэй давхацдаг байна.

### Өндөр уулын бүсийн ургамал

Эндхийн төлөөлөл болсон ургамал бол янз бүрийн бушилз /*Kobresia* sp / бөгөөд хад асган дунд алаг цоог ургана. Энд мөн ихэвчлэн олон янз дэгд, нэрс, үхрийн нүд, улаалзгана, улаагана, хад, аньс, чонын хэл, тошлой, гүзээлзгэнэ зэрэг жимс, самар, мэхээр, мөөг, сонгино гэх мэт хүнсний ургамлын арвин баялаг нөөцтэй юм. Эдгээрээс биологийн нөөц удмын сангаараа эрдэмтний сонирхлыг татдаг Сибирь жодоо, хонин арц, ягаан цээнэ, ямаан сэрдэг, шивүүрт, ортууз зэрэг олон төрлийн ургамлууд Монгол улсын улаан номонд оржээ.

### Ойн төлөв байдал, ашиглалт хамгаалалт


Ойн сан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, сөөг, таримал ойгоос бүрдэнэ. Ойн бүсчлэл: Ойн сангийн нийт талбай 67129 га үүнээс хамгаалалтын бүсийн ой 34223 га, ашиглалтын бүсийн ой 32906 га байна.

Тус сумын хамгаалалтын ба ашиглалтын бүсийн ойг байгальд үзүүлэх нөлөөлөл, ач холбогдол, эдийн засгийн нөхцөлөөр дараах дэд бүсүүдэд хуваасан байна.

Аж ахуйн төрөл	Ойн бүс		Дүн
	Хамгаалалтын	Ашиглалтын	
Ногоон бүсийн ой	7125	-	7125
Хориотой зурвасын ой	10201	-	10201
100 га хүртэлх төгөл ой	691	-	691
30 хэмээс дээших налуу газрын ой	16206	-	16206
Ашиглалтын ой		32906	32906
Сумын дүн	34223	32906	67129

**Ойн талбай:** Ойн сангийн нийт талбай 67129 га байгаа бөгөөд үүнээс 54507 га буюу 81.2 хувийг ойгоор бүрхэгдсэн талбай, 28 52 га буюу 4.2

хувийг ойгоор бүрхэгдээгүй талбай, 9970 га буюу 14.5 хувийг ойн сангийн доторхи ойн биш талбай эзэлж байна. Газрын төрөл тус бүрийн эзлэх хувийг 2-р зургаар үзүүлэв.



**Модны төрөл:** Ойг модны төрлөөр нь авч үзвэл шинэс 99.7 хувь, бургас 0.2 хувь, улиас 0.1 хувь байна. Төмөрбулаг сумын ойн сангийн нийт нөөц нь 7509.5.1 мянган шоо.метр гэж тогтоогдсон байдаг. Манай орны ойд хүнс тэжээлийн ач холбогдолтой олон зүйлийн мөөг ургадаг. Эдгээрийн нөөц судлагдан тогтоогдоогүй боловч ой судлалын ажлын явцад илэрсэн 10 гаруй зүйл мөөг байдаг байна. Тус сум түлшний хэрэгцээгээ ойгоос хангадаг ба жилд дунджаар хэрэглээний мод 700м<sup>2</sup>, түлшний мод 45800 м<sup>2</sup> хэрэглэдэг.Цаашид түлшний мод болон хэрэглээний мод зүй зохистой ашиглах, ашиглагч нь хамгаалагч байх зарчмын хүрээнд 2014 онд дөрвөн ААН, дөрвөн нөхөрлөлтэй мод бэлтгэлийн гэрээ байгуулан сумын албан байгууллага, иргэдийн хэрэгцээг хангаж байна.

### Ан амьтан

Төмөрбулаг сум байгалийн асар их баялагтай, мөн ан амьтан жигүүртэн шувуудын өлгий нутаг юм. Эрчмийн нурууны өвөр талын Талбулаг, Дөш, Агт, Донхор, Жаргалант, Бадагт тарвага элбэг байдаг бөгөөд аймгийн тарваганы нөөцийн 40 гаруй хувийг эзэлж байсан гэдэг мэдээ бий. Мөн зурам, оготно, алаг даага, туулай, үнэг хярс, мануул, шилүүс, өмхий хүрэн зэрэг амьтдаас гадна ой хөвчид чоно, хэрэм, үен, солонго, жирх, дорго, буга, гахай, хүдэр гөрөөс элбэг тааралдана. Тус сум уул нуруу, хөвч ой мод, гол мөрөн олонтой учир ан амьтан, араатан, жигүүртэн, загас жараахай нутагшин байрших, үржин төлжих таатай орчинтой юм. Тус сумын нутагт 20 гаруй хөхтөн, 100 гаруй зүйлийн шувуу, 10-аад төрлийн загас байдгаас таван баг, 13 овог, 31 төрөлд хамрагдах 35 зүйлийн агнуурын амьтан байна. Хөхтөн амьтдын олонх нь ойт хээрийн болон сэрүүн бүсийн амьтад юм. Энд шавьж идэштний багийн ес, гар далавчитны багийн тав, мэрэгчдийн багийн 22, махчдын багийн 10, хос туурайтны багийн гурван зүйл, бүгд зургаан багт хамаарагдах 68 зүйлийн хөхтөн амьтан амьдардаг. Тус сумын нутаг дэвсгэрт халиун буга, хүдэр зэрэг амьтад ховордож, тэдгээрийн байрших нутаг нь хумигдаж байна.

**ТАРВАГА:** Суманд тоо толгой нь цөөрч, тархац нутаг нь хумигдаж байгаа амьтны нэг бол тарвага юм. Хөвсгөл орчимд 1972 онд 253 бүл тарвага тоологдож байсан бол 1988 онд 171 болж цөөрсөн. 2013 онд Хөвсгөл аймгийн хэмжээнд 25 мянга болж цөөрсөн байна.



**СААРАЛ ЧОНО:** Тус сумын хэмжээнд Эрчмийн нуруу, Дашдэрчингийн нуруу дагуух уулсаар байрлана. Сүүлийн жилүүдэд тоо олширч мал руу дайрч идэш тэжээлээ болгох нь ихэсч малчдад багагүй хохирол учруулах болжээ.

**ХАЛИУ БУТА:** Төмөрбулаг сумын Байгаль орчны тасаг 2008 онд ажиглалтын аргаар халиу бугын тоо толгойг тоолоход Эрчмийн нуруу дагуух уулсаар 25, Дашдэрчингийн нуруу дагуу 38 тооллогдсон. 2013 оны агнуур зохион байгуулалтын ерөнхий судалгаагаар 120 болж өссөн нь хууль бусаар агнах явдал бүрэн зогсч, экологи эдийн засгийн үнэлгээ өндөр болсонтой холбоотой.



**ХҮДЭР:** Уулархаг нутгийн ой модоор түгээмэл тархмал. Шөнийн голдуу амьдралтай, ойрхон нүүдэллэдэг энэ амьтан 2600 м-ээс дээш өндөрт амьдардаг. Сумын хэмжээнд Жаргалантын эх, Тариат багийн Шар мараанд нутагшиж байгааг нутгийн иргэдийн аман мэдээгээр тэмдэглэжээ.

Монголдоо хамгийн томд тооцогдох тул загас, Сэлэнгэ мөрнөөр дамжин ирсэн хилэм загас бий. Бүгсий, Олон голын бэлчир, Бүгдгээний цутгаланд манай оронд байдаг олон төрөл зүйлийн загас бий.

Тус сумын нутагт манай оронд түгээмэл байдаг бараг бүх дүрс төрлийн шувуу байхын хамт тас, бүргэд, шар шувуу, ууль, харцага, бөг баатар, ёл, ятуу, хур, сойр ногтруу, тоншуул, ихэвчлэн байна. Бүгдгээн, Бүгсийн голын сав дагуу Олон голын бэлчирээр хавартаа нүүдлийн шувууд ирж зусдаг. Өрөв тас, гангар хун, хээрийн галуу, байгалийн нугас, явлаг сар, усны цагаан сүүлт бүргэд, итгэлэн цахлай гэх мэт шувууд Дэлхийн болон Монгол улсын улаан номонд орсон шувууд ч бий.

## Цаг уур

Тус сум нь уур амьсгалын мужлалтаар “Чийглэгдүү, сэрүүвтэр зунтай бүс”-ийн “Хажир өвөл”-ийн мужид хамаарна. Уур амьсгал бүрэлдэхэд тус сумын газарзүйн байрлал, онцлог, газрын гадаргын тогтоц, далайн түвшнээс дээших өндөршил зэрэг бие биетэйгээ нягт холбоотой хүчин зүйлс голлон нөлөөлдөг байна.

Газар зүйн байрлалын хувьд далай тэнгисээс алслагдсаны зэрэгцээ тал бүрээсээ өндөр уулсаар хүрээлэгдсэний улмаас хур тунадас бага төдийгүй хэлбэлзэл ихтэй байдаг байна. Далайн түвшнээс дээш өндөрт өргөгдсөн учраас сэрүүн бөгөөд хур чийг бага байх, агаарын температур улирлаар болон нэг хоногийн дотор их хэлбэлздэг. Дулааны ба чийгийн нөөц жил жилд харилцан адилгүй ялгаатай байдаг зэрэг эх газрын эрс тэс байдал тус сумын нутагт тодорхой илэрдэг.

Агаарын температур ихээхэн ялгаатай, эрс тэс байдалтай байдаг. Энэ нь өвлийн улирал урт, хүйтэн, зун нь дулаан, хавар намрын улиралд халуун, хүйтэн эрс солигдож байдгаар нотлогдоно. Хоногийн температурын хамгийн их нь гол төлөв үдээс хойно буюу 14-15 цагийн үед, хамгийн бага хэмжээ нь өглөөний 5-6 цагт тохиолдоно. Мөн температурын өөрчлөлт улирлаар хувирах нь илүү байдаг. Ажиглалтаас үзвэл хоногийн температурын хэлбэлзлийн хамгийн бага хэмжээ өвлийн улиралд, хамгийн их хэмжээ нь зуны улиралд тус тус тохиолддог байна. Тус сумын нутагт хамгийн хүйтэн нь өвөл нэгдүгээр сард болдог ба хамгийн их дулаан нь зуны улиралд долдугаар сард тохионо. Олон жилийн дунджаас үзэхэд хамгийн хамгийн их үнэмлэхүй дулаан зургадугаар сард +34,4 градус хүрсэн байна. Хамгийн их хуурайшилттай сар нь 4, 5-р сар, 6-р сарын эхний хагас, намар 9, 10-р сарууд байна.

Хөрсний гадаргуугийн температурыг олон жилийн дунджаас үзэхэд хамгийн хүйтэн үе буюу нэгдүгээр сард -21 градус, хамгийн дулаан үе буюу долдугаар сард +20 градус байсан байна. Тус суманд орох жилийн тунадасны хэмжээ жил жилд харилцан адилгүй юм. Төмөрбулаг сумын цаг уурын станцын сүүлийн таван жилийн мэдээнээс үзэхэд жилд дунджаар 301,6 мм тунадас унасан байна. Олон жилийн дунджаас үзэхэд 307,9 мм тунадас жилд унах бөгөөд үүний 284,7 мм /92,4%/ нь 5-9-р сард унажээ. Жилд унах тунадасны дундаж 200-300 мм, өвөлдөө цасны зузаан 5-15 см, уул хөвчийн оройд 20-40 см зузаантай байна. Хавар Бүгдгээн, Бүгсийн гол дагуу заримдаа салхины хурд секундэд 15-18 метр хүрч, элс шороогоор шуурах ба Эрчмийн нурууны сав, ар бие талдаа хэдийд ч салхи багатай, хавцал, ам, жалга элбэгтэй нутаг билээ.

## Байгалийн баялаг

Сумын нутагт сайн чанарын чулуун нүүрстэй Жилчиг булгийн нүүрсний орд газар байдаг. Тус сумын нутагт үе уламжлан ашиглаж ирсэн барилгын материал элбэг бөгөөд Бүгсийн голын сав дагуу барилгын сайн чанарын шавар, хайрга, Цагаанд элс, Бадагт зос, Донхорт цуулмал чулуу, Эрчмийн нурууны өвөр талын уулархаг газартхүрмэн чулуу, билүү, занар,

цахиур, жонш, шөрмөсөн чулуу бий. Төмрийн хүрэн хүдэр, зэс, цайрын хүдэр байгаа нь одоогоор мэдэгдэж байгаа боловч нөөц нь тогтоогдоогүй учраас олзворлох хэмжээнд хүрээгүй байна. Харин Жилчиг булгийн чулуун нүүрсний орд газрыг ил уурхайн хэлбэрээр олзворлож байна.

## Байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газар

Дуниартан хүрэнтэх цавчим өндөр хад хясаа, ой модоор хүрээлэгдсэн Бүгдгээний цутгалан, Бүгсий, Дэлгэрмөрөн, Идэр, Чулуут голуудын хуран нийлсэн боргио шуугиан, амгалан төрхтэй сүрлэг атлаа ихэмсэг уул нурууд тойрсон тэгш намдуу арал тохой бүхий Олон голын бэлчир, Уранхайрхан зэрэг гадаад дотоодын гийчдийн сонирхлыг татдаг байгалийн үзэсгэлэнт газруудтай.

### Олон голын бэлчир



Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын 2-р багийн нутагт Бүгсийн амны бэлчирт Олон голын бэлчир нь далайн түвшнээс 1148м өргөдсөн. Сумын төвөөс 45км зайтай Идэр, Чулуут, Мөрөнгийн голоос Сэлэнгэ мөрөн эх аван урсдаг байгалийн үзэсгэлэнт газар юм.

### Буган чулуу хөшөө

Тус сумын нутаг дэвсгэр дээр нэн эртний үеэс хүн оршин сууж амьдарч байсныг илтгэсэн чулуун болон хүрэл зэвсгийн үеийн булш, хадны сүг зураг, буган хөшөө олонтой. Буган



хөшөө бол Төв Ази болон Европын зарим нэг бүс нутагт тархсан, хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед оршин суугч нүүдэлч ард түмний түүх, соёлын гайхамшигтай дурсгалын нэг билээ. Гонзгой чулууг засч ихэнхдээ сүрлэг бугыг уран гоёмсоор, загварчлан дүрсэлдэг учраас “буган хөшөө” хэмээн нэрлэдэг. Мөн хөшөөнөө бүс, зэр зэвсэг, толь, бамбай, хүзүүний зүүлт, дугуй цагираг сүйх, зарим тохиолдолд титэм /малгай/ дүрсэлсэн байна. Ихэнх буган хөшөөнд бугыг уран гоёмсоор, загварчлан дүрсэлсэн байдаг



бол зарим буган хөшөөнд буга, гахай, адуу, зээр зэрэг амьтныг бодитойгоор дүрсэлсэн байдаг.

Харин зарим буган хөшөөнд огт амьтны дүрс байхгүй зөвхөн бүс, хүзүүний зүүлт, зэр зэвсэг, сүйх зэргийг дүрсэлсэн нь бий. Буган хөшөө нь утга зүй, зориулалтаараа оршуулга, тахилгын зан үйл бүхий хиргисүүртэй хамт орших цогцолбор дурсгал бөгөөд дийлэнх судлаачид хөшөөний илэрхийллийг хүнтэй холбоотой хөшөө дурсгал гэдэг үзлийг баримталж байдаг.

**Тодруулбал:** “оршуулсан дайчин цэргийн хөшөө”, “дайчин эр”, “язгууртан удирдагч хүний дүр”, “хүний сүнслэг бие дүр” хэмээн үзэж байна.

Үүнийг ч буган хөшөөний хэлбэр дүрслэлийн агуулга нь нотолдог.

Ази, Европ тивийн хээр талын бүс нутагт хүрэл, төмөр зэвсгийн түрүү үед өргөн тархсан түүх, соёлын гайхамшигтай дурсгал болох буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судалж 700 орчим буган хөшөө оллоод байна. Энэхүү дурсгалын үүсэл тархалтын төв нь болох Монгол улсын нутагт 550 орчим нь байдаг. Тус сумын 4-р багийн нутагт байдаг Буган чулуу нь түүхийн дурсгалт чулуу бөгөөд Хөвсгөл аймгийн тусгай хамгаалалтанд авчээ. Зуна голд буй энэхүү 190 см өндөр, нийтдээ 13 ширхэг буган хөшөөнүүд өнөөдөр жуулчдын анхаарлыг зүй ёсоор татдаг.

### Жаргалантын сийлбэртэй хад

Жаргалант, Цагааны сийлбэртэй хад голын эх уулын хойморт байрлах элдэв хиргисүүр хөшөө чулуу Хүннүгийн үеийн бололтой булшнууд, улар бууцууд нь Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд эртний хүмүүс амьдарч байсныг гэрчилдэг.



### Торцын рашаан

19 дүгээр зууны эцсээр рашааныг нутгийн маарамба, оточ нар судал бүрт төвд бичгээр пайз хатган ямар өвчинд тохирохыг зааж тэмдэглэсэн байжээ. Эдүгээгээс 60-аад жилийн өмнө ч энэ байдал хэвээр хадгалагдаж байсан. Торцын рашаан нь хүний биеийн дотор ходоод цөс бруцеллөз үе мөчний архагшсан өвчнийг анагаах бодисын солилцоог сайжруулах онцлогтой юм.



Торцын рашааныг 2009 онд ТА-2 төслөөр тохижуулж, рашааныг эхийг хамгаалснаар рашааны ундарга сайжирч Бүгсийн голын урсацын түвшин нэмэгджээ. Энэхүү рашаанд 2013 оны байдлаар сумын 200 гаруй амрагчид амарсан бөгөөд энэ тоо жилээс жилд нэмэгдэж байна.

Өвдөж зовсон олонд ачлал буянаа түгээсэн Торцын рашааны талаар түүх домог олон бий. Энэ талаар тус сумын уугуул иргэн Цэрэннадмид ийнхүү хуучилж байна. “Төмөрбулагийн рашаан бол эрт дээр үеэс хүн амьтан ихээр ирж, бүр оочирлон дугаарлаж байсан гэдэг. Энэхүү рашааны онцлог нь таван цул, зургаан сав эрхтэнд онцгой сайн хэмээн шүтдэг байжээ. Намар цагийн хур татсан үед хол ойрын нутгаас хүмүүс ирж Төмөрбулагийн рашааныг тойрч айл олж буугаад мөддөө явдаггүй байж, тэр тусмаа Хятадууд маш их ирдэг байсан гэнэ. Манай хүрээний гурван маарамба рашааныг судлаад намар цагийн хур татсан үед биш Идэр гурван ес эхлэхээр рашаан дотроос шар цэцэг ургаж, ногоон навч найгаж байдаг. Тэр үед нь увал хүч чадал нь гүйцэж эмчилгээний чанар нь сайн гэж тогтоосон гэдэг. Үүнийг нь Хятадууд мэдээд намар биш өвөл тогтмол ирдэг болж. Нутгийн иргэд үүнд нь дургүйцэн удаа дараалан айлган хөөсөн ч өвөл дахиад л ирчихсэн рашаан ууж байж. Нутгийн хэдэн залуус тэднийг айлган хөөхөд тэр шөнөө бүгд нүүгээд явсан ч хэд хоногийн дараа Төмөрбулагийн рашаан гэнэт ширгэчихсэн гэнэ лээ. Хошуу ноён зарлигдаж Хүрээний лүүжинч лам нар лүүжин тавиад гараагүй гэнэ. Үзмэрч үзээд “Эхийг ухаж үз, ямар нэг амьтныг алж булсан байна” хэмээн хэлж. Нутгийн залуусаар ухуулан үзэхэд Хятадууд явахдаа булагийн эхэнд шар жингэр алж булаад явсан байж. Тэрийг нь цэвэрлээд дахин лүүжин тавиад удаагүй жинхэнэ эхнээсээ биш хажуу талаасаа гарсан гэсэн. Хуучин янзаараа шар цэцэг навч нь гурван ес эхлэхээр гардаг гэсэн. Үүнийг мэддэг нь авч уудаг байж. Манай аав ярихдаа “Би аавдаа цэцэг навчыг нь ургахаар авч өгдөг байсан, ширгэсэнээс нь хойш хүн амьтан ер ирэхээ больсон доо” гэж ярьж байсан. Би муухан санадаг юм. Буурай аав маань их л уудаг байсан, намар болохоор рашааны тэнд майхантайгаа дандаа байдаг байсан хэмээн хуучилжээ.

**Зуна голын арслан хэлбэртэй хад Шивэртийн Сэнжит хад-нүхэн чулуу**

Шивэртийн сэнжит хад хүнэн чулуу нь холоос гэр хэлбэртэй харагддаг бөгөөд эрт дээр үеэс нутгийн ардууд бишрэн шүтэж, өвчин эмгэгтэй мал сүргээ тэрхүү хүнэн хад руу тууж оруулан гаргадаг, алс холын аян жин, цэргийн албанд явагсад хадны хөндийгөөр морьтойгоо орж амь насаа даатган гардаг байжээ.

**Дашдэрчин хайрхан**

Оройд нь гарсан хүн долоон хошууны нутаг харж, хийморио сэргээн, тэр жилдээ эрүүл саруул, олз омогтой байдаг гэж хавь ойрын хил залгаа Халх, Хотогойд хошууны хуучуул шүтэн дээдэлсээр ирсэн. далайн төвшнөөс дээш 2556 м өргөгдсөн хамгийн өндөр цэг юм.



**Эрчмийн нуруу**

Төмөрбулаг сумын өмнүүр дүнхийн цэнхэртэх Эрчмийн нуруу нь Бүрэнтогтох сумын нутаг дахь Бүрэнтогтох, Төмөртийн нуруутай нийлж 100-гаад км үргэлжлэх бөгөөд харьцангуй өндөр нь 2200 метр юм. Нурууны ар хэсэг нь ой мод ихтэй, олон гол горхи эх авч урсдаг. Эрчмийн нурууг давах гол даваа нь Цагаан бургасын даваа юм. Эрчмийн нурууны ноён оргил нь Урандөш хэмээх унтарсан галт уул юм.

**Гол мөрөн**

**Ус зүйн нөхцөл:** Тус сумын нутагт том жижиг нийлсэн 22 гол, горхи урсаж хүн малаа ундаалж байдаг. Үүнд Дэлгэр, Хана хадны, Торц, Төмөрийн булаг, Урт сайр гэх мэт 26 булаг, Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Идэр, Бүгсий зэрэг томоохон гол, мөрөн бий. Эдгээр голуудаас Сэлэнгэ мөрөн эх авч уг газрыг Олон голын бэлчир гэж нэрлэдэг. Манай орны нутаг дундуур гарах дэлхийн усны хагалбар шугам, тус улсын нутагт бүрэлдэх ус зүйн сүлжээг гурав хуваасан бөгөөд “Хойд мөсөн далайн ай сав”-д тус сумын ус зүйн сүлжээ хамаарч байдаг. “Хойд мөсөн далайн ай сав”-д багтаж байгаа гол мөрний сүлжээний нягтшил 0,07 км/кв байдаг байна. Дээрх ус зүйн сүлжээг бүрдүүлж буй гол горхиудаас хамгийн том нь Сэлэнгэ мөрөн юм.

**Сумын эдийн засгийн салбарын хөгжил**

Сумын эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг эрхэлж ирсэн туршлагатай ба сумын нийт өрхийн 68.4 % буюу 823 малчин өрхтэй. Сумын хүн амын тоо сүүлийн 3 жилд дунджаар 0.4 хувиар өсч байна. Нийт бүтээгдхүүний үйлдэрлэлд ХАА-н бүтээгдхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 88.8 хувийг эзэлж байна. МАА-н үйлдвэрлэлээс жилд дунджаар 80.0 мянган кг ноос, 40.0 мянган кг ноолуур, 14900 ширхэг арьс шир авч ашигладаг.

Сумын татварын ба татварын бус орлогоор төсөвт 154.0 сая төгрөг бүрдүүлсний 25.0 % нь орон нутгийн орлогод орж байна. 2013 онд орон нутгийн орлого 57.5 сая төгрөгөөр бүрдсэн. Орон нутгийн орлогын 61.4 хувийг ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр эзэлж байна. Орон нутгийн төсвийн байгууллагууд зардлынхаа 0.5 хувийг өөрийн орлогоор, 11.6 хувийг орон нутгийн орлогоор 87.9 хувийг санхүүгийн дэмжлэг, аймгийн орлогоор санхүүжүүлж байна. Сумын төсвийн нийт зарлага 2073.2 сая төгрөг байгаа ба энэ нь өмнөх оныхоос 456.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Сумын хөрөнгө оруулалтын хэмжээ:**

**Сүүлийн 3 жилийн байдлаар/сая төг/**

Он	2011	2012	2013
Хөрөнгө оруулалтын дүн	220.6	99.0	337.9

Дээрх хөрөнгө оруулалт нь улсын төсвийн хөрөнгөөр төсвийн байгууллагуудад хийгдсэн хөрөнгө оруулалт ба 2013 оны хөрөнгө оруулалтын 46.7 хувь нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжсэн байна.

### Газар тариалангийн салбар

Газар тариалангийн салбар нь тус суманд 1934 -аад оноос эхлэн хөгжиж,1960-оноос хөгжил нь саарч, 1984-1986 онуудад эрчимтэй хөгжиж 1990 оны дунд үеэс дахин сэргэсэн. 1984-1986 онуудад Тариатын ам, Бүгдгээн Бүгсийн ам Устын ам, Тал булгийн аманд малын ногоон тэжээл тариалан 600 гаруй га эргэлтийн талбайтай,420 орчим га талбайд малын ногоон тэжээл, 4 га талбайд төмс хүнсний ногоо тариалж байжээ. Өмч хувьчлал явагдаж 1992 оноос хойш малын тэжээл тариалахаа больж иргэд хувиараа өрхийн хэмжээнд өөрсдийн хүнсний хэрэгцээгээ хангах төдий тариалдаг болсон. Өнөөдөр цөөн тооны иргэд төмс, манжин, лууван, байцаа гэх мэт хүнсний ногоо тариалж, өргөст хэмх, улаан лооль гэх мэт нарийн ногоонуудыг хүлэмжинд ургуулан хүнсэндээ хэрэглэж байна. Тариалалт эрхэлж байсан жилүүдэд ургацын хэмжээ харилцан адилгүй, цаг агаарын аясыг дагасан шинжтэй байжээ. Хамгийн их ургацыг 1993-2000 оны хооронд авч байсан гэсэн албан бус мэдээ байна. 1992 оноос хойш хамгийн их ургац авсан 2010 онд 59.0 тн төмс хураан авсан. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлээс 2010 онд нэг иргэнд 1.5 сая төгрөгийн, 2011 онд нэг иргэнд 2.5 сая төгрөгийн зээл тоног төхөөрөмж авах, технологийн шинэчлэл хийхэд зориулж олгосон. Иргэд хувиараа ногоо тариалж байгаагаас гадна нэг аж ахуйн нэгж, нэг ТББ байгууллага газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж төмс хүнсний ногоо, малын тэжээл тариалдаг. Гэвч цаг агаарын байдал, усжуулалтын асуудалтай холбоотойгоор хүнсний ногоо тариалалт буурч байна. 2013 онд сумын хэмжээнд 8.1 га талбайд төмс тариалж 26 тн төмс, 0.923 га талбайд хүнсний ногоо / улаан лооль, өргөст хэмх, манжин, лууван/ тариалж 295 кг хүнсний ногоо,0.5 га талбайд малын тэжээл буюу овъёосыг тариалж 500 кг ургац хураан авсан байна. Мөн сумын хэмжээнд “Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд нийт 60 өрх 1200 суулгацыг,ЗДТГ нь сумын төвд нэг га газарт 1000 ш чацарганы суулгац тариалсан байна.Газар тариалангийн чиглэлээр “Аваргуудын алдар” хоршоо, “Мэргэн гүн Бүгдгээн” ТББ зэрэг аж ахуйн нэгжүүд улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Жил бүр “Ногоон цагаан хувьсгал” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж,үзэсгэлэн худалдаанд иргэд идэвхитэй оролцдог.

#### 6. Газар тариалангийн салбарын хөгжлийн үзүүлэлт сүүлийн 6 жилийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2008	2009	2010	2011	2012	2013
Хураасан ургац, тн	4609,6	5198,5	5693,5	5923,5	6957,5	6335,3
Үр тариа						
Төмс	32.0	61.0	59.0	61.0	76.0	13,8
Хүнсний ногоо	9.6	9.5	6.5	9.5	9.5	3,5
Тэжээлийн таримал		8	8	6	6	5
Хадлан	4568	5120	5620	5847	6866	6313

**Эрчим хүчний хангамж:** Төвийн эрчим хүчний нэгдсэн системд 2007 онд холбогдсон ба эхлээд сумын төвд 180-200 өрх байдаг байсан бол 2013 оны жилийн эцсээр сумын төвд 340 гаруй өрх цахилгааны эх үүсвэрт холбогдсон байна.

Хөдөөгийн 1 багийн төв эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон.

**Ундны усны хангамж:** Тус суманд одоогийн байдлаар инженерийн хийцтэй 38, энгийн уурхайн буюу богино яндант 42 худгийг 5 багийн нийт 4316 хүн амын ундны ус, бэлчээрийн усжуулалтанд ашиглаж байна.

### БИЗНЕСИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Тус сумын эдийн гол салбар нь мал аж ахуй, худалдаа үйлчилгээний салбар болж байна. Бизнесийн үйл ажиллагаанд зургаан компани, хоёр хоршоо, нэг нөхөрлөл, 1228 мал аж ахуй дагнан эрхлэгч, 42 худалдаа эрхлэгч, 78 тээвэр эрхлэгч оролцож байна.

#### Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил:

Суманд 1960-аад оны эхээр Артель нэртэйгээр нэг цэгт төвлөрсөн үйлдвэрлэл эрхэлж байгаад 1980 оны эхээр ахуй үйлчилгээний төв нэртэйгээр үсчин, гуталчин, оёдол, эсгүүр, жолооч , зурагчин, борлуулагч гэсэн орон тоотойгоор нилээд олон хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байлаа. Давшилт нэгдлийн харьяанд Тэжээлийн байнгын бригад, автограш, үйлдвэр бригад, хадлангийн бригад, эмчилгээ тэжээлийн цэг ажиллаж,үйлдвэр бригадын харьяанд талхны цех ажиллаж сургуулийн дотуур байрны хүүхэд, иргэдийг талхаар хангаж байв.

Эдгээр үйлдвэрүүд нь 1992 онд хувьчлалын татан буугдсан.Үүнээс хойш иргэд өрхийн хэмжээнд үйлдвэрлэлээ явуулж байна. Хэрэглэгчдэд эрүүл хүнс, чанартай бүтээгдэхүүнээр үйлчлэхэд голлон анхаарч орон нутагт жижиг дунд үйлдвэрлэлийг бий болгож, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зорьж байна.Тус суманд 1992 онд хувьчлал явагдсанаас хойш ахуй үйлчилгээний нэгдсэн төв хувьд гарч ажиллахгүй болсон ба одоо энэ чиглэлийн үйлдвэрлэл зөвхөн өрхийн хэмжээнд явагдаж байна. Сүүлийн жилүүдэд ард иргэдэд хэрэгцээт бүтээгдэхүүнийг нийлүүлэх, залуу малчдад мал маллах арга ухааныг зааж сургах, гэр ахуй болон үндэсний хувцас үйлдвэрлэх бүх төрлийн хувцасны засвар үйлчилгээ, бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэх, шүр сувсан урлал, мод модон эдлэлийн тавилга, блокны үйлдвэрлэл, шахмал түлшний үйлдвэрлэлийг бий болгож ажлын байр нэмэгдүүлж байна. Суманд жижиг дунд үйлдвэрлэл нь цех болон өрхийн үйлдвэрлэлийн хэмжээнд явагдаж байна. Жил бүр аймаг , сумандаа жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр өрхийн үйлдвэрлэгчдийг үзэсгэлэн худалдаанд оролцуулж ирсэн ба 2013 онд аймгийн шилдэг үйлдвэрлэгч байгууллагаар шалгарсан.

## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧООН

### ЗУРГААДУГААР БҮЛЭГ

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨМӨРБУЛАГ СУМЫН ИТХ, ЗДТГ

Монгол Улсын 1992 онд батлагдсан ардчилсан шинэ Үндсэн хуулиар нутгийн удирдлагын тогтолцоог өөрчлөн шинэчлэх эрх зүйн орчин бүрдэж, мөн оны наймдугааар сарын 25-ны өдрөөс мөрдөгдсөн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу сумын ИТХ-ын анхны сонгуулийг явуулж, тойрог тус бүрээс сонгогдсон 25 төлөөлөгч “Анхдугаар хуралдаан”-аа мөн оны есдүгээр сарын 25-ны өдөр хийж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Д.Түмэндэмбэрэл, нарийн бичгийн даргаар Ц.Батбаяр, Тэргүүлэгчээр С.Давааням, Д.Бат-Эрдэнэ, Ч.Доржпалам нарыг сонгосноор Төмөрбулаг сумын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох ИТХ үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

Тухайн үед мөрдөгдөж байсан Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн дагуу ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга нь орон тооны бус, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нь орон тоогоор ажиллаж, ИТХ-ын байгууллага үндсэн нэг орон тооны ажилтантай ажиллаж байжээ. Тус сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар 1992-1994 онд Д.Түмэндэмбэрэл, 1994-2000 онд Ч.Сандагдорж, 2000-2004 онд Ж.Маналсүрэн, 2004-2008 онд Ц.Батбаяр, 2008-2012 онд Б.Чулуундаваа нар ажиллаж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх талаар идэвх санаачлага, үр дүнтэй ажиллаж, бодит хувь нэмэр оруулсан бөгөөд эдгээр хүмүүс нь улс нийгэмд олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж төр засгийн өндөр шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, “Цэргийн гавьяа” одон, “БСШУ-ны яамны тэргүүний ажилтан”, “Нутгийн удирдлагын тэргүүний ажилтан” зэрэг шагнал хүртсэн нэр хүндтэй тэргүүний төрийн албан хаагчид байсныг онцлон дурьдаж болно. Мөн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарыг он дарааллаар дурьдвал 1992-1998 онд Ц.Батбаяр, 1998-1999 онд С.Данаажав, 2000-2004 онд Д.Түмэндэмбэрэл нар ажиллаж, 2005 оноос Ц.Бямбадорж одоог хүртэл ажиллаж байна.

Сумын ИТХ-ын байгууллага нь 2012 оны сонгуулиар орон нутгийн иргэдийн итгэлийг хүлээн сонгогдсон 21 төлөөлөгч, долоон тэргүүлэгч, ИТХ-ын дэргэдэх Төсөв санхүү хяналт шалгалтын байнгын хороо, Хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал, жуулчлалын байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо, Нутгийн удирдлага, нийгмийн дэг журам, иргэдийн эрх ашгийг хамгаалах хороо гэсэн бүтэц зохион байгуулалтай ажиллаж байна. ИТХ-ын даргаар Г.Бямбасүрэн сонгогдон, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын ажлын үр дүн, нөлөөллийг сайжруулах, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах зорилт тавин ажиллаж байна. Төмөрбулаг сумын ИТХ нь хууль тогтоомжинд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгаа хөгжүүлэх бодлого чиглэл гарган, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төрийн удирдлагатай хослуулан иргэд сонгогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалан, тэдний өмнө тулгамдсан орон нутгийн чанартай асуудлыг бие



даан шийдвэрлэх, Монгол улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, сум, багийн Засаг дарга нарын хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, төр иргэдийн харилцааг ойртуулж төрийн үйл хэрэгт оролцох оролцоог нь дээшлүүлснээр иргэний нийгмийн хөгжилд түлхэц болох, орон нутгийн нийгмийн бодлогын асуудлын хүрээнд соёл, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж зэрэг төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, сайн засаглалыг бэхжүүлэн, иргэдийн амьжиргааны чадавхийг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа чиглүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.



*Сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нарын хамт /2012-2016 онд/*

### *Сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан хүмүүс*

Доржийн Түмэндэмбэрэл нь 1943 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. Намын дээд сургууль төгссөн. Нягтлан бодогч, улс төрийн удирдлага мэргэжилтэй, 1992-1994 онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн анхны даргаар сонгогдон ажиллаж байсан.

Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр зургаан удаа сонгогдсон. Улс, нийгмийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Алтангадас одон бусад салбарын



шагналаар шагнагдсан. Чимэддоржийн Сандагдорж 1942 онд Хөвсгөл аймгийн Галт суманд төрсөн. Хөдөө аж ахуйн дээд сургууль, ЗХУ-д / хуучнаар/ Цэргийн академи төгссөн. Агрономич, Цэргийн удирдлага мэргэжилтэй, цэргийн хурандаа цолтой. Тэрээр 1994-2000 онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдон ажиллаж байсан. Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр дөрвөн удаа сонгогдсон. Улс, нийгмийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Алтангадас одон болон төр засгийн болон салбарын шагналаар шагнагдсан.

Жигжидийн Маналсүрэн 1949 оны зургадугаар сарын 15-нд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Сангийн далайн “Цагаан толгой” хэмээх газарт мэндэлсэн. 1969 онд УБДС-ийн математик, зургийн багшийн ангид суралцан төгсжээ. 1978-1985 онд УБДС-д дахин сурч, газар зүйн багшийн мэргэжилээр давхар эзэмшсэн. Математик, зураг технологи, газар зүйн багшийн мэргэжилтэй. 2000-2004 онд Төмөрбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдон ажилласан. Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр гурван удаа сонгогдсон. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байх хугацаандаа тус сум, орон нутгийн хөгжил дэвшил, ард иргэдийнхээ сайн сайхан амьдралын төлөө ажил үйлсээ зориулан ажиллаж Төмөрбулаг сумын мал сүргийн үүлдэр угсааг сайжруулах, байгууллагуудын тохижилт соёлжилтыг сайжруулах, шашны зан үйлийг сэргээн хөгжүүлэх, сум байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан дурсгалын самбар, өндөрлөгийг бүтээн байгуулах зэрэг олон ажил санаачлан хийсэн. Улс, нийгмийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж “Ардын хувьсгалын ойн медалиуд”, “Боловсролын тэргүүний ажилтан”, “Их Монгол Улс байгуулагдсаны 800-н жилийн ойн медаль”, МУЗН-ийн Нигүүлсэл мөнгөн медаль” зэрэг шагналуудаар шагнасан.



Цэдэнсамбуугийн Батбаяр 1957 онд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох суманд төрсөн, Бүрэнтогтох сумын 8 жилийн дунд сургууль, Мөрөн сумын 10 жилийн сургуулийг дүүргэж, улмаар УБДС-ийн техник хөдөлмөрийн багшийн курс, Намын



дээд сургуулийг тус, тус төгсөж, Хөдөлмөрийн багш, Улс төрийн удирдлага мэргэжил эзэмшсэн. 2004-2008 онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдон ажилласан. Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр зургаан удаа сонгогдсон. Улс, нийгмийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, АХ-ын ойн медалиуд, МНУХ-ны Тэргүүний ажилтан, “Их Монгол Улс байгуулагдсаны 800-н жилийн ойн медаль” зэрэг шагналуудаар шагнагдсан.

Бадарчийн Чулуундаваа нь 1966 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. Төмөрбулаг сумын 8 жилийн сургууль, Дархан уул аймгийн Усны аж ахуйн техникумыг Газар зохион байгуулагч мэргэжлээр төгссөн. 2008-2012 онд сумын ИТХ-ын даргаар сонгогдон ажилласан. ИТХ-ын төлөөлөгчөөр хоёр удаа сонгогдсон. Улс, нийгмийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж “Алтан гадас одон”, МНУХ-ны соёмбо одон болон төр засгийн болон салбарын шагналаар шагнагдсан.



Гэлэгчулууны Бямбасүрэн нь 1985 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. Эдийн засаг бизнесийн дээд сургууль төгссөн, банкны эдийн засагч мэргэжилтэй. 2012-2016 онд сумын ИТХ-ын даргаар сонгогдон ажиллаж байгаа. Эрхэлсэн ажилдаа амжилт бүтээлтэй ажиллаж ХААН банкны “Алтан од” шагнал, МНУХ-ны соёмбо одон, МУЗН-ийн “Нигүүсэл мөнгөн медаль зэрэг шагналуудаар шагнагдсан.

### Сумын ИТХ-ын бүтэц, бүрэлдэхүүн

1992-1994 онд тухайн үед мөрдөгдөж байсан Орон нутгийн хурлын сонгуулийн хуулийн дагуу ИТХ-ын 25 төлөөлөгчийг улирал бүр сонгож, жилдээ 4 удаа ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгууль явагдаж байсныг тухайн үед ИТХ-д сонгогдож байсан зарим ахмадууд дурсан ярьж байна.

Монгол Улсад шинээр үүсэн хөгжсөн Нутгийн удирдлагын тогтолцооны дагуу 1992 оны 9 сард сумын анхны ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:

№	Төлөөлөгчдийн овог, нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харъяалал
1	Д.Түмэндэмбэрэл	Ня-бо, улс төр судлаач	ИТХТ-ийн дарга, ХАА-н банкны т/т-ийн эрхлэгч	МАХН
2	Ц.Батбаяр	Багш, улс төр судлаач	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	МАХН
3	Ч.Доржпалам	Жолооч	Ахмадын хорооны дарга	МАХН
4	С.Давааням	Малын бага эмч	Малын эмч	МАХН
5	Д.Бат-Эрдэнэ	Багш	Багш	МСДН
6	Б.Бурмаа	Багш	Багш	МУАН
7	Ч.Лхагвасүрэн	Ня-бо	Байгаль орчны улсын байцаагч	Нам бус
8	Г.Цэрэндаш	Соёлын төвийн ажилтан	Хоршооны эзэн	МУАН
9	Ч.Бадраа	-	Цаг уурын ажиглагч	МУАН
10	О.Нямсүрэн	Ня-бо	“Саруул зам” компаний захирал	МАХН
11	Д.Батхүү	Малын их эмч	Малын эмч	МУАН
12	Ж.Батбаяр	Гидротехникч	Багийн Засаг дарга	МАХН
13	Ж.Лхагважав	Биологич	Хичээлийн эрхлэгч	МСДН
14	Б.Шарбанди	Мал зүйч	Давшилт компанийн захирал	МАХН
15	Ц.Даваажаргал	Малын их эмч	Малын эмч	МАХН
16	Ч.Сандагдорж	Агрономич, Цэргийн удирдлага	Сумын Засаг дарга	МАХН
17	Ц.Хадбаатар	Ня-бо	Давшилт компанийн ня-бо	МАХН

18	Б.Лигшигдорж	Жолооч	Жолооч	МАХН
19	Д.Жүгдэрнамжил	-	Малчин	МҮАН
20	Д.Наранбаатар	Малын бага эмч	Багийн Засаг дарга	МАХН
21	Ж.Маналсүрэн	Багш	Сургуулийн захирал	МАХН
22	Д.Түмэнжаргал	Жолооч	Хоршооны эзэн	МҮАН
23	Б.Чулуунбат	Малын эмч	ХХЭ	МАХН
24	П.Банзрагч	Тоо бүртгэгч	Малчин	МАХН
25	Б.Балдандорж	Багш	Багш	МҮАН

### Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1994-1996 он

Тухайн үед мөрдөгдөж байсан сонгуулийн хуулийн дагуу ИТХ-ын байгууллага нь бүтэц зохион байгуулалтын хувьд 25 төлөөлөгч, 7 тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан байна. Үүнд: ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Ч.Сандагдорж, нарийн бичгийн даргаар Ц.Батбаяр ИТХ-ын Тэргүүлэгчээр Ч.Сандагдорж, Ц.Батбаяр, Д.Батхүү, Б.Шарбанди, Б.Чулуунбат, Д.Даваадорж, Ж.Маналсүрэн нар сонгогджээ.

#### 1994-1996 оны сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:

№	Төлөөлөгчдийн овог, нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харъяалал
1	Ч.Сандагдорж	Агрономич, Цэргийн удирдлага	ИТХТ-ийн орон тооны бус дарга	МАХН
2	Ц.Батбаяр	Багш, улс төр судлаач	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	МАХН
3	Д.Батхүү	Малын их эмч	Малын эмч	МҮАН
4	Б.Шарбанди	Мал зүйч	Давшилт компанийн захирал	МАХН
5	Д.Даваадорж	Хуульч	Багийн Засаг дарга	МҮАН

6	Б.Чулуунбат	Малын эмч	Компанийн захирал	МАХН
7	Ж.Маналсүрэн	Багш	Сургуулийн захирал	МАХН
8	Г.Цэрэндаш	Соёлын ажилтан	Хоршооны эзэн	МҮАН
9	Ч.Бадраа	-	Өндөр настан	МҮАН
10	Ж.Хөрөнгөө	-	Малчин	Нам бус
11	С.Давааням	Малын бага эмч	Малын эмч	МАХН
12	Д.Дансранжав	Багш	Багш	Нам бус
13	Б.Пүрэв-Осор	Соёлын ажилтан	Хоршооны эзэн	МАХН
14	Д.Түмэндэмбэрэл	Ня-бо, улс төр судлаач	ХАА-н банкны тооцооны төвийн эрхлэгч	МАХН
15	Ц.Даваажаргал	Малын их эмч	Малын эмч	МАХН
16	Ч.Хүрэлчулуун	-	Малчин	МҮАН
17	С.Юндэндорж	Малын эмч	Компанийн ня-бо	МҮАН
18	Д.Батдэмбэрэл	Малын эмч	Малын эмч	МҮАН
19	Д.Жүгдэрнамжил	-	Малчин	МҮАН
20	П.Банзрагч	Тоо бүртгэгч	Малчин	МАХН
21	Б.Балдандорж	Багш	Багш	МҮАН
22	Д.Түмэнжаргал	Жолооч	Хоршооны эзэн	МҮАН
23	Д.Цэрэндорж	Ня-бо	Хоршооны эзэн	МАХН
24	Б.Алтанхуяг	Малын эмч	МЭҮА-ны дарга	МСДН
25	С.Цогтоо	Механик	ЗДТГ-ын дарга	МАХН

### Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1996-2000 он

2000-2004 онд сумын ИТХ нь бүтэц зохион байгуулалтын хувьд 20 төлөөлөгч, 7 Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон ажиллаж байжээ. ИТХ-ын даргаар Ч.Сандагдорж хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж, нарийн бичгийн даргаар Ц.Батбаяр 1996-1998 онд, С.Данаажав 1998-1999 онд ажиллаж байжээ. Тухайн үед шинэчлэгдсэн ЗЗНДНТУХ-ийн дагуу 1996 оноос ИТХ-ын дарга нь орон тооны ажилтан болж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нь орон тооны бус болсон байна. ИТХ-ын Тэргүүлэгчээр Ч.Сандагдорж, Ц.Батбаяр, Г.Цэрэндаш, С.Данаажав, Д.Түмэндэмбэрэл нар ажиллаж байжээ.

**1996-2000 оны сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:**

№	Тэргүүлэгчдийн овог нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харъяалал
1	Ч.Сандагдорж	Агрономич, Цэргийн удирдлага	ИТХТ-ийн дарга	МАХН
2	Ц.Батбаяр	Багш	Багийн Засаг дарга	МАХН
3	Г.Цэрэндаш	Соёлын ажилтан	Соёлын төвийн эрхлэгч	МУАН
4	С.Данаажав	Малын бага эмч	ХХЭ	Нам бус
5	Д.Түмэндэмбэрэл	Ня-бо, улс төр судлаач	ХАА-н банкны тооцооны төвийн эрхлэгч	МАХН
6	Д.Батхүү	Малын их эмч	Малын эмч	МУАН
7	Ж.Лхагважав	Биолигич	Хичээлийн эрхлэгч	МСДН
8	Б.Шарбанди	Мал зүйч	Сумын Засаг дарга	МАХН
9	Ж.Маналсүрэн	Багш	Сургуулийн захирал	МАХН
10	Б.Чулуунбат	Малын эмч	Компанийн захирал	МАХН
11	Д.Цэрэндорж	Ня-бо	Хоршооны эзэн	МАХН
12	С.Цогтоо	Механик	ЗДТГ-ын дарга	МАХН
13	Ч.Лхагвасүрэн	Ня-бо	Байгаль орчны улсын байцаагч	Нам бус
14	Ц.Даваажаргал	Малын их эмч	Мал зүйч	МАХН
15	Ж.Батбаяр	Гидротехникч	Багийн Засаг дарга	МАХН
16	Б.Бурмаа	Багш	Багш	МУАН
17	Д.Жүгдэрнамжил	-	Малчин	МУАН
18	Д.Түмэнжаргал	Жолооч	Хоршооны эзэн	МУАН
19	Ж.Баянмөнх	Хүний бага эмч	Эх барих бага эмч	МУАН
20	Б.Чулуундаваа	Газар зохион байгуулагч	Газар зохион байгуулагч	МУАН

**Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал**

2000-2004 он

2000-2004 онд сумын ИТХ нь бүтэц зохион байгуулалтын хувьд 20 төлөөлөгч, 7 Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон ажиллаж байжээ. ИТХ-ын даргаар Ж.Маналсүрэн, нарийн бичгийн даргаар Д.Түмэндэмбэрэл нар сонгогдон ажилласан байна. 2004 оны 4 сараас ИТХ-д шинээр дотоод ажил хариуцсан ажлын орон тоо нэмэгдэж хоёр хүний бүрэлдэхүүнтэй ИТХ-ын Тэргүүлэгчээр Ж.Маналсүрэн, Ц.Батбаяр, Д.Түмэндэмбэрэл, Б.Шарбанди, Ж.Энэбиш, Т.Энхтуяа, Ба. Алтахуяг нар сонгогдон ажиллаж байсан. ИТХ-ын төлөөлөгч Б.Шарбанди, Д.Цэнгэл нар өөр аймаг хот руу шилжсэн тул ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлөгдөж оронд нь нөхөн сонгуулиар Д.Түмэнжаргал, Б.Баясгалан нар ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогджээ.

**2000-2004 оны сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:**

№	Тэргүүлэгчдийн овог нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харъяалал
1	Ж.Маналсүрэн	Багш	ИТХТ-ийн дарга	МАХН
2	Ц.Батбаяр	Багш	Багийн Засаг дарга, Тамгын газрын дарга	МАХН
3	Д.Түмэндэмбэрэл	Ня-бо, улс төр судлаач	ХАА-н банкны тооцооны төвийн эрхлэгч	МАХН
4	Б.Алтанхуяг	Малын эмч	МЭҮА-ны дарга	МСДН
5	Ж.Энэбиш	Нягтлан бодогч	Нийгмийн халамжийн байцаагч	Нам бус
6	Т.Энхтуяа	Нягтлан бодогч	Нийгмийн даатгалын байцаагч	МАХН
7	Б.Шарбанди	Мал зүйч	ХХЭ	МАХН
8	С.Данаажав	Малын бага эмч	Багийн Засаг дарга	Нам бус
9	Ү.Содномпил	Бага ангийн багш	Багш	МАХН
10	П.Банзрагч	Тоо бүртгэгч	Малчин	МАХН
11	Б.Ганзориг	Багш	ХХЭ, Сумын Засаг дарга	МАХН
12	Н.Чулуун	-	ХХЭ	МАХН

13	Д.Цэнгэл	Хүний бага эмч	Э/э-ийн сангийн эрхлэгч	МАХН
14	Ж.Батбаяр	Гидротехникч	Багийн Засаг дарга	МАХН
15	Д.Оюунчимэг	Бага ангийн багш	Багш	МАХН
16	Г.Дашбямба	Малын бага эмч	Малчин	МАХН
17	Д.Даваадорж	Хуульч	ХХЭ	МҮАН
18	Ж.Лхагважав	Биологич	Сургуулийн захирал	МСДН
19	С.Хадбаатар	Улс төр судпаач	ЗДО дарга	МАХН
20	Ц. Нарантуяа	Багш	Багш	МАХН
21	Д.Түмэнжаргал	Жолооч	Хоршооны эзэн	МҮАН
22	Б.Баясгалан	Бэлтгэл судлал	Багийн Засаг дарга	МҮАН

### Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2004-2008 он

2000-2008 онд сумын ИТХ нь бүтэц зохион байгуулалтын хувьд 20 төлөөлөгч, 5-7 Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон ажиллаж байсан. ИТХ-ын даргаар Ц.Батбаяр сонгогдож байжээ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу ИТХ-ын орон бүтцийн чиг үүрэг өөрчлөгдөж, ИТХ-ын ажилтны орон тоо хасагдаж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга орон тоогоор ажиллах болж уг орон тоон дээр ИТХ-ын ажилтнаар ажиллаж байсан Ц.Бямбадорж төрийн албаны болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтаар томилогдон ажиллаж эхэлсэн байна. ИТХ-ын Тэргүүлэгчээр Ц.Батбаяр, Ц.Нарантуяа, Д.Наранцэцэг, Ж.Баянмөнх, Ба.Амаржаргал, Ш.Наранхүү, Б.Алтанхуяг нар сонгогдон ажиллаж байсан. ИТХ-ын төлөөлөгч Ч.Сандагдорж агсны оронд явагдсан нөхөн сонгуулиар Ч.Мөнх-Эрдэнэ ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон байна.

#### 2004-2008 оны сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:

№	Тэргүүлэгчдийн овог нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харъяалал
1	Ц.Батбаяр	Багш	ИТХ-ын дарга	МАХН
2	Ц. Нарантуяа	Багш	Багш	МАХН
3	Т.Энхтуяа	Нягтлан бодогч	Нийгмийн даатгалын байцаагч	МАХН

4	Д.Наранцэцэг	Нягтлан бодогч	ХАА-н банкны ня-бо	МАХН
5	Б.Жаргалсайхан	Байгаль хамгаалагч	Байгаль хамгаалагч	МАХН
6	Ж.Лхагважав	Биологич	Сургуулийн захирал	АН
7	Б.Амаржаргал	Бага ангийн багш	Багш	ЭОН
8	Ш.Наранхүү	Малын бага эмч	Малын эмч	АН
9	Б.Алтанхуяг	Малын эмч	МЭҮА-ны дарга	АН
10	Ч.Сандагдорж	Агрономич, Цэргийн удирдлага	Өндөр насны тэтгэвэрт	МАХН
11	Б.Ганзориг	Багш	ХХЭ, Сумын Засаг дарга	МАХН
12	А.Батсайхан	-	Малчин	ЭОН
13	Ш.Нацагдорж	Агрономич, Улс төр судлал	Багийн Засаг дарга	АН
14	Ц.Анхбаяр	Ня-бо, хүнсний технологи	ХААН банкны салбарын эрхлэгч	МАХН
15	Ч.Гунгаажанцан	Жолооч	ХХЭ	АН
16	Б.Дашдондог	Жолооч, механик	Багийн Засаг дарга	МАХН
17	Жа.Лхагважав	Мужаан	ЗДТГ-ын нярав	МАХН
18	Б.Доржгочоо	Жолооч	ХХЭ	Нам бус
19	Би.Амаржаргал	Жолооч	ХХЭ	АН
20	Ж.Баянмөнх	Хүний бага эмч	Эх барих бага эмч	АН
21	Ч.Мөнх-Эрдэнэ	Жолооч	ХХЭ	Нам бус



Сумын ИТХ-ын төлөөлөгчид /2004-2008 он

### Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2008-2012 он

2008-2012 онд сумын ИТХ нь Орон нутгийн сонгуулийн шинэчилсэн хуулийн дагуу бүтэц зохион байгуулалтын хувьд 21 төлөөлөгч, 7 Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгогджээ. ИТХ-ын даргаар Б.Чулуундаваа сонгогдон ажилласан байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Ц.Бямбадорж ажиллаж, ИТХ-ын Тэргүүлэгчээр Б.Чулуундаваа, Д.Мэнджаргал, Ба.Алтанхуяг, Ш.Наранхүү, Д.Мягмармаа, Д.Оюунчимэг, Д.Баасанхүү нар сонгогдон ажиллаж байв.

#### 2008-2012 оны сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:

№	Тэргүүлэгчдийн овог нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харъяалал
1	Б.Чулуундаваа	Газар зохион байгуулагч	ИТХ-ын дарга	АН
2	Д.Мэнджаргал	Хүний их эмч	Хүний их эмч	АН
3	Б.Алтахуяг	Малын их эмч	Торц мөрөн ББН-ийн эзэн	АН
4	Ш.Наранхүү	Малын бага эмч	Ганболор ББН-ийн эзэн	АН

5	Д.Баасанхүү	Жолооч	ХХЭ	МАХН
6	Д.Мягмармаа	Багш	Багш	МАХН
7	Д.Оюунчимэг	Багш	Бага ангийн багш	МАХН
8	Т.Энхтуяа	Нягтлан бодогч	Сумын Засаг дарга	МАХН
9	Ш.Нацагдорж	Агрономич, Улс төр судлал	ХХЭ	АН
10	М.Цэрэнбадам	Сувилагч	Сувилагч	АН
11	Я.Мөнх-Эрдэнэ	Сантехникч	Цаг уурын ажиглагч	АН
12	Д.Зоригоо	Жолооч	Жуулчин компанийн ажилтан	МАХН
13	Ч.Цэдэвсүрэн	Ня-бо	Засаг даргын орлогч дарга	МАХН
14	Ж.Батбаяр	Гидротехникч	Багийн ИНХ-ын дарга	МАХН
15	Ч.Батхүү	Жолооч	Малчин	АН
16	Ч.Цэцэгмаа	Хүний их эмч	Эмнэлэгийн эрхлэгч	АН
17	Р.Цагаанхүү	Сувилагч	Сувилагч	АН
18	Ц.Нямханд	Малын их эмч	Далай гүн ББН-ийн эзэн	АН
19	Ш.Гэрэлсайхан	Багш	Багш	МАХН
20	Л.Нэргүй	Жолооч	Малчин	АН
21	Бя.Алтанхуяг	Эдийн засагч, инженер	ХХЭ	АН

### Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2012-2016 он

2012-2016 онд сумын ИТХ нь бүтэц зохион байгуулалтын хувьд 21 төлөөлөгч, 7 тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнтэйгээр сонгогдон ажиллаж байна. Орон нутгийн сонгуулийн шинэчилсэн хуулийн дагуу 21 төлөөлөгчөөс 14 нь сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нэр дэвшин өрсөлдөн сонгогдож, 7 төлөөлөгч нам эвслийн жагсаалтаар сонгогдсон. Үүнд сумын АН-

аас Б.Чулуундаваа, Ш.Нацагдорж, Л.Нэргүй, Д.Бат-Эрдэнэ, МАН-аас Ц.Батбаяр, Д.Түмэндэмбэрэл, Л.Дугаржав нар тухайн нам эвслийн авсан саналын суудлын тоогоор намын жагсаалтаар ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон байна. ИТХ-ын даргаар Г.Бямбасүрэн сонгогдон ажиллаж байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Ц.Бямбадорж ажиллаж, ИТХ-ын Тэргүүлэгчээр Г.Бямбасүрэн, Л.Бат-Эрдэнэ, М.Энхбат, Ш.Нацагдорж, Б.Алтанхуяг, Н.Бямбачулуун, Ц.Батбаяр нар сонгогдон ажиллаж байсан бөгөөд Ц.Батбаяр агсны оронд тус намаас авсан суудлын тоогоор Ш.Дашдэлгэр ИТХ-ын төлөөлөгчөөр нөхөн сонгогдсон. Мөн ИТХ-ын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж Н.Бямбачулуун, Ц.Батбаяр нарын оронд тэргүүлэгчээр Ч.Цэдэвсүрэн, Д.Түмэндэмбэрэл нар сонгогдон ажиллаж байна.

**ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ БАЙНГЫН ХОРООД**



Нутгийн удирдлага, нийгмийн дэг журам, иргэдийн эрх ашгийг хамгаалах хороо



Төсөв санхүү, хяналт шалгалтын хороо ТТБ



Хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлалын хороо



Нийгмийн бодлого, хөгжлийн хороо

**2012-2016 оны сумын ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:**

№	Тэргүүлэгчдийн овог нэр	Мэргэжил	Эрхэлж байсан албан тушаал	Сонгогдсон намын харьяалал
1	Г.Бямбасүрэн	Банкны эдийн засагч	ИТХ-ын дарга	МАН
2	М.Энхбат	Ня-бо, Сантехникийн багш	Цэцэрлэгийн ня-бо	МАН
3	Л.Бат-Эрдэнэ	Эдийн засагч	ХААН банкны тооцооны төвийн эрхлэгч	МАН
4	Бя.Алтанхуяг	Эдийн засагч, инженер	Ус цаг уурын харуул	АН
5	Н.Бямбачулуун	Түүх, солонгос хэлний багш орчуулагч	Багийн Засаг дарга	МАН
6	Ч.Цэдэвсүрэн	Ня-бо	Засаг даргын орлогч дарга	МАН
7	Д.Сайнбаяр	Мал зүйч, төрийн удирдлага, эрх зүйч	Сумын АН-ын дэд дарга	
8	Д.Нямсүрэн	Жолооч	Хур бороо хоршооны эзэн	МАН
9	Б.Дашдондог	Жолооч, механик	Малчин	МАН
10	Д.Баасанхүү	Жолооч	ХХЭ	МАН
11	Б.Доржгочоо	Жолооч	ХХЭ	МАН
12	Ч.Батхүү	Жолооч	Малчин	АН
13	Ц.Нямханд	Малын их эмч	Далай гүн ББН-ийн эзэн, ИНХ-ын дарга	МАН
14	Б.Дэлгэрсайхан	Жолооч	Донхор булаг ХХК-ний захирал	АН
15	Ц.Батбаяр	Багш, улс төр судлаач	Сумын МАН-ын дэд дарга	МАН
16	Д.Түмэндэмбэрэл	Ня-бо, улс төр судлаач	Ахмадын хорооны дарга	МАН
17	Л.Дугаражав	Бичээч	Өндөр настан	МАН
18	Ш.Нацагдорж	Агрономич, Улс төр судлал	Сумын АН-ын дэд дарга	АН
19	Б.Чулуундаваа	Газар зохион байгуулагч	Багийн ИНХ-ын дарга	АН
20	Л.Нэргүй	Жолооч	Малчин	АН
21	Д.Бат-Эрдэнэ	Жолооч	Малчин	АН
22	Ш.Дашдэлгэр	Жолооч	Малчин	МАН



ИТХ-ын төлөөлөгчид /2012-2016 он/

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Тус сумын Засаг захиргааны байгууллага нь 1931-1952 онд Сумын захиргаа, 1952-1960 онд Хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа, 1960 – 1990 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа, 1990- 1992 онд Ардын хурлын гүйцэтгэх хороо, 1992 оноос сумын Засаг даргын тамгын газар гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн.

1991 оны дөрөвдүгээр сарын 5-ны өдөр сумын АДХ-ын 16 удаагийн сонгуулийн 3-р чуулганыг хуралдуулж сумын Ардын хурлын тэргүүлэгчдийн даргаар Л.Цэдэнсодномыг сонгов. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль батлагдан гарч хуулийн дагуу АДХ-ын гүйцэтгэх захиргааг татан буулгаж төрийн захиргааны байгууллагыг шинээр зохион байгуулахаар орон нутгийн сонгуулийг явуулж байжээ. Анхан шатны нэгжээ баг байхаар зохион байгуулж, тус суманд таванбаг байгуулагджээ. Баг бүр иргэдийн нийтийн хурлаар багийн засаг даргад нэр дэвшүүлж, олонхийн санал авсан хүнийг багийн засаг даргаар сонгуулахаар нэрийг нь сумын засаг даргад өргөн барьснаар 1992 оны арван нэгдүгээр сарын сонгуулиар 1-р багийн засаг даргаар Ж.Дорждаян, 2-р багийн засаг даргаар Д.Наранбаатар, 3-р багийн засаг даргаар Ж.Батбаяр, 4-р багийн засаг даргаар Л.Цэгмид, 5-р багийн засаг даргаар Н.Чулуун нар сонгогдож байжээ. Баг бүр сумын хурлын төлөөлөгчөөр сонгох хүмүүсийнхээ нэрийг бүх нийтийн хурлаараа дэвшүүлж, олонхийн санал авсан таван хүнийг сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгожээ. Иргэдийн төлөөлөгчдийн анхдугаар хуралдаанаар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн даргаар Д.Түмэндэмбэрэл, орон тооны нарийн бичгийн даргаар Ц.Батбаяр,



тэргүүлэгч гишүүнээр С.Давааням, Д.Бат-Эрдэнэ, Ч.Доржпалам нарыг сонгож сумын засаг даргад Лосолын Цэдэнсодномын нэрийг дэвшүүлж, аймгийн засаг даргад өргөн барьснаар сумын засаг даргаар батлагдсан юм. Шинээр томилогдсон засаг дарга тамгын газрыг 14 орон тоотойгоор зохион байгуулж, тамгын газрын даргаар С.Цогт, засаг даргын орлогчоор Ч.Жаргалсайхан нарыг томилжээ. Сумын татварын албан улсын байцаагч Ш.Хүрэлбаатар, хөдөлмөр, нийгмийн даатгалын байцаагчаар Т.Энхтуяа нар ажиллаж байв. Сумын даатгалын алба нь сумын гүйцэтгэх захиргааны санхүү төсвийн бүрэлдэхүүнд байснаа 1991 онд аймагт байгуулагдсан Монгол даатгал компанийн салбар болж орон тооны бус төлөөлөгчөөр Ч.Жаргалсайхан ажиллаж байсан бөгөөд 1994 оноос даатгалын алба болон өөрчлөгдөж, Ч.Сүмбэрэлдорж ажиллаж байлаа. Байгаль орчны байцаагчаар Ч.Лхагвасүрэн, соёл олон түмэн хүн ам зүйн асуудал эрхэлсэн байцаагчаар Ж.Болдбаатар нар ажиллаж байв. 1996 онд Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт орж, 1996 оны сонгуулийн дараа сумын засаг даргад Б.Шарбандийг нэр дэвшүүлж улмаар аймгийн Засаг даргад уламжилснаар томилогдсон байна. 2000 оны сонгуулийн дараа сумын засаг даргад Б.Ганзоригийн нэрийг дэвшүүлж, Засаг даргаар сонгожээ. ЗДТГ-ын бүтцэд Засаг дарга



Б.Ганзориг, ЗДТГ-ын дарга Д.Сайнбаяр, Засаг даргын орлогч Т.Энхтуяа, түүний шууд удирдлагад байдаг төрийн сангийн ажилтан Б.Уранмандал, нярав Ж.Лхагважав, татварын улсын байцаагч Х.Даваачулуун, нийгмийн даатгалын байцаагч С.Сэргэлэн, хэсгийн төлөөлөгч Б.Нямрэнчин, нийгмийн халамжийн байцаагч Л.Отгонжаргал, БОХ-ын улсын байцаагч М.Батмөнх, туслах түшмэл Ч.Жаргалсайхан, МЭҮА-ын байцаагч Т.Тэрбиш, аж ахуй үйлчилгээ, архив, бичиг хэргийн эрхлэгч Л.Амарбат, жолооч Б.Ганбат, үйлчлэгч Б.Цэцэгмаа, галч Х.Хадбаатар нар ажиллаж байв. 2008-2012 онд тус сумын Засаг даргаар Т.Энхтуяа томилогдож байлаа. Харин 2012 оны орон нутгийн сонгуулийн дараа сумын Засаг даргаар Б.Ганзориг томилогдон ажиллаж байна.

## ТӨМӨРБУЛАГ СУМАНД ЗАСАГ ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮС



### ЧИМИДДОРЖИЙН САНДАГДОРЖ

Агрономич мэргэжилтэй, аймгийн цэргийн хэлтэст офицер, цэргийн хэлтсийн дарга зэрэг хариуцлагатай алба хашиж байсан. Дэд хурандаа цолтой. Цэргийн гавьяаны одон болон ойн медалиудаар шагнагдаж байжээ.



### ЛОСОЛЫН ЦЭДЭНСОДНОМ

Тэрээр 1953 төрсөн. 1977 онд МУИС-ийг төгсч, математикч мэргэжил эзэмшсэн. 1977-1991 онд Геологи уул уурхайн яамны томилолтоор Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрт томилогдон очиж инженер, ахлах инженер, боловсон хүчний хэлтсийн даргаар ажиллаж байсан бөгөөд 1991-1995 онд Төмөрбулаг сумын Засаг даргаар, 1995 оноос Орхон аймаг дахь Монгол Швейцарийн хамтарсан “Эрдэнэт ноолуур” ХХК-ийн захирлын алба хашиж байна. Тэрбээр 1976 онд оюутан байхдаа “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдаж байжээ. Л.Цэдэнсодном нь 1982 онд аймгийн арслан цол хүртэж байжээ.




### Б.ШАРБАНДИ

Бямбажав овогтой Шарбанди нь 1950 онд Төмөрбулаг сумын “Гангын ам” гэдэг газар төрсөн. Мөрөн 10-н жилийн дунд сургуульд 1960-1970 онд, ХААДС-ийг 1971-1975 онд суралцан төгссөн. 1975-1981 онд Их-Уул, 1981-1986 онд Төмөрбулаг суманд ерөнхий мал зүйч, сум нэгдлийн даргаар ажиллаж

байгаад 1986-1988 онд НДС-дсуралцан төгсөөд 1988-1991 онд Жаргалант сум нэгдлийн дарга, 1991-1995 онд Давшилт нэгдлийн дарга, “Давшилт” компанийн захирлаар, 1995-2000 онд Төмөрбулаг сумын Засаг дарга, 2001-2010 онд Үйлдвэр худалдааны “Говь компани” “Говь жуулчин”, “Рашаан” амралтын дарга, “Говь компаний түүхий эд бэлтгэн нийлүүлэх төлөөлөгчөөр ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан. Төмөрбулаг сумын хар ямааг 1982 онд ангилах ажилд оролцож, 1,2-р ангийн шилмэл ямааг 2-р бригадад, бусад ямааг 1,3-р бригадад шилжүүлж суурь зохион байгуулалтыг анх удаа Ц.Мишигдорж тэргүүтэй мал аж ахуйн мэргэжилтнүүдтэй хамтран хийжээ. Ингэж нутгийн мал сүрэг түүний дотор хар ямааг бие бялдар, амьдын жин, ноолуур, зүсний байдлаар ангилан дотор нь үржүүлэх ажлыг анх удаа эхлүүлсэн. 1996 оны 12 сарын 14-ны ХААҮЯ-ны сайдын А/70 дугаар тушаалаар Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд үржүүлж байгаа ноолуур махны хэвшлийн нутгийн шилмэл ямааг “Эрчим” омгоор баталсан юм. Тэрээр ЗГ-ын жуух бичиг, ХАА-н тэргүүний ажилтан, Үйлдвэр худалдааны тэргүүний ажилтан, Ардын хувьсгалын 60,70,80,90-н жилийн ойн медалиар шагнагдсан.

### Т.ЭНХТУЯА 2008-2012 ОН

Т.Энхтуяа Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Засаг даргаар томилогдон, 2008-2012 онд сумын Засаг даргаар ажиллаж байсан. Т.Энхтуяа 1998 онд УНДЕГ-ын баярын бичиг, 2005 онд бүртгэл статистикийн тэргүүний ажилтан, 2006 онд Төрийн сангийн шилдэг төлөөлөгч, 2007 онд АЗДТГ, Монголын эмэгтэйчүүдийн академаас “Шилдэг удирдагч” цом өргөмжлөл, Хөдөлмөрийн хүндэт тэмдэг, 2010 онд Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулж байсан.



### БАТ-ОЧИРЫН ГАНЗОРИГ



Олзвой овогтой Бат-Очирын Ганзориг нь 1967 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1975-1983 онд тус сумын 8-н жилийн дунд сургуулийг, 1983-1985 онд Шинэ-Идэр сумын 10-н жилийн дунд сургуулийг төгссөн. 1985-1988 онд ардын армийн 107-р анги, Зүүнбаянгийн 126-р дивизд цэргийн алба хаасан. 1988-1989 онд тус суманд байгаль хамгаалагч, цаг уурын албанд ажиллаж байгаад 1989-1994 онд МУИС-ийн Ховд дахь салбар сургуульд элсэн суралцаж, биологи-газарзүйн багш мэргэжлээр төгссөн. 1995-1996 онд 5-р багийн засаг дарга, 1996-2000 онд хувийн хэвшилд ажиллаж байсан. 2000-2008 онд тус сумын Засаг дарга, 2009-2011 онд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ахлах сургуулийн захирал, 2011-2012 онд Хөвгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын орлогч дарга зэрэг ажил албыг хашиж байгаад 2012

оноос тус сумын Засаг даргаар ажиллаж байна.

**Сумын орлогч дарга нар**

- |                   |                  |
|-------------------|------------------|
| 1. Ж.Цэвэгдорж    | 6. Ж.Энэбиш      |
| 2. Ч.Лхагвасүрэн  | 7. Ш.Хүрэлбаатар |
| 3. Г.Нямцэцэг     | 8. Б.Балдандорж  |
| 4. Ч.Жаргалсайхан | 9. Т.Энхтуяа     |
| 5. С.Хадбаатар    | 10. Ч.Цэдэвсүрэн |

**Сумын ЗДТГ-ын дарга нар**

- |                 |                  |
|-----------------|------------------|
| 1. С.Цогтоо     | 5. Маналсүрэн    |
| 2. Г.Цэрэндаш   | 6. Д.Сайнбаяр    |
| 3. Б.Балдандорж | 7. Д.Түмэнжаргал |
| 4. Ц.Батбаяр    | 8. Г.Нямханд     |

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БҮТЭЦ

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, туслах түшмэл, татвар, нийгмийн даатгал, нийгмийн халамж, мал эмнэлэг үржлийн алба, байгаль орчны зэрэг байцаагч нар, төрийн сангийн төлөөлөгч, нягтлан, нярав, хэсгийн төлөөлөгч, үйлчилгээний ажилчидтайгаар төрийн үйлчилгээг ард түмэндээ шударга, зарчимч, ажил хэрэгчээр хүргэж Сумын Засаг дарга болон ИТХ-ын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа хүргэн ажиллаж байна. Сумын Засаг даргын Тамгын газар нь улс төрийн 7, төрийн захиргааны 15, төрийн тусгай 2, төрийн үйлчилгээний 7, гэрээт ажилчин 4, нийтдээ 35 ажилчин албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, ил тод хүргэх ажлыг удирдлага болгон ажиллаж байна. Төрийн албан хаагчдын боловсролын хувьд авч үзвэл нийт ажиллагсдын 22 нь буюу 71 хувь нь дээд, үүнээс тав нь магистрийн зэрэгтэй, нэг буюу 3.5 хувь нь тусгай дунд, найм буюу 25.8 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой байна. Төрийн удирдлагаар мэргэшсэн таван албан хаагч ажиллаж байна.

Ажиллагсдын 94,2 хувь нь орон нутгийн боловсон хүчин ажиллаж байгаагаараа онцлогтой юм. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны албан хаагчид ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ерөнхий болон тусгай шаардлагын дагуу төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн албан хаагчид ажиллаж байна.

1. Засаг дарга Б.Ганзориг  
ЗДТГ-ын дарга Г.Нямханд  
Засаг даргын орлогч Ч.Цэдэвсүрэн  
Төрийн сангийн төлөөлөгч Б.Уранмандал

Нягтлан бодогч А.Гантуяа

Архив, бичиг хэргийн эрхлэгч Л.Амарбат

Татварын байцаагч Х.Даваачулуун, нийгмийн даатгалын байцаагч Б.Болорцэцэг, улсын бүртгэгч Д.Пүрэвдорж, хэсгийн төлөөлөгч Р.Эрдэнэбат, цагдаа Баярсайхан, халамжийн мэргэжилтэн Б.Нямдаваа, нийгмийн ажилтан Д.Өлзийсайхан, БОХ-ын улсын байцаагч Д.Хишигсайхан, байгаль хамгаалагч Б.Жаргалсайхан, ойн ажилтан М.Мягмар, байгаль хамгаалагч Ч.Амаржаргал, жолооч Ц.Нямдорж, нярав Б.Батхишиг, МЭҮТ-ийн дарга Т.Тэрбиш, мэргэжилтэн Б.Алтанцэцэг, дотоод ажил эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн П.Ганчимэг, үйлчлэгч Б.Цэцэгмаа, галч Р.Равдандорж, Х.Хадбаатар, Ц.Лхагвасүрэн нар ажиллаж байна.



**ГАНБОЛДЫН НИЯМХАНД**

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд 1982 онд төрсөн. 1989-1999 онд Төмөрбулаг сумын 10 жилийн сургууль, 1999-2003 онд Хүмүүнлэгийн их сургууль, 2003-2005 онд ХИС-ийн магистрийн сургууль, 2005-2007 онд Удирдлагын академи төгссөн. Аялал жуулчлалын менежер, төрийн удирдлагын менежер аргазүйч мэргэжилтэй. 2003-2008 онуудад Орхон аймгийн Экологи аялал жуулчлалын Маргад дээд сургуульд багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байсан. 2008 оноос одоог хүртэл ЗДТГ-ын даргаар ажиллаж байна. Тэрээр 2005 онд шилдэг илтгэгч багш, 2006 оны сургуулийн шилдэг багшаар шалгарч, 2006 онд Ази номхон далайн орнуудын аялал жуулчлалын эдийн засгийн чуулга уулзалтанд төлөөлөгчөөр оролцож байсан. Аймгийн ЗДТГ-ын баярын бичиг, Их Монгол улс байгуулагдсны 800 жилийн ойн медальтай. 2013 онд төрийн болон төрийн бус байгууллага хамт олныг удирдан сумын мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

**ЧУЛУУН-ЯНЖИНГИЙН ЦЭДЭВСҮРЭН**

Төмөрбулаг суманд 1966 онд төрсөн. 1974-1982 онд Төмөрбулаг сумын ЕБС-ийн 8-р анги төгсөж бүрэн бус дунд, 1983-1984 онд Шинэ-Идэр сумын ЕБС-ийн 10-р анги төгсөж бүрэн дунд, 1984-1989 онд Завхан аймаг дахь Худалдааны техникумын худалдааны нягтлан бодогчийн анги төгсөж, тусгай дунд боловсрол эзэмшиж, 1985-1988 онд АА-д цэргийн алба хаасан. 1989 онд Худалдаа бэлтгэлийн удирдах газрын харъяа Бараа хангамжийн хэлтэст бараа задлан найруулагч, Улаан-Уул сумын ХБА-д ерөнхий ня-бо, Түнэл сумын ХБА-д ня-бо, Аймгийн ЗДТГ-ын харъяа Хүнсний бүтээгдэхүүний



захын ангид ахлах ня-бо, Бүрэн бус хариуцлагатай “Малчин” хоршоонд гутлын бригадын дарга, 2002-2006 онд Төмөрбулаг сумын ХААН банкны 49-р тооцооны төвд нярав, 2006-2008 онд Төмөрбулаг сумын Монгол шуудан банкны теллер, 2008 оноос хойш Төмөрбулаг сумын ЗДТГ-ын Засаг даргын орлогчоор ажиллаж байна.

Сумын ИТХ-ыг сонгох тав дахь удаагийн сонгуулиар 3-р тойргийн ИТХ-ын төлөөлөгчөөр хоёр удаа улиран сонгогдсон. Сумын ИТХ-ын тэргүүлэгч, МАН-ын дэд даргын сонгуульд ажилтай.

2007 онд Монголын ардчилсан социалист залуучуудын холбооны “Алтан од” медаль, Төмөрбулаг сумын “Шилдэг авъяастан” медаль, 2010 онд МУЗН-ийн Тэргүүний залуу алтан медаль, Аймгийн ЗДТГ-ын баярын бичиг, 2011 онд МАН-ын хүндэт тэмдэг, Аймгийн 80 жилийн ойн медаль, 2014 онд “Хөвсгөлийн бахархал” медалиар тус тус шагнагдсан.



**ПҮРЭВДАЛАЙ ГАНЧИМӨГ**

Төмөрбулаг сумын Засаг даргын тамгын газрын дотоод ажил, эрхзүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Пүрэвдалай овогтой Ганчимэг 1989 онд төрсөн. Ам бүл-3. Нөхөр, хүүхдийн хамт амьдардаг. 1997-2007 онд Төмөрбулаг сумын 10-н жилийн ахлах сургууль төгссөн. 2007-2011 онд НУДС-ийг нийгэм-судлал эрхзүйн багш мэргэжлээр төгссөн байна.

**ТӨРИЙН САН, САНХҮҮГИЙН АЛБА**

Сумын санхүүгийн тасаг нь 1977 он хүртэл сум нэгдлийн санхүү



Зүүн гар талаас: Г.Батхүү /ЭМТ-ийн нягтлан бодогч/, А.Гантуяа /ЗДТГ-ын ахлах ня. бо/, Б.Уранмандал /Төрийн сангийн төлөөлөгч/, М.Буяндэлгэр /ЕБС-ийн ерөнхий ня.ба/, Б.Болорцэцэг /НД-ийн байцаагч/, М.Энхбат /СӨБ-ийн ня.бо/, Д.Нямдаваа /Халамжийн мэргэжилтэн/.

нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад 1977 оны нэгдүгээр сард АДХГЗ-ны санхүү тасаг болон шинэчлэгдэж, тасгийн даргыг сумын орлогч Цэвэгдорж давхар гүйцэтгэн, нягтлан бодогчоор Ундармаа, Чимэд-Очир нар ажиллаж байжээ. 1977 оны зургадугаар сараас Ч.Лхагвасүрэн, Мягмаржав, Ундармаа нар нягтлан бодогчоор ажилласан. Ундармаа 1980 он хүртэл ажилласан бөгөөд Ч.Лхагвасүрэн 1980-1982 онд санхүүгийн тасгийн даргаар томилогдож байжээ. Энэ хугацаанд нягтлан бодогчоор Ч.Жаргалсайхан, Сүхээ нар ажилласан байна. Харин 1982 оны есдүгээр сараас санхүү тасгийн дарга-байцаагчаар Ч.Жаргалсайхан, нягтлан бодогчоор М.Буяндэлгэр, 1979-1980, 1983-1985 онуудад Ш.Нямбаатар санхүү тасгийн даргаар ажиллажээ. 1982 оны арваннэгдүгээр сараас Дунгармаа нягтлан бодогчоор ажиллаж байв. 1983-1985 онд З.Цэрэнханд санхүү тасагт ня-бо орон тоон дээр томилогджээ. 1986 оноос санхүүгийн тасагт Ц.Тэгшжаргал М.Буяндэлгэр нар ажиллаж байгаад 1992 оноос засаг захиргааны нэгж өөрчлөгдөн 1991 онд санхүү тасгийн даргаар Л.Энх-Амгалан ажилласан байна. Сумын ЗДТГ бий болоход ЗДТГ-ын нягтлан бодогчоор Ц.Тэгшжаргал, М.Буяндэлгэр нар ажиллаж, Сумын ЗДТГ-ын нягтлан бодогч нь Тамгын газрын нягтлан бодогчийн ажлаас гадна Хүн эмнэлгийн салбар, мал эмнэлэг Соёлын төвийн нягтлан бодогчийн ажлыг давхар гүйцэтгэдэг байжээ.

ЗДТГ-ын ахлах нягтлан бодогчоор

Б.Уранмандал 1993-2007 он

А.Гантуяа 2007- оос одоог хүртэл ажиллаж

2005 оноос Төрийн сангийн тогтолцоо бий болсноор сумын засаг даргын орлогч бөгөөд төрийн сангийн төлөөлөгчөөр Т.Энхтуяа ажиллаж, 2009 оноос сумын төрийн сангийн төлөөлөгчөөр Б.Уранмандал ажиллаж байна.

Суманд 1992 оноос татварын байцаагчын орон тоо шинээр үүсч анхны татварын байцаагчаар Б.Уранмандал ажиллаж байсан бөгөөд татварын байцаагчаар Б.Уранмандал 1992-1993 онуудад, Ш.Хүрэлбаатар 1994-1997 онд, Б.Алтанхуяг 1998-2001 онд тус тус ажиллаж байжээ. 2002 оноос Х.Даваачулуун татварын байцаагчаар томилогдож, одоог хүртэл ажиллаж байна.



**БАДРААГИЙН УРАНМАНДАЛ**

1969 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. 1987 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн дунд сургууль, 1989 онд Санхүү эдийн засгийн техникумыг нягтлан бодогч-эдийн засагч мэргэжлээр, 2004 онд Идэр дээд сургуулийг нягтлан бодогч-бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн. 1989-1991 онд Эг-Үүрийн САА-д тооцооны ня-бо, 1991-1992 онд Төмөрбулаг суманд багийн тоо бүртгэгч-татварын байцаагчаар, 1992-1993 онд сумын татварын байцаагчаар 1993-2007 онд тус сумын ЗДТГ-ын ахлах ня-бо-гоор, 2007 оноос 2008 онд сумын нийгмийн ажилтнаар, 2009 оноос Төмөрбулаг сумын Төрийн сангийн төлөөлөгчөөр

ажиллаж байна. Тэрээр улсад 25 жил, өөрийн сумандаа санхүүгийн ажлыг 23 жил хашиж байгаа бөгөөд 2005 онд МЗХ-ны “Тэргүүний ажилтан залуу” алтан медаль, 2006 онд ИМУБ-ны 800 жилийн ойн хүндэт медаль, 2007 онд Сангийн Яамны жуух бичиг, 2011 онд “Санхүү-банкны тэргүүний ажилтан” цол, тэмдэг, Сангийн яамны 100 жилийн хүндэт тэмдгээр тус тус шагнагдсан байна..

**МАГВАНЫ БУЯНДЭЛГЭР**

Төмөрбулаг сумын Дөшийн гол хэмээх газар 1961 оны хоёрдугаар сарын 19-нд төрсөн. Санхүү эдийн засгийн техникум, Эдийн засгийн коллежи, Далай коллежид суралцаж, төгссөн. Мөрөн суманд Төвлөрсөн нягтлан бодох ангид ажиллаж байгаад Санхүүгийн хэлтсийн томилолтоор Төмөрбулаг сумын санхүүгийн тасгийн нягтлан бодогчоор томилогдсон. Тэрээр 1999 онд Аймгийн засаг даргийн жуух бичиг, 2001 онд Сангийн яамны жуух бичиг, 2006 онд Санхүү банкны тэргүүний ажилтан, 2011 Улаан загалмайн тэргүүний ажилтан зэрэг шагнал хүртэж байсан.



**ЖАНЦАНГИЙН ЛХАГВАЖАВ**

Их мэргэд овогт Жанцангийн Лхагважав 1960 онд төрсөн. “Давшилт” нэгдэлд малчнаар ажиллаж байгаад Улаанбаатар хотын 027-р ангид цэргийн алба хаасан. Тэрээр 1982-1985 онд Худалдаа бэлтгэлийн ангид түүхий эдийн туслах, Үйлдвэр бригадад өрлөгчин, Ерөнхий боловсролын сургуульд Хүнсний нярав, 2002-2004 онд 1-р багийн засаг дарга

2005-2012 онд ЗДТГ-т няраваар ажиллаж байжээ.

Ж.Лхагважав улс нийгэм төрийн байгууллагад тасралтгүй 34 жил, тэр дундаа санхүүгийн салбарт 20 жил ажилласан байна.



**ЛУВСАНБАЛДАНГИЙН МАГНАЙБАЯР**

Лувсанбалдан овогтой Магнайбаяр нь 1929 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын 2-р багийн нутаг Хавчуугийн ам гэдэг газар төрсөн. Тэрээр сумынхаа бага сургуулийг үүсгэн байгуулахад анхны сурагчаар суралцаж бага сургуулийг дүүргэжээ. 1947-1950 онд цэргийн алба хааж 1951 онд УБ хотод Нягтлан бодох бүртгэлийн сургуульд суралцаж төгссөн. 1951-1968 онд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын МАА-н станцад нягтлан бодогчоор, 1968-1974 онд Төмөрбулаг сумын 2-р бригадад тоо бүртгэгчээр, 1974-1989 онд тус сумын “Давшилт” нэгдэлд нягтлан бодогчоор, 1989-1990 онд сумын санхүүгийн тасагт сургуулийн нягтлан бодогчоор, 1991-1994 онд Төмөрбулаг



сумын “Таван-Эрдэнэ” хоршоололд нягтлан бодогчоор тус тус ажиллаж улс нийгэмдээ тасралтгүй 42 жил хөдөлмөрлөжээ.

**ОВОГ.....АЛТАНХУЯГ**

1950 онд Төмөрбулаг суманд төрж 1960-1968 онд ЕБС-д суралцаж төгссөн. 1970-1973 онд Улаанбаатар хотод Санхүү Эдийн Засгийн техникумд төсвийн нягтлан бодогчийн ангид суралцаж төгсөөд 1973-1990 онуудад Ардын боловсролын хэлтэс, Эрүүлийн хамгаалах газруудад ахлах нягтлан бодогчийн ажлыг гүйцэтгэж байв. 1990-1995 онуудад Төмөрбулаг сумын “Саруул зам” ХХК-д ерөнхийн нягтлан бодогчоор ажиллаж байгаад 1995-2010 онд хүртэл Хувийн хэвшилд үйлдвэр аж ахуйн газарт нягтлан бодогч хийсэн. Банк Санхүүгийн тэргүүний ажилтан, Хөвсгөл аймгийн Тэргүүний ажилтан цол тэмдэг, Сангийн яамны хүндэт медаль, Ардын хувьсгалын 70, 80, 90 жилийн ойн медалиудаар шагнагдаж байсан

**ЧУЛУУНЫ ЖАРГАЛСАЙХАН**

1950 онд төрсөн.Төмөрбулаг сумын АДХГЗ-ны санхүүгийн тасгийн нягтлан бодогч, тасгийн дарга, Засаг даргын орлогч, багийн засаг дарга зэрэг албыг хашиж, “Баядын булаг” хоршоонд нягтлан бодогчоор ажиллаж байсан. Тэрээр 38 жил улсад ажилласан ахмад туршлагатай санхүүчдын нэг байсан бөгөөд Сангийн яамны хүндэт жуух бичиг, Санхүү-банкны тэргүүний тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдаж байсан байна.

**ЧОЙЖООГИЙН ЛХАГВАСҮРЭН**

Ч.Лхагвасүрэн нь Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд.1971-1974 онд цэргийн алба хааж,1974-1977 онд сумын эмнэлэгт аж ахуй,1977-2007 онд сумын захиргаанд санхүү тасгийн нягтлан бодогч,санхүүгийн тасгийн дарга,захиргааны орлогч дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч зэрэг ажлуудыг хариуцан 30 гаруй жил ажиллах хугацаандаа Ардын хувьсгалын 60,70,80 –н жилийн ойн медаль,Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр,Монгол улсын Засгийн



газрын хүндэт жуух бичгээр тус тус шагнагдсан.

**АЛТАНЦЭЦЭГИЙН ГАНТУЯА**

Төмөрбулаг суманд 1983 онд төрсөн. 2001 онд “Тэнгэр” дээд сургуульд элсэн суралцаж, 2005 онд төгсөж ирсэн.Тэрээр Төмөрбулаг сумын ЗДТГ-н нягтлан бодогчоор 2007 оноос эхлэн ажиллаж байна. 2012 онд Сангийн яамны 100 жилийн ойн хүндэт тэмдгээр шагнагдсан.





*Зүүн гар талаас: Улсын бүртгэгч Д.Пүрэвдорж, НД-ын байцаагч Б.Болорцэцэг, МАХЦҮХУ-ын байцаагч Д.Алтанцэцэг, Т.Тэрбиш, БОХ-ын улсын байцаагч Д.Хишигсайхан*



**Засаг даргын тамгын газрын үйлчилгээний ажилтнууд:  
Ц.Лхагвасүрэн, Ц.Хадбаатар, Э.Цэцэгмаа, Р.Равдандорж,  
Б.Батхишиг, Т.Төмөрбаатар, Ц.Нямдорж.**



*Багийн засаг дарга нар: 1-р багийн засаг дарга Ш.Наранхүү, 5-р багийн засаг дарга Ц.Эрдэнэбат, 3-р багийн засаг дарга Л.Батсайхан, 2-р багийн засаг дарга Н.Бямбачулуун, 4-р багийн засаг дарга Д.Одбаяр.*



*Засаг даргын тамгын газрын хамт олон. 2014.07.11*

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН ТАТВАРЫН АЛБА

Төмөрбулаг суманд 1991 оноос татварын байцаагчийн орон тоо



шинээр үүсч тухайн үедээ 1-5-р багуудад тус бүр нэг байцаагч ажиллаж байжээ. Тухайн үед 1-р багийн татварын байцаагчаар Ш.Нацагдорж, 2-р багийн байцаагчаар С.Ёндонжамц 3-р багийн байцаагчаар С.Гомболүдэв 4-р багийн байцаагчаар Д.Батдэмбэрэл 5-р багийн байцаагчаар Б.Уранмандал нар ажиллаж байв. 1992 онд татварын



алба зохион байгуулалтын өөрчлөлтөнд орж, татварын байцаагчаар Б.Уранмандал ажиллаж байжээ.

Тус сумын татварын байцаагчаар

- Б.Уранмандал 1992-1993
- Ш.Хүрэлбаатар 1994-1997
- Б.Алтанхуяг 1998-2001 онуудад тус тус ажиллаж байжээ.

### Х.ДАВААЧУЛУУН

Х.Даваачулуун 2002 оноос одоог хүртэл 13 дахь жилдээ Төмөрбулаг сумын татварын байцаагчаар ажиллаж байна. Тэрээр УТЕГ болон Аймаг, сумын Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд заасан үүрэг даалгавар болон татварын орлого, төлөвлөгөөг биелүүлэн ажилладаг. Х.Даваачулуун нь 1977 онд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл суманд төрсөн. 1995 онд 10 жилийн дунд сургууль, 1999 онд УБ хотод СЭЗДС-ийг нягтлан бодогч-эдийн засагч мэргэжлээр, 2012 онд Удирдлагын академийг төрийн захиргаа удирдлагын менежер, 2013 онд МҮИС-ийг хууль зүйн ухааны магистр зэрэгтэй төгссөн. 2000-2001 онд Төмөрбулаг суманд төслийн ня-бо, 2001-2002 онд халамжийн байцаагчаар, 2002 оноос татварын байцаагчаар ажиллаж байна.



УТЕГ-ын “Жуух”, Сангийн яамны “Жуух”, АСЗХ-ны “Алтан од”, МЭХ-ны 90 жилийн ойн медалиар шагнагдсан.

### Төмөрбулаг сумын 2010-2013 оны орлогын төлөвлөгөө биелэлт

Орлогын төрөл	2009			2010			2011			2012			2013		
	Төлөв-Төлөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөв-Төлөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөв-Төлөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөв-Төлөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөв-Төлөө	Гүйцэтгэл	Хувь
Патент ОТБТБЭУ-ний татвар	850.0	972.9	114%	687.0	787.5	115%	980.0	1066.1	109%	1250.0	1290.3	103%	1250.0	1263.4	120%
Хувяараа аж ахуй эрхэлсэний	200.0	205.0	103%				0	0	0%	0	0	0%	500.0	550.0	145%
Мал бүхий иргэний орлогын татвар	21165.6	8356.1	39%	0	1504.5	0%	0	1069.4	0%	500.0	963.3	192%	0	460.3	0%
Хувяараа бараа материал болгосний орлого	0	3165.6	0	0	1113.5	0%	0	602.6	0%	1701.8	890.8	52%	2000.0	8025.2	401%
Бууны албан татвар	456.0	316.0	69%	472.0	480.0	102%	472.0	472.0	100%	472.0	254.0	54%	500.0	518.0	104%
АА-ийн нөөц аш-ны хураамж	0	475.2	0	86.0	1419.3	1650%	86.0	1534.6	1783%	1300.0	2507.9	193%	2347.9	2000.0	85%
Газрыг дуудлагаар худалдсаны	0	0.0	0	0	0	0	0	0	0	0	4392.0	0%	0	0	0%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	75.0	162.0	216%	0	0	0%	180.0	245.0	136%	110.0	110.0	100%	670.0	670.0	100%
Улсын тэмдэгийн хураамж	800.0	561.0	70%	1220.0	1221.4	100%	1100.0	1844.9	167%	1800.0	1869.2	103%	2150.0	1321.1	61%
Ус рашаан ашигласны төлбөр	75.0	0.0	0	80.0	80.0	100%	85.0	97.0	114%	180.0	180.3	100%	110.0	125.0	113%
Ургамал ашигласны төлбөр	0	220.0	0	200.0	200.0	100%	200.0	200.0	100%	200.0	200.0	100%	410.0	410.0	100%
Ойн гоожин	11390.0	14933.6	131%	13916.5	13951.3	100%	15180.0	19291.9	127%	20000.0	20527.7	103%	22565.0	35296.4	156%
Хүү торгуулийн орлого	1600.0	2512.1	157%	1600.0	1841.7	115%	2206.7	3819.1	173%	3750.0	6269.9	167%	4000.0	6438.9	161%
Ул хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0%	1100.0	475.0	43%
<b>Орон нутгийн орлогын дүн:</b>	<b>36611.6</b>	<b>31879.5</b>	<b>87%</b>	<b>18261.5</b>	<b>22599.2</b>	<b>124%</b>	<b>20489.7</b>	<b>30242.6</b>	<b>146%</b>	<b>31263.8</b>	<b>39455.4</b>	<b>126%</b>	<b>37602.9</b>	<b>57553.3</b>	<b>153%</b>
Суутган -1	30956.7	35772.5	115%	32000.0	35342.3	110%	45500.0	47245.2	104%	59735.1	72351.8	121%	60000.0	81972.3	137%
НӨАТ	0.0	0.0	0	720.0	0	0%	600.0	157.5	26%	800.0	1225.0	153%	1690.0	1194.7	71%
АТӨЯХ-ийн татвар	3708.0	3967.2	107%	4054.7	3968.1	98%	4927.1	5617.5	114%	6074.1	6321.0	104%	6074.1	7438.7	122%
Агаарын бохирдлын төлбөр	0	0	0	0	0	0%	0	0	0%	920.0	798.2	87%	750.0	1041.7	139%
Газрын төлбөр	600.0	692.8	115%	494.0	846.7	171%	600.0	1040.0	173%	650.0	631.1	97%	1000.0	1000.1	100%
ААН-ийн татвар	100.0	147.7	147%	200.0	265.1	132%	200.0	436.5	218%	300.0	816.2	272%	840.0	890.1	106%
Ул хөдлөх хөрөнгийн татвар	74.4	561.0	758%	140.0	466.4	333%	672.0	672.0	100%	800.0	808.0	100%	900.0	1000.0	111%
<b>Төлөрүүлэх орлогын дүн:</b>	<b>35389.1</b>	<b>41141.2</b>	<b>116%</b>	<b>37608.7</b>	<b>40888.6</b>	<b>108%</b>	<b>52499.1</b>	<b>55168.7</b>	<b>105%</b>	<b>69279.2</b>	<b>82951.3</b>	<b>120%</b>	<b>71254.1</b>	<b>94537.6</b>	<b>132%</b>
<b>Нийт орлого</b>	<b>72000.7</b>	<b>73020.7</b>	<b>101%</b>	<b>58870.2</b>	<b>63487.8</b>	<b>113%</b>	<b>72988.8</b>	<b>85411.3</b>	<b>117%</b>	<b>100543.0</b>	<b>122406.7</b>	<b>121%</b>	<b>108857.0</b>	<b>152091.1</b>	<b>139%</b>

Төмөрбулаг сумын татварын алба нь 1991 онд байгуулагдсан. Жил бүр татварын орлого нэр төрлөөр 2010-2013 оны байдлаар 101-139 хувиар биелж байна.

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН АЛБА

Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1942 оны нэгдүгээр сарын 22-ны өдөр хуралдсан хоёрдугаар хурлын тогтоолоор “Монгол улын дотор дагаж шийтгүүлэх нийгмийн аюулаас хамгаалах тухай дүрэм” –ийг баталснаар өнөөгийн нийгмийн хамгааллын түүх эхэлжээ. МҮЭ-ийн Төв зөвлөлийн тэргүүлэгчдийн 1942 оны дөрөвдүгээр сарын 28-ны өдрийн 27 дугаар хуралдааны тогтоолоор аймгуудын ҮЭ-ийн зөвлөлд Нийгмийг аюулаас хамгаалах хэлтэс нэртэйгээр анх үүсгэн байгуулагдаж, Нийгмийг аюулаас хамгаалах дүрэм-ийг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 1960 оноос Нийгмийн даатгалын хэлтэс болж зохион байгуулагдсан байна. Нийгмийн даатгалын хөрөнгөөс тэтгэмж олгох дүрмийг 1960 оны тавдугаар сарын 17-ны өдрийн 238 дугаар тогтоолоор баталжээ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 124-р тогтоолыг үндэслэн Аймгийн АДХГЗ-ны даргын 1974 оны 7 дугаар сарын 29-ний 119 дүгээр захирамжаар Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс байгуулагдсан байна. Төмөрбулаг сумын Нийгмийн даатгалын алба нь 1986 оноос эхлэсэн түүхтэй билээ. Тус суманд 1986 онд Б.Лувсандорж Тэтгэврийн байцаагчаар ажиллаж байсан ба улсаас олгох олон хүүхэдтэй эхийн тэтгэвэр, өндөр насны тэтгэмж тогтоох, олгох ажил, тухайн үеийн аймгийн АДХ-ийн гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэст харьяалагдаж байжээ. Аймгийн Засаг даргын 1993 оны 130, 134-р захирамжаар Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтсийг аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгэм хангамжийн хэлтэс нэртэйгээр өөрчлөн байгуулж, улмаар тус сумын Хөдөлмөр нийгэм хангамжийн байцаагчаар 1991-1993 онд Ц.Даваажаргал, 1993 оны 11 сараас 2001 оны 11 сар хүртэл Т.Энхтуяа нар ажиллаж байлаа. Энэ цаг үед Нийгмийн даатгалын багц хуулийг 1995 оноос хэрэгжүүлж эхлэхэд гол ажил нь шинээр батлагдсан нийгмийн даатгалын хууь тогтоомжийг сумынхаа бүх аж ахуй нэгж, байгуулага, иргэдэд таниулж, нийгмийн даатгалд хамруулах явдал байсан юм. 2001 оны арван хоёрдугаар сараас 2006 он дуустал С.Сэргэлэн, 2007 оноос 2010 оны арван нэгэн сар хүртэл Б.Хүрэлбаатар, 2010 оны 11 сараас Б.Болорцэцэг нар нийгмийн даатгалын байцаагчаар ажиллаж байна.

## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тус сумын иргэний бүртгэл нь хуучин ЗДТГ-т шууд харьяалагдаж байсан бол 2011 оноос эхлэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт шилжин босоо удирдлагатай болжээ. Тус суманд 2010 онд насанд хүрсэн иргэдийн шинэчилсэн бүртгэлийг явуулж, 2600 иргэнийг цахим үнэмлэхжүүлсэн. Мөн жил бүр шинээр 16 нас хүрч байгаа иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийг авч, үндсэн мэдээллийн санд суулгаж цахим үнэмлэхийг тухай бүр олгож байна. 2012 оноос “Хүүхдийн мөнгө” олгож эхэлсэнтэй холбоотойгоор



хүүхдүүдийн бүртгэлийг сайжруулан, алдааг залруулж дууссан. Мөн иргэний 8 төрөлтийн бүртгэлд бүртгэгдсэн иргэдийн мэдээллийг тухай бүр хуулийн хугацаанд аймаг, улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэн, үндсэн мэдээллийн санд суулгаж баталгаажуулах ажлыг зохион байгуулж байна.

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН АРХИВЫН ТАСАГ

Төмөрбулаг сумын захиргаа 1943 оноос анхны орон тооны бичээч-зарлагатай болсон бөгөөд энэ үед Дуламжавын Батаа бичээч, зарлагаар анх томилогдож байжээ. Сумын захиргаа өргөжин тэлж сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны бичээчээр Цэвэгдорж, Даваадорж нар ажиллаж байсан бөгөөд 1965-1975 онуудад Р.Нансалмаа бичээчээр ажиллаж байжээ. Тус суманд 1975-1991 оны долдугаар сарын 01-ны өдөр хүртэл Ө.Сайнноров ажиллаж байжээ. Монгол Улсын Архивын тухай хууль 1998 онд батлагдаж, энэ хуулийн дагуу сумын Засаг даргын тамгын газрын бичээч нь Архив, бичиг хэргийн эрхлэгч нэртэй болж өөрчлөгджээ.

## ЛҮНДЭНДОРЖИЙН АМАРБАТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд 1971 онд төрсөн. Бага бүрэн бус дунд сургуулийг 1987 онд төгссөн. 1987-1990 онд Ховд аймаг дахь ХАА-н техникумыг малын бага эмчээр төгссөн. Малын бага эмч, архивч мэргэжилтэй. 1990 оны 6-р сард малын бага эмчээр төгсөж ирээд 1990 оны 7 сарын 20-ны өдрөөс ХАА-н газрын даргын тушаалаар тус сумын мал эмнэлгийн тасагт аптекийн эрхлэгч, эмчээр ажиллаж байсан. Архив, бичиг хэргийн эрхлэгчийн ажлыг 1991 оны долдугаар сарын 01-ний өдрөөс эхлэн одоог хүртэл хариуцан ажиллаж байна. 2003 онд Архивын ерөнхий газраас зохион байгуулдаг Бичиг хэрэг архивын ажилтны анхан шатны сургалтанд хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авчээ. Л.Амарбатын ээж Ө.Сайнноров нь 1951 онд төрсөн. 1969 онд 10-р ангийг дүүргэж сумынхаа дунд сургуульд бага ангийн багшаар ажиллаж байсан ба 1975-1990 оны 7 сар хүртэл АДХ-ын гүйцэтгэх захиргаанд бичээчээр ажилласан ба ээжийнхээ хийж байсан ажлыг өвлөн авч одоог хүртэл амжилттай ажиллаж байна. Л.Амарбат нь 2012 онд Архивын ерөнхий газраас “Архивын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдаж байсан. Архивын ерөнхий газрын даргын тушаалаар Ахлах болон тэргүүлэх зэрэг авсан бөгөөд 2009 онд Төрийн үйлчилгээний тэргүүний ажилтнаар шалгарч байжээ. Тэрээр Архивын өрөөг стандартын дагуу тохижуулж, аймгийн архивын тасагт баримтуудаа цахим хэлбэрээр жил бүр өгч хэвшсэн. Архивын 596 баримтанд нягтлан шалгалт хийж Архивын тасгаас ирсэн шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн. Сумын ЗДТГ-ын архив нь байнга хадгалах, түр хадгалах, устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэж



Ө.Сайнноров

жил бүр Аймгийн архивын тасгийн дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссоор батлуулан ажиллаж байна. Л.Амарбат нь ажиллах хугацаандаа сумын архивын нэгж үүсгэх ажлыг Давшилт нэгдлийн бичээч, нярав, нягтлан нартай хамтран зохион байгуулж 1995 онд Давшилт нэгдэл, Саруул зам нэгдлийн 70-р дансыг сумын архивт төвлөрүүлэн авч үүнээс малчдад лавлагаа олгодог.

## БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТАСАГ

Тус сумын Байгаль орчин, тогтвортой хөгжлийн тасаг нь 1950 онд анх үндэс сууриа тавьжээ. Тухайн үед Төмөрбулаг суманд ойн цагдаа нэртэйгээр байгуулагдан ажиллаж эхэлсэн түүхтэй. Төмөрбулаг сумын анхны ойн цагдаагаар Дүвчин, Өлзийбаяр, Ж.Пүрэвээ, Г.Батдорж, С.Цогзол нар ажиллаж байсан бөгөөд 1987-1990 оны хооронд И.Ганбаатар, С.Цогсол, Б.Жаргалсайхан ойн цагдаагийн үрэг гүйцэтгэж байв. 1990 онд бүтэцийн өөрчлөлт орж, ойн цагдаа нар байгаль хамгаалагч гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ үед Б.Чулуундаваа, Б.Жаргалсайхан, Д.Ганхуяг, Д.Хүрэлбаатар, Д.Уламбаяр нар ажиллаж байсан байна. 1996 оноос сумын Байгаль орчныг хамгаалах тасаг болон өргөжиж, байгаль орчны улсын байцаагч гэсэн орон тоо шинээр гарч Ч.Лхагвасүрэн, байгаль хамгаалагчаар Б.Жаргалсайхан, Р.Ёндонжамц, Д.Ганхуяг, Ч.Бадраа, Д.Хүрэлбаатар, Д.Лхагвадорж нар ажиллаж байлаа. Төмөрбулаг сумын Байгаль орчныг хамгаалах тасаг нь тухайн үед ан агнуурын хяналт шалгалтыг сайтар хийж, ан агнуураас орох орлогыг давуулан биелүүлж ажиллаж байсан байна. 2004 оноос 2007 оны хооронд байгаль орчны хяналтын улсын байцаагчаар М.Батмөнх, байгаль хамгаалагчаар Ч.Лхагвасүрэн, Б.Жаргалсайхан нар ажиллаж, мөн 2007 оноос хойш байгаль орчны хяналтын улсын байцаагчаар Д.Хишигсайхан байгаль хамгаалагчаар



Байгаль орчны тасгийн хамт олон.

Д.Түмэнжаргал, Б.Жаргалсайхан нарыг ажиллаж байлаа. Байгаль орчныг хамгаалах тасаг нь 2009 оны дөрөвдүгээр сараас эхлэн сумын Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг болон өргөжсөн юм. Энэ тасгийн анхны даргаар Ч.Цэдэвсүрэн томилогдож, байгаль орчны хяналтын байцаагчаар Д.Хишигсайхан, байгаль хамгаалагчаар Д.Түмэнжаргал, Б.Жаргалсайхан, газрын даамлаар Х.Нямрагчаа, цаг уурчаар Я.Мөнх-Эрдэнэ, усны харуулаар Б.Алтанхуяг, ойн ажилтнаар М.Мягмар нар томилогдож, найман хүний бүрэлдхүүнтэйгээр ажиллаж эхэлжээ. 2014 онд Байгаль хамгаалагчаар Ч.Амаржаргал томилогдсон байна. Тус албаны дэргэд газрын даамлын ажлын байрны орон тоог 2005 онд шинээр нэмж батласан бөгөөд Төмөрбулаг сумын газрын даамлаар 2005-2007 он хүртэл Д.Пүрэвдорж, 2008 оноос одоог хүртэл Х.Нямрагчаа нар ажиллаж байна.

Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг нь 252172,0 га талбайн нутаг дэвсгэрийг хариуцан ажилладаг.Үүнээс ойн сан бүхий газар 56697.7 га, усан бүхий газар 288.0 га, бэлчээрийн талбай 192667.23 гаг эзэлдэг. Сумын БОТХБ тасаг нь 2013 оны байдлаар төсвийн өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавин ажилласнаар газрын төлбөр 100 хувь биелүүлж, ойгоос хэрэглээний болон түлшний мод бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 35296,4 сая төгрөг хуримтлуулж, төлөвлөгөөгөө 156 хувь, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 100 хувь, рашаан ашигласны төлбөрийг 113 хувиар давуулан биелүүлж ажилласан. Тус тасаг нь Цагаанбургасын давааны хяналтын постыг засварлаж, ой хээрийн түймэр, хулгайн мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх харуулын цамхаг гурвыг байгуулж, ойн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 6.4 га ойд нөхөн сэргээлт хийж, цөлжилтэй тэмцэх ажлын хүрээнд Олон голын бэлчирт мод тариалах төсөл арга хэмжээг сум дундын “Эрчимт идэр” ойн ангитай хамтран зохион байгуулж, 21 мянган ширхэг суулгалцаар нөхөн сэргээлт хийжээ.

### БҮГСИЙ-ТӨМӨРБУЛАГ УС СУДЛАЛЫН ХАРУУЛ

Бүгсий-Төмөрбулаг ус судлалын харуул нь 1963 оны долдугаар сарын 23-нд байгуулагдсан. Төмөрбулаг сумын төвөөс баруун урагш 1.5 орчим км зайд голынхоо зүүн эрэгт байрладаг. Тус харуулд хийх хөтөлбөрт ажлын хүрээнд усны түвшин, температур, өнгөрөлт, мөсний үзэгдэл, мөсний зузаан, усны хэвгийн хэмжилтийг тогтмол хийдэг. Усны өдөр тутмын мэдээг гаргадаг байна. Мөн үүний зэрэгцээ усны химийн сорьцыг Байгаль орчны шинжилгээний лабораторид явуулж шинжлүүлж байдаг. Тус сумын Бүгсий-Төмөрбулаг ус судлалын харуулаар Б.Алтанхуяг ажиллаж байна.





## **ТӨМӨРБУЛАГ СУМЫН НИЙГМИЙН ХАЛАМЖ**

Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиуд батлагдаж, нийгмийн халамжийн үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдэж, 1995 оноос тус суманд Нийгмийн халамж үйлчилгээний байцаагчаар Жигжидийн Энэбиш ажиллаж эхэлжээ. Мөн 2001 оны наймдугаар сараас 2002 оны таван сар хүртэл Түдэвпунцагийн Тэрбиш халамжийн байцаагчийн албыг давхар хавсран гүйцэтгэж байсан ба энэ үед халамжийн тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг банкаар дамжуулан олгож эхэлсэн байна. Мөн 2002 оны 5 сараас 2006 оны 5 сард Ламжавын Отгонжаргал ажиллаж байв. Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хийгдэж, нийгмийн ажилтны орон тоог бий болсон ба халамжийн үйлчилгээний төрөл, зорилтот бүлгийн хамрах хүрээ нэмэгдсэн байна. Мөн 2009 оноос сумын халамжийн мэргэжилтэн, халамжийн нийгмийн ажилтны хоёр орон тоотой болжээ. Халамжийн үйлчилгээнд программ хангамж ашиглан, тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ авагчдын мэдээллийн бааз үүсгэсэн. Халамжийн үйлчилгээний төрөл хамрах хүрээ нэмэгдэж, шинэчлэл хийгдэж байна.

### **ЖИГЖИДИЙН ЭНЭБИШ**

1946 онд төрсөн 1954 онд бага сургууль, 1966 онд Мөрөнд 10 жилийн сургууль төгссөн. 1967 онноос 3 жил цэргийн алба хааж, 1970 оноос Давшилт нэгдэлд ажилчин, нягтлан бодогчоор, ахуйн үйлчилгээний нягтлан бодогч, даргаар, сумын ЗДТГ-д халамжийн байцаагч, сумын засаг даргын орлогч зэрэг ажил эрхэлж байсан

### **ЦИЕНХҮҮГИЙН БАТЗАЯА**

1992 онд 10 жилийн сургууль төгссөн. 2005 онд Далайван коллежийг нягтлан бодох мэргэжлээр төгссөн.

### **БҮРЭГДЭЭЖАНЦАНГИЙН НИЯМДАВАА**

2009.02-2011.02 сард ЗДТГ-ын халамжийн нийгмийн ажилтнаар, 2011.02 сараас НХҮХ-ийн Төмөрбулаг сум хариуцсан халамжийн мэргэжилтнээр ажиллаж байна. 2003 онд Төмөрбулаг сумын 10 жилийн сургуулийг, 2007 онд МУБИС-ын МаСС-ийг “Эдийн засагч-Математикч” мэргэжлээр төгссөн. Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. 2013-2014 онд нийгмийн ажилтны мэргэшүүлэх сургалтанд хамрагдан сертификат авсан. Аймгийн ЗДТГ-ын даргын баярын бичиг, засаг даргын жуух бичгээр шагнуулж байсан.

### **ЦЭРЭНДОРЖИЙН ГАНТУЯА**

Сумын анхны халамжийн мэргэжилтнээр ажиллаж байсан. 2003 онд Мөрөн сумын Тетра-Эдр ахлах сургуулийг, 2007 онд МУИС-ын НШУС-ийг “Нийгмийн ажилтан” мэргэжлээр төгссөн. Нийгмийн ухааны магистр зэрэгтэй. Сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг давхар хариуцан ажиллаж байсан бөгөөд Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хүнс тэжээлийн дэмжлэг олгох хөтөлбөрийг анхлан хэрэгжүүлж ажилласан.

### **ДУЛМААГИЙН САЙНБАЯР**

Тэрээр 1988 онд Төмөрбулаг сумын 8 жилийн сургуулийг, 2005 онд Удирдлагын академын Төрийн захиргаа удирдлагын менежер мэргэжлээр төгссөн. 2013 онд Их засаг Их сургуулийг Хууль зүйн магистр цолтой төгссөн. Д.Сайнбаяр нийгмийн халамжин мэргэжилтнээр ажиллаж байхдаа сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг давхар хариуцан ажиллаж байсан.

### **ГАНБАТЫН АРИУНСАЙХАН**

2007 онд Мөрөн сумын 3 дугаар 10 жилийн сургуулийг, 2012 онд МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийг төгссөн. Сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг давхар хариуцан ажиллаж байсан бөгөөд Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүй, өрхийн хөгжлийн төлөвлөгөө, хөдөө орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь гэсэн сургалтуудад харагдан сертификат авч байсан.

### **ДОРЖСҮРЭНГИЙН ӨЛЗИЙСАЙХАН**

Төмөрбулаг сумын нийгмийн ажилтан Д.Өлзийсайхан нь 2008 онд Төмөрбулаг сумын 10 жилийн сургуулийг, 2012 онд Ховд аймгийн Ховд Их Сургуулийг “Нийгэм судлал, эрх зүйн багш” мэргэжлээр төгссөн. Сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг давхар хариуцан ажиллаж байна.

### **Төмөрбулаг сумын нийгмийн халамжийн үйлчилгээг хариуцан гүйцэтгэж байсан хүмүүс**

№	Овог нэр	Ажиллаж байсан үе	Албан тушаалын нэр
	Жигжидийн Энэбиш	2005-2001 он	Халамжийн байцаагч
	Түдэвпунцагийн Тэрбиш	2001.08 -2002.05 сар	Халамжийн байцаагч
	Ламжавын Отгонжаргал	2002.05-2006.05 сар	Нийгмийн ажилтан
	Лхамсүрэнгийн Энэбиш	2006.07-2007.08 сар	Нийгмийн ажилтан
	Циенхүүгийн Батзаяа	2006.09-2007.04 сар	Нийгмийн ажилтан
	Лхагважавын Бат-Эрдэнэ	2007.07-2009.08 сар	Нийгмийн ажилтан
	Бадраагийн Уранмандал	2007.09-2009.02 сар	Нийгмийн ажилтан
	Бүрэгдээжанцангийн Нямдаваа	2009.02-2011.02 сар	Нийгмийн ажилтан
	Цэрэндоржийн Гантуяа	2011.02-2013.01 сар	Нийгмийн ажилтан
	Дулмаагийн Сайнбаяр	2013.01-2014.01 сар	Нийгмийн ажилтан
	Ганбатын Ариунсайхан	2014.01-2014.09 сар	Нийгмийн ажилтан
	Доржсүрэнгийн Өлзийсайхан	2014.10 сараас	Нийгмийн ажилтан

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН 1-Р БАГ

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль батлагдаж, хуулийн дагуу АДХ-ын гүйцэтгэх захиргааг татан буулгаж анхан шатны нэгжээ баг байхаар зохион байгуулж, тус суманд 1992 оны наймдугаар сарын 21-нд таван баг байгуулагдсан. Өнгөрсөн хугацаанд 1-р багийн засаг даргаар

**1992- 1996 онд Ж.Дорждаян**

**1996-2000 онд Ч.Зүмбэрэлдорж**

**2000-2004 онд Ж.Лхагважав**

**2004-2012 онд Ц.Доржготов** нар ажиллаж байсан бөгөөд 2012 оноос Ш.Наранхүү томилогдон ажиллаж байна. Тус сумын 1-р баг нь 63001 га



1-р баг

нутаг дэвсгэртэй, хойд талаараа Агт, Донхор, Бадаг, урд талаараа Бургаст, Цагаанбургас, Өлийн даваа баруун талаараа Элстэй, Урт, Халзан даваа, зүүн талаараа Тэлээгийн баруун зүүн салаа Хөндийн тагаар хиллэдэг.

Тус баг нь 316 өрхийн 1122 хүн амтай. 2013 оны жилийн эцсийн байдлаар 55355 толгой мал тоологдсон. Тус багт ажил хөдөлмөрөөрөө сум орон нутагтаа тэргүүлсэн олон алдартнууд аж, төрж, амьдарч ирсэн түүхтэй. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонтой аварга тууварчин А.Хишигдорж, “Алтангадас” одонтой И.Ганболд, Б.Чулуундаваа, Улсын сайн малчин С.Давааням, Аймгийн сайн малчин Г.Дашбямба, М.Даваахүү сумын сайн малчин Л.Бямбасүрэн, Б.Түмэнбаяр, Х.Гонгор нар тус багийн иргэд юм. Өнөөдөр тус багт М.Батмөнх захиралтай “Донхор булаг” ХХК, Д.Сансарсайхан эзэнтэй “Донхорын буянт сүрэг” хоршоо Ш.Батгэрэл эзэнтэй “Ялбагант хайрхан” Б.Цэцэндулам эзэнтэй “Овгор ээж хорхойт” зэрэг аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна.

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН 2-Р БАГ

Тус сумын 2-р багийн нэр нь Нарийн гэх бөгөөд сумын төвөөс 20 км зайтай байрладаг. Нийт 25000 га газар нутагтай, 192 өрхийн 704 хүн амтай 47976 толгой таван хошуу малтай. Тус багийн нутаг дэвсгэр уулархаг ямаан сүрэг өсгөн үржүүлэхэд нэн тохиромжтой нутаг юм. Төмөрбулаг суманд 1970 оны үеэс эхлэн нутгийн мал сүрэг түүний дотор ямааг бие бялдар, амьдын жин, ноолуур зүсний байдлаар ялгаж тухайн үеийн нэрээр Давшилт

нэгдлийн 2-р бригадад ялган, ямаан сүрэгт гардан зохиомол хээлтүүлэг хийж байсан түүхтэй. 1986 оноос 2-р бригадын дарга С.Давааням, Н.Надмид докторын удирдлагаар аймгийн Үржил селекцийн станц, ХААДС-ийн багш Д.Нэргүй зоотехникч Зундуй, Даваацэдэв Ч.Гунгаажанцан Ц.Мишигдорж М.Дорждүдэл малын эмч Д.Оюунцэцэг /үйлдвэр хөдөө аж ахуйн газрын ариутгалын эмч/ болон дадлагын оюутнуудтай хамтран 2-р бригадын ямаан сүрэг дээр мах ноолуурын чиглэлээр ангилан ялгалт хийж ноолуурын гарц амьдын жингээр илүү шилмэл ямааг 1,2,3, ангиар ялгаж Нарийн буюу 2-р багт байршуулан Ямааны үржлийн улсын фермийг байгуулж байсан юм. 1992 оны өмч хувьчлалын хуулийн дагуу үржлийн фермийн сүргийг малчдын хүсэлтээр хувьчлан бусад барилга машин техник үндсэн хөрөнгийг төрийн мэдэлд үлдээсэн. Одоогоор Эрчим омгийн ямаан сүрэг нь 32671 болон өсч үржиж байна. Тус багт “Аваргуудын алдар”, “Дуганч хайрхан”, “Өлзийт улаан хан” гэсэн гурван хоршоо үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Тус баг нь эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон бөгөөд 2012 онд Аймгийн шилдэг багаар шалгарч байсан. Багийн төвд Лувсангийн Санжаагийн нэрэмжит хүүхдийн Эко зуслан, үзэсгэлэнт байгаль болох Олон голын бэлчирт жуулчны баазууд ажиллаж байна. Эдгээр жуулчны бааз нь гадаад дотоодын жуулчид амрахаас гадна спорт загас ан агнуур хийлгэх Сэлэнгэ, Дэлгэрмөрөн, Идэр, Чулуутын голоор аялах боломжтой юм. Төмөрбулаг сумын хоёрдугаар багийн Засаг даргаар Н.Бямбачулуун, багийн ИНХ-н даргаар Г.Хүрэлбаатар, багийн хүний эмчээр Л.Мөнхбат, малын эмчээр А.Алтанхуяг Д.Наранбаатар нар ажиллаж байна.

Тус багаас Хөдөлмөрийн баатар ямаачин П.Цагаач, Аж үйлдвэрийн гавъяат ажилтан Б.Ёндонжамц, Монгол улсын залуу аварга, улсын сайн малчин Б.Батмөнх, Монгол улсын сайн малчин Г.Төөчөө, ХАА-н тэргүүний ажилтан П.Банзрагч, С.Давааням, Д.Наранбаатар Г.Төөчөө, Анагаах ухааны доктор Д.Агваандорж, Эдийн засгийн ухааны доктор Ү.Хадбаатар, Нисэх хүчний нисгэгч П.Баадай, БНМАУ-н морин спортын мастер Ж.Амраа, П.Цагаанбаатар, Шатрын спортын мастер Д.Пүрэвдорж

Аймгийн цэргийн штабын дарга мөн Нарантолгой ХХК захирал хийж байсан Хурандаа Д.Цагаанбаатар, ҮААЭГ дарга Т.Дэмчигдорж, Онц холбоочин Ж.Бүжинлхам, “Ард түмний гавъяат” эмч Г.Дорж, 12 байгууллагын тэргүүний ажилтан Д.Батаа, Хувьсгалт тэмцэлийн ахмад зүтгэлтэн Ш.Гаваа, Аймгийн гурван удаагийн аварга хоньчин АИХ-депутат Д.Банзрагч, Аймгийн дөрвөн удаагийн аварга ямаачин АИХ-депутат П.Лунхай, Аймгийн хошой аварга ямаачин Х.Ням-Очир, Аймгийн аварга хадланч Д.Долгорсүрэн, “Алтан ишигний эзэн” Ж.Чулуунсүрэн, Аймгийн аварга адуучин Д.Даваажав, аймгийн дөрвөн удаагийн аварга төлчин, хоёр удаагийн тарга хүчний аварга төлчин М.Нямжав, Аймгийн сайн малчин Б.Дашням, Ж.Амраа, Д.Зоригоо, Д.Хүрэлбаатар, Л.Тэгшбаяр, Б.Дашдондог, Уран сийлбэрч Навааны Лувсанцэрэн, Л.Ганхөлөг, Л.Батцэнгэл, сумын дөрвөн удаагийн аварга малчин Г.Нансалдулам сумын аварга малчин Г.Хишигжаргал, Т.Пүрэвдорж, Б.Чойдогбавуу, Ч.Лхамсүрэн, Б.Норовсамбуу, Б.Отгонбаяр, Т.Галтбаяр, 2000-г мянгат малчин Т.Галтбаяр зэрэг олон алдартнууд төрж гарсан билээ. Мөн тус багаас Б.Чойдогбавуу, П.Цагаач, Г.Төөчөө, Д.Марку, Ж.Амраа, Д.Шагдар,



2-р багийн төв

Т.Пүрэвдорж, Л.Тэгшбаяр, Б.Отгонбаяр, Ч.Лхамсүрэн, Ж.Хөрөнгөө, Б.Дашдондог, Л.Даваасэнгэ, Д.Хүрэлбаатар, Д.Зоригоо, Д.Урантуяа зэрэг малчид мянгат малчны болзол хангаад байна. Төмөрбулаг сумын хоёрдугаар багийн даргаар 1992 онд Д.Наранбаатар, 1994-1997 онд Ч.Гунгаажанцан 1997-2000 онд Д.Наранбаатар 2000-2002 онд Д.Данаажав 2002-2004 онд Д.Наранбаатар 2004-2012 онд Б.Дашдондог 2012 оноос Н.Бямбачулуун нар ажиллаж байна.

### ТӨМӨРБУЛАГ СУМЫН 3-Р БАГ

1939 оны дөрөвдүгээр сарын 15-нд Тариатын аманд 2, 3-р багийн Р.Даваа, Н.Дамбаравжаа, П.Дан-Аа, П.Дэлгэр, Д.Ёндон, Ч.Ёндон, А.Зундуй, Ж.Лхүндэв, Наваан, Ж.Долгоржав, Л.Түндэв, Г.Халтар, П.Цог нарын 13 өрхийн 17 хүн өөрсдийн сайн дураар хүч хөдөлмөрөө нэгтгэн жин тээх, тариа тарих, ардын үйлдвэрлэлийн нэгдэл байгуулан ажиллахаар санаа нэгдэж “Шинэ-Амьдрал” нэгдлийг байгуулж даргаараа Сүрэнгийн Рагчааг сонгожээ. “Шинэ-Амьдрал” нэгдэл “Оч” нэгдэлтэй 1956 онд нэгдэж “Шинэ-Амьдрал” нэрээрээ үлджээ. Тус багийн Балдан, Ж.Готов нарын 20-иод өрхийнхүүс 1958 оны эхээр Бүгдгээнд хуралдаж, ХАА-н “Ирээдүйн зам” нэгдлийг байгуулж даргаараа намын хорооны орлогч дарга байсан Ж.Готовыг сонгожээ. Энэ нэгдэл удалгүй “Саруул зам”, “Давшилт” нэгдлүүдэд шилжин нэгджээ. Тус баг нь Төмөрбулаг сумын анхны нэгдлүүдийн өлгий нутаг болсон баг юм. 1992 оны наймдугаар сарын 21-нд анхан шатны нэгж баг байх хууль гарч, 1992 оны арваннэгдүгээр сард Төмөрбулаг сумын гуравдугаар багийг шинэчлэн зохион байгуулж, сонгууль явуулж, багийн Засаг даргаар Жамцын Батбаяр сонгогджээ. Өдгөө Төмөрбулаг сумын 3-р баг нь 199 өрхтэй, 734 хүн амтай, 44868 толгой малтай, 62341 га нутаг дэвсгэртэй, сумын төвөөс 35 км зайтай, ойт хээрийн болон уулархаг бүсэд хамрагддаг. Тус баг нь Архангай аймгийн Цэцэрлэг, Жаргалант, баруун урдуураа өөрийн аймгийн Галт, Шинэ-Идэр сумдтай хиллэдэг. Багийн хэмжээнд дөрвөн мянгат малчинтай, малын төрлөөр багийн иргэн Т.Батхуяг 109 адуугаар, мөн 116 үхэрээр, Б.Энхдалай 543 хониор, Б.Мөнхзаяа 1068 ямаагаар тэргүүлж явна. Тус багийн ард иргэд бусдын адил ажиллаж хөдөлмөрлөн төр улс нийгэмдээ хийсэн бүтээсэн зүйлтэй, хэлж ярих дурсамжтай, бахархан дуурсах ахмад, дунд, залуу үетэй жаргал дүүрэн амьдарч байна. Төмөрбулагчууд төдийгүй Монголчуудын бахархал болсон олон алдартнууд тус багаас төрж гарсан юм. Бүгдгээний уугуул Агвааны Лхасүрэн хамба, түүхийн ухааны Дэд



3-р багийн төв

эрдэмтэн Лувсангийн Санжаа, МУ-ын 25 дахь Ерөнхий сайд Санжаагийн Баяр, Түүхийн ухааны доктор профессор Сандуйн Пүрэвжав, ахмад дайчин Батын Ганжууржав гэх мэт олон алдартнуудыг энд дурьдаж болно. Тус багт Н.Сүрнээбазар ахлагчтай “Цагаан бургас” ойн нөхөрлөл, Б.Энхдалай ахлагчтай “Бүгдгээний нуруу” хоршоо, Л.Батсайхан ахлагчтай “Бүгэд гэгээний уул” хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тус багийн засаг даргаар 1992-2000 онд Ж.Батбаяр, 2000-2001 онд Д.Наранбаатар, 2001-2004 онд Ж.Батбаяр, 2004-2012 онд Ц.Нэргүй нар ажиллаж байлаа. Өдгөө Төмөрбулаг сумын 3-р багийн Засаг даргаар Л.Батсайхан, ИНХ-ын даргаар О.Уургачхүү, хүний эмч Ж.Баянмөнх, малын эмч Б.Алтанхуяг нар ажиллаж байна.

### ТӨМӨРБУЛАГ СУМЫН 4-Р БАГ

Тээл баг нь 1972 онд Бүрэнтогтох сумын “Саруул зам” нэгдлээс салж, Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд Тээл 3-р бригад Цагаан толгой нэртэйгээр үүсэн байгуулагдсан. Тус баг нь 1- 3-р ангийн хүүхдүүд сургадаг, 10 гаруй багш ажилчидтай бага сургуультай байсан юм. Лхан-Аа Дуламсүрэн, Ж. Маналсүрэн, Лумсан-Очир, Халтар, Ж.Даваа, Доржготов гэх зэрэг үе үеийн захиралтай хамт олон тус багийн бага сургуулийг удирдаж байв. Мөн Тээл бригадэд Хүн эмнэлгийн бага эмчийн салбар найман хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж, хүн ардад эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлж байжээ. Үүнээс гадна зургаан хүний орон тоотой Сүү тосны зовад ажиллаж сумын нийт цөцгийнний 80 орчим хувийг бэлтгэж байсан түүхтэй. 1991 онд өмч хувьчлалын үед Тээл бригад дээр Нямсүрэн даргатай “Эрээн булаг” ХХК байгуулагдаж нягтлан бодогчоор Алтанхуяг, Ёндон тоо бүртгэгч С.Юндэндорж Т.Цагаач, жолооч Д.Цэгмид гэх зэрэг 10 гаруй орон тоотой үйл ажиллагаа эхэлж байв. Тээл бригад буюу одоогийн 4-р баг нь Төмөрбулаг сумаас 30 км зайтай байрладаг. Нийт 76103 га газар нутагтай, 284 өрх 1017 хүн амтай. Нийт 52226 толгой малтай. Орон нутгын ард иргэд шүтэн дээдэлдэг Дашдэрчин, Дөш хайрхан, Эрчимийн нуруу зэрэг өндөр сүрлэг уулс, Торцын рашаан, Рашааны ээж хад, Зуна голын буган хөшөө, Нүхэн чулуу, Арслантай хад, Баядын овоо гэх мэт байгалийн үзэсгэлэнт газруудтай. Олон зууны турш дээдлэн шүтэгдэж, Далай гүний хошууны соёл, иргэншлийн төв болж байсан Бүгсийн хүрээ тус багийн нутаг дэвсгэрт байрладаг юм.

Төмөрбулаг сумын 4-р баг буюу Тээл бригадын даргаар Сосорбарам, Цэдэн-Иш, П.Банзрагч, Б.Ганхуяг, С.Юндэндорж нар ажиллаж, тус багийн



аж ахуйн нярваар Б.Содном, Д.Дэмбэрэл, С.Баргадь нар томилогдож байжээ. Мөн бригадын мухлагын худалдагчаар О.Должин, Баярсүрэн, Төмөр-Очир, Лхагвадэмбэрэл нар ажиллаж байсан байна. Тус багт үйл ажиллагаа явуулж байсан фермийн эрхлэгчээр Х.Даш, Ч.Батбаяр, Даваа, Давааням, Дашмягмар, Ичинхорлоо, Г.Алтангэрэл, Гомбодорж Д.Сүхбаатар томилогдож байжээ. Мөн агентаар Ё.Дашмягмар, Төмөр-Очир, Д.Дагвашадав. П.Дэлгэрдалай, Г.Алтангэрэл, Д.Цэнд-Аюуш, Х.Нямсүрэн, А.Цэвээнлхазал, Д.Сүхбаатар тэргүүтэй олон хүн ажиллаж байлаа. Тус багт хөдөө аж ахуйн салбарт ажиллаж амжилт гаргасан Улсын сайн малчин Е.Жүгдэр, Дашмягмар, Ё.Магсар, Аймгийн Алдарт уяач Ч.Ренчинжүгдэр, Аймгийн сайн малчин Бат-Очир, Аймгийн аварга саальчин Я.Надмид, Долгорсүрэн, Цэрэннадмид, Бүжиллхам, Д.Нямсүрэн, сумын аварга малчин Д.Батдорж, Б.Эрдэнэ, Д.Дэлгэрмөрөн нар тэргүүтэй олон хүмүүс ажил үйлсээрээ манлайлж байдаг. Тус багийн малчин Д.Батдорж, Ё.Магсар, Ё.Бат-Очир, Б.Ганболд, Д.Ганбат Л.Өлзийбаяр, Б.Эрдэнэ, Б.Баттулга, Б.Болдхуяг, Д.Дэлгэрмөрөн, М.Баттулга, Ч.Даваадорж Б.Нямбал, Ц.Мөнх-Очир, Д.Лхагвасүрэн, Д.Билэгсайхан нар мянгат малчны болзол хангажээ. Тус багийн иргэн Н.Батнасан эхнэр С.Лхагвадулам нар “Уран шаглаа” төсөл орон нутагтаа хэрэгжүүлж, аймаг суманд зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаанд удаа дараа амжилттай оролцож байна. Мөн цагаан идээ үйлдвэрлэгч А.Ганаа Л.Азжаргал нар жил болгон аймаг сумын үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцдог. Энэ багт Д.Хүрэлбаатар ахлагчтай “Дашдэрчин”, С.Батжаргал ахлагчтай “Таван гол”, Р.Сэргэлэн ахлагчтай “Баянбулаг”, Д.Борбаатар ахлагчтай “Баянчулуут” Т.Ганбаатар ахлагчтай “Таравч овоо” С.Цэрэндэжид ахлагчтай “Баянхангай” гэсэн ойн зургаан нөхөрлөл ажиллаж байна. Мөн үүний зэрэгцээ Р.Пунцаг даргатай “Дэлт шувуун саарал”, Л.Азжаргал даргатай “Баян чулуут” Ц.Мөнх-Очир даргатай “Таравч Тээл” гэсэн гурван хоршоо үйл ажиллагаа явуулдаг. Төмөрбулаг сумын 4-р багийн даргаар

1992-1996 онд Л.Цэгмид

1996-2000 онд Д.Даваадорж

2000-2004 онд М.Энхбат

2004-2008 онд Б.Баясгалан

2008-2010 онд Д.Даваадорж

2010-2012 онд М.Магсаржалам нар ажиллаж байжээ. Өнөөдөр тус багийн Засаг даргаар Д.Одбаяр ажиллаж байна.

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН 5-Р БАГ

Төмөрбулаг сумын төв нь 5-р багт харьяалагддаг. Тус багийн Засаг даргаар

1992-1994 онд Н.Чулуун

1994-1995 онд Б.Чулуундаваа

1995-1996 онд Б.Ганзориг

1996-2000 онд Ц.Батбаяр

2000-2002 онд Б.Хүрэлбаатар

2002-2003 онд Ц.Бямбадорж

2003-2004 онд Ч.Жаргалсайхан

2004-2008 онд Ш.Нацагдорж нар ажиллаж байжээ. Мөн Иргэдийн нийтийн хурлын даргаар Я.Мөнх-Эрдэнэ, Ц.Батбаяр нар ажиллаж байжээ. Өдгөө тус багийн даргаар Т.Эрдэнэбат, Иргэдийн нийтийн хурлын даргаар Г.Золжаргал нар ажиллаж байна.

Тус багийн нутаг дэвсгэр дээр ЗДТГ, ЕБС, ЭМТ, Чандмань цэцэрлэг, Соёлын төв, Цагдаагийн хэсэг гэсэн төсвийн байгууллагууд, Холбооны салбар, Эрчим хүч, ХААН банк, Төрийн банк, Баян-Энх-Айраг ШТС, Торц мөрөн хувийн мал эмнэлэг, Тээвэр зохицуулалтын алба, Эмийн сан болон хүнс, барааны 22 дэлгүүр, дөрвөн цайны газар үйл ажиллагаагаа явуулдаг. Тус баг 2014 оны байдлаар нийт 214 өрхийн 792 хүн амтай, 2013 оны оны эцсийн байдлаар 18486 толгой мал тоологджээ. Жижиг дунд үйлдвэрлэл болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч Б.Амарбат, Д.Дорж, Б.Дагвасүмбэрэл, Л.Мөнхбаяр, Д.Түмэнжаргал, А.Батмөнх, Д.Бат-Эрдэнэ, Ё.Батмөнх, Ц.Батмөнх, Х.Эрдэнэбат, Д.Батболд, С.Наранбат, Т.Элдэв-Очир, Ц.Мөнхбаяр, Т.Отгонбаяр, С.Баянмөнх, Э.Чулуунбаатар, Х.Зоригтбаатар, Ө.Балжинням, Б.Бямбачулуун, Д.Ганбаатар, З.Цэрэнханд, Ш.Сумъяа, С.Нарантуяа, Д.Баасандулам, Л.Мядагмаа, Г.Цэцгээ, Т.Нарангэрэл, М.Долгорсүрэн, Б.Болормаа, Д.Амгалан, Ш.Гүндэгмаа, А.Лувсмаа, Ц.Амгалан нарын иргэдэд бүх төрлийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлж байна. Багийн иргэдийг ундны усаар хангадаг гүний гурван худагт М.Оюундэлгэр, Д.Зоригт, Д.Ганбаатар нар, сумын төвийн хогийн машины жолоочоор Ж.Төмөрбаатар ажилладаг.



Тус багт Орон нутгийн тээвэр зохицуулалтын алба 2013 оноос үйл ажиллагааг явуулж эхэлсэн бөгөөд 14 жолооч тендэрт шалгарч сумын иргэдэд тээврийн үйлчилгээг үзүүлж байна. Тээвэр зохицуулалтын албаны даргаар Ц.Ууганбаяр ажиллаж байна. Тус багаас улсын аварга хадланч Ч.Цэрмаа, монгол улсын начин М.Эрдэнэбат, ОУХ-ны мастер Н.Нандинбилэг, спортын мастер Д.Алтантөгс, спортын мастер Г.Чадалбатхуяг, спортын мастер Т.Түвшинжаргал нарын олон алдар гавьяатнууд төрөн гарсан байдаг. Мөн байлдааны гавьяаны улаан тугийн одонт Б.Ганжууржав, С.Чойжоо, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Д.Түмэндэмбэрэл, Алтан гадас одонт Ч.Цэрмаа, Д.Түмэндэмбэрэл, Д.Түмэнжаргал, Б.Алтанхуяг, Ш.Гэрэлсайхан, Ч.Цэцэгмаа зэрэг олон алдартнууд төрөн гарчээ.

**Сүүлийн таван жилийн хугацаанд 5-р багт хийгдсэн бүтээн байгуулалтын томоохон ажлуудаас...**

2008 оноос хойш Төмөрбулаг сумын төв болох 5-р багт бүтээн байгуулалтын олон ажил хийгдэж байна.

1. Спорт заал
2. ЭМТөвийн барилга
3. Хүүхдийн цэцэрлэгийн их засвар
4. 80 хүүхдийн дотуур байрны их засвар
5. Соёлын төвийн хувцас
6. ЗДТГ-ын засвар
7. Улсын баатар Л.Даваадоржийн талбай
8. Баяр наадмын талбай
9. Хогийн цэгийг хумьж хашаалан хогны машин шинээр авсан
10. Гудамжны гэрэлтүүлэг, камержуулалт
11. Иргэдэд газар эзэмшүүлэн шинээр 11 гудамж гарсан
12. Сумын төвийн дээд хэсэгт гүний худаг ашиглалтанд орсон.
13. Соёлын төвийн шинэ барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна.



Төвийн эрчим хүчний шугамд холбогдож гэрэл цахилгааны асуудал бүрэн шийдэгдэв. 80 сая төгрөгний өртөг бүхий гудамжны гэрэлтүүлэг камержуулалтын ажил хийгдлээ.



Эмнэлгийн шинэ байр ашиглалтанд оров



Цагдаагийн хэсгийн байр ашиглалтанд оров



1,2 тэрбумын өртөгтэй Соёлын төв баригдаж байна.

### 5-р багт үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний цэг

Дэлгүүрийн нэр	Дэлгүүрийн эзэн	Дэлгүүрийн нэр	Дэлгүүрийн эзэн
Сутай	Б.Баярцэцэг	Хишигт	Д.Баасанхүү
Баян зүрх	Б.Амаржаргал	Дэлгэрэх	А.Хадбаатар
Алтан овоо	О.Бямбасүрэн	Хүслэнт	Д.Түмэндэлгэр
Бөмбөөлэй	А.Баттөр	Уран дөш	Ш.Нацагдорж
Эсперо	А.Лувсмаа	Далай ээж	Н.Баярдалай
Баян булаг	Б.Цэрэнсүрэн	Жинст	Ш.Мягмаржав
Сант	С.Даваадорж	Хайрхан	Ч.Мөнх-Эрдэнэ
Баян хангай	Д.Болдбаатар	Ёлт	Ч.Даваасүрэн
Жаргалант	Б.Энхжаргал	Сайхан	Б.Батхишиг
Инерци	Л.Мөнхбаяр	Баян булаг	Ц.Хүрэлбаатар
Арвин	Ц.Ууганбаяр	Даш дэрчин	Б.Доржгочоо
Эрчим	Д.Мөнхбат	Дөл	Б.Баян мөнх
Жаргалан	С.Батбаяр	Нарийн	Г.Очирбат

#### Талх нарийн боовны цех

д/д	Цехийн нэр	Цехийн эзэн
1	Донхор булаг	М.Батмөнх
2	Дээж хүнс	А.Бадамханд



5-р багт үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний цэгийн эзэд.

### ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

#### Түүхэн замнал

Монгол улсын баруун хойд хязгаар нутагт Ардын хувьсгалын ололтыг бэхжүүлэн, хөдөөг гэгээрүүлэх бодлого эрчимжиж шинэ цагийн эхэн үе хөдөө гадаа хөгшин залуугүй өвчин, эмгэгт баригдан хаашаа хэнд хандах нь үл ойлгогдох завсрын үе байлаа.

1939 онын хавар Цэцэрлэг Мандал аймгийн Наран Жаргалант уулын хошуу Ахай бэйс Цэрэндоржийн захирч байсан Дулаан сумын нутаг Дэлгэр мөрний хөвөөнд 100 гаруй жилийн түүхтэй Мөрөнгийн хүрээний зүүн талд одоогийн Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн тулгын чулуу тавигджээ. Нэгдсэн эмнэлгийн анхны 14 санитар нь хөдөө хязгаар нутагт европ эмнэлгийн эхлэлийг тавьж өгсөн түүхтэй. Анхны 14 санитарын нэг нь Санжаагийн Дамбасүрэн 1937 онд Төмөрбулаг суманд томилогдон ирж малчин, хөдөлмөрчдөд эмнэлгийн анхны тусламж үзүүлж эхэлснээр Төмөрбулаг сумын хүн эмнэлгийн түүхийн хуудсыг нээж байжээ.

1938 онд сувилагч Ш.Бадмаа ажиллах болсноор тус сумын эмнэлэг хоёр хүний орон тоотой болжээ. 1937-1942 онд хүн эмнэлгийн техникум дүүргэж бага эмч болсон Гонгорын Банзрагч хүний бага эмчийн салбарыг сумын төвийн зүүн урд байгуулж Ш.Бадмаа сувилагчаар, Дамбасүрэн галчаар, М.Самбуу тогоочоор ажилласнаар орчин цагийн анагаах ухааны шинэ эмнэлгийн суурь тавигдсан байна. 1942 онд тус суманд бага эмчийн салбар шинээр баригдаж, С.Пагма, Санжаа хэмээх бага эмчтэй ажиллаж байв. 1943-1950 онд Тойв, Норов, 1950-1960 онд Дамбадаржаа, Г.Дулмаа, Лувсанжамбаа, Л.Дамдинжав нар, 1963-1968 он хүртэл Цэнд-Аюуш, Цэрмаа, Цог, Цодномдорж, Рэгзэн, Намсрайжав, Дорж, Жигжид нар ажиллаж байв. Тус сумын хүн эмнэлэг 1962 оноос хоёр асрагчтай болж Рэгзэн, Маам нар ажиллаж байжээ. Мөн 1968-1972 он хүртэл бага эмчийн салбарын эрхлэгчээр Батмөнхийн Сүхээ ажиллаж, бага эмчээр Бадамханд, Гочоо, Үдэнбор, Т.Долгор, Чанцал, Содномдорж эх баригч бага эмчээр Б.Даваасүрэн, сувилагчаар Жамсранжав, багийн эмчээр Г.Дорж, Норовсамбуу нар ажиллаж байсан байна. Төмөрбулаг суманд 1972 онд их эмчийн салбар байгуулагдаж, бага эмчийн салбар дээр хоёр гэр нэмж барин гал тогоо, угаалгын гэртэй болж тогоочоор Цогзолмаа, угаагчаар П.Цэцэгээ нар ажиллаж байлаа. Мөн хүний их эмчийн салбар болон өргөжснөөр эмнэлгийн зориулалтын шинэ барилгыг Нэгдэл дундын үйлдвэрийн барилгачид барин ашиглалтанд оруулж байжээ. Тус сумын анхны их эмчээр Дашдорж ажиллаж байсан бөгөөд 1972 онд анхны түргэн тусламжийн машинтай болж, жолоочоор Д.Балжинням ажиллаж байв. Тухайн үед их эмч-1, бага эмч-2, сувилагч-3, асрагч-3, галч, угаагч, жолооч, тогооч зэрэг 13 орон тоотой ажиллаж эхэлсэн байна. 1980 онд хүний их эмчийн салбарт 2 их эмч, 5 бага эмч, 8 асрагч, 4 үйлчилгээний ажилтан

ажиллаж байсан. Төмөрбулаг сумын хүн эмнэлэг 1998 онд менежментийн хувьчлал буюу удирдлагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулах багаар ажиллах хэлбэрт шилжсэн байна. 1998- 2013 онд Хүний эмнэлэг нэртэй болж 32 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилчидтай болж өргөжиж байсан бол 2013 оноос Эрүүл мэндийн төв нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

**ЭРХЛЭГЧ НАР**

1. Дашдорж 1972- 1974 он
2. Шагдар 1974 -1976 он
3. Б.Гэрэлтуяа 1976 -1978 он
4. Д.Доржханд 1982 1983 он
5. Г.Раазай 1983- 1984 он
6. Нарантуяа 1984- 1985
7. Доржгочоо, Должинсүрэн, Мягмар 1987 -1988 он
8. Л.Оюунцэцэг, Шагжжав 1988- 1993 он
9. Д.Мэнджаргал, Дамбийням, Батбуян 1993 -1994 он
10. С.Баярмаа, Д.Мэнджаргал 1994- 1995 он
11. Ж.Чулуунбат 1995 -1996 он
12. Ч.Цэцэгмаа, Д.Мэнджаргал 1996 он
13. Ч.Цэцэгмаа 1996 оноос одоог хүртэл ЭМТ-ийн даргаар ажиллаж байна.

**БАГА ЭМЧ**

- |                   |                   |
|-------------------|-------------------|
| 1. Балдан-Ёндон   | 17. Г.Дорж        |
| 2. Доржсүрэн      | 18. Ц.Цэнд-Аюуш   |
| 3. Сэргэлэн       | 19. Юмжав         |
| 4. Л.Амарсайхан   | 20. Доржоо        |
| 5. Д.Дашдорж      | 21. Халтар        |
| 6. Б.Сүхээ        | 22. Ч.Сарангэрэл  |
| 7. Цэнд-Аюуш      | 23. Дарьсүрэн     |
| 8. Л.Дамдинжав    | 24. Лхагвасүрэн   |
| 9. Жамсранжав     | 25. Э.Доржсэмбэ   |
| 10. Д.Нансалмаа   | 26. Амарбаясгалан |
| 11. Үдэнбор       | 27. Бадамханд     |
| 12. Содномдорж    | 28. Даваасүрэн    |
| 13. Бямба-Очир    | 29. Д.Энхбаяр     |
| 14. Төмөрхуяг     | 30. Л.Гантөмөр    |
| 15. Т. Даваасүрэн | 31. Ё.Цэрэнпил    |
| 16. Должинжав     |                   |

**СУВИЛАГЧ**

- |                 |                 |
|-----------------|-----------------|
| 1. Амаржаргал   | 16. Нэргүй      |
| 2. Оюундалай    | 17. Намжилмаа   |
| 3. Навчаа       | 18. Цэрэнсодном |
| 4. Цэнгэлчулуун | 19. Энхтуяа     |
| 5. Өлзийбүрэн   | 20. Эннаа       |

- |                   |                 |
|-------------------|-----------------|
| 6. Мөнхжаргал     | 21. Нарантуяа   |
| 7. Гаваасамбуу    | 22. Дуламсүрэн  |
| 8. Баясгалан      | 23. Байгаль     |
| 9. Цагаанчулуун   | 24. Нарангэрэл  |
| 10. Сарантуяа     | 25. Уртнасан    |
| 11. Янжиндулам    | 26. Намжилмаа   |
| 12. Б.Эрдэнэцэцэг | 27. Дамдинжав   |
| 13. Төгсдэлгэр    | 28. О.Чанцал    |
| 14. Оюун          | 29. Цагаанхүү   |
| 15. Батцэцэг      | 30. Э.Сарантуяа |

**ЭМИЙН САНЧ**

- |                 |               |
|-----------------|---------------|
| 1. Т.Даваасүрэн | 5. Батхишиг   |
| 2. Цэдэнсодном  | 6. Бат-Эрдэнэ |
| 3. Цэнгэл       | 7. Саранчимэг |
| 4. Урандэлгэр   | 8. Д.Цээсүрэн |

**ТУСЛАХ АЖИЛТАН**

- |               |                 |
|---------------|-----------------|
| 1. Ц.Уртнасан | 3. Б.Баяржаргал |
| 2. Д.Удвал    | 4. Б.Уламбаяр   |

**НЯ-БО, НЯРАВ**

- |                   |                 |
|-------------------|-----------------|
| 1. Б.Уранмандал   | 8. Р.Ёндонжамц  |
| 2. Мягмаржав      | 9. Ж.Дорж       |
| 3. Ундармаа       | 10. Г.Насанбуян |
| 4. Ч.Лхагвасүрэн  | 11. Ц.Хадбаатар |
| 5. Д.Ганхуяг      | 12. Х.Дашдаваа  |
| 6. Ч.Жаргалсайхан | 13. Д.Цээсүрэн  |
| 7. Я.Мөнх-Эрдэнэ  |                 |

**АСРАГЧ**

- |                   |                   |
|-------------------|-------------------|
| 1. Ж.Эрдэнэчимэг  | 15. Буянжаргал    |
| 2. Мөрөн          | 16. Мөнхөө        |
| 3. Л.Түмэнбаяр    | 17. Уранчимэг     |
| 4. Т.Ичинхорлоо   | 18. Нарантуяа     |
| 5. Л.Дугаржав     | 19. Сэнгээ        |
| 6. Л.Цэрмаа       | 20. Т.Эрдэнэчимэг |
| 7. Буянтогтох     | 21. Ч.Энхцэцэг    |
| 8. Д.Наранхүү     | 22. Л.Түмэнбаяр   |
| 9. Ш.Наран        | 23. Д.Оюунчимэг   |
| 10. Сэрчмаа       | 24. Рэгзэд        |
| 11. Аюуш          | 25. Цэрэндулам    |
| 12. Б.Буян-Ундрах | 26. Сосорбарам    |
| 13. Анхцэцэг      | 27. Амгалан       |
| 14. Ч.Амаржаргал  | 28. Ч.Тэгшбуянт   |

**ТОГООЧ**

1. Цэндээ
2. Туул

**ТУСЛАХ АЖИЛЧИН**

1. Удвал
2. Уламбаяр
3. Уртнасан
4. Ч.Энхтуяа

**ГАЛЧ**

1. Г.Санжаа
2. Ч.Мөнх-Эрдэнэ
3. Ч.Ганбаатар
4. Ц.Лхагва-Очир

**ЖОЛООЧ**

1. Балжинням
2. Жамжаа
3. Лхамсүрэн
4. Болдбаатар
5. Амбалдорж
6. Д.Баатар
7. Л.Батчулуун
8. Ц.Ууганбаяр

**МАЛЧИН**

1. Янжин

**Өнөөгийн төрх**



*Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төв нь өнөөдөр 32 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтантай.*

**Ажилчид**

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төв нь 2007, 2011, 2014 онуудад гурван удаа магадлан итгэмжлэгдсэн. 2004 онд Хөвсгөл аймгийн “Шилдэг хамт олон”-оор шалгарсан. 2010 онд сумын шилдэг хамт олноор шалгарсан. 2013 онд аймгийн ГХУС33-ийн өргөмжлөлөөр шагнуулсан. 2014 онд Монгол ёс заншил сэдэвт уралдаанд тэргүүн байр эзэлж “Шилдэг дүр бүтээгч” хамт олноор шалгарсан. Сүүлийн 18 жил дараалан санхүүгийн



зөрчилгүй, өр, авлагагүй ажилласан. Идэр бүсэд 10 жил дараалан ОУС-ын баяр угтсан гар бөмбөгийн тэмцээнд тэргүүн байр эзэлж шилжин явах цомыг хадгалж байна. 2012 онд ОУС-ын өдрөөр ур чадварын аймгийн уралдаанд сувилагч, тусгай мэргэжилтнүүд багаараа 2-р байр эзэлсэн бөгөөд сүүлийн 14 жил эхийн эндэгдэлгүй ажиллаж байна. Мөн зайлшгүй шаардлагатай эмийн 95 хувийг бүрдүүлж чадсан. Тус суманд 2010 онд 509 сая төгрөгний өртөгтэй, 15 ортой зориулалтын эмнэлгийн байр баригдаж ашиглалтанд оржээ. Эмнэдгийн тоног төхөрөмж, багаж





хэрэгслийг сайжруулах ажилд онцгой анхаарч, 2010 онд 7 төрлийн, 2014 онд 4 төрлийн 21.5 сая төгрөгний багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. 2010 онд лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмж, 2013 онд ММСС-н 14.1 сая төгрөгний багаж тоног төхөөрөм шинээр авсан. 2013 онд “Цахим эмнэлэг” төслөөр 18.1 сая төгрөгний техник хэрэгслээр хангагдсан. 2010 онд 18.6 сая төгрөгний түргэн тусламжийн авто машины парк шинэчлэл хийгдсэн. Японы “Вансэмбэрүү” ТББ-ын өрхийн эмийн сангийн төслийг 2010 – 2014 онд амжилттай хэрэгжүүлсэн. ДЗОУБ-ын дэмжлэгээр “Гал голомт” хөтөлбөр, НЭМ-ийн өрөө, өсвөр үе “Ирээдүйн босго” төвийг нийт 20 сая төгрөгний дэмжлэгээр тохижуулсан.

**ЧОЙЖООГИЙН ЦЭЦЭГМАА**

1959 оны 05 -р сарын 10нд Төмөрбулаг суманд төрсөн. 1968-1970 онд Төмөрбулаг сумын бага сургууль, 1971-1977 онд Мөрөн 1-р 10 жилийн дунд сургуулийг төгсөж , 1977-1983 онд АУДэСургуулийг хүүхдийн их эмч мэргэжлээр төгссөн.

1990 онд УБ хотод халдвартын эмчийн мэргэшил олгох курс, 2001 онд Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийн Эрүүл мэндийн удирдлагын курс, 2003 онд ЭМШУИС-ийн хүүхдийн анагаахын дээшлүүлэх курс, 2003 онд УБ хотод “Эврика” гадаад хэл, компьютерийн курс, 2005 онд Дархан-Уул амгийн АУК-д сумын эмчийн эмнэлзүйн курс, 2008 онд Мөрөн Нэгдсэн эмнэлгийн ЭХО-оношлогооны дагалдан курс, 2010 онд ЭМШУИС-ийн хүүхдийн зүрх судас– эрчимт эмчилгээний дээшлүүлэх курсыг тус тус дүүргэсэн. 2001 онд Анагаах ухааны их сургуулийн магистр цол хүртсэн.



**ДАГВАДОРЖИЙН МЭНДЖАРГАЛ**

1966 оны 12 –р сарын 12 нд Төмөрбулаг суманд төрсөн 1974-1982 онд Төмөрбулаг сумын 8 жилийн дунд сургууль, 1982-1984 онд Шинэ –Идэр сумын 10 жилийн сургуулийг төгссөн. 1984- 1989 онд УБ хотын АУДэС-ийг их эмчийн мэргэжлээр төгссөн.

1992 оноос одоог хүртэл Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвд дотрын их эмчээр ажиллаж байна. 2007 оноос сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгчээр ажиллаж байна.



**ДАРЬСҮРЭНГИЙН БАЯНМӨНХ**

Дарьсүрэн овогтой Баянмөнх 1964 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1972 – 1980 онд тус сумын 8 жилийн дунд сургуулийг төгссөн. 1980-1984 онд Дархан хотын АУДуС-ийг эх баригч бага эмч мэргэжлээр төгсөөд 1984-1987 онд Дорнод аймагт АА-ийн дугаар ангид алба хаасан. 1987 оноос одоог хүртэл тус сумын ЭМТ-д статистикч

бага эмчээр ажиллаж байна.2014 оны 09-р сараас эхлэн 1-р багийн бага эмчээр ажиллаж байна.



**ЖАМБЯНШАРАВЫН БАЯНМӨНХ**

1965 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1973-1981 онд Төмөрбулаг сумын 8-н жилийн дунд сургуулийг, 1981-1985 онд Дархан хот дахь АУДуСургуулийн эмчилгээний ангийг тус тус төгссөн. 1988-2012 оныг хүртэл тус сумын эмнэлэгт эх баригч бага эмчээр ажилласан. 2012 оноос одоог хүртэл 3-р багийн бага эмчээр ажиллаж байна.

**ДОЛГОРСҮРЭНГИЙН ЦЭЭСҮРЭН**

1971 оны 10-р сарын 10-нд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. 1979-1987 онд Төмөрбулаг сумын 8 жилийн дунд сургууль, 1987- 1989 онд Шинэ-Идэр сумын 10н эилийн дунд сургуулийг, 1989 -1990 онд Эрдэнэт хотын ХУТМДС, 1991- 1994 онд Дархан хотын АУДуСургуулийг төгссөн. 1990 -1991 онд тус сумын НАААҮ -ний төвд оёдолчин, 1995- 1998 онд сумын III, IV багт багийн бага эмч, 1998-2007 онд сумын эмнэлэгт бага эмч, ахлах сувилагч, нярав, 2006 оноос одоог хүртэл Эргэлтийн Эмийн сангийн эрхлэгчээр ажиллаж байна.



**СОДНОМБАЛЖИРЫН БОЛОРСАЙХАН**

1985 оны 03-р сарын 03 нд Хөвсгөл аймгийн Жаргалант суманд төрсөн. 1993 -2003 онд Жаргалант сумын 10 жилийн дунд сургуулийг, 2003 -2006 онд Дархан-Уул аймгийн АУК-ийг эх баригч бага эмчийн мэргэжлээр төгссөн.

2006 -2008 онд Төмөрбулаг сумын хүн эмнэлэгт дархлаажуулалт хариуцсан сувилагчаар ажиллаж байгаад 2008 оноос одоог хүртэл эх баригч бага эмчээр ажиллаж байна.



**БУЯНХИШИГИЙН НАРАНЧИМЭГ**

Буянхишиг овогтой Наранчимэг 1970 оны 11-р сарын 14 нд Төмөрбулаг суманд төрсөн. 1991-1994 онд Дархан хотын АУДуС-ийн бага эмч сувилагчийн ангийг төгссөн. 1988 -1991 онд Давшилт компанит ажиллаж байсан. 1994-2005 онд тус сумын 1, 4-р багийн эмч, 2005- 2007 онд автоклавчин бага эмчээр ажиллаж байгаад 2007 оноос одоог хүртэл нийгмийн эрүүл мэндийн бага эмчээр ажиллаж байна.



**ЦЭВЭЭНИЙ ДОРЖПАГМА**

1958 онд Галт суманд төрсөн. 1965-1973 онд Галт сумын 10 жилийн сургууль, 1974-1975 онд ойн ТМС-д жижүүр, 1975-1980 онд Мөрөн I яслид туслах багшаар ажиллаж байгаад 1980-1982 онд Дархан хотын АУДyC-ийн сувилагчийн ангийг төгссөн.

1982 -1990 онд Тээлийн бага эмчийн салбарт эх баригч бага эмчээр, 1990-1995 онд Тээлийн бага эмчийн салбарт сувилагчаар, 1995 он одоог хүртэл 4-р багийн эмчээр тасралтгүй ажиллаж байгаад гарсан.



**ЖАМСРАНГИЙН ГҮНДСАМБУУ**

Жамсран овогтой Гүндсамбуу 1961 онд Галт суманд төрсөн 1970- 1978 онд Галт сумын 8 жилийн дунд сургууль, 1978-1980 онд Мөрөн 1-р 10н жилийн 10-р ангийг төгссөн. 1980-1982 онд Дорноговь аймгийн АУДyC-ийн сувилагчийн ангийг төгссөн. 1982-1986 онд тус сумын 2-р бригадын бага эмчээр ажиллаж байгаад 1987 оноос одоог хүртэл сумын эрүүл мэндийн төвд ээлжийн сувилагчаар ажиллаж байна.



**ЯНЖИНГИЙН БЯМБАСҮРЭН**

Янжин овогтой Бямбасүрэн 1964 оны 06-р сарын 01 нд Улаанбаатар хотод төрсөн. 1972-1980 онд Төмөрбулаг сумын 8 жилийн дунд сургууль, 1980-1982 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн дунд сургуулийг төгссөн. 1983-1987 онд Төмөрбулаг сумын хүүхдийн яслид ажиллаж байгаад 1987-1989 онд АУДyC-ийн сувилагчийн ангийг дүүргэж 2001 онд НЭМ-ийн чиглэлээр мэргэжил дээшлүүлж 1989-1990 онд тус сумын 3-р багийн эмчээр, 1990-2007 онд хүн эмнэлэгт ээлжийн сувилагчаар, 2007-2011 онд 3-р багийн

эмчээр ажиллаж байгаад 2011 оноос одоог хүртэл ээлжийн сувилагчаар ажиллаж байна.



**МАГНАЙБАЯРЫН ЦЭРЭНБАДАМ**

Магнайбаяр овогтой Цэрэнбадам 1966 оны 02-р сарын 26 нд Төмөрбулаг суманд төрсөн. 1974- 1982 онд Төмөрбулаг сумын 8 жилийн дунд сургууль, 1982-1984 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн сургуулийг төгссөн.

1991 онд Дархан хотын АУДyC-ийн сувилагчийн ангийг төгсөөд сувилагч мэргэжлээрээ орон нутагтаа тасралтгүй ажиллаж байна. 2010 оноос ахлах сувилагчаар ажиллаж байна. 2003 онд Дархан



хотын АУДyC-д НЭМ-ийн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн. 2012 онд “Ахлах” зэрэг хамгаалсан.

**БАЛХААГИЙН БАЯНМӨНХ**

Балхаа овогтой Баянмөнх 1968 оны 06-р сарын 18 нд Төмөрбулаг суманд төрсөн. 1976- 1984 онд Төмөрбулаг сумын 8 жилийн дунд сургууль, 1984 -1986 онд Шинэ –Идэр сумын 10 жилийн дунд сургууль, 1986 -1988 онд УБ хотын АУДyC-ийн сувилагчийн ангийг тус тус төгссөн. 2001 онд уламжлалт эмчилгээгээр мэргэжил дээшлүүлсэн. 1988 -1990 онд АА-ийн 013 -р ангид цэргийн алба хаасан. 1990- 2013 онд тус сумын 1-р багийн эмчээр ажиллаж байгаад 2013 оноос одоог хүртэл дархлаажуулалтын сувилагчаар ажиллаж байна.



**ЛАМЖАВЫН МӨНХБАТ**

1974 оны 10-р сарын 24-нд Төмөрбулаг суманд төрсөн. 1983-1993 онд тус сумын 10 жилийн дунд сургууль, 1993-1996 онд Дархан хотын АУДyC-ийг урамжлалын бага эмчийн мэргэжлээр төгссөн. 1996 оноос одоог хүртэл сумын 2-р багийн бага эмчээр тасралтгүй ажиллаж байна. 2004 онд Дархан хотын АУК-д НЭМ-ийн чиглэлээр дээшлүүлэх курс, 2008 онд УБ хотод өрхийн эрүүл мэндийн чиглэлээр дээшлүүлэх курс төгссөн.



**ДАШДЭМБЭРЭЛИЙН НАРАНГЭРЭЛ**

1976 оны 03-р сарын 22нд төрсөн. 1985-1995 онд тус сумын 10 жилийн дунд сургууль, 1995-1999 онд Дархан-Уул аймгийн АУДyC-ийг бага эмч сувилагчийн мэргэжлээр төгссөн. 1999-2001 онд 4-р багийн бага эмчээр, 2001-2005 онд ЕБС-ын эмчээр, 2005-2007 онд 5-р багийн эмчээр, 2007-2012 онд сумын ЭМТ-ийн ариутгагч бага эмчээр, 2012 оноос одоог хүртэл биеийн тамирын арга зүйчээр тус тус ажиллаж эрүүл мэндийн салбарт 13 дахь жилдээ ажиллаж байна.



**ЦЭГМИДИЙН ОТГОНБАЯР**

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 1986 онд төрсөн. 1995-2005 онд тус сумын 10 жилийн дунд сургуулийг, 2006-2009 онд Дархан-Уул амийгийн АУК-ийг эх баригч бага эмчийн мэргэжлээр төгссөн. 2009-2011 онд Дархан-Уул аймгийн Сувилахуйн Дээд сургуулийн эх баригчийн бакалаврын зэрэг хамгаалсан.



2012-2013 онд Төмөрбулаг сумын ЭМТ-д дархлаажуулалтын сувилагчаар ажиллаж байгаад 2013 оноос одоог хүртэл ариутгагч бага эмчээр ажиллаж байна.

**АМАРААГИЙН ОЮУНЧИМЭГ**

1978 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1986-1994 онд тус сумын 10 жилийн дунд сургууль, 1994-1996 онд Тосонцэнгэл сумын 10н жилийн дунд сургуулийн 10-р ангийг төгссөн. 1996-1999 онд Дархан-Уул аймгийн АУК-ийг бага эмч сувилагч мэргэжлээр төгссөн. 2007 оноос одоог хүртэл сумын эрүүл мэндийн төвд сувилагчаар ажиллаж байна. 2014 онд Дархан АУИСургуульд хүүхдийн эрүүл мэндийг чиглэлээ олгох курс төгссөн. 2014 онд дархлаажуулалтын сувилагчийн орлон ажиллахаар бэлтгэгдсэн.



**ГАНБААТАРЫН ЭРДЭНЭЧИМЭГ**

1974 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1981-1991 онд сумын 10 жилийн дунд сургууль, 1991-1994 онд Дархан хотын АУДyС-ийг бага эмч сувилагчаар төгссөн.

1994-1997 онд Дархан хотын Нэгдсэн эмнэлгийн гэмтэл согогийн тасаг сувилагчаар, 1998-2000 онд УБ хотод Хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж байгаад 2008 оноос одоог хүртэл сумын Эрүүл мэндийн төвд сувилагчаар ажиллаж байна.



**СҮРЭНЖАВЫН ОЮУНСҮРЭН**

1970 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1978-1986 онд сумын 8 жилийн дунд сургууль, 1986-1988 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн дунд сургуулийг төгссөн.

1989 оноос одоог хүртэл сумын Эрүүл мэндийн төвд үйлчлэгчийн ажлыг хийж байна. 2013 онд аймгийн ЭМГ-т “Сувилагчийн туслах”-аар бэлтгэгдэж сертификат авсан.



**БААСАНГИЙН БАЯРЖАРГАЛ**

1968 онд Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд төрсөн. 1976-1984 онд тус сумын 10 жилийн 8-р ангийг төгссөн.

1984-1987 онд Өвөрхангай аймгийн УААТМДС-ийг сантехникийн слесарь мэргэжлээр төгсөж, 1987-1990 онд Нэгдэл Дундын үйлдвэрт ажиллаж байгаад 1993-1997 онд Төмөрбулаг сумын эмийн



санд үйлчлэгч, 1997 оноос одоог хүртэл тус сумын эрүүл мэндийн төвд үйлчлэгчээр ажиллаж байна. 2013 онд аймгийн ЭМГ-т “ Сувилагчийн туслах” –аар бэлтгэгдэж сертификат авсан.

**ТӨВДИЙН ЗҮМБЭРЭЛДОРЖ**

1972 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. 1980-1988 онд сумын 10 жилийн дунд сургууль, 1988-1990 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн дунд сургуулийг төгссөн.

1990-1994 онд НАААУ-ний төвд оёдолчноор ажиллаж байгаад 2001 оноос одоог хүртэл тус сумын эрүүл мэндийн төвд үйлчлэгчээр ажиллаж байна.



**ДАШБАЛЖИРЫН НЭРГҮЙ**

1970 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1978-1986 онд сумын 8 жилийн дунд сургууль, 1986-1988 онд Шинэ-Идэр сумын 10н жилийн дунд сургуулийг төгссөн. 2003 онд тогооч, нарийн боовчны курс төгссөн.

2008 онд “Ахмад настны зөв зохистой хооллолт“, 2009 онд эмчилгээний хоолны курс төгссөн. тогоочийн курс, 1995 оноос одоог хүртэл сумын эмнэлэгт тогоочоор ажиллаж байна.



**ЛХАМСҮРЭНГИЙН АРИУНЦЭЦЭГ**

1970 онд Улаанбаатар хотод төрсөн. 1979-1987 онд Төмөрбулаг сумын 8 жилийн дунд сургууль, 1987-1989 онд Тариалан сумын 10н жилийн дунд сургуулийг төгссөн.

1989 -1990 онд хүүхдийн яслид асрагчаар ажиллаж байгаад 2005 оноос одоог хүртэл сумын Эрүүл мэндийн төвд үйлчлэгчийн ажлыг хийж байна.



**БАЛЖИННЯМЫН БААСАНЧУЛУУН**

1980 онд Мөрөн суманд төрсөн. 1988-1996 онд Мөрөн 1-р 8 жилийн дунд сургуулийг төгссөн. 2002 онд Батлан хамгаалахын туслах нийгэмлэгийн жолооны курс төгссөн. 2006 оноос одоог хүртэл Төмөрбулаг сумын эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто амшины жолоочоор ажиллаж байна.





**ДАШБЯМБЫН ӨНӨРСАЙХАН**

1972 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1980-1988 онд сумын 8 жилийн дунд сургууль, 1988-1990 онд УБ хотын НАААҮ-ийн сантехникийн ангийг төгссөн. 1992 оноос одоог хүртэл эрүүл мэндийн төвд слесариар ажиллаж байна.



**МАГНАЙБАЯРЫН ӨНӨРЦЭЦЭГ**

1976 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1983-1991 онд тус сумын 8 жилийн дунд сургуулийг төгссөн. 2001 оноос одоог хүртэл эрүүл мэндийн төвд угаагчаар ажиллаж байна.



**ДАМДИНЖАВЫН САНДАГСҮРЭН**

1956 онд Бүрэнтогтох суманд төрсөн. 1964 онд тус сумын бага сургуулийг төгссөн. 1974-1977 онд АА-д цэргийн алба хаасан. 1978 онд барилгын өрлөгчний курс төгссөн. 1979-1997 онд Нэгдэл дундын үйлдвэрт барилгын өрлөгчний ажил хийж байсан. 1997 оноос одоог хүртэл Төмөрбулаг сумын эрүүл мэндийн төвд галчаар ажиллаж байна.



**ЛУВСАНГИЙН БАТ-ЭРДЭНЭ**

1961 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1969-1977 онд сумын 8 жилийн дунд сургуулийг төгссөн. 1974-1977 онд АА-д алба хаасан. 1981-1989 онд Нэгдэл дундын үйлдвэрт цахилгаанчин байгаад 1994 оноос одоог хүртэл Төмөрбулаг сумын эрүүл мэндийн төвд галчаар ажиллаж байна. 2010 онд Хөвсгөл аймгийн “Хөх даваа” сургалтын төвд сантехникийн мэргэжлээр курс төгссөн.



**ЦЭРЭНДОРЖИЙН СОРОГДОНГАРАВ**

1984 онд Архангай аймгийн Цэцэрлэг суманд төрсөн. 2010 оноос одоог хүртэл тус сумын эрүүл мэндийн төвд галчар ажиллаж байна. 2010 онд Хөвсгөл аймгийн “Хөх даваа” сургалтын төвд сантехникийн чиглэлээр курс төгссөн.

**ЧОЙЖООГИЙН ЭНХТУЯА**

1964 оны 11-р сарын 17-нд Төмөрбулаг суманд төрсөн. 2000 оноос одоог хүртэл Эмийн эргэлтийн санд үйлчлэгчээр ажиллаж байна.



**МАГНАЙБАЯРЫН АЗБИЛЭГ**

1974 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1982-1992 онд тус сумын 10 жилийн дунд сургуулийг, 2004-2008 онд Хөвсгөл аймгийн Далай ван коллежийг нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. 1995-2002 онд сумын хүний эмнэлэгт үйлчлэгчээр ажиллаж байгаад 2010 оноос одоог хүртэл эрүүл мэндийн төвд няраваар ажиллаж байна.

**ГАНЦООЖИЙН БАТХҮҮ**

1987 онд төрсөн. 2004 онд ХААИС-ийн ЭЗБСургуульд элсэн суралцаж 2008 онд Бизнесийн удирдлагын ангийг бакалавр зэрэгтэй төгссөн. 2009 оноос Төмөрбулаг сумын ЭМТ-д нягтлан бодогчоор ажиллаж байна.



**ПҮРЭВИЙН ЦЭНД-АЮУШ**

1983 онд Арбулаг суманд төрсөн. 2000-2003 онд УБ хотын АУК-ийг лабораторийн ангийг төгссөн. 2003-2011 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгийн үйл оношийн тасагт лаборант, 2011-2012 онд Ренчинлхүмбэ сумын ЭМТ-д лаборант, 2012 оноос одоог хүртэл Төмөрбулаг сумын ЭМТ-д лаборантаар ажиллаж байна.



**ЖАРГАЛСАЙХАНЫ АРИУНЖАРГАЛ**

1987 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1995-2005 онд сумын 10 жилийн дунд сургууль, 2011-2014 онд УБ хотын ЭМШУИС-ийн харъяа Сувилахуйн сургуулийг төгссөн. 2014 оны 07-р сараас эхлэн тус сумын эрүүл мэндийн төвд дүн бүртгэгчээр ажиллаж байна.



*Ахмад ажилчид*

**ТҮНДЭВИЙН ИЧИНХОРЛОО**

Түндэв овогтой Ичинхорлоо 1931 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Их Булан хэмээх газар төрсөн. Тэрээр 1954-1982 онд гэр бүлийн хамт “Давшилт” нэгдэлд мал маллаж байгаад 1982-1991 онд тус сумын хүний их эмчийн салбарт үйлчлэгчээр ажиллаж байгаад гавъяаныхаа амралтанд гарсан.



**ЁНДОНЖАМЦЫН ЦЭРЭНПИЛ**

1955 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1963-1971 онд сумын 8 жилийн сургууль төгсөөд 1974 онд УБ хотын АУДyC-ийн сувилагчийн курс төгссөн.

1975 онд Мөрөн хотын нэгдсэн эмнэлэгт сувилагч, 1980 оноос Төмөрбулаг сумын хүний эмнэлэгт ээлжийн сувилагчаар, 1986-2007 онд 3-р багийн эмчээр ажиллаж байсан. 2009 оноос одоог хүртэл тус сумын Сэргээн засах үйлчилгээний өдрийн төвд бага эмчээр ажиллаж байна.



**РЭНЧИНЖҮГДЭРИЙН ЦАГААНХҮҮ**

1960 онд Бүрэнтогтох суманд төрсөн. 1978- 1980 онд УБ хотын АУДyC-ийг сувилагч мэргэжлээр тус тус төгссөн.

1980- 2012 онд Төмөрбулаг сумын хүний эмнэлэгт сувилагчаар тасралтгүй ажиллаж байсан. Одоо гавъяаныхаа амралтанд гарсан.

**ДАМБЫН НАНСАЛМАА**

Тэрээр Төмөрбулаг сумын 2-р бригадын нутаг Сайрын ам гэдэг газар төрсөн.

Улаанбаатар хотод Анагаах ухааны дунд сургууль төгсөөд хоёрдугаар эмнэлэгт ажиллаж байсан.

Тэрээр 1978 онд төрсөн нутаг Төмөрбулаг сумандаа очин сумын эмнэлэг, 2, 3-р бригадын бага эмч,

Тариатын бага эмчээр ажиллаж, 18 хүүхэд эх барьж авч байжээ.


**ДАШДЭЛЭГИЙН ӨЛЗИЙДҮҮРЭН**

Дашдэлэг овогтой Өлзийдүүрэн нь 1965 онд төрсөн. Тэрээр Улаанбаатар хотын Сальвадер Алеондогийн нэрэмжит Анагаах ухааны соёлч дунд сургуульд элсэн орж 4 жил суралцаж “Эх баригч бага эмч” мэргэжил эзэмшсэн.

Бага эмч Д.Өлзийдүүрэн нь эрүүл мэндийн салбарт тасралтгүй 28 жил ажиллаж байгаа бөгөөд 1999 оноос Зоонозын өвчин судлалын үндэсний төвд халдвар судлалын хяналт, дархлаажуулалт, дуудлага хяналтын бага эмчийн ажлуудыг хийж байна.

Д.Өлзийдүүрэн нь 2006 онд ЗӨСҮ Төвийн “Хүндэт тэмдэг”, 2007 онд ЭМЯ-ны “Жуух бичиг”, Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн “Хүндэт тэмдэг”, 2009 онд “Нийслэлийн эрүүл мэндийн газрын тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2011 онд “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдгээр тус тус шагнагдсан. 2013 онд ажил мэргэжлээрээ хамт олноо хошуучлан шалгарч “Оны шилдэг ажилтан” болж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдаж байсан.

**ТӨМӨРБУЛАГ СУМЫН ХОЛБООНЫ САЛБАР**



Тус сумын 6,7,8-р багийн ардууд нийлж, 1950 оны зун, намар Тал булаг чиглэлийн утасны шон мод авч бэлтгэх, нүх ухах ажилд хүчин зүтгэсний үр дүнд арван хоёрдугаар сарын 30-нд годон шугам буюу нэг гинжтэй шугам ашиглахад бэлэн болж сумын төвд Мятавын хувийн байшинд МБ аппараттай телефон апарат анх суурилуулснаар харилцаа холбооны салбар Төмөрбулаг суманд анх үүссэн түүхтэй.

Анхны эрхлэгчээр Холбооны ахмад ажилтан Дампилын Лувсан ажиллаж байлаа. Холбооны салбар анх байгуулагдсан цагаас хойш Лүүлүү, Сэрээнэн, Базардэндэв, Ж.Бат-Очир, Т.Ламжав, П.Цэцгээ, С.Чойжил нар эрхлэгчээр, монтёр залгагчаар Дэмбэрэл, Магсар, Ухнаа, Д.Далайхутаг, Ч.Төгсдэлгэр, Д.Төмөрбаатар, Д.Түмэндэлгэр, Ч.Батчимэг, Б.Мөнхбат нар, жолоочоор Х.Шагдар, Цогоо, Д.Дашням нар ажиллаж байсан ба 1999 оноос өнөөг хүртэл салбарын эрхлэгчээр Б.Энхтуул ажиллаж байна.

Тус сумын холбооны салбарт 1966 онд ТУ-100 радио өсгөгч тавьж, техникийн шинэчлэлт хийгдэж эхэлсэн бөгөөд 1981 онд У100-101 өсгөгч, 1986 онд ТПС-58 радио өсгөгчтэй болж, 1987 онд холбооны Экран-КР орбит станц ашиглалтанд орж анх сумын төвийн найман айл



*Ахмад холбоочин, анхны эрхлэгч нарын нэг Ж.Бат-Очир*

телевизийн нэвтрүүлэг хүлээн авч үзэж эхэлсэн байна.

1986 онд МБ-25 маркын гар ажиллагаатай телефон аппарат, 1992 оноос хагас автомат, 1993 оноос КРД-Т 200\*50 номерийн АТС тавигдаж, 1991 онд үндэсний телевизийн нэвтрүүлэг дамжуулах Азиасат станц суурилагджээ. 2005 оны долдугаар сард АТС-ын өргөтгөл хийж С12-48 станц ашиглалтанд орж мөн оны наймдугаар сард Нарны зайн үүсгүүр тавигдаж ашиглалтанд орж байлаа.

2007 онд телевизийн дөрвөн суваг хүлээн авч үзэж эхэлсэн бол 2010 онд телевизийн зургаан сувгийн нэвтрүүлэг хүлээн авч үзэж эхэлсэн юм. Харин 2014 оны долдугаар сарын 31-нд телевизийн тоон системд шилжээд байна.

2008 онд шилэн кабель татагдаж Мобиком, Скайтел, Юнител, Жи-мобайлын сүлжээ орж ирснээр ард иргэд Мобиком, Скайтел, Юнител, Жи-мобайлын суурин болон гар утаснуудыг ашиглаж байна.

Мөн MSAN станц ашиглалтанд орж одоогийн байдлаар интернэтийн 20 цэг, суурин телефоны 25 цэг, 7 компьютертэй интернэт кафе ажиллаж байна.

Юнител ХХК 2011 онд өргөтгөл хийснээр хүчин чадал холбоо барих алслал нэмэгдсэн бөгөөд 2014 оны долдугаар сард Скайтел ХХК ийн өргөтгөлөөр 3G өндөр хурдны сүлжээ нэвтрээд байна.

2013 онд Мэдээллийн технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газрууд хамтарч сумдад “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ” байгуулах ТН-03/12 тоот төслийн хүрээнд шилэн кабелиар тавигдсан өндөр хурдны интернэтийг ЗДТГ, ЭМТ, ЕБС-д тус бүр 1 компьютер ашиглаж байна. Мөн бодит хурдны свич суурилуулжээ. Үүний үр дүнд Холбооны салбараас 500м-ын алслалд интернетийн утасгүй сүлжээ барих Wi-Fi төхөөрөмж суурилагдан, ашиглагдаж байна.



Залгагч Түмэндэлгэр

### БАЛЖИННЯМЫН ЭНХТУУЛ

Б.Энхтуул 1970 онд Архангай аймагт төрсөн. 1985 онд Улаанбаатар хотын Холбооны сургалтын төвд орж 1989 онд радиотехникч мэргэжлээр төгсөөд Булган аймагт ажиллаж байсан. Тэрээр 1999 оноос эхэлж Төмөрбулаг сумын Холбооны салбарын эрхлэгчээр ажиллаж байна. 2009 онд Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газрын “Жуух бичиг”, 2011 онд Мэдээлэл, Харилцаа Холбооны Тэргүүний Ажилтан тэмдгээр тус тус шагнагдаж байсан.



## ТӨМӨРБУЛАГ СУМЫН СОЁЛЫН ТӨВ

Тус сумын хөдөлмөрчид 1946 онд хөрөнгө хуримтлуулж “Улаанбулан” байгуулах болж Ёргоон, Цанжид тэргүүтэй хэсэг мужаан уг барилгыг барьж 1947 онд ашиглалтанд өгснөөр Төмөрбулаг суманд мэргэжлийн урлагын байгууллагын үндэс суурь тавигдсан юм. Тус соёлын төвийн анхны эрхлэгчээр нь Сүхийн Хуушаан хэмээх хүн ажиллаж байлаа.

Тухайн үед ахмад уран сайханч Ч.Мандшир, У.Сэргээ, Х.Нүүгээ, Ө.Ичинхорлоо нарын 20 гаруй уран сайханчид “Хурц”, “Бээжин лам” зэрэг жүжиг тоглож, нутгийн ард иргэдэд урлаг соёлоор үйлчилж байжээ.

Нэгдэл дундын үйлдвэрийн барилгачид 1976 онд 250 хүний суудалтай одоогийн соёлын төвийг барьж ашиглалтанд өгснөөр соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэх нөхцөл боломж сайжирсан юм. 1985-1990 он хүртэл клубын эрхлэгч Г.Цэрэндаш хөгжмийн багш С.Даваадоржоор ахлуулсан “Таван эрдэнэ”, “Залуус” хамтлаг байгуулагдаж, сум орон нутаг болон зэргэлдээх аймаг сумдаар тоглолт хийж сум орон нутгийн соёл урлагийн арга хэмжээг сурталчилж байлаа. Мөн уран сайханч Д.Төмөрхуяг, Ц.Дэлгэрмөрөн, Г.Эрдэнэ-Очир, Д.Амарсанаа, Ч.Мөнхтуяа, Б.Наранчимэг, М.Нямдэлгэр, Б.Уртнасан зэрэг 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй үндэсний хөгжмийн хамтлаг байгуулж, сумын иргэдэд тоглолт хийж, бүжиг явуулж, урлаг соёлын үйлчилгээг үзүүлж байлаа. Сумын соёлын төв нь хөдөөгийн болон сумын төвийн хөдөлмөрчдөд соёл урлагаар үйлчлэхийн сацуу автоклуб байгуулж гадаад болон дотоодын урансайхны киногоор үйлчилдэг байлаа. Түүнчлэн сумын нийтийн номын сан тухайн үед шинээр хэвлэгдэн гарч ном хэвлэлийг ард түмэнд хүргэж, номын фондыг арвижуулан ажиллаж байлаа. Тус соёлын төв нь 2007 оны аравдугаар сарын 01-нээс бүтэц зохион байгуулалтын хувьд шинэчлэгдэн, таван орон тоотой үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Соёлын төвийн эрхлэгчээр Б.Энхжаргал, Хөгжмийн багш, Б.Пүрэв-Осор, дуу бүжгийн багш Б.Дагвадорж, номын санч Л.Цэцэгмаа үйлчлэгч Ч.Амаржаргал нар ажиллаж байгаад 2008 оноос Соёлын төвийн эрхлэгчээр М.Нямдэлгэр, бүжгийн багшаар Я.Нарантуяа нар томилогдон ажиллаж байсан юм. Өнөөдөр Соёлын төвийн эрхлэгчээр Б.Шүрэнцэцэг, хөгжмийн багшаар Б.Энхжаргал, ОНСТА-аар Б.Пүрэв-Осор, бүжгийн багшаар Д.Цэрэннадмид, номын санчаар О.Даваадорж, үйлчлэгчээр Ч.Амаржаргал нар ажиллаж байна.



Төмөрбулаг сумын уран сайханчид 1965 он



*Эрхлэгч Б.Шүрэнцэцэг, Бүжгийн багш Д.Цэрэннамид,  
Хөгжмийн багш МУСТА Б.Энхжаргал, Номын санч  
О.Даваадорж, ОНСТ-ийн ажилтан СТА Б.Пүрэв-Осор*

Сумын Соёлын төв нь бүтэц зохион байгуулалтын хувьд зургаан орон тоотой, төв, хөдөөгийн таван багт урлаг соёл, мэдээ мэдээлэл, номын сан, хөгжим бүжгийн дугуйлан, олон талт уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулж, үр бүтээлтэй ажиллаж байна. Соёлын төв нь баг, байгууллагын дунд ардын урлагийн наадам, бүсийн наадам, хөгжим бүжгийн дугуйлан, хөгжим бүжгийн тайлан тоглолт, ахмадуудын дунд урлагийн наадам, багуудын өдөрлөг, шинэ жилийн үйл ажиллагаа, өдөрлөг үдэшлэг, соёл спортын уралдаан тэмцээн зохион байгуулж, багт явуулын номын сан, шинэ номын үзэсгэлэн, уншигч клубын сурагчдын үйл ажиллагаа, соёлын биет болон биет бус өвийг бүртгэх, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, бүртгэл мэдээллийн сангийн ажил зэрэг олон ажлыг тогтмол явуулан Засгийн газраас хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг сум орон нутагт хэрэгжүүлэн амжилттай ажиллаж байна. Түүнчлэн аймаг бүсийн олон уралдаан тэмцээнд амжилттай оролцож 2013 онд Хөвсгөл аймгийн Олон ястны урлагийн их наадамд хамт олноороо шилдэг сумаар шалгарч байлаа.

Соёлын төвийн номын сан нь өдгөө 9.800.572 төгрөгийн 4722 ширхэг номтой, интернет төвтэй, орчин үеийн техник хэрэгслээр бүрэн хангагдаж “Уншигч клуб”-ыг тогтмол ажиллуулан, Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал болон бусад олон төрлөөр сайн ном уншсан иргэд, хүүхдүүдийг шагнаж урамшуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Соёлын төвийн Орон нутаг судлах танхим нь бүртгэл мэдээллийн гурван сантай, 69 дэсийн 151 үзмэртэй бөгөөд фондыг жил бүр баяжуулан ажиллаж байна. Мөн соёлын үл хөдлөх биет дурсгалыг ойролцоох малчин иргэдэд гэрээгээр эзэмшүүлэн, харуул хамгаалалтын асуудлыг шийдэж байгаа бөгөөд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг гэрчилгээжүүлэн тэдгээрийг үр хойчдоо өвлүүлэн уламжлуулах талаар олон ажлыг зохион байгуулсаар байна.



**2014 оны Ардын хувьсгалын 93 жилийн баярын үеэр**



**Соёлын төвд ажиллаж байсан үе үеийн эрхлэгчид**

<i>№ Үе үеийн эрхлэгч</i>	<i>Он цаг</i>
1. С.Хуушаан	1947-1950
2. н.Гүржав	1950-1953
3. н.Дамдинсүрэн	1953-1956
4. Г.Дашдаваа	1957-1960
5. Д.Түмэндэмбэрэл	1960-1962
6. Д.Сүхээ	1962-1974
7. Г.Дашдорж	1974-1976
8. Д.Цагаач	1977-1978
9. Н.Бямбасүрэн	1978-1979
10. Н.Гомбосүрэн	1980-1981
11. Б. Пүрэв-Осор	1982-1983
12. Г.Цэрэндаш	1983-1988
13. С.Даваадорж	1988-1990
14. Б.Пүрэв-Осор	1990-1992
15. Н.Намбал	1993-1995
16. Ж.Түмэнжаргал	1995-1996
17. Д.Ганхуяг	1996-1998
18. Б.Энхжаргал	1998-2008
19. М.Нямдэлгэр	2008-2010
20. Б.Шүрэнцэцэг	2011 оноос

**Үе, үеийн кино механикчид**

<i>№ Кино механикчид</i>	<i>Он цаг</i>
1. н.Агваан	1964-1966
2. н.Базардэндэв	1967-1977
3. Б.Дашдорж	1978-1981
4. н.Цэдэн	1981-1984
5. Л.Бат-Эрдэнэ	1984-1986
6. С.Сүхбаатар	1986-1990
7. Ж. Дагвадорж	1990-1992
8. Ц.Дашзэвэг	1993-1996
9. С.Даваадорж	1996 оноос

**Соёлын төвд ажиллаж байсан үе үеийн номын санчид**

<i>№ Номын санчид</i>	<i>Он цаг</i>
1. Л.Замбал	1969-1970
2. Л.Нина	1970-1974
3. Ц.Чанцал	1974-1978
4. н. Цэрэнханд	1978-1988
5. Л.Цэцэгмаа	1988-2008
6. Ч.Пунцагдулам	2009-2010
7. О.Даваадорж	2011 оноосодоогхүртэл

**Соёлын төвд ажиллаж байсан үе үеийн үйлчилгээний ажилчид**

<i>№ Үе үеийн үйлчилгээний ажилчид</i>	<i>Он цаг</i>
1. Д. Жавзмаа	1962-1969
2. Д. Занданхүү	1970-1974
3. Д.Цэрмаа	1974-1980
4. Р.Банк	1980-1985
5. П.Цэцэгээ	1985-1998
6. Ч.Амаржаргал	1998-2006
7. Д.Амарсанаа	2007-2008
8. Ч.Амаржаргал	2008-2010
9. М.Нямдэлгэр	2010-2011
10. Ч.Амаржаргал	2011-2014

Тус сумын Соёлын төвд 2007 оноос хөгжмийн багш, бүжгийн багшийн орон тоо шинээр нэмэгдэж, хөгжмийн багшаар Б.Пүрэв-Осор, Б.Энхжаргал нар ажиллаж байна. Бүжгийн багшаар Б.Дагвадорж, Нарантуяа нар ажиллаж байсан бөгөөд Д.Цэрэннадмид 2011 оноос одоог хүртэл ажиллаж байна. Соёл урлагийн салбарт зүтгэсэн олон ахмад уран сайханчид бий. Өнөөдөр бидний дунд н.Должинсүрэн, Д.Лхамсүрэн, Р.Наранцэцэг, Г.Нансалдулам, Ж.Сосорбарам, Д.Цэцэгээ, М.Бямбачулуун, Ж.Нямсүрэн, Н.Мягмарчулуун, Л.Лхагвасүрэн, С.Давааням, З.Цэрэнханд нарын ардын авьяастанууд ажиллаж амьдарч байна. Тэргүүний ардын авьяастан Д.Оюунчимэг, Улсын тэргүүний ардын авьяастан Д.Далайжаргал, Улсын тэргүүний ардын авьяастан Д.Амарсанаа, Шилдэг ардын авьяастан Ч.Цэдэвсүрэн, Б.Уртнасан, Д.Төмөрхуяг, Ма.Нямдэлгэр, Н.Бямбаа, Л.Чойжилжав Б.Дагвадорж, Ц.Жаргалсайхан, О.Цэдэндамба, Л.Энхчимэг тэргүүтэй уран бүтээлчид бий. Мөн тус сумын уугуул Я.Нарантуяа Дархан хотын Залуучууд театрт бүжигчнээр, Д.Дэлгэрмаа Хөвсгөл аймгийн хөгжимт драмын театрын гоцлол дуучнаар Б.Бямбаа зураачаар, Д.Отгонбат монгол зургийн зураачаар ажиллаж амьдарч байна.

**Төмөрбулаг сумын уугуул Соёл урлагийн чиглэлээр төрийн одон Медаль авсан хүмүүс**

<i>№ Овог нэр</i>	<i>Авсан гавьяа шагнал</i>
1. Ч.Мөнхшүр	МУАЖ
2. Н.Цагаач	МУСГЗ
3. Ж.Эрдэнэбилэг	МУСТА
4. Ж.Жаргалсайхан	МУСТА
5. Р.Ганболд	МУСТА
6. Л. Мягмарсүрэн	МУСТА
7. Г. Нарантуяа	МУСТА
8. З.Лхамсүрэн	МУСТА
9. Б.Пүрэв-Осор	МУСТА
10. Б.Энхжаргал	МУСТА



### СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Б.ШҮРЭНЦЭЦЭГ

1988 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. 1996 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Ерөнхий боловсролын сургуульд элсэн орж суралцаж байх хугацаандаа дөрвөн жил дараалан Сургуулийн хөгжмийн аварга сурагч, 2005 оны сургуулийн шилдэг сурагч, Хөвсгөл аймгийн хүүхдийн төлөө төвийн “Авьяас” алтан медаль хүртэж байсан. 2006 Монгол Улсын Их Сургуульд элсэн суралцаж 2010 онд төгсөн. Хүмүүнлэгийн Ухааны Их сургуульд 2012 онд Соёл судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. Суралцаж байх хугацаандаа “Монгол гэрийн хөгжил хувьсал”, “Буган чулуун хөшөөг Соёлын аялал жуулчлалын үзмэр болгох нь” сэдвүүдээр эрдмийн ажил бичсэн. 2010-2011 он хүртэл ерөнхий боловсролын сургуульд багшаар ажиллаж байгаад 2011 оноос соёлын төвийн эрхлэгчийн албыг хашиж байна.



### Б.ПҮРЭВ-ОСОР

Б.Пүрэв-Осор нь 1960 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Тариатын Гурван гүвээ гэдэг газар төрсөн. 1968 онд сумын бага сургуульд орж 1976 онд Ерөнхий боловсролын 8 дугаар анги, 1978 онд 10 дугаар анги дүүргэж 1978 онд цэргийн албанд татагдаж дугаар ангид цэргийн албыг 3 жил хаан орон нутагтаа ирж клубын эрхлэгчийг 1982-1983 онд ажиллаж 1983 оноос сумын Хувьсгалт залуучуудын эвлэлийн үүрийн нарийн бичгийн даргаар 1988 оныг дуустал ажиллаад 1988 оноос сумын Ахуй үйлчилгээний төвийн эрхлэгч 1990 оноос Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний даргаар 1996 он, 2000 оноос Соёлын төвийн

эрхлэгч хөгжмийн багш зэрэг ажлуудыг өнөөг хүртэл хийж улсад нийтдээ 27 жил ажиллаж байна. Сум орон нутгийн иргэдийн дунд соёлыг түгээн дэлгэрүүлэх орчин үеийн болон ардын уламжлалт урлагийг сурталчлах зорилгоор сумын клубын дэргэд залуучуудын дунд цахилгаан хөгжмийн “Энхийн айзам” хамтлаг мөн үндэсний хөгжмийн “Таван эрдэнэ” хамтлаг байгуулж Завхан, Хөвсгөл аймгийн сумдуудаар урлагийн тоглолт хийж давхардсан тоогоор 30 гаруй мянган хүнд үйлчилсэн. БНМАУ-ын Засгийн Газрын хүндэт жуух бичиг, ЗХУ-ын Байгаль Амурын хилийн цэргийн 2-р зэргийн онц хилчин, Цэргийн алдар медаль, МХЗЭТХ-ны хүндэт жуух бичиг, МУСТА цол тэмдэг бусад ойн медалиудаар шагнагдаж байсан.

### Б.ЭНХЖАРГАЛ


Б.Энхжаргал нь 1973 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. 1981 онд тус сумын Ерөнхий боловсролын сургуульд элсэн орж 1991 онд 10 жилийн сургуулийг төгссөн. Сум орон нутагт анх бизнес эрхлэж байгаад 1996 оноос сумын Соёлын төвд хөгжмийн багш, эрхлэгч зэрэг ажлыг 19 жил тасралтгүй хийж байна. Энэ хугацаандаа сум орон нутагт зохион байгуулж байгаа соёл урлагийн ажлыг чанартай зохион байгуулж нутгийн тухай олон уран бүтээл туурвиж олны хүртээл болгосон. МУСТА цол, Хүүхдийн байгууллагын 80 жилийн ойн медаль, Аймаг байгуулагдсаны 80 жилийн ой, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, Сумын 80 жилийн ой, Монгол улсын онц тээвэрчин, 1989 оны тэшүүрийн Идэрчүүдийн улсын аврагын алт, мөнгө, хүрэл медальтай, тэшүүрийн спортын 1-р зэрэг хүртсэн байна. Одоо тус сумын Соёлын төвд хөгжмийн багшаар ажиллаж байна.

### С.ДАВААДОРЖ

1962 онд төрсөн. 1970-1980 онд ЕБСургуульд суралцаж төгсөөд 1980-1982 онд Эрдэнэт хотын Уул уурхайн ТСМ-д беладын жолооч.

1982-1985 онд ардын армийн дугаар ангид цэргийн алба хааж 1985-1996 оныг хүртэл клубын эрхлэгч, хөгжмийн багшаар.

1986 оноос одоог хүртэл кино механикчаар ажиллаж байна.



### Л.БАТ-ЭРДЭНЭ

Төмөрбулаг суманд 1961 онд төрсөн. Тус сумын клубт 1982 онд галчаар ажиллаж байгаад 1984-1986 оныг дуустал кино механикчаар ажиллаж 1985 онд нүүдэлийн кино үйлчилгээгээр аймагтаа 3-р байранд шалгарч байсан. Одоо эрүүл мэндийн төвд галчаар ажиллаж байна.

### Ж.ЭРДЭНЭБИЛЭГ

Жигжидийн Эрдэнэбилэг 1953 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод төрсөн. Төмөрбулаг сумын уугуул. Тэрээр 1961-1969 онд Мөрөн хотын 1-р сургуульд, 1969-1973 онд Улаанбаатар хотын багшийн сургуулийн хөгжмийн багшийн ангид суралцсан. 1973-1975 онд Мөрөн хотын найман жилийн дунд сургуульд дуу хөгжмийн багш, 1975-1976 онд Аймгийн соёлын ордонд хөгжимчин, 1976 оноос өнөг хүртэл Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрт хөгжимчин, хөгжмийн багш, удирдаач, дарга уран сайхны удирдаач, зэрэг ажлуудыг гүйцэтгэж ирлээ. 1980 онд УБДС –ийн хөгжмийн багш, удирдаачийн дээд курс суралцсан. Ж.Эрдэнэбилэг нь Хөвсгөл аймгийн ХДТ-ыг анх байгуулахад тулгын чулууг нь тавилцсан ахмад уран бүтээлч юм. Ж.Эрдэнэбилэг ажилах хугацаандаа ардын хувьсгалын 60,70,80 жилийн ойн медалиуд, МУСТА цол тэмдэг, Эвлэлийн төв хорооны тэргүүний залуу алтан медаль, Аймгийн тэргүүний ажилтан цол тэмдэг, Хөдөлмөрийн хүндэт медалиар тус тус шагнагджээ.

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСАГ

Тус суманд 1933 онд Тамшаа хэмжээх Д.Шарав нь малын санитарчаар ажиллаж, Төмөрбулаг суманд мал эмнэлгийн салбар үүсч хөгжих үндэс суурийг тавьжээ. Мал эмнэлгийн салбарын анхны малын их эмч Ч.Алтангэрэл, малын бага эмч Д.Шарав, ерөнхий зоотехникч Намсрай, шинжлэгч их эмч П.Чулуунбаатар, аптекийн бага эмч С.Данаажав, жолооч Ш.Ганболд нар ажиллаж, мал эмнэлгийн салбарын анхны эрхлэгч нь малын бага эмч Д.Шарав байлаа.



Дээд эгнээнд: *Б.Алтанхуяг, Г.Дашибямба, Л.Бат-Өлзий, Ёлгоо.*  
Доод эгнээнд: *Х.Чулуунбаатар, Л.Данаажав, Д.Доржпагма, Нэгдлийн дарга Т.Батбаяр, Чутнай, Б.Төртогтох*

Малын бага эмч Д.Шараваас хойш 1939 онд Р.Даваа, 1942 онд Б.Санжжав, санитарчаар С.Галсандамба, Ц.Лосол, 1945 онд бага эмчээр Л.Доржжүгдэр, 1951 онд Б.Ичинноров, 1956 онд Сосорбарам, 1955-1956 онд Ц.Жамсран, 1959 онд Чадраабал, 1959-1961 онд Эрдэнэ-Очир, 1961 онд Б.Диваарагчаа, Гэрэлчулуун, санитарчаар Барамсай нар ажиллаж, 1965 онд малын их эмчийн салбар бий болж 1 их эмч, 2 бага эмч, 1 санитарч, 1 зоотехникч, бүгд 5 орон тоотойгоор улсын мал эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус салбарт анхны малын их эмчээр Чоймбалын Алтангэрэл 1965-1973 онуудад ажиллаж байв. Мөн 1973-1984 онуудад Пүрэвжавын Чулуунбаатар их эмчээр, Б.Түдэвдорж шинжлэгч их эмчээр, Аюурзана 1976-1978 онд тасгийн эрхлэгчээр ажиллаж байжээ. Барамсайн Төртогтох нь 1972-1990 он, Лхамжавын Бат-Өлзий нь 1971-1995 онд, Эрдэнэсамбуугийн Батжанцан 1984-1987 он, Б.Дамдинсүрэн 1988-



*Сумын малын эмч, зоотехникч, санитарич, малын бага эмч нар. Мал эмнэлгийн 80 жилийн ойн үеэр.*

1990 он, С.Бат-Эрдэнэ, С.Давааням 1964-1991 онд, 1991 он Б.Ганхуяг, Б.Алтанхуяг 1991 оноос одоог хүртэл ажиллаж байна.

Шинжлэгч их эмчээр анх 1976-1981 онд П.Чулуунбаатар, 1981-1986 онд Ц.Даваажаргал, 1986-1987 онд П.Энхтуяа, 1988-1990 онд С.Бат-Эрдэнэ, 1990-1993 онд Г.Дэлгэр, 1993 онд Ц.Даваажаргал ажиллаж байсан.

Малын бага эмчээр Д.Шарав, Р.Даваа, Б.Санжжав, Л.Доржжүгдэр, Б.Ичинноров, Сосорбарам, Ц.Жамсран, Ёлгоо, Чадраабал, Бараадазан, Д.Зоригт, Б.Диваарагчаа, Гэрэлчулуун, Л.Бат-Өлзий, С.Давааням, Ж.Лхагважав, Д.Бат-Эрдэнэ, Д.Баасандэлгэр, Ш.Наранхүү

Ерөнхий мал зүйчээр анх 1965 онд Намсрай ажиллаж байсан бөгөөд 1967-1973 онд Сайнбилэгийн Дамдинжав, 1973-1977 онд Р.Доржпагма, 1977-1980 онд Цэдэнгийн Мишигдорж, Б.Нарантуяа, 1981-1984 онд Ц.Мишигдорж, 1984-1986 онд Пүрэвэ, 1986-1990 онд М.Зундуй, Б.Шарбанди, 1990-1991 онд Г.Эрдэнэчимэг, 1991-1992 онд Гансүх, 1992-1993 онд Ц.Мишигдорж, 1993-1995 онд Д.Батхүү, 1991-1997 Б.Алтанцэцэг Д.Сайнбаяр, Даваацэдэв, Оюунцэцэг, Бямбадалай, Д.Ганхуяг нар ажиллаж байжээ. Анх 1958-1960 онд дунд мэргэжлийн зоотехникчээр Ж.Хорлоо ажиллаж байсан бөгөөд Ч.Гунгаажанцан 1981-1984 онд үржлийн техникчээр ажиллаж байжээ. Мөн 1971 оноос мал эмнэлгийн үйлчилгээнд А-69 машин авчирч жолоочоор нь Шатарбалын Ганболд ажиллаж улмаар 1975 онд Газ-51 машиныг Жаргалантын ЭТЦ дээр ажиллуулахаар болж, жолоочоор нь Д.Гэлэгсэнгээ ажиллаж байсан байна. Мал эмнэлгийн аптекийн эрхлэгчээр С.Данаажав, Лхагвасүрэн, Б.Оюунчимэг Ц.Даваажаргал тэргүүтэй хүмүүс ажиллаж байлаа.

Мал эмнэлгийн салбарт санитарчаар Барамсай, Чадраабал, Л.Дугаржав, Ц.Лосол, С.Юндэндорж, Д.Хүрэлбаатар, Ч.Гунгаажанцан, С.Данаажав, Л.Дамдинжав, А.Дашдорж, М.Энхбат, Д.Гүндсамбуу, Л.Чимэд, Т.Ням-Очир, Д.Наранбаатар, П.Бат-Эрдэнэ нар ажиллаж байв.

Мал эмнэлгийн жолоочоор Ш.Ганболд, Д.Гэлэгсэнгээ, Д.Мархүү, Ц.Жамъянжав, Р.Сэрээтэр, М.Дорж, Ёндонжамц, Д.Пүрэв-Өлзий, Ш.Бүрэгдэежанцан, Д.Ганбаатар нар ажиллаж байжээ.

Тус сумын мал эмнэлгийн салбар нь зоо мал эмнэлгийн тасаг болтлоо өргөжин бэхжиж, улмаар оношлох, лабораторийн нарийн мэргэжлийн эмчтэй болсон. Мал эмнэлэг байгуулагдсаны 50 жилийн ойгоор 1973 онд орчин үеийн зураг төслийн барилга байгууламж баригдаж, Газ-69, Газ-51 машин тус бүр нэгтэй болж биеэ даасан зоо-мал эмнэлгийн тасаг хэмээн нэрлэж, сумын албан байгууллагын хэмжээнд хүртэл өргөжжээ. Мал аж ахуйн мэргэжилтнүүдээс 1970-1990 онуудад санитарчаар Б.Сосорбарам, малын бага эмчээр Лхамсүрэн, Данаажав, Л.Бат-Өлзий, Д.Наранбаатар Б.Төртогтох, С.Давааням, Б.Алтанхуяг, Д.Батдэмбэрэл, Н.Дашням, мал зүйчдээс Ц.Мишигдорж, малын их эмч нараас П.Чулуунбаатар, жолоочоор Ш.Ганболд тэргүүтэй ахмадуудын нэрийг дурьдаж болно.

Дээрхи мэргэжилтнүүдээс төр засгийн одон медалиар олон хүн шагнагдаж байжээ. Тухайлбал, Хөдөлмөрийн хүндэт медалиар П.Чулуунбаатар, Ц.Мишигдорж, Б.Диваарагчаа, Б.Алтанхуяг, “Алтан гадас” одонгоор мал зүйч Г.Доржлүдэл, Б.Алтанхуяг, ХХАА-н тэргүүний ажилтнаар Д.Наранбаатар, С.Давааням, Л.Бат-Өлзий, Л.Данаажав, Ш.Наранхүү нар шагнагдаж байжээ.

1991 оны долдугаар сараас Мал эмнэлэг үржлийн алба болж малын их эмч 2, бага эмч 7, санитарч 1, жолооч 1, ерөнхий зоотехникч 1, үржлийн зоотехникч дээд мэргэжлийн 1, дундын 1 гэсэн орон тоотойгоор ажиллаж байв.

Мал эмнэлэг үржлийн албаны хамт олон нь сүүлийн 20 жилийн хугацаанд ажлын үзүүлэлтээрээ аймагт байнга шалгарч ирсэн юм. Тухайлбал 1991, 1992 онд 2-р байр, 1993 онд 3-р байр, 1993,1994 онд “Аймгийн тэргүүний хамт олон” гэрчилгээ, 1995 онд 4-р байр, 1996 онд 2-р байр, 1998 онд 4-р байр, 1999 онд 1-р байр, 2000 онд 4-р байр, 2001 онд 1-р байранд тус тус шалгарч байжээ.

Мал эмнэлэг үржлийн алба нь 1997 онд Торцмөрөн нэртэй Төрийн өмчит Улсын үйлдвэрийн газар болон ажиллаж байгаад 1999 оны дөрөвдүгээр сарын 16-ны өдөр хувьчлагдан хувийн мал эмнэлэг болж малын их эмч Б.Алтанхуяг, гэрээт малын бага эмч Ш.Наранхүү, П.Бат-



Улсын үйлдвэрийн газар болон ажиллаж байгаад 1999 оны дөрөвдүгээр сарын 16-ны өдөр хувьчлагдан хувийн мал эмнэлэг болж малын их эмч Б.Алтанхуяг, гэрээт малын бага эмч Ш.Наранхүү, П.Бат-

Эрдэнэ, Д.Баасандэлгэр, Д.Наранбаатар нар ажиллаж байна.

Тус суманд 2000 оноос 2,3-р багийн малыг хариуцан “Торц мөрөн” нэртэй мал эмнэлгийг малын их эмч Б.Алтанхуяг, 2002 онд 1,5-р багийн малыг хариуцан “Ган болор” нэртэй мал эмнэлгийг малын бага эмч Ш.Наранхүү, 2003 онд 4-р багийн малыг хариуцан “Далай гүн” нэртэй мал эмнэлгийг малын их эмч Ц.Нямханд байгуулан одоог хүртэл мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг явуулж байна. “Торц мөрөн” мал эмнэлэгт 2003 оноос малын их эмч 2, малын бага эмч 2, Далай гүн мал эмнэлэг малын их эмч 1, техникч 1, “Ган болор” мал эмнэлэг нь малын бага эмч 1 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.”Торц мөрөн” мал эмнэлэг нь ажлын амжилтаараа 2001 онд 1-р байр, 2002 онд дэд байр, 2003 онд 2-р байр, 2004 онд тэргүүн байр, 2006 онд оны Тэргүүний аж ахуйн нэгжээр, 2007 онд тэргүүн байрт тус тус шалгарч байсан.

Мөн ЗДТГ-ын МЭҮХУ байцаагчаар малын их эмч Т.Тэрбиш 2001-2010 онд ажиллаж байлаа. Монгол мал хөтөлбөрийн хүрээнд 2010 онд суманд МЭҮТ-г ЗДТГ-н бүтцэнд оруулан 3 орон тоо шинээр бий болж малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн тасгийн даргаар Т.Тэрбиш, малын үүлдэр технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэнээр Б.Алтанцэцэг, Бэлчээр усжуулалт, газар тариалан, жижиг дунд үйлдвэр үйлчилгээ, хоршоо хариуцсан мэргэжилтнээр А.Нямханд, Ж.Нямханд нар ажиллаж байсан. МЭҮТ нь 2011 онд ажлын үзүүлэлтээрээ аймагт 5-р байранд орсон.



МЭҮХ-ийн жолооч Р.Равдандорж



Ганболор мал эмнэлэг




Торцмөрөн мал эмнэлэг

### Мал аж ахуйн салбар

2013 оны жилийн эцсийн мал тооллогоор бүгд -219819 толгой малтай. 2009 онд 34 мянгат малчинаар аймагтаа тэргүүлж байсан. 2012 онд 10 мянгат малчинтай байсан бол 2013 оны жилийн эцсийн мал тооллогоор 20 мянгат малчинтай болсон. Үүнээс 2000-т малчин нэг байна. Тус суманд эрчим омгийн хар ямааны үүлдэрийг 1989 онд бий болгож одоог хүртэл


өсгөн үржүүлж түүхий эдийг нь авч ашиглаж байна. Төмөрбулаг сум нь Ё.Магсар, Г.Төөчөө, С.Давааням гэсэн гурван Улсын сайн малчинтай.



Эрчим омгийн ямаан сүрэг

**Нийт малын бүтцийг хувиар авч үзвэл:**

Тэмээ - 0,1%,  
Адуу -3%,  
Үхэр -5%,  
Хонь-38%,  
Ямаа-54% байна.  
Сумын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй юм.




**Сумын мал сүргийн тоо сүүлийн 6 жилийн байдлаар:**

Малын нийт тоо	2009	2010	2011	2012	2013	2014
Тэмээ	20	19	17	16	17	
Адуу	4427	4774	5000	5332	5563	
Үхэр	10196	9848	10823	11480	11826	
Хонь	71673	58982	63605	77049	82344	
Ямаа	123339	100270	110725	116107	119042	
Дүн	209655	173893	190170	209984	218792	

**МАЛ ЭМНЭЛГИЙН САЛБАРЫН АЖИЛЧДЫН НАМТАР ТҮҮХ**

**ДАШДАВААГИЙН НАРАНБААТАР**

Дашдаваагийн Наранбаатар нь 1960 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суман төрсөн. Д.Наранбаатар нь Архангай аймгийн ХАА-н Техник мэргэжлийн сургууль 1978-1980, УБ хотын ХАА-н дээд сургууль дээр малын бага эмчийн курс 1986-1988, Монголын ардын армийн улс төрийн дээд сургуулийн намын ажилтны 2 жилийн курс 1983 -1985 онд суралцаж төгссөн.Төмөрбулаг сумын 2-р бригадад 1980-1982 онд малын санитарч, Ардын армийн 073-р ангид 1983-1985 онд Малын бага эмч, Төмөрбулаг сумын мал туувьрийн малын бага эмч тоо бүртгэгчээр 1986-1988, 1-р бригадад эмчилгээ тэжээлийн цэгийн малын бага эмчээр 1989-1991, 2-р баг 3-р багт багийн Засаг даргаар 1992-2004, Төмөрбулаг сумын Торц мөрөн мал эмнэлэгт 2005-2012 он хүртэл малын эмч 2-р багийн ИНХ-н даргаар ажиллаж байсан



**Төр засгаас авсан шагнал:** ХАА-н хүндэт жуух бичиг 1987, Аймгийн тэргүүний ажилтан 1997, Сумын тэргүүний ажилтан 1993, ХАА-н тэргүүний ажилтан 2005, Ардын хувьсгалын 60,70,80,90 жилийн ойн медалиудаар шагнагдсан.

**ЛАМЖАВЫН БАТ-ӨЛЗИЙ**



Ламжавын Бат-Өлзий нь 1951 онд төрсөн, 1971 онд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь ХАА-н техникумыг төгсөж Хөвсгөл аймгийн Арбулаг суманд 1971-1973 онд, Төмөрбулаг суманд 1974 оноос 1995 он хүртэл эмчилгээ тэжээлийн цэгийн малын эмчээр, багийн малын эмчээр ажиллаж байсан. 1995-2000 оны хооронд хувийн мал эмнэлэгт малын эмчээр ажилласан.Л.Бат-Өлзий нь 2001 онд сумын сайн малчин болж одоог хүртэл мянгат малчнаар малаа маллан амьдарч байгаа.төр засгаас авсан шагнал:Аймгийн баярын бичиг өргөмжлөлөөр удаа дараалан, АХ-ын 60,70,80 жилийн ойн медаль, ХАА-н тэргүүний ажилтан, аймгийн засаг даргын жуух бичиг, МУЗН-н ойн медаль, Хөвсгөлийн бахархал тэмдэгээр Монгол ардын намын ойн медаль, хүндэт энгэрийн тэмдгээр тус тус шагнагдаж байсан.



**БАНЗРАГЧИЙН АЛТАНЦЭЦЭГ**

Банзрагчийн Алтанцэцэг нь 1964 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. Шинэ-Идэр сумын 10 жилийн сургуулийг 1983 онд дүүргэж улмаар ХААДС-ийг зоотехникч мэргэжлээр 1992 онд төгссөн.

Б.Алтанцэцэг нь 1992-1994 онд Төв аймгийн Октябрийн САА-д мал зүйчээр, Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн сангийн аж ахуйд 1994-1995 онд мал зүйчээр ажиллаж байсан.

1996-1998 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЗДТГ-т мал зүйчээр, 1998-2000 онд Нарантолгой компаний захирлаар, 2010 оноос одоог хүртэл ЗДТГ-т МАХЦЧХУБайцаагч, МЭҮТ-н мэргэжилтнээр ажиллаж байна. Хөвсгөл аймгийн Тэргүүний ажилтан.

**ТҮДЭВПУНЦАГЫН ТЭРБИШ**

Түдэвпунцагын Тэрбиш нь 1976 онд төрсөн. Т.Тэрбиш нь 1994 онд Тосонцэнгэл сумын 10 жилийн дунд сургууль, 1999 онд ХААИС-ийг малын их эмч мэргэжлээр төгссөн. Мэргэжлээрээ 2000 онд Тосонцэнгэл сумын ЗДТГ-т мал эмнэлэг үржлийн хяналтын улсын байцаагч, Энх Элит сүрэг мал эмнэлэгт малын их эмчээр, 2001 оны 7 сараас одоог хүртэл Төмөрбулаг сумын ЗДТГ-н мал амьтан, хорио цээр чанарын хяналтын улсын байцаагч, МЭҮТ-н даргаар ажиллаж байна. Ажиллах хугацаандаа Төмөрбулаг сумын нийгмийн халамжийн байцаагч, иргэний бүртгэлийн ажилтаны ажлыг 2001 оны 8 сараас эхлэн 2006 оныг хүртэл хавсран гүйцэтгэж байсан. Ажлын амжилтыг үнэлж баярын бичиг өргөмжлөлүүд, ҮХАА-н яамны “Жуух бичиг” ээр шагнуулж байв.



**ШАНЖИЙН НАРАНХҮҮ**

Шанж овогтой Наранхүү нь 1964 онд төрсөн. 1986-1990 онд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь ХАА-н техникумыг малын бага эмчийн мэргэжлээр төгссөн. Ш.Наранхүү нь 1985-1986 онд тус сумын эмчилгээ тэжээлийн цэгт санитарчаар, 1989-1995 онд 2,4-р багт малын эмчээр, 1995-2002 онд 1-р багт, 2003 онд Ган болор мал эмнэлгийг байгуулан одоог хүртэл ажиллаж байна. Ган болор мал эмнэлэг нь 1,5-р багийн малчин өрхүүдэд мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээг хүргэж малыг эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх вакцин, тарилга, туулгалт, угаалга, боловсруулалтыг цаг хугацаанд хийж байна.

Ш.Наранхүүгийн ажлын амжилтыг үнэлж 2001 онд ХХАА-н жуух

бичиг, 2007 онд ХААҮйлдвэрийн тэргүүний ажилтан цол тэмдгээр, 2009 онд эрх чөлөөний одонгоор, АХ-ын 80 жилийн ойн медаль, 2013 онд Хөвсгөл аймгийн тэргүүний ажилтан цол тэмдгээр тус тус шагнагдсан.

**ЦЭВЭЭНЛХАЗОЛЫН НЯМХАНД**

Цэвээнлхазолын Нямханд 1981 онд төрсөн. 2003 онд ХААИС-ийг малын их эмч мэргэжлээр төгсөж ирээд 2003 онд тус сумандаа Далайгүн мал эмнэлгийг үүсгэн байгуулж одоог хүртэл ажиллаж байна. Нөхөр Б.Сүхбаатар нь малын техник мэргэжлийг эзэмшиж хамтран Далайгүн мал эмнэлгийг үүсгэн байгуулж 4-р багийн мал сүрэгт мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээг тогтмол хүргэж малыг эрүүлжүүлэх, эмчлэх ажлыг чанартай хийж малын өвчлөлийг бууруулж чадаж байгаа сумын шилдэг малын их эмч юм. Тус мал эмнэлэг нь багийнхаа 50 гаруй мянган малыг хамруулан халдварт өвчнүүдүүс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, паразит өвчнийг эмчлэн сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтыг нэгдсэн графикайн дагуу хэрэгжүүлдэг.



**БАТ-ОЧИРЫН АЛТАНХУЯГ**

Бат-Очирын Алтанхуяг нь 1953 онд төрсөн. 1969-1972 онд Алтанбулаг дахь Хөдөө аж ахуйн техникумыг малын бага эмчийн мэргэжлээр, 1986-1991 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг төгсөж малын их эмч мэргэжил эзэмшсэн. 1969-1972 онд Бүрэнтогтох суманд малын бага эмч 1973-1976 Ардын армид цэргийн алба 1973-1977 1976-1986 онд Төмөрбулаг сумын 3-р бригад малын бага эмч 1991-1999 онд тус сумын мал эмнэлэг



үржлийн албанд эрхлэгч их эмч 1999 оноос одоог хүртэл мал эмнэлгийн үйлчилгээний “Торц мөрөн” мал эмнэлгийн эзэн, малын их эмчээр ажиллаж байна. Сумынхаа Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн зохицуулагчаар 2012 оныг дуустал ажиллаж 100 гаруй өрхийг малжуулахад оролцсон.

Улсын болон хувийн салбарт 39 дэхь жилдээ ажиллаж байна. Б.Алтанхуяг нь ажлын чанар үр дүнг дээшлүүлж байгууллага аж ахуйгаа санхүүгийн хувьд бэхжүүлж малчдад үйлчлэх болон дотоод ажлаа шаардлагын хэмжээнд хүргэн 2006 онд “аймгийн тэргүүний хамт олон” болсон. Удирдаж байгаа “Торц мөрөн” мал эмнэлэг нь аймгийн мал эмнэлгийн салбар нэгжүүд дотроос 1999, 2000, 2001 онд тэргүүн байр, 2002 онд дэд байр, 2003 онд 2р байр, 2004-2013 онд 4-6-р байрт шалгарсан байна. Одоо тус сумын 2,3-р багийн 310 өрхийн ерөн хоёр мянган малыг хариуцан ажиллаж байна.

Б.Алтанхуяг нь Ардын уламжлалт мал эмнэлгийн дамжаа, 2003, 2008, 2013 онуудад малын их эмч нарын итгэмжлэх сургалт, малын их эмч нарын эдийн засаг менежмент ня-бо бүртгэл мэдээлэлийн сургалтанд

хамрагдан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн. 1997 онд мэргэжлийн зэрэг олгох шалгаруулалтанд 1-р зэрэг, 2001 онд ХААЯ-ны улсын хяналтын албанаас хувьчлагдсан мал эмнэлгийн түвшин тогтоох үзлэгт “хангалттай сайн” үнэлгээ авсан. 1990 оноос сумын ИТХ-ын төлөөлөгчөөр 4 удаа, тэргүүлэгчээр 2 удаа сонгогдон ажилласан.

**Гавьяа шагнал:** Төрийн Алтан гадас одон, Ардын хувьсгалын 80,90 жилийн ойн медаль, Хүнс ХАА-н тэргүүний ажилтан цол тэмдэг, Хөвсгөл аймгийн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан



**ЛХАМСҮРЭНГИЙН ДАНААЖАВ**

Лхамсүрэнгийн Данаажав 1948 онд төрсөн. Архангай аймгийн ХАА-н Техникумд суралцаж, малын бага эмч мэргэжлээр төгссөн.

1967-1969 онд Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын “Алтан тал” нэгдэлд малын эмчээр, 1969-1973 онд Бүрэнтогтох сумын Дэлгэр мөрөн нэгдэлд Малын эмнэлгийн аптекийн эрхлэгчээр, 1974-1976 онд Төмөрбулаг сумын “Давшилт” нэгдэлд эмчилгээ тэжээлийн цэгийн эмчээр, 1976-1989 онд Төмөрбулаг сумын мал эмнэлэгт Малын эмнэлгийн аптекийн эрхлэгчээр, 1989-1991 онд Шинэ-Идэр сумын “Жаргалын зам” нэгдэлд

эмчилгээ тэжээлийн цэгийн эмчээр, 1991-1995 онд Төмөрбулаг сумын мал эмнэлэгт тэжээлийн цэгийн эмчээр тус тус ажиллаж байсан.

Л.Данаажав нь ХАА-н сургуулийн төгссөнөөс хойш эзэмшсэн мэргэжлээрээ хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж Бүрэнтогтох сумын “Дэлгэр мөрөн” нэгдэлд ажиллаж байхдаа малын гэдэс ходоодны өвчинд сайн эмийн ургамлыг цуглуулж мал эмнэлэгтээ ашиглаж байсан нь үр дүнд хүрч байсан.

Мөн Төмөрбулаг сумын давшилт нэгдэлд эмчилгээ тэжээлийн цэгийн эмчээр, малын эргүүг мэс заслын аргаар авч малчид ард иргэдийн талархал хүлээж ажиллаж байв. Мөн Л.Данаажавын ажлын амжилтуудыг үнэлэн Хүнс хөдөө аж ахуйн яамны жуух бичгээр 2007 онд, хөдөө аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажилласныг үнэлж 2011 онд Хөвсгөл аймгийн ХАА-н шилдэг эмэгтэйгээр шалгарч шагнагдаж байсан.

**БАДАРЧИЙН ИЧИННОРОВ**

1924 онд төрсөн. Малын эмчийн мэргэжилтэй. Б.Ичинноров гэрийн сургалтаар анхан шатны боловсрол эзэмшиж, улмаар 1946 онд Алтанбулагийн Хөдөө аж ахуйн техникумыг малын бага эмч мэргэжлээр төгсч, төрөлх сургуульдаа малын бага эмчийн мэргэжлээр ажилласан анхны эмэгтэй байв. Тэрээр 1955 оноос аймгийн мал эмнэлгийн тасагт лабораторийн эрхлэгч, шинжлэгч эмчээр насан өөд болтлоо ажиллажээ.



**ТӨМӨРБУЛАГ СУМЫН 12 ЖИЛИЙН АХЛАХ СУРГУУЛЬ**



**1921-1940 он /Ардын засгийн үед/**

1922 оны 8 сарын 14-нд гарсан Засгийн газрын шийдвэрийн дагуу зарим шинэхэн суурингуудад 1923 оноос эхлэн танхим нэртэй анхны сургуулиуд байгуулагдаж эхэлсэн билээ. 1921 онд Бүгдгээн хан уулын хошууны дэргэд тэнхим хэмээн сургууль байгуулагдан 10 гаруй хүүхэд ном заалгаж байлаа. Энэ хошуу нь 1931 онд Төмөрбулаг, Бүрэнтогтох сум болсон юм. Засгийн газрын 1927 оны 8 сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолоор 1928 оны 8 сард Бүгсийн хүрээн дээр шинэ Наймаан гэдгийн хашаанд дарга сургагч Борбаатарын удирдлагаар 25 сурагчтай тэнхим байгуулагдсан. Энэ тэнхимд Монгол цагаан толгой, тоо бодлого, Түмэн бодисын ухаан зэрэг хичээлийг буриад багш Балдандорж, Бэх-Очир нар зааж эмчээр нь тус сумын харьяат Жигмэд овогтой Галай хэмээх маарамба ажиллаж байжээ.

Хэдийгээр энэ тэнхим нь 1932 онд Хөвсгөл, Архангай, Завхан зэрэг аймгийг хамарч тухайн үедээ нийгэм, эдийн засгийн талаар нам засгаас авч хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийг үл ойлгон эсэргүүцсэн анги давхаргынхны өдүүлсэн бослого хөдөлгөөний уршгаар тарж бутарсан боловч ард түмний үр хүүхэд, залуусыг бичиг үсэгт сургах, ертөнцийг танин мэдэх шинэ үеийн шинжлэх ухааны мэдлэгийг олгох, улмаар ардын бага сургуулийг жинхэнэ ёсоор байгуулахын эхлэл болсон юм.

1934 онд Бүгсий, Бүгдгээний хүрээн дээр шавилан сууж байсан 120 гаруй хүүхдийн 50 шахам хувь нь сайн дураараа хар болж монгол бичигт тайлагдаж байжээ. Бичиг үсэгт сургах ажлыг ихэвчлэн гэрээр буюу сумаас зохион байгуулсан улирлын түр сургалтаар гүйцэтгэж байжээ.

1938 онд Төмөрбулаг сумын бичиг үсэгт сургах ажилд хяналт болон бичиг хэргийн зардалд 53 төгрөг аймгаас олгож байсан баримт байдаг. 1939 онд сумын төвийн ойролцоо гэр барьж монгол бичгийн багш 8 дугаар багийн ард бичээч Зундуйн Цэдэнсодном улирлын зуны түр сургуульд багшлан, залууст бичиг эрдэм зааж байжээ. Эдгээр арга хэмжээний үр дүнд бичиг үсэг мэдэх хүн 1931 онд 36 байсан бол 1935 онд 156, 1940 онд 617 болж, сүүлийн 10 жилд 17 дахин өссөн байна.

**1940-1972 он / Шинэ үе шатанд /**

1940 онд Төмөрбулаг суманд бага сургууль байгуулах тухай Хөвсгөл

аймгийн захиргааны шийдвэр гарсны дагуу зуны түр сургуулийг ардын бага сургууль болгон өргөтгөжээ. Энэ сургууль нь 1940 оны есдүгээр сарын 10-нд 1-р ангийг 2 бүлэг, 60 сурагчтайгаар хичээлээ эхэлсэн бөгөөд анхны захирал нь Ишбалын Давааням, багш нь Бавуугийн Хярваа нар байсан юм.

Энэ үед эх орны дайны хүнд хэцүү үе байсан учир дэвтэр, харандаа, үзэг, бэх ховор хүрэлцээгүйгээс олддоггүй, барааны ороолт цаас цуглуулж дэвтэр хийнэ. Сарампай мод тосолж үнсээр бүрхүүлж бичгийн самбар хийж ашиглах, тэмээний хоргол битүү саванд шатааж үнсийг чихэртэй хольж, усанд найруулаад бэх, улаан хошуутын хошуугаар үзэг, хугархай балыг бургасанд шургуулж харандаа хийж бичлэгт хэрэглэх зэргээр олон бэрхшээлийн өмнө тэр үеийн багш сурагчид шантарч байгаагүйг тэр үеийн сурагч Содномбалжир, Доржоо, Н.Сосорбарам, Гаваа, Л.Бямбасүрэн, М.Даваахүү, Г.Пүрэвдорж, Д.Түмэндэмбэрэл нар дурсан ярьж байна. Тус сургуульд анхны жилүүдэд И.Давааням, анхны багш, захирал Б.Хаянхярваа, Нансалдулам, Ядамсүрэн, Нямжанцан, Жигжид, Д.Ёндон, Шагдар, Ш.Гарваа, Б.Баасанжав, Цогбадрах, Лувсангомбо, С.Гомбо, Ж.Дамдиндорж, Д.Батаа, Л.Лхагваа, С.Сэнгээ, С.Цэрэнбалжир, Н.Аюушжав, Д.Халтар, Л.Лханаа, Н.Содномбалжир, Д.Ядамжав, Должинсорогдох, Г.Дэмчиг нар нар багшаар ажиллаж байжээ. Мөн энэ үед Дамбасүрэн Цэндээжий, Чалхаажав, Товуужав, Соном, Сандагсүрэн, Төмөршагдар, Лхагважав, Цэрэндаш, Лхагва, Ишханд, Мааньгүмбэн, Ванданцэрэн, Эрдэнэбилэг, Чимэдхүү зэрэг багш нар ажиллаж байжээ.

Тус сургуулийн анхны захирал И.Давааням, багш Б.Хярваа, комендат Д.Бат-Очир, тогооч Долгор, галч Магсар нарын цалин нь 50-60 төгрөг байв. Сургууль эхлэн байгуулагдаж байсан 1940 онд монгол бичиг, дөрвөн аргын тоо зэрэг ухагдахууныг зааж байсан бол дараагийн 1941-1942 оны хичээлийн жилээс шинэ кирилл үсэг, тоо бодлого гүнзгийрүүлэн судлуулж



Анхны багш, захирал  
Б.Хаянхярваа

байсан аж. Энэ нь улс орон даяар 1946 оны шинэ бичигт шилжихийн урьдчилсан бэлтгэл сургалт байсан билээ.

Сумын анхны бичиг үсгийн багш 5-р багийн харъяат Бэгз бөгөөд Сүхийн Сэнгээ 1948 он хүртэл шинэ үсэгт сургаж байв.

1942-1954 онуудад олон хүнийг хамруулж нийт 1096 хүнийг бичигтэй болгосон байна.

1954-1955 оны хичээлийн жилээс сургуулиудад шинээр хөдөлмөрийн хичээл нэмэгдэж орох болсны дээр 1957 онд сургуулийн захирлаар ажиллаж байсан С.Цэрэнбалжир удирдан залуу байгальчдын дугуйлангийн багш сурагчдын хүчээр тарьж суулгасан 30 гаруй шинэс мод одоо хүртэл сургуулийн хашаанд ургасаар байна.

1940-1950 оны үед сургуульд орохгүйн тулд насаа дарах, сургуулиас оргож харих нь нэлээд байсан. Дотуур байранд 1 сурагч 5 тэрэг түлээ

70 кг төрөл бүрийн мах нийлүүлж байж суудаг байв. 1950-1951 оны үед 4-р анги төгсөгчдөөс 2-3 сурагч л аймгийн дунд сургуулийн 5-р ангид дэвшин суралцаж байсан.

1952-1957 оны сурагчдын дурсамжаас үзэхэд сургуулиас оргоход тэр өдөртөө л баригдаж ирдэг, тэр байтугай сүүлд 4-р анги төгсөөд Шинэ-Идэр суманд хувиарлагдахад эцэг эхчүүд хүүхдээ нуугаад явуулдаггүй, Шинэ-Идэрээс морьтой багш сурагчаа авахаар ирдэг байжээ.

Тус сургуулийн анхны сурагчид “Байрны сурагчдыг өдөрт гурван удаа хооллодог байлаа.Өглөө боорцог юмуу талх, өдөрт хоол, орой унд өгдөг байжээ.Орос сахар талхтай хамт өгнө.Монгол гуталтай, дээлний өнгө хөх, ногоон даалимбаар ижилсэнэ.Ногоон бүс цагаан хурган малгайтай дулааны улиралд саравчтай малгайтай байдаг байсан.Улаан таван хошуутай үзгээр бичнэ.Хуурай черний олодохгүй бол хортой харандаа найруулж бэх хийдэг байсан” хэмээн дурсжээ.

Сумын бага сургууль 1955 он гэхэд 400 хүүхдийг бага боловсролтой болгож 13-49 насны хүн амын бараг 50 хувь нь бичиг үсэгтэй болсон байна. 1960-1972 оны үед хичээлийн танхим одоогийн агуулахын хүрэн байшинд, шинээр баригдан шилжиж оров. Бусад нь аж ахуйн аргаар боловсруулсан цагаан идээ, талх хүнсэнд хэрэглэж улсын төсвөөр санхүүжигдэж байсан учир тухайн үедээ хөрөнгө санхүүгийн хувьд бололцоотой байв. Бага боловсрол эзэмшсэн суралцагсад 1972 оныг хүртэл тойргийн сум Шинэ-Идэрт суралцдан, зарим хэсэг нь Мөрөнд ах дүүгээ даган суралдаг байжээ. Хичээлийн агуулга тогтвортой байсаар 1964 онд Намын Төв Хорооноос Эцэг эх хөдөлмөрчдөд хандаж албан захидал гарсан нь олны хүч хөдөлгөөнийг өрнүүлсэн юм.

1960 аад оны сүүлчээр багш нарын хичээл сургалтанд тавигдах хяналт шалгалтыг сайжруулж сургуулийг удирдах арга барилыг боловсронгуй



болгоход ихээхэн анхаарч төв орон нутагт сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах ажил ид өрнөж байлаа. Энэ үеийн багш нараас ахмад багш асан Г.Билэгдэмбэрэл энэ сургуульд хамгийн олон жил ажилласан нэгэн байлаа.

**1972-1990 он /ардчилсан шинэчлэлийн үед/**

1972 онд МАХН-ын төв хороо СнЗ-өөс Ерөнхий боловсролын сургуулийн системийг боловсронгуй болгож, сургалтын чанарыг сайжруулах тухай 215/250 дугаар тогтоол гарсан нь ач холбогдолоо өгсөн юм. Энэ ажлын хүрээнд сургууль албан газар байгууллага эх, эцэг хөдөлмөрчдийн хүчин туслалцааг авч багагүй зүйл хийв.

Тус сумыг 8 жилийн сургуультай болгох тухай аймгийн Ардын Депутатуудын 3-р чуулганы тогтоол 1968 оны 4 сарын 14-нд гарчээ.

1972 оны 8-р сард хичээлийн шинэ байр ашиглалтанд орж 8 жилийн сургуулийн анхны захирлаар Б.Дамба, хичээлийн эрхлэгчээр Д.Мишингээ, багш нараар Буянсанжаа, Хандмаа, Халтмаа, Ичинхорлоо, Лувсмаа, Ө.Мажиг, Г.Долгорсүрэн, О.Нямсүрэн, Ч.Янжинхүү, А.Баттулга, Ч.Дэмчиг, Банзрагч, Ядамсүрэн, Б.Нямбуу, Д.Лхагважав, Д.Чулуунхүү, Ж.Дүгэрсүрэн, Г.Лханаа нар ажиллаж байсан нь сурагчдад бүрэн бус боловсрол эзэмшүүлж байсан анхны багш нар болой.

Энэ үеэс сургуулийн бүтэцтэй холбогдсон багшлах боловсон хүчин



1977 оны Т.Найдансүрэн захиралтай багш ажилчид

бэхжиж сургуулийн аж ахуй хөрөнгө оруулалт өөрчлөгдөн сургалтын хэрэглэгдэхүүн, кабинет, заал ашиглалтанд орж ажилагсдын орон тоо нэмэгдэж авто машинтай болж бүрэлдхүүний өөрчлөлт орсноор байрын багш Дашбалжир, анхны жолооч Ж.Төмөрбаатар, анхны аж ахуй эрхлэгч Ч.Сүмбэрэлдорж нар ажиллаж байжээ.

1976 онд Г.Долгорсүрэн багштай анхны 8-р анги төгсөж байлаа.



*Багш та хормой өвдөгөөс нь адис авмаар хүмүүн бүрхэн  
Багш та хоёр нүднээс нь арвин эрдэм ууцаардаг гүн ухаантан  
Багш та хорвоог гийгүүдэхээр тэнцэрт мандсан огилооний наран  
Багш та хойгийн төлөө ирээдүйнээс ирсэн номын элч*

*Айдрай бүрхэн шавь нар Имь  
Алит багш тандоо хайрын дээдийн өрөө  
Анхны багш тандоо өрөөлөөр хайрласан  
"Дурсамж"-аа үлдээ.*

Тус сургуулийн анхны 8-р анги төгсөгчдийн дурсгалын цомог.

Энэ үеэс сурагчдын дунд идэвхтэн сонгуультаан, тэргүүний бүлэг салааны удирдагч, спорт урлагийн авъяастай хүүхдийг хөгжүүлэхэд пионерийн танхимаас зохиох ажил эрч хүчтэй болж баатарчуудын баг аравт олноор зохион байгуулагдан “Пионерийн үнэн”, “Залгамжлагч сэтгүүл”, хүүхдийн хүмүүжил, өсвөрийн зохион бүтээгчид, залуу байгальчид зэрэг танин мэдэх ач холбогдолтой сонин хэвлэл олноор гарч байсныг хүүхэд багачуудаар захиалуулан ашигладаг байв. Энэ ПАУ-аар Т.Дэмбэрэлням ажиллаж байлаа.

Тэрээр сурагчдын сайн дурын байгууллагыг зохион байгуулж сурагчдын дунд идэвхтэн сонгуультаан, тэргүүний бүлэг салааны удирдагч, онц сурлагтан, спорт урлагийн авъяастай хүүхдүүд олноор төрөн гарч байснаас сурлагын анхны алтан медалийг Б.Бурмаа, мөнгөн медалийг Д.Даваадорж, хүрэл медалийг Д.Баярсүрэн нар авч, анхны 5 онцын эзэн Р.Цагаанбаатар болж байсан ба Б.Ганхуяг, Ж.Бат-Эрдэнэ, Р.Цагаанхүү, Ц.Туул зэрэг анхны зэрэгтэй тамирчид төрөн гарсан нь тус сургуулийн сурагчдын ирээдүйн амжилтын үндэс суурийг тавьжээ.

Хүүхэд багачуудыг юмханаар юм хийж алдагдал хаягдлыг ашиглах төрөл бүрийн арга хэмжээнд хамруулдаг байсан нь өсвөр үеийг хүмүүжүүлж арвилан хэмнэх, нөөц бололцоог ашиглан төр олон түмэнд тус хүргэсэн сайн үйлс байлаа.





*1980 оны хичээлийн жил. Т.Найдансүрэн захиралтай багш нар*

Хүүхэд бүрийг ХБХБ тэмдэгийн нормыг бүрэн хангуулах, хүүхдийн дунд “Номын сайн нөхөр”, “Д.Нацагдорж тэмдэгтэн” зэрэг хөдөлгөөн өрнөж сурагчид идэвхтэй оролцож байв.

1972-1980 онд сургалтын агуулгад өөрчлөлт орсонтой холбогдуулан сургалтын “Шинэ систем”-ээр хичээллэх болж төв орон нутгийн багш нарыг давтан бэлтгэх, багш сурагчдын гарын авлага ном товхимол олноор бэлтгэх тэргүүний багш нарын туршлага нэвтрүүлэх, сургалтыг амьдрал үйлдвэрлэлтэй холбон ажил мэргэжлийн дадлага олгох зэрэг ажлууд эрчимтэй явагдаж эхлэв.

Монгол хэл уран зохиолын багш О.Нямсүрэн нь сурагчдын дунд “Дэвтрийн зайг зөв ашиглах”, “Цэвэр гоё бичигтэн” болох, сурагч бүр “Арвич хямгач байх” хөдөлгөөн өрнүүлж туршлага нь аймгийн хэмжээнд нэвтэрч байжээ. Энэ багшийн даасан анги нь сургуулийн хөдөлмөрийн аварга анги болж байлаа. Тэр үед Ч.Дэмчиг багштай 86 анги Монгол улсын баатар Л.Даваадорж баатарын нэрэмжит улсын тэргүүний дэд бүлгээр шалгарч байв.

1974 онд Тээлийн бага сургууль байгуулагдаж газар нутгийн харъяалалаар 4-р багийн бага ангийн сурагчид багтаа анхан шатны боловсрол эзэмших боломжтой болжээ.

МАХН –ын төв хорооноос 1983 оныг сурагчийн жил болгохоор заасан тогтоол, МАХН-ын 18-р их хурал түүнээс хойш хуралдсан НТХ-ын бүгд хурлуудын шийдвэрийн дагуу боловсролын хуулийг хэрэгжүүлэх сурагчийн жилд зохиох ажлыг эрчимжүүлж, сургалт хүмүүжлийн ажлыг сайжруулах, сургалтын болон материаллаг баазыг бэхжүүлэхэд нэлээд амжилт гарч, хамт олны идэвх санаачлага дээшилж сургууль завсардалт буурч, сурлагын амжилт жилээс жилд ахиж байжээ.

Энэ үед сурагчдыг хичээлийн жил эхлэх, дуусах, улирлын амралтаар сургуульдаа ирэх гэртээ буцахад нь сумын төвөөс багийн төв, багаас сумын төвд тогтоосон өдөр нь машин унаа гаргаж нэгдсэн зохион байгуулалтаар

авч, тарааж байжээ.

Жил бүрийн намар хөдөлмөр соёлын чуулганаар эмнэг сургалт, сааль сүү, хадлан тэжээл, зуны даалгаварын аварга сурагч, анги бүлгүүдийг шалгаруулан урамшуулж байв.

1980 оны дунд үеэс багш нэг бүртэй ажиллах удирдлагын систем боловсронгуй болж сурган хүмүүжүүлэх удирдлагад чанарын ахиц гарч, сургалт ба хичээлээс гадуурх хүмүүжлийн ажилд сургуулийн захиргаанаас тодорхой чиглэлтэй хандаж сургалтыг бага ангиас нь эхлэж мэдлэгийг гүн бат эзэмшүүлж сурах ба сургах арга зүйд сургах, сурган хүмүүжүүлэх тэргүүн туршлагыг судлан нэвтрүүлж, тодорхой үр дүнд хүрэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, сургуулийн туслах аж ахуйтай болох зэрэг олон зорилтуудыг дэвшүүлж үр дүнтэй ажиллаж байжээ. Энэ үед сургуулийн захирал агсан Ж.Маналсүрэн, хичээлийн эрхлэгч агсан Н.Дашдаваа, М.Морхоон, ПАУ Галбадрах гэсэн удирдах ажилтан, ахмад багш Г.Долгорсүрэн, Ж.Дорж, Л.Ганболд, Р.Дуламсүрэн, Ж.Дэжээхүү, Гүнрэг, Т.Найдансүрэн, Ж.Далай, нярав А.Хадбаатар, аж ахуй Ш.Цэдэн –Иш нар нь идэвх санаачлагтай ажиллаж байжээ.

Багш нар асуудал шийдвэрлэх, /Тайлбартай дасгал/, С.Цагааны туршлага, орос хэлний хичээлд коммуниктовын зарчмыг ашиглах ээлжит хичээлд бүлэг сэдвээр бэлтгэдэг З.Хагаагийн туршлага зэрэг тэргүүн туршлагуудыг хичээл сургалтандаа ашиглаж үр дүнтэй хэрэглэснээр сурагчдын сурлагын амжилт чанарт ахиц гарч олон багш нар тэргүүн туршлагын эздээр тодорч байжээ.

Сурагчдыг хөдөлмөр сургалт, амьдрах хөдөлмөрт бэлтгэх ажлын хүрээнд зуны улиралд отор саалийг зохион байгуулан багш ажилчид сурагчдын ээлжээр ажиллуулдаг байлаа.

1987 онд дотуур байрны зориулалтаар анхны 2 давхар барилга баригдаж 250-иад хүүхэд байранд авах нөхцөл бүрдэж жилдээ 340-400 хүүхэд дотуур байрнаас хооллодог байлаа. Энэ нь малчдын хүүхдийг сургуульд хамрагдах аятай боломжийг хангах болсон юм. Хүүхдийг сургуульд бэлтгэхэд гэр цэцэрлэг улирлын чанартай байгуулж мэргэжлийн багш нар ажиллаж байлаа.

Өөрчлөн байгуулалтын явц улс орон даяар эрч хүчээ авч байсан үе буюу 1987-1988 оны байдлаар тус сургууль 700 сурагч 34 багш, 43 ажилчидтай 2.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ажиллаж байв.

Сургуулийн их түүхийг бүтээлцэж, нөр их хөдөлмөрөө зориулж ирсэн ахмад үеийн багш нар маань хүндтэй байр эзэлдэг юм.

### **1991-2000 он боловсролын шинэ тогтолцоонд шилжсэн үе шат**

1991-1992 оны хичээлийн жилд 615 сурагч, 27 багштай хичээллэж захирал Д.Бат-Эрдэнэ, хичээлийн эрхлэгч Ж.Лхагважав, Д.Цагаач, аж ахуйн захирлаар багш Ж.Гончиг ажиллаж ЗАН-ийн ажил тогтмолжиж багш нарын бүтээлч идэвх санаачлага өрнөсөн жил боллоо. Энэ хичээлийн жилд боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлалыг сургууль сумандаа хэрхэн өрнүүлэх талаар багш нар эцэг эхийн хамтарсан бага хурал хийж дараах



1990 онд Н.Дашдаваа захиралтай багш ажилчид

зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд :

- 1-р ангийн сурагчдыг хугацаанд нь уншуулж сургах,
- Монгол бичгийн орчин бий болгох
- Сургалтанд ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалыг сургалтын шинэ аргуудтай хослуулах, үр дүнд хүргэх
- Хүүхдийн цэцэрлэг, бага дунд ангийн залгамж холбоог сайжруулж гэрээтэй ажиллах
- Байрын сурагчдын дунд эрүүл аж төрөх ёс, нөхцөлийг бүрдүүлж халамж бүлэг ажиллуулах
- Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч бодитой зүйлийг хийх

Эдгээр зорилтуудын хүрээнд нэлээд олон ажил хийгдсэний дотор ажиллагсдын нийгмийн асуудалд анхаарч 24 хүний суудалтай цайны газар шинээр барин ашиглалтанд оруулах, туслах аж ахуйтай болохын тулд 50 эм ямаа, 30 хонь худалдан авч өвөлжөөний хашааг барьжээ. Мөн Буриадын Тункен районы Хойт голын сургуультай соёлын харилцаа тогтоож бүгд 12 багш ажилчдыг суруулийн зардлаар туршлага судлуулах, нутаг оронтой танилцах, ажлыг зуны амралтаар нь аяллын журмаар зохион байгуулж байв.

Аймгийн хэмжээнд зохиогдсон физик, математик, хими, биологи, монгол хэлний олимпиад болон сагс волейбол, бөх, хөнгөн атлетик, гэшүүрийн тэмцээн урлагийн “Яргуй” наадамд сурагчдыг бэлтгэн оролцуулснаас 10-р ангийн сурагч Д.Нарансайхан математикийн олимпиадад 5-р байр, сурагч Д.Дэлгэрмаа, Д.Баярмаа нар “Яргуй” наадмын

шагналт байранд орж, физикийн багш А.Баттөмөр физикийн хичээлийн олимпиадад 2-р байранд тус тус шалгарч байлаа.

Дотуур байранд малчин өрхийн 83 сурагчийг хамруулжээ. Энэ үед нь төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж нийгмийн өөрчлөлтийн эхний үе байсан учир сургууль завсардалт урьд жилүүдээс эрс нэмэгдэж, сурагчдын сурлагын амжилт чанар ч буурсан үзүүлэлтүүд гарч байжээ.

Гэвч манай сургуулийн багш ажилтан удирдлагууд энэ үед боловсролын салбарын ачааны хүндийг үүрч нэгэнт бий болсон хүнд байдлыг даван туулж гарах эзэд нь өөрсдөө гэдгийг сайтар ухаарч олон ургалч үзэл бүрэлдсэн үед мэргэжлийн ур чадвар, ур ухаанаа уралдуулан ажиллаж цагийн шалгарлыг давж гарах сэтгэлийн тэнхээтэй, нэгэн зорилготой ажиллаж сургалт хүмүүжлийн ажлаа явуулж аж ахуйгаа хөгжүүлэн сургуулийн материаллаг баазаа бэхжүүлж хичээлүүдийн олимпиадуудыг үе шаттай явуулж сурагчдыг амьдрал хөдөлмөрт бэлтгэх олон төрлийн ажлуудыг зохион явуулж үр дүнтэй ажиллаж байлаа.

Ээлжит хичээлийг кабинетын системээр явуулан кабинетуудыг үзүүлэн, тарааж өгөх материалаар баяжуулан сургуулийн хэмжээнд олон төрлийн тэргүүн туршлагуудыг нэвтрүүлэн багш Д.Сэвжээ, С.Дэмбэрэлмаа, Ж.Жаргалсайхан, Б.Халтар, А.Баттөмөр, Г.Цэвэлмаа, нар туршлагын эзэд болж заах арга, ур чадвар амжилт бүтээлээрээ бусдыгаа тэргүүлж байжээ.

1993-1994 оны хичээлийн жилд сургуулийн захирлаар Б.Баярнэмэх сонгогдон хичээлийн эрхлэгчээр Ж.Лхагважав ажиллаж, цугларалт 83 хувьтай, элсэлт 92 хувьтай, 26 багш 16 ажилтантай хичээл сургалтыг үйл ажиллагааг явуулж, багш нарын жилийн ажлыг нээлттэй хичээл, сэдвийн заах аргын боловсруулалт, түвшин тогтоох шалгалт, ажлын хариуцлага, ажлын цаг ашиглалт, хичээлийн хэрэглэгдэхүүн, шинээр санаачлан хийсэн зүйл, анги даалт, бичиг баримт хөтлөлт, хичээлээс гадуурх ажлын оролцоо гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэж оноожуулахад багш Д.Оюунчимэг, Ү.Содномпил, Э.Жаргалмаа, Б.Халтар, С.Дэмбэрэлмаа, Ц.Нарантуяа нар бусдыгаа хошуучлан тэргүүлж байсан байна.

Багш Г.Доржготов /физик, математик, монгол бичиг/ Ж.Маналсүрэн /газар зүй, математик, зураг, хөдөлмөр/ нар нь тодорхой мэргэжлээр мэргэшсэн хос мэргэжлээр ажиллаж чадах багш нарын судалгаанд бүртгэгдэж байжээ.

1994-1995 онд 13 анги бүлэгтэй 26 багш 455 сурагчидтай 16 ажилтантай сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаагаа явуулж захирлаар Б.Баярнэмэх, хичээлийн эрхлэгчээр Ж.Лхагважав нар ажиллаж байжээ.

Энэ хичээлийн жилд сургалтын ажлын хүрээнд хийсэн ажлуудаас дурдвал:

Сургуулиас завсардсан хүүхдийн судалгааг нарийн гаргаж, завсардсан шалтгаан, дахин сургуульд суралцах боломж бололцоог судлах түүнийхээ үндсэн дээр 8-р сард бүх багш нараа айл өрхүүдээр хуваарилан өгч унаагаар хангаж “Сургууль боловсрол” сэдвээр ухуулга сурталчилгааны ажил зохион явуулсан ба сургуулийн дотуур байранд суух сурагчдыг тоон

хязгааргүйгээр хүлээн авч хоол хүнс үйлчилгээний бүх зардлыг сургуулийн төсвөөс гаргах, амьдралын хүнд нөхцөлд сурч байгаа сурагчдыг сургуулийг гал тогооноос үнэгүй хооллох зэрэг бодлогын шинж чанартай арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 28 сурагчийг сургуульд буцаан хамруулж сургууль завсардалтыг тодорхой хэмжээгээр бууруулсан байна. Заах аргын нэгдлийн ахлагч нарыг шинээр томилон тэдний ажлын төлөвлөгөөг сар бүрээр хянан тооцож, үүрэг даалгавараар ханган, хийх ажлыг нь тодорхой болгон ажилласнаар ЗАН-ын ажил тогтмолжин чанаржиж багш нар багаар хамтарч ажиллах халуун уур амьсгал бүрдэж, багш нарын бүтээлч үйл ажиллагаа нэмэгдэж ажлын бүтээмж сурлагын сурц ахисан байна.

Чөлөөт цагийн сургалтыг хэд хэдэн чиглэлээр явуулж 10-р ангид суралцагчдыг сонгон суралцах хичээлд хамруулж, тэднийг дараачийн шатны сургуульд бэлтгэх нэмэлт сургалтуудыг зохион явуулж эхэлжээ.

Хичээлүүдийн олимпиад, урлаг спортын уралдаан тэмцээнүүдэд оролцогчдын тоог нэмэгдүүлж бэлтгэлийг чанаржуулах бодит ажлыг зохион явуулснаар аймгийн олимпиадад оролцсон сурагчдаас газар зүйн хичээлээр 2-р байр, химийн хичээлээр 6-р байр, шатрын тэмцээнд 2-р байранд тус тус шалгаран оролцжээ.



*Бага сургуулийн анхны төгсөгчид 60 жилийн ойн үеэр:  
Баруун талаас Санжаа, Д.Дэмбэрэл, Дашдэлэг, Д.Дуйнхаржав*

Туслах аж ахуйн малын тоо 320 хүрч багш ажилчдын нийгмийн асуудалд анхаарч цайны газрын хоолыг 30 хувиар хямдруулан үйлчилж байжээ.

Сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулахад анхаарч спорт заал, 50 хүүхдийн хичээлийн байранд уурын халаалтын төхөөрөмжийг суурилуулан ажиллуулж эхэлсэн ба сургуулийн аж ахуйн үйлчилгээний ажилд хэрэглэхээр “Урал” моторт хөрөөг иж бүрдлийн хамт худалдан авч “Хонда” цахилгаан үүсгүүрийн мотор, угаалгын “Эврико” машин зэрэг техник хэрэгслүүдийг засаж сэлбэн ашиглалтанд оруулжээ.

1995-1996 оны хичээлийн жилд 432 сурагч 20 багштай захирал Ж.Маналсүрэн, хичээлийн эрхлэгч Ж.Лхагважав, хүмүүжлийн эрхлэгчээр Б.Бурмаа нар ажиллаж байв.

Энэ хичээлийн жилийн эхэнд “Орчин үеийн хичээлийн технологи” сэдвээр онол мэтгэлцээн явуулж, анги бүлгүүдээс бүх хичээлүүдээр төвшин тогтоох шалгалт авч жилийн ажлын зорилго зорилтоо тодорхойлсон 7 хоногоор ажлын төлөвлөгөөгөө гарган биелэлтийг тооцон ажиллаж байжээ.

Ажилчдын дунд түлш, операц зохион байгуулж дүгнэж, идэвхтэй оролцсон хүмүүсийг шагнаж урамшуулж байжээ.

Сургуулийн хөгжлийн хэтийн төлөвлөлтийг

-Төсөв санхүү

-Сургуулийн бүтэц

-Сургалтын материаллаг бааз

-Орон сууц гэсэн чиглэлээр боловсруулан гаргажээ.

Сурагчдын дунд уран уншлагын аварга шалгаруулж сурагч Х.Батцагаан аварга болж байсан.

Боловсролын жилийн ажлын нээлт хийж багш сурагчдын хамтарсан тоглолт хийж боловсролын жилийг дэмжих сан байгуулжээ.

1996-1997 оны хичээлийн жилд өмнөх хичээлийн жилийнхээ ажлыг ярилцаж багш нар сурган хүмүүжүүлэх ажилдаа тодорхой үр дүнд хүрсэн, хамт олны бүтээлч санаачлага сайн байлаа гэж ололтоо дурьдаад

-Сургуулийн удирдлагын арга ухаан дутмаг

-Мэргэжлийн багш нар дутмаг

-Эдийн засгийн хүндрэл бэрхшээл

-Үйл ажиллагаандаа анализ хийж дүгнэх чадвар сул

-Эд хөрөнгө элэгдэлд орсон

-Туслах аж ахуйн эх үүсвэр бага гэх зэрэг дутагдалтай зүйлүүдээ дүгнэн шүүгээд шинэ хичээлийн жилдээ:

Боловсролын системийн шинэ тогтолцоонд эрх зүйн баримт бичиг олноор гарч шавь төвтэй сургалтын арга зүйд шилжиж, хүүхдийг амьдрах арга ухаанд сургах чиглэл баримтлах зорилгын хүрээнд:

-Боловсрол, хууль, эрх зүйн баримт бичиг суртчилах, ойлгох

-Ажиллагсдын эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг судалж, бололцоо нөхцөлөө ашиглан бие дааж сурч хөгжихөд нь тусалж дэмжих гэсэн зорилтууд дэвшүүлж сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Багш бүрт байгаа сайн эхлэлийг дэмжиж мэргэшүүлэх, тэдний дунд сургалтын шинэ тогтолцоонд чиглэсэн сургалт, уралдаан тэмцээнийг олон хэлбэрээр зохион явуулж багш нараа хөгжүүлж байжээ.

Сургууль дээр талх барих, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, бизнес эрхлэх хөдөлгөөн өрнүүлж ногоо тариалах, зэрэг аж ахуйн үр дүнтэй ажлуудыг хийжээ.

Үнэлгээнд тестийн хэлбэр орсноор хичээл бүрийн агуулгыг шалгах сонгомол тестүүдийн сантай болжээ.

Ёс суртахууны цагаан толгой буюу эрхэмлэж явах зүйлийн жагсаалт анги бүлгүүдээр гарган мөрдлөг болгож хэвшсэн байна.

Ажиллагсдын мал ба өрхийн орлогын судалгааг гаргаж малжуулах,

амьдрал ахуйд туслах талаар бодлоготой хандаж тэднийг ажлын үр дүнгээр нь туслах аж ахуйн орлогод тулгуурлан хүүгүй зээл олгож эхэлсэн нь нэг талаас тэднийг үр дүнтэй сайн ажиллах эдийн засгийн хөшүүрэг болж нөгөө талаас ажиллагсадын ахуй амьдралаа дээшлүүлэхэд их хэмжээний түлхэц болж чадаж байсан.

1990-ээд оны сүүлчээр орчин үеийн технологийн элемент болох сурагч сурагчаасаа суралцах, багш сурагчаас суралцах, сурагч орчноосоо суралцах асуудлыг судалж багш нарын заах арга, ур чадвар шинэчлэгдэж, сурагчдын сурлагын амжилт чанарт ахиц гарч, хичээлээс гадуурх сургалтын ажлын тоо чанарт өөрчлөлт орж бүс аймгийн хэмжээний ур чадварын уралдаан, хичээлүүдийн олимпиад, шатар даам, сагс, волейбол, самбо, жудо, үндэсний бөхийн төрлүүд, урлагийн “Яргуй” наадам, хүүхдийн шүлгийн “Хүрэл тулга”, “Уран жиргээ” зэрэг тэмцээнд багш нар сурагчдаа бэлтгэл сайтай оролцуулж шагналт байрууд эзэлж байв.

### **Боловсролын шинэ тогтолцоонд шилжсэн үе буюу 2000-2010 онд хийгдсэн бүтээлч ажлууд**

Энэ үед 80 хүүхдийн дотуур байрны дээврийн засвар болон халаалтын засвар, 75 хүүхдийн дотуур байрны их засвар, 50 хүүхдийн дотуур байрны их засвар, 320 хүүхдийн хичээлийн байрны их засвар нийт 200 гаруй сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засвар хийгджээ.

Сургуулийн спорт заал, 6 настны бие засах газар шинээр баригдлаа.

Хуучин халуун усыг засварлаж дотуур байрны сурагчдыг долоо хоног бүр усанд орж байх ая тухтай нөхцлөөр хангажээ.

Сургуулийн номын санг эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр байгуулж номын фондод 10 мянган номтой болж, багш нарыг мэргэжлийн хичээлүүдийн гарын авлагатай болгож сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх ая тухтай нөхцлийг бүрдүүлсэн байна.

Физик, хими, биологийн хичээлийн лабораторитой болсон. Мөн 14.5 сая төгрөгөөр цайны газар, чийрэгжүүлэх танхим бүхий барилга шинээр барьж ашиглалтанд оруулжээ.

Мөн зургаан настны хоёр ангийг иж бүрэн тохижуулж, анхан шатны сургалтын заах аргын нэгдлийг зөөврийн компьютер, дэлгэц, болон байгалийн ухааны хичээл, монгол хэлний хичээлийн иж бүрэн хэрэглэгдэхүүнтэй болгож сургуулийн дуу хөгжмийн кабинетыг туслах аж ахуйгаас үндэсний хөгжмөөр хангаж, албан бус боловсролын кабинетыг тохижуулж гэрчилгээжүүлсэн байна.

Дотуур байрандаа угаалгын машин, телевизор, магнитофон, 1-р хоолны тогоо, махны цахилгаан машинтай болсноор байрны сурагчдын амьдрах ая тухтай орчныг бүрдүүлж тэнд ажиллагсдын ажлын ачааллыг хөнгөвчилж чаджээ.

Үүний зэрэгцээ 75-80 хүүхдийн дотуур байр, 320 хүүхдийн хичээлийн байранд гэрлийн монтажийг шинэчлэн хийж бүх объектод газардуулгыг зургийн дагуу хийсэн нь багш сурагч, ажиллагсдыг байнгын компьютер болон бусад техник хэрэгсэл дээр аюулгүй ажиллах нөхцөлөөр хангасан юм.

Сургуулийн гадна талбайд шар хуайс, шинэс, чацаргана, саваа модыг тариалж цэцэрлэгжүүлэх эх үүсвэр тавьснаар сургуулийн орчинд экологийн тэнцвэрт байдлыг хангах анхны алхам болов.

Дэлхийн зөн Олон улсын байгууллагын төслөөр дотуур байрны ширээ сандлыг шинэчилсэн ба “Тогтвортой амжиргаа-2 төслөөр дотуур байрны хатуу зөөлөн эдлэлийг 6.5 сая төгрөгийн өртөгтэйгээр шинэчлэн сайжруулсан байна.

Мөн шилэн кабелиар интернетэд холбогдсон нь сургалтын чанарт сайнаар нөлөөлж багш сурагчдыг орчин үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй авч байх бололцоогоор хангаж өгөв.

2000-2010 онд төвлөрсөн сургалтанд 17 хүн хамруулж, 3 багш бакалавр зэрэгтэй төгссөн байна.

### **Сургууль өнөөдөр /Баримт мэдээ/**

#### **Сургуулийн хэв шинж**

Бага, дунд ангиуд ердийн болон хөгжүүлэх сургалттай, мини волейбол, бөхийн секц, байгалийн ухаан, математик, хэлний сонгон, бүжиг, шатар, зураг, цэцгийн дугуйланд хамрагдан хичээллэдэг.

2014-2015 оны хичээлийн жилдээ нийт 24 бүлэгт 688 сурагч хичээллэж байна. Удирдах ажилтан 4, багш сурган хүмүүжүүлэгчид 37, үйлчилгээний ажилтан 33 байна. Захиргаа аж ахуйн, Дотуур байр, Сэтгэмж ЗАН, Хүмүүнлэг ЗАН, Авъяас технологи, Анхан шатны заах аргын нэгдэл гэсэн нэгжүүдтэй хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Нийт багш, удирдах ажилтнаас

Алтан гадас одонтой 1, Хөдөлмөрийн хүндэт медаль 2, БТА 11, БТСТА 3, СТА 1, Тэргүүний ардын авъяастан 2, Спортын мастер 1,



*Оюунчимэг захиралтай Төмөрбулаг сумын 12 жилийн сургуулийн хамт олон*



Сургуулийн ажилчид

Аймгийн тэргүүний ажилтан 3, Мэргэжлийн Тэргүүлэх зэрэгтэй 5, Заах аргач 14, Магистр 8, аймгийн ур чадварын уралдааны аварга 2 байна. өндөр хурдны интернет бүхий компьютерийн лаборатори, физик, хими биологийн иж бүрэн лабораторитой хичээл сургалтын 18 танхимтай, хүүхэд хөгжлийн танхим 1, 6000 гаруй номтой номын сантай.

#### Хүүхдийн оролцооны байгууллага

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 2011-2015 оны хичээлийн жилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой СИОН буюу сэтгэл итгэл оюуны нэгдэл, GOLD GOLLAR, Өсвөрийн улаан загалмай, Өсвөрийн цагдаа, Тэмүүлэл клуб, сурагч судалгаа, ХОУЗ зэрэг 7 байгууллага байгуулагдаж тус тусдаа чиглүүлэгч багштайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

#### Амжилт

Э.Батжаргал дасгалжуулагчтай “МИНИ” волейболын секц хичээллэж 2012, 2014 оны аймаг, улсын аваргаар шалгарсан.

Багш Ц.Баянмөнх “Үндэсний бөх”-ийн төрлөөр аймгийн өсвөр үе залуучуудын аварга шалгаруулах тэмцээн, “Алтан дуулга” ХХК-ний нэрэмжит тэмцээнд сурагчдыг бэлтгэн тогтмол өндөр амжилтыг гаргаж байна.

Яргуй “Хүүхдийн урлагийн наадам”-д бүсийн аварга, аймгийн 3 удаагийн аварга “Зөнгийн одод” тэмцээнээс 26 алт, мөнгөн медаль хүртсэн авьяаслаг сурагчидтай сургууль юм.

#### Бүс аймаг, улсын олимпиадад

Багш Д.Мягмармаа монгол хэлний олимпиадаас алтан медаль, хошой хүрэл медальтай. Багш Л.Мяпан Монгол бичгийн олимпиадаас хошой мөнгөн медаль, 1 хүрэл медаль, монгол хэлний олимпиадад хүрэл

медальтай, 2011-2012 оны хичээлийн жилд Багш З.Одсүрэн аймгийн биологийн олимпиадаас алтан медаль, мөн улсын олимпиадад амжилттай оролцсон, багш Г.Баясгалан англи хэлний олимпиадаас хүрэл медаль хүртсэн байна.

#### Манай сургуулийн бренд

Сургуулийн туслах аж ахуйг хөгжүүлж 700 гаруй эрчим омгийн ямаатай, өөрийн орлого болох 15 сая төгрөгөөр хоёр давхар цайны газар шинээр барьж, багш ажилтандаа 40 хувийн хөнгөлөлттэй халуун хоол цайгаар үйлчилдэг.

Мөн “Биеийн тамирыг дэмжигч хамт олон” уриан дор чийрэгжүүлэлтийн иж бүрэн тоног төхөөрөмж, ширээний теннисний хэрэгслийг суурилуулсан, долоо хоногийн лхагва гараг бүр багш ажилтанд эрүүл мэндийн хичээл орж хэвшсэн байна.

2011 оны ажлаараа аймгийн “Хүүхдэд ээлтэй сургууль” -аар шалгарсан.

2009-2010 оны хичээлийн жилд тус сургууль 23 бүлэгт 743 сурагч суралцсанаас анхан шатны сургуульд 439 суурь боловсролын түвшинд 244 сурагч бүрэн дунд боловсролын түвшинд 90 сурагч суралцаж анги дэвшиж сургууль төгссөн. Дөрвөн удирдах ажилтан, 34 багш 32 ажилтантай. Багш нараас магистр 3, магистрант 3 бакалавр 20, тэргүүлэх зэрэгтэй 13, заах аргач зэрэгтэй 5, АБТА-5, СТА-1, БТА-1, БСШУЯ-ны хүндэт жуух бичигтэн 5 байна. Захиргаа аж ахуй, дотуур байр, анхан шатны заах аргын нэгдэл, байгалийн ухааны ЗАН, хүмүүнлэгийн ухааны ЗАН гэсэн ажлын 5 нэгжээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

12 жилийн сургалтын хөтөлбөрөөр 1-р ангид 52, 2-р ангид 64, 7-р ангид 49 сурагч суралцсан. Анхан шатны боловсролыг 79 сурагч, суурь боловсролыг 60 сурагч бүрэн дунд боловсролыг 48 сурагч эзэмшиж төгссөн ба дүйцсэн хөтөлбөрөөр 4 суралцагч, эчнээ сургалтаар бүрэн дунд боловсролыг 6 эзэмшиж төгсөв.

Тус сургууль нь туслах аж ахуйн 570 гаруй малтай 1260604.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 109259,2 мянган төгрөгний эргэлтийн хөрөнгөтэй. 352905,2 мянган төгрөгийн төсөвтэй.

2011 оны ажлаараа АШСЗАН-ийн хамт олон шалгаран шилдэг заах аргын бүтээлээ “Оюунлаг Хөвсгөл” хөтөлбөрт танилцуулан амжилттай оролцсон байна.

Мөн 2012 оны 11 сард Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хот, Дорноговь аймгийн Сайншанд Хамрын хийд-Энергийн төв хүртэл хамт олноороо аялахад нь сургуулиас зохих дэмжлэг үзүүлсэн байна.

#### Хамтран ажилладаг байгууллагууд

Дэлхийн зөн Монгол ОУБ

Тогтвортой амжиргаа-2 төсөл

СХҮЭБИБҮТХ төсөл буюу боловсролын багц тусламж

Тус сургууль нь Багш хөгжлийн иж бүрэн кабинеттай, багшийн хөгжлийн бодлого боловсруулж мэдлэг мэргэжлийн ур чадварыг хэтийн үйл ажиллагаанд тулгуурлан ажлын байрандаа багшаа хөгжүүлэн сургуулийн хөгжилд бодит үр дүнгээ өгч ирсэн.

Төмөрбулаг сумын гэрэлт ирээдүй өсвөр үеэ амьдрах ухаанд сургах, хүмүүнлэг, оюунлаг иргэд болгох ариун үйлсэд ахлах сургуулийн хамт олон оюуныг ундруулан, ухааныг бадрааж, эрдмийг оргилуулан, авьяасыг хөгжүүлж бүтээлч хөдөлмөрөө зориулж явна.

**Тус сургуулийн анхдагчид**

Анхны захирал: И.Давааням,  
 Анхны багш : Б.Хярваа  
 Анхны эмэгтэй захирал: н.Нансалдулам  
 8 жилийн сургуулийн анхны захирал: Б.Дамба  
 10 жилийн сургуулийн анхны захирал: Д.Бат-Эрдэнэ  
 Анхны 8-р анги төгсгөсөн багш: Г.Долгорсүрэн  
 Анхны 10-р анги төгсгөсөн багш: н.Дарханболд  
 Анхны 11-р анги төгсгөсөн багш: Ц.Нарантуяа  
 Анхны пионерийн удирдагч :Ч.Дэмбэрэлням  
 Анхны ээлжийн хичээлийн эрхлэгч: Р.Дуламсүрэн  
 Бага сургуулийн анхны аж ахуйн эрхлэгч: Д.Бат-очир  
 8 жилийн сургуулийн анхны аж ахуйн эрхлэгч: Ч.Сүмбэрэлдорж  
 Анхны жолооч :Ж.Төмөрбаатар  
 Анхны тогооч : н.Долгор  
 Анхны эмч: Д.Энхбаяр  
 Анхны галч н.Лувсан  
 Анхны мэргэжлийн номын санч Б.Мөнхтөр  
 Анхны мэргэжлийн архив, бичиг хэргийн эрхлэгч Г. Батцэцэг  
 Анхны бүлгэмийн зөвлөлийн дарга: Л.Насанцэцэг  
 Анхны сурагчдын зөвлөлийн дарга Б.Нямсүрэн  
 Анхны байрын зөвлөлийн дарга Ц.Өлзийдүүрэн  
 Анхны байрын багш : Д.Лхагважав  
 Анхны доктор (Ph. D) А.Саранчимэг  
 Анхны сурлагын алтан медальт Б.Бурмаа  
 Анхны мөнгөн медальт: Д.Даваадорж  
 Анхны сурлагын хүрэл медальт : Д.Баярсүрэн  
 Анхны 5 онцын эзэн : Р.Цагаанбаатар  
 Анхны спортын зэрэгтэй тамирчин : Б.Ганхуяг  
 Анхны малчин М.Дорж  
 Анхны улсын тэргүүний дэд бүлэг Ч.Дэмчиг багштай 1978 оны 3-р төгсөлт  
 Анхны урлагийн Алтан медальт хамтлаг (А.Саранчимэг,Б.СарантуяаЦ.Билэгдэмбэрэл,А.Мөнхгэрэл)  
 Анхны сургуулийн хөдөлмөрийн аварга бүлэг О.Нямсүрэн багштай 1985 оны 9-р төгсөлт

**Захирлууд**

№	Нэр	Он
	И. Давааням	1940-1941
	н Нансалдулам	1941-1942
	Б.Хярваа	1942-1943
	н Нямжанцан	1943-1944
	Б.Хярваа	1944-1945
	н Лувсангомбо	1945-1946
	Б.Хярваа	1946-1951
	Д.Ядамжав	1951-1953
	Т.Должинсоргодог	1953-1955
	С.Цэрэнбалжир	1955-1961
	И.Бямбаа	1961-1965
	Д.Халтар	1966-1969
	н Лханаа	1969-1970
	Д.Дамба	1970-1974
	Д.Мишингээ	1975-1976
	Т.Найдансүрэн	1977-1982
	Ч.Дашдаваа	1982-1986
	Ж.Маналсүрэн	1986-1990
	Б.Бат-Эрдэнэ	1990-1992
	Б.Баярнэмэх	1993-1994
	Ж.Маналсүрэн	1994-2000
	Ж.Лхагважав	2000- оноос
	П.Оюунчимэг	2014 оноос

**Хичээлийн эрхлэгч, технологич, менежерүүд**

№	Нэр	Он
1	Д.Мишингээ	1972-1974
2	А. Баттулга	1975-1976
3	Д.Ярман	1977-1979
4	Г.Доржготов	1979-1980
5	Н.Давааням	1980-1982
6	Ж.Дорж	1982-1986
7	Д.Гүнрэг	1986-1987
8	Н.Дашдаваа	1986-1988

9	Р.Дуламсүрэн	1986-1987 ээлж
10	М.Морхоон	1987-1989 ээлж
11	Ж.Далай	1988-1989 ээлж
12	Ц.Адъяахүү	1988-1990
13	Д.Цагаач	1989-1990 ээлж
14	Ж.Лхагважав	1990-1997
15	П.Оюунчимэг	1997-1998
16	Я.Ариунтунгалаг	1997-1998 ээлж
17	Ж.Лхагважав	1998-2000
18	Д.Оюунчимэг	2000-2001 ээлж
19	Ц.Нарантуяа	2000-2001
20	М.Лхамсүрэн	2001-2002
21	Ж.Жаргалсайхан	2002-2003
22	Д.Далайжаргал	2003-2004
23	Д.Нарансайхан	2004-2007
24	П.Оюунчимэг	2007-2009
25	Б.Энхжаргал	2009-оноос

**Сургуулиас төрсөн алдартнууд**

**1. Монгол улсын хөдөлмөрийн баатар**

№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
1	П.Цагаач	БНМАУ-ын хошой аварга, хөдөлмөрийн баатар, малчин	1955 оны төгсөгч

**2. Аймаг улсын аваргууд**

№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
1	Д.Амартүвшин	Улсын хошой аварга тээвэрчин	1980 оны 8 төгсөгч
2	Б.Батмөнх	Улсын хошой аварга малчин	1970 онд бага анги төгссөн
3	Ч.Цэрмаа	Улсын аварга хадланч	
4	Г.Отгонбаяр	Аймгийн 2 удаагийн аварга малчин	1969 оны төгсөгч
5	Ж.Даваажав	Аймгийн 2 удаагийн аварга малчин	
6	Б.Алтанцэцэг	Аймгийн 2 удаагийн аварга малчин	1969 оны бага анги төгссөн
7	Л.Тэгшбаяр	Аймгийн аварга малчин	1979 оны төгсөгч
8	Х.Ням-Очир	Аймгийн 2, сумын 3 удаагийн аварга	1967 оны төгсөгч

**Гавьяат цолтнууд**

№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
1	Г.Ёндонжамц	Аж үйлдвэрийн гавьяат ажилтан	1944 оны төгсөгч

**Эрдэмтэн судлаачид**

№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
1	Х.Дамдинсүрэн		
2	Цэнд-Аюуш		1964 оны төгсөгч
3	З.Жадамба		1956 оны төгсөгч
4	Ж.Үржгэр		1958 оны төгсөгч
5	Б.Чойдог	МУ-ын дэд эрдэмтэн	Анхны сурагч
6	О.Гунаа	Багш, лектор улс төрийн ажилтан	Анхны сурагч

**Байлдааны гавьяаны улаан тугийн одонт**

№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
1	Д.Цагаанбаатар	Хурандаа /асан/	1958 оны төгсөгч
2	З.Батбаатар	Шүхэрчин /асан/	1971 оны төгсөгч

**АИХ-ын төлөөлөгчид**

№	Нэр	Хэдэн онд сурч байсан
1	Ш.Хасбазар	
2	Б.Лунхай	
3	Д.Даваадорж	

**Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт**

№	Нэр	Хэдэн онд сурч байсан
1	А. Хишигсүрэн	
2	Д.Бүжлхам	1948 оны бага анги
3	Б.Лунхай	
4	Б.Түмэндэмбэрэл	1957 оны бага анги
5	Ч.Доржпалам	1948 оны төгсөгч

**Спортын мастер, зэрэгтэй тамирчид**


№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
1	Г.Пүрэвдорж	Шатрын спортын мастер, аймгийн 29 удаагийн аварга шатарчин	1957 оны бага сургууль төгсөгч
2	Н.Нандинбилэг	Олс таталтын төрлөөр олон улсын хэмжээний мастер	2007 оны төгсөгч
3	П.Цагаанбаатар	Морин спортын мастер	1965 оны төгсөгч
4	Г.Чадалбат	Явган спортын мастер	
5	Д.Алтантөгс	Хөнгөн атлетикийн мастер	Биеийн тамирын багш
6	П.Цэцгээ	Хөнгөн атлетикийн мастер	
7	Т.Түвшинжаргал	Сагсан бөмбөгийн 3-р зэрэгтэй	2000 оны
8	Д.Цэдэндамба	Тэшүүрийн 1-р зэрэгтэй	1990 оны төгсөгч
9	Л.Бат-Эрдэнэ	Гүйлтийн 1-р зэрэгтэй	1978 оны төгсөгч
10	Д.Дашзэвэг	Шатрын 1-р зэрэг	
11	Г.Тэрбиш	Цанын 1-р зэрэгтэй	
12	И.Даваажаргал	Хүндийн өргөлтийн 1-р зэрэгтэй	
13	Б.Ганхуяг	Сагсан бөмбөгийн 1-р зэрэгтэй	1974-1976
14	Р.Цагаанхүү	Сагсан бөмбөгийн 2-р зэрэгтэй	1974-1976
15	А.Саранчимэг	Сагсан бөмбөгийн 3р зэрэгтэй	1986
16	Р.Бямбагэрэл	Зээрэнцэг, бөөрөнцөг шидэлтийн 1-р зэрэгтэй	

**Суманд түрүүлсэн ба аймаг улсын цолтой бөхчүүд**


№	Нэр	Шагнал	Хэдэн онд сурч байсан
	М.Эрдэнэбат	Аймгийн хурц арслан	1999 оны төгсөгч
	Ч.Түмэндэмбэрэл	Цэргийн арслан	1953 оны төгсөгч
	Ч.Хүрэлчулуун	Аймгийн начин	1989 оны төгсөгч
	Д.Түвд	Сумын заан	1948 оны төгсөгч
	С.Давааням	Сумын заан	1948 оны төгсөгч
	Т.Төөчөө	Сумын заан	1951 оны төгсөгч
	П.Цагаач	Сумын заан	1955 оны төгсөгч
	С.Мөнх-Очир	Сумын заан	1956 оны төгсөгч
	Ч.Төртогтох	Сумын заан	1954 оны төгсөгч
	Д.Чулуунхүү	Сумын заан	1965 оны төгсөгч

	Ч.Лхагвасүрэн	Сумын заан	1965 оны төгсөгч
	Х.Жамжаа	Сумын заан	1952 оны төгсөгч
	П.Банзрагч	Сумын заан	1956 оны төгсөгч
	Д.Лхагвасүрэн	Сумын заан	1970 оны төгсөгч
	И.Ганболд	Сумын заан 2 удаа	1969 оны төгсөгч
	Б.Ганхуяг	Сумын заан 2 удаа	1976 оны төгсөгч
	Т.Буян-Амгалан	Сумын заан	1989 оны
	Д.Лхагвадорж	Сумын заан	
	Т.Эрдэнэбат	Сумын заан	1985 оны төгсөгч
	Д.Отгонбаатар	Сумын заан	1999 оны төгсөгч
	Д.Бат-Эрдэнэ	Сумын заан	
	Л.Ганболд	Сумын заан	2006 оны төгсөгч
	Б.Баяраа	Сумын заан	
	Ц.Хатанбаатар	Сумын заан	1995 оны төгсөгч
	Ц.Баянмөнх	Сумын заан	2000 оны төгсөгч
	Ч.Хасбаатар	Сумын заан	1987 оны элсэгч
	Ч.Цолмон	Сумын заан	2002

**Үе үеийн захиралууд**



Анхны захирал  
И.Давааням



Анхны багш,  
захирал Б.Хярваа



Захирал  
С.Цэрэнбалжир



Захирал, багш  
И.Бямба



Захирал, багш  
Д.Халтар



Захирал, багш  
Д.Дамба



Захирал, багш  
Д.Мишингээ



Захирал, багш  
Т.Найдансүрэн





Захирал, багш  
Ч.Дашдаваа



Захирал, багш  
Ж.Маналсүрэн



Захирал, багш  
Д.Бат-Эрдэнэ



Захирал, багш  
Б.Баярнэмэх




Захирал, багш  
Ж.Лхагважав



Захирал, багш  
Ц.Оюунчимэг

**БАТДЭМБЭРЭЛИЙН ДАМБА**

Төмөрбулаг сумын 9-р багийн нутаг, Нарийнд 1929 онд төрсөн. 1945 онд долдугаар ангиа төгсөөд Сумын захиргаанд гар бичээчийн ажил хийж байсан. Тэрээр Бага ангийн багш нарыг бэлтгэх курст суралцаж, Төмөрбулаг сумын бага сургуульд багшилж байлаа. Б.Дамба 1965-1969 онд аймгийн Гэгээрлийн хэлтэст ажиллаж байгаад Галт сумын хичээлийн эрхлэгчээр дөрвөн жил ажиллажээ. Тэрээр 1972 оноос Төмөрбулаг сумын дунд сургуулийн анхны захирлаар томилогдон ирж ажиллаж байсан юм. Түүний эхнэр Өвгөн овогтой Мажигханд 1928 онд төрсөн. 1948 оноос 1961 он хүртэл Төмөрбулаг сумын дунд сургуульд мөн багшилж байжээ.



**АЮУШЖАВЫН БАТТУЛГА**

1944 онд төрсөн. 1969 онд Улсын багшийн сургуулийг газар зүйн багш мэргэжлээр төгсөж, Завхан аймгийн Шилүүстэй суманд ажиллаж байгаад 1974 онд эхнэр Ч.Янжинхүүгийн хамт хамт Төмөрбулаг сумын найман жилийн сургуульд ирж багшилж байжээ. Багшийн хүрэлцээ муу газар зүйн багш мэргэжилтэй ч эхнэр нь биологийн хичээл, А.Баттулга багш орос хэлний хичээл заадаг байсан аж.Тэрээр үлээвэр хөгжим тоглодог, сайхан дуулдаг, төрөл бүрийн авьяастай нэгэн байсан гэнэ. А.Баттулга тус сумын сургуульд хичээлийн эрхлэгчээр мөн ажиллаж байжээ.



**ТӨМӨРБУЛАГ СУМЫН  
“ЧАНДМАНЬ” ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ**



Сум нэгдлийн дарга Ч.Лхамсүрэнгийн санаачлагаар 1971 онд “Давшилт” нэгдлийн хөрөнгө хүчээр цэцэрлэгийн барилга барьж, 1971 оны есдүгээр сарын 01-нд 25 хүүхэд, эрхлэгч багш, асрагч, тогооч гэсэн гурван орон тоотой анх хүүхдийн цэцэрлэг нээгджээ. Төмөрбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн анхны эрхлэгч багшаар тус сумын харьяат Лувсанжамцын Цэрэндулам, тогооч Даваа, асрагч Дэнсмаа нар ажиллаж байлаа. Хүүхдийн цэцэрлэг нь нэгдлийн төсөв хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тэр цагаас хойш Ц.Юмжирдулам, Чанцалдулам, Бямбажав, Д.Доржпагма, Л.Далантай, Г.Хандсүрэн, А.Амаржаргал нар эрхлэгч багшаар ажиллаж сургуулийн өмнөх насны хүүхдийг асран хамгаалж, сурган хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, танин мэдэхүйн анхны дадал хэвшил олгох, баримжаатай болгох талаар их зүйлийг хийж байлаа. 1983 оноос 50 хүүхэд, 6 орон тоотой болон эрхлэгч багшаар Д.Доржпагма, хүмүүжүүлэгч багшаар Ц.Оюундэлгэр, асрагч Б.Ургаа, А.Оюунчимэг, тогооч



Янжин, сахиул Дуламсүрэн нар ажиллаж байв. 1983 онд анхны мэргэжлийн хүмүүжүүлэгч багшаар Ц.Оюундэлгэр, 1985 онд Н.Хишигдорж нар ирж ажиллаж байв. 1984-1985 онд эрхлэгч Д.Доржпагма, Багш Г.Жүгдэрнамжил, Н.Хишигдорж, тогооч Цэрэнбалжир, асрагч Г.Бадамцэцэг,



А.Оюунчимэг, сахиул Дуламсүрэн нар ажиллаж байв. 1987 онд 9 орон тоотой болж эрхлэгчээр Отгонжаргал, багшаар Жүгдэрнамжил, Н.Хишигдорж, тогооч Цэрэнбалжир, асрагч Б.Ургаа, А.Оюунчимэг, нярав Лхагваа, Туслах тогооч Амгалан, сахиул Ц.Батмөнх нар ажиллаж байв. 1993 онд сумын яслийг татан буулгаж нэгдэл дундын үйлдвэрийн барилгачдын барьсан зориулалтын байранд ясли- цэцэрлэгийн комбинат болон 75 хүүхэд, 11 орон тоотой болж эрхлэгчээр нь Л.Далантай, багшаар Ё. Нэргүй, Г.Жүгдэрнамжил, Н.Хишигдорж, Туслах багшаар А.Оюунчимэг, Б.Мөнхнасан, Д.Дуламжав, тогооч А.Амаржаргал, Амгалан, галч сахиул Ж. Баттогтох, нярав Ч.Хүрэлтогтох, угаагч П. Цагаанхүү ня-бо М.Буяндэлгэр нар ажиллаж байв. 1997-2000 онд эрхлэгчээр Г.Хандсүрэн багш, 2000-2010 онд эрхлэгчээр Л.Далантай багш ажиллаж байлаа. 2010 онд 4 бүлэгт 100 хүүхэд, 17 орон тоотой болж эрхлэгчээр нь А.Амаржаргал ажиллаж байна. Тус цэцэрлэг нь хүүхдийн ая тухтай орчинг бүрдүүлэхэд анхаарч байгууллагын гадна дотно орчинг өөрсдийн хүчээр тохижуулах мөн сум орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрт хамрагдах зэрэгт анхаарч ирсэн бөгөөд цэцэрлэг нь 2011 онд “Японы өвсний үндэс төсөл”-өөр их засварт орж 2010-2014 онд БШУЯ болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж нийт 194 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж бага насны хүүхдийн сурч, хүмүүжих сургалтын ая тухтай таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна. 2011 онд Хөвсгөл аймгийн хэмжээний төсөвт байгууллагуудаас “Санхүүгийн зөрчилгүй байгууллага”-аар шалгарч 3-р байранд орж, 2011-2012 онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс баг, байгууллагуудын дунд зохион байгуулсан бүтээлч ажлаар удаа дараалан тэргүүн байранд шалгарсан. 2014 онд Сумын “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-аар шалгарсан амжилтаар 2015 оны хичээлийн жилийг угтаж байна. 2014-2015 оны хичээлийн жилд эрхлэгчээр А.Амаржаргал, багшаар Л.Далантай, О.Гарамханд, А.Тэрбиш, Д.Цэнд-аюуш. Ц.Оюундэлгэр, Ч.Батцэцэг нар ажиллаж байна. Туслах багшаар Ж.Лхагвасүрэн, Д.Удвал,

Б.Лхагвадэмбэрэл, Б. Өнөржаргал, тогоочоор Г.Дуламсүрэн, Б. Ганчимэг, үйлчлэгч Д.Сарантуяа, Ня-бо М.Энхбат, Нярав. Ч.Энхбаяр, галч сахиул Ж.Баттогтох, Б.Баяраа, Д.Анхнэр нар ажиллаж байна. Тус цэцэрлэг нь 2015 оны хичээлийн жилд таван бүлэгт үндсэн сургалтаар 130-140 хүүхэд, хувилбарт сургалтаар 60 гаруй хүүхэд хүлээн авч Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Жил бүр цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг зуны нүүдлийн гэр цэцэрлэгээр гурван багт авч хамруулдаг. Төмөрбулаг сумын цэцэрлэг сургуулийн өмнөх боловсрол олгох мэргэжлийн багш нараар 100 хувь хангагдсан.

### *Төмөрбулаг сумын Яслийн түүхээс..*

Тус суманд 1979 онд 25 хүүхэдтэй, 8 орон тоотой ясли анх байгуулагдаж байжээ. Тухайн үед сумын яслийн эрхлэгчээр Ч.Амаржаргал, асрагч, сувилагчаар Л.Нямгардорж, Бадамгарав, М. Нямсүрэн, Цэрэнпил, тогооч Рэгээд, угаагч Буд, галч сахиул Ц.Ярваа нар ажиллаж байв. 1983 онд 50 хүүхэдтэй, эрхлэгчээр Лэгдэнжав, асрагч Я.Бямбасүрэн, Л. Уртнасан, Л.Нямгардорж, тогооч Загдаа, асрагч нар ажиллаж байлаа. 1985-1990 онд



эрхлэгч Д.Оюундалай, сувилагчаар Я.Бямбасүрэн, Чанцал, асрагчаар Л.Уртнасан, Д.Дуламжав, Д. Цэрэнханд, тогооч Загдаа, галч сахиул Ц.Ярваа нар ажиллаж байлаа. 1987 онд нэгдэл дундын үйлдвэрийн барилгачдын барьсан шинэ байранд орсон. 1990-1993 онд 4 бүлэгтэй болж эрхлэгчээр О.Наранцэцэг, сувилагч А.Мөрөн, Ж.Гүндсамбуу, Я.Бямбасүрэн, Г.Чанцал, тогооч Загдаа, М. Өлзийдүүрэн, Галч сахиул Ж. Баттогтох, асрагч Д.Дуламжав, Х.Батчимэг, Ц.Эрдэнэбилэг, угаагч П.Цагаанхүү, нярав Ж.Пүрэвчулуун, асрагч Ж.Энхтуяа, Б.Жаргал, М.Нямдэлгэр нар ажиллаж байлаа.

### ДАШЗЭВЭГИЙН ДОРЖПАГМА

Д.Доржпагма нь 1955 онд Төмөрбулаг сумын Жаргалант гэдэг газар төрсөн. 1963-1971 онд Мөрөнгийн 8 жилийн сургуулийг төгсөөд 1971-1974 онд Улаанбаатар хотын Цэцэрлэгийн багшийн сургуулийг хүмүүжүүлэгч багш мэргэжлээр төгссөн. 1974-1978 онд Цагаан-Уул сумын хүүхдийн цэцэрлэгт эрхлэгч, 1978-1990 он хүртэл Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгт эрхлэгч, 1991 оноос хойш Аймгийн 1-р цэцэрлэгт багшаар ажиллаж байсан. Д.Доржпагма нь Боловсролын байгууллагад 39 жил тасралтгүй ажиллаж тэтгэвэртээ гарсан. Төр улс нийгэмд олон жил үр бүтээлтэй ажиллаж байсныг үнэлж Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медаль, “Ардын боловсролын тэргүүний ажилтан” Монголын тэргүүний багш, Ардын хувьсгалын 70,80 жил, Боловсролын байгууллага үүсэж хөгжсний 60,70,80 жилийн ойн медалиар, “Аймгийн чанарын сургалттай багш” цол, “Ахлах багш” Багшийн алдар” болон Аймаг, БШУЯ-ны “Хүндэт жуух бичиг” зэргээр шагнагдаж байснаас гадна Монголын багш нарын анхдугаар зөвлөгөөнд төлөөлөгчөөр сонгогдож оролцож байсан.



### АВИРМЭДИЙН АМАРЖАРГАЛ

А.Амаржаргал нь 1971 онд Төмөрбулаг суманд төрсөн. 1979-1987 онд Төмөрбулаг сумын 8 жилийн сургуулийг төгсөөд Улаанбаатар хотын Худалдааны техникумыг 1987-1990 онд, Улаанбаатар хотын МУБИС-ын СӨБС-ыг 2004-2007 онд тус тус төгссөн. 1991 оноос одоог хүртэл тус цэцэрлэгт тогооч, багш, эрхлэгч зэрэг ажлыг тасралтгүй хийж, нийт боловсролын байгууллагад 23 жил ажиллаж байна. 2012 онд Хүмүүнлэгийн их сургуулийн магистрыг “Боловсрол судлал”-аар суралцаж төгссөн. Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрлөснийг үнэлж, Боловсролын байгууллагын 70 жилийн ойн “Эрдмийн цагаан лавай” хүндэт тэмдэг, 90 жилийн ойн медаль, МУЗ-н

нийгэмлэгийн “Шилдэг залуу” алтан медаль”, Аймгийн 80 жилийн ойн медаль, Аймгийн ЗДТГ-ын баярын бичиг, Сумын ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл “БШУЯ-ны “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдэг, зэрэг шагналаар шагнагдсан байна.



### ЛУВСАНЖАМБЫН ДАЛАНТАЙ

Л. Далантай нь 1959 онд Галт суманд төрсөн. 1968-1976 онд Галт сумын 8 жилийн сургуулийг, 1976-1979 онд Улаанбаатар хотын Цэцэрлэгийн багшийн сургуульд суралцаж төгссөн. Тусгай дунд боловсролтой. Л.Далантай нь 1990-1997 онд тус цэцэрлэгт эрхлэгч, 2000-2010 он хүртэл хүмүүжүүлэгч, эрхлэгчийн ажлыг давхар хийж гүйцэтгэж байгаад, 2011 оноос одоог хүртэл багшаар ажиллаж байна. СӨББ-ын үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад багшаар хангах, хүүхдүүдэд СӨБ-ыг олгох үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж боловсролын байгууллагад 32 жил ажиллаж хөдөлмөрлөж байна.

Л.Далантай багшийн ажлыг өндрөөр үнэлж Боловсролын байгууллагын 70 жилийн ойн “Эрдмийн цагаан лавай” хүндэт тэмдэг, Ардын хувьсгалын 80 жилийн ойн медаль, Их монгол улсын 90 жилийн ойн медаль, Багшийн алдар, Аймгийн Засаг даргын Жуух бичиг, Эх орны төлөө тэмдэг, БШУЯ-ны “Хүндэт жуух “бичгээр тус тус шагнагдсан байна.

### ЛУВСАНЖАМЦЫН ЦЭРЭНДУЛАМ

Л.Цэрэндулам нь 1952 онд Төмөрбулаг сумын Тээл багт төрсөн. 1960-1968 онд Мөрөн 8 жилийн дунд сургуулийг төгсөөд 1968-1971 онд Улаанбаатар хотын Цэцэрлэгийн багшийн сургуулийг төгссөн. 1971 онд Төмөрбулаг сумын Хүүхдийн цэцэрлэгийн анхны эрхлэгчээр ажиллаж байгаад 1972-1992 он хүртэл Аймгийн 3-р цэцэрлэгт багшаар, 1992-1995 онд тус цэцэрлэгт эрхлэгч, 1995-2002 онд Аймгийн Ясли- цэцэрлэгийн цогцолборт эрхлэгч, 2002-2008 онд багшаар ажиллаж байгаад 2008 онд тэтгэвэрт гарсан. Л.Цэрэндулам нь боловсролын байгууллагад 36 жил үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрлөж бага насны хүүхдийг асран хамгаалж, сурган хүмүүжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг нь үнэлж Монгол улсын “Тэргүүний багш”, “Ардын боловсролын тэргүүний ажилтан” БШУЯ-ны “Хүндэт жуух бичиг” Аймгийн Засаг даргын “ Жуух бичиг”, Боловсролын байгууллагын 70, 80 жилийн ойн медаль, Аймгийн 70, 80 жилийн ойн медаль, Аймгийн “Хөдөлмөрийн аварга багш”, Зөвлөх” зэрэгтэй багш, ” Багшийн алдар” медаль, зэрэг шагналаар шагнагдаж байсан.



## БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД...

### Хаан банк

**Эрхэм зорилго:** Хаан банк нь хүмүүсийн амьдралыг бодитойгоор өөрчилж, нийгмийн сайн сайханд хувь нэмэр оруулах, санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүнийг нэвтрүүлдэг үндэсний хэмжээний тэргүүлэгч банк юм.



Тус суманд улсын банкны тооцооны касс 1975 оны 2 дугаар сарын 1-нд аймгийн банкны хэлтсийн даргын 08 тоот тушаалаар эрхлэгч, няравын орон тоотойгоор байгуулагдан эрхлэгчээр Бадмаагийн Батбаяр, няраваар Дамдинсүрэнгийн Чулуун нар томилогдож байжээ. Тус банк 1975 оны хоёрдугаар сарын 3-нд анхны гүйлгээ хийж нэг ширхэг баримтаар 1192 төгрөг оруулжээ. 1975 оны 2 дугаар сарын 5-нд 1-р багийн иргэн Самбуугийн Маамаа олон хүүхдийн тэтгэврийн мөнгөө аваад хүү М.Ганболдын нэр дээр мөнгөн хадгаламж нээлгэсэн нь тус тооцооны кассын анхны хувийн хадгаламж болжээ. Иргэдэд банкны ажил үйлчилгээ хувийн хадгаламжийн ач холбогдолыг сурталчлан албан байгууллага иргэдийн бэлэн мөнгөний гүйлгээг эрхлэн явуулж байх тэр үеэс эрхлэгчээр Найдангийн Цагаач, Шанжийн Дашбалжир манаачаар Намсрайн Жамьяаншарав, Лханаажав, Бадарчийн Дугараа, Шатарбалын Цэдэв, Гунгаан Санжаа, Дагвасүрэнгийн Циен-Ойдов нар тус тус ээлж дараагаа залган ажиллаж 1980 онд 6-р таван жилийн гавшгайч хамт олноор шалгарч байжээ.

Банкны тооцооны касс нь сумын ардын депататуудын хурлын гүйцэтгэх захиргааны байранд байрлаж байсан байна.

1990-ээд оны эхээр Монгол улс зах зээлийн эдийн засгийн системд шилжиж банкны 1 шатлалтай тогтолцооноос 2 шатлалтай тогтолцоонд шилжиж Банкны тухай анхны хууль батлагдан анхны арилжааны банкууд үүсч эхэлсэн билээ. Хөдөө аж ахуйн хоршоолол банк 1990 оны 2-р сард



Хаан банкны хамт олон.

анх байгуулагдаж 1991.05.04-ны өдөр аймгийн салбар байгуулагдсан. Тухайн үед ажиллаж байсан Улсын банкны сумын тооцооны касс нь, эд хөрөнгө, боловсон хүчинтэйгээ ХАА-н хоршоолол банкны харьяанд шилжсэн. Шинээр байгуулагдсан тооцооны төвийн эрхлэгчээр Алтангадас, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Д.Түмэндэмбэрэл, Э.Ундармаа, Д.Наранцэцэг, Ц.Анхбаяр, Г.Цэнд-Аюуш, эдийн засагчаар Э.Мягмарсүрэн, Л.Бат-Эрдэнэ, Б.Бямбасүрэн, нягтлан бодогчоор Д.Наранцэцэг, Э.Ундармаа, Э.Сонинбилэг, няраваар Д.Отгонбаяр, Л.Дугаржав, Ч.Цэдэвсүрэн, Ж.Ариунаа, манаачаар Г.Мөнхбаяр, П.Мөнх-Очир, үйлчлэгчээр М.Цэрэннамжил, галч сахиулаар Ц.Шинэхүү, З.Баатар нар ажиллаж байсан.

Одоогоор үндсэн таван орон тоотой, гэрээт ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулан эрхлэгчээр Л.Бат-Эрдэнэ, Эдийн засагчаар Н.Төмөрхуяг, Д.Мөнхзул, Ахлах теллер П.Цэнд-Аюуш, Теллер Ц.Батжаргал, гэрээт ажилтан З.Хатанбаатар нар “Нөхөрсөг таатай орчин бүрдүүлье” уриан дор салбарын тэргүүний тооцооны төв болох зорилт тавин ажиллаж байна. ХААН банкны Төмөрбулаг тооцооны төв нь 2003 онд өөрийн гэсэн байртай болсон бөгөөд 2007 онд онлайн сүлжээнд холбогдон, 2008 оноос үйлчилгээний стандартад нийцсэн шинэ байртай болж, иргэдэд тохилог орчинд чанарын өндөр түвшинд үйлчилж байна.

### Төрийн банк

Төмөрбулаг суманд 2005 онд явуулын “Монгол шуудан” банкны үйл ажиллагаа эхэлж, иргэдэд малчны зээлийн хүү, иргэдийн хугацаатай болон хугацаатай хадгаламжийн үйл ажиллагааг суртчилан ажиллаж эхэлсэн бөгөөд зээлийг аймгийн Монгол шуудан банкаар уламжлуулан шийдвэрлэж байжээ. Тус банк 2006 оны есдүгээр сард албан ёсны байртай

болон нээлтээ хийж, сумынхаа албан байгууллага аж ахуй нэгж иргэдэд банкныхаа үйл ажиллагааг хүргэж эхэлсэн. 2011 онд Хадгаламж банктай нэгдэн Хадгаламж банк нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаад 2013 оны долдугаар сараас Монгол банкны эрх хүлээн авагчийн шийдвэрээр Төрийн банктай нэгдэн, өнөөдөр Төрийн банк нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна,

Төрийн банк нь Хөвсгөл аймгийн хэмжээнд 26 салбар нэгж 137 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Төмөрбулаг сумын Төрийн банк нь дөрвөн орон тоотойгоор банкны цогц үйлчилгээ болон Төрөөс явуулж байгаа үйлчилгээ болох тэтгэвэр тэтгэмж, халамж хүүхдийн мөнгө зэргийг иргэдэд 100 хувь хүргэн хөнгөн шуурхай үйлчилж байна, Тус банкинд залуу чадварлаг хамт олон ажиллаж байгаагаараа давуу талтай бөгөөд “Далай ээж” хүнсний дэлгүүрт “Cash back” суурилуулж, амралтын өдөр гэлтгүй гүйлгээ хийж байгаагаараа давуу талтай. Төмөрбулаг сумын Төрийн банкинд Т.Эрдэнэбат, Д.Батсайхан, Ч.Цэдэвсүрэн, Б.Цэрэннадмид, Т.Дэлгэррагчаа, Л.Ууганчимэг, Э.Хадбаатар Б,Цэрэндаваа Б,Алтанзул Ц.Гүрбадам зэрэг олон хүн ажиллаж байсан юм. Тус банкны харуул Т.Мөнх-Очир нь тус банкныг анх үүсэн байгуулагдсан цагаас эхлэн одоог хүртэл ажиллаж байна.

### **“Баян-Энх-Айраг” ХХК**

“Баян-Энх-Айраг” ХХК нь 2005 онд үйл ажиллагаагаа эхэлж, сумын иргэдэд анх А-80 бензин худалдаалж эхэлжээ. Түүнээс хойш тасралтгүй 10 дахь жилдээ Төмөрбулаг сумын нутаг дэвсгэрт тогтвортой үйл ажиллагаа



явуулж байна. Энэ хугацаанд ажлын байраа өргөтгөж, бүх төрлийн шатах, тослох материал хадгалах, худалдаалах техник, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулжээ. Мөн найман нэрийн хүнсний дэлгүүр нээж, түлш шатахуун тээвэрлэх зориулалт бүхий 20 тонны даацтай машинаар иргэдэд үйлчилж байна. “Баян-Энх-Айраг” ХХК нь чанарын шаардлага хангасан



бүтээгдэхүүнээр аюул осолгүй иргэдэд үйлчлэхийг эрхэм зорилгоо болгон ажилладаг бөгөөд төрийн байгууллагууд, үйлчилгээний тээврийн хэрэгсэлд хямдралтай үнээр түлш, шатах, тослох материал нийлүүлдгээрээ онцлогтой. Тус компани нь нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, сум орныхоо ажлыг дэмжиж, иргэд болон аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин хандив тусламж, дэмжлэг үргэлж үзүүлж байдаг. Хүн эмнэлгийн барилга шинээр ашиглалтанд ороход хоёр өрөөг бүтэн тохижуулж, сургуулийн 70 жилийн ойн арга хэмжээг ивээн тэтгэж, санхүүгийн дэмжлэг үзүүлж байсан бөгөөд Төмөрбулаг суманд 3-4 хүнийг ажлын байртай болгожээ.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД

### Төмөрбулаг сумын МАН

1922 оны 9 сарын 9-14 ний өдөр болон 12-р сарын 19-ний өдрүүдэд Засагт хан аймгийн Далай гүн /Бүрэнтогтох сум/, Мэргэн гүн /Төмөрбулаг сум/, Эрдэнэдүүрэгч вангийн хошуу /Цэцэрлэг сум/-ны нутагт мөн Бүгсий, Бүгдгээн, Тэсийн хүрээний орчимд Монгол ардын намын 17, 18, 23-р үүрүүд байгуулагджээ. Тус сумын МАН-ын даргаар:

1960-1965 онд Доржготов  
 1965-1975 онд Чимэд  
 1975-1980 онд Чутнай  
 1980-1990 онд С.Аюуш  
 1990-1992 онд Ойдов  
 1992-1994 онд Ч.Сандагдорж  
 1994-1996 онд Ж.Маналсүрэн  
 1996-2001 Б.Шарбанди  
 2001-2003 онд Б.Ганзориг  
 2003-2008 онд Ж.Маналсүрэн  
 2008-2009 онд Т.Энхтуяа  
 2009-2013 онд Т.Болдбаатар

2013 оноос Б.Ганзориг нар тус тус ажиллаж байжээ.

1992, 1996, 2000, 2004, 2012 оны орон нутгийн сонгуулиудад МАН-аас нэр дэвшигчид, төлөөлөгчдийн олонхийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд МАН-ын тэргүүлэгчдээр Г.Бямбасүрэн, Ч.Цэдэвсүрэн, Л.Бат-Эрдэнэ, Д.Түмэндэмбэрэл, Л.Дугаржав, Ц.Батбаяр, Н.Бямбачулуун нар, МАН-ын бүлгийн даргаар Б.Дашдондог нар сонгогдон ажиллаж байна. Намын анхан шатны хороо, үүрүүд байгуулагдаж



Төмөрбулаг сумын МАХН-ын гишүүд 1976 он

1-р үүрийн даргаар Ц.Доржготов  
 2-р үүрийн даргаар Б.Дашдондог  
 3-р үүрийн даргаар Ц.Нэргүй  
 4-р үүрийн даргаар Ш.Дашдэлгэр  
 5-р үүрийн даргаар Л.Дугаржав нар 5-8 жил улиран ажиллаж, ажлаараа 2 болон 5-р үүрүүд тэргүүлэн ажиллаж байна.

МАХН-ын 11-р их хуралд Г.Дамба- Сумын намын үүрийн дарга  
 МАХН-ын 12-р их хуралд Б.Түмэндэмбэрэл- Аймгийн НХ-ны хэлтсийн эрхлэгч

Т.Саяннямбуу- Намын үүрийн дарга  
 МАХН-ын 13-р их хуралд Г.Жалцав- Сумын намын хорооны дарга  
 МАХН-ын 14-р их хуралд З.Доржготов- Сумын намын үүрийн дарга  
 МАХН-ын 15-р их хуралд Г.Замбал- Бригадын дарга  
 МАХН-ын 16-р их хуралд П.Лянхуа- Хоньчин  
 МАХН-ын 17-р их хуралд Д.Батаа- Гурилын үйлдвэрийн дарга  
 Я.Надмид- Саальчин

МАХН-ын 19-р их хуралд П.Цагаач- Ямаачин  
 МАХН-ын Онц их хуралд Х.Ням-Очир- Ямаачин  
 МАХН-ын 21-р их хуралд Ч.Сандагдорж- Сумын намын дарга  
 МАХН-ын 22-р их хуралд Ж.Маналсүрэн- Сургуулийн захирал  
 МАХН-ын 23-р их хуралд П.Банзрагч- Хоньчин  
 МАХН-ын 24-р их хуралд Д.Түмэндэмбэрэл- Сумын Ахмадын хэсгийн

ахлагч

МАХН-ын 25-р их хуралд Х.Даваачулуун- Сумын татварын байцаагч  
 МАХН-ын 26-р их хуралд Т.Болдбаатар- Намын дарга  
 МАХН-ын 27-р их хуралд Б.Ганзориг- Намын дарга

Ц.Батбаяр- Намын дэд дарга нар их хуралд төлөөлөгчөөр сонгогдон оролцсон байна.

Намын дэд даргаар Д.Сайнбаяр, Ц.Батбаяр, Ч.Цэдэвсүрэн нар 2008 оноос хойш ажиллаж байна.

### Төмөрбулаг сумын МоАХ, МоАН-ын түүх

Төмөрбулаг суманд 1990 оны 4-р сарын 18-нд “Эрх чөлөө” сонины цайр зурагчин Г.Энхтайван болон Ч. Жамъянсүрэн нар ирж цаг уурын эрхлэгч Ч. Бадраагийн гэрт нь байрлаж, Физикийн багш Д. Бат-Эрдэнэ ерөнхий боловсролын сургууль дээр анги танхим гарган хөдөлмөрчдийн уулзалт цуглаан хийж, иргэдэд улс төр онолын чиглэлээр мэдээлэл өгч, сургалт дугуйлан явуулж, МоАХ, МоАН-ын салбар зөвлөл байгуулжээ. Энэ өдөр тус сумын 73 хүн МоАХ, МоАН-ын гишүүнээр элсэжж байжээ. Суманд ардчилсан хөдөлгөөнийг үүсгэх үйлсэд цаг уурын эрхлэгч Чогсомын Бадраа, Физикийн багш Данзангийн Бат-Эрдэнэ, Биеийн тамирын багш Баадайн Балдандорж, Клубын эрхлэгч Готовын Цэрэндаш, багш Жамъянжавын Жаргалсайхан, Ж.Лхагважав, Бурмаа, Энхтуяа, бригадын эрхлэгч Дамдингийн Дашдорж, 3-р багийн малчин Д. Жүгдэрнамжил, Давшилт нэгдлийн Үйлдвэр бригадын ажилчин Готовын Насанбуян, 1-р бригадын малчин Х. Ням-Очир, Ц. Төртогтох, Бригадын тоо бүртгэгч Р. Ёндонжамц,

өндөр настан О.Төмөрбаатар, Нэгдлийн боловсон хүчин Ш.Батмөнх, М.Магсаржалам, Д.Гүндсамбуу, Д.Түмэнжаргал, Л.Бат-Эрдэнэ, Ш.Мөнх-Эрдэнэ, Б.Баясгалан, Аймгийн төвд Геологийн инженер, Аймгийн Засаг дарга асан Б. Батхүү, Чандмань-Өндөр суманд биеийн тамирын багшаар ажиллаж байсан Т.Гантөмөр нар манлайлан оролцсон байна.

Анхны цуглаан хийснээс хэдхэн хоногийн дараа аймгаас Геологийн инженер Б. Батхүү, Олзбаатар нар ирж, малчид хөдөлмөрчдийн цугларалт зохион байгуулж, ардчиллын үйл явцын талаар яриа хийж, малчин олны хүсэлтээр Ардын аж ахуйтны сумын холбооны тэргүүнээр сумын Ардчилсан холбооны гишүүн Б.Балдандоржийг сонгожээ. Тус сумын иргэн Д.Жүгдэрнамжил, Ж.Дуламсүрэн, Я.Жаймаа, С.Бадраа, М.Даваахүү, П.Бэхбаатар, Б.Баярдалай, Ц.Дамдинжав, Г.Дамдин, Ж.Үенч нар хамгийн анхны ардын аж ахуйтан болж байжээ.

МоАН-ын анхдугаар чуулганы таван төлөөлөгчийн нэгээр Геологийн инженер Б. Батхүү сонгогдсон боловч аав нь татгалзсан учраас яваагүй байна. Мөн 2-р чуулганд тус сумын иргэн Д.Түмэнжаргал, Б.Баясгалан нар төлөөлөгчөөр оролцож байжээ. Төмөрбулаг сумын МҮАН-ын даргаар:

Б.Балдандорж 1990-1993 он

Г.Цэрэндаш 1993-1996 он

Б.Чулуундаваа 1996-2000 он

Ч.Цэцэгмаа 2000 он /6 сар/

МоАН-ын даргаар Д. Түмэнжаргал нар ажиллаж байсан бөгөөд 2003 оноос Г. Сүхбаатар Төмөрбулаг сумын АН-ын даргаар ажиллаж байна.

МоАН-ын дэд даргаар Д.Даваадорж, Д.Сайнбаяр, Ш.Нацагдорж ажиллаж байгаа бөгөөд сумын АН-ын дарга Г.Сүхбаатарын санхүүжилтээр 2009 онд АН-ын шинэ байртай болжээ.



Төмөрбулаг сумын  
Эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүд

## Төмөрбулаг сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн дагуу 1924 оны 03 дугаар сарын 19-нд МАХН-ын Төв Хорооны Суртлын хэлтсээс эрхлэн “Бүсгүйчүүдийг боловсруулах тасаг” нэртэйгээр Монголын эмэгтэйчүүдийн байгууллагыг анх үүсгэн байгуулсан түүхтэй. Энэ дагуу Хөвсгөл аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөл 1931 онд байгуулагдсан бөгөөд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэднийг сурч боловсрох боломж нөхцлөөр хангах олон талт үйл ажиллагаа Төмөрбулаг суманд зохион байгуулагдаж, сургалт, лекц семинаруудыг идэвхитэй зохион

байгуулсаар энэ цагтай золгожээ. Тус сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн анхны даргаар Доржийн Түмэндэмбэрэл ажиллаж байсан бөгөөд 2007 онд Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн хүрээнд эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдийг ард иргэдийн саналаар сонгож байжээ. Өнөөдөр Төмөрбулаг сумын эмэгтэйчүүдийн зөвлөлийн даргаар Эрүүл мэндийн төвийн дарга Ч.Цэцэгмаа, тэргүүлэгч гишүүдээр сумын засаг дарга асан Т.Энхтуяа, сургуулийн захирал асан Ж.Лхагважав, нийгмийн багш Д.Нарансайхан, их эмч Д.Мэнджаргал, татварын байцаагч Х.Даваачулуун, МЭҮАТ-ын дарга Т.Тэрбиш, ахмадын хорооны дарга Д.Түмэндэмбэрэл, ахмад настан Л.Дугаржав нар сонгогдон ажиллаж байна. Тус сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл нь өөрийн гэсэн дүрэмтэй, зөвлөлийн тамгатай, ажлаа жил бүр төлөвлөн ажиллаж аймагтаа ажил үйлсээрээ байнга тэргүүлдэг, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, төрийн бус байгууллага юм. Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс жил бүр аймаг, сумын “Ачит ээж”-ийг тодруулан алдаршуулж, таван номинацаар тэргүүний эмэгтэйчүүдийг тодруулан алдаршуулах ажлыг уламжлал болгон зохион байгуулдаг. Тус сумын Эмэгтэйчүүдийн зөвлөл 2013 онд “Төлчин эмэгтэйчүүдийн чуулган”, 2014 онд Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жилийн ажлын хүрээнд “Ангир уураг - Амьдралын булаг - Хайрын холбоо” сэдэвт 150 эмэгтэйчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулж сумын 9 шилдэг эмэгтэйчүүдийг тодруулан урамшуулж байжээ. 2014 оны аравдугаар сарын 08-нд нийслэлд зохион байгуулсан Монголын эмэгтэйчүүдийн холбооны 90 жилийн ойн арга хэмжээнд сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ч.Цэцэгмаа, тэргүүлэгч гишүүн их эмч Д.Мэнджаргал, татварын байцаагч Х.Даваачулуун нар оролцон Монголын эмэгтэйчүүдийн холбооны 90 жилийн ойн медалиар шагнагдсан байна.

## Төмөрбулаг сумын Ахмадын Хороо

Тус сумын ахмадын хороо 2001 онд албан ёсоор тамга тэмдгээ авч, нийгэмд үйлчилдэг, төрийн бус байгууллага болон үйл ажиллагаагаа өргөтгөжээ. Ахмадын хорооны анхны даргаар Чойжилсүрэнгийн Доржпалам сонгогдон ажиллаж байжээ. 2002 оны арваннэгдүгээр сард ахмадууд хуралдан Ахмадын хорооны тэргүүлэгчдийг долоон хүний бүрэлдэхүүнтэй батлаж, Ахмадын хорооны даргаар Доржийн Түмэндэмбэрэлийг сонгожээ. Тус сум 270 гаруй ахмад настантай бөгөөд Ахмадын хорооны даргаар Д.Түмэндэмбэрэл 12 дахь жилдээ ажиллаж байна.

### 2003- 2006 он

Ахмадуудын урам зоригийг сэргээх, тэднийг олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг голчлон зохион байгуулж байжээ. Ахмадуудын хурал чуулган, өдөрлөгүүдийг бэлтгэл зохион байгуулалт сайтай явуулж тэргүүний ахмадуудын хөдөлмөрийн алдарыг нийт хамт олны дунд тэмдэглэн алдаршуулах зэрэг шинэ хэлбэрийн олон төрлийн ажил зохиож ахмадуудын идэвх, урмыг сэргээж чадсан.

### 2006-2009 он

Энэ үед ахмадын байгууллагад өөрийн төсөв санхүүтэй болгох зорилт



тавин ажиллаж эхэлжээ.

Үүний тулд сумын ахмад бүр, ахмадынхаа байгууллагад 2000 төгрөгний хандив өгч байхаар шийдвэрлэж, Улаанбаатар, Эрдэнэт, Мөрөнгийн уугуул нутгийн ахмадууд болон зарим бизнесменүүдээс хандив тусламж цуглуулан ХААН банкинд данс нээж 400-800 мянган төгрөгний санхүүтэй болж, ахмадын хорооны ажил үйлчилгээг өөрөө санхүүжүүлдэг болжээ.

**2009-2013 он**

Сумын ахмадын байгууллагын өөрийн гэсэн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, аймгийн тэргүүний ахмадын хороодын түвшинд хүрэх зорилт тавин ажиллажээ. Багийн салбар зөвлөлийн дунд болзол зарлаж, ажлаа дүгнэн, сонгуультны өдөрлөгийг жил бүр зохион байгуулж ажилласаны дүнд 1, 5-р багийн болон 2-р багийн 3.Цэрэнханд, Г.Нансалдулам нарын удирдсан салбар зөвлөлүүд “Тэргүүний салбар зөвлөл” болон ажил нь тогтмолжсон байна. Сумын нийт ахмадын дунд “Хамгийн хамгийн” тэмцээнийг найман үзүүлэлтээр шалгаруулж иржээ. Мөн ахмадын шинэ жил тэмдэглэх, эко аялал зохион байгуулах зэрэг олон ажлуудыг тогтмол хийж ирсэн. Төмөрбулаг сумын Ахмадын хороо нь 2014-2016 онд сумын ИТХ-д төсөл оруулж сумын Хөгжлийн сангаас төсөл батлуулан, ахмадын байр, чийрэгжилтийн танхимыг засварлан тохижуулж, байнгын ажиллагаатай болгох, ахмадуудыг эрүүл урт наслах боломжийн талаар сургалт сурталчилгаа хийх, зүүн аймгуудын туршлагаар бясалгал, дасгал хөдөлгөөний кабинетыг тогтмол ажиллуулахаар зорьж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Ахмадын хорооны дарга Д.Түмэндэмбэрэл нь монголын Рейкийн Холбооны Гранд мастер цол авч Рейкийн баясгал хичээллүүлж, энергийн эмчилгээг эхлүүлээд байна.

Мөн дасгал хөдөлгөөн хийх байр танхимыг тогтмол ажиллагаатай болгож, 40-өөд ахмадын дунд Л.Дугаржав, 3.Цэрэнханд ахлагчтай арёх баг тогтмол хичээллэж байна. Сумын ахмадын хороо ажлын түвшингээ ахиулан ажилласнаар аймгийн бүх сумын ахмадын хороодоос 1-р байранд 5 удаа, 2 байранд 2 удаа, 3-р байранд 2 удаа, 4-р байранд 1 удаа тус, тус шалгарч Хөвсгөл аймгийн Тэргүүний ахмадын хорооны түвшинд хүрч чаджээ.



## ТӨМӨРБУЛАГ СУМЫН ХҮЧИТ БӨХЧҮҮД

Хошуу нутгаас эхлээд халх даяар алдар нэр нь түгсэн хүчтэнүүд энэ суманд олон байжээ. Улсын арслан Бөрт хэмээх Дамдин, Заан Бороохой хэмээх Дамдин, арван засгийн наадмаас улсын цол авсан Наянтай, аймгийн арслан Жамсрангийн Гэлэгжамц, Базарын Дан-Аа, Зэвэгийн Чимэдрагчаа, Лосолын Цэдэнсодном, аймгийн заан Жамсрангийн Дэндэв, Жадамбын Жамба, аймгийн начин Санжаа, Жамсрангийн Ренчин, Паньдийн Лхагва, Дагвадоржийн Гэндэн, Дандгайсүрэнгийн Жамъянжав, Галын Жамсран, Баадайн Балдандорж, Чулуунбаатарын Хүрэлчулуун, ардын цэргийн начин Дашийн Цэдэн-Иш, ардын цэргийн начин Палайн Банди. Энэ алдартай хүмүүсийн хүмүүсийн тухай домог мэт хууч яриа өдгөө нутгийн дунд ам дамжин яригдсаар байна.

Тус сумын уугуул Бөрт хэмээх Дамдин Бүгсийн голын урд бие Хаваржаатад нутагладаг байхдаа Бүгсийн аманд байсан “Мухар халзан” гэдэг хятад наймаачныд хар бор ажил хийж өгдөг байжээ. Нэг өдөр тэр хятадаас идчихмээр боломжийн мал гуйхад хятад наймаачин зөвшөөрч “Би өнөө орой малаа хашаад хононо. Чи үүдийг нь онгойлгохгүйгээр даахынхаа хирээр нэг мал үүрээд яваарай гэжээ. Дамдинг үдэш ирэхэд МухарХалзангийнх унтсан байхаар нь намайг даахын хирээр мал ав гэсэн юм чинь гээд хонины хашаа уруу нь очиход хажуугийн хашаанд нь бас хэдэн тэмээ хашсан байжээ. Тэрээр хятад худалдаачны хашаанаас нэг тайлаг тэмээг өргөж гаргаад үүрч, Мөрөнгийн шанаанд /Зээргэнэтэд/ аваачиж муулаад махыг эвдэн хэсэг мах шарж идээд байж байтал Мухар Халзан мөрдөн ирээд “Чи үнэхээр хүчтэй хүн байна. Би чамайг нэг эр хонь үүрээд явсан байх гэж бодсон чинь харин тэмээ үүрээд ирсэн байна. За яах вэ надад юм хийж өгч байгаарай” гээд яваад өгсөн гэдэг. Бөрт Дамдин гуай эхийгээ үүрээд Богдын хүрээ орох гэж явах замдаа Сайн ноён ханы Мэргэн гүний нутгаар өнгөрч явахад нь Мэргэн гүн дуулаад дуудуулжээ. Мэргэн гүн өөрөө яггүй сайн барилдчихдаг, бөхөд элэгтэй хүн байсан учраас Дамдингаар учир байдлыг яриулж мэдээд “Чи эхийгээ суулгаад юмаа ачаад яв гэж нэг шар тэрэг, жаал зугаа идэж, хэрэглэх юм өгөөд явуулжээ. Ингэж явсаар Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошуу наадам хийж байхтай тааралдаж барилдсаар үзүүр түрүүнд үлдсэн гэнэ. Гэтэл хошууны ноёд дургүйцэж, явуулын хүнд наадмаа алдаж магадгүй нь гээд /буулга/ гэж айлджээ. Ингэхэд нь Дамдин учир байдлаа ярьж барилдья гэж гуйсан боловч үл хэрэгсэн бай мөрийг ч өгөлгүй барилдуулалгүй хасжээ. Тэрээр явсаар Богдын хүрээ орж амьдрахын эрхээр хөлсөөр газар ухаж байсан бөгөөд эргийн шороо нурж дарагдсанаас болон Бүгсийн голын алдарт хүчтэн Бөрт хэмээх Дамдин насан өөд болжээ. Их хүчтэний хүч бяраа сорьж өргөж байсан хад чулуу өнөөдөр ч Төмөрбулаг суманд бий. Тэрээр Хаваржаатад гурван чулуу өргөж тавьсан гэдэг бөгөөд нэгэн чулууг Дашдаваан Цоодол аавынхаа хамт кранаар өргөн, машинд ачиж сумын төвийн наадмын талбайд авчирч тавьжээ. Энэ чулуу 786 кг жинтэй

байсан байна. Мөн заан Гүрээ Жамьян, Загд Хундаа хэмээх харцага Дамдинсүрэн, Дамбаа тулгат, Равдан шандас Жаргалантаар нутаглаж байсан Зэвэг харцага, Бадаг Донхороор нутаглаж байсан Хүрэн тулгат, Ерөөлт тулгат, Нарийны голоор нутаглаж байсан Цорхи хэмээх Дамдин шонхор гээд л олон алдартай хүчтэнүүд энэ орон нутагт амьдарч байсныг энэ сумынхан бахархан дурсаж, үлгэр домог мэт ярьсаар байна.

### Улсын начин М.Эрдэнэбат

Тэрэр 1982 оны дөрөвдүгээр сарын 29-нд Төмөр булаг сумын Тээлд төрсөн, нохой жилтэй. 2000 онд Монгол улсын дархан аварга Б.Бат-Эрдэнийн сонгон шалгаруулсан Хөвсгөл аймгийн Идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд хоёрдугаар байрт шалгарч үндэсний бөхийн гараагаа эхэлсэн. 2002 онд чөлөөт бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлсэн. Мөн 2004 онд байлдааны самбогоор мөнгөн медаль хүртэж байжээ. М.Эрдэнэбат 2003, 2004 онд Хөвсгөл аймгийн улсын баяр наадамд тав давж, 2005 онд түрүүлэн аймгийн арслан цолны болзол хангасан. Мөн 2006, 2010 онд Улсын баяр наадамд дөрөв давсан. Аймаг цэргийн цолтой бөхчүүдийн барилдаанд 2003 онд нэг түрүүлж, нэг шөвгөрсөн. Тэрээр 2011 онд Ардын хувьсалын 90 жилийн ойгоор Улсын харцага Элбэгээр тав давж Монгол улсын начин цолны болзол хангаж Төмөрбулаг сумынхаа анхны улсын цолтой бөх болж нутгийн ахан дүүс зон олноо баярлуулж яваа өсөх ирээдүйтэй шилдэг начны нэг билээ.

М.Эрдэнэ бат 2011 онд “Монгол бөх Гиннесийн номонд” 6002 бөхийн барилдаанд 8 давж амжилтаа бататгасан байна.



## Аймгийн арслан

### Аймгийн арслан Жамсрангийн Гэлэгжамц

1913 онд төрсөн, үхэр жилтэй. 1936 онд АХ-ын 15 жилийн ойн баяр наадмаар зохиогдсон биеийн тамирын тэмцээн дээр Ж. Гэлэгжамц нь 58 удаа “сонс “эргэж гарамгай дээд амжилт үзүүлсэн учир бүх цэргийн жанжин Дэмид Улсын бага хуралд мэдүүлж, наадамчин олны өмнө “Алтан гадас” одонгоор шагнуулж байсан. Ж.Гэлэгжамц нь бөхийн барилдаанд байнга барилдсаар 1937 онд цэргийн арслан цол хүртэж, 1938 оны Улсын баяр наадамд дөрөв давж байжээ. Тэрээр 1942 онд Булган аймгийн наадамд түрүүлж аймгийн арслан цол хүртсэн. Мөн сумынхаа баяр наадамд тав түрүүлж, гурван удаа үзүүлэн нутгийн олноо барлуулсан хүчит бөх байлаа.

### Аймгийн арслан Лосолын Цэдэнсодном

1953 онд төрсөн, могой жилтэй. Л.Цэдэнсодном 10-р ангид байхдаа



Баруун гар талаас с/з П.Банзрагч,  
с/з И.Ганболд, с/з Ч.Лхагвасүрэн

идэрчүүдийн үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 4-р байрт орж тусгай шагнал авч байжээ.

Л.Цэдэнсодном нь 18 настайдаа Түнэл сумын наадамд түрүүлж сумын заан, 1978 онд Эрдэнэт хотын наадамд үзүүлж, 1982 онд аймгийн аварга шалгаруулах бүсийн тэмцээнд түрүүлж аймгийн арслан цол хүртсэн. Тэрээр Эрдэнэт хотын наадамд хоёр удаа үзүүлж, гурван удаа шөвгөрсөн. Мөн 1990 онд зохиогдсон Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан даншиг наадамд 768 бөх барилдахад гурав давсан. Л.Цэдэнсодном нь самбо, жү-до бөхийн улсын 1-р зэрэгтэй тамирчин юм.

### Аймгийн заан Жамсрангийн Дэндэв

Аймгийн заан Жамсрангийн Дэндэв 1905 онд төрсөн. Ж.Дэндэв нь цэргийн алба хааж байхдаа Ховд аймгийн баяр наадамд зодоглож, аймгийн заан цол авсан. Бяр хүч ихтэй энэ хүн Хөвсгөлийн шүлхий Дэндэв хэмээн нэрлэгдэж явжээ. Ж.Дэндэв сумынхаа баяр наадамд хоёр түрүү, хоёр үзүүр, нэг шөвөг авч байсан байна.

### Аймгийн заан Жадамбын Жамба

Жадамбын Жамба нь 1930 онд Хөвсгөл аймгийн баяр наадмаас аймгийн заан цол авсан. Тэрээр 1932 онд аймгийн наадамд тав давсан, сумын наадамд олон жил барилдсан бяр хүч ихтэй сайн бөх байжээ.

## Аймгийн начин

### Аймгийн начин Пандийн Лхагва

1924 онд төрсөн, хулгана жилтэй. П. Лхагва нь 1950 онд Хөвсгөл аймгийн баяр наадамд зодоглон, тав давж аймгийн начин цол авсан. Сумандаа нэг түрүүлж, гурван удаа шөвгөрч байсан.

### Аймгийн начин Дандгайсүрэнгийн Жамъянжав

1950 онд төрсөн, бар жилтэй. Д.Жамъянжав нь 1954 онд аймгийн наадмаар тав давж аймгийн начин цол авсан. Мөн 1956 онд тав давж, цолоо бататган, 1961 онд зургаа давсан энэ бөх сумандаа нэг үзүүлж, хоёр удаа шөвгөрч байсан байна.

### Аймгийн начин Баадайн Балдандорж

Баадайн Балдандорж нь 1984 онд аймгийн үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээнд 20 бөх тойргийн журмаар барилдахад 18 давж, аймгийн начин цол хүртжээ. Тэрээр 1983 онд жү-до барилдаанаар аймгийн аварга, 1984 онд жү-до бөхийн 71 кг-ийн жинд улсад 2-р байр эзэлж байсан самбо, жү-до барилдааны улсын 1-р зэргийн тамирчин юм.

Баадайн Балдандорж сумандаа нэг үзүүлж, хоёр удаа шөвгөрчээ.

### Аймгийн начин Чулуунбаатарын Хүрэлчулуун

1973 онд төрсөн, үхэр жилтэй. Ч.Хүрэлчулуун нь 2000 онд Хөвсгөл аймагт тав давж, аймгийн начин цол, сумандаа 1997 онд түрүүлж, 1992, 1994, 2003 онуудад үзүүлэн, гурван удаа шөвгөрсөн байна.

1995 он, 1996 онуудын сумын заануудын чансаа үнэлэх барилдаанд гуравдугаар байранд шалгарч, 1994 онд Шинэ-Идэр суманд болсон дөрвөн сумын бүсийн тэмцээний бөхийн барилдаанд түрүүлсэн. Мөн 1995 онд Төмөрбулаг суманд түрүүлсэн, 1996 онд Жаргал суманд үзүүлж байжээ. Монголын Үндэсний телевизийн Үдшийн хэмнэл студиас зохион байгуулсан Монголын хүчтэн тэмцээнд хоёрдугаар байр, 2004 онд Улаанбаатар хотын “Ирээдүйн мистер” 11 дэхь удаагийн тэмцээний +75 кг-ын жинд мөнгөн медаль авч байсан. Ч.Хүрэлчулуун нь баруун зүүн хөл авах, хонгодох, тонгорох, зайлж бусгах мэхүүдийг даацтай сайн хийдэг шилдэг начингуудын нэг юм.

### Төмөрбулаг сумын “Бөхийн холбооны тэргүүн” Сумын заан Т.Эрдэнэбат

Сумын заан Т.Эрдэнэбат 1990 онд Галт суманд болсон долоон сумын бүсийн тэмцээнд барилдаж, Цагаан-Уулын харьяат Аймгийн начин Гармаатай үлдэн түрүүлж, үндэсний бөхийн гараагаа эхэлж байсан түүхтэй.

1987 онд аймгийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд хоёрдугаар байрт шалгарч байсан.

1991 онд сумынхаа үндэсний бөхийн аварга шалгаруулах 32 бөхийн барилдаанд Аймгийн арслан Л.Цэдэнсодномтой үлдэж, түрүүлээд сумын начин цол авч байжээ.

1992 онд Архангай аймгийн Цэцэрлэг суманд үзүүлсэн. Тэрээр сумынхаа баяр наадамд 2002 онд түрүүлж, 2004, 2008 онд шөвгөрсөн.

Сумын заан Т.Эрдэнэбат 2011 онд “Монгол бөх Гиннесийн номонд” 6002 бөхийн барилдаанд хоёр давсан байна. Тэрээр 2003 оноос эхлэн өнөөг хүртэл сумынхаа бөхийн холбооны тэргүүнээр ажиллаж, барилдаж байгаа залуу бөхчүүдийг амжилт чансаагаар нь эрэмбэлэх, мөн сумынхаа гаралтай цолтой бөхчүүдийг энгэрийн тэмдэгтэй болгох, сумын бөхчүүдийн намтар түүхийг судлаж цуглуулах зэрэг олон ажлуудыг сэнаачилжээ.



Баруун гар талаас Улсын начин  
М.Эрдэнэбат  
Сумын заан Т.Эрдэнэбат 2011 он  
6002 бөхийн барилдааны үеэр

## Цэргийн начин

### Цэргийн начин Дашийн Цэдэн

Цэргийн начин Дашийн Цэдэн-Иш сумынхаа баяр наадамд хоёр удаа шөвгөрсөн.

### Цэргийн начин Палайн Банди

## Сумын заан

### Сумын заан Дамдиншонхорын Шатарбал

1918 онд төрсөн, морь жилтэй. Д.Шатарбал нь сумынхаа баяр наадамд 1942, 1947, 1953 онуудад түрүүлж, 1945 онд үзүүрлэн, 1948 онд шөвгөрч байсан байна.

### Сумын заан Ренчингийн Хүрлээ.

Сумын заан Ренчингийн Хүрлээ сумандаа 1946 онд түрүүлж, 1948 онд шөвгөрсөн.

### Сумын заан Ренчингийн Бямбажав.

1922 онд төрсөн, нохой жилтэй. Р.Бямбажав нь сумынхаа наадамд тав түрүүлэхдээ дөрвөн жил дараалан түрүүлж суманд долоон удаа буюу хамгийн олон шөвгөрч, дөрвөн удаа дөрөв давж, нийтдээ 20 гаруй жил барилдаж байсан бөх юм.

Заан Бямбажав нь цэрвүү барьцнаас дугтарч хавирах, суйлах, хутгах, тонгорох зэрэг угсраа олон мэх хийдэг шалмаг хурдан барилдаантай бөх байжээ.

### Сумын заан Дамдины Жамцаа

1929 онд төрсөн, могой жилтэй.

Сумын заан Дамдины Жамцаа нь сумандаа 1955, 1957, 1962 онуудад түрүүлж, сумынхаа наадамд олон жил шөвгөрсөн хүчтэй, хийцтэй сайн бөх байлаа.

### Сумын заан Баатарын Батхүү

Сумын заан Баатарын Батхүү нь сумын наадамд 1956 онд түрүүлсэн байна.

### Сумын заан Паньджунай Цагаач

Сумын заан Паньджунай Цагаач сумынхаа баяр наадамд нэг үзүүрлэж, хоёр удаа шөвгөрсөн байна.

### Сумын заан Даваагийн Агваан

Сумын заан Даваагийн Агваан нь сумын наадамд гурван удаа түрүүлж, хоёр удаа үзүүрлэж, тав шөвгөрсөн бяр хүчтэй хийц сайтай заан байлаа.

### Сумын заан Халтарын Жамжаа

Сумын заан Халтарын Жамжаа нь сумынхаа баяр наадамд 1961 онд түрүүлж, 1960, 1964, 1966 онуудад шөвгөрч байжээ.

### Сумын заан Дагвын Түвд

Сумын заан Дагвын Түвд сумынхаа баяр наадамд 1963 онд түрүүлж, 1965 онд шөвгөрч, 1968 онд үзүүрлэж байсан бяр ихтэй заан байлаа.

### Сумын заан Циений Төртогтох

1935 онд төрсөн, гахай жилтэй. Сумын заан Циений Төртогтох нь сумынхаа баяр наадамд 1964, 1965 онуудад түрүүлж гурван удаа үзүүрлэн,



таван удаа шөвгөрч байсан байна. Аймгийн бүх ард түмний спартакиадын үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээнд 1965 онд хоёрдугаар байр, 1966 онд гуравдугаар байр эзэлж байсан байна.

### Сумын заан Түвдэнгийн Сэрээтэр

Сумын заан Түвдэнгийн Сэрээтэр 1967 онд түрүүлсэн байна.

### Сумын заан Санжжавын Давааням

Сумын заан Санжжавын Давааням нь 1968 онд түрүүлж 1964, 1966 онуудад үзүүрлэж байсан байна.

### Сумын заан Г.Төөчөө

Сумын заан Г.Төөчөө нь сумынхаа баяр наадамд нэг удаа түрүүлж, хоёр удаа шөвгөрч байжээ.

### Сумын заан Сосорын Мөнх-Очир

Сумын заан Сосорын Мөнх-Очир нь суманд 1970, 1971 онуудад түрүүлж, нэг удаа үзүүрлэсэн байна.

### Сумын заан Чойдогийн Дамдинжав

Сумын заан Чойдогийн Дамдинжав сумынхаа баяр наадамд 1974 онд үзүүр, 1975, 1979 онд шөвгөрч байжээ.

### Сумын заан Чойжоон Лхагвасүрэн

Сумын заан Чойжоон Лхагвасүрэн сумынхаа баяр наадамд 1975, 1982 онд түрүүлж, 1984, 1986, 1987 онд үзүүрлэж, 1980, 1983, 1990, 1992, 1996 онуудад шөвгөрсөн байна.

Ч.Лхагвасүрэн нь барьцтай, барьцгүй суйлах, хонгодох мэхийг даацтай сайн хийдэг, 20 гаруй жил барилдсан хашир зааны нэг билээ.

### Сумын заан Паньджунай Банзрагч

Сумын заан Паньджунай Банзрагч сумынхаа баяр наадамд 1976, 1977 онд түрүүлсэн. Мөн 1979, 1982 үзүүрлэж, 1973, 1978, 1984, 1985, 1986 онуудад шөвгөрсөн байна.



Зүүн гар талаас с/з Л.Ганболд, с/з Ц.Баянмөнх, с/з Т.Эрдэнэбат, с/з Б.Баяраа, с/з Т.Буян-Амгалан, с/з Д.Бат-Эрдэнэ, с/з Ч.Хатанбаатар, с/х Г.Отгонбаяр

Банзрагч заан нь хүч тэнхээ ихтэй ялангуяа гарын шуундаа их бярттай, хараа, мэдрэмж сайтай, тонгорох мэхийг баруун, зүүнгүй даацтай сайн хийдэг ахмад бөх юм.

**Сумын заан Ж.Бат-Очир**

Сумын заан Ж.Бат-Очир нь сумынхаа баяр наадамд нэг үзүүлсэн байна.

**Сумын заан Бадмаан Лувсандорж**

Сумын заан Бадмаан Лувсандорж сумынхаа баяр наадамд нэг үзүүлэжээ.

**Сумын заан Маамын Магнай**

Сумын заан М.Магнай Алаг-Эрдэнэ суманд нэг түрүүлсэн. Мөн сумынхаа баяр наадамд 1950 онд шөвгөрч байжээ.

**Сумын заан Хишигтийн Тамаажав**

Сумын заан Хишигтийн Тамаажав Бүрэнтогтох суманд түрүүлж заан цол хүртсэн.

**Сумын заан Б.Банзайрагчаа**

Тэрээр Бүрэнтогтох суманд нэг түрүүлж, сумын заан цол авсан.

**Сумын заан Халгарын Монхоодой**

Сумын заан Халгарын Монхоодой нь Сэлэнгэ аймгийн Хушаат суманд түрүүлсэн бөгөөд сумынхаа баяр наадамд 1973 онд үзүүлсэн.

**Сумын заан Далхаагийн Лхагвасүрэн**

Сумын заан Далхаагийн Лхагвасүрэн сумынхаа баяр наадамд 1980 онд түрүүлсэн, 1988 онд үзүүлж, 1987 онд шөвгөрсөн байна. Д.Лхагвасүрэн заан барьцтай барьцгүй суйлах, хонгодох мэхийг даацтай сайн хийдэг, унаа холтой ахмад заан юм.

**Сумын заан Баасайн Ганхуяг**

Сумын заан Б.Ганхуяг нь сумынхаа баяр наадамд 1983, 1987 онд түрүүлж, мөн Төв аймгийн Сүмбэр суманд 1991 онд түрүүлсэн байна.

Б.Ганхуяг нь 18 настайдаа чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж, аймгийн аваргаар шалгарч, улмаар улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцон хүрэл медалийн болзол хангаж байсан чөлөөт бөхийн улсын хоёрдугаар зэрэгтэй тамирчин юм.



Мөн 1990 онд Улаанбаатар хотод Их дээд сургуулиудын үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээнд 64 бөхөөс хоёр давж, 16 бөхтэй тойргоор барилдаж түрүүлэн аварга болж байжээ

**Сумын заан Жамцын Батбаяр**

Сумын заан Жамцын Батбаяр сумандаа 1984, 1994 онуудад түрүүлсэн. Мөн Шинэ-Идэр суманд нэг түрүүлж, 1985 онд үзүүлж гурван удаа шөвгөрсөн байна.

Ж.Батбаяр нь бусгах, хутгах, дагуулж цохих мэхүүдийг даацтай хийхээс гадна барьц сайтай, хурдан хөдөлгөөнтэй, угсраа мэхийг сайн хийдэг ахмад зааны нэг юм.

**Сумын заан Ичинхорлоогийн Ганболд**

Сумын заан И.Ганболд нь сумынхаа баяр наадамд 1986, 1988 онд түрүүлж, 1983 онд үзүүлсэн байна.

Заан И.Ганболд нь өмсөх, этэх, суйлах, суганд сэжиж өргөх мэхийг даацтай сайн хийдэг бярттай ахмад зааны нэг юм.

**Сумын заан Бандийн Доржготов**

Сумын заан Бандийн Доржготов нь сумынхаа баяр наадамд 1990 онд түрүүлж, 1997 онд шөвгөрсөн байна.

Заан Бандийн Доржготов нь барьцтай барьцгүй хавирах, бусгах мэхийг даацтай сайн хийдэг манай залуу зааны нэг юм.

**Сумын заан Даваанямын Лхагвадорж**

Сумын заан Д.Лхагвадорж сумын баяр наадамд 1991 онд түрүүлж 1993, 1995, 1998 онуудад үзүүлж 1987 онд шөвгөрсөн байна.

Заан Д. Лхагвадорж нь халж суйлах, хонгодох, өмсөх мэхүүдийг даацтай сайн хийдэг манай залуу заануудын нэг юм.

**Сумын заан Доржийн Бат-Эрдэнэ**

Сумын заан Д.Бат-Эрдэнэ нь сумынхаа баяр наадамд 1996, 1998 онд түрүүлж, 1997, 2000 онуудад үзүүлж, хоёр удаа шөвгөрсөн байна.

Тэрээр хутгаж, хөмрөх мэхийг даацтай сайн хийдэг.

**Сумын заан Түвдийн Буян-Амгалан**

Сумын заан Т.Буян-Амгалан нь сумынхаа баяр наадамд 1999 онд түрүүлж, 2007 онд шөвгөрсөн байна.

Тэрээр хагалж гуд татах, зайлах мэхийг даацтай сайн хийдэг хүч бярттай манай залуу заануудын нэг юм.

**Сумын заан Батмөнхийн Баяраа**

Сумын заан Б. Баяраа нь сумынхаа баяр наадамд 2000 онд түрүүлж, 2001 онд Жаргал сумын 70 жилийн ойн баяраар түрүүлж, 1999 онд үзүүлж, 1997, 2001 шөвгөрч байсан. Мөн 2005 онд Архангайн Цэцэрлэг суманд шөвгөрсөн байна.



Б.Баяраа баруун зүүн сэмжигнээс зайлж маниулдах, хонгодох, хөмрөх, өмсөх зэрэг мэхүүдийг даацтай сайн хийдэг хүч бяраа ихтэй залуу заануудын нэг юм.

**Сумын заан Чулуунбаатарын Хатанбаатар**

Сумын заан Ч.Хатанбаатар нь сумынхаа баяр наадамд 2003 онд түрүүлж, 1998 онд шөвгөрсөн байна. Мөн 2011 онд “Монгол бөх Гиннесийн номонд” 6002 бөхийн барилдаанд хоёр давсан.

Ч.Хатанбаатар өмсөх, баруун зүүн тонгорох мэхийг даацтай сайн хийдэг эртэй бяраатай залуу заануудын нэг юм

**Сумын заан Данаажавын Отгонбаатар**

Сумын заан Данаажавын Отгонбаатар сумынхаа баяр наадамд 2004 онд түрүүлсэн.

**Сумын заан Цэнд-Аюушийн Гантулга**

Цэнд-Аюушийн Гантулга нь сумынхаа баяр наадамд 2007 онд түрүүлсэн байна. Заан Гантулга нь шахаж татах, хавирах мэхүүдийг даацтай сайн хийдэг эр бяраатай залуу зааны нэг юм.

**Сумын заан Цэрэнхорлоогийн Баянмөнх**

Сумын заан Ц. Баянмөнх нь Сэлэнгэ аймгийн Сайхан суманд нэг түрүүлж, 2005 онд Архангайн Цэцэрлэг сумын наадамд үзүүлсэн. Тэрээр сумынхаа баяр наадамд 2007 онд үзүүлж, 2004, 2008, 2010 онуудад шөвгөрсөн байна. Сумын заан Ц.Баянмөнх нь барьцтай барьцгүй хавирах, хагалж цохих, хонгодох, зайлах мэхүүдийг даацтай сайн хийдэг манай залуу заануудын нэг юм.

**Сумын заан Лхагвасүрэнгийн Ганболд**

Сумын заан Л.Ганболд сумынхаа баяр наадамд 2008 онд түрүүлж, 2010 онд шөвгөрсөн байна. Заан Л.Ганболд тахимдах, суйлах, давхар хамах мэхүүдийг даацтай сайн хийдэг манай залуу заануудын нэг юм.

**Сумын заан Чулуунбаатарын Хасбаатар**

Сумын заан Чулуунбаатарын Хасбаатар нь сумынхаа баяр наадамд 2009 онд түрүүлсэн. Мөн 2011 онд “Монгол бөх Гиннесийн номонд” 6002 бөхийн барилдаанд нэг давжээ.

**Сумын заан Баярсайханы Бямбабаяр**

Сумын заан Баярсайханы Бямбабаяр 2009 онд Шинэ-Идэр суманд түрүүлж, Төмөрбулаг сумын наадамд нэг удаа шөвгөрсөн.

**Сумын заан Чимэдийн Цолмон**

Сумын заан Чимэдийн Цолмон сумынхаа баяр наадамд 2011 онд



Сумын начин М.Баянцогт, Сумын заан Б.Бямбабаяр, Т.Эрдэнэбат, Ч.Цолмон, Б.Баяраа, Ц.Баянмөнх.

түрүүлсэн. Заан Ч. Цолмон хутгаж хөмрөх, зайлах мэхийг даацтай сайн хийдэг манай залуу заануудын нэг юм.

**Сумын заан Цэрэнхорлоогийн Батцоож**

Сумын заан Ц.Батцоож 2012 онд сумынхаа баяр наадамд түрүүлсэн.

**Сумын заан Нямбаатарын Оюунбаатар**

Н.Оюунбаатар нь 2009, 2010 онд жү-до бөхийн аймгийн аварга, 2010 онд самбо бөхийн аймгийн аварга, 2010 оны чөлөөт бөхийн аймгийн аварга, 2011 онд баруун бүсийн цолгүй бөхчүүдийн барилдаанд тэргүүн байр, 2011 онд үндэсний бөхөөр аймгийн аварга, “Алтан дуулга” ХХК-ны нэрэмжит үндэсний бөхийн барилдаанд дөрвөн удаа гуравдугаар байранд шалагарч байсан. Мөн аймгийн үндэсний бөхийн холбооны 20 жилийн ойн барилдаанд үзүүлж, сумын начин цолны болзол хангасан байна.

Мөн 2011 онд “Монгол бөх Гиннесийн номонд” 6002 бөхийн барилдаанд гурав давж, дөрвийн даваанд Дархан аварга Бат-Эрдэнэд өвдөг шороодсон. 2014 оны сумынхаа баяр наадмаар түрүүлж сумын зааны болзол хангасан өсөх ирээдүйтэй залуу зааны нэг юм..

**СУМЫН ХАРЦАГА:**

- |                     |                             |
|---------------------|-----------------------------|
| 1. Н.Буянхишиг      | 8. Доржийн Болдбаатар       |
| 2. Д.Дарьсүрэн      | 9. Батдоржийн Ганбат        |
| 3. Г. Батдорж       | 10. Бат-Очирын Ганхуяг      |
| 4. Шаравын Цэдэн-Иш | 11. Түвдэндоржийн Хадбаатар |
| 5. Р.Батбуян        | 12. Т.Адилбиш               |
| 6. Сангаагийн Дорж  | 13. Ганболдын Отгонбаяр     |
| 7. Доржийн Батболд  |                             |

**СУМЫН НАЧИН:**

1. Найдангийн Шарав
2. Чойжамцын Магван
3. Д.Балжинням
4. Хангайдорж
5. Гомбожавын Дамдиндорж
6. Чимэдбазарын Тэрбиш

7. Дамдинсүрэнгийн Түмэнжаргал.
8. Гунгаан Болд
9. Дагвын Марку
10. Жүгдэрийн Чулуунбат
11. Дашдаваан Чулуунхүү
12. Замбалын Баатар
13. Батдоржийн Ганхуяг
14. Гомбын Шаравпил
15. Төөчөөгийн Ариунсан
16. Төөчөөгийн Гантөмөр
17. Намсрайн Амарсанаа
18. Бямбажавын Равдандорж
19. Санжаа Баянмөнх
20. Түвдийн Отгонбаяр
21. Мягмарын Буянцогт
22. Диваарагчаа Батмөнх
23. Бат-Очирын Гантулга
24. Чулуунбатын Эрдэнэбат
25. Ганбаатарын Мөнх-Эрдэнэ
26. Өнөрсайханы Ган-Эрдэнэ
27. Мөнхбатын Өсөхбаяр
28. Ганбаатарын Гансүх
29. Дашбалжирын Цэрэнтогтох
30. Дэмбэрэлийн Даваадоньд



Сумын заан, ахмад бөх  
н.Дамдинжав

**Гадны аймаг сумаас цол авсан бөхчүүд:**

- 1.Маамын Магнай- сумын заан
2. Хишигтийн Тамаажав- сумын заан
3. Пэрэнлэйн Цагаанбаатар-сумын заан
4. Б.Банзарагчаа- сумын заан
5. Дүвчин- сумын начин
6. Балжинням-сумын начин
7. Ж.Чулуунбат-сумын начин
8. Галсанпунцагийн Отгонбаатар-Завхан аймгийн Ургамал суманд 2012 онд түрүүлж сумын заан цол авсан. Шонхор дээд сургуульд багшилдаг. Биеийн тамирын тэргүүний ажилтан.
9. Ж.Үүрцайх-Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд 2011 онд сумын начин цол авсан.
10. Дашдэлгэрийн Бат-Орших-Хатгал суманд 2013 онд сумын начин цол авсан.

**Сумын хүргэн болон суугуул бөхчүүд:**

- 1.Улсын начин Амарзаяа-Архангайн Чулуут сум
2. Аймгийн арслан Очирбал
- 3.Аймгийн начин Сандагдорж- Шинэ-Идэр сум
4. Аймгийн начин Ө.Гантулга- Улаан –Уул сум

5. Сумын заан Эрдэнэбилэг--Увс Баруунтуруун
- 6.Сумын заан Амартайван-Жаргал сум
- 7.Сумын харцага Цэрэнтогтох-Жаргал сум
8. Сумын харцага Нямдаваа- Улаанбаатар хот
9. Сумын начин Г.Ганбат-Тосонцэнгэл сум

Бөхийн үе үеийн засуул Рагчаа, Буянхишиг, О.Найдансүрэн, Д.Цэдэн-Иш, Б.Оюун, Ж.Нямсүрэн, Л.Бат-Эрдэнэ, Д.Балдандорж, М.Бямбачулуун, З.Баатар, Д.Зоригт, бөх цоллооч Ж.Нямсүрэн, Б.Оюун, О.Уургачхүү, М.Бямбачулуун Д.Амарсанаа, О.Цэдэндамба, бөх тайлбарлагч Н.Төмөрхуяг, Б.Энхжаргал, Ц.Доржготов, бөхийн шүүгч Д.Түмэнжаргал, Ж.Баянмөнх, Ц.Баянмөнх, нар хамтран ажиллаж байна.

**ӨНӨРСАЙХАНЫ ГАН-ЭРДЭНЭ**

2005 онд “Цодгор” хүү аймгийн шатрын аварга шалгаруулах тэмцээнд тусгай байр

2009 он Тээл багийн наадамд шөвгөрч хүрэл медаль

2010 он Хөвгүүд залуучуудын үндэсний бөхийн аймгийн аварга

-“Гурван аваргын залгамж холбоо” үндэсний бөхийн аймгийн аварга

-Чөлөөт бөхийн өсвөр үеийн аймгийн аварга

-Жү-до бөхийн өсвөр үеийн аймгийн аварга

-Самбо бөхийн өсвөр үеийн аймгийн аварга

-Төмөрбулаг сумын сургууль байгуулагдсаны 70 жилийн ойн хүүхдийн барилдаанд үзүүр

-ОХУ-ын Буриадад болсон чөлөөт бөхийн тэмцээнээс мөнгөн медаль

-Хотгойдын шадарван Чингүнжавын мэндэлсэний 300 жил, АХ-ын

89 жил, Хангайн бүсийн даншиг Хотгойдын хурд-2 наадмын өсвөрийн барилдаанд үзүүр

-Төмөрбулаг сумын сургуулийн спортын шилдэг сурагч

-Сумын заан Төртогтох агсны нэрэмжит барилдаанд түрүү

2011 он:

- Жү-до бөхийн өсвөр үеийн аймгийн аварга

- Төмөрбулаг сумын сар шинийн барилдаанд түрүү

-Аймгийн үндэсний бөхийн холбооны 20 жилийн ойн баруун бүсийн цолгүй бөхчүүдийн барилдаанд шөвгөрсөн

-Хүүхдийн спортын 4-р наадамд самбо бөхөөр түрүүлсэн , жү-до бөхөөр 3-р байр

-МАН-ын “Ард түмнээ сонсоё” аяны хүрээнд зохиогдсон барилдаанд аймагт түрүүлсэн

-Өсвөр үе залуучуудын үндэсний бөхийн аймгийн аварга

-Сумын заан Төртогтох агсны нэрэмжит барилдаанд үзүүр

-Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 , Их Монгол улс байгуулагдсаны 805 , АХ-ын 90 жилийн ойгоор улсын начин цол хүртсэн М. Эрдэнэбатын хүндэтгэл “сумын начин” цол олгох барилдааны түрүү

-“Аварга Хадбаатар сан” –гийн нэрэмжит үндэсний бөхийн улсын аварга

-“Монгол бөх Гиннесийн номонд” 6002 бөхийн барилдаанд нэг

давсан

-Хөвсгөл Алтан дуулга үндэсний бөхийн барилдаанд гурван удаа түрүүлж , 4 удаа шөвгөрсөн байна.

**Төмөрбулаг сумын наадамд түрүүлж шөвгөрсөн бөхчүүд**

№	Түрүүлсэн	Үзүүрлэсэн	Дөрөвт үлдсэн
1931	Улсын начин Ш.Пүрэвцэрэн	Аймгийн заан Ж.Дэндэв	Аймгийн арслан Чойндон Аймгийн заан Дөвчин
1932	Сумын заан Готов	Улсын начин Осор	Улсын начин Пүрэвцэрэн Аймгийн арслан Жигжид
1933	Аймгийн заан Ж.Дэндэв	Ишжавын Жамба	Аймгийн начин Сажаа Сумын заан Дагваа
1934	Аймгийн заан Ж.Дэндэв	Аймгийн арслан Чойндон	Нэр олдоогүй
1935	Залуу бөх Д.Дашхүү	Улсын начин Батсуурь	Аймгийн начин Л.Жамсран Дэрэн хэмээх Төмөр
1936	Сумын заан дэрэн Төмөр	Аймгийн начин Л.Жамсран	Аймгийн заан Ж.Дэндэв
1937	Аймгийн начин Л.Жамсран	Сумын заан Д.Дашхүү	Аймгийн заан Ж.Дэндэв
1938	Сумын начин И.Жамба	Самбуу	Н.Шарав Шавжаа хэмээх Аюуш
1939	Мундаг хэмээх Гэндэн	Ч.Мандшир	Аймгийн заан Ж.Дэндэв Ж.Жамба
1940	Цэргийн арслан Ж.Гэлэгжамц	Монсоо хэмээх Шагдар	Сумын заан Дагваа Аймгийн заан Ж.Дэндэв
1941	Цэргийн арслан Ж.Гэлэгжамц	Аймгийн заан Ж.Жамба	Сумын заан Дагваа Сумын начин Шарав
1942	Д.Шадарбал	Шагдар	Нугалуур хэмээх Гаваа Шавжаа хэмээх Аюуш
1943	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	Сумын заан Дагваа	Нэр олдоогүй
1944	Б.Данаа	Аймгийн заан Ж.Дэндэв	Нэр олдоогүй
1945	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	Сумын заан Д.Шадарбал	Нэр олдоогүй
1946	Залуу бөх Р.Хүрлээ	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	Нэр олдоогүй
1947	Сумын заан Д.Шадарбал	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	Дансранжав

1948	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	Р.Бямбажав	Сумын заан Д.Шадарбал Р.Хүрэл
1949	Сумын заан Р.Бямбажав	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	М.Жанцан Г.Жамсран
1950	Сумын заан Р.Бямбажав	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц	Залуу бөх Н.Буянхишиг М.Магнай
1951	Сумын заан Р.Бямбажав	Сумын начин Н.Буянхишиг	Нэр олдоогүй
1952	Сумын заан Р.Бямбажав	Ж.Жамъяндорж	Сумын начин Н.Буянхишиг Ч.Магван
1953	Сумын заан Д.Шадарбал	Аймгийн арслан Ж.Дугаржанцан	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц Ч.Дорж
1954	Сумын заан Р.Бямбажав	Д.Дарьсүрэн	Д.Дунгар
1955	Д.Жамцаа	Г.Батдорж	Аймгийн начин П.Лхагваа Сумын заан Р.Бямбажав
1956	Б.Батхүү	Сумын начин Д.Дарьсүрэн	Д.Далай Сумын заан Р.Бямбажав
1957	Сумын заан Д.Жамцаа	Улсын начин Ч.Жүгдэрнамжил	Сумын начин Д.Дарьсүрэн Д.Гомбодорж
1958	М.Ярваа	Ш.Цэдэн-Иш	Сумын заан Р.Бямбажав Сумын заан Д.Жамцаа
1959	Аймгийн начин П.Лхагваа	Н.Цагаач	Аймгийн арслан Ж.Гэлэгжамц Б.Балжинням
1960	Сумын заан Д.Агваан	Г.Төөчөө	Х.Жамжаа П.Цагаач
1961	Сумын начин Х.Намжаа	Аймгийн начин Ж.Жамъянжав	Сумын заан Р.Бямбажав Сумын начин П.Цагаач
1962	Сумын заан Д.Жамцаа	Сумын заан Д.Агваан	Сумын заан Р.Бямбажав Р.Батбуян
1963	Сумын начин Д.Түвд	Сумын начин П.Цагаач	Сумын начин Р.Батбуян Хангайдорж
1964	Залуу бөх Ц.Төртогтох	С.Давааням	Сумын заан Х.Намжаа Сумын начин Бахимбор
1965	Сумын заан Ц.Төртогтох	Сумын начин Г.Төөчөө	Сумын заан Д.Төвд Д.Отряд
1966	Сумын заан Д.Агваан	Сумын начин С.Давааням	Сумын заан Х.Жамжаа Сумын начин Р.Батбуян
1967	Т.Сэрээтэр Залуу бөх	С.Мөнх-Очир Залуу бөх	Сумын начин Г.Төөчөө
1968	Сумын начин С.Давааням	Сумын заан Д.Түвд	Сумын начин Г.Төөчөө Сумын заан Ц.Төртогтох

1969	Аймгийн арслан Баттогтох	Аймгийн арслан Төмөрбаатар	Аймгийн заан Сэрээтэр Түвдэндорж
1970	Сумын начин С.Мөнх-Очир	Аймгийн начин П.Лхагваа	Сумын начин Р.Батбуян Б.Лувсандорж
1971	Сумын заан С.Мөнх-Очир	Сумын заан Ц.Төртогтох	Г.Дамдиндорж Г.Дагвадорж
1972	Сумын заан П.Лхагважав	Сумын заан Р.Бямбажав	Ц.Банди С.Дорж
1973	Аймгийн начин С.Халтар	Х.Монхоодой	А.Бямбасүрэн Залуу бөх П.Банзрагч
1974	Аймгийн арслан Ж.Пүрэвдорж	Ч.Дамдинжав	Аймгийн начин Б.Батмөнх Сумын начин Б.Арилдий
1975	Ч.Лхагвасүрэн Залуу бөх	Аймгийн начин С.Халтар	Сумын начин Дамдинжав Залуу бөх Ичинхорлоо
1976	Сумын начин П.Банзрагч	Ж.Бат-Очир	Цэргийн начин Ш.Цэдэн- Иш Залуу бөх Ч.Тэрбиш
1977	Сумын заан П.Банзрагч	Сумын заан Б.Лувсандорж	Залуу бөх Б.Нэргүй Залуу бөх Ё.Шагдар
1978	Даваа-Очир	Аймгийн арслан Ж.Пүрэвдорж	Сумын заан П.Банзрагч Залуу бөх Г.Болд
1979	Аймгийн начин Дарьжавын Лхагвасүрэн	Сумын заан П.Банзрагч	Аймгийн начин Ч.Дамбадаржаа Сумын начин Ч.Дамдинжав
1980	Далхаан Лхагвасүрэн Залуу бөх	Аймгийн начин Батнасан	Сумын заан Х.Жамсранжав Сумын заан Ч.Лхагвасүрэн
1981	Сумын заан Д.Нямбуу	Аймгийн арслан Базарраднаа	Аймгийн заан Ванчигдорж Ж.Батбаяр Залуу бөх
1982	Сумын заан Ч.Лхагвасүрэн	Сумын начин П.Банзрагч	Сумын начин Ж.Батбаяр Б.Ганхуяг Залуу бөх
1983	Сумын начин Ганхуяг	И.Ганболд	Б.Балдандорж аймгийн начин Сумын заан Ч.Лагвасүрэн
1984	Сумын начин Б.Батбаяр	Сумын заан Ч.Лагвасүрэн	Сумын заан П.Банзрагч Д.Мархүү Залуу бөх
1985	Аймгийн начин Батнасан	Сумын заан Ж.Батбаяр	Сумын заан П.Банзрагч Д.Чулуунхүү Залуу бөх
1986	Сумын начин И.Ганболд	Сумын заан Ч.Лхагвасүрэн	Сумын заан П.Банзрагч З.Баатар Залуу бөх

1987	Сумын заан Б.Ганхуяг	Сумын заан Ч.Лагвасүрэн	Сумын заан Д.Лхагвасүрэн Д.Лхагвадорж Залуу бөх
1988	Сумын заан И.Ганболд	Сумын заан Д.Лхагвасүрэн	Д.Батболд Залуу бөх Г.Шаравпил Залуу бөх
1989	Аймгийн арслан Т.Оюунбилэг	Аймгийн арслан Л.Цэдэнсодном	Сумын заан Ж.Батбаяр Цэргийн начин Г.Сэргэлэн
1990	Б.Доржготов Залуу бөх	Аймгийн начин П.Лхагвадорж	Залуу бөх Д.Бат-Эрдэнэ Сумын заан Ч.Лагвасүрэн
1991	Сумын начин Да.Лхагвадорж	Аймгийн начин Б.Балдандорж	Сумын заан Б.Ганхуяг Т.Ариунсан Залуу бөх
1992	Аймгийн начин П.Лхагвадорж	Ч.Хүрэлчулуун Залуу бөх	Сумын заан Ч.Лхагвасүрэн Сумын начин Д.Батболд
1993	Даваадорж	Сумын заан Д.Лхагвадорж	Т.Гантөмөр Залуу бөх Н.Амарсанаа Залуу бөх
1994	Сумын заан Ж.Батбаяр	Сумын начин Ч.Хүрэлчулуун	Сумын заан Даваадорж Д.Болдбаатар
1995	Аймгийн заан Батчулуун	Сумын заан Д.Лхагвадорж	Аймгийн арслан Очирбал Сумын начин Ч.Хүрэлчулуун
1996	Сумын начин Д.Бат-Эрдэнэ	Б.Ганбат Залуу бөх	Сумын заан Ч.Лхагвасүрэн Сумын начин Д.Батболд
1997	Сумын заан Ч.Хүрэлчулуун	Сумын заан Д.Бат-Эрдэнэ	Сумын заан Б.Доржготов Б.Баяраа Залуу бөх
1998	Сумын заан Д.Бат-Эрдэнэ	Сумын заан Д.Лхагвадорж	Сумын начин Ч.Хатанбаатар Залуу бөх Б.Равдандорж
1999	Т.Буян-Амгалан Залуу бөх	Сумын начин Б.Баяраа	Сумын начин Д.Болдбаатар Б.Ганхуяг Залуу бөх
2000	Сумын начин Б.Баяраа	Сумын заан Д.Бат-Эрдэнэ	С.Баянмөнх Залуу бөх Баасанхүү Залуу бөх
2001	Сумын заан М.Дугаржанцан	М.Эрдэнэбат Залуу бөх	Сумын заан Б.Баяраа Аймгийн заан Т.Баярсайхан
2002	Сумын начин Т.Эрдэнэбат	Т.Хадбаатар Залуу бөх	Сумын начин Б.Ганхуяг Залуу бөх Т.Отгонбаяр
2003	Сумын начин Ч.Хатанбаатар	Аймгийн начин Ч.Хүрэлчулуун	Залуу бөх Д.Батмөнх Залуу бөх Т.Буянцогт
2004	Д.Отгонбаатар Залуу бөх	Адилбиш Залуу бөх	Сумын заан Т.Эрдэнэбат Сумын начин Ц.Баянмөнх



2005	Улсын харцага Г.Ганхуяг	Улсын начин Б.Бадрал	Аймгийн арслан Ж.Жамъянсэнгэ Аймгийн арслан Ё.Даваа
2006	Аймгийн арслан М.Эрдэнэбат	Аймгийн арслан Ж.Жамъянсэнгэ	Сумын заан Нямбаяр Аймгийн заан Дэлгэрдалай
2007	Ц.Гантулга Залуу бөх	Сумын заан Ц.Баянмөнх	Сумын заан Т.Буян- Амгалан Залуу бөх Баасандорж
2008	Л.Ганболд Залуу бөх	Г.Отгонбаяр Залуу бөх	Сумын заан Т.Эрдэнэбат Сумын заан Ц.Баянмөнх
2009	Ч.Хасбаатар Залуу бөх	Сумын заан Даваажанцан	Аймгийн начин Ч.Хүрэлчулуун Аймгийн начин Доржсүрэн
2010	Ч.Цолмон Залуу бөх	Сумын начин Г.Отгонбаяр	Сумын заан Ц.Баянмөнх Сумын заан Л.Ганболд
2011	А.Мөнх-Эрдэнэ Залуу бөх/ Бүрэнтогтох/	Аймгийн заан Энхзаяа	Залуу бөх Г. Мөнх- Эрдэнэ Залуу бөх Баасанжав
2012	Ц.Батцоож Залуу бөх	Нямдаваа Сумын начин	Сумын начин Ө.Ган- Эрдэнэ Сумын начин Базаррагчаа/ Бүрэнтогтох/
2013	Ө.Гантулга Сумын заан	Гомбожав залуу бөх /Шинэ-идэр/	Залуу бөх М.Өсөхбаяр Залуу бөх Гантулга
2014	Н.Оюунбаатар Сумын начин	Ч.Хүрэлчулуун Аймгийн начин	Залуу бөх Г.Гансүх Залуу бөх Г.Ганбат/ Тосонцэнгэл/

1931-2013 он

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН МОРИН СПОРТ УЯАЧДЫН ХОЛБОО

Монгол хүний буян хишиг цог хийморийн бэлгэдэл төрийн сүлдэнд заларсан хүлэг морь нь үндэсний их баяр наадмын нэг төрөл болж эрт дээр үеэс эдүгээ хүртэл уламжлалт соёл болон хөгжин дэлгэрсээр ирсэн түүхтэй. Үндэсний их баяр наадмын тухай хууль ММСУХ, Хөвсгөл аймгийн “Дэлтэй цэнхэр” МСУХ-оос гаргасан удирдамж, тогтоол шийдвэрийг ажлын чиглэл үүрэг болгон уяачидтай хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төмөрбулаг сумын МСУХ анх 1991 онд уяачдын үүсэл санаачилгаар бий болж тэргүүнээр нь ИТХ-ын нарийн бичгийн дарга Цэдэнсамбуугийн Батбаярыг сонгосон байдаг. Энэ хүн 1991-2013 он хүртэл олон жил үр бүтээлтэй ажиллаж, уяачдын хөдөлмөр зүтгэлийг төр засгаар үнэлүүлэх, орчин цагийн монгол адууг хөгжүүлэх зэрэг томоохон ажлыг эхлүүлж тамга тэмдэг бүхий төрийн бус байгууллага болтол зохион байгуулан ажилласан.

2013 оны гуравдугаар сарын 17-нд сумын МСУХ ээлжит бус хурлыг зохион байгуулж хуралд оролцсон уяачдын олонхийн саналаар МСУХ-ны тэргүүнээр Б.Энхжаргал, дэд тэргүүнээр Б.Дашдондог тэргүүлэгч гишүүдээр Т.Сүхбат, Ч.Отгонбаяр, Ц.Батбаяр, Д.Наранбаатар, А.Баясгалан нарыг сонгосон. Сумын МСУХ нутгийн адууны үүлдэр угсааг сайжруулах орчин цагийн монгол адууг хөгжүүлэх зорилгоор Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудаас хурдан удмын хээлтэгч болон хээлтүүлэгч адууг худалдан авч сүргийн бүтцээ сайжруулж байна. Хурдан морь уяж сойх арга барил, эрдэм ухааныг өвөг дээдсээсээ өвлөн авч өнөө цагийн залуу уяачдад зааж сургаж байгаа олон арван ахмад уяачид байдаг. Эдгээр уяачид сум, аймаг, бүсийн наадамд хурдан хүлгээ айрагдуулж байсан алдарт уяачид билээ. Ахмад уяачдын уяж сойж сумын баяр наадамд 2-5 удаа түрүүлж байсан түмэн эхээс цухас дурьдвал Санжаа начинны бөөгийн бор, хурдан хар, Г.Паалайн



далбан улаан, Х.Намсрайн хонгор, Д.Хярваан бор, Я.Ичинхорлоон хээр, Ж.Даваажавын цоохор, Х.Дагвадоржийн бор, Д.Мархүүгийн бор, Д.Чимэдийн халиун зэрэг хурдан буянууд юмаа. Ахмад уяачдын гаргасан амжилт хөдөлмөр зүтгэлийг үнэлэх, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулж байна. Сумын уяачдын баярыг жил бүр тэмдэглэж, залуу уяачдыг урамшуулах тэдний гаргасан амжилтыг үнэлж сумын алдарт уяач цол олгож байна. Тус сумаас аймаг, бүс, даншиг наадамд нутгийнхаа нэрийг гаргаж уясан эзнээрээ цолоо дуудуулсан удамт хурдан хүлгүүдтэй билээ. Энэ хурдан хүлгүүдийн ач буянаар аймаг сумын алдарт уяачид олноор төрөн гарсан.

**Төмөрбулаг сумаас төрсөн Аймгийн алдарт уяачид**

Д.Гонгор	Ш.Дашмягмар
Я.Ренчинжүгдэр	Б.Дашдондог
Д.Жамьяанжав	Ц.Баатар
Л.Оюун-Эрдэнэ	Б.Баясгалан
Д.Баасанжав	Ч.Гэлэгчулуун
Ц.Нацагдорж	Ч.Лхагвачулуун
Ц.Батцэнгэл	Д.Далайхутаг
Б.Балжинням	А.Батсайхан
Ж.Довдон	А.БатЭрдэнэ.
Г.Болд	Д.Ганхуяг
Г.Рахадь	Ч.Отгонбаяр
Ж.Лхамсүрэн	Ж.Хөрөнгөө
Ж.Түмэн-Өлзий	Д.Хүрэлбаатар
Ж.Борбаатар	Д.Сосорбарам

**Морин спортын мастер**

П.Цагаанбаатар  
Ж.Амраа нар төрөн гарсан.

**Сумын алдарт уяачид:**

Ц.Тэрбиш, Ю.Очир, Г.Сундуй, Т.Сүхбат, Л.Үнэнбат, Л.Нэргүй, М.Өсөхбаяр, О.Оюунсайхан, Л.Цэдэндамба, Ч.Батхүү, Ц.Шинэбаяр, Д.Дашдаваа, Д.Даваадоньд, А.Баясгалан, Б.Дамбажав зэрэг залуу уяачид үндэснийхээ өв соёл болсон хурдан морь уяж сойх эрдэмд суралцаж сумынхаа баяр наадамд олон айраг түрүү авч байна.

Төмөрбулаг сумын хурдан хүлгүүд ихэвчлэн улаан хүрэн саарал зүстэй байсан учир хурдан саарлууд гэж зэргэлдээх сум орон нутагтаа алдаршиж сумын баяр наадмын дэвжээг гадны морьдод алдаж үзээгүй ийм л хурдан хүлгүүдтэй билээ. Төмөрбулаг сумын түүхт 80 жилийн ойн баяр наадамд Ц.Нацагдоржын саарал, Ч.Лхагвачулууны саарал, Ө.Энх-Амгалангын саарал, Ц.Батцэнгэлийн саарал, Х.Хашчулууны саарал гэсэн хүлгүүд айргийн тавд хурдан ирсэн нь үүнийг гэрчилнэ.

Өсөх ирээдүйтэй залуу уяач О.Оюунсайхан, Л.Цэдэндамба, А.Баясгалан, Б.Ариунсан, О.Энхболд, Д.Даваадоньд нарын уясан хүлгүүд

сүүлийн жилүүдэд сумынхаа баяр наадамд магнайлж байна.

*Аймгийн алдарт уяачдын нэрэмжит сумын уяачдын баяраар залуу уяачдад сумын алдарт уяач цол шинээр олгож байгаа нь*

**Овог:** Лувсанзундуй  
**Нэр:** Оюун-Эрдэнэ  
**Төрсөн он сар:** 1963.08.26  
**Цол:** Аймгийн алдарт уяач

Л.Оюун-Эрдэнэ нь 1979 оноос эхлэн бие даан морь уяж тэр жилийнхээ сумын наадамд бор халзан морь нь айргийн гуравт хурдан ирсэн нь түүнийг морь уях уяач болох замд хөтөлжээ. Тэрээр бага залуудаа олон сайхан хурдан хүлгүүдийг уяж сойж 1981-1984 онуудад сумын баяр наадамд айраг түрүү авч 1985 оны сумын 60 жилийн ойд хоёр морь шөвөгүүлсэн. Түүний уяж сойсон олон хүлгүүд дотроос хурдан хүрэн халзан морь нь хангайн бүсийн даншиг наадамд айрагдаж хөвсгөл аймгийн түүхт 80 жилийн ойгоор түрүүлж байсан дархан түмэн эх билээ. Энэ гаргасан амжилтыг үнэлж 1994 онд Аймгийн алдарт уяач цол олгосон.



**Овог:** Гэндэн  
**Нэр:** Рахадь  
**Төрсөн он сар:** 1940.03.18  
**Цол:** Аймгийн алдарт уяач

Г.Рахадь нь 1960 оноос одоог хүртэл хурдан морь уяж сойж залуу уяачдад зааж сургаж яваа ахмад уяач билээ. Түүний гаргасан амжилтаас дурьдвал 1960-2006 он хүртэл сумынхаа баяр наадамд 28 шөвөг, 8 түрүү авч байсан байна. Мөн 2004 онд Хөвсгөл аймгийн Шинэ Идэр сумын түүхт 80 жилийн ойн их насны морьдын уралдаанд хонгор морь нь аман хүзүүдэж, 2006 онд Архангай аймгийн Цэцэрлэг сумын түүхт 80 жилийн баяр наадамд хонгор морь нь түрүүлж байсан. Энэхүү хонгор морь нутгийн олондоо Ааяагийн хонгор гэж нэрлэгдсэн хурдан хүлэг байлаа. Г.Рахадийн гаргасан амжилт хөдөлмөрийг нь үнэлж 2001 онд Аймгийн алдарт уяач цол олгосон.



**Овог:** Дорж

**Нэр:** Чимэд

**Огноо:** 1939-1991 он

**Цол:** Сумын алдарт уяач

Д.Чимэд 1957-1991 он хүртэл сумын баяр наадамд олон хурдан хүлэг уяж сойж байсны дотроос хурдан хар морь нь сумын баяр наадамд 3 түрүүлж аймгийн баяр наадамд айрагдаж байсан. Нутгийн олондоо Чимэдийн халиун гэж нэрлэгдсэн энэ хурдан буян нь 1983-1992 он хүртэл сумынхаа баяр наадамд айраг түрүү, аман хүзүүг алдаж үзээгүй алдарт хүлэг билээ. 1984, 1985, 1986, 1988, 1990 оны сумын наадамд аман хүзүүнд хурдалж ирсэн нь түүхэн давтагдашгүй амжилт юм.

Хурсан олныг харахаараа хургаж зогсдог халиун морь 1991 оны сумын баяр наадамд анх түрүүлсэн хурдан ажнай билээ.



**Овог:** Жунай

**Нэр:** Довдон

**Төрсөн он сар:** 1932.09.10

**Цол:** Аймгийн алдарт уяач

Ж.Довдон нь бага наснаасаа малын дэргэд өсөж хурдан морь унаж байсан нь морь уяж сойх сонирхлыг нь татсан гэдэг. Тэрээр 1955 оноос хойш 50 гаруй жил хурдан морь уяж сойх эрдэмд суралцаж олон залуу уяачдад зааж сургаж үлгэр дууриалал болсон ахмад уяач билээ. Түүний уяж сойсон хурдан хүлгүүд нь сум аймаг бүсийн наадамд амжилттай уралдаж

сум орон нутгийн уралдаанаас 21 түрүү, 42 шөвөг аймгийн баяр наадамд буурал даага нь 5, хүрэн хязаалан нь 7д хурдалж байсан. Энэ гаргасан амжилт хөдөлмөр зүтгэлийг нь үнэлэж 2000 онд аймгийн алдарт уяач цол олгосон.



## ТӨМӨРБУЛАГ СУМЫН МЭРГЭН ХАРВААЧИД

Далай жанжин гүний хошуу эрт дээр үеэс эрхий мэргэн харваачид олонтой байсны нэг нь уртын дууч, хоёр метр хиртэй өндөр гоолиг нуруутай, өвөр зүүн багт амьдарч байсан Г.Чадраабал “хүнд” гэж үндэсний сурын мэргэн харваач байжээ. Чадраабал “Хүнд”-ийн нумаа татаад тавих гэж байхыг харахад жинхэнэ Монгол баатар эр гэдэг ийм байдаг байхдаа гэж хэнд ч бодогдохоор тийм сүрлэг сайхан эр байсан тухай хөгшчүүд хуучилдаг байж. Гүнсэнгийн Чадраабал өөрийнхөө зэргэлдээх аймаг, хошуудын наадамд олон удаа түрүүлж байсан алдартай мэргэн харваач байсан учраас Далай жанжин гүн 1923 оны даншиг наадамд авч явахаар дуудуулжээ. Энэ үед Чадраабал хол юманд явсан байсан учир зарыг хожуу дуулаад хугацаа хожимдож очиход Далай жанжин гүн өвөр Тогоруутын багийн /одоогийн Бүрэнтогтох сум/-ийн “Унтаа” хэмээх Лосол мэргэнийг авч явахаар бэлтгэсэн байжээ. Далай жанжин гүн Чадраабалыг 20 сум тавиад 20 оновол баа зэмээс хэлтрүүлж авч явна гэж айлдсаны дагуу шөнө зулын гэрэлд “Хонгио” /сур харвааны бай/ тавьж харвуулж шалгахад 20 сумнаас 19 оносон учир баалж зэмлэлгүйгээр өршөөн хоёр харваачаа хоёуланг нь даншиг наадамд авч явжээ. Чадраабал мэргэн олон аймаг, хошуудын мэргэчүүлтэй даншиг наадамд цэц булаалдан харвасаар түрүүлж халх даяар нэр нь алдаршин Богд эзэн хаанаас “Гэрэлт цагаан од”-той отго жинс, “Хүнд” хэргэм зэрэг шагнаж, Улсын мэргэн цол олгож, үүлэн хээтэй дээлийн торго өгч байсан байна. Чадраабал “хүнд”-ийн отго жинс, хэрэглэж байсан нум сум түүний хүү Мандшир болон хүүхдүүдэд нь хадгалагддаг.

Өвөр зүүн багийн Мэжээн Дамдинжав жонон гэдэг улсын мэргэн харваач, улсын чанартай олон наадамд оролцож онч мэргэнээр олонд гайхагдаж алдаршсан бөгөөд 1937 онд улсын наадмын сурын харваанд тэргүүн байр эзэлж, “Нанжин гахай ногоон гөлөм” бусад зүйлээр шагнагдаж ирээд гэртээ дөнгөж хоёр хоноод баривчлагдаж яваад сураггүй болжээ. Дамдинжавын шагналын гахай гөлөмтэй эмээл, бусад хэрэглэл тус аймгийн Бүрэнтогтох суманд амьдарч байгаа түүний хүү Жамсрангийн үр хүүхдүүдэд хадгалагдаж байна.

Тус сумын хүргэн Шаравын Дашдэлгэрийнх удмаараа сайн харвадаг мэргэн харваачид Хөвсгөл аймаг болон улсад нэрээ цуурайтуулан амьдарч байна. Түүний төрсөн эцэг Цэдэнхүүгийн Шарав Улсын хүндэт мэргэн цолтой, эгч Шаравын Лхагвасүрэн 1969 онд улсад түрүүлж, улсын мэргэн цол хүртэж байжээ. Мөн Шаравын Дашдэлгэр Төмөрбулаг сумын хүргэн 1970-1980 оны хооронд улсын чанартай олон олон уралдаан тэмцээнд цэц мэргэнээ сорьж үндэсний болон байт сурын харвааны улмын 1-р зэрэгтэй. Түүний төрсөн дүү Шаравын Гансүх 1992 онд улсад түрүүлж анхны Ерөнхийлөгч П.Очирбатаас алтан өргөмжлөл авч байсан бөгөөд улсын мэргэн цолтой хүртжээ. Мөн хүү Дашдэлгэрийн Батсүмбэрэл нь Аймгийн хүүхдийн сурын тэмцээнд тогтмол эхний нэгээс гуравдугаар байр эзэлж

байсан байна.

2011 оны 05 сарын 01-нээс Монгол үндэсний сурын харвааг Хөвсгөл аймагт хөгжүүлэх, уламжлалыг сэргээн сурталчлах, иргэдийг нум сумаар бахархах, өвлөн уламжлах сонирхол, санаачлагыг өрнүүлэх бүх талын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Хөвсгөл хөгжил” сангаас “Монгол нум сум” хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр сум бүрт нум, сум, бүтэн хасаа сур болон харвааны бусад хэрэглэгдэхүүнээр хангаснаар энэ оны улсын баяр наадмаар эрийн гурван наадмаа эн тэгш байдлаар нь хийдэг түүхэн уламжлалаа дэлгэрүүлж эхэлсэн юм. АХ-ын 90-н жилийн ойгоор 24-н эрэгтэй харваачаас Г.Батхүү /Хүн эмнэлэгийн ня-бо, тус сумын хүргэн/ түрүүлж, Ё.Мөнхбаяр, Д.Очирсүм нар удаах байр, 6-н эмэгтэй харваачаас Т.Нарангэрэл түрүүлж, П.Цэцэгээ /1-р баг/ Б.Цэрэннадмид /МШБ-ны эдийн засагч / нар удаах байр, 2012 оны АХ-ын 91-н жилийн ойгоор 6-н эмэгтэй харваачаас Т.Нарангэрэл түрүүлж Д.Мягмармаа, Мэндсайхан нар удаах байр 24-н эрэгтэй харваачаас Э.Очирсүм /5-р баг/ Г.Батхүү, /Хүн эмнэлэгийн ня-бо, /Ч.Эрдэнэ-Очир/ Ч.Ганбат 1-р баг/ нар удаах байр, эмэгтэй харваачаас Т.Нарангэрэл түрүүлж, Б.Золжаргал, О.Гарамсүрэн нар удаах байр, 2014 оны АХ-н 93 жилийн ойн баяраар 10-н эрэгтэй харваачаас Ч.Эрдэнэ-Очир /Ганбат 1-р баг / түрүүлж Э.Очирсүм /5-р баг/, Ё.Мөнхбаяр /1-р баг/ нар удаах байр, 10-н эмэгтэй харваачаас Т.Нарангэрэл /5-р баг/ түрүүлж, О.Гарамсүрэн /1-р баг/ Б.Алтанцэцэг /5-р баг/ нар удаах байрыг тус тус эзэлсэн байна. Дээрх дөрвөн жилийн сурын харваанаас харахад сумын заан Ц.Төртогтохын үр хүүхэд Т.Сүхбат, Т.Нарангэрэл бэр О.Гарамханд, ач Т.Очирсүм нар нь сумын наадамд сайн харваж, цэц мэргэнээ гайхуулж байна. Үүний дундаас Т.Нарангэрэл нь эмэгтэй сумын харваанд сумын аварга харваачийн байр сууриа алдаагүйгээр үл барам 2011 онд аймагт зохиогдсон урлаг, спортын наадамд аймгийн мэргэчүүлтэй эн зэрэгцэн цэц мэргэнээ сорин харваж байсан мэргэн харваач юм. Мөн Сумын начин Чулуунбатын хүүхдүүд Ч.Эрдэнэбат, Ч.Эрдэнэ-Очир нар шагайн харваанд онч мэргэн харвадаг ба Ч.Эрдэнэ-очир /Ганбат/ нь Галт суманд зохиогдсон Идэр бүсийн тэмцээний шагайн харваанд улсын цолтой харваачидтай эн зэрэгцэн харваж, багаараа мөнгөн медаль хүртэж байсан ба сүүлийн үед үндэсний сурын харваанд тогтмол сайн харваж байгаа цэцэн харваачдын нэг.

## ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБОО

Төмөрбулаг сумын залуучуудын холбоо анх 1996 онд байгуулагдсан бөгөөд анхны даргаар Б.Хүрэлбаатар ажиллаж байсан.



2011.04.07 Төмөрбулаг сумын Залуучуудын холбооны Тамгыг Анхны дарга Б.Хүрэлбаатараас гардан авч байгаа нь.

Сумын залуучууд 2009 оны арванхоёрдугаар сард анхны хуралдаанаа хийж залуучуудын холбооны үйл ажиллагааг дахин сэргээж ажиллахаар шийдвэр гаргасан. Мөн 2011 онд дахин хуралдаж залуучуудын холбооны тэргүүнээр Н.Төмөрхуягийг, нарийн бичгээр А.Лхагвасүрэн нарыг томилж байжээ.

2012 онд Монголын Залуучуудын Холбооны “Тэргүүний малчин залуу”-аар 3-р багийн малчин О.Энхболд, “Хөдөлмөрийн алдар”-аар ХААН банкны эдийн засагч Н.Төмөрхуяг нарыг шагнасан.

2013 онд НАМЗХолбооны “Тэргүүний залуу малчин”-аар 4-р багийн малчин Ц.Пүрэвбат, 3-р багийн малчин Б.Баянмөнх,

“Эх орон таны төлөө” медалиар Эрүүл мэндийн төвийн жолооч Б.Баасанчулуун,

АЗ Холбооны “Тэргүүний залуу” алтан медалиар Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан А.Лхагвасүрэн, бизнесмен Б.Дэлгэрсайхан,

Монголын Залуучуудын Холбооны “Тэргүүний залуу” алтан медалиар Байгаль орчны улсын байцаагч Д.Хишигсайхан, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш Э.Батжаргал нарыг тус тус шагнасан.



2010 оноос хойш Төмөрбулаг сумын залуучуудын холбоо нь тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.



## ДОЛООДУГААР БҮЛЭГ

ТҮҮХ ТОДОТГОХ  
90 АЛДАРТАН

## НАМТАР, ТЭМДЭГЛЭЛ

*“Залуу халуун насанд хүн их хэнэггүй, тэнэг явах юм. Цаг хугацааны эрхээр өөрсдөө нас ахиад ирэхээр тэр гуайг байхад ийм юм, энэ гуайг байхад тийм юм асуугаад авахгүй дээ гэсэн харуусал сэтгэлд үлддэг юм байна” хэмээн Төмөрбулаг сумын Засаг дарга Б.Ганзориг өгүүлж байсан. Тиймээс ч тэрээр түүх тодотгох өвгөд, азай буурлууд, алдартнуудын тухай хөрөг болгон дэлгэрэнгүй бичиж, энэхүү номын хуудаснаа шигтгэж үлдээхийг хүссэн хэрэг. Түүнийг ярьж байх үед “Нээрээ дугараа эргэн тухалдаг найрын ширээний хундага шиг, дутуу орхисон шүлэг бадаг нэхэж зовоох шиг, дурсамж сэдрээсэн дуу нулимс гуйн эгшиглэх шиг доголлон нулимстай хорвоогоос азай буурлууд, алдартан гавьяатнууд маань нэг нэгээрээ одож, бид ч бас тэднийхээ араас алхаж явна даа” гэсэн хөндүүрхэн бодол цээж нухаж байлаа. Тиймээс ч нутгийн сайхан буурлуудын тохойг өргөн мэндчилж, нэр алдраа түүхэнд үлдээсэн алдартнуудын гавьяаг нэхэн санаж, өнгөрсөн он жилүүдийг сөхөн харж, өчигдөр, өнөөдөр, маргаашийн тухай тэмдэглэн үлдээхийг хүсэж, “Түүх бүтээсэн 90 жил” номын хуудаснаа 90 хүний намтрыг дэлгэрэнгүйгээр тэмдэглэн үлдээлээ. Түүхийг ард түмэн зохиодог. Тиймээс ч энэхүү бүлэгт төрийн эрхийг гартаа барьсан ерөнхий сайдаас эхлээд бригадын дарга, багийн ухуулагч, түмэндээ хүндлэгдсэн Хөдөлмөрийн баатрууд, түүхэнд мөнхөрсөн баатарлаг гавьяатнууд, тууварчин малчин, эрдэмтэн доктор, эгэл нэгэн худалдааны ажилтан гээд нийгмийн бүхий л давхаргын хүмүүсийг багтаасан юм. Нэг хүний намтар нэгэн он цагийг өгүүлж, нэгэн хүний амьдрал нэгэн нийгмийн түүхийг тодотгож байгаа. Тийм ч учраас энэ тэмдэглэлд уянгын халил, хэтрүүлэг чимэглэл, уран сайхан үг нэмж хачирлахгүйгээр бичиж үлдээх гэж хичээсэн хэрэг.*

*Б.Цоожчулуунцэцэг*

## МӨНХИЙН ХАРУУЛ

Хөвсгөл аймаг дөрвөн Улсын баатартай. Харин энэ дөрвөн баатрын хоёр нь Төмөрбулаг сумын иргэд. Хотогойдуудын эрх чөлөөний төлөөх тэмцлийг нь зогсоож, зоригийг нь мохоох гэж зовоож, тарчлааж, зовлогыг нь тасдаад ч дийлээгүй тэр л хүмүүс бүгд өнөөдөр түүхийн хуудсанд бараан нэртэйгээ үлдэж. Харин тэмцэж, зүтгэж, ялагдаж явсан ард түмэн өнөөдөр ялан дийлсэн гэдгээ батлан бүрэн бүтнээрээ оршиж байна. Эрх чөлөөний төлөө амиа зольсон хотогойд түмний мянга, мянган хөвгүүдийн нэг нь Улсын баатар Лхүнрэвийн Даваадорж. Энэ нэрийг Хөвсгөлчүүд төдийгүй Монголчууд андахгүй. Саяхныг хүртэл аймгийн төв талбай дээр буугаа мөрөвчлөн, дурангаа барин зогсоо баатар эрийн хөшөө сүндэрлэж, энэ хөшөөний дэргэд бид жагсаж, тоглож, инээж наадаж, дуулж хөгжилдөж явсан. Үнэхээр Л.Даваадорж Хөвсгөлчүүдийн төдийгүй, Монголчуудын баатар нь юм гэдэгтэй хэн ч маргахгүй нь лавтай. Эх орныхоо төлөө амиа өгөх зоригтой хорьхон настай энэ хүү Төмөрбулаг сумын уугуул, Манжийн дарангуйлал, түрэмгийллийг эсэргүүцэж, олон зууны турш эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж явсан хотогойд түмний хүү байсан юм. Түүний тухай Төмөрбулаг сумын уугуул Сосорбарам нэгэнтээ “Даваадорж номхон зантай, илүү дутуу үггүй, хүнд тусархаг, жижигхэн биетэй ч гэсэн их гартаа чадалтай хүү байсан” хэмээн дурсан ярьсан нь бий. Цэрэгт морьдохоор үеийн залуустай бужигнаж, нутгийнхаа ахан дүүсээр бууж, зүүн хацраа үнсүүлээд Цагаан бургасны даваа давсан энэ хүү эргэж ирээгүй ч гэсэн түүх домог болон үлдэж, түмнийхээ сэтгэлд хэзээ ч үл мартагдах дурсамж болон хоцорсон юм. Дөнгөж 20 настай Л.Даваадорж 1946 онд эр цэргийн албанд мордож, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагааны отрядад алба хааж байгаад баруун хилийн байдал хүндрэхэд Ховд аймгийн Алтай сумын Буданчийн хөх толгойн хилийн заставт очжээ. Энэ хугацаанд Л.Даваадорж хэмээх хилчин залуу хөнгөн пулемётын наводчик болжээ. Одоогоос жар гаруй жилийн тэртээ буюу 1948 оны долдугаар сарын 7-нд Байтаг богдын хязгаарын ... дугаар отрядын Байтаг богдын заставын Бүдүүн Харгайтын харуулын постод арван хилчин манаанд гарчээ. Уг тасгийн даргаар тухайн үеийн Увс аймгийн Өлгий сумын уугуул, түрүүч Б.Гиваан томилогдож, бүрэлдэхүүнд нь Ховд аймгийн Чандмань сумын харьяат, хөнгөн пулемётын наводчик Б.Тэгшээ, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын харьяат туслах наводчик Л.Даваадорж, байлдагч Пэлжээ, Чойжин нар багтжээ.

Хилийн тагнуулын албаныхан тэдний байрлах харуулын постын



## УЛСЫН БААТАРЫН АХ ХӨДӨЛМӨРИЙН БААТАР



чиглэлээр дайсны үлэмж хэмжээний хүч цөмөрч болзошгүй гэсэн мэдээлэл өгсөн тул заставын удирдлага харуулыг хүч нэмэгдүүлж, хөнгөн хоёр пулемёттой манаанд гаргасан байв. Түүрүүч Б.Гиваанаар ахлуулсан тасаг цэрэг товлосон хугацаанд хилийн постдоо ирж, Бүдүүн Харгайтын голыг шөнөдөө сэрэмжлэн харж хоножээ. Байтаг богдын хилийн цаад талд хятадын гоминданы морьт хороо, Оспаны толгойлсон Шинжааны хасгийн зэвсэгт дээрэмчид удаа дараа хилд халдаж байгааг манай хилчид сайн мэдэж байсан учир тэдний байрлаж байгаа хэсгээр дайснууд зайлшгүй орж ирнэ гэдгийг тооцоолж байв.

Долдугаар сарын 8-ны өдөр болж үүр манхайн цайж байх үеэр хилчид морь, тэмээнд зэр зэвсгээ ачсан олон тооны дээрэмчид хилээр цөмрөн ирж байгааг мэджээ. Хилчид газрын ашигтай байрлалыг эзлэн дайсныг отсон аж. Бүрэн зэвсэглэсэн 170 гаруй зэвсэгт дээрэмчдийг угтахдаа тэд айгаагүй. Гэвч хүч тэнцвэргүй тулаан дөрвөн цаг гаруй үргэлжилж, цэргүүдийн сум дуусчээ. Тэд сүүлийнхээ гранатыг ч эх орныхоо төлөө, халуун амьтайгаа хамт зориулсан юм. Гар бөмбөгийн дэлбэрэлтийн хонхорхойд дайсны 37 хүний цогцос байсныг тэр тулааны дараа шалгаж явсан албаны хүмүүс тогтоосон байдгийг зарим ном дурдатгалд бичиж үлдээжээ. Харийн 150 гаруй цэрэгтэй есүүлхэнээ амь хайргүй тэмцсэн Баянбалын Тэгшээ, Лхүнрэвийн Даваадорж хоёрт 1949 нэгдүгээр сарын 28-нд БНМАУ-ын баатар цолыг нэхэн олгосон юм. Эх орныхоо төлөө амиа өргөсөн хорьхон настай зоригт хүүг ард түмэн мартаагүй. Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотод 1968 онд түүний хөшөөг босгож, 1998 онд анх алба хааж байсан Сүхбаатар аймаг дахь Эрдэнэцагааны отрядын Тэрэгтийн заставыг Л.Даваадорж баатрын нэрэмжит болгон алдрыг мөнхлөн үлдээжээ. Эх орноо манасан зоригт хилчин өнөөдөр ч үүргээ биелүүлсээр байгаа. Хөвсгөл аймгийн Хил хамгаалах ангийн хашаанд байрлах Л.Даваадоржийн хөшөө Монгол улсын хил халдашгүй дархан юм шүү гэдгийг хойч үедээ ч сануулсаар байгаа.

Анхдагч гэдэг сайхан алдар. Бас их үүрэг хариуцлага. Энэ нэрийг дааж явна гэдэг анхдагч болохоосоо ч хэцүү. Үүнийг анхдагч болсон хүн л ойлгох биз. Чухамдаа л энэ алдар нэрийг даасан шиг дааж, алдар нэрээ түүхийн хуудсанд мөнхлөн үлдээсэн хүн бол Дугарын Дарамжав. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум хоёр Хөдөлмөрийн баатартай. Түүний нэг нь Дугарын Дарамжав. Хамгийн сонирхолтой нь Монголын ууган сангийн аж ахуйн дарга, бас сангийн аж ахуйн дарга нараас анх удаа Хөдөлмөрийн баатар цолоор энгэрээ мялаасан хүн Монгол Улсын баатар Дугарын Гунгаагийн төрсөн ах. Төмөрбулаг сум бахархах олон үйлстэнтэй. Гэхдээ л тус сумын нэг өрх гэрээс Монгол



улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын баатар төрж гарсан ховорхон хувь тавилангаар бүгд бахархдаг. Үнэхээр ч нэг гэрээс улсын хоёр баатар төрж гарсан тохиолдол Монголын түүхэнд ганцхан бий. Улсын баатар дүүтэй, Хөдөлмөрийн баатар энэ хүний төрсөн дүүгийн нь хүүхэд Монгол улсын гавьяат нисгэгч Д.Жаргалсайхан. Ийм л бахархмаар намтар түүхийн эзэн болсон Дугарын Дарамжав Төмөрбулаг суманд 1911 онд төржээ. Тэрээр багадаа гэрийн багшаар бичиг үсэг, дөрвөн аргын тоо заалгаж, хошуу тамгын газарт бичээч, галчаар ажиллаж байжээ. Эрийн цээнд хүрч, 1932 онд цэргийн албанд татагдаж, цэргийн албыг цэргийн нисэх хүчинд хааж, штабын бичээч, салаан дарга хийж, бага дарга, офицерын албан тушаалд дэвшин, дэд хурандаа цолтой болтлоо эх орноо батлан хамгаалах үйлсэд зүтгэж явсан байх юм. Тэрээр Дорнод аймгийн цэргийн ангид 1946 он хүртэл ажиллаж, 1946-1955 онд нисэх отрядад хүчин зүтгэж явжээ. Түүнийг 1955 онд Сөгнөгөрийн амралтын газрын даргаар томилох тушаал гарчээ. Гэвч удалгүй атар газар эзэмших их ажил улс орон даяар өрнөж Д.Дарамжав намын даалгавраар 1956 онд Төв аймгийн Батсүмбэрийн Сангийн аж ахуйн даргаар томилогдон очиж байжээ. Атар газар эзэмших их үйлсэд хүчин зүтгэж, анхны шанг таталцаж явсан энэ хүн Хөдөө аж ахуйн байгууллагын үйлдвэрлэлийг эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлж эдийн засгийн хувьд бэхжүүлэхэд гарамгай гавьяа байгуулсан шилдэг удирдах ажилтнуудын тоонд зүй ёсоор ордог. Нийслэл хотыг хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилготой байгуулагдсан Батсүмбэрийн сангийн аж ахуйг удирдаж, богино хугацаанд Улсын тэргүүний сангийн аж ахуй болгож чадсан. Түүний удирдлаган дор ажиллаж байсан олон хүн амжилтанд хүрч, алдар цолны эзэд болжээ. Монгол улсын анхны

эмэгтэй Хөдөлмөрийн баатар А.Авирмэд, Хөдөлмөрийн баатар ногоочин Д.Долгор, Б.Пүрэв, Б.Должинжав тэргүүтэй алдартнууд Батсүмбэрийн сангийн аж ахуйгаас төрж гарсан бөгөөд Д.Дарамжав Сүхбаатарын одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор хоёр удаа, “Алтан гадас” одонгоор гурван удаа, Хөдөлмөрийн хүндэт медаль, бусад медалиудаар шагнагдаж байжээ. Тэрээр 1965 онд Ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар Хөдөлмөрийн баатар цолыг хүртжээ. Нэгдэл сангийн аж ахуйн дарга нараас анх удаа Хөдөлмөрийн баатар цол авч 45 тоот үнэмлэх гардаж байсан гэдэг. Тухайн үед Монгол улс 45 Хөдөлмөрийн баатартай байсан хэрэг. Тэрээр Батсүмбэрийн сангийн аж ахуйг богино хугацаанд аж ахуйн зохион байгуулалтын хувьд бэхжүүлж, газар тариалан, төмс хүнсний ногоо, мал аж ахуйг хослон эрхлэж, жимс, жимсгэнэ тариалж, гахай, тахиа, зөгийн аж ахуйг амжилттай хөгжүүлж чадсан юм. Энэ хүний амьдралын намтарт анхдагч гэсэн үг олонтоо тааралдана. Тэрээр сангийн аж ахуйд анхны хөдөлмөр амралтын зуслан байгуулж явжээ. Батсүмбэрийн сангийн аж ахуйг 10 жил удирдсан энэ хүн Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн сангийн аж ахуйн даргаар томилогдож, 1975 он хүртэл ажиллажээ. Тэрээр 1975 оноос Сангийн аж ахуйн зөвлөх даргын ажлыг хийж байгаад 1977 онд гавьяаныхаа амралтанд гарсан байна.

Дугарын Дарамжав Төмөрбулаг сумын төдийгүй Хөвсгөл аймгийн анхны баатруудын нэг. Бас сангийн аж ахуйн дарга нараас хамгийн түрүүнд Хөдөлмөрийн баатар цол хүртсэн нэгэн. Төв аймгийн Батсүмбэр, Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн сангийн аж ахуйн даргаар 20-иод жил ажиллаж, бусдыг удирдаж, бас манлайлж, хүнийг урамшуулж чаддаг, хамт олныг нэгтгэж зангидаж сурсан энэ хүний тухай өнөөдөр Сэлэнгэ, Төв аймгийн тариаланчид байнга дурсан ярьдаг юм билээ.



## УУЛЫН БҮРГЭД

**Т**өмөрбулаг сум тэнгэрт ойрхон нутаг. Энэ л нутгаас төрж гарсан зоригтнуудын тухай ярихын тулд МУ-ын баатар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын гавьяат нисгэгч, хошууч генерал Дугарын Гунгаа гэдэг хүний тухай дурсахгүй өнгөрөхийн аргагүй.

“Байлдсан бүхэн баатар болдоггүй” гэсэн гашуун үг бий. Гэвч баатарлаг ард түмний дотроос баатрууд төрж гарсаар л байна. Тэдний нэг нь Дугарын Гунгаа. Түүнийг уулын бүргэд шиг омголон, бас эрэлхэг нэгэн явсныг олон хүн гэрчилнэ. Монгол Улсын Баатар, Монголын Иргэний нисэхийн ерөнхий газрын анхны дарга, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, БНМАУ-ын Гавьяат нисгэгч, хошууч генерал Дугарын Гунгаа 1916 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг, Хаахайн сайр гэдэг газарт төржээ. Ядуу тарчигхан амьдралтай хүү 1937 онд Улаанбаатар хотод ирж, Нисэх бригадын дэргэдэх нисэх сургуульд сурснаар ажил амьдралынхаа гарааг эхлүүлсэн юм. Тэрээр 1958-1959 онд ЗХУ-ын нисэхийн курс төгсөж, Сүхбаатар аймгийн Дарьганга дахь 35 дугаар морьт хорооны цэрэг, бага дарга, 1937 оноос Нисэх сургуульд хэсгийн дарга, 1939 оноос Нисэх I хороонд эскадрилийн дарга, 1942 оноос Нисэх дивизийн III хорооны дарга, 1944 оноос Нисэх II хороонд эскадрилийн дарга, 1945 оноос Нисэх V хороонд нислэгийн туслах, 1947 оноос Нисэх отрядын дарга, 1948 оноос Нисэх V хорооны орлогч дарга, 1953 оноос мөн хорооны нислэгийн орлогч, 1958 оноос Нисэх V отрядын дарга, 1963 оноос Агаарын харилцааны



газарт боловсон хүчний хэлтсийн дарга, 1964 оноос Агаарын харилцааны газрын хөдөлгөөний албанд шалгах группын дарга, 1965 оноос Агаарын харилцааны газар, ИАТУЕГ-ын даргаар тус тус ажиллаж, нисэх хүчин болон Иргэний нисэхийн салбарт өөрийн хүч, авьяас чадвараа зориулсан тус салбарын шилдэг боловсон хүчний нэг, ахмад сурган хүмүүжүүлэгч байлаа. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын унаган хүү Д.Гунгаа 1939 оны Халхын голын байлдаанд отряд командлан оролцож, 1944, 1947 онд баруун хязгаарт болон зэвсэгт тулгаралтын үед Нисэх хүчний командлагч, генерал М.Зайсановын орлогчоор ажиллаж, Гоминданы халдан түрэмгийлэгчид, Оспаны дээрэмчдийг устгахад голлох үүрэг гүйцэтгэсэн. Түүнчлэн 1945 оны Чөлөөлөх дайнд нисэх хороо командлан оролцож байсан түүхтэй.

1939 оны байлдаанд цэл залуухан хүү онгоц хөлөглөн хилийн цаана 60-70 км-ийн тэртээ орших Халуун рашаан, Жанжин сүм, Ламын сүм, Ганжуур сүмд Японы цэргийн бэлтгэл хүчин, агуулах, баазуудыг бут ниргэж явжээ. Зэвсэглэсэн дайсны өөдөөс тэдний эсэргүүцэх галыг сөрөн, шөнийн түнэр харанхуйг туулж, дайсныг дарах хатуу тушаал даалгавар авч байжээ. Энэ даалгаварыг тараар нэр төртэйгээр биелүүлсэн. Дугарын Гунгаа тэргүүтэй манай шөнийн нисгэгчид хоёр сарын хугацаанд 158 удаа байлдааны нислэг хийж, 40 тонн бөмбөг хаяж, дайсанд хүн хүч, зэвсэг техник, эд агуурсын асар их хохирол учруулсан гэдэг. Д.Гунгаа баатар шөнийн цагаар дайсны ар талд бөмбөг хаяж, амь өрсөн байлдааны олон нислэг хийсэн учир “Алтан гадас” одонгоор шагнуулж байжээ. Гэвч амар тайван болоогүй зүүн хилийг агаарын довтолгооноос сэргийлэн хамгаалах зорилгоор 1940 онд Монгол, Зөвлөлтийн хамтарсан 12 онгоцтой агаарын харуулын хэсгийг байгуулахад Д.Гунгаа монгол нисгэгчдээ ахлан оролцож 24 цагаар онгоцтой эргүүл хийж явсан гэдэг. Түүгээр ч зогсохгүй 1941-1945 онд эх орны дайны хүнд хэцүү өдрүүдэд Улаанбаатар хот, Налайх дүүрэг зэрэг аж үйлдвэрийн төвүүдийг агаараас сэргийлэн хамгаалах чухал үүргийг хошууч Д.Гунгаагийн удирдсан сөнөөгч онгоцны хоёрдугаар хороо гүйцэтгэж, байнгын хяналт тавьж, үе, үе жижүүрийн болон эргүүлийн нислэг хийж байжээ. Дайн байлдаанд орж туршлагажсан цэргийн шилдэг нисгэгч Д.Гунгааг 1944 оны хоёрдугаар сард баруун хязгаарын зэвсэгт тулгаралтад оролцуулахаар илгээв. Түүний ахласан баг Ховдын Булган сумын нутаг, Буданчийн хөх толгойд байрлажээ. Гоминданыханд хөөгдсөн Оспаны бүлэг Алтайн их уулсын сархиаг нугачаагаар бүгэж, араас нь мөшгөсөн Гоминданы цэргийн 500-600 хүнтэй хороо Булган голын адагт хуарагнаад байжээ. Асга хадтай өндөр уулс, байц цохио, гүн хавцал бүхий асар их бартаатай тэр нутагт үүрлэсэн дайсныг устгахад зөвхөн онгоц л ашиглах хэрэгтэй байв. Цэргийн хүн тушаал биелүүлэх үүрэгтэй учир Д.Гунгаа гэр орондоо ч дуулгаж амжилгүй тийшээ нисчээ. Дайсны байрлал руу түрүүлж нисэх, эхний бөмбөг хаях амаргүй үүрэг Д.Гунгаа болон бусад хоёр нисгэгчид оногдов. Өмнөөс нь дүрэлзэх шөргөн гал, шүршин тургих суман мөндрийн зай завсрыг олж бөмбөгөө хэрхэн оновчтой хаях вэ гэсэн ганцхан бодол л толгойд эргэлдэж байлаа хэмээн хожим нь Д.Гунгаа гуай дурссан байдаг. Эхний бөмбөг онилсон цэгтээ буулаа. Дараагийнх нь, бас дараагийнх нь ч мөн адил. Дөрвөн өдрийн турш сэхээ чөлөөгүй

үргэлжилсэн байлдаанд ялагдсан гоминдан цэргүүд маш их хохирол амсаж ухрав. Гэтэл дайсны радио холбоо нь ажиллаж мэдээ дамжуулсаар байсан учир түүнийг устгах үүргийг Д.Гунгаад өгчээ. Булган голын дагуу хээр асаасан галаар чиг барин шөнө нисч 1200 метрийн өндрөөс агаарын дайралт хийж, дайснуудыг устгажээ. Энэхүү агаарын довтолгооны талаар Жанжин штабын дарга Рубинд илтгэх үүрэгтэй байжээ. Үүр цайх үеэр цэргийн ангидаа эргэн ирж илтгэхээр очиход жанжин Д.Сүхбаатарын хүү, хурандаа Галсан түүний илтгэлийг штабын дарга Рубинд орчуулж танилцуулаад “Үүрэг сайн биелүүллээ” хэмээн үнэлснийг дуулгав.

...1947 оны 6 дугаар сард Д.Гунгаа дахин баруун хил Байтаг Богдыг зорьж бас л байлдааны үүрэг гүйцэтгэв. Тэрээр Гоминданы цэргийн өдөөн хатгалгыг няцаах, газар орон, дайсны байрлалыг тагнан мэдэх үүрэг хүлээж, хувцсаа ч тайлах завгүй ажиллаж байсан гэдэг. Гадуур хувцастайгаа амарч хоноглон 27-28 өдрийг үджээ. Эцэст нь гурван нөхрийн хамт И-15 онгоцоор Хужирт голд байрласан дайсны байрлалыг бөмбөгдөв. Ийнхүү Алтайн их уулсын дунд, гүн хавцалд байрласан дайсны цэргийн байрлалыг илрүүлж тэрээр өөрт оногдсон үүргээ амжилттай биеүүлсэн юм.

Дугарын Гунгаа байлдааны болон иргэний 10 гаруй төрлийн онгоцоор агаарт түм илүү цаг ниссэн, нэгдүгээр зэргийн багш нисгэгч, цэргийн болон иргэний нисэх байгууллагын бүх шатны албаны (нисэх эскадриль, отряд, хороо, Агаарын харилцааны газар, ИАТУГ гэх мэт) даргын албыг 40 шахам жил хашиж байлаа. Д.Гунгаа энх цагт Монголын Иргэний агаарын тээврийг үүсгэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн учир 1965 онд Монгол Улсын гавьяат нисгэгч цолоор шагнуулжээ. Харин 2009 оны наймдугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигаар ахмад дайчин, гавьяат нисгэгч, хошууч генерал Дугарын Гунгаад “Улсын баатар” цол хүртээсэн юм. Уулын бүргэд хэмээн нэрлэгдэж явсан Д.Гунгаа баатар төрсөн нутаг Төмөрбулаг сумтайгаа байнга холбоотой байсан юм.

## ЭГЭЛ БААТАР ГЭЖ БАЙДАГГҮЙ



**М**онголын баатарлаг охид хөвгүүдийн тухай түүх домог мянга мянган жилээр дуурсагдсаар ирсэн. Харин энх цагт баатарлаг үйлс зөвхөн цэрэг дайны талбараар хязгаарлагдахаа байсан тул 1957 оноос “Хөдөлмөрийн баатар” хэмээх шинэ цол бий болжээ. Гэхдээ энэ агуу хүндэтгэлийг Монголын төрөөс тэглээ баруун солгойгүй цацлаад байдаггүй. Учир нь “Хөдөлмөрийн баатар” гэдэг цолыг олгож эхэлснээс хойш бараг нэгэн жаран өнгөрч байгаа ч Монгол улсад 417 Хөдөлмөрийн баатар төрж гарчээ. Харамсалтай нь хөдөлмөр бүтээлээрээ баатар цолыг хүртсэн 417 хүнээс бидний дунд ердөө л 160 хүн амьдарч байгаа бөгөөд бусад нь бурхны оронд оджээ. Тэдний нэг нь Монгол улсын Хөдөлмөрийн баатар Паньджунай Цагаач. Тэрээр 1942 онд Төмөрбулаг сумын Зөөлөнгийн аманд төржээ. П.Цагаач дөрөвдүгээр анги төгсөөд төрсөн ах П.Лунхааныхаа туслах малчнаар долоон жил ажиллажээ. Түүний төрсөн ах П.Лунхаа аймгийн дөрвөн удаагийн аварга, АИХ-ын депутатаар сонгогдож байсан Төмөрбулаг сумын нэртэй малчдын нэг. Гэвч тэрээр ахынхаа туслах малчнаар долоон жил ажилласны эцэст нэг л өдөр өөрөө суурь дааж авч, мал маллах шийдвэр гаргажээ. Хоёрдугаар бригадад улсын ямааны үржлийн ферм байгуулагдахаас өмнө, хөх ямааны суурийг байгуулаад удаагүй байхад буюу 1976 онд 450 орчим эм ямаа авч маллаж эхэлжээ. Ил шулуухан үгтэй, туйлын хөдөлмөрч энэ хүн малынхаа нутаг бэлчээрийг тун сайн сонгодог, нүүдэл их хийдэг, газар сайн таньдаг хүн байсан гэдэг. Сүү сааль тушаахаас өөр цагт байнга отор нүүдэл хийдэг, сумын дарга нарт олдохгүй нүүж алга болоод байна хэмээн хэл үг ч гаргаж байсан удаатай. Тэрээр 1986 онд 540 эм ямаанаас 612 ишиг бойжуулж, ямаа бүрийн амьдын жинг 60-67 кг-д хүргэж, дээд амжилт тогтоон Улсын ашиг шимийн аварга цол хүртэж, 1988 онд хошой аварга болж байсан түүхтэй. П.Цагаач 1991 онд Хөдөлмөрийн баатар цол хүртсэн юм. Гэхдээ энэ цол түүнд зүгээр ч нэг олдсонгүй. Хөдөлмөрийн баатарт тодорхойлсны дараа түүний талаар таагүй мэдээлэл очиж, “Архи уудаг, авгай хүүхдээ сольсон” гэдэг матаас бичиг дээд газарт иржээ. Энэ мэдээлэл очсны дараа Монголын радиогийн сэтгүүлч, олноо “радиогийн зөөлөн дуут” гэж нэрлэгдсэн Энхтуяа, Төв хорооны шалгалтынхантай хамт Төмөрбулаг суманд очжээ. Тэд П.Цагаачтай уулзаж, нутаг орны хүмүүстэй ярилцаж, “Хоёр эхнэр авсан, архи дарс уудаг” гэсэн ор үндэсгүй мэдээлэл явуулсан



гэдгийг тогтоож, улсын хошой аварга П.Цагаачийн тухай радиогийн хөрөг нэвтрүүлэг хийгээд буцжээ. Энэ шалгалтын дараа 1991 онд Улсын их баяр наадмын өглөө түүнд Хөдөлмөрийн баатар цол олгосныг радиогоор зарлаж, Нарийны голд морь уяж явсан П.Цагаач энэ мэдээг сонсож байсан гэдэг. П.Цагаач гуай малаа сайн таргалуулдаг, тиймээс мал ч жилбэ сайтай төллөдөг байсан. Гэхдээ л 100 ямаанаас 140 төл хүлээж авна гэдэг Монгол улсад рекорд амжилт шүү хэмээн нутгийн зон олон өнөөдөр ч бахархан ярьж байна. Сумын заан цолтой, барилдах дуртай, ан ав сайн хийдэг байсан энэ хүний талаар хөнгөн цайлган сэтгэлтэй их шударга, бусдад тусархуу хүн байсан гэж дурсах хүмүүс олон. П.Цагаач баатрынх зургаан хүүхэдтэй. Хэдийгээр олон малтай, ажил ихтэй хүнд хэцүү байсан ч тэрээр хүүхдүүдээ сургууль соёлоос хөндийрүүлж байсангүй. Өнөөдөр П.Цагаач баатар бидний дунд алга. Гэхдээ эцэг өвгөдөөс уламжилсан мал маллах арга ухаан үр хүүхдүүдэд нь өвлөгдөн үлдэж, Хөдөлмөрийн баатар ямаачны дөрвөн хүү дөрвүүлээ мал маллаж, хоёр хүү нь мянгат малчин болжээ. П.Цагаач баатрыг эглээс эгэл нэгэн байсан гэж олон хүн өгүүлж байсан. Гэхдээ л эгэл баатар гэж байдаггүй. Баатар цолыг хэн дуртай хүн нь хүртдэггүй. Энх цагийн баатрууд энэ цолыг хүртэхийн тулд асар их хөдөлмөр хөлсөө зарцуулж явсан гэдэгтэй хэн ч маргахгүй нь лавтай. Өмч хувьчлал болж, хүн бүр л тэдний ямааг авах гэж сонирхож байх үед тэрээр “Би задарсанд нь бус ядарсанд нь малаа өгнө” хэмээн олны салхийг сөрж, 13 хүүхэдтэй айлд үр хүүхэд шиг л хайрлаж, хамгаалж өсгөсөн малаа өгч байсан гэдэг. Нутаг орноо гэх халуун сэтгэлтэй энэ хүн 1990-ээд оноос хойш эмх замбараагүй, энэрэх сэтгэлгүйгээр ан авд хорхойсч байсан анчидтай ширүүхэн үзэлцэж, хангай дэлхий, ан амьтнаа өмөөрөн боссон цөөхөн хүмүүсийн нэг байсан гэдэг.



## ХОВОР САНААНЫ ЭЗЭН

Хүний хүсэл мөрөөдөл шал эсрэгээрээ эргэсэн ч гэлээ онох нь бий. Сэтгүүлч болохоор шийдсэн хүү хүчээр шахам эм зүйчийн ангид ороод бараг л орхиж зугтах нь халаг болж байсан бол өдгөө “Салимон”, “Биомон” зэрэг эм, гоо сайхны бэлдмэлүүдийн жорыг зохион бүтээж, эм зүйн салбарын тэргүүлэгч бизнесмэн болсон төдийгүй Монгол улсын Төрийн соёрхол хүртсэн нэртэй эрдэмтэн болж чаджээ. “Монос групп”-ын ерөнхийлөгч Хүрэлбаатар 1952 онд Лувсангийн ууган хүү болон төржээ. Түүний аав Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Бүгдгээний голын хүн. Хөдөө төрж, захын хороололд өссөн хүү нарийн мэргэжил эзэмшиж, хэн хүн хүрээд байхааргүй өндөр оргилд гарсан ч гэлээ социалист нийгэмд “эсэргүү” хэмээн адлагдаж, улсын ажлыг дэндүү өөриймсөг хийж, амьдралыг туулсан гээд хэдэн боть романы баатар шиг л арвин түүх цуглуулжээ. Т.Эдисоныг биширч явдаг энэ эрхэм Монголын бизнесмэнүүд дотроос арай л өөр. Өөрийнхөө жороор эм барьж, валют урсган бүсгүйчүүдийн нүүрэнд түрхэгддэг оо энгэсгийг Монгол газрын “ориг” түүхий эдээр, байгаль цаг уурын онцлогт тохируулан хийж чаддаг гээд энэ хүний дотор эрдэмтэн, бизнесмэн хоёр зэрэгцэн оршдог. Тэр “онц” сурдаг байсан бөгөөд 9-р ангиаа эхлэн сэтгүүлч болох хүсэлд автан “Пионерийн үнэн” сонинд шүлэг, өгүүлэг бичин нийтлүүлдэг байлаа. 1970 онд 10-р ангиа алтан медальтай төгссөн боловч сэтгүүлчийн ангийнх нь хуваарийг өөр хүүхдэд өгчихжээ. Уг нь “Пионерийн үнэн” сониноос түүний нэрийг сэтгүүлчийн ангид оруулахаар заачихсан байсан боловч эрх мэдэлтэй хүний хүүхдэд тэр хуваарь нь оногдсон гэдэг. Түүнд ЗХУ-ын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн анги оногдсон боловч тэр дургүйцлээ. Ээж нь ятгаснаар сургуульдаа очсон боловч Москвагаас уг сургуульд энэ жил хүн авахгүй гэсэн учраас Пятигорскийн АУДС-ийн Эм зүйчийн ангид орохоор болов. Анагаахын сургуульд очоод мэргэжлийнхээ хичээлийг бус Оросын сонгодгуудыг

уншчихаад сургуулиа орхихоор шийджээ. Москва дахь ЭСЯ-даа очиж сургуулиасаа гарах хүсэлтэйгээ хэлтэл “онц” сурдаг учраас халгаасангүй. Элчингийн Энэбиш гэдэг хүн сайтар ухуулсанаар сургуульдаа буцаж очив. Ийм л адал явдалтайгаар тэр сургуулиа төгсчээ. Тэрээр 1975 онд сургуулиа төгсч ирэн Ардын эмнэлэгийн хүрээлэнд ажиллаж байгаад Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад томилогдсон гэдэг. 1978 онд хөдөөнөөс ирж Анагаах ухааны хүрээлэнд ажиллаж байхдаа Ардын хувьсгалын 60 жилийн ойд зориулж “Үнэн” сониноос зарласан найруулын уралдаанд оролцож хоёрдугаар байрт шалгарчээ. Үүнийг мэдсэн дарга нар нь Л.Хүрэлбаатарыг Эрүүл мэндийн нэгдсэн редакцид редактораар томилжээ. Сэтгүүлч болохыг багаасаа мөрөөдөж байсан залуу харин мэргэшсэн ажлаасаа салахыг хүсэхгүй байв. Гэлээ гээд яахав “үгүй” гэх эрхгүйгээс хойш ажиллахаар болжээ. Удалгүй тэрээр мэргэжлээрээ эрдмийн ажил ч хийж эхэллээ. Хөвсгөлд ажиллаж байсан үеэсээ ургамлын нөөц, бүтэц судлаж эхэлсэн ч орхисонгүй. Анх 1978 онд буюу одоогоос 30 гаруй жилийн тэртээ Л.Хүрэлбаатар доктор Хөвсгөл нутагтаа Эмийн үйлдвэрийн харьяа “Гален” цех байгуулсан нь олон мянган хүнд үр өгөөжөө өгсөн юм. 1990 онд Латвид эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавиад иртэл түүний нэрийг Эмийн сангуудыг удирдах конторын даргад дэвшүүлчихсэн байжээ. Мань эр дахиад л эсэргүүцсэн боловч гурван хүнтэй өрсөлдүүлээд 98 хувиар ялах нь тэр. Улаанбаатар хотын 51 эмийн сантай, 800 эм зүйчтэй том байгууллага удирдаж явсан Хүрлээ доктор 1990 оны 5-р сард эмийн жижиг үйлдвэр байгуулж болно гэсэн хууль гарсаныг тэр баяртайгаар хүлээж авсан юм. Тэр хувийн эмийн үйлдвэр байгуулахаар шийдэж өргөдлөө өгөөд байтал ЭМЯ-ны сайд П.Нямдаваа “Эмимпекс концерн”-ы захирал бол гэдэг тушаал өгчээ. Тэрээр энэ байгууллагад очиж жил шахам ажиллаад өөрийн хүсэлтээр гарчээ. Л.Хүрэлбаатар захиралтай “Монос” группын хөгжлийн түүх эндээс эхлэсэн гэхэд болно. “Темп” гэдэг өнгөт зурагтаа 4000 төгрөгөөр зарж, үйлдвэрийнхээ анхны санхүүгийн эх үүсвэрийг босгосон Л.Хүрэлбаатар захирал ургамал түүж, таван салаа хатааж, ургамал хандалдаг машиныг өөрөө гарын дор материал ашиглан зохион бүтээж, шүдний клиникийн эмнэлэг дээр өрөө түрээслэн эмийн сан нээж байсан түүхтэй. Түүний бизнес өргөжин тэлсээр 2004 оноос “Монос Групп” болон өргөжиж “Монос Холдинг” ХХК, “Монос Фарм” ХХК, “Монос Косметик” ХХК, “Монос Фарм трейд” ХХК, “Монос Улаанбаатар”, “Монос Хаусхолд” ХХК, “Монос Хүнс” ХХК, “Монос” Дээд Сургууль, Эм судлалын хүрээлэн, “Монос Констракшн” ХХК, “Монос Дэлгэрэх” ХЗХ зэрэг 10 охин компанитай улс орныг хамарсан өргөн сүлжээг бүрдүүлж чадсан мэргэжлийн өндөр ур чадвартай менежментийн баг өнөөдөр ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд “Монос” групп нь эм, гоо сайхан, эрүүл мэндийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, судалгаа шинжилгээ, боловсрол үйлчилгээний салбарыг хамарсан үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн салбарын тэргүүлэгч, Монгол улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн нэг болж чадсан юм. Эмийн хажуугаар гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд анхны бэлэн бүтээгдэхүүн нь “Булга”, “Марал” зэрэг нүүрний тоснууд байв. Л.Хүрэлбаатар доктор, профессор 400 гаруй шинэ санаа гаргасан. Өөрөөр хэлбэл түүний нэр дээр



патенттай 400 бүтээл байдаг гэсэн үг. Бидний сайн мэдэх, өргөн хэрэглэдэг “Читамон”, “Эрвилкор”, “Дентамон”, “Натурвит”, “Салимон” зэрэг 15 нэр төрлийн эм, гоо сайхны “Биомон” иж бүрдэл зэргийг бий болгож Монгол улсын Төрийн соёрхол хүртжээ. Шинэсэрхүү бударганаар хийсэн “Салимон” хэмээх бэлдмэл, олон төрлийн цайнууд гээд түүний бүтээсэн бүхнийг дурьдаад байвал барагдахгүй. Эм зохион бүтээнэ гэдэг хэн хүний санаанд багтаад байхааргүй ажил. Асар их туршлага, судлагаа, бас туршилт хэрэгтэй. Гэхдээ тэрээр шантраагүй. Өдгөө ОХУ-д “Монос Фарма Россия” нэртэй хамтарсан компани байгуулж, ажиллахын сацуу нийт 10 орчим сая ам.долларын өртөг бүхий, олон улсын стандартад нийцсэн эмийн үйлдвэр барих том төслийг тэрээр эхлүүлээд

байна.

Монгол улсын төрийн соёрхолт доктор, профессор Л.Хүрэлбаатар нутаг орныхондоо ч халуун дулаан сэтгэлээр хандаж, тусламж дэмжлэгийн гараа харамгүй сунгадаг. Одоогоос хэдэн жилийн өмнө “Төмөрбулагчууд ямаагаа сайн өсгөж байна. Гэхдээ үүний зэрэгцээ газар тариалангаас ч бас ашиг олох хэрэгтэй. Би нутгийнхандаа 20.000 чацарганы мод өгнө” хэмээн ярьж байсан. Үүнээс хойш хэдхэн хоногийн дараа Л.Хүрэлбаатар захирал чацарганы 20.000 суулгац, модыг арчилах зааварчлага, зөвлөгөө өгөх хүнтэй нь хамт Төмөрбулаг сум руу илгээсэн байж билээ. Өнөөдөр Хүрлээ захирлын бэлэглэсэн 20.000 чацарганы бут Жаргалантын голын хөвөөнөө найгаж байгаа. Улаанбаатарт эмийн ургамлын цэцэрлэг байгуулж, олон зуун ургамал суулгаж тарималжуулсан энэ эр Энэтхэг, Болгар, Италид ургадаг гоё ургамлуудыг хүртэл тариалсан нь сайхан ургажээ.

Үргэлж шинийг санаачилж, басхүү санаачилсан зүйлүүдээ бодит бүтээл болгож чаддаг энэ эрхэм тун шаггүй зохиолч. Монгол улсын төрийн шагналт, академич Л.Хүрэлбаатар сурах бичиг, гарын авлага, судалгаа шинжилгээний нийт 11 ном монгол, орос хэл дээр туурвин, хэвлүүлсэн бөгөөд түүний “Шаргал навчис” нэртэй шүлгийн түүвэр ч олны анхаарлыг татаж чадсан юм.



## ТҮҮХЭНД ҮЛДЭХ ХҮН

Монгол улсын 25 дахь Ерөнхий сайд Санжаагийн Баяр. Хотогойд түмний дундаас төрсөн олон арван сод хөвгүүдийн нэг энэ эрхмийн тухай өгүүлэхийн тулд нялуун үг, гоё сайхан магтаал хэрэггүй. Хатуу чанга гэмээр арга барил, ил шулуун үгтэй энэ улс төрч бусдад ая тал олох гэж хуурамч инээмсэглэл нүүрэндээ зүүж, бусдаас айж хулчийж, хэлэх гэсэн үгээ битүү залгих зан үгүй. Аав нь түүхч хүн байсан бол, ээж загас судлаач. Түүний аав Санжаа Төмөрбулаг сумаас төрсөн, Монголын ууган түүхчдийн нэг. Ээж А.Дулмаа нь Монголд анхны “Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төв”-ийг байгуулсан бөгөөд насаараа энэ үйлсэд зүтгэсэн эрдэмтэн. Санжаа гуайн аав монгол, төвд, самгарьд гурван хэл мэддэг, тухайн үедээ боловсролтой, бас л олон түмнээ гэсэн сэтгэлтэй нэгэн явжээ. Гэвч бас л хэлмэгдүүлэлтэнд өртөж байсан гэнэ. Дулмаа доктор Байгалаас Хөвсгөл нууранд омуль загас аваачиж нутагшуулж байх үед С.Баяр төржээ. Тиймээс ч “Миний хүү Монголын омультай чацуу юм шүү” гэж хүүдээ хэлдэг байжээ. Одоогийнхоор Мобикомын төв оффисын арын орос цэцэрлэгт хүмүүжсэн түүнийг аав ээж нь эмээд нь даатган эрдэм номын мөр хөөхөөр Оросыг зорьжээ. С.Баярын ээжийнх нь ээж 1920-иод онд нөхөр Аюурзанын Аюурын хамт Оросын буриадаас орж ирсэн Маньдарь гэх өндөр боловсролтой нэгэн байв. Түүний өвөө ХААЯ-нд газар тариалан эрхэлсэн түшмэлийн алба хашиж байгаад 1937



оны хэлмэгдүүлтэнд өртөн амиа алджээ. Хаант Орост гимнази дүүргэсэн тухайн үедээ өндөр боловсролтой эмээгээрээ үлгэр уншуулж өссөн ирээдүйн ерөнхий сайд эмээгээсээ өөр хүний гарын хоол амсдаггүй танхи хүү байсан гэдэг. Монголын хоёр том сэхээтний гэрт өсөж торнисон С.Баяр нийслэлийн Орос 10 жилийн дунд сургууль төгсөж, Москвагийн Ломоносовын нэрэмжит их сургуульд суралцан дүүргэж, хуульч мэргэжил эзэмшсэн. Сургууль төгсөөд хотын захиргаанд мэргэжилтнээр ажилласнаар хөдөлмөрийн гараагаа эхэлж, 1979-1983 онд зэвсэгт хүчний жанжин штабт офицер, 1983-1988 онд МОНЦАМЭ агентлагт редактор, ерөнхий редактор, 1988-1990 онд Монголын радио Телевизийн Улсын Хорооны орлогч дарга, 1990 онд БНМАУ-ын бага хурлын гишүүнээр сонгогдон, төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ажиллаж байв. Тэрээр 33 настай, Улсын бага хурлын гишүүнээр сонгогдож, Монголын шинэ үндсэн хуулийг батлаж явсан байнгын ажиллагаатай анхны парламентийн гишүүн. С.Баяр 1992 оноос төр нийгэм судлалын академид багш, АНУ-ын Вашингтоны их сургуульд судлаач, Батлан хамгаалах яаманд стратеги судалгааны хүрээлэнгийн захирал, 1997-2001 онд Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга, 2001-2004 онд Монгол улсаас ОХУ-д суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар ажиллаж байлаа. С.Баярыг ОХУ-д элчин сайдаар сууж байх үед их өрийг тэглэж, Орос Монгол хоёр улсын харилцаанд суусан сэв арилж байсан удаатай.

2005 оноос МАХН-ын ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдож мөн оны арваннэгдүгээр сард МУ-ын 25 дахь Ерөнхий сайдаар томилогдсон. МАХН-ыг 2008 оны сонгуульд удирдаж орсон С.Баяр ялалт байгуулж, 2008 оны 9 сарын 11-ний өдөр УИХ-ын гишүүдийн 98.5 хувийн саналаар Монгол Улсын ерөнхий сайдаар дахин томилогдож байлаа. Хэдийгээр МАХН дангаараа засгийн эрх барихад хангалттай тооны суудал авсан ч С.Баяр Ардчилсан Намтай хамтарсан засгийн газар байгуулах шийдвэр гаргасан. Ялсан намын гишүүдийнхээ алба, амин хувийн асар том ашиг сонирхолын зөрчлийг нам дарж, Хамтарсан Засгийн газар байгуулах зоримог гэмээр түүний шийдвэр олон хүний бухимдал, бас эгдүүцэл дургүйцлийг хүргэж байсан түүхтэй. Гэвч С.Баяр эргэж буцаагүй. Монгол Улсын Ерөнхий сайдаар хоёр дахь удаагаа томилогдсон С.Баяр “Атрын гурав дахь” аяныг эхлүүлсэн. Элгээрээ хэвтээд байсан Монголын газар тариалан түүний үед сэргэж, Монголчууд сүүлийн 20 жил тарьж чадаагүйгээ тарьж, хурааж чадаагүй их ургацаа хурааж авч байсан түүхтэй. Мөн улс төрчдийн хэрүүлийн алим болон өнхөрч байсан Оюутолгойн гэрээг эцэслэж, монголчууд анх удаа “Эх орны хишиг” хүртэж, энэ улсын эзэн нь юм шүү гэдгээ бодит байдлаар мэдэрч чадсан. С.Баяр харин өөрийнхөө Засгийн газрын үйл ажиллагааг арай өөрөөр үнэлдэг. Тэрээр “Манай Засгийн газрын гол гавьяа бол Хамтарсан Засгийн газар байгуулж, хоёр намд хуваагдан хагарч бутрах дээрээ тулаад байсан олон хүнийг нэгтгэж чадсанд л оршдог” хэмээн ил тод хэлж байсан удаатай. Гэсэн ч С.Баярын Засгийн газрын үед уул уурхай сэргэж, гадаадын хөрөнгө оруулалтууд орж ирж, Монголын эдийн засаг өмнө нь хүрч чадаагүй тэр л оргилдоо хүрч байсныг хэн бүхэн мэднэ. С.Баяр нутаг орныхоо төлөө гэх халуун дулаан сэтгэлээр хандаж, Хөвсгөл аймагт ч, аавынхаа төрсөн нутаг Төмөрбулаг суманд ч олон зүйл хийж байсныг Төмөрбулагчууд бүгд мэддэг. Нэгэнтээ сэтгүүлчид түүнийг “Богинохон нэртэй, урт түүхтэй хүн” гэж тодорхойлсон нь бий. Монголын түүхэнд үлдэх том улс төрчийн түүх ч бас үргэлжилж байна.

## ТҮҮХ БҮТЭЭСЭН ТҮҮХЧ



**М**иний аав Лувсангийн Санжаа гэж түүхч, эрдэмтэн хүн байсан. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул. Намайг арван гуравтай байхад бурхан болсон. Нас ахих тусам аавын надад ярьсан, дурссан болгон бүдгэрч мартагдах биш, улам л тод томруун болоод байгаа юм шиг санагдах юм. Аав минь нутаг усандаа нэртэй нэгэн том ламын отгон хүү нь байсан юм билээ. Аав багадаа сургуулиасаа оргож яваад хээр осгох дөхсөн тухай, сайн багшийн буянаар номд сонирхолтой болсон тухай, дэлхийн дайны үед ЗХУ-д цэргийн сургуульд суралцаж байхдаа баривчлагдсан германчуудыг Москвагийн гудамжаар туухад харуулд гарч байсан тухай, дараа нь цэргээс халагдаж МУИС-д оюутан болж түүх сонирхох болсон тухайгаа ярьж байсан нь санагддаг. МУИС-д багш байхдаа,

гучин нас гарч байж гэрлэсэн юм билээ. Архи, тамхи огт хэрэглэдэггүй, эрүүл чийрэг хүн байсан хэрнээ залуугаараа өөд болсон доо” хэмээн Монгол улсын Ерөнхий сайд асан С.Баяр аавынхаа тухай дурсан ярьжээ. Монгол улсын 25 дахь Ерөнхий сайдын аавынхаа тухай өгүүлсэн энэ богинохон дурсамж Лувсангийн Санжаа хэмээх эгэлгүй нэгэн эрдэмтний намтар түүхийг тодотгож өгнө. Төмөрбулаг сумын эрдэмтэн мэргэдийн их өлгий болсон Бүгсийн хүрээнээс төрсөн алдартнуудын нэг нь Л.Санжаа. Уг нь Л.Санжаа гуайн эцгийн бүтэн нэр нь Лувсаннямжамц гэдэг байсан хэмээн зохиолч Ж.Үржгэр бичиж үлдээжээ. Тухайн үедээ олонд нэртэй хувилгаан, ном ихт гүрэмч хүн байсан учраас тэрээр хүүгээ эрдэм номтой хүн болгохыг хүсэж хүрээ хийд бараадуулж байсан хэрэг. Гэвч цаг өөрчлөгдөж, Л.Санжаа тэнхимийн сургалтаар анхныхаа боловсролыг эзэмшжээ. Хүрээ хийдээс оргож явсан Л.Санжаа гуай эх орны дайны үед Москвад цэргийн дунд сургуульд сурч байжээ. Цаг хүнд тэр үед Санжаа гуай нутагтаа ирж холбоочноор ажиллаж байгаад Их сургуулийн түүхийн анги төгсч, сургуульдаа багшаар үлдсэн гэдэг. Түүхийн багш мэргэжил эзэмшин, улмаар түүхийн шинжлэх ухааны эрдэмтэн болтлоо хөдөлмөрлөсөн, Монголын томоохон сэхээтэн байсан юм.МУИС-ийг түүхийн багш мэргэжлээр улаан дипломтой төгссөн энэ хүн МУИС-даа багшаар үлдэн ажиллаж байгаад МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институтэд шилжин ирж олон жил багшлах хугацаандаа ЗХУ-д түүхийн ухааны Дэд эрдэмтний

зэрэг хамгаалж, улмаар МАХН-ын түүхийг иж бүрнээр нь бүтээн туурвихад доривтой хувь нэмрээ оруулсан ахмад эрдэмтдийн нэг. Басхүү Монголын ууган эрдэмтэн гэж хэлэхэд буруудахгүй. Тэрээр Марксист Ленинист онолын үндсэн дээр МАХН-ын хувьсгалт үзэл суртал бүрэлдэн хөгжсөн нь сэдвээр 1961 онд боловсролдын докторын зэрэг хамгаалж байжээ. Эрдэм шинжилгээний олон арван бүтээл тууривсан энэ эрдэмтэн 30 гаруй ном бүтээж, олон мянган шавь нартай явсан эрдэмтэн багш.

Л.Санжаа гуайн тухай “Аливаа зүйлд нягт нямбай, эргэж буцах зангүй, илүү дутуу үгүй, ёстой л за гэвэл ёогүй хүн байсан” хэмээн найз нөхөд нь дурсан өгүүлсэн нь бий. Түүний хань ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төвийн судлаач, академич, шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор, профессор Аюурын Дулмаа гуайг мэдэхгүй, танихгүй хүн ховор биз ээ. Түүнийг Ерөнхий сайд С.Баярын ээж гэдгээс нь илүү “загасны” Дулмаа гэдгээр нь Монголчууд андахгүй. Шинжлэх ухаанд 50 гаруй жил чин сэтгэлээр зүтгэж яваа А.Дулмаа гуай нийт загасгүй байсан 25 нуурыг загастай болгосон хүн. Голдуу оморь, цагаан зарам буюу пельд загас үржүүлдэг энэ эрдэмтэн дунд сургуулийн зургадугаар ангиас шууд л МУИС-д элсэн суралцаж байсан юм байна.

Тэрээр Сүхбаатарын нэрэмжит II арван жилийн дунд сургуульд сурч байхдаа Их сургуульд шалгалт өгч орсон. Их сургуульд дөрвөн жил сураад, 19 настай хүүхэд Багшийн дээд сургуульд багшлахаар очиж байсан гэдэг. Төмөрбулагчууд төдийгүй Монгол түмний бахархал болсон ийм л хоёр том эрдэмтний гэрт Монгол Улсын 25 дахь Ерөнхий сайд Санжаагийн Баяр төрсөн юм.

## МОНГОЛ КАРМЕН



Эрх чөлөөт, үзэсгэлэнт цыган хүүхэн, гал халуун хайр дурлалын бэлгэдэл Кармен, түүний дүрэлзсэн хайр сэтгэл, эмгэнэлт хувь заяа. Зүрх сэтгэлийг хөндөж, гуниг харуусал, басхүү баяр баяслыг нэгэн дор нэгтгэх дэлхийд зартай Кармен дуурь, соёлт хүн бүхний мэдэх болсон удиртгал хөгжим, “Тореадорийн дуу”, “Хабанера”, “Цэцгийн дуу” зэрэг шилдэг шигтгээ болсон аянуудаар баялаг энэ дуурь 1875 оны гуравдугаар сард Францын театрт анх тавигдсан хэдий ч зуун зуун жилийг эзэгнэж, өнөөдөр ч хүмүүсийн сэтгэлийг эзэмдсээр байна. Жорж Бизегийн энэ алдарт жүжгийг Монголчууд 1984 оны дөрөвдүгээр сарын 5-нд анх тайзнаа тавьж байжээ. Гэхдээ гол дүрийг Дуурийн театрийн үе үеийн уран бүтээлчид амилуулж байсан

ч Монголын үзэгчдийн зүрх сэтгэл, ой ухаанд хэзээ ч мартагдашгүйгээр үлдээж чадсан хүн бол яах аргагүй Ч.Мөнхшүр. Бүхий л насаа урлагтай холбож яваа эрхэмсэг, тансаг, басхүү эгэлгүй энэ уран бүтээлч Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын харьяат. Түүний ээж Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул. Тиймээс Ч.Мөнхшүр ч гэсэн энэ л нутаг устай халуун сэтгэл, дулаан итгэлээрээ үргэлж холбоотой явдаг. Тэрээр 1965-1967 онд Хөнгөн үйлдвэрийн ТМС төгсөж, ажлын гараагаа эхэлжээ. Гэвч зүрх сэтгэлээ урлагт өгсөн жаахан охины мөрөөдөл тэс өөр байлаа. Багадаа дүү нартайгаа эгнэж зогсоод аавынхаа удирдлага дор найрал дуу дуулдаг байсан охин урлаг руу тэмүүлж, ЦДБЭЧ-д анх хөтлөгчөөр орж байсан гэдэг. Гэвч хөтлөгч бүсгүй нэг өдөр үл таних бүсгүйтэй таарч. “Наашаа хүрээд ир. Чи бүжигчин болно” гэж хэлсэн тэр өдрөөс хойш Ч.Мөнхшүр гэдэг хүний амьдрал урлагтай салшгүй холбогджээ. “Чи бүжигчин болно” гэж эгээ л барин тавин хэлсэн тэр хүн ямар нэг хувь тавиланг өөрчлөгч үзмэрч бус, харин бүжиг дэглээч, Ардын жүжигчин Долгорсүрэн гуай байсан гэнэ. Гурван сар бүжиг заалгаад л “мэргэжлийн бүжигчин” гэдэг үнэмлэх авсан охин ЦДБЭЧ-д бүжигчнээр ажиллаж байгаад 1976 онд ОХУ-ын Санкт-Петербург хотын хөгжмийн дээд сургуульд элсэн оржээ. ОХУ-ын Ленинградын хөгжмийн дээд сургуулийг 1981 онд төгсөж ирээд тэрээр Сонгодог урлагтай амьдралаа холбосон юм. Түүнийг Дуурийн театрт замчилсан хүн бол Санкт-Петербург хотын хөгжмийн дээд сургуулийн багш нар, бас МУ-ын ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар Хайдав гуай. Санкт-Петербург хотын хөгжмийн дээд сургуулийн өмнө байрлах Зировын театрт суугаад “Кармен” дуурьт дуулахыг мөрөөдөж байсан залуухан дуучин Монголын сонгодог урлагын тайзнаа анх “Чоно ба долоон ишиг”

дуурийн эх ямааны дүрийг бүтээж, Монголын сонгодог урлагт хөл тавьсан түүхтэй. Тэр мөрөөдлөө биелүүлсэн. “Кармен”д тоглож байна гэж олон жил мөрөөдөж, төсөөлсөн болохоор тэр “Кармен”-ы дүрийг Монголчуудын сэтгэлд буутал амилуулж, өдгөө ч “Монгол Кармен” хэмээн нэрлэгдэж яваа. “Евгений Онегин”-ы Ольга, “Чио Чио сан” дуурийн Сузуки, “Риголетто” дуурийг Чепрона, “Учиртай гурван толгой” дуурийн Хоролмаа, “Чингис хаан” дуурийн Өүлэн эх гээд Монголын сонгодог урлагын тайзнаа 40-өөд гол ба туслах дүрд тоглосон энэ хатагтайг “Тагтаа” дуугаар Монголчууд андахгүй.



Монгол даяар нэр алдраа цуурайтуулж явсан дуучин бүсгүй өдгөө 60 насны босго алхсан ч гэсэн цэл залуухнаараа... Чинзаяагийн Мөнхшүр 1996 онд СТА цол, 1998 онд УГЖ, 2006 онд Ардын жүжигчин цол хүртсэн юм. Төмөрбулагийн дууч охин түмэндээ хүндлэгдсэн Ардын жүжигчин маань эдүгээ ч гэсэн Монголын урлагт өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж, шавь нараараа хүрээлүүлэн, багш хэмээх эрхэм цолоор дуудуулж явна.



## ТЭНГЭРТ ӨДЛӨСӨН БҮРГЭД

**А**мьдрал гэдэг амар сайхандаа жаргадаг үлгэр биш. Амьдрал ашид үргэлжилдэг төгсгөл үгүй үлгэр гэдэгт би итгэдэг. Амьдралыг би асар том модтой зүйрлэн боддог. Энэ модны нэгээхэн мөчир дээр нахиалсан навч нар салхи, хур борооны аясаар элэгдэж, гандаж, унаж гэмээнэ дахиад л шинэ навч ургадаг. Энэ бол яг л хүмүүний амьдралын ёс юм. Хүний амьдралд төгсгөл гэж үгүй. Хэдийгээр хүн үрэгдэж алга боллоо ч түүний бүтээсэн түүх үргэлжилж, түүний эхлүүлсэн тэр түүхийг үр хүүхэд нь үргэлжлүүлдэг. Дэндүү гэгээн, бас зарим хүнд хэтэрхий омголон, романтик мэт санагдах энэхүү бодолдоо би итгэдэг. Итгэхээс ч өөр аргагүй юм. Төмөрбулаг сумын уугуул Улсын баатар, Ахмад дайчин, гавьяат нисгэгч, хошууч генерал Дугарын Гунгаа агсны хүү Монгол Улсын гавьяат нисгэгч Гунгаагийн Жаргалсайханы түүх намтар миний энэхүү омголон бодлыг эсэргүүцэх хэн нэгэнд хариулт өгнө гэдэгт итгэж байна.

Түүний аав Д.Гунгаа агаарт 16 мянган цаг ниссэн. Халхын голд шөнийн нислэг хийж, харийн дээрэмчидтэй тулалдаж, 1945 оны чөлөөлөх дайнд нисэх хороог командлан оролцож, Байтаг Богдын зэвсэгт мөргөлдөөнд эх орноо өмгөөлөн нисэж явсан хүн. Д.Гунгаа баатар гавьяат нисгэгч хэмээх эрхэм цолыг нисгэгч нараас хамгийн түрүүнд хүртсэн. Тэгвэл түүний гэрт бас л Монголын нисэх хүчний түүхийг бичилцэх гавьяатай нисгэгч төржээ. Энэ бол түүний хүү Гунгаагийн Жаргалсайхан байлаа. Нисэхийн дэнж, Буянт-Ухаад бага насаа өнгөрөөж, ирж буцах онгоц харж, тэнгэрт нисэж яваа аавыгаа хүлээж явсан жаахан хүү нисгэгч болох их мөрөөдлөөр жигүүрлэж өссөн. Түүнийг 1969 онд аравдугаар ангиа төгсөхөд аав нь “Дээд сургуульд л ор” гэдэг ганцхан өгүүлбэртэй хатуу үүрэг өгчээ. Нисгэгч болохыг мөрөөддөг хүү тухайн үед цэргийн дээд сургуульд шалгалт өгсөн ч хоосон цаас хураалгаад гарч ирж байсан гэдэг. Г.Жаргалсайхан Нисэхийн сургуульд шалгалт өгч, ЗХУ-ын Рязань мужийн Сасовын Нисэхийн коллежид орж суралцаад 1972 онд төгсч иржээ. Тэрээр АН-2 онгоцны хоёрдугаар нисгэгчээр Архангай аймагт томилогдож, түүнээс хойш 2012 оны хоёрдугаар сарын 18 хүртэл 40 жил нисчээ. Анх бидний “царцаа ногоон” гэж нэрлэдэг АН-2 онгоцоор Архангай аймаг руу нислэг хийж байсан Г.Жаргалсайхан Санкт-Петербург хотын Иргэний нисэхийн академид дөрвөн жил суралцаад инженер нисгэгч мэргэжлээр төгсөж, хожим АНУ-д мэргэжил дээшлүүлж, Монголын анхны “Боинг-737-800” онгоцыг хөлөглөж явсан түүхтэй. Тэрээр 28 настайдаа АН-24-ийн дарга болж, хожим Тээврийн эскадрилийн даргаар томилогдож, Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэг штурманы хэлтэст дунд онгоц хариуцсан

байцаагч нисгэгч гэсэн албан тушаалд ажиллаж, Нисэх техникийн улсын байцаан шалгах газрын даргаар томилогдож байсан. Харин өнөөдөр МУ-ын баатар хошууч генерал Д.Гунгаагийн хүү, МУ-ын Гавьяат нисгэгч Г.Жаргалсайхан МИАТ хэмээх том байгууллагыг удирдаж явна. МИАТ хэмээх энэ байгууллага Монголчуудын хөл дүүжлэх чөдрийн ганц унаа болж байсан цаг саяхан. Тэгвэл байгуулагдаад эдүгээ 90 жилийнхээ түүхтэй золгож буй МИАТ хэмээх энэ байгууллагын бүхэл бүтэн 80 жилийн түүхийг Дугарын Гунгаа, Гунгаагийн Жаргалсайхан хэмээх аав хүү хоёр бичилцэж явна. Монголын иргэний нисэхийн үүсч хөгжсөн түүх нь цэргийн нисэх хүчнийхээ түүхтэй салшгүй холбоотой. Учир нь түүний аав Д.Гунгаа Монголын анхны нисгэгч нарын нэг. Тэртээ 1945 онд МАХЦ-ийн нисэх дивизийг татан буулгаж нисэх 5 дугаар холимог хороо болгон зохион байгуулж, орон тоог 355 хүн, байлдааны болон сургууль дадлагын 72 нисэх онгоцтойгоор батласнаар Д.Гунгаа баатар Монголын иргэний агаарын тээврийг хөгжүүлэх үйлсэд хүчин зүтгэж эхэлж байжээ. Агаарт нисэж яваа аавыгаа газарт хүлээж суусан хүү өдгөө алдартай нисгэгч болж. Тэр хүү аавынхаа хийж бүтээж явсан ажлыг өдгөө ч үргэлжлүүлж байна. Түүний аав Нисэх V отрядын дарга, 1963 оноос Агаарын харилцааны газарт боловсон хүчний хэлтсийн дарга, 1964 оноос Агаарын харилцааны газрын хөдөлгөөний албанд шалгах группын дарга, 1965 оноос Агаарын харилцааны газар, ИАТУЕГ-ын даргаар тус тус ажиллаж байсан бол өдгөө хүү нь МИАТ-ын захирлаар ажиллаж байна. Агаарт 40 жил, 20 мянган цаг ниссэн Г.Жаргалсайханд Монголын төр хүндэтгэл үзүүлж, 2011 онд МУ-ын Гавьяат нисгэгч гэдэг эрхэм цолыг олгосон юм.

Бүргэдийн зулзага газарт өдөлдөггүй. Тэнгэрт өдлөсөн энэ бүргэд өдгөө ч тэнгэртэйгээ холбоотой яваа. Түүний хүү ч бас нисгэгч болохоор мөрөөдөж, мөрөөдлөө биелүүлэхийн төлөө бас л Иргэний агаарын тээвэр хэмээх их айлд хүчин зүтгэж, нисэхийн сургуульд сурч байна.

Тиймээ. Амьдрал гэдэг амар сайхандаа жаргадаг үлгэр биш. Амьдрал ашид үргэлжилдэг төгсгөл үгүй үлгэр гэдэгт би итгэдэг. Итгэсээр ч байх болно.





## ГОВИЙН ЁНДОНЖАМЦ

Мал дагаж, малынхаа үр шимийг хүртэж, олон зуун дамжин амьдарч ирсэн Монголчууд социализмын үед ямааныхаа ноолуурыг өөрсдөө боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэл сонирхолтой байлаа. Гэвч энэ төлөвлөгөөг хэрэгжүүлнэ гэдэг амаргүй том даваа байв. Тухайн үед монголчуудад бүхий л төрлийн дэмжлэг туслалцаа үзүүлж байсан орос ах нар өөрсдөө ч ямааны ноолуур боловсруулах үйлдвэргүй, бас техник, технологийн тухай нарийн мэдлэг битгий хэл, сайтар ойлголт ч байсангүй. Монголчууд түүхий ноолуураа Зүүн Герман, Унгар, Чех зэрэг улсад хямд үнээр зардаг, тэд монголчуудаас авсан ноолуураа цааш нь Английн “Даусан”, Америкийн “Forte Cashmere”, японы үйлдвэрүүдэд арилжиж, тэд анхан шатны боловсруулалт хийн АНУ, Англи, Итали, Япончуудад худалддаг, түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дэлхийн зах зээл дээр гаргаж байлаа. Тиймээс Монголчууд зориг гарган, капиталист улсад хандахаар шийджээ. Ямааны ноолуураа Англи, Япон зэрэг улс руу явуулж, нарийн судлагаа, шинжилгээ хийлгэж эхэлжээ. Гэвч англичуудаас эхлээд олон газар “Танайх ноолуурын үйлдвэртэй болтлоо 100 жил” гэсэн хатуу хариу өгч байсан юм гэнэлээ. Үнэндээ өргөн уудам газар нутагтай, дэд бүтэц сайн хөгжөөгүй, техник, технологийн тухай мэдлэг хомс монголчуудыг ноолуурын үйлдвэр барьж байгуулна гэдэгт тэд эргэлзэж байсан хэрэг. Гэвч Монголчууд шантраагүй. Тэр үед буюу 1975-1978 онд Бадарчийн Ендонжамц ХХҮЯ-ны хөнгөн үйлдвэрийн хэлтсийн даргаар ажиллаж, ямааны ноолуур, тэмээний ноос, боловсруулах судлагааны ажил хийж, япончуудтай хамтран ажиллах, шинэ үйлдвэр барих төсөл боловсруулж байлаа. Түүний энэ судлагаа амьдрал дээр хэрэгжиж, Төв хорооны улс төрийн товчоо 1977 оны 11 сарын 29-ны өдөр 306 тоот тогтоол гаргаж, Японы засгийн газраас буцалтгүй тусламж болгож өгсөн мөнгөөр ноос, ноолуурын том үйлдвэр барих тогтоол батлагдаж байсан түүхтэй. Японы техник, тоног төхөөрөмжийг сонгох, судлах ажилд Төмөрбулаг сумын хүү Ёндонжамц тэргүүтэй инженерүүд томилогдож, Япон руу явуулсан ноолуур, ноосны туршилтанд оролцох, техник технологи ноу хауг нь судлах, үйлдвэр байгуулах компанийг сонгох ажлаар 1977 оны 12 сараас 1978 оны 1 сар хүртэл сар гаруй ажиллаж, өнөөгийн “Говь” комбинатын намтрын хуудсыг бичиж эхэлсэн түүхтэй. Ёндонжамц тэргүүтэй инженерүүдийн хүч хөдөлмөрийн үр дүнд Монголчууд ноолуурын үйлдвэртэй болж, социализмын үед энэ үйлдвэр комбинат “Эрдэнэт”-ээс илүү ашиг өгдөг, улсын гадаад валютын нөөцийн 70 хувийг дангаараа бүрдүүлдэг байсан гэдэг. Олноо Говийн Ёндонжамц хэмээн нэрлэгддэг, Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан Ёндонжамц 1945 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төржээ. Түүний ээж Бадарчийн Ичинноров Алтанбулгийн техникум төгссөн, Төмөрбулаг сумын мал аж ахуйн мэргэжилтнүүдийн нэг байсан юм. Багаасаа аливаа зүйлд хянуур няхуур ханддаг, өөрөө өөрийгөө хөгжүүлдэг энэ хүн тооны



олимпиадын аварга, тэр үеийн мундаг сурагчдийн нэг байжээ. Тэрээр 1962 онд Мөрөн хотын 10 жилийн дунд сургуулийг төгсөж, 1967 онд Москва хотын Нэхмэлийн дээд сургуульд суралцан, хөнгөн нэхмэл ба нэхмэлийн инженер, механикч мэргэжил эзэмшжээ. Анх 1968 онд Аж үйлдвэрийн комбинатын механик, монтажийн хэлтэст дагалдан инженерээр ажиллаж, засварчин, токарьчин, гагнуурчин хийж, үйлдвэрийн ажилчдын хүнд хэцүү амьдралыг өөрийн биеэр туулж, басхүү Хөнгөн үйлдвэрийн техник мэргэжлийн сургуульд багшилж явжээ. Тэрээр Аж үйлдвэрийн комбинатаас ажлынхаа гарааг эхлэж, засвар угсралтын үйлдвэрт инженер, үйлдвэрийн даргын алба хашиж, ХХҮЯ-ны хөнгөн үйлдвэрийн хэлтсийн даргаар ажиллаж байжээ. Цаг хатуу юм бүхэн

нарийн хяналт шалгалттай, олон дамжлага дамжиж байж нэг асуудал шийдэгддэг байсан үед ийм том үйлдвэр байгуулна гэдэг амар байгаагүй. Улсын төлөвлөгөөний комисс, Сайд нарын зөвлөлд асуудал оруулах, Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж батлуулах, үйлдвэртэй холбоотой бүхий л материалыг боловсруулах ажилд тэрээр гар бие оролцсон. Тухайн үед ХХАҮЯ-ны сайдаар ажиллаж байсан П. Дамдин “Монголчуудад энэ үйлдвэр хэрэгтэй” гэдгийг яс махандаа шингэтэл ойлгож мэдэрч чадсан хүн байж. Тиймээс Б.Ендонжамц хоёр чемодан загвар, төсөл баримтуудаа бариад сайдыгаа даган Улс төрийн товчоо, Төлөвлөгөөний комиссын үүдний өрөөнд дэлгэн тавьж, танилцуулж явсан гэдэг. Тэрээр 1978 оны 7 сард ХХҮЯ-ны сайдаас үүрэг авч, барилгын талбай дээр очиж, одоогийн “Говь” ХК-ны улаан шугамыг татснаар Бадарчийн Ендонжамц гэдэг хүн дэлхийд алдартай “Говь” гэсэн нэртэй салшгүй холбоотой болсон түүхтэй. “Говь” хэмээх энэ үйлдвэр ямар их хүч хөрөнгө, ямар их идэвх санаачлага дээр тулгуурлан боссон бэ гэдгийг Б. Ёндонжамцаас өөр мэдэх хүн цөөхөн. Анх үйлдвэрийг хаана барих бэ гэдэг газрын асуудал шийдэгдэлгүй багагүй хугацааг авчээ. Улаанбаатар, Дарханд барих санал гарч, бүгд л өөр өөрсдийнхөө саналыг зүтгүүлж байсан тэр үед Москвад байсан Ю.Цэдэнбал дарга “ноолуурын үйлдвэрийг Улаанбаатар хотод байгуулья” гэсэн чиглэл өгч байсан юм гэнэлээ. 1978 оны 7 сард барилгын талбай дээр очин “Говь” үйлдвэрийн суурийг тавьж, улаан

шугамыг татаж байсан энэ хүн 1978-1981 онд одоогийн “Говь” үйлдвэр буюу тэр үеийн Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэрийн анхны даргаар томилогдож байсан юм. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг суурилуулах, инженерийн шугам сүлжээг монтажлахын тулд боловсон хүчнээ сургахаар Б.Ендонжамц 30 хүн дагуулан 1979 онд Японд очиж байжээ. Тэд үйлдвэрт тавигдах тоног төхөөрөмжийг угсарч, угсарсан тоног төхөөрөмжөө ажиллуулж, дараа нь буцаад задлаж, тослож, хайрцаг саванд хийгээд Монгол руу ачуулж байжээ. Б.Ендонжамц дарга одоогийн “Говь” үйлдвэрийн тоног төхөөрөмж бүхий хэдэн зуугаар тоологдох контейнер барааг оросын “Находка” боомтоор дамжуулан хүлээж авч байсан түүхтэй. Энэ их ачаа барааг Монголд ирсний дараа тоног төхөөрөмжүүдийнхээ тоос, тортог арилгаж цэвэрлэхийн тулд 22 мянган литр керосин, 12 мянган литр бензин зарцуулж байсан гээд бодохоор ямар нүсэр тоног төхөөрөмж ирж, ямар том үйлдвэр Монголд сууриа тавьж байсныг уншигчид маань ойлгох буй заа. Монголчууд гуравхан жилийн дотор ноолуурын том үйлдвэр байгуулж, үйлдвэрийг хүлээж авах тууз хайчлах хавсралт протоколуудад Монгол улсын ХХҮЯ-ыг төлөөлөн Б.Ендонжамц, Иточу компанийг төлөөлөн Н.Савада нар гарын үсэг зурж байжээ. Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр нэрээ сольж, Ноолуур боловсруулах комбинат болох үед тэрээр мөн л даргаар нь томилогдож, 1981-1986 он хүртэл ажиллажээ. Монгол ноолуурын үйлдвэр барьж байгуулж, ашиглалтанд оруулж чадсан энэ хүнийг 1986 онд Ноосны үйлдвэрийн нэгдлийн даргаар томилох шийдвэрийг дээд газраас гаргажээ. Тухайн үед Арьс ширний үйлдвэрийн нэгдэл, Ноос боловсруулах ноосны үйлдвэрийн нэгдэл гэж техник технологиор нь төрөлжүүлэн хоёр том нэгдлийг төр засгийн шийдвэрээр байгуулаад удаагүй байсан үе. Ноосны үйлдвэрийн нэгдэл гэж 14 үйлдвэрийг багтаасан 14 гаруй мянган ажилчинтай том цогцолбор байлаа. Энэ нэгдлийн үйлдвэрүүд улсын хэмжээнд бэлтгэсэн 20 орчим мянган тонн ноос хүлээн авч анхан шатны боловсруулалт хийж, утас ээрч, нарийн даавуу, бүдүүн нэхмэл долгион хөнжил, цэмбэ, драп аяны хөнжил зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байлаа. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дотоодын хэрэгцээнд зориулан худалдахаас гадна гадаадын арваад оронд 40 гаруй хувийг нь экспортолдог байв. Ноосны үйлдвэрийн нэгдэлд гурван том хивсний үйлдвэр, Нэхээсгүй эдлэлийн үйлдвэр, Сүлжмэлийн нэг, хоёрдугаар үйлдвэр, Эсгий эсгий гутлын хоёр ч үйлдвэр харьяалагддаг байсан түүхтэй. Ийм л том байгуулагыг хөл дээр босгож, улсад хэдэн арван тэрбумын ашиг өгч, 14 мянга гаруй хүнийг удирдаж байсан Б.Ендонжамц дарга тус үйлдвэрт 1994 он хүртэл ажиллажээ. Гэхдээ л “Говь” гэдэг энэ нэр түүний намтартай салшгүй холбоотой. Ямаагаар алдартай Төмөрбулаг сумын хүү ямааны ноосон эдлэлээрээ дэлхийд танигдсан “Говь” хэмээх энэ үйлдвэрийн даргаар гурван удаа томилогдож, нийтдээ 15 жил ажилласан байх юм. Тэрээр анх энэ үйлдвэрийн улаан шугам татаж явсан бол хожим 1996 онд үйлдвэрийг өргөтгөх “Говь-2” төслийг эхлүүлж, бас хэрэгжүүлж чадсан. Ингэснээр өмнө нь 24/2, 28/2 гэсэн хэмжээтэй сүлжмэлийн зориулалтын ээрмэл утас ээрч, бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг байсан “Говь” компани Ёндонжамц даргын хэрэгжүүлсэн

төслийн үр дүнд 48/2,64/2, 80/2, 100/2 гэсэн илүү нарийн ээрмэл утас ээрч, дэлхийд алдартай кашмеран ороолт, монгол дээл, костюм хийх зориулалтын нарийн даавуу нэхэж, бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээл дээр гаргаж эхэлсэн юм. “Говь-2” үйлдвэр нарийн утас ээрэхээс гадна нэхэх үйлдвэрлэлд өргөтгөл хийж, ямааны ноос, тэмээний ноосон өргөн хөнжил нэхэх боломжтой болжээ. Үйлдвэр дээрээ эрдэм шинжилгээ, туршилт, судлагааны тасаг байгуулагдаж, бүтээгдэхүүний чанар сайжирч, нэр төрөл олширч, сарлагын хөөвөр, тэмээний ноос боловсруулах, бараан өнгийн ноолуурыг цайруулж цагаан болгох шинэ технологи мөн нэвтэрчээ. Мөн энэ үеэс ноолуурыг торго, австрали хонины нарийн ноос гэх мэт бусад төрлийн материалтай хольж, бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр чанар өнгө үзэмж, эдэлгээ нь сайжирсан гээд олон зүйлийг энд дурьдаж болно. Тэрээр “Говь” хэмээх нэгэн том вант улсыг бүтээж, дэлхийд Монголыг таниулах брэнд бүтээгдэхүүнийг бий болгож чадсан юм. Тийм ч учраас 2001 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар түүнд “Аж үйлдвэрийн гавьяат ажилтан” гэдэг эрхэм цолыг олгосон юм. Төмөрбулаг сумын Хавчуугийн аманд төрсөн хүү аль хэдийнээ дэлхийд танигдсан том үйлдвэрийг үндэслэгч, басхүү гадаадын олон орны эрдэмтэн мэргэдтэй санал бодлоо хуваалцсан “шилдэг менежер” болжээ. Гэхдээ тэрээр нутаг уснаасаа хөндийрөөгүй. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутгийн зөвлөлийг үүсгэн байгуулсан Б.Ёндонжамц хэмээх энэ л эрхэм хүн одоо ч нутгаа гэх халуун дулаан сэтгэлтэй яваа. Тэрээр “Оны шилдэг менежер”, Монгол улсын зөвлөх инженер гээд олон цол хэргэм бий. Хөдөлмөр бүтээлээрээ өөрийгөө хэн бэ гэдгийг олонд таниулж өгсөн энэ хүний тухай бичихэд элдэв магтаал, гоё үг хэрэггүй. “Говийн Ёндонжамц” гэх энэ нэр түүнийг хэн бэ гэдгийг олонд таниулаад өгнө.

## НОМ ТҮГЭЭСЭН АЧТАН

Төрийн шагналт Л.Түдэвийн гэргий Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Найдангийн Цагаач хэмээх номын буяныг олноо дэлгэрүүлж, хэл бичгийн соёлд гарамгай нэвтэрсэн их хүмүүн байлаа. Түүний нэгэн насны хань Лодонгийн Түдэвийн тухай мэдэхгүй хүн гэж Монголд үгүй. МУ-ын төрийн шагналт, хэл бичгийн ухааны доктор, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол, Хөдөлмөрийн баатар, “Зууны шилдэг сэтгүүлч” олон өргөмжлөл шагнал энэ хүнд бий. Мөн түүний бүтээл туурвил дэлхийн 15 улсад хэвлэгдэж, монголын зохиолчоос анх удаа Америкт орчуулагдан олны хүртээл болж байсан түүхтэй. Тэгвэл Монголын бичгийн мэргэдийн шинэ цагийн төлөөлөл болсон Лодонгийн Түдэвийн гэргий Найдангийн Цагаач хэмээх энэ хүн мөн л эрдэм номыг дээдлэн шүтсэн, оюуны бүтээлийг хүндэтгэн эгнэгт өөд нь залсан бичгийн хүн байсан юм. Төмөрбулаг сумаас төрж гарсан алдар цуутнуудын нэг Найдангийн Цагаач 1938 онд мэндэлжээ. Соёлын дээд сургууль төгссөн, номзүйч мэргэжилтэй энэ эмэгтэй Улсын төв номын санд танхимын эрхлэгч, хэлтсийн дарга, Номын сангийн даргаар тасралтгүй олон жил ажиллажээ. Эрдэм номын замд зорьсон хэн бүхний оюуныг гийгүүлж, урмыг сэргээж урагш тэмүүлэх мөрөөдлийг хөтлөгч, номын өглөгч ахмадуудын нэгэн болсон Н.Цагаач 1983-1985 онуудад хүүхдийн номын сангийн “Номын сан-Номзүйн ангилал” номыг бүтээж, 1962-1965 онуудад 300-аад хүнийг курсээр сургах ажилд оролцож, басхүү хөдөө орон нутагт номын сан байгуулах ажлыг удирдаж явсан хүмүүсийн нэг. Үзүүргүй оргил, ёроолгүй тэнгис, эрдэм мэдлэгийн их далай гэж нэрлэгддэг номын санг Монголд хөгжүүлэхэд бүхий л насаа зориулсан энэ хүн “Монголын үндэсний номын сан” нэртэй түүхэн номыг бичиж, Монголчуудын номын соёл ба Номын сангийн үүсэл хөгжлийн түүхийг өгүүлсэн “Эрдэнийн сувд” хэмээх томоохон хэмжээний судлагааны бүтээлийг хойч үеийнхэндээ үлдээжээ. Номын санг ангилах төрөлжүүлэх, зохиолч бүтээлчдийн оюуны хөдөлмөрийг хамгаалах ажилд оролцохын зэрэгцээ олон арван ном бүтээж, редакторлаж, түгээсэн юм. Хамгийн сүүлд тэрээр өөрийн хань, Хөдөлмөрийн баатар эрдэмтэн зохиолч Л.Түдэвийн “Бүтээлийн чуулган” 25 боть зохиолыг эмхэтгэж хэвлүүлсэн байна. Н.Цагаач Олон улсын номын санчдын холбооны гишүүн, Монголын номын санчдын холбооны анхны тэргүүнээр сонгогдон ажиллаж байсан түүхтэй. Түүний хөдөлмөр зүтгэлийг үнэлж, 2001 онд Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цолоор шагнасан байна. Тэрээр Улсын төв номын сангийн эрхлэгчээр ажиллаж байхдаа Нэгдсэн үндэсний байгууллагын хадгалагч номын сангийн салбар фонд байгуулж, Монгол Улсын Үндэсний номын санд дөрвөн сая гаруй нэр төрлийн номтой томоохон сан хөмрөг бүрдүүлэхэд гар бие оролцож ажилласан түүхтэй. Н.Цагаач оюуны бүтээлийг, зохиогчийн эрхийг хамгаалах, хяналт сул байгааг шүүмжилж, 2010 онд Монгол улсад “Зохиогчийн эрхийн тухай хууль” батлагдахад өөрийнхөө санаа бодлыг



нэмэрлэж явсан ахмадуудын нэг нь. Тэрээр “Монгол улсын стандарт, номын сангийн орчны нөхцөл үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг боловсруулах ажилд оролцож байжээ. Улсын төв номын сангийн номыг ангилж, каталог бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулж явсан Н.Цагаач гуай зохиолчдын бүтээлд ISBN код олгох ажлыг эхлүүлж, зохиол бүтээлийг хадгалж, хамгаалахын төлөө тэмцэж байсан гавьяатай. ISBN кодтой болсноор зохиогч, номын нэр, сэдэв, агуулга, түлхүүр үг, хэвлэгдсэн он сар өдөр гэх мэт бүхий л мэдээлэл электрон санд хадгалагдах боломжтой болж, монгол ном дэлхийн бүртгэлд орсон

юм. Ном гэдэг нэг талаараа хэн нэгэн буюу хэсэг хүний оюуны бүтээл, нөгөө талаараа аль нэгэн улс үндэстний материаллаг үйлдвэрлэлийн бүтээгдхүүн, цаг үеийн гэрч байдаг. Ном бол зөвхөн гэрийнхээ хойморт тахьдаг бурхан шүтээн бус, уншиж судлан учир утгыг нь таньж оюун ухаанаа нээж сэтгэл дотроо ариулан үр хүүхэд залгамж үеэ сургаж хүмүүжүүлдэг хэрэглээний зүйл гэдгийг Монголчуудад гүн гүнзгий ойлгуулж өгсөн гавьяатнуудын нэг нь Найдангийн Цагаач хэмээх энэ хүн. Ном түгээх ажилд бүхий л насаа үдсэн Н.Цагаач гуайн эрдэм шинжилгээний бүтээлүүд, судлагаа шинжилгээний ажлууд мянган мянган хүнд өгөөжөө өгсөөр байна. Тиймээс ч энэхүү хөрөг тэмдэглэлээ бид “Ном түгээсэн ачтан” хэмээн гарчиглахдаа огтхон ч эргэлзээгүй юм. Тэрээр Орос, Герман, Чех, Польш зэрэг арав гаруй оронд болсон номын санчдын Олон улсын хурал зөвлөгөөнүүдэд оролцож, илтгэл, хэлэлцүүлэг тавьж, “Книга Монголий”, “Писатели Монгольской Народной Республики” зэрэг олон бүтээлүүдээ орос хэлнээ гаргаж байжээ. Мөн цаг хатуу үед Засгийн газарт санал тавьж, валют гаргуулан АНУ-д Ганжуур, Данжуурын бүх ботийг хэвлүүлэн Улсын төв номын санд залж байсан юм. МУ-ын төрийн шагналт, хэл бичгийн ухааны доктор, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол, Хөдөлмөрийн баатар, “Зууны шилдэг сэтгүүлч” Лодонгийн Түдэв “Бурхан минь энэ чинь би юм уу” хэмээх дурсамж номондоо “1961 онд Төв хороонд дуудагдаж, “Үнэн” сонины утга зохиолын нарийн бичгийн даргаар ажиллах томилолт авлаа. Томилолтоо өвөртлөөд “Үнэн” сонины эрхлэгчтэй уулзахаар очтол туслагч нь бололтой нэгэн залуухан хүүхэн “Эрхлэгч дээр орох юм уу” хэмээн асуув. Тэр хүүхний дууг сонсож, царайг хармагц миний зүрх ёг хийх шиг хачин болж билээ” хэмээн гэргий Н.Цагаачтайгаа танилцаж байсан түүхээ дурсан өгүүлж, ханьдаа зориулан

...Амраг чамтайгаа учирснаас хойш

Алтан дэлхийгээс горьдох зүйл дуусав хэмээн шүлэг тэрлэж байснаа шигтгэн үлдээжээ.

## НЭР ЦЭВЭР УЛС ТӨРЧ

Төмөрбулаг сумаас төр нийгмийн олон зүтгэлтэн гарч, яам удирдаж, төр барьж, хууль батлалцаж явсан түүхтэй. Тэдний нэг нь Гэндэнгийн Төртогтох. Түүний өвөг эцэг Жунай гэдэг хүн Донхорын ам, Бадаг хавиар нутаглаж байжээ. Г.Төртогтох гуай нэгэнтээ “Аавын маань төрсөн ах Чойжав, Цоохор Санжжав гэж урт цагаан сахалтай сайхан буурлууд төрж өссөн нутагтаа малаа дагаж, нүүдлэн амьдарч, отор хийж, туувар тууж явсан” хэмээн дурсан өгүүлсэн байх юм. Гэхдээ Төртогтох гэдэг энэ хүнд аав нь удам судраа нэг их ярьдаггүй байж. Намтар түүхэндээ “Ядуу ард Жунайн гэр бүлд төрсөн, багаасаа мал маллаж өссөн л гэж тэмдэглэдэг” байсныг л тэр сайн мэднэ. Гэвч үнэндээ түүний эцгийн талын дээдчүүл, хамаатны хүмүүсээс хүрээ хийдэд шавилан суусан том лам нар олон байжээ. Тэднийг лам, феодал гэх мэтээр ад үзэж их хэлмэгдүүлэлтийн үеэр барьж хорьж, егүүтгэсэн учраас аав нь удам судрынхаа талаар нууцалж байсныг хожим мэдсэн гэнэ. Г.Төртогтохын аав Гэндэн 1945 оны дайнд оролцож явсан түүхтэй. Дайны дараа цэргээс халагдаад тэр үед шинээр байгуулагдаж байсан Тариалангийн САА-д илгээлтээр очиж улсад ажиллах гараагаа эхэлжээ. Бичиг үсэгтэй байсан тул шууд л тоо бүртгэгч, бригадын даргаар ажиллажээ. Тэрээр Цэдэв тайж гэдэг хүний охин Должмаатай танилцан гэр бүл болсон аж. Г.Төртогтохын ээжийн аав алтан ургийн тайж язгууртай, хөрөнгө чинээтэй баян хүн байсан учраас феодал дарлагч ангийн төлөөлөгч гэж адлагдаж гурван удаа хөрөнгөө хураалгаж, эцэст нь цаазалагдсан гэдгийг ч тэр хожуу мэдсэн гэдэг. Ийм л намтар түүхтэй хоёр хүний гэрт тэрээр 1948 онд Хөвсгөл аймгийн Тариалан суманд төржээ. Гэндэн гуай хар залуудаа ханиа алдаж, гурван нялх хүүхэдтэй хоцорч, багагүй зовлон амссан гэдэг. Гэвч амьдралын хатууд тэр бууж өгөөгүй. 1957 оны үед хоёр хүүхдээ дагуулан Мөрөн хотод шилжин ирж, аймгийн хүнсний үйлдвэрт ажиллаж эхэлжээ. Таван жилийн гавшгайч, хөдөлмөрийн аварга, социалист хөдөлмөрийн бригадын гишүүн болж байгууллагын болон аймгийн хүндэт үнэмлэх, тэмдэг, баярын бичгээр олонтаа шагнагдаж байсан энэ хүн нутаг орондоо их элэгтэй, Төмөрбулаг сум, нутаг усаа их ярьдаг, аймгийн төвөөс сум орон нутаг руугаа олонтаа очдог нутаг амьтай хүн байсан гэдэг. Түүний хүү Г.Төртогтох Тариалан суманд төрж Мөрөнд өссөн ч гэсэн хүүхэд байхдаа аавынхаа ах Цоохор Санжжав гэгч айлд очиж зусч, морь унаж, хонь хариулж байсан гэдэг. Хожим Улсын их хурлын 1992 оны сонгуульд нэр дэвшиж аймгийнхаа бүх сумаар тойрч явахдаа Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Гавьяат хуульч Б.Чимид, тэр үед Монгол Банкны дарга байсан “алт диллерийн хэрэг” гэгчийг илрүүлж ард олноос “ардын баатар” гэдэг нэр аваад байсан Дарийн Данзан гуайтай хамт очиж, аавынхаа төрсөн нутаг Төмөрбулаг сумын иргэдтэй уулзаж байжээ. Улсын их хурлын гишүүнээр хоёр удаа сонгогдож ажилласан Гэндэнгийн Төртогтох гуай Мөрөнгийн 1-р арван жил төгсөж эвлэлийн илгээлтээр Дархан хотын Тоосгоны үйлдвэрт ажилчин болжээ. Эндээсээ хотын Хувьсгалт залуучуудын эвлэлийн хороонд зааварлагч, хэлтсийн эрхлэгчээр ажиллаж улмаар МХЗЭ-ийн Төв хороонд дэвшин, тэр үеийн “Залуучуудын үнэн” сонинд сурвалжлагчаар ажиллаж



байжээ. Удалгүй Эвлэлийн төв хорооны удирдлагын шийдвэрээр ЗХУ-ын Москва хотод Комосмолын дээд сургуульд явж, төгсч ирээд Эвлэлийн төв хороондоо зохион байгуулагч хийж байжээ. Түүнийг МАХН-ын Төв хорооноос Москвад Нийгмийн ухааны академид суралцуулах шийдвэр гарсны дагуу тэнд аспирантурт суралцаж эрдмийн зэрэг хамгаалсан аж. Г.Төртогтох гуай төгсч ирээд МАХН-ын төв хороонд зохион байгуулагч, Намын төв хорооны ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх, намын төв хэвлэлүүдийн болон “Үнэн” сонины 1-р орлогч эрхлэгч, ерөнхий эрхлэгч зэрэг албыг хашиж байсан түүхтэй. Тэрээр 1992-1996 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж хууль батлаж

явсан. Харин 1996 онд “Үнэн” сонины Ерөнхий эрхлэгчээр томилогдон ажиллаж байгаад 200-2004 онд дахин УИХ-ын гишүүнээр томилогджээ. Хууль батлалцаж явсан энэ хүн 2006-2010 он хүртэл Монгол Улсаас ОХУ-ын Буриад улсад суух Ерөнхий консулын албыг хааж дуусгаад тэтгэвэртээ гарсан ч өнөөдөр СИТИ гэдэг дээд сургуульд дэд захирлаар ажиллаж, одоо зөвлөхийн албыг эрхэлж байна. Боловсролын доктор, профессор цолтой энэ хүн яруу найргийн “Аяны шувуу” номоо хэвлүүлж, олон зуун нийтлэл бичиж хэвлүүлжээ. Тэрээр 1985 онд “Үнэн” сонинд өөрчлөн байгуулалтын сэдвээр улс төрийн томоохон нийтлэл бичиж, шуугиан тарьж байсан удаатай. Г.Төртогтох гуай “Би Төмөрбулаг суманд төрж өсөөгүй ч гэсэн эцгийн нутаг гэдэг элэг зүрхэнд дотно, эгнэгт дурсагдаж байдаг юм шүү дээ. Ахимаг настай болох тусам аавын нутгыг эргэх юмсан гэдэг бодол хүсэл улам л төрж байдаг юм байна. Би чинь өвөө Жунайнхаа нэрийг ургийн овгоо болгоод явж буй учир удам судар, ах дүүс маань энэ л суманд байгаа. Би удам гарвалаа ярьвал Төмөрбулаг, унасан газраа ярьвал Тариалангийн хүн дээ” гээд инээмсэглэж байсан. Улс төр гэдэг зарим хүнийг танигдахгүй болтол өөрчилж, орхих нь бий. Харин би түүнийг улс төрийн халуун тогооноос нэр цэвэр үлдэж чадсан цөөхөн хүмүүсийн нэг гэж боддог юм. Үнэндээ ч илүү дутуу амбиц, хов жив, улс төрийн хор найруулгаас ангид явж, хийж бүтээж, УИХ-д хоёр ч удаа сонгогдон хууль батлалцаж явсан Гэндэнгийн Төртогтох гэдэг энэ хүн өөрийн гэсэн түүх намтраа Монголын улс төрд бичиж үлдээсэн. Тэрээр 1992-1996 онд шинээр батлагдсан Үндсэн хуулинд нийцүүлэн хууль тогтоомжийг өөрчлөх, зах зээлд шилжээд удаагүй байсан Монгол улсын улс төр эдийн засгийн тогтворжуулах гээд асар олон хууль батлахад гар бие оролцож явсан гавьяатай ахмад улс төрчдийн нэг нь юм.

## ХОТОГОЙДУУДААС ТӨРСӨН ТӨРИЙН САЙД

Түмэнгийн Дэмчигдорж Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумнаас төрсөн сайд нарын нэг. Энэ хүн 1936 онд Төмөрбулаг сумын Хавчигийн ам гэдэг газар төржээ. Түүний аав Түмэн Төмөрбулаг сумын бичээч, багийн дарга, гар үйлдвэрийн артелийн даргаар ажиллаж, аймгийн Гар үйлдвэрийн артелийн холбооны даргаар томилогдож, аймгийн намын хорооны даргын туслах хийж явжээ. Түмэн гуай тэртээ 1948 онд Улаанбаатар хотод Тээврийн яамны боловсон хүчний хэлтсийн даргаар томилогдож байжээ. Тэрээр ганц хүүгээ өөрийнхөө ажил амьдралаар үлгэр дуурайлал үзүүлсэн хүн байсан гэдэг. Т.Дэмчигдорж 1948 онд Мөрөнгийн арван жилийн сургуульд элсэн орж, 1956 онд Нийслэлийн 2-р 10 жилийн сургуулийг төгсжээ. Дунд ангид байхдаа Өсвөр үеийн шатарчдын улсын аваргын тэмцээнээс алтан медаль хүртэж явсан энэ хүн ЗХУ-д Ленинградын Төмөр замын дээд сургуулийг дүүргэж, 1961-1972 онд УБТЗ-д ахлах инженер, техникийн хэлтсийн дарга, эрчим хүч, ус хангамжийн ангийн дарга, Төмөр замын намын хорооны 2 дугаар нарийн бичгийн даргаар ажиллаж байсан аж. Аливаа ажлын арга барилыг сайн олдог, гарын уртай, хамт олонч нөхөрсөг энэ хүн олон арван шинэ санаачилга, тэргүүн туршлага ажилдаа нэвтрүүлж, олондоо авьяаслаг инженер, сайн зохион байгуулагч болохоо харуулж чадсан юм. Түүний удирдаж байсан Төмөр замын эрчим хүч, ус хангамжийн ангийн хамт олон 1968-1978 онд 360 км урт цахилгаан өндөр хүчдлийн шугам барьж, төмөр замын 36 цэг зөрлөгийг цахилгаан эрчим хүчээр хангаж, 500 гаруй айлыг эрчим хүчтэй болгож байсан гэдэг. Тийм ч учраас 1972 онд түүнийг Нийтийн аж, ахуй үйлчилгээний яамны орлогч сайдаар томилжээ. Өмнө нь хоршоолол маягаар ажиллаж байсан гар урчууд, үсчин, дархан гэх мэт үйлчилгээний салбарыг нэгдсэн нэг удирдлагаар хангаж ажилахын тулд Нийтийн аж ахуй үйлчилгээний яамыг байгуулжээ. Т.Дэмчигдорж сайд 1972 онд Нийтийн аж ахуй үйлчилгээний яамны орлогч сайд, 1979 оноос нэгдүгээр орлогч сайд, 1982-1990 онд тус яамны сайдаар тус тус томилогдож байжээ. Тэр үеийн Нийтийн ахуй үйлчилгээний яам гэдэг асар том салбар. Үсчин, оёдолчноос эхлээд энэ яам том үйлдвэрүүдийг хариуцаж, үйлчилгээний соёлыг нэвтрүүлж, хувцас загварт хүртэл анхаарч дэргэдээ “Шилмэл загвар” хэмээх хувцас урлалын товчоог байгуулж байсан түүхтэй. Нийтийн ахуй үйлчилгээний оёдол эсгүүрт хүртэл анхаарч дээл хийхээс эхлээд дээс томох хүртлэх стандартыг боловсруулж батлуулж байсан баримт байна. Т.Дэмчигдорж сайд орлогч сайд байх үеэс эхлэн нийтдээ 100 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий стандартыг боловсруулж, батлуулжээ. Энэ үеэс Монголд ахуй үйлчилгээ, зоогийн газруудад үйлчилгээний соёл бүрэн нэвтэрч эхэлсэн гэхэд болно. Т.Дэмчигдорж сайдын үед Нийтийн аж, ахуй үйлчилгээний яам үйлчилгээний чанарыг сайжруулах, мэргэжилтэй



“Алтай” үйлчилгээний төвийн даргаар тус тус ажиллаж байгаад ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

боловсон хүчин бэлтгэхийн тулд гадаадад олон зуун хүнийг сургаж, шинээр үйлчилгээний томоохон төвүүд байгуулж байжээ. Үүнээс гадна тэрээр 1970 онд Монголын сагсан бөмбөгийн холбооны Ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, мөн Монгол улсын бүх салбарын тэргүүний ажилтан цол хүртэж байсан Т.Дэмчигдорж сайд АИХ-ын депутатаар гурван удаа, МАХН-ын Төв Хорооны орлогч, МХЗЭ, МҮЭ-ийн удирдах дээд байгууллагын гишүүнээр олон сонгогдон ажиллаж байжээ. Нийтийн ахуй үйлчилгээг хувьчилсны дараа Т.Дэмчигдорж 1990-1991 онд МАХН-ын Төв Хороо, Засгийн газрын үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын дарга,

## АМЬДРАЛ ТУЛАХ БАГАНА


Өдрөг үзэлтэй, өөрийгөө ялж чадсан хүнд амьдрал бол бэлэг. Харин өөрийгөө голж, гуньж гутардаг хүнд амьдрал зовлон мэт санагддаг гэсэн үг бий. Өдрөг үзэлтэй байж, үргэлж бусдыг гэрэлтүүлж, бас бусдын жаргал, зовлонг хуваалцаж явсан сайхан хүмүүсийн тухай дурсамж олон. Энэ удаа би Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул, өвөө, аав, хүү гурвын тухай онцлон өгүүлэхийг хүссэн юм. Гурван үеийн түүх намтар нэгэн тэмдэглэлд бүү хэл нэгэн номонд ч багтах аргагүй. Гэвч салгаж бичихийн аргагүй гурван хүний намтрыг гурван хуудсанд багтаахаар сэтгэл шулуудснаа та бүхэнд дэлгэж байна.

Төмөрбулаг сумын анхны бага сургуулийн багш Бавуугийн Хаянхярваа хэмээх нэгэн буурал номын авшиг шингэж, эрдэмтэн мэргэдийн өлгий болсон Бүгсийн хүрээнд бага залуугаасаа шавилан сууж байжээ. Тэрээр 1932 онд эсэргүү бослого хөдөлгөөн өрнөж, сүм хийдийг тараах үеэр хар болж, цэргийн албанд татагджээ. Угийн авхаалжтай, эрдэм номын үр шимийг сайн ойлгосон залуу хүү цэргийн албыг таван жил хаах хугацаандаа шинэ үсэг сурчээ. 1940 онд Төмөрбулаг суманд бага сургууль байгуулах тухай Хөвсгөл аймгийн захиргааны шийдвэр гарч, зуны түр сургуулийг ардын бага сургууль болгон зохион байгуулах үед Б.Хаянхярваа энэхүү сургуулийн анхны багшаар томилогдож байжээ. Тэрээр нутгийн ардуудтай хамтран Бүгсийн хүрээнд дээр байрлах лам нарын хураагдсан байшингаас хоёр хуучин модон байшин, шургааган хашаа, таван гэрийн мод, шал зэргийг үхэртэргээр олон хоног зөөж, Төмөрбулаг сумын орчин цагийн боловсролын байгууллагын үндэс суурь болсон сумын Бага сургуулийн анхны хичээлийг 1940 оны есдүгээр сарын 10-ны өдөр эхлүүлж байжээ. Төмөрбулаг сумын бага сургууль ганцхан багштайгаар хичээлээ эхэлсэн бөгөөд Б.Хаянхярваа хэмээх энэ хүн 1-р ангийн хоёр бүлгийн 60 сурагчдад анхны “А” үсгийг зааж явсан түүхтэй. Бага сургуулийн багшаас эхлээд сургуулийн захирлын ажлыг хийж байсан энэ хүн намын даалгавараар Тариалан, Цагаан-Үүр зэрэг сумуудад сургууль байгуулж, үндэс суурийг нь тавих амаргүй даалгавар авч, дан ганц Төмөрбулаг суманд ч бус олон газар шинэ сургуулийн үүд хаалгыг нээж өгсөн ачтан. Хөдөөгийн хээр талд соёлын үр тарьж, шинэ цагийн боловсролын байгууллагыг нээнэ гэдэг тэр цагт амар байгаагүй нь лавтай. Эсэргүү бослого хөдөлгөөн гарч, хоршоо дэлгүүр түймэрдүүлж, Халх голын байлдаантай залгаад Эх орны дайн эхэлсэн хүнд



цаг үед сургуулийн ажлыг төвхнүүлж, сурагчиддаа дэвтэр харандаа, үзэг бал хүртэл олж өгөх гэж тэрээр хичээж явжээ. Б.Хаянхярваа багш барааны боодлын цаас хуулан оёж, үдэж дэвтэр хийж, сарампай мод тослон үнсэн самбар бүтээж, тэмээний хорголыг битүү саванд шатааж, үнсийг нь чихэртэй холин бэх зуурч, харандааны хугархай бал цуглуулан бургасны голд хийн, мөр гаргах бичгийн хэрэгсэл урлаж, цагаан толгой, тоо бодлого, үг хөгжил, биеийн тамир, зургийн хичээлийг хүртэл зааж байсан гэж ахмад шавь нар нь дурсан өгүүлжээ. Сургуулийн захирал, нэгдлийн даргаар ажиллаж явсан энэ хүн аймгийн Нэгдэл дундын үйлдвэрт нярваар ажиллаж байгаад тэтгэвэртээ гарчээ. Нутаг орондоо нэр хүндтэй, аливаа зүйлд сэтгэлээсээ хандаж чаддаг, бусдад ёстой л уул шиг нөмөр нөөлөгтэй энэ хүнийг одоо ч нутаг усныхан нь дурсан ярьцгаадаг. Төмөрбулаг сумын сургуулийн шавийг тавьж, анхны 60 хүүхдийг сургаж явсан энэ хүний шавь нараас олон анхдагчид төрж гарсан. Боовонгийн Чойдог, Ширчингийн Даваасүрэн нар энэ сумаас төрсөн анхны хүний эмч Шагдарын Баадай сумаас төрсөн анхны малын их эмч болж, мөн О.Гун-Аа, н.Даваапил, Д.Баатар, Г.Ичинноров тэргүүтэй олон алдартнууд төрж гарсан юм. Харин харамсалтай нь түүний нэрийг Төмөрбулаг сумын зарим түүхэн номуудад Б.Хаян хэмээн товчлон оруулсан байх юм. Төмөрбулаг сумын анхны багш нарын нэг Б.Хаянхярваа гуайн хүү аймгийн анхны нарийн мэргэжлийн эмч нарын нэг Х.Цэнд-Аюуш 1954 онд Төмөрбулаг сумын нутаг “Бяцхан булаг” хэмээх газар мэндэлжээ. Тэрээр аавынхаа үүсгэн байгуулсан Төмөрбулаг сумын Бага сургуульд сурч, Мөрөнгийн 10 жил төгсөж, Анагаах ухааны дээд сургуульд элсэж оржээ. Мэргэжилдээ шамдан суралцдаг, шилдэг оюутнуудын нэг байсан энэ залуу хөгжим тоглодог, дуулж хуурддаг, басхүү бичиг үсгийн өндөр чадвартай, сайхан зурдаг, барилддаг, бокс тоглодог, ер нь бүхий л зүйлээр бусдыгаа манлайлж чаддаг нэгэн байжээ. Боксын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож, хүрэл медаль авч байсан залуухан оюутанг спортоор нэг мөр хичээллэхийг дасгалжуулагч нар ятгаж байсан ч тэрээр эмч болох шийдвэртээ үнэнч үлдсэн юм. Х.Цэнд-Аюуш 1978 онд Анагаах ухааны Их сургуулийн эмчилгээний ангийг төгсөж, Ханх сумын эмнэлэгт томилолт өвөртлөн очжээ. Мэргэжилдээ сайн, хүний төлөө гэсэн халуун сэтгэлээр ажилдаа ханддаг залуухан эмчийг суманд удаан ажиллуулсангүй, Аймгийн нэгдсэн эмнэлэгт татаж авчирчээ. Төгс сайн эмч болж, олондоо тус хүргэхийг хичээж байсан Х.Цэнд-Аюуш эмч байнга өөрийгөө хөгжүүлж, асар их ажлын хажуугаар дотор, сэхээн амьдруулах, мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээ, цусны станц, уламжлалт анагаах ухаан зэргийг судлаж, нарийн мэргэжлийн сургалтуудад хамрагдаж байж. Үүний зэрэгцээ орос хэл дээр гарсан мэргэжлийн ном, товхимолуудыг байнга уншиж, мэргэжил мэдлэгээ дээшлүүлдэг байжээ. Түүний энэ хичээл зүтгэл талаар өнгөрөөгүй гэдгийг олон хүн мэднэ. Тэрээр Аймгийн нэгдсэн эмнэлэг гэдэг том эмнэлгийн бүхий л тасагт хүрч ажиллаж, эмч нарт заавар зөвлөгөө өгнө. Тухайн үед нарийн мэргэжлийн эмч нар ховор. Тиймээс өвдсөн зовсон, яарсан сандарсан бүхэн л Х.Цэнд-Аюуш эмчид ханддаг, тэр бүрт Х.Цэнд-Аюуш эмч тус дэм болдог байсныг өнөөдөр ч дурсан ярих хүмүүс олон байна. Хөвсгөл аймагт 1980-аад оны үед хүүхдийн

өвчлөл нэмэгдэж, маш хүнд амьсгалын замын өвчин дэлгэрч, эндсэн хүүхдүүдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байсан учраас аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга нар Х.Цэнд-Аюуш эмчийг Хүүхдийн тасагт очиж ажиллах үүрэг өгч байжээ. Х.Цэнд-Аюуш эмч хүүхдийн тасагт ажиллах богино хугацаандаа хүүхдийн эндэгдлийг 50 хувиар бууруулж чадсан юм. Тэрээр Хөвсгөл аймагт анх удаа Хүүхдийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасгийг байгуулж, эрхлэгчээр ажиллаж байсан юм. Мөн үүний зэрэгцээ Б.Цэнд-Аюуш эмч “Залуучуудын гавшгайч бригад” байгуулж, залуу эмч нарт “Ходоодонд хаймсгуур тавьж, шингэн сэлбэх арга”, “Захын судсанд гуурс тавьж



эмчлэх”, “Эгэмний доорх хураагуур судсанд гуурс тавих арга” зэрэг олон зүйлийг зааж сургаж, мэддэг чаддаг бүхнээ хуваалцаж явсан гавьяатай. Монголын эмч нараас “Сельдингерийн гуурс” тавих ажилбарыг орон нутагт анх удаа хийсэн Х.Цэнд-Аюуш эмчийг өнөөдөр ч багшаа гэж дурсдаг олон хүн бий. Олон зуун хүнийг үхэл зовлон, хагацал шаналлаас аварч чадсан энэ алтан гартай эмч шарын комд орж, амьсгал зогссон залууг хүртэл эдгээж байсан гэдэг. Багаар ажиллах, хамтарч асарч сувилах, хүнд хүнлэг байдлаар хандах ёстой гэдгийг олон хүнд үлгэрлэн үзүүлж чадсан энэ эмч төрөл бүрийн авьяастай, хамт олноо манлайлж чаддаг нэгэн байсан юм. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн орлогч дарга, хүүхдийн сэхээн амьдруулах тасгийн эрхлэгч, эмчлэгч эмч, дотрын тасгийн эмч, мэс заслын эмчээр ажиллаж байсан энэ хүн ажлынхаа хажуугаар эмнэлгийн МАХН-ын хороог удирдаж, 1984-1987 онуудад Нэгдсэн эмнэлгийн цусны тасгийн их эмчийн ажлыг хавсран гүйцэтгэж, тасаг нэгжүүдийг цус, цусан бүтээгдэхүүнээр хангаж ажиллаж байв. Эзэмшсэн мэргэжилдээ чадварлаг, өвчтөнүүдэд яг л өөрийн ах дүү, аав, ээж, үр хүүхэд мэт хандаж, бүхий л сэтгэл зүрхнээрээ хүнд туслахыг хичээдэг байснаараа Х.Цэнд-Аюуш эмч бусад эмч нараас ялгаатай. Тийм ч учраас түүнийг зорьж ирэх хүмүүсийн тоо хэзээ ч буурдаггүй байж. Тэрээр хөдөөний дуудлагад байнга явна, мэс засалд орно, сэхээн амьдруулах тасгуудад үзлэг хийнэ гээд асар их ачаалалтай ажиллана. Гэртээ ирж хэдхэн цаг амрахдаа ч сэтгэл тайван сууна гэж үгүй. Х.Цэнд-Аюуш эмчийн гэрийн утас байнга дуугарч, тусламж дэмжлэг хүссэн хүмүүс, зөвлөгөө авах гэсэн өвчтнүүд, яаралтай хагалгаа, хүнд өвчтний тухай мэдээ тасралтгүй ирж байна. Тэр бүхэнд Х.Цэнд-Аюуш эмч хэзээ ч төвөгшөөж хойш сууж байсангүй. Х.Цэнд-Аюуш эмч арван жилийн нэг ангид сурч байсан С.Эрдэнэсүрэн хэмээх бүсгүйтэй ханилж, гурван сайхан хүү төрүүлж өсгөжээ. Аймгийн хөдөлмөрийн аваргаар хоёр удаа шалгарч, хамт олноо

үргэлж манлайлж, Эрүүл мэндийн яамны хүндэт жуухаар шагнуулж явсан Х.Цэнд-Аюуш эмч Хөвсгөл аймагт анхны уламжлалт анагаах ухааны хувийн эмнэлгийг байгуулсан юм. Гэвч харамсалтай нь тэрээр 37-хон настайдаа хорвоогоос зуурдаар буцсан юм. Нийгэм задарч, зах зээлд шилжээд удаагүй байсан хүнд цаг үед, цэл залуухан хүүгээ алдсан Б.Хаянхярваа гуай тухайн үед 73 настай байсан ч хагацал зовлонгийн өмнө бууж өгөхийг хүссэнгүй. Өнчирч хоцорсон гурван балчир ач, хагацал үзсэн бэр охиныхоо өмөг түшиг болон тэрээр амь, амьдралын төлөө зүтгэж, тэмцэж эхэлжээ. Тэтгэврийн цөөн төгрөгөө бүхий л зүйлд хүргэж, амины хэдэн малаа өсгөж үржүүлж, гурван ач хүүгээ тэр хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзганд хүргэж чадсан. Хамгийн гол нь амьдрал хэмээх энгүй их далайд гурван ач хүүгээ хөл алдахааргүй ухааны бядтай, хүний итгэл даахаар сэтгэлийн хаттай, хүсэл хясал дүүрэн орчлонг туулах оюуны цартай хүмүүс болгож өсгөж хүмүүжүүлсэн. Х.Цэнд-Аюуш эмчийн том хүү Ц.Цэцэнзориг аавыгаа өөд болоход дөнгөж л арван гурван настай байжээ. Ээждээ дэм, өвөөдөө тус болох, аавынхаа хийж амжаагүй бүхнийг гүйцээх хүслээр дүүрэн байсан хүү 1994 онд аравдугаар ангиа төгсөөд Анагаах ухааны Их сургуулийн эмчилгээний ангийн хуваарь авчээ. Гэвч амьдралын ачаанаас үүрэлцэх үүрэг хүлээсэн айлын том хүү дүү нараа сургах, өөрөө ч сурах гээд олон асуудлыг шийдэх хэрэгтэй болжээ. Тэрээр сургуулиасаа түр чөлөө авч Солонгост жил гаруй ажиллаад эргэж ирсэн аж. Тэндээс бүтээн байгуулалт хийх ёстойг, хүн бүр хөдөлмөрлөж, тэрхүү хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх ёстой юм байна гэдгийг ойлгож, басхүү өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа монголын нийгмийн байдлыг анзаарч харсан залуу хүү сургуульдаа сурч, сурахын хажуугаар аялал жуулчлалын компани байгуулж, хэвлэлийн компани ажиллуулж байж. Тэрээр 2000 онд Анагаах ухааны эрүүл мэндийн их сургуулийн ерөнхий эмчилгээний ангийг төгссөн байна. Сургуулиа төгссөний дараахан Ц.Цэцэнзоригт “Green resource” нэртэй хувийн компани байгуулж, барилга, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж эхлэжээ. Тус компани өнөөдөр 200 гаруй ажилтантай, барилга, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж, нарийн ногоо, хүлэмжийн аж ахуй эрхэлдэг. “Green resource” компани байгуулагдсан цагаасаа хойш 200 гаруй мянган метр квадрат барилгын ажил угсарч, 1000 гаруй айлын орон сууц барьж, улсын хөрөнгө оруулалттай томоохон бүтээн байгуулалтын ажилд ч гар бие оролцож яваа. Хэдийгээр Ц.Цэцэнзоригт аавынхаа мэргэжлийг өвлөж, эмчээр ажиллаагүй ч гэсэн эцэг өвгөдийнхөө нутагт юм хийж бүтээх юмсан гэсэн хүсэл дүүрэн явдаг цөөхөн залуучуудын нэг. Тэрээр хоёр дүүтэйгээ хамтарч аймгийн эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийн дунд шинэ санаа, шинэ мэдлэг онол практикийн бага хурлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, эмч ажилчдыг

урамшуулдаг. Энэхүү уралдаанд оролцохын тулд эмч нар асар их хэмжээний судлагаа хийж, илтгэл бэлтгэж, тэдний хийсэн бүтээлүүд ном болон гарч, бусдад мөн мэдлэг түгээж байна. Ц.Цэцэнзоригт МАН-ын намын бага хурлын гишүүн. Үүний зэрэгцээ аймаг орон нутагт ажиллаж байгаа залуучуудаа байнга дэмжин ажиллаж чаддаг. Тэрээр 2013 онд Хөвсгөл аймагт “Нутгийн бахархалын ордон” барихаар зориг шулуудаж, найз нөхдийн хамт судалгаа хийж, зураг төслийг нь бэлэн болгон, шавыг нь тавьжээ. “Нутгийн бахархалын ордон” нь спорт сургалтын цогцолбор төв, гэрлэх ёслолын танхим, кофе shop, томоохон үзвэр үйлчилгээ хурлын танхим, хүлээн авалтын танхим, зочид буудал, Мөрөн хотыг тольдох цамхаг, орон нутгийн онцлогийг харуулсан үзэсгэлэнгийн танхим, худалдаа үйлчилгээний танхим зэрэг олон хэсэгтэй, орчин үеийн хийц, загвартай, томоохон бүтээн байгуулалтын ажил болох юм. Өвөөгийнхөө итгэлийг дааж, аавынхаа нэрийг өргөж яваа Ц.Цэцэнзоригт хэмээх энэ залууг Төмөрбулагчууд онцолж, “2014 оны Шилдэг залуу”-гаар шалгаруулан өргөмжлөл гардуулжээ. Өөртөө итгэлтэй бусдыг ч араасаа дагуулж үлгэрлэж чаддаг энэ л залуугийн гурван үеийн түүхээс сөхөж эрхэм танд хүргэлээ.

Цаг эрт байна. Юуны ч өмнө шантарч нугараагүй, хөдөлмөр бүтээл хүнлэг чанараараа олондоо танигдсан сайн өвөөгийн, сайхан эцгийн нэрийг өргөж, төрж өссөн Хөвсгөл нутаг, Төмөрбулаг сумынхаа төлөө энэ залуу илүү олон сайхан зүйл бүтээж, ирж яваа он цаг Цэнд-Аюушийн Цэцэнзоригт хэмээх энэ залуугийн тухай илүү сайхан мэдээллүүдийг та бидэнд дуулгана гэдэгт итгэж байна.

## ТҮҮХЧДИЙН БАГШ

**Х**өвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутагт 200 гаруй жилийн түүхтэй, 15 сүм дуган, 3 суварга, маанийн 20 гаруй том хүрд, 16 жасын байшингууд, ном барлах бархан, лам хуваргуудын суух 200 гаруй хашаа байшин бүхий томхон хүрээ саяхан хүртэл оршин байсныг бид мэднэ. Хэдэн зуунаар тоологдох он цаг дамнан эрдэмтэн мэргэдийн номын буян шингэсэн энэ л газраас олон арван эрдэмтэн мэргэд төрж гарсны нэг нь доктор, профессор С.Пүрэвжав. Номын авшиг шингэсэн Бүгсийн хүрээнд шавилан сууж байсан Сундуйн Пүрэвжав хэмээх энэ хүмүүн 1922 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Тал булагын бэлчир хэмээх газар мэндэлжээ. Арав орчим насандаа Бүгсийн хүрээнд шавилан сууж байх үед нь эсэргүү бослого хөдөлгөөн гарч, сүм дуган хаагджээ. Төвд ном үзэж, бурхан багшийн сургаал цээжилж суусан жаахан хүү цагийн аясыг даган сүм хийдээ ч орхихоос өөр аргагүйд хүрчээ. Тэрээр хүрээ хийдээ орхин, гэрийн сургалтаар бичиг үсэгт тайлагдаж, Төмөрбулаг суманд байгуулагдсан анхны тэнхимд суралцаж, эрдэм номын мөр хөөх их үйлсийн аянд гарчээ. Улаанбаатар хотод ирж, соёл гэгээрлийн байгууллагад ажиллаж байгаад 1945 онд МУИС-д элсэж орж, 1949 онд түүхийн багш мэргэжил эзэмшин, их сургуулийг онц дүнтэй төгсөж, сургуульдаа багшлах томилолт авч байсан гэдэг. Балчир бага насандаа Бүгсийн хүрээнд шавилж, эрдэмтэн багш нар нь эсэргүү болон баригдаж явахыг нүдээрээ харж байсан залуу эрдэмтэн энэ цагаас эхлэн судлагаа, шинжилгээний ажилд ханцуй шамлан оржээ. Тэрээр “БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь” хэмээх нилээд хатуухан сэдэв сонгон авч, 1952 онд түүхийн ухааны дэд эрдэмтний зэргийг Зөвлөлт холбоот улсад хамгаалжээ. Хэлмэгдүүлэлтийн их шуурганд өртөж зовж шаналсан олны унагасан нулимс эгшиж амжаагүй шахам байхад, Монголчуудын шашин шүтлэг, өв уламжлагдсан соёлын ул мөрийг бүрэн устгахыг санаархаж байсан орос ах нарын хэнээрхэл дарагдаагүй байхад тэрээр тун зоригтой алхам хийж, энэ сэдвийг барьж авсан хэмээн түүний үеийнхэн ярьдаг юм билээ. Шашин шүтлэгийг гаж буруу зүйл мэт хардаг, ярьдаг хүнд цаг үе байсан ч тэрээр судлагааны ажлаа орхиогүй. 1984 онд Зөвлөлт холбоот улсын дорно дахины хүрээлэнд “16-20 зууны үеийн Монгол дахь шарын шашины хүрээ хийдийн түүх” сэдвээр түүхийн шинжлэх ухааны





докторын зэрэг хамгаалжээ. Шарын шашныг устгах нэрээр монголчуудын өв соёл, ном судар, асар их барилга байгууламж устаж алга болж байсан учраас тэрээр энэ сэдвийг сонгож авсан хэрэг. Үнэндээ ч шашин, сүм хийдүүдийн талаарх мэдээллийг С.Пүрэвжав докторын энэ судлагааны ажил бүрэн хадгалж үлдэж чадсан юм. Тэрээр 1970 онд доцент, 1989 онд профессор цол хүртжээ. Монгол улсын Их сургуульд багш, тэнхимийн эрхлэгч, Шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэнд тасаг, хэлтсийн эрхлэгч, ЦБДС-д тэнхимийн эрхлэгчээр олон арван жил ажилласан энэ эрдэмтэн хэдэн зуугаар тоологдох шавь нартай. Үүнээс гадна тэрээр Ерөнхий боловсролын сургуулийн 5-р ангид үздэг “Эртний дэлхий дахины түүх” 7-р ангид үздэг “Шинэ түүх” гэх мэт сурах бичгүүдийг зохиожээ. Түүний зохиосон сурах бичгүүд нэгэн үеийн Монголчуудын гараас гарт дамжин хадгалагдаж, өнөөдөр ч үнэ цэнээ алдаагүй л байна. Тэрээр үүнээс гадна 10 гаруй нэг сэдэвт судлагааны бүтээл бичиж ном болгон хэвлүүлж 100 гаруй судлагааны өгүүлэл бичин дотоод гадаадын хэвлэлд нийтлүүлжээ. Их түүхийн жим дагаж, эрэл хайгуул судлагаа шинжилгээний ажилд цөхрөлтгүй зүтгэж явсан энэ хүмүүн хотогойдуудын тухай судлаж, сурвалжилж, тэмдэглэн үлдээсэн байх юм. “Хотогойдуудын угсаа гарал ба түүхийн асуудалд” хэмээх судлагааны ажлыг хийхийн тулд ямар их хичээл зүтгэл гаргаж байсныг шавь нар нь дурсан ярьж байсан юм. 1967 онд Октябрийн хувьсгалын 50 жилийн ойг тохиолдуулан Ленинград хотод социалист орнуудын оюутан залуучуудын эрдэм шинжилгээний хуралд оролцох залуучуудыг С.Пүрэвжав багш ахлаж авч явсан гэнэ. Ленинград хотод очсон цагаасаа эхлэн С.Пүрэвжав багш тус хотын “Дом ученых” хэмээх номын санд өдөр шөнөгүй сууж, судлагаа, шинжилгээний ажил хийж байжээ. Түүнтэй хамт явсан Бүдрагчаагийн Даш-Ёндон “Багшаа та ядарч уналаа. Номуудыг нь гуйгаад ир. Бид орчуулж чадахгүй ч гэсэн хуулаад өгье” гэж хэлжээ. Тэр үед одоогийнх шиг хуулагч, хувилагч машин байсангүй. Гэвч С.Пүрэвжав багш шөнө дөл болтол сууж, номын санчдыг гуйн хонох шахан ажиллаж байж өөрт хэрэгтэй мэдээллүүдээ цуглуулж авч байжээ. Үүний үр дүнд “Хотогойдуудын угсаа гарал ба түүхийн асуудалд” хэмээх бүтээл төрж гарсан түүхтэй. С.Пүрэвжав багш олон зуун эрдэмтэн шавь нартай. Тэдний нэг нь Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Бүдрагчаагийн Даш-Ёндон. Тэрээр багшийнхаа тухай “Эрдэмтэн хүн яаж ажиллаж, яаж судлагаа шинжилгээгээ хийх ёстой юм бэ гэдгийг багш маань бидэнд “амьдаар нь үзүүлдэг хүн байсан” хэмээн дурсжээ. Түүх судлана гэдэг амаргүй. Хүний амьдрал, нийгмийн үйл явцыг цаг хугацаа, орчинтой нь уялдуулан задлан шинжилж, үр дагавар, нөхцөл, харилцаа холбоо зэргийг судлан үлдээхийг чармайж, олон арван бүтээлээ бидэнд өв хөрөнгө болгон өгсөн энэ л түүхчийн тухай намтар түүх харамсалтай нь өнөөдөр тун бүдэгхэн байна. Харин Монголын түүхчдийн багш болсон энэ хүний шавь нар Монголын түүхийг бичилцэж явна.

## ТЭНГЭРИЙН ХОЛБООЧИН

Өдгөө бурхны оронд заларч байгаа ч гэсэн Монголын харилцаа холбооны түүхийн нэгэн хуудсыг нээж, ур чадвар, мэдлэг боловсролоороо тэргүүлж явсан энэ хүний тухай бичихгүй байхын аргагүй. Д.Эрдэнэбат 1962 онд тухайн үеийн Төмөрбулаг сумыг удирдаж явсан дарга нарын нэг Дамдиндорж хэмээх айлд мэндэлжээ. Түүний аав Дамдиндорж, сумын намын үүрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан бөгөөд хүүг төрсний дараахан Жаргал сум руу нэгдлийн даргаар томилогдож байсан гэдэг. Д.Эрдэнэбат 1980 онд аравдугаар ангиа төгсөж, Чехийн Жилина хотод зохион бүтээгч инженерийн ангийн хуваарь авч байжээ. Чехэд шилдэг оюутнуудын нэгд тооцогддог байсан оюутан залуу сургуулиа төгсөж ирээд Төв хорооны сайд нарын зөвлөлийн харьяанд Техник засварлах үйлдвэрийн хэлтэст ажиллаж байжээ. Газар тариалангийн техник, жижиг оврын трактор угсрах чиглэлээр байгуулагдсан энэ том албанд тэрээр зохион бүтээгч инженерээр ажиллаж байсан юм. Гэхдээ зохион бүтээгч инженер болохын тулд монтер хийж, засварчнаар ажиллаж байсан гэдэг. Байнга өөрийгөө хөгжүүлж, мэдлэг боловсролоо дээшлүүлэхийг чухалчилж байсан залуу инженер ажлынхаа хажуугаар МУИС-ийн англи хэлний ангид хоёр жил сурчээ. 1989 онд тэрээр Худалдаа үйлдвэрийн яаманд бүх төрлийн сав, баглаа боодол үйлдвэрлэх чиглэлээр ажиллах, эдийн засгийн судлагааны багт оржээ. Гадаадад сургууль төгссөн, англи хэлний мэдлэгтэй, ажилдаа сайн, хүнтэй нийцтэй харьцаж, баг болон хамтарч ажиллаж чаддаг энэ залууд дэлхийд алдартай Самсунг компани ажлын санал тавьж, тэрээр 1990-1993 онд Солонгосын Самсунг корпорацийн Монгол дахь төлөөлөгчөөр ажиллаж эхэлжээ. Зүү тариур дутагдалтай, эмнэлгийн тоног төхөөрөмж тааруу, ариутгал хангалтгүйн улмаас иргэд шприцний шараар өвдөж, элгэний вирус авах нь түгээмэл байсан цаг. Тэг үед нэг тариа хийх гэж зүү тариураа хэдэн цаг буцалгадаг. Тарианы зүү ховор, олон удаа тарилга хийсээр мохсон зүү, буцалгасаар байгаад шарласан тариур үнэндээ аюулын харанга дэлдэж байлаа. Тиймээс монголчууд нэг удаагийн зүү тариур үйлдвэрлэхээр



судалгааны ажил хийж, Эрүүл мэндийн сайдаар толгойлуулсан комисс гарч, ажлаа эхэлсэн боловч хөрөнгө мөнгөний асуудлаас болж хэрэгжиж чадалгүй зогсч байсан түүхтэй. Монголын эрүүл мэндийн салбарт ёстой л нөгөө шүдний өвчин болж хувираад байсан зүү тариур үйлдвэрлэх асуудлыг шийдэхэд Д.Эрдэнэбат том хувь нэмрээ оруулсан юм. Нэг удаагийн зүү тариурын үйлдвэр байгуулах төслийг Самсунг корпораци хэрэгжүүлэх болж, Д.Эрдэнэбат Солонгосын хөрөнгө оруулагч талыг төлөөлөн гэрээн дээр гарын үсэг зурж байжээ. Үүний ачаар 1990 онд “Монсам” үйлдвэр нээгдэж, Монголын эрүүл мэндийн салбар дэлхийн түвшинд хүрсэн баталгаат зүү тариураар үйлчилдэг болж чадсан юм. Үүнээс гадна тэрээр Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажиллах, шинэ төсөл хөтөлбөр боловсруулах ажилд хамаг анхаарлаа зориулж байсан гэдэг. Тэрээр 1993 онд “Эрдэнэт” үйлдвэр, Солонгосын “Самсунг” корпорацийн хамтарсан “Эрдсам” ХХК-ийг байгуулж, “Самсунг” гэдэг энэ том компанийг төлөөлөн менежерээр нь ажиллаж байлаа. Монголд хөрөнгө оруулах, Солонгосын аж ахуй, нэгж, үйлдвэр худалдааны байгууллагуудын менежментийг судлах зорилгоор байгуулагдсан энэ компани төрийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг “Самсунг”-ийн хөрөнгөөр зохион байгуулж, Солонгост үйлдвэрлэсэн үнэ хямд басхүү түлш шатахуун бага зарцуулдаг машинуудыг Монголд олон тоогоор оруулж ирж, “Самсунг”-ийн гэр ахуйн болон цахилгаан тоног төхөөрөмжийг худалдаалж, Монголоос зэсийн баяжмал, алт, ноолуур, үхрийн шир Солонгос руу экспортолж байжээ. Зах зээлд шилжээд удаагүй, оросоос орж ирдэг бараа бүтээгдэхүүн хумигдаж, хятадын чанар муутай өртөг өндөртэй бараанд хамаг байдаг мөнгөө барж байсан хүнд цаг үед түүний хэрэгжүүлсэн энэ төсөл монголчуудад үр өгөөжөө өгч чадсан гэдэгтэй хэн ч маргахгүй нь лавтай. Д.Эрдэнэбат захирал “Богд импекс” нэртэй хувийн компани байгуулан хувийн хэвшилд ажиллаж байх үед буюу 1996 онд түүнийг Монголын цахилгаан холбооны компанийн хангамж эрхэлсэн захирлаар томилжээ. Тэрээр картын таксофоны үйлчилгээг нэвтрүүлж, энэ байгууллагыг Ази Номхон Далайн Сансрын Холбооны Зөвлөлд гишүүнээр элсүүлэх ажилд хүчин зүтгэж байлаа. Түүнийг Цахилгаан холбоо компанийн удирдлагад ажиллаж байх үед манай харилцаа холбооны салбар шинэ түвшинд гарч, Умард болон баруун чиглэлийн аналог системийн радио релейний системийг сольж, 900 км урт тоон радио релейний системийг шинээр байгуулж, Интелсаттай ашиглалтын гэрээ байгуулж, радио релейний дахин дамжуулах 24 станц дээр нарны эрчим хүчний систем суурилуулсан юм. Харилцаа холбооны салбарт ажиллаж өөрийн гэсэн туршлага хуримтлуулсан энэ эрхэм 1999 онд Монголд үүрэн холбооны хоёрдагч оператор шалгаруулах тендерт оролцон, солонгосчуудын хөрөнгө оруулалттай Скайтел компанийг байгуулж байсан түүхтэй. Тэрээр хөдөлгөөнт холбооны хамгийн орчин үеийн “CDMA200 1x” системийн сүлжээг орон даяар нэвтрүүлж өндөр хурдын интернэт, олон төрлийн нэмэлт үйлчилгээг шинээр ашиглах боломжийг хэрэглэгчдэд олгож, харилцаа холбооны салбарт шинэ өөрчлөлт хийж чадсан. Гар утсыг зөвхөн мөнгөтэй хүмүүс л барьдаг, төлбөр нь хэтэрхий өндөр, тансаг хэрэглээ гэж нэрлэгдэж байсан үед Д.Эрдэнэбат захирал “Гар

утас бол гангараа биш харин хэрэглээ” гэдгийг монголчуудад ойлгуулахын тулд ярианы хямд төлбөрийн системийг бий болгож, басхүү хямд үнэтэй гар утас оруулж ирж, хэрэглэгчиддээ хүргэж байлаа. Үнэхээр ч түүний хүсэж байснаар гар утас өнөөдөр гангараа биш хэрэглээ болж чаджээ. Өнөөдөр бидний дунд Дамдиндоржийн Эрдэнэбат хэмээх энэ хүн алга. Гэхдээ түүний үүсгэн байгуулсан Скайтел компани 100 хувь монголчуудын хөрөнгө оруулалттай компани болж, Үүрэн холбооны оператор компаниуд дундаас өөрийн өвөрмөц дүр төрх, үндэсний гэсэн тодотголоороо бусдаас ялгарч, салбарынхаа хөгжил дэвшилд байнгын хувь нэмрээ оруулж, технологийн шинэчлэлийг үргэлж хийж, ухаалаг хэрэглээг хүн бүрт хүргэдэг том групп компани болжээ. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх, тус салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, техник технологийн өргөтгөл шинэчлэл, гадаадын зээл тусламжийн төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж байсан энэ хүний хөдөлмөр зүтгэлийг Монголын төр төр үнэлж, “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнажээ. Түүнтэй Төмөрбулаг сумын 80 жилийн ойн баярын өмнөхөн уулзаж байж билээ. “Энэ жил ажил ихтэй, нутгийнхаа ойд оролцож амжихгүй нь дээ” хэмээн ярьж, ойн ажилд хөрөнгө мөнгөний туслалцаа үзүүлж байсан энэ хүн түүнээс хойш удалгүй бурхны орноо залагдсан. Гэхдээ түүний үүсгэн байгуулсан бүхий л ажил өнөөдөр үргэлжилж, өнгөтэй өөдтэй яваа.

## ШИЛЭН ТҮРИЙВЧНИЙ “ЭЗЭН”

Төмөрбулаг сумын Жаргалантын голын хөвөөнөө бага насаа өнгөрүүлж, эрдмийн аянд, мордож, амьдралын зах руу хөл тавьсан мянга, мянган залуучуудын нэг нь Доржпаламын Батчулуун. Түүний аав Төмөрбулаг сумын Бүгдгээний голын хүн. Цэргээс халагдаж, сумынхаа нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Доржпалам гуай сумынхаа Ардын хянан шалгах хороонд насаараа ажилласан нэгэн. Д.Батчулуун одоогийн ШУТИС-ийг 1989 онд Холбооны инженер мэргэжлээр төгсчээ. Сургуулиа төгсөөд хоёр жил Дорнод аймгийн Радио станцад ерөнхий инженерээр ажилласан залуу мэргэжилтэн 1990 онд Улаанбаатар хотод ирж, Цахилгаан холбоо компанид гол шугамын инженерээр ажиллаж байжээ. Тэрээр Германд магистр хамгаалсан Монголын анхны холбоочдын нэг. Хол газар сурч, эрдэм өвөртлөж, магистр хамгаалж ирсэн залуухан инженер Монголын харилцаа холбооны салбарт цоо шинэ зүйлийг хийж чадсан. Тухайн үед Улаанбаатар хотын иргэд ч аймаг сум руу ярихын тулд холбооны салбар дээр очиж дугаарладаг, хотоос аймаг руу, аймгаас сум руу холбогдож байж ярьдаг байлаа. Нэг нэгэнтэйгээ мэнд мэдэхийн тулд захиалга өгч, бөөн оочер дугаар, явдал чирэгдэл болдог байсан үе. Үүнийг өөрчлөхийн тулд монгол инженерүүд цөхрөлтгүй ажиллаж байсны нэг нь Д.Батчулуун. Оросын хиймэл дагуул хэт өндөрт байрладаг, нарийн зурвастай, асар өндөр өртөгтэй байсан учраас тэд Япон, Герман, Франц, Хятадуугай холбоо тогтоож, Японы хиймэл дагуулыг ашиглан харилцаа холбооны салбарт шинэчлэл хийж чаджээ. Тэдний энэ ажил амьдрал дээр ч үр өгөөжөө өгч, харилцаа холбоо шинэ түвшинд гарч чадсан хэрэг. Д.Батчулуун хувийн хэвшлийн салбарт ч амжилт олж чадсан. Тэрээр Монголын анхны хувийн кабелийн телевизүүдийн нэг болох “Хийморь” кабелийн телевизийг байгуулж, японоос туршлага судлаж, “Монгол шат” нэртэй цахилгаан шатны компанийг ч хөл дээр нь босгож эхэлжээ. Мөн тэрээр “Монгол буга” нэртэй бугын сангийн аж ахуйг байгуулсан. Ямар ч үр ашиггүй, үнэтэй тэжээл иддэг буга тэжээдэг хэмээн зарим нь түүнийг шүүмжилж байсан ч Д.Батчулуун хангайн сайхан амьтныг хамгаалах өсгөж үржүүлэх энэ ажлаасаа буцаагүй юм. Хустайн нуруунд бугаа үржүүлсээр л байгаа.

Хувийн хэвшлийн салбарт олон жил ажиллаж, бизнесээ хөл дээр босгож чадсан Д.Батчулууныг 2013 онд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эдийн Засаг Хөгжлийн тэргүүн проректороор томилсон нь жинхэнэ нүдээ олсон томилгоо байлаа. Иноваци ба дээд боловсрол сэдвээр докторын зэрэг хамгаалсан энэ залуу албан ажлаа хүлээж авангуутаа “ШУТИС-ийг шилэн түрийвчтэй болгоно” хэмээн зарласан нь тухайн үедээ л багагүй дуулиан тарив. Боловсролын салбар мэддэггүй бизнесийн хүн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эдийн Засаг Хөгжлийн



тэргүүн проректороор ирлээ гэж шүүмжлэх хүн ч цөөнгүй байсан. Гэвч тэрээр шантраагүй. ШУТИС-ийн нийт орлогын 76,4 хувь нь зөвхөн сургалтын төлбөрөөс санхүүждэг. Нийт орлогын 56,4 хувь цалин хөлсөнд нь зарцуулагддаг. Хөрөнгө мөнгөний гачаалаас болж сургалтын баазаа ч өөрчилж шинэчлээгүй сургуулийн хаалгаар ороод л тэр үнэхээр гайхсан гэдэг. Өөрийг нь оюутан байхад л байсан цайны газар, багш шавийн нэгэн хэвийн харилцаа, хуучин сургалтын бааз суурийг өөрчлөхийг тэр зорьж байлаа. Эдийн Засаг Хөгжлийн тэргүүн проректор гэдэг энэ албыг

авсны дараахан Солонгосын техникийн их сургуульд тэр томилолтоор ажиллажээ. Солонгосчууд шинэ захиралд найр тавьж, багагүй хэмжээний мөнгө бэлэглэхэд Д.Батчулуун татгалзсан хариулт өгч, “Энэ мөнгөнийхөө оронд манай сургууль дээр оюутны цайны газар байгуулаад өг” хэмээн шууд л тулгасан гэдэг. Үүний үр дүнд ШУТИС өнөөдөр Монголд байхгүй тохилог оюутны зоогийн газартай болж чаджээ. Оюутнуудын сургалтын төлбөрт цугласан 40 гаруй тэрбум төгрөгийг арилжааны банкуудад сарын 0.2 хувийн хүүтэй хадгалж байсныг ч тэр хүчтэй шүүмжилсэн. Арилжааны банкуудад албан бичиг илгээж, сургалтын төлбөрийн хүүг өөрчлөх санал тавьжээ. Хуучин захирлууд нь эсэргүүцэж, зарим нь мөнгө угаах гэж байна хэмээн хардаж, багагүй хэл үг хийсэн. Гэвч үүний үр дүнд гэхэд л сургалтын төлбөрийн хүүнээс 1.6 тэрбум төгрөг ШУТИС-ийн дансанд орж иржээ. Тэрээр хэлсэндээ хүрсэн. ШУТИС үнэхээр ч шилэн түрийвчтэй болж чадсан. Өмнө нь сургалтын төлбөр хаана байгааг, хэн ямар мөнгийг яаж зарцуулж байсныг хэн ч мэддэггүй байсан бол Д.Батчулуун үүнийг өөрчилж, санхүүгийн тайлан бланс нийтэд ил тод байх зарчмыг гаргаж иржээ. Түүний шилэн түрийвч төслийг дуу нэгтэйгээр дэмжсэн хүмүүсийн нэг нь МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж. ШУТИС дээр ирж, “Шилэн түрийвч” төсөлтэй танилцсныхаа дараахан Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу шинэчлэлийн Засгийн газарт чиглэл өгөх тухай зарлигт гарын үсэг зурсан юм. Монгол төрийн тэргүүн “Шилэн данс” тогтолцоонд шилжихийг Засгийн газарт даалгасан хэрэг. Ингэснээр тухайн байгууллагын дансны бүх гүйлгээ олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болно гэсэн үг. Энэ өөрчлөлтийн дагуу татвар төлөгчдийн мөнгө болох төсвийн зарцуулалтанд хяналт тавих гарч гарч, эдийн засгийн

хувьсгал гарах гарцыг нээлээ гэж олон хүн баярлаж байгаа. ШУТИС-ийн Эдийн Засаг Хөгжлийн тэргүүн проректорын “Шилэн түрийвч” төсөл Монгол төрийн бодлогод “Шилэн данс” хэмээн туссан нь энэ. Д.Батчулуун проректор боловсролын гол тулах багана болох багш нараа чадавхижуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдэхэд онцгой анхаарч байгаа. Өнгөрсөн намар 180 багшийг орон сууцтай болгосон бол 800 гаруй багш удахгүй ашиглалтанд орох орон сууцандаа орохоор хүлээж байгаа гэнэ. ШУТИС бол монголын инжнерүүд, эрдэмтэн мэргэдийн өлгий болсон сургууль. Энэ сургуулийн эрдэмтэд асар олон зүйл бүтээж, хийж байгаа ч түүнийхээ үр шимийг хүртэж чадахгүй үлддэг. Үүнийг ч Д.Батулуун проректор өөрчилөхөөр зоригтой хөдөлсөн. ШУТИС-ийн ҮТДС, Нэхмэлийн хүрээлэнгийн профессор, доктор Р.Мядагмаа хонины ноосоор хийсэн даавуун материалыг нано технологийн аргаар боловсруулан нэгэн төрлийн даавуу гарган авчээ. Тэрбээр энэ бүтээгдэхүүнийхээ судалгааны ажлыг Герман улсад сурч байхдаа хийсэн юм байна. Нано аргаар гаргаж авсан уг даавуу нь илжирдэггүй, наранд гандаж өнгөө алддаггүй сайн талтай, гадаадын эрдэмтдийн анхаарлыг татсан бүтээл болж чаджээ. Тиймээс Д.Батулуун проректор түүний бүтээлийг дэмжиж, 800 гаруй сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч, “Эрдэнэт хивс” компанитай гэрээ байгуулж, ус, чийг шингээдэггүй, үжирч, урагддаггүй нано даавууны үйлдвэр байгуулаад байгаа гэнэ. Энэ үйлдвэрийн бүтээгдэхүүн иргэдэд хэрэгтэй, эдийн засагт нэмэртэй. Энэ үйлдвэр байгуулагдснаар “Эрдэнэт хивс” компани ч ашиг олно. ШУТИС-д ч үр өгөөжөө өгнө. Олон арван жил эрдмийн ажил хийсэн багш нар ч бүтээлээ үнэлүүлэх давхар боломжтой болж байгаа. Хамгийн гол нь Монголчуудын хонины ноосоор хийсэн өнгө үзэмжээ алдахгүй, цоорч, элэгдэж урагдахгүй даавуу дэлхийд нэртэй брэнд бүтээгдэхүүн болохыг ч үгүйсгэхгүй юм. Энэ талаараа Д.Батчулуун захирал “Судалгааны үр дүн бизнес болж, тэр нь эргээд судалгаагаа дэмжих механизм бүрдэх учиртай” гэж ярьж байсан. Монголын баялаг монгол хүн юм. Дуусашгүй ундрах тэр их баялаг бол бидний оюун ухаан, сэтгэн бодох чадвар, сурсан эрдэм мэдлэг юм хэмээн бахархан ярьдаг Д.Батчулуун проректор боловсролын салбарт асар том өөрчлөлт хийхээр зориг шулуудаад байгаа. Тэрээр 21 аймагт сурагчдийг бэлтгэж, аймаг бүрээс 100 шилдэг инженер бэлтгэх том зорилго өмнөө тавиад ажиллаж байна. Өсвөр үеийнхнийг техник, технологид дуртай болгох ажлуудыг мэдээллийн хэрэгсэлүүд, интернэт ашиглан өргөн хүрээнд таниулж, математик, физик, хими, биологийн сургалтуудыг зайны сургалтаар зохион байгуулах төлөвлөгөө гаргажээ. Д.Батчулуун захирлын санаачилгаар хэрэгжиж буй энэ хөтөлбөрийн нэр нь “1+99”. Энэ хөтөлбөрт нийтдээ 3000 хүүхдийг хамруулах бөгөөд Монголын ирээдүйг гартаа атгаж, хөгжлийг манлайлж, эрдэм мэдлэгээрээ гайхуулсан шилдэг залуус эх орныхоо ирээдүйг цаашид авч явна гэдэгт, Шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжлийн эрин үед дэлхийн зах зээлд амжилт гаргах мэргэжилтнүүд Монголоос төрж гарна гэдэгт Д.Батчулуун захирал итгэлтэй байгаа.

## АЯНЫ ЖОЛООГ ӨРГӨЖ ЯВАА ХҮН



“Аяны жолоо” компани... Энэ нэрийг Хөвсгөлчүүд андахгүй. Харин Хөвсгөлчүүдийн тухай мэдэхгүй хүн энэ нэрийг сонсоод ямар нэгэн тээврийн компани хэмээн ойлгох нь бий. Үнэндээ “Аяны жолоо” хэмээх энэ нэр Хөвсгөл аймагт үйл ажиллагаагаа явуулдаг хүнсний манлай үйлдвэрийн нэр. Тус компанийн захирал Гэндэнсүрэнгийн Сүхбаатар хэмээх эрхэм бий. Түүний аав Рагчаагийн Гэндэнсүрэн Төмөрбулаг сумын уугуул бөгөөд Бүгдгээний голд төрж өсчээ. Р.Гэндэнсүрэн гуай 1955 онд барилгын цэрэгт мордож, нутагтаа ирэхдээ тухайн үедээ л ховорт тооцогдож байсан жолоочийн мэргэжил эзэмшиж иржээ. Тэрээр Тээлийн аманд мал аж ахуйн станцад ажиллаж байгаад 1970 оны үеэс аймгийн Нэгдэл дундын үйлдвэрт орж, 1991 он хүртэл жолоочоор ажилласан гэдэг.

Насаараа аяны жолоо мушгиж явсан жолооч аавын хүү өөрийнхөө үүсгэн байгуулсан компанийг “Аяны жолоо” хэмээн нэрлэсэн санамсаргүй зүйл биш байлаа. Гэндэнсүрэн жолоочийн том хүү Г.Сүхбаатар 1961 онд төржээ. Сурагчийнхаа амралтыг аавынхаа төрсөн нутагт өнгөрүүлдэг, Агтын голд үеийнхэнтэйгээ бужигнаж, Бүгдгээний голоос загас суйлж, Нарийны аманд хадлан хийж, аавийнхаа ах дүү нарт нэмэр тус болж зуныхаа амралтыг өнгөрүүлдэг байсан Г.Сүхбаатар Мөрөн 10 жилийн сургуулийг 1980 онд төгсөж, Цэргийн сургуульд сурч, цэргийн холбоочин гэдэг ховор мэргэжил эзэмшсэн аж. Тэрээр наран мандах Дорнод нутагт хилийн алба залгуулж, Говь-Алтай аймагт хил дээр алба хашиж, хил дамнаж явсаар Хөвсгөлийн хилийн отрядад ажиллаж байгаад цэргийн албаа дуусгажээ. “Алтангадас” одонтой онц хилчин эр эх орныхоо хилийг манаж, холбоо харилцааг хариуцаж, хорин таван жилийг үдсэн юм. Монгол орон даяар зах зээлд шилжиж, айл бүр картын бараатай, сардаа нэг хүн гурван килограмм гурил идэх нормтой байсан тэр хүнд хэцүү үед Г.Сүхбаатар хүнс гэдэг хүнд ямар чухал болохыг тун сайн ойлгосон гэдэг. Тиймээс ч хүнсний салбарт ажиллахаар зориг шулууджээ. Тэрээр

эхнэртэйгээ нийлж, 1996 онд 8х9 хэмжээтэй жижигхэн байшинд дөрвөн том шавар зуух барьж, талхан цех байгуулснаар ажлаа эхлэж байлаа. Эхний талхаа өглөөний найман цагт хэрэглэгчидэд хүргэхийн тулд үүр хагаслан дөрвөн цагт босч, талхны хөрөнгөө зуурч, зургаан цагт гурилаа нухаснаар тэдний ажил эхэлнэ. Өглөөний найман цагт эхний худалдан авагчид үүдэн дээр нь ирчихсэн дугаарлаад зогсож байдаг учраас эрт босохоос ч өөр аргагүй. Өдөртөө дөрвөн зуун талх хийдэг. Гэрийнхээ гаднаас талхаа борлуулж, илүү гарсан бүтээгдэхүүнээ зарахын тулд хүүхдийн тэрэгний дөрвөн дугуй ашиглаж, түрдэг тэрэг хийгээд зах руу чирээд явж байсан үе ч тэдэнд бий. Тог цахилгаангүй тэр хүнд нөхцөлд дөрвөн том шавар пийшинг ээлжгүй галлаж, талхныхаа хөрөнгийг буулгахгүйн тулд цонх, хаалгаа ч онгойлгох эрхгүй халуун галын дэргэд ажиллаж байсан тухайгаа Г.Сүхбаатар захирал ярихдаа “Хүний хуйх хамгийн их халдаг юм билээ. Тэр үед үсэндээ гар хүрэхэд л халуу төөнөдөг байсан шүү” гээд инээмсэглэж байсан. Гэвч тэрээр шантраагүй. Г.Сүхбаатар захирлын үүсгэн байгуулсан “Аяны жолоо” компани өдрөөс өдөрт өргөжин тэлсээр өнөөдөртэй золгож байна. Өдөрт 400 талх хийдэг байсан энэ жижиг цех өнөөдөр хоногтоо 3.8 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай том үйлдвэр болжээ. Тэрээр 2000 онд үйлдвэрээ өргөтгөж, талх нарийн боов бялуу үйлдвэрлэж байгаад 2010 онд шинэ үйлдвэрээ барьжээ. “Аяны жолоо” компани дотроо таван цехтэй, үйлдвэрийнхээ хажууд бие даасан хүнсний лаборторитой, өөрийн гэсэн цахилгааны эх үүсвэртэй, Хөвсгөл аймагт төдийгүй баруун таван аймагтаа томд тооцогдох үйлдвэр болж чаджээ. Социализмын үед аймгуудад барьж байгуулсан хүнсний үйлдвэрүүдийг хүмүүс хувьчлалаар авч, зарим нь тоногдож, зарим нь салж бутарч, үндсэн үйл ажиллагаа нь доголдсон. Тэгвэл Г.Сүхбаатар захирал бүх зүйлийг өөрийнхөө гараар босгосон. Түүнийг 2010 онд шинэ үйлдвэрээ нээх үеэр Хүнс хөдөө аж ахуй



яамны газрын дарга, Улсын мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар очоод бүгд гайхсан гэдэг. Тэд “1991 оноос хойш хөдөө орон нутагт ийм том хүнсний үйлдвэр байгуулагдсангүй” хэмээн ярьж байсан юм. Өнөөдөр “Аяны жолоо” компани лабораториа өргөтгөж, нян судлалын, хүнсний химийн лаборатори байгуулжээ. Энэ лабораторийг Стандартчилал хэмжил зүйн газраас шалгахар ирсэн шалгалтын комиссынхон үзээд мөн л гайхаж байсан гэдэг. Асар их хөрөнгө оруулалт хийж, хүнсний үйлдвэр байгуулж, хүнсний аюулгүй байдалдаа онцгой анхаарч тусгай лаборатори байгуулсан хүн улсын хэмжээнд ч хуруу дарам цөөхөн учраас тэд гайхсан хэрэг. Хүний хүнс хамгийн найдвартай бас аюулгүй байх учиртай гэдэг зарчмыг Г.Сүхбаатар захирал яс баримталдаг. Тиймдээ ч “Аяны жолоо” компанийн бүтээгдэхүүн чанартай, бас эрүүл байж чаддаг. Тус үйлдвэрийн “Сүүт” нэрийн бүтээгдэхүүн амт чанараараа гайхагдаж, Хүнс хөдөө аж ахуйн яамнаас энэ бүтээгдэхүүнийг нь 2009 онд “Монгол брэнд” хэмээн өргөжилжээ. “Аяны жолоо” компанийнхан удаа дараа “Шилдэг татвар төлөгч,”-өөр шалгарч, Улсын мэргэжлийн хяналтын газраас тус үйлдвэрийг “Хүнсний чанарыг хангасан үйлдвэр” хэмээн өргөжилж, Худалдаа аж үйлдвэрийн танхим “Шилдэг үйлдвэрлэгч” батламжаа гардуулжээ. Г.Сүхбаатар захирлаас “Танай бүтээгдэхүүний орц найрлагын нууц жор олон бий биз” хэмээн асуухад тэрээр “Манай Хөвсгөл нутаг хамгийн эрүүл хөрстэй. Энэ эрүүл хөрсөн дээр ургасан буудай хамгийн амттай. Энэ эрүүл хөрснөөс хооллож, эрүүл цэвэр тунгалаг уснаас уусан малын сүү, өрөм тараг, өөх тос хамгийн чанартай. Үүнд л манай үйлдвэрийн бүтээгдэхүүний нууц жор бий дээ” хэмээн хариулж байсан юм. Үнэндээ ч тус үйлдвэрийн бүтээгдэхүүний амт чанарыг Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэтчүүд ч мэддэг болжээ. Г.Сүхбаатар захирал 2004-2008 онд аймгийнхаа үйлдвэр дэд бүтэц, байгаль орчны хэлтсийн даргаар ажиллаж байжээ. Тэрээр энэ хугацаанд Төмөрбулаг суманд багагүй хөрөнгө оруулалт татаж, бас чамлахааргүй олон зүйл хийж бүтээсэн. Г.Сүхбаатар захирал Төмөрбулаг сумын АН-ын даргын сонгуульт ажил хашиж, Төмөрбулагчуудтай байнга холбоотой явдаг нэгэн. Амьдралыг нэгэн их далайтай зүйрлэж гэмээнэ хүмүүн биднийг тэрхүү далайд аялаж яваа аянчид юм. Энэ л аянчдын жолоог Г.Сүхбаатар захирал шиг уйгагүй, хөдөлмөрч, басхүү итгэл даах хүмүүс өргөж яваа...



## ХҮҮХДИЙН АГВААН

Энэ нэрийг Монголчууд андахгүй. Эрүүл мэндийн салбарт бүхий л насаараа зүтгэсэн энэ эрхэм ачлал буянаа түгээсэн эмч, ардын хүүхдийг сургасан багш, басхүү мэдсэн сурсан бүхнээ олондоо баринтаглаж үлдээсэн судлаач, эрдэмтэн хүн байсан юм. Хотогойд түмний хүү Агваандорж 1940 оны луу жил Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг “Дунд хэдрэг” хэмээх газар ард Дэмбээгийн гурав дахь хүү болон төржээ. Тэрээр 1960 онд Мөрөнгийн 10 жилийн дунд сургууль, 1965 онд АУДэСургуулийн Хүүхдийн эмчийн ангийг онц дүнтэй, улаан дипломтай дүүргэсэн гэдэг. Шинэ тутам хөгжиж байсан анагаахын салбарын дээд сургуулийг улаан дипломтой төгссөн залуу эмч 1965 онд нутгийнхаа зүг хүлгийн жолоо залжээ. Тэрээр Хөвсгөл аймгийн хүүхдийн эмнэлгээс ажлын гараагаа эхлэсэн түүхтэй. Эм ховор, эмчилгээний багаж төхөөрөмж тун муу тэр хүнд цагт Д.Агваандорж эмч Шинэ-Идэр сумын Сум дундын эмнэлэгт ерөнхий эмчийн алба хашиж, хүүхдүүд гэлтгүй олон хүнд үзлэг оношлогоо хийж, эмчилж сувилж явсан ахмад эмч нарын нэг. Гэвч түүнийг 1974 оноос эхлэн Анагаахын дээд сургуулийн багш нар нь дуудаж, “Монголд хүүхдийн эмч нарыг бэлтгэхэд хүчин зүтгэ” гэдэг том үүрэг даалгавар өгчээ. Анагаахын сургуулийг онц төгссөн, хүүхдийн эмчээрээ дагнан ажиллаж байсан хүмүүс ховор учраас Анагаахын дээдийн эрдэмтэн багш нар ярилцаж, шавь нараасаа сонгож хоёр хүнийг Улаанбаатарт дуудаж авчиран багшлуулах шийдвэр гаргаж байсан юм гэнэлээ. Ийнхүү Д.Агваандорж эмч 1975 оноос эхлэн АУДэС-д багшилж эхэлсэн байна.

Орчин үеийн ангаахын шинжлэх ухааны үндэс суурийг Монголд тавьсан Анагаахын дээд сургуулийг Анагаах ухааны Их сургууль, Эрүүл мэндийн шинжлэх ухааны Их сургууль болтол тэрээр энэ салбарт 29 жил тасралтгүй ажилласан. Монголын эрүүл мэндийн салбарт эмч нар бэлтгэх том үүрэг хүлээж явсан Д.Агваандорж эмч гавьяаныхаа амралтанд гарсан ч гэсэн зүгээр суухыг хүссэнгүй. Тэрээр 2004 оноос “Монос” АУДэС-д багшилж байжээ. Монголын хүүхдийн эмчийн ангийн анхны төгсөгч эмч, багш басхүү эрдэмтэн гэж цоллуулах хүндтэй гавьяа байгуулсан энэ хүн залуу эмч нарын гарын авлага болсон олон арван бүтээл тууриривж үлдээсэн. Тэрээр 1992 онд “Бага насны хүүхдийн уушгины цочмог үрэвслийн үеийн амьсгалын дутал, хүчил-суурийн гомеостаз хямралын оношилгоо, эмчилгээ” сэдвээр анагаах ухааны докторын зэрэг хамгаалж байжээ. Эрс тэс уур амьсгалтай Монгол оронд бага насны хүүхдүүд уушигны цочмог үрэвслээр их өвдөж байгаад сэтгэл эмзэглэсэн буурал эмчийн энэхүү судлагааны ажил өнөөдөр ч оюутан сурагчдаас эхлээд анагаахын салбарт ажиллаж байгаа эмч нарын ч ширээний ном болон үлджээ. Та бидний “хатгаа” гэж нэрлэдэг уушигны цочмог үрэвслийг оношлох, эмчилэхэд түүний бүтээл асар их тус дэм болж байгааг хүүхдийн эмч нар ч одоо ч бүгд хүлээн зөвшөөрдөг юм билээ. Тэрээр 1997 онд “Дэд профессор”, 2002 онд “Профессор” цол хүртэж, 2004 онд “Алтан гадас” одонгоор шагнуулсан, “Эрүүлийг хамгаалахын”, “Ардын боловсролын тэргүүний ажилтан” байсан юм.


Д.Агваандорж эмч багшлахын зэрэгцээ эрүүл мэндийг сахин хамгаалах өргөсөн тангарагтаа үнэнч байж, олон эмнэлэгт зөвлөх эмчээр ажиллаж байжээ. Тэрээр 1978-1989 онд Октябрь, Найрамдал дүүргийн эмнэлэгт зөвлөх эмчээр, 1990-1994 онд Сүхбаатар дүүргийн ЭМН-д, 1994 оноос ЭНЭШ Төвийн зөвлөх поликлиник, Дотрын 1-р тасаг, 2006 оноос Нялхсын клиник сувилалд зөвлөх эмчээр ажиллаж байсан гэдэг. Монгол улс зах зээлд шилжээд удаагүй тэр л хүнд үед Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн зөвлөх поликлиник, уушги судлалын тасаг, Нялхсын клиник сувилалд зөвлөх эмчээр ажиллаж хүнд, эгзэгтэй 6000 гаруй хүүхдийг оношлох, эмчлэхэд шавь нартаа үнэтэй зөвлөгөө өгч, олон зуун хүүхдийн амь насыг аварсан хэмээн түүний мэргэжил нэгтнүүд үнэлдэг бөгөөд “1995-2005 онд Монгол улсын хэмжээнд суулгалт өвчний хүндрэл эрс багасч, эндэгдэл 5 дахин буурахад эмч, багш-эрдэмтэн Д.Агваандорж жинтэй хувь нэмэр оруулсан” хэмээн өнөөдөр ч дурсан ярих хүмүүс олон байна.

Бусдад зөвлөхийн зэрэгцээ үргэлж өөрийгөө хөгжүүлж, шинэ зүйл сурч мэдэж, судалж явсан буурал эмч анагаах ухааны чиглэлээр 15 ном бичиж, дэд докторын ажил хоёр, анагаах ухааны магистрын ажил тавыг удирдаж, Монголд 2000 гаруй хүүхдийн эмч бэлтгэхэд том үүрэг гүйцэтгэсэн юм. Д.Агваандорж эмч 21 аймаг, хотын 1800 эмч нарыг сургалтанд хамруулснаас гадна нялхсын эндэгдэл өндөртэй Дорнод, Дорноговь, Баян-Өлгий, Хөвсгөл аймгуудын ХӨЦМ сургалтыг дагнан хариуцаж ажилладаг байжээ. Түүний тухай Монгол улсын гавьяат эмч Малчин “Миний найз Агваан оюутан ахуйдаа МАХН-д элссэн. Улс төрийн буурь суусан ер нь их оюунлаг, кирилл, уйгаржин монгол алинаар нь ч маш гоё, хурдан бичдэг, марзан зантай, алиа шооч ёжтой үнэн үгтэй, маш хүлээцтэй, баргийн

юманд уурлахгүй, шатраас өөр спорт сонирхохгүй, найз нараа хүндэтгэж ч, “явуулж” ч чаддаг, хатуу тоглоомтой, нөхөддөө тусалж ч чаддаг, сайхан том шүд яралзуулан инээдэг, жинхэнэ гүндүүгүй монгол эр хүн байсан даа” хэмээн дурсан бичжээ. Д.Агваандорж эмч 1961 онд буюу оюутан байхдаа хамт сурч байсан С.Навчаатай гэр бүл болж, 1 охин, 2 хүү төрүүлж өсгөсөн бөгөөд охин А.Буянжаргал бараа судлагч, хүү Буян архитекторч, хүү Буяндэлгэр нь хүүхдийн нүдний эмч мэргэжлийг эзэмшжээ. Түүний хань С.Навчаа мөн л эрүүлийг хамгаалах их үйлсэд зүтгэж, Сайд нарын 2-р эмнэлэгт дотрын эмчээр насаараа ажилласан гэдэг. Д.Агваандорж эмч нутаг амьтай Хөвсгөлөөрөө бахархаж, Чингүнжаваараа омогшиж явдаг нэгэн байсан бөгөөд насан эцэслэх хүртлээ төрсөн нутаг гэсэн халуун дулаан сэтгэлээ гээгээгүй нэгэн явжээ. Тэрээр төрж өссөн нутаг руугаа явахын яг өмнөх өдөр гэнэт зүрх нь зогсож, тэнгэрийн орноо заларсан хэмээн анд нөхөд нь түүний тухай дурсаж байсан. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул Д.Агваандоржийн ах Д.Дагвадорж, Д.Дашням хоёр нь төрсөн нутагтаа мал маллан амьдарч байсан бөгөөд ажил үйлсээрээ олондоо хүндлэгдсэн хүмүүс байсан байжээ. Өдгөө тэдний үр хүүхдүүд нь бас удам дамжсан малчин болж, Төмөрбулаг сумандаа ажиллаж, амьдарцгааж байна.

## ИХ ТҮҮХИЙН ЭРЭЛЧИН

Одоогоос арван жилийн тэртээ нэгэн ахмад намайг зорьж ирэн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын 80 жилийн ойд зориулсан “Бүтээлч үйл, баатарлаг үйлстэн хэзээ ч мартагдахгүй” гэсэн түүхийн ном хэвлүүлэхээр зориг шулуудаад явж байгаагаа хуучилж билээ. “Сумын түүх бичнэ гэдэг амаргүй. Тэр олон хүний санаанд нийцтэл бичнэ гэдэг бүүр ч хэцүү байх даа ах минь” хэмээн бид хоёр ярилцаж, Ж.Үржгэр ах “Ямартай ч зорьсон хэргээ биелүүлнэ дээ” гэж хэлээд гарч байсныг тодхон санаж байна. Ж.Үржгэр ах маань зорьсон хэргээ бүтээж, Төмөрбулагчууд 80 жилийнхээ ойгоор түүний бүтээсэн номыг бэлэг болгон хүлээж авсан. Үүнээс хойш 10 жил өнгөрч. Харин өнөөдөр “сумын ойн ном бичих хэцүү дээ” хэмээн зоригыг нь мохоох үг унагаж суусан надад Төмөрбулаг сумын



90 жилийн ойд зориулсан ном бичих үүрэг оногджээ. Би энэхүү хөрөг тэмдэглэлээ “Их түүхийн эрэлчин” хэмээн нэрлэсэн минь учиртай. Учир нь Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын түүхийг түүн шиг сайн мэдэх хүн ховор. Тэрээр тус сумын түүхийн номыг хоёр ч удаа бичиж бидэнд үлдээжээ. Төмөрбулаг сумын 70 жилийн ой, басхүү 80 жилийн ойд зориулсан хоёр номыг бичих гэж Ж.Үржгэр хэмээх энэ буурал олон өдөр архивт сууж, басхүү тухайн үед амьд сэрүүн байсан олон арван ахмад буурлуудтай уулзаж явсан юм. Тиймээс ч түүний бичиж үлдээсэн энэ хоёр ном Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын дараа дараагийн түүхийг бичихэд гол баримт материал болон үлдэж байгаа хэрэг.

Жүгдэрнамжилын Үржгэр Төмөрбулаг сумын долдугаар багийн нутаг, Агтын эхний Цайварын давааны эхэнд 1938 онд төржээ. Түүний ээжийн аав буюу өвөө нь Галай маарамба хэмээх хүн байж. Ж.Үржгэр гуайг төрөхийн өмнө олноо Галай маарамба хэмээн нэрлэгдэж нутгийн олон түмэндээ ач буянаа өгч явсан энэ хүнийг төрсөн дүү аграмба Ж.Лувсанганчиг нарын хамт “Эсэргүүний хэрэг” тулгаж, Элстийн ард буудан хөнөөсөн гашуун түүх бий. 1938 онд түүнийг өлгийтэй байхад өвөг эцэг Ж.Галай маарамбын төрсөн дүү нар болох Ж.Гомбо, Ж.Гончиг нарыг мөн л баривчлан 10 жил хорих ялаар шийтгэж, Булган аймгийн Ингэт толгойн хорих лагерь руу илгээж байжээ. Гэвч Булган руу ачигдсан ах дүү хоёр шоронгийн хүнд хэцүү амьдрал, эрүү шүүлтийг даалгүй нас эцэслэсэн юм гэнэ лээ. Хэлмэгдүүлэлтийн шуурга, эсэргүүний хэрэг, бослого үймээн самуун гарч хаа сайгүй айдас хүйдэст өртөж байсан тэр л жил Ж.Үржгэр гуай

эцэг эхийнхээ магнайг тэнийлгэн мэндэлжээ. Хоёр гэрт хуваагдан нэгэн ам бүлд амьдарч байсан ах дүү дөрвөн лам хилсээр ял хүлээж амиа алдсныг гэрчлэх хүн бол түүний ээж Г.Балжинноров. Түүхийн хүнд хэцүүг бие сэтгэлээрээ амсаж явсан Г.Балжинноров гуай 1916 Далай гүний хошууны нутаг Агтын голд мэндэлжээ. Гар үйлдвэрийн артельд оёдолчин хийж, нэгдэл сааль сааж, хонь хариулж явсан энэ буурлыг олон түмэн “Агтын голын өндөр ээж” хэмээн нэрлэдэг байж. Тэрээр 2014 оны хавар 98 насыг наслаад тэнгэрийн орноо заларсан юм. Ээжийнхээ хайрыг бурхны хишиг хэмээн дээдэлдэг хүү нь тэр намар 76 настайдаа ээжийгээ тэнгэрийн оронд үдэж байжээ. Харин Ж.Үржгэр гуайн аавын талынхан гарын уртай хүмүүс байсан гэнэ. Тиймээс ч түүнийг бага



байхад аав нь Төмөрбулагын анхны гар артелийн гишүүнээр ажилд оржээ. Тухайн үед Төмөрбулаг сумын төв бараг л эзэнгүй. Артелийн ажилчдын цөөн хэдхэн айлаас өөр айл байсангүй. Гэхдээ л өглөө бүр дун үлээдэг. Артелийн ажилчид дун үлээх дуугаар ажилдаа цуглаж, дун үлээх үед үдийнхээ цайнд явдаг, орой дун үлээх чимээнээр ажлаасаа бууцгаадаг байлаа хэмээн Ж.Үржгэр гуай дурсан ярьж байсан. Тэрээр Мөрөнд долдугаар ангиа төгсөж, хотод Үйлдвэрийн техникумд сурчээ. Нийгмийн идэвхтэй оюутан залуу сургуулиа төгсөөд багшаар ажиллаж байтал 1957 онд “Гадаадад есөн хүн сургах гэж байна. Нийтдээ 30 гаруй залуучууд бүртгүүлсэн. Удахгүй шалгалт авна” гэсэн мэдээ сонсож, бүртгүүлжээ. Үнэхээр ч шалгалт авч, тэрээр шалгалтандаа тэнцэж Унгарт Геофизикийн дээд сургуульд суралцах эрхтэй болжээ. Ж.Үржгэр Унгарт таван жил сураад Усны аж ахуйн инженер мэргэжил өвөрлөн эх орондоо эргэж ирсэн юм. Гадаадад боловсрол эзэмшсэн шинэхэн инженер тухайн үеийн Усны аж ахуйн яаманд Усны хайгуул хариуцсан мэргэжилтнээр ажиллаж, эндээс ажил амьдралын гараагаа эхлэсэн гэхэд болно. Тэрээр Булган аймагт усны аж ахуй байгуулагдахад томилолт өвөртлөн очиж байжээ. Эрхэлсэн ажилдаа үнэнч, итгэлтэй, эзэмшсэн мэргэжилдээ сайн хэмээн үнэлэгдэж, залуухан инженер намын дээд сургуульд орох эрхээр шагнуулжээ. Тухайн үед Намын дээд сургуульд орно гэдэг хэн хүний санаанд багтах зүйл биш байсан гэдгийг өнөөгийн ахмадууд сайн мэдэж байгаа нь лавтай. Тэрээр 1970 онд намын дээд сургууль төгсөж, Эрдэнэбулган сумын Эг-Үүрийн сангийн аж ахуйн даргаар томилогджээ. Мөн Рашаантын сум нэгдлийн даргаар ажиллаж байж. Гэвч аливаа зүйлд сэтгэлээсээ ханддаг, хийх

гэсэн ажлынхаа эцсийг нь харж байж санаа нь амардаг, ил шулуун үгтэй залуухан дарга “Засгийн газрын төлөөлөгч, Аймгийн төлөөлөгчийг хэл амаар доромжилсон” хэмээн буруудаж, ажлаасаа халагдсан гэнэ. Усны аж ахуйн байгууллагад оператор, инженер гео физикч, экспедицийн дарга, ахлах инженер, Эг-Үүрийн сангийн аж ахуйн дарга, Булган Хөвсгөл аймагт сум нэгдлийн даргаар ажиллаж байсан, гадаадад боловсрол эзэмшсэн энэ хүнийг Мөрөнд “эсэргүүний хэрэг”-т холбогдох шахаж ажилгүй байхад нь Төмөрбулаг сумын уугуул, Дуламжавын Батаа тааралдаж, өөрийнхөө удирдаж байсан Гурилын үйлдвэрт Тэжээлийн цехийн даргаар ажилд авч байсан тухай тэрээр дурсан ярьж байсан юм. Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан ч Ж. Үржгэр гуай зүгээр гар хумхин суусангүй. Одоо ч ном зохиол оролдож, түүх намтар цуглуулсаар л яваа. Түүний хөдлмөр зүтгэлийг үнэлж, 2009 онд Ерөнхийлөгч байсан Н.Энхбаяр Хөвсгөл аймагт ирэхдээ Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонгоор шагнаж байсан юм. Тэрээр үүнээс өмнө “Алтан гадас” одон, ойн медалиуд, намын хүндэт шагналуудаар шагнагдаж явсан байна.



## САМБУУ САЙДЫН ШИНЭ ҮСГИЙН БАГШ

Төмөрбулаг сум эрэлхэг дайчид, эрдэмтэн мэргэд, эгэлгүй авьяастнуудаараа алдартай. Бас ажилсаг, өнгөлөг, авхаалжтай бүсгүйчүүдээрээ ч зартай. Тэдний нэг нь Дэмчигийн Гарамжав. Түүний ээж Д.Гүнсэнгийн нэр Хөвсгөл аймгийн ч, Төмөрбулаг сумын түүхэнд ч тааралдах нь олонтой. Учир нь Д.Гүнсэн хэмээх энэ хүн Хөвсгөл нутагт бошгыг халах залуучуудын эвлэлийг байгуулалцаж, сум нэгдлийн суурийг тавьж, 1927 онд МАХН-ын зургадугаар их хуралд төлөөлөгчөөр оролцож байсан түүхтэй. Тэрээр Хөвсгөл аймагт улаан гэрийн эрхлэгч, суртал ухуулгын бригадын гишүүн зэрэг ажил хийдэг, монгол бичиг, шинэ үсэг хослон сурсан цөөхөн бичиг үсэгтнүүдийн нэг байжээ. Дэмчигийн Гүнсэн хэмээх энэ хүний төрсөн дүү Дэмчигийн Баасанжав Монгол залуусаас гадаадад сурахаар морьдсон анхны оюутнуудын нэг. Тэрээр Эрхүүд суралцаж байгаад 1932 онд амралтаараа нутагтаа ирж яваад амь насаа харамсалтайгаар алджээ. Эсэргүү бослогын харуулууд гэр орноо зорьж явсан 18 настай залууг буудаж хороосон байна. Үүний дараахан Д.Гүнсэн нь төрсөн ганц охин Д.Гарамжавыгаа дагуулан улсын нийслэлийг зорьсон гэдэг. Д.Гүнсэнгийн охин Дэмчигийн Гарамжав 1921 онд Төмөрбулаг сумын Агтын голд төржээ. Тэрээр ээжийгээ даган Улаанбаатарт ирж, үлгэр жишээ дунд сургууль буюу одоогийн Улсын тэргүүний нэгдүгээр сургуульд оржээ. Түүний сурч байсан Үлгэр жишээ дунд сургууль нь 20 дугаар зууны Монголын төр нийгмийн нэртэй зүтгэлтнүүд, эрдэмтэд, жүжигчид суралцаж байсан, тухайн үедээ нэртэй сургууль байсан гэдгийг өнөөдөр Монголчууд бүгд мэднэ. Д.Гарамжав нь бага наснаас сэргэлэн цовоо, дуу бүжигт авьяастай, шүлэг бичдэг охин байж. Тэрээр сургуулиа төгсөөд тухайн үеийн Дотоод явдлын яамны ажилтан Дүгэржав гэдэг хүний эхнэр болж, нөхрөө даган ЗХУ-руу явж байсан аж. Нөхөр нь Москва дахь Монголын Элчин сайдын яаманд ажиллаж, Д. Гарамжав элчин сайд Ж.Самбуу болон түүний гэргий Нямаа гуайд кирилл (орос) үсэг зааж байсан гэсэн сонин баримт байх юм. Тэр үед зөвхөн монгол бичиг хэрэглэгдэж байсан болохоор тэр бүр хүн кирилл үсгийг мэддэггүй байсан цагт Ж.Самбуу гуай Гарамжав бүсгүйгээр бичиг үсэг заалгаж, хожим “Манай багш” хэмээн хүндэтгэдэг байсан гэдэг. Д.Гарамжав 1943 онд МАХН-д элсчээ. Улмаар Дотоод яамны төв сургуулийн дэргэдэх курст суралцаж, ДЯЯ-ны Төв аппаратад нэрт хатагтай С.Удвал ахайтантай хамт ажиллаж байсан гэнэ. Монголын сор болсон эмэгтэйчүүд тухайн үед ойр дотно найзалж нөхөрлөж явсан тухай олон дурсамжууд түүхийн шар хуудсанаа тэмдэглэгдэн үлджээ. Д.Гарамжав 1948 онд Намын Шинэ Хүчний дээд сургууль төгсөөд Намын Төв хорооны нарийн бичгийн дарга С.Янжмаагийн туслахаар ажиллаж байжээ. С.Янжмаа гэдэг нэрийг Монголчууд бас л андахгүй сайн мэднэ. Жанжин Д.Сүхбаатарын гэргий Янжмаа 1924 оны 3 сард Намын төв хорооны дэргэд “Бүсгүйчүүдийг сурган боловсруулах



тасаг”-ын даргаар ажиллаж байсан бөгөөд 1940 онд хуралдсан намын их хурлаас түүнийг НТХ-ны гишүүн, тэргүүлэгч, улмаар эмэгтэйчүүдийн хэрэг эрхэлсэн гуравдугаар нарийн бичгийн даргаар сонгожээ. С.Янжмаагийн туслахаар томилогдон ажиллаж, эмэгтэйчүүдийн эрх, хүүхдийн хөгжил, сургууль цэцэрлэг зэрэг боловсролын байгууллагууд байгуулах том, том төлөвлөгөөг хариуцаж байсан Д.Гарамжав ахайтан 1950 онд Булган аймгийн Намын хорооны хоёрдугаар нарийн бичгийн даргаар томилогдож, 1953 он хүртэл ажиллажээ. Нэр хүндтэй, олонтой явсан тэрээр 1953-56 онуудад Хүнсний Үйлдвэрийн яамны орлогч сайдаар ажиллаж, тэр үедээ Буйр нуурын загасны үйлдвэрийг сэргээн босгож, Зүүнхараагийн Спиртийн үйлдвэрийг тухайн үеийн

шинэ техник тоног төхөөрөмжөөр тоноглож, аймаг сумдуудад сүү тосны завод байгуулж явжээ. Г.Гарамжав Хүнсний Үйлдвэрийн яамны орлогч сайдаар томилогдсныхоо дараахан Төмөрбулаг суманд ирж, сүү тосны зовадын ажилтай биелчлэн танилцаж байсан тухай ахмадууд дурсан ярьж байсан юм. Олон нийтийн ажилд ч оройлж явсан энэ бүсгүй 1956 онд Бээжинд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн их хуралд төлөөлөгчөөр оролцож Мао Зедун, Чжоу Энх Лай нартай уулзаж зураг татуулж явсан гэдэг. Дөчөөс тавиад оны үед Улаанбаатарын ганган шаавай хүүхнүүдийн тоонд Гарамжав гэх энэ арвин баялаг түүх намтартай, цалгисан сайхан бүсгүй яах аргагүй багтаж явжээ. Түүнийг биеэ маш гоё авч явдаг, ялангуяа европ, монгол хувцасны донжийг тохируулж хэрэглэдэг, үг хэл цэцэн цэлмэг, ухаан саруул, ааль ялдам нэгэн явсан талаар гэж үеийнхэн нь өдгөө ч дурсдаг юм билээ. Д. Гарамжав бичиг үсгийн өндөр чадвартай, багаасаа шүлэг зохиол бичдэг байсан бөгөөд түүний “Давхар баяр”, “Ганц модны дэргэд”, “Жимсгэний төгөл”, “Шар тохойн цэцэг”, “Ганган хул” зэрэг өгүүллэг, найруулал, бэсрэг туужууд тухайн үед сонин хэвлэлээр гарч, 7-8 ном нь хэвлэгдэж байсан юм. 1959 онд ЗХУ-ын Москва хотод Коммунист намын дээд сургууль төгсч ирэхэд нь чухал албан тушаал санал болгосон ч өөрөө очихоос татгалзаж, Эдийн засгийн сургуульд багшилж эхэлсэн аж. Энэ сургуулийг МУИС-тай нийлэхэд тэнд очиж 30 шахам жил боловсролын салбарт зүтгээд өндөр насны тэтгэвэрт гарчээ.

## СҮҮЛЧИЙН НОЁНЫ АГЬ

Далай гүний хошуу захирагч ноёдын удам судрыг XIII зуунаас эхтэй гэж үздэг. Батмөнх даян хаан /1464-1517/ нь Мандуул хааны дүү Баянмөнх жононгийн хөвгүүн бөгөөд Чингис хааны 15-р үеийн ач, долоон настайдаа 1470 онд хаан ширээнд сууж Монголын түүхэнд хамгийн олон жил буюу 47 жил хаан төр барьсан байна. Даян хааны 11 хөвгүүний отгон хөвгүүн нь Гэрсэнз жалайр хунтайж, түүний ахмад хөвгүүн нь Ашихай мэргэн дархан хунтайж, түүний дэд хөвгүүн нь Түмэндарь дайчин, түүний ахмад хөвгүүн нь Шолой Убаши хунтайж, түүний гуравдугаар хөвгүүн Дорждай ноён, түүний ахмад хөвгүүн Бэйл Гэндэн, түүний хоёрдугаар хөвгүүн гүн Сунгарав, түүний дөрөвдүгээр хөвгүүн гүн Шагж / Шагжаа баатар/, гэж бичигдсэн байдаг.



Далай гүний хошуу нь угтаа Шагжаагийн эзэмшил нутаг бөгөөд Манж нар Шагжид гүн цол, түүний хөвгүүн Доржцэдэнд Засаг улсад туслагч гүн цол олгосон байдаг. 1757 оноос Чингэсийн алтан ургийн ноёдын нэг Шижирбаатар ноёны үр хүүхэд 10 үе дамжиж Далай гүний хошууг захирсан. Тэгвэл Чингэсийн алтан ургийн сүүлчийн ноён болох Базаррагчаагийн Содномваанчиг ардын хувьсгалтай 1921 онд золгожээ. 1923 онд Засаг ноёдын ёсыг устгахад Содномваанчиг ноён хошуунд Засаг даргаар сонгогдож байсан түүхтэй. Далай гүний хошууны сүүлчийн ноён, өдгөөгийн Төмөрбулаг сумын анхны Засаг дарга Содномваанчиг ноён Ховдод цэргийн сургуульд явж суралцаж байсан, басхүү бичиг, цэргийн эрдэмд сайн, түвшин төлөв зантай нэгэн байсан бөгөөд улсын шүүхэд эх зохиогч-бичээч зэрэг алба хашиж байгаад 1932 онд таалал төгссөн бөгөөд түүний шарил өнөөдөр ч Төмөрбулаг сумын нутаг Талбулагт оршиж байгаа гэнэм. Б.Содномваанчиг буюу нутгийнхны нэрлэж заншсанаар Сомоо ноёны хатан Цагаан овогтой Аюушаас 1930 оны төмөр морин жилд нэгэн хөвүүн төрсөн нь Дуйнхоржав гуай. Тэрээр Далай гүний хошууны удам залгамжилсан ноёдын сүүлчийн удам угсааны ганц хүн. Дуйнхоржав гуай одоогийн Төмөрбулаг сумын Бүгсийн голд төржээ. Б.Содномваанчиг ноёныг нас барсны дараа ноёны хатан Аюуш Дандгайсүрэн гэдэг хүнтэй ханилж, хүүгээ Дандгайсүрэн гэх энэ нэрээр овоглосон аж. Цаг төр үймж, хаа сайгүй үймээн самуун гарч, эсэргүү бослогын хэрэг дэгдэж, ноён бүү хэл лам нар нь буудуулж, амиа алдаж байсан тэр цөвүүн цагт сүүлчийн ноёны хатан хүүгийнхээ овгийг төөрүүлсэн хэрэг. Дуйнхоржав гуайн хойт эцэг

Дандгайсүрэн Төмөрбулаг сумыг үүсгэн байгуулагчдийн нэг байсан юм. Тэрээр Төмөрбулаг сумын анхны хоршооны даргаар ажиллаж, хүүхдүүд дайчилж ус шуудуу татаж, сумын төв дээр мод тарьж явжээ. Тэдний тарьсан мод өнөөдөр ч сумын төв, сургууль, цэцэрлэгийн хашааны гадаа найгаж байна. Дандгайсүрэн хэмээх энэ хүн тун ажилсаг, бас нийтэч хүн байсныг Дуйнхоржав гуай дурсан ярьж байсан. Үхэр тэргээр мод татаж, сумын төвийн анхны байшин барилгуудыг барилцаж, Мухарын бэлд хар буудай тариалж, ургацаа хурааж байсан гэдэг. Тэрээр нас бага ч гэсэн энэ бүхий л ажилд аавыгаа дагаж явдаг байжээ. Д.Дуйнхоржав гуай Төмөрбулаг сумын сургууль байгуулагдахад 1941 онд элсэж оржээ. Тэрээр Төмөрбулаг сумын сургуулийн анхны сурагчдийн нэг. Түүнийг анх сургуульд ороход сургууль эсгий бүрээстэй 4-5 гэртэй, нэгдүгээр ангиас дээш анги байхгүй байсан хэмээн хуучилж байсан юм. Энэ хүн Төмөрбулаг сумын анхны сурагч төдийгүй бас анхны шинэ үсэгтэн. Сургуульд орохоосоо өмнө ааваараа хуудам монгол бичиг заалгасан хүү бичиг үсгээ дөнгөж сэргээж эхлэж байтал шинэ үсэг үзэх болжээ. Тэрээр ээжийгээ өнгөрсний дараа мал маллаж байгаад цэрэгт явжээ. Цэргээс халагдаж ирснийхээ дараа сумандаа багийн даргаар ажиллаж байсан гэнэ. Тухайн үед Төмөрбулаг сум есөн багтай байсан бөгөөд Д.Дуйнхоржав гуай нэгдэлд ажиллаж, зургадугаар багийн засаг дарга хийж, ажил амьдралынхаа гарааг эхлүүлсэн түүхтэй. Түүний хариуцагч зургадугаар баг тухайн үед 100 гаруй өрхтэй, өнөөгийн Тээл, Тээлийн өвөр тал Дөш, Талбулагийг хамарсан өргөн уудам нутагтай, мал их сайтай байсан аж. Тухайн үеийн багийн дарга нар морио унаад л гэрээс гарна, гэртээ ирэхгүй хэд хоногоор явна, албан журмын даалгавар биелүүлэх, хөдөө аж ахуйтнуудыг нэгдэлжүүлэх үүрэг даалгавартай ажилладаг байж. Тэрээр 5-р багийн даргатайгаа хамтран “Эрчмийн оргил” нэгдлийг Дөшийн аманд байгуулж байсан түүхтэй. Д.Дуйнхоржав гуай 1956 онд олон нэгдлийг нийлүүлэх үед Сумын төлөвлөгч гэсэн алба хашдаг байжээ. Тухайн үеийн нэгдлийн даргаар Давааням, намын даргаар Жалцав гэдэг хүн ажиллаж байжээ. Энэ үеийн тухай Д.Дуйнхоржав гуайтай хууч хөөрсөн юм. Тэрээр “Манай Жалцав дарга байнга л “Одоо” гэж ярьдаг хүн байлаа. Намын 13-р Их хуралд яваад ирснийхээ дараа хурал хийж, үзсэн харсан, сонссон дуулснаа тайлагнасан юм. Жалцав дарга “Одоо Намын Их хуралд одоо Оросоос одоо ЗХУ-ын Комунист намын Төв хорооны дарга одоо ирсэн. Игнаа одоо Тоов гуай одоо үг хэлээд одоо” хэмээн ярьж билээ. Уг нь ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга В.В.Игнатов гэдэг хүн ирсэн юм билээ. Жалцав даргын ярианаас





Оросоос Игнаа, Тойв гэдэг хоёр хүн л ирж гэж олон хүн ойлгосон байх. Нийслэл хүү кинон дээр гардаг хургаа үхүүлсэн төлчдийн зургийг авдаг онигоо чинь уг нь манай сумаас гаралтай юм шүү дээ. Жалцав дарга үхсэн хурга авчирч “Хоёр чих нь одоо мод болоод дөрвөн хөл нь одоо жад болоод төлөө одоо үхүүлсэн байна” хэмээн ярьж байсан юм гээд инээд алдаж суух. 1958-1959 онд сумын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д.Дуйнхоржав гуай 30 хүрсэн

хойноо оройгоор долдугаар анги төгсөж, Хууль цаазын дунд сургуулийг 1965 онд дүүргэжээ. Тэрээр Булган аймгийн шүүхэд шүүгчээр томилогдож, хоёр жил ажилласны эцэст нутагтаа ажиллах санал гаргаж байж Хөвсгөл аймагт ирсэн гэнэ. Тухайн үед Хөвсгөл аймгийн шүүх жижигхэн контортой 10 гаруйхан хүнтэй цомхон байгууллага байжээ. Сумууд руу явж шүүх хурлаа хийнэ, шууданд суугаад хавтаст хэргээ тэврээд явдаг, ихэнх ажлаа мориор л амжуулдаг байж. Тэрээр шүүгчээр ажиллаж байгаад 1982 оноос аймгийн шүүхийн орлогч даргаар ажиллажээ. Нийтдээ 20 гаруй жил аймгийн шүүхэд ажилласан ахмад буурал тэтгэвэртээ гарснаас хойш хорь гаруй жил мал маллаж, морь уяж байгаа аж. Эдүгээ Дуйнхоржав гуай 500 гаруй малтай, бас аймгийн “Алдарт уяач” цолтой. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон. Ардын хувьсгалын 40 жилийн ойгоос хойшх бүх ойн медаль түүний энгэрт гялалзаж байна. Мөн Хөдөлмөрийн хүндэт медалиар хоёр удаа шагнуулжээ. Бидний очихын өмнөхөн Улаанбаатар хотын гэрлэх ёслолын ордноос түүнд “Очир-Эрдэнийн хурим” гэсэн батламж олгосон байлаа. Сүүлчийн ноёны угсаа залгах агь маань нутгийнхаа бүсгүйтэй 1953 онд гэр бүл болж, сумын нарийн бичгийн дарга дээр очин гэрлэлтээ батлуулж байсан гэнэ. Тэднийг тоонот гэрт толгой холбож, 61 жил нэг гэрт хамтдаа амьдарч байгааг Гэрлэх ёслолын ордноос батлаж, “Очир эрдэнийн хурим” гэдэг өргөмжлөл олгосон нь энэ. Жараас дээш жил нэг гэрт амьдарч, хоёулаа амьд сэрүүн байгаа хүмүүст энэхүү өргөмжлөлийг олгодог бөгөөд улсын хэмжээнд цөөхөн гэр бүл ийм хүндтэй өргөмжлөлийн эзэн гэж бодохоор л бахархмаар сайхан санагдаж билээ. Ийнхүү Далай гүний хошууны сүүлчийн ноён М.Содномваанчиг ноёны хүү өнөөдөр энх тунх сайхан амьдарч байна. Сүүлчийн ноёны эдлэж хэрэглэж байсан зүйлсээс түүнд цөөнгүй зүйл үлджээ. Сомоо ноёны цагаан гэж олноо нэрлэгдсэн жижигхэн цагаан хаш хөөрөг олон оны эрхээр элэгдэж, бөөрнөөсөө нимгэрсэн байх юм. Чулууг ч элээдэг цаг хугацаа хүмүүний амьдралыг ч гэсэн өөрчилж чаддаг. Хэрвээ цаг өөрчлөгдөж, хувьсгал ялаагүй байсан бол өнөөгийн Төмөрбулагчууд Сомоо ноёны хүү Дуйнхоржав хэмээх хошуу ноёнттой байх байж дээ гэсэн саваагүй бодол өвөртөлсөөр тэдний гэрээс гарч билээ.

## ХОЙМОР НУТГИЙН ХИЙМОРЬ

Монгол орны хойморь болсон Хөвсгөл аймгийн хийморь нь болсон олон сайхан залуучууд бий. Тэдний цөөнгүй хэсэг нь Төмөрбулаг сумаар овоглодог. Энэ удаа би Хөвсгөл аймгийн Иргэдийн хурлын дарга Т.Болдбаатарыг онцолж байна. Түүний ээж Норжмаа Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул. Тиймээс ч Т.Болдбаатар дарга Төмөрбулаг сумтай сэтгэл зүтгэлээрээ холбоотой явдаг нэгэн. Тэрээр 1965 онд Мөрөн суманд төржээ. Т.Болдбаатар 1983 онд аравдугаар ангиа төгсөөд Калининградын Цэргийн инженерийн дээд сургуульд таван жил сурч, Зам гүүрийн инженер мэргэжлийг 1988 онд эзэмшжээ. Хойно сургууль төгссөн залуу инженер ардын армид салаан захирагч, ротын техникийн салааны орлогч, Цэргийн их сургуульд багшилж байжээ. Тэрээр 1995-1996 Удирдлагын академи төгссөн бөгөөд мөн МУИС-ийн Хууль зүйн дээд сургуульд сурч, эрх зүйч мэргэжил эзэмшжээ. МУ-ын зөвлөх инженер цолтой энэ эрхэм 2001 оноос “Хөвсгөл зам” компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж эхэлсэн байна. Анх түүнийг 2001 онд “Хөвсгөл зам” компанийн гүйцэтгэх захирлаар ирэхэд мэргэжлийн ажилчидгүй, техник тоног төхөөрөмж нь хуучирсан, ажилчдынх нь итгэл алдарсан. Жилд 60 орчим сая төгрөгийн борлуулалт хийдэг, 30 гаруй саяын өртэй компани байжээ. Харин түүнийг захирлаар ирснээс хойш тус байгууллага өргөжин тэлсээр байгаа. 2013 оны жилийн эцэс гэхэд “Хөвсгөл зам” компани 6-7 тэрбумын борлуулалттай, 150 гаруй ажилчидтай, сардаа 60-90 саяын цалин олгодог том компани болж чаджээ. Мөн үүнээс гадна тэрээр “ОСПМО” бетон эдлэлийн үйлдвэр байгуулсан бөгөөд энэ компани 30 гаруй ажилчидтай. Хөвсгөл аймагт бүхий л бетон эдлэлийн бүтээгдэхүүнүүдийг нийлүүлж байгаа юм. Мөн элсний карьерын үйлдвэр байгуулж, агаарын шугамаар холбож чаджээ. Үүнээс гадна тоосго, вакум цонхны үйлдвэрээ нээж, ажлын байрууд бий болгосон гээд түүний тухай тоочоод байвал асар олон зүйлийн тухай ярих хэрэг болно. Тэрээр Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны УЗ-ийн гишүүн. Энэ төрийн бус байгууллагын удирдах зөвлөлд хөдөө орон нутгаас ганцхан хүн сонгогдож ажиллаж байгаа бөгөөд тэр нь Т.Болдбаатар дарга. Тус холбооныхон Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 10,000 айлын орон сууц хөтөлбөрийг боловсруулах ажилд өөрсдийнхөө саналыг тусгаж чадсан байгууллага. Зам гүүр, барилга бүтээн байгуулалтын ажилтай амьдралаа холбосон Монгол улсын зөвлөх инженер маань мэргэжлээрээ 20 гаруй жил ажиллахдаа Идэрийн голын төмөр бетонон гүүр, Жаргалын гүүр, Эгийн голын гүүр, Монголчуудын анх удаа бие даан хийж байгаа Цагаан үүрийн 350 метр, 40 метрийн алслалтай гүүрийг барилцаж, Хөвсгөл Өмнөговь, Баянхонгорын аэродром, аймгийн төвийн бүх замын ажилд гар бие оролцож, Сантын гүүрийг тавилцсан. Бүтээн байгуулалтын ажлаас хойш сууж байгаагүй энэ эрхэм олон нийтийн

ажилд ч тун идэвхитэй оролцож яваа. Төмөрбулаг сумын намын хорооны даргаар дөрвөн жил ажилласан Болдбаатар дарга 2012 оноос аймгийн ИТХ-ын даргаар ажиллаж байна. Ард олны итгэлийг хүлээж, төрд түмнээ төлөөлөхөөр сонгуульт ажил хүлээж авсан Болдбаатар дарга энэ их ажлынхаа хажуугаар “Дэлтэй цэнхэр” морин спортын холбооны нарийн бичгийн даргын сонгуульт ажлыг гүйцэтгэдэг. Тэрээр энэ ажлыг 2010 онд хүлээж авчээ. Үүнээс хойш Засгийн газрын тогтоолтой хоёр дахь том наадам буюу “Хотгойдын хурд-2” даншиг наадам Хөвсгөл аймагт зохион байгуулагдаж наадамчин олны сэтгэлийг сэргээсэн юм. Т.Болдбаатарын удирдлага, бодлого чиглэл, сайн менежментийн үндсэн дээр сүүлийн хоёр жилд Хөвсгөл аймгийн уяачдын чансаа эрс сайжирч, улс бүсийн наадмаас айраг түрүү хүртэх уяачдын тоо нэмэгдэж байгаа хэмээн морь сонирхогчид маань ярьж байлаа.



Тодруулбал 2012 оны АХ-ын 91 жилийн ойд Тариалан сумын харьяат МУАУяач Г.Доржпүрэвийн Толбот зээрд хязгаалан түрүүлж, Б.Ганбаярын “таван цагаан” хэмээх үрээ эрлийз дээд насанд аман хүзүүдсэн бол Төвийн бүсийн даншиг наадамд Г.Доржпүрэвийн соёолон үрээ айрагдаж, Б.Ганбаярын “таван цагаан” давхар уяагаар айрагджээ. Баян-Өлгий аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн даншиг наадмаас Хөвсгөлийн уяачид гурван айраг хүртсэн бол хурдны өлгий Сүхбаатар аймгийн 70 жил, зүүн бүсийн даншигт “Дэлтэй цэнхэр” МСУХ-ны нарийн бичгийн дарга Т.Болдбаатарын өөрийнх нь халиун хязгаалан айргийн гуравт хурдалж, хоймор нутгийн хийморилонг түмнийг баясгасан билээ. Ганц жишээ дурьдахад өнгөрсөн жил болсон “Хотгойдын хурд” наадмаас Хөвсгөлийн уяачид хоёр түрүү 14 айраг авсан байх юм. “Дэлтэй цэнхэр” морин спортын холбооныхон морьдын үүлдэр угсааг сайжруулах тал дээр онцгой анхаарч байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд Галт, Мөрөн, Тариалан зэрэг сумдын морьдын чанар чансаа эрс дээшилж байгаа гэнэ. Т.Болдбаатар даргын хурдан морьд ч зартай. Түүний халиун азарга Улсын наадамд аман хүзүүдсэн, “Хотгойдын хурд”-д гурваар ирсэн, Хэнтий аймгийн наадамд хоёр ч удаа түрүүлж байсан бөгөөд Зүүн бүсийн уралдаанд наадамд хязгаалан насандаа айргийн гуравт ирж байжээ. Т.Болдбаатарын энэхүү хурдан буян Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай гээд дөрвөн тэгш ойтой аймгийн

наадамд айрагдаж, Хөвсгөлчүүдийн төдийгүй монгол түмнийхээ магнайг тэнийлгэж, уясан эзэн, унасан хүүхдээ баярлуулаад байна. Т.Болдбаатар даргын хувьд Аймгийн алдар уяач цолыг 2011 онд авсан бөгөөд Улсын алдарт уяач болоход ганцхан түрүү дутуу байгаа гэнэ. Тариалан сумын уугуул Доржпүрэв гуай Хөвсгөлчүүдийн хийморийг өргөж, анх удаа Улсын алдарт уяач авсан. Энэ жил улсын Манлай уяач цолны болзол хангасан хэмээн Т.Болдбаатар дарга тун ч сэтгэл хангалуун ярьж байна билээ.

Үүнээс гадна тэрээр Хөвсгөл аймгийн хөл бөмбөгийн холбооны тэргүүнээр ажилладаг. Оюутан байхдаа хөл бөмбөг тоглож, цэрэгт байхдаа армийн аварга, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож явсан учраас тэрээр хөл бөмбөгт тун их элэгтэй. “Хөл бөмбөг гэдэг хүнийг хамт олонч болгодог. Хөвсгөлчүүд маань нийлж нэгдэж чаддаггүй муу талтай. Тиймээс багийн спортыг түшиглэн хүүхэд залуучуудыг хамт олонч болгохыг зорьж байна даа” хэмээн тэр ярьж байсан юм. Тиймээс ч Хөвсгөл аймагт Европын стандартад нийцсэн хөл бөмбөгийн том талбай байгуулахаар зорьж ажиллаж байна. Үүний тулд аймгийн цэнгэлдэх хүрээлэнг засаж, тохижуулж эхлэжээ. Жилд ганцхан удаа наадам болж, бусад үед нь хог шороонд дарагдаж байдаг төв цэнгэлдэх хүрээлэнд Европ стандартын хөл бөмбөгийн талбай тун удахгүй ашиглалтанд орно. Энэ талбай дээр дэлхийд нэр алдраа цуурайтуулах Монголын ирээдүйн тамирчид өсөж өндийнө гэдэг олон хүн итгэж байгаа. Учир нь өнгөрсөн жил Ерөнхийлөгчийн ивээл дор явагдсан хөл бөмбөгийн “Дуулиан” наадамд Хөвсгөлийн хүүхдүүд оролцож багаараа алтан медаль хүртжээ. Энэ амжилтын цаана ч Т.Болдбаатар даргын хичээл зүтгэл бий. Тэрээр хөл бөмбөгийн спортыг хөгжүүлэхийн тулд мэргэжлийн багш нарыг урьж авчирч, 8-14 насны хүүхдүүдэд хөл бөмбөгийн сургалт явуулж эхлэсэн бөгөөд үүний үр дүн хоёр жилийн дараа л гарч эхэлжээ. Т.Болдбаатар даргын ээж Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул. Тиймээс ч тэрээр өглөө бүр ээжийнхээ цай сүүний дээжээ өргөдөг Цог-Өндөрийн овоо өөрийг нь харж хандаж явдаг гэдэгт итгэдэг нэгэн. Хөвсгөл нутгийн хийморь болсон мянга, мянган залуучуудын нэг Т.Болдбаатарын хөдөлмөр бүтээлийг төр үнэлж, 2008 онд “Алтангадас”, 2011 Онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

## МОНЖОО ЗААНЫ ХҮҮ

Төмөрбулаг сумын алдартай нэгдлийн дарга нарын нэг Б.Шарбанди гуайтай уулзлаа. Тэрээр Бүгдгээний голын хүн. Түүний аавынх нь аав Ренчин гэж аймаг хошуу дамжсан цуутай эмээлч байсан бөгөөд монгол эмээл их хийдэг, гарын ур дүй сайтай нэгэн байжээ. Тэрээр өөрийгөө “Би чинь Эмээлчийн удмын хүн шүү дээ” хэмээн хуучилж байсан. Түүний аав Р.Бямбажав сумын заан цолтой, бас л гарын ур дүй сайтай, эмээл хийдэг байжээ. Ер нь л Төмөрбулаг сумынхан эрт дээр үеэс хусны үндсээр бүүргийг нь хийж, хусаар хавтасыг нь урлаж, малын арьсны год буцалган цавуудаж, бугын эврээр бүүргийг нь хярлаж, сайхан эмээл хийдэг, Далай гүний хошууны урчуудын хийсэн эмээл хот хүрээ газар ч цуутай байсан аж. Эмээлчийн удмын хүү Б.Шарбанди 1950 онд Гангын ам гэдэг газар төржээ. Тэрээр 1960 онд Төмөрбулаг сумын сургуульд сурч, 1975 онд Хөдөө аж ахуйн дээд сургуулийг мал зүйч мэргэжлээр төгссөн. Сургуулиа төгсөөд суманд мал зүйчээр томилогдож байжээ. Б.Шарбанди дарга 1975-1981 он хүртэл Их уул суманд мал зүйчээр ажиллаж байгаад төрсөн нутагтаа иржээ. Төмөрбулаг суманд мал зүйчээр ажиллаж, 1983-1985 онд Төмөрбулаг сумын даргаар ажиллаж байгаад Намын дээд сургуульд 1986 онд элсжээ. Тухайн үед ажил үйлсээрээ шалгарсан, цаашид өсөх ирээдүйтэй, боловсон хүчнүүдийг Намын дээд сургуульд бодлогоор сургадаг байсан цаг. Б.Шарбанди дарга Намын дээд сургууль төгсөөд намын даалгавар өвөртөлж, Жаргалант сумын Улаан туг нэгдлийн даргаар томилогдож байсан түүхтэй. Гэвч тэрээр 1991 онд төрж өссөн Төмөрбулагтаа ирж, сум нэгдлийнхээ даргаар ажиллажээ. Төмөрбулаг сумын сүүлийн гучин жилийн түүхийг хамгийн сайн мэдэх хүмүүсийн нэг нь Б.Шарбанди гээд хэлчихэд нэг их буруудахгүй. Энэ сумын иргэдийн амьдрал ахуйг ч бас сайн мэдэх хүмүүсийн нэг нь яах аргагүй Б.Шарбанди дарга. Түүнийг 1981 онд нэгдлийн даргаар томилогдон ирж байхад Төмөрбулаг сум 1000 өрхтэй, 90 гаруй мянган малтай, малынхаа тоогоор аймагтаа эхний тавд ордог сум байжээ. Мөн түүнийг нэгдлийн дарга байх үед Төмөрбулагчууд 7-р таван жилийг төлөвлөгөөгөө биелүүлж, малаа таван толгойгоор нь өсгөсөн хэмээн сумаараа Гавшгайч цолоор шагнуулж байжээ. Тэрээр Эрчмийн хар ямааг хоёрдугаар багт ангилж, Тээл бригадыг таваарын бригад болгосон, 1986 онд ямааны Улсын үржлийн ферм байгуулсан гээд тоочоод байвал энэ сумын иргэдийн ахуй амьдралтай салшгүй холбоотой олон түүхийг энд дурьдах хэрэгтэй болно. Б.Шарбандийг нэгдлийн даргаар ажиллаж байхад Хөдөө аж ахуйн дээд сургуулиас багш нар ирж хар ямааг судлах ажил эрч хүчээ авч, Төмөрбулаг сум Говь компанитай холбоо тогтоож, Монголын ноолуурын ууган үйлдвэр, Төмөрбулаг сумын малчдаас түүхий эдээ бэлтгэх үндэс суурь тавигдсан юм. Тэрээр сум нэгдлийн даргын ажлаа өгсөн ч “Эрчмийн хар ямаа” гэдэг энэ нэрийг гэж үлдээхийг хүссэнгүй. 1996 онд эрдэмтэдтэй хамтран хар ямааныхаа тодорхойлолтыг бичиж, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хурлаар



орж, 1996 оны 12 сард Төмөрбулаг сумын хар ямааг гэж омог гэж хүлээн зөвшөөрч, Хөдөө аж ахуйн сайдын тушаал гарах үед сэтгэл догдлон хүлээж суусан цөөнгүй хүмүүсийн нэг нь Б.Шарбанди гуай. Түүний “Эрчмийн хар ямаа”-ны талаар бичсэн, судласан, бас асуудал дэвшүүлсэн олон нийтлэл төвийн сонин хэвлэлээр гарч, Төмөрбулаг сумын нэр олон хүний чихэнд хүрч, анхаарлыг татаж байсан удаатай. Энэ хэрээр Төмөрбулаг сумын онцгой ашиг шимтэй, мах, ноолуурын чиглэлийн хар ямаагаар малынхаа үүлдэр угсааг сайжруулах сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэж, өнөөдөр Өмнөговь, Архангай гээд Монгол улсын өнцөг булан бүрээс хүмүүс ирж, үржлийн мал худалдан авч, эцэг малаар малынхаа цусыг сэлбэж байгаад тэрээр сэтгэл өөдрөг

явдаг хүмүүсийн нэг. “Эрчмийн хар ямаа бол байгалиас л заяасан ямаа. Зоотехникч Гунгаажанцан зохиомол хээлтүүлэг хийж байсан. Мөн “Горны алтай” үүлдрийн ухна 1981 онд авчирч, нэгдүгээр үеийг нь үржүүлж, цус сэлбэсэн. Нарийн мяндсан ноолууртай үндсэн сүрэг гэж батласан. Энэ хар ямаа Төмөрбулагчуудын хувьд эцэг өвгөдөөс нь үлдээсэн бэлэг, өв залгамжлан авсан үнэт эрдэнэ л гэсэн үг шүү дээ” хэмээн ярихдаа тэрээр сэтгэл тун ч хангалуун байсан юм. Гэвч Эрчмийн хар ямааг судлаж байсан эрдэмтэн Надмидын бие чилээрхэж, сүүлийн үед судалгааны ажил орхигдож байгаад тэрээр жаахан сэтгэл дундуур явдаг гэнэ. “Уг нь манай хар ямааны судалгааны ажил бүрэн хийгдсэн, үүлдрийн хэмжээнд хүрсэн. Даанч үүнийг хөөцөлдөөд явах эрдэмтэд алга даа” гэж ярьж байлаа. Нэгдлийн даргаар ажиллаж, засаг даргаар томилогдож явсан Б.Шарбанди дарга нэгдлийнхээ ахмадуудыг дурсан ярих дуртай. Хэн юу хийж, хэн ямар амжилтанд хүрч, хэн ямар бэрхшээл саад давсан тухай яриад байвал уртаас урт жагсаалт гарах нь тодорхой. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, бүхий л зүйл тоотой, тооцоотой явах үед сум нэгдлийг удирдаж, төлөвлөгөө норм биелүүлэх гэж өдөр шөнөгүй ажиллаж, нэгдлийн мал өсгөх даалгавар гүйцээх гэж өөд уруугүй давхиж явсан энэ хүн цаг хугацааны эрхээр малыг малчдад хувьчлах их ажилд гар бие оролцсон хүн. Малыг малчдад хувьчлах төр засгийн шийдвэр гарч байх тэр үед буюу 1991 онд Тээл багийнхан хамгийн түрүүнд тусдаа бие даасан нэгдэл байгуулах хүсэлтээ гаргажээ. Төмөрбулаг сумын хамгийн таваарлаг малтай байсан энэ бригад тусдаа гарч, малаа хувьчилж авсны дараа багууд малаа хувьчилж авах болжээ.

Тухайн үед хоёрдугаар бригадын малчид хамгийн их гомдол санал гаргаж байсан гэдэг. Тэд “бид дан ямаа авч байна” хэмээн бухимдаж, Засаг даргаа сандаргаж байсан удаатай. Харин тэр үед уурлаж бухимдаж байсан цөөнгүй хүн өнөөдөр “Ямаа авсан нь оносон шүү” хэмээн түүнд хэлдэг гэнэлээ. Нэгдэл тарж, өмч хувьчлал явагдах үед Төмөрбулаг сумын Давшилт нэгдэл 120 гаруй мянган малтай байсан бөгөөд энэ малыг 700 гаруй нэгдлийн гишүүдэд хуваажээ. Бас албан байгууллагуудын ажилчид, оюутнуудад хүртэл 16 толгой мал оноож өгчээ. Нэгдэл тарж, өмчөө хувааж байгааг сонссон нутгийн уугуул иргэд хөдөө орон нутаг, хот хүрээ газраас ч ирж хувиа авцгаасан гэнэ. “Манай нутгийнхан нэгдэл тарлаа” гэж хэрэлдэж муудалцаагүй, өмчөө хуваах гэж зодоон цохион хийгээгүй. Нэгдлийн бүхий л хүн 120 гаруй мянган толгой мал, 4.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, машин тэрэг, байшин барилгаас хувь хүртсэн. Нэгдлийн гишүүд сар бүр хуралдаж, өмчөө хуваана. Хэн нэгэн хүнд ямар нэгэн зүйл тасалж өгөх болбол хуралдаж байгаад л шийдвэрээ гаргаж байсан юм. Тийм ч учраас өмч хувьчлалын талаар ямар нэг хэрүүл ам гараагүй. Авсан юмаа ч үрэн таран хийгээгүй. Малаа сайн өсгөсөн. Өнөөдөр Төмөрбулаг сум малынхаа тоогоор аймагтаа тэргүүлж, 110 мянга гаруй малыг өнгөрсөн хугацаанд 200 гаруй мянган тоо толгойд хүргэж, жилдээ 40 гаруй тонн ноолуур бэлтгэж, үүнийхээ үр шимээр 3.2 тэрбум төгрөг хүртэж байна. Бусад газруудыг бодоход байшин барилгаа ч бага буулгасан газар шүү” хэмээн тэрээр нутгийнхаа ард иргэдээр бахархан ярьж байсан юм. Нутгаараа омогшиж, иргэдээрээ бахархаж явдаг Шарбанди дарга “Аав азарга хоёр” гэдэг сайхан ном бичиж, олны хүртээл болгожээ. Түүний аав “Монжоо заан” гэж олноо хүндлэгдсэн Р. Бямбажав гуай сумынхаа наадамд 5 түрүүлж 6 үзүүрлэсэн. Харин Р.Бямбажав зааны алдартай хурдан Халтар хээр азарга нь сумын баяр наадамд 7 түрүүлж, 5 удаа аман хүзүүдэж байсан түүхтэй. Аймгийн 50 жилийн ойн баяр наадамд бариан дээр шургаад аман хүзүүдэж байсан энэ алдартай хурдан хүлгийг ганц удаа уяж, сойж байсангүй. Улсын баяр наадмын өмнөх өдөр барьж уяад уралдуулдаг, уралдсан л бол түрүүлдэг зартай хурдан хүлгийнхээ тухай Монжоо зааны хүү тун сонирхолтой ном бичиж үлдээсэн байх юм. Б.Шарбанди дарга таван хүүтэй. Түүний эхнэр нь Цэмбэлдоржийн Даваажаргал Төмөрбулаг суманд малын эмчээр ажиллаж байсан аж. Б.Шарбанди дарга гавьяаныхаа амралтанд гарсан ч гэсэн гар хумхиж зүгээр суусангүй. Төмөрбулаг сумын түүх хүүрнэх ахмадуудын нэг Б.Шарбанди дарга өдгөө хувийн хэвшилд ажиллаж байна.

## БАЛДАН МОЁОР

Улсын баатар Л.Даваадоржтой нас чацуу энэ буурал өнөөдөр Төмөрбулаг сумын хамгийн ахмад настнуудын нэг. Хэлмэгдүүлэлтийн бараан сүүдэр дайрч, хүн бүр айдас хүйдэст

автсан бараан жилүүдийг нүдээрээ үзсэн цөөхөн гэрч нарын нэг нь Балдан моёор. Жижиг хар машинтай, ногоон малгайтай Аюулаас хамгаалахын ажилтнууд хаа сайгүй явдаг байсан үеийг ч тэр сайн мэднэ. Лам нарыг баривчилж, сүм дуганыг нь хэмх цохиод л ачиж буулгаж байсныг жаахан хүү нүдээрээ харж байсан гэдэг. Хүн ачигдаж, хөрөнгө эвдэгдэж байхад бүгд л таг чиг. Нохой хуцахаас өөр чимээ гардаггүй байсан хэмээн тэрээр ярьж байсан юм. Энэ их хэлмэгдүүлэлтийн шуурганд олон хүн өртөж, Балдан моёорын ах дүүс ч хэлмэгдэж, зовж явсан түүхтэй. Төмөрбулаг сумын уугуул Шатар гэлэн хэмээх аавынх нь ах хэлмэгдүүлэлтээс зугатааж явсаар насныхаа эцэст эргэж иржээ. Гэвч айдас хүйдэс, дарамт шахалтанд өртөж, их хэлмэгдүүлэлтийн шарх зүрх сэтгэлд нь хурсан энэ хүн гав ганцаараа насаа элээсэн гэдэг. Мөн Жунаа гавж хэмээх авга ах нь бас л хэлмэгдэж, ял сонсож, хол газар хоригдож явсан гэдгийг ч тэр дурсаж ярьж байсан. Балдан моёор гэж олноо хүндлэгдсэн энэ буурал Төмөрбулаг сумын 9-р багт 1926 онд төржээ. Түүний аав цэрэгт татагдаж, Ховдод очиж, Ховдыг чөлөөлөх үед цэргийн хэлтэст ажиллаж, халагдаж ирээд нутагтаа лам нарын гар үйлдвэрийн артелийн даргаар томилогдож явсан удаатай. Балдан моёор ажил амьдралынхаа гарааг Төмөрбулаг сумын 9-р багийн дарга гэдэг албанаас эхлэжээ. Нарийн, Тэлээ, Дуганчийн овоо орчмын газар нутгийг хамарсан том газар нутагтай, 100 гаруй өрх айлтай том багийн дарга тухайн үед улс төрийн суртал ухуулга хийж, ноос, ноолуурын төлөвлөгөө биелүүлэх ажилд хүчин зүтгэж явсан ахмадуудын нэг. Тэрээр Хэнтий аймагт Их бууны ангид алба хааж ирээд тухайн үеийн цагдан сэргийлэх ангид аж ахуй, комендат хийж байгаад туслах төлөөлөгч болжээ. Армид дөрвөн жил, цагдаад 41 жил ажилласан энэ ахмад буурал Цагдаагийн байгууллагад эрүүгийн ахлах төлөөлөгчөөр олон жил ажилласан. Олон жил хууль сахиулах албанд зүтгэж, гэмт хэрэгтнүүдтэй хөөцөлдсөн тэрээр 1987



онд гавьяаныхаа амралтанд гарчээ. Төрөөс түүнд хошууч хэмээх цолыг зүүж өгсөн. Харин нутгийн олон моёор хэмээн энэхүү цолоор нь түүний нэрийг тодотгодог. Тухайн үеийн цагдан сэргийлэх ангид ажиллаж, олныг түгшээсэн гэмт хэргүүдийг мөрдөж явсан Балдан моёорын илрүүлсэн хэргүүдийн жагсаалтыг гаргавал уртаас урт жагсаалт болох нь тодорхой. 1950 онд Тува цаатангуудын хооронд байнга малын хулгай, дээрмийн асуудал үүсдэг байсан гэнэ. Тэр үед Монголын хоёр цаатанг буудаж, мал ахуйг нь тууж одсон хэрэг гарчээ. Хил зөрчиж орж ирсэн дээрэмчдийн араас Балдан моёор тухайн үеийн аюулаас хамгаалахын төлөөлөгчтэй мордож, бүтэн хоёр сар гаруй хөвч тайгаар хэсэж байж, гэм буруутнуудыг илрүүлж байсан гэнэ. Мөрдөн шалгах ажлын асар их дадалга туршлагатай, бүхий л насаа цагдан сэргийлэх, хууль сахиулах албанд зориулсан энэ ахмад гавьяаныхаа амралтыг авахын өмнөхөн эрүүгийн төлөөлөгчийн ажлаас өөрийнхөө хүсэлтээр чөлөөлөгдөж, тухайн үеийн паспортын хэлтэст ажиллаж байжээ. Гэвч нэг гэрийн хоёр хөгшнийг буудаж, охиныг нь авч явсан хэрэг гарч. Энэ дуудлагатай хамт “Хулгайлагдсан охины цогцсыг олсон. Гэмт хэрэгтэн охиныг хүчиндээд чулуугаар цохиж, ам насыг нь бүрэлгэсэн байна” гэдэг мэдээлэл ирж, олныг цочирдуулжээ. Хөвсгөл аймгийн сэргийлэхийн хэлтсийн дарга Балдан моёорыг өөрийн биеэр дуудаж, “Энэ ээдрээтэй, зэрлэг балмад хэргийг та л илрүүлж ир. Таны дадлага туршлага энэ хэрэг дээр хэрэг болоод байна” хэмээн гуйх, тушаахын завсар үүрэг өгчээ. Гэмт хэрэгтнийг харсан хүн байхгүй. Бас хаашаа явсныг нь мэдэхгүй мухар эрэлд гарч, тэрээр замаас таарсан хүн болгоноос асууж сурагласаар Солонготын давааг давж, Завханы Их- Уул сум хүрчээ. Даваан дээр дурандаад зогсож байтал гэнэт морьтой хүн гараад ирж. Эцэж ядарсан морьтой, аяншиж сульдсан тэр хүн зам зуураас сураг гаргасан хүмүүстэй тун адилхан байсан учраас Балдан моёор машинаа мод руу оруулж нуугаад энгийн хувцас өмсөж, замыг тосон очжээ. Үл таних залууг амдан очиж, мэнд мэдэнгүүтээ л учир зүггүй

-Мал төллөж байхад чи хаагуур алга болоод байгаа юм. Бүх хүн ааг амьсгаагүй ажилтай байхад юу хийж сэлгүүцээд байна. Алив наад мориноосоо буу” хэмээн хэзээний таньдаг хүн шиг загнаж эхлэжээ. Хүний аминд хүрсэн гэмт этгээд түүнийг сэргийлэхийн ажилтан гэж огтхон ч сэжиг авсангүй. Хүн л андуурч байна хэмээн бодсон бололтой.

-Би та нарт хамаагүй. Архангайгаас явж байна. Энэ нутгийн хүн биш, малын эрэлчин байна хэмээн зөрүүдлэж, морио ташуурдан зугатах гэж оролджээ. Балдан моёор тэр үед мориноос нь цулбуурдан авч, гэмт хэрэгтнийг баривчилж байсан түүхтэй. Цагаан хайнаг гэдэг хочтой, энэ балмад этгээд тууварт яваад буцаж байхдаа зэрлэг аашилж хүний аминд хүрч, олон сар оргож босч явсны эцэст Балдан моёорт баригджээ. Балдан моёорыг цагдан сэргийлэхэд ажиллаж байхад хуулийн байгууллагын ажилчид өнөөгийнх шиг зэвсэг, хувцас, багаж төхөөрөмж, тусгай хангалт, хангамж гэж байсангүй. Морь унасан, ганц жижиг цүнх, гар буунаас өөр хань болох зүйлгүй сэргийлэхийн ажилтан адуу малын хулгайнаас эхлээд алуурчдыг хүртэл хайж, ууланд бүгсэн Тайгын Төмөртэй хүртэл хөөцөлдөж 40 гаруй жилийг элээсэн байх юм. Түүнийг Дорноговь аймгийн сэргийлэх

ангийн даргаар томилох тушаал ирж байсан ч тэр төрж өссөн нутагтаа хоргодоод явалгүй үлдэж байсан удаатай. 1965 онд ажил үйлсээрээ шалгарч, Монголын сэргийлэгчдээс анх удаа Орост аялах эрхээр шагнуулж, тухайн үеийн ЗХУ-ын гурван том хотод хөл тавьж явсан энэ ахмад “Хятадын цагаан хэрэм гэгчийг л үзэх юмсан” хэмээн мөрөөддөг байсан гэнэ.

-Яагаад гэсэн асуултанд

-Монгол хүнээс айсандаа босгосон тэр том бэхлэлтийг харах юмсан л гэж бодсон юм гээд инээж билээ. Түүний энэ мөрөөдлийг хүүхдүүд нь биелүүлж, аавыгаа Хятад, Солонгост аялуулж, Америкт ирэх урилга явуулжээ. Тэрээр олон сайхан хүүхдийн аав, бас ач зээ нараа тойруулсан хүндтэй өвөө. Түүний гэргий Аюурын Содонпил гэж хүн байжээ. “Миний хань ёстой л цагдаа сэргийлэхийн ар гэр болсон хүн байсан даа. Сайн ханийн буянаар л би цагдаагийн албанд 41 жил зүтгэсэн хүн шүү дээ” хэмээн Балдан моёор дурсан ярьж байлаа. Тэрээр Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, “Алтангадас”, байлдааны медалиудаар шагнуулсан байна.

# ҮЙЛЖ ДУУЛАХ ХОРВООД УДААН АМЬДРАХ УРАН БҮТЭЭЛЧ

Дууны урын сан ая, аялга, хэлбэр, хөгжмийн найруулгыг шинэчилсэн содон бүтээлээр баяжуулах зорилготой Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг “Морин хуур” наадам 2011 онд 25 жилийнхээ хүндэтгэлийн Гала тоглолтыг Соёлын төв өргөөнөө ёслол төгөлдөр зохион байгуулж байсан удаатай. Морин хуур наадам 25 жилийн түүхтэй, 25 ялагчтай. Гэхдээ энэхүү гала тоглолтонд олны сэтгэл зүрхэнд хүрсэн арван шилдэг уран бүтээлийг дээжлэн үзэгчиддээ хүргэж байсан юм. Монголын хөгжмийн зохиолчдын хорооноос гаргасан 10 шилдэг бүтээлийн эздийн нэг нь Жигжидын Жаргалсайхан. 1993 онд Морин хуур наадамд “Тэнгэрийн тамга” дуугаараа түрүүлж байсан Жигжидын Жаргалсайхан Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын хүн. Төмөрбулаг сумын 70 жилийн ойгоор Агтын гол хэмээх сайхан дуу бичиж, тэр дууг Төмөрбулаг сумын улаан буланд дуучин Дэлгэрмаа анх олонд хүргэж байсан түүхтэй. Төмөрбулаг сумын улаан булан нэртэй жижигхэн цагаан байшинд нутгийн ахан дүүстээ мэхийн ёслол байсан, хүний сэтгэлийг хөндсөн уран нарийн мэдрэмжтэй, төрлөхийн авьяас билэгтэй, хөгжмийн асар өндөр боловсролтой энэ хүн бидний дунд алга. Харин зохиосон дуунууд нутгийн зон олныхоо төдийгүй, монголчуудын сэтгэл зүрхэнд мөнхрөн үлдэж, ард түмнийхээ дунд эгшиглэсээр байна. Жигжидын Жаргалсайхан 1957 оны 1 дүгээр сарын 13-нд төржээ. Багаасаа л урлагт сонирхолтой байсан жаахан хүү дөнгөж дөрөвдүгээр ангиа төгсөөд их хотын зүг хүлгийн жолоо залж, Улаанбаатар хотын хөгжим бүжгийн дунд сургуульд элсэн орсноор хөгжмийн ертөнцөд хөл тавьсан юм. Тэрээр 1978 онд “Аль хүрэх юм бол” хэмээх шүлэг бичиж, түүндээ ая зохиож байсан аж. Хэдийгээр энэ дуу түүний анхны уран бүтээл байсан ч гэсэн удалгүй олны хүртээл болж, ам дамжин дуулагддаг дуунуудын нэг болж чаджээ. “Тайгын залуус” нэртэй хамтлаг байгуулж, улс төрийн дууны анхдугаар наадамд тусгай шагнал хүртэж байсан энэхүү хөгжмийн зохиолч маань ЗХУ-ын Ленинград хотын Соёлын дээд сургуулийг төгссөн, мэргэжлийн хөгжмийн зохиолчдын нэг. Тэрээр Хөвсгөл аймгийн ХТД-т хөгжмийн багш удирдаач, 1990-1991 онд Монголын үндэсний Телевизийн хөгжмийн найруулагч редактор, 1991-1994 онуудад МҮЭ-ийн Соёлын төв ордонд хөгжмийн багш, 1996 оноос Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Соёл урлаг, спорт залуучуудын асуудал эрхэлсэн түшмэл, 1990 оноос Батлан хамгаалахын их сургуульд хөгжмийн багшаар ажиллаж байсан юм. Тэрээр тал бүрийн авьяастай нэгэн байлаа. Олны сэтгэлд шингэсэн зохиолын дуунууд, үндэсний хөгжимд зориулсан аялгуу бичиж үлдээснээс гадна бие даасан олон арван концерт, “Учиртай гурван толгой” дуурь, “Амьдралын улаан шугам”, “Алиа Тогмид” зэрэг хөгжимт жүжгүүдийн удирдагчаар ажиллаж, байсан бөгөөд дан хөгжмийн болон

кино, жүжиг, бүжгийн хөгжим, нийтийн дуунууд зохиож уран бүтээлээрээ Монгол туургатны танил болсон төдийгүй олон шавь төрүүлсэн багш хүн байжээ. Хөгжим бичихээс гадна өөрөө ч сайн хөгжим тоглодог байсан энэ уран бүтээлч Ленинград хотод сурч байхдаа үлээвэр хөгжмийн улсын уралдаанд оролцож 3-р байранд шалгарч байсан гэдэг. Түүний бүтээлүүдээс хамгийн алдартай нь “Хангал цааны хатираа” нэртэй үндэсний хөгжимд зориулан бүтээл. Өнөөдөр ч энэ бүтээл Монголын радиогийн “Алтан сан”-д хадгалагдаж, үндэсний хөгжмийн шилдэг аялгуугаар тодорч, “Тэнгэр аялгуу” нэртэй шилдэг бүтээлийн цомогт багтжээ. Үүнээс гадна тэрээр Төрийн соёрхолт яруу найрагч З.Доржийн шүлэг “Уйлж дуулах хорвоо” дуугаараа “Морин хуур-90” наадмын тусгай шагнал, Д.Баасанжавын шүлэг “Туулын хөвөөнд”, Ц.Сайннямбуугийн шүлэг “Хайрын дуу” зэрэг дуунууд нь Хайрын дууны уралдаанд тусгай шагнал, “Миний унасан шүлэг” дуу нь “Монголын аялгуу” дууны наадамд 2-р байранд шалгарч байжээ. Сайн дуу сайхан дуучныг төрүүлдэг гэдэг үнэн аж. Түүний “Тэнгэрийн тамга” дууг анх дуучин Д.Ширмэнтуяа 19-хөн настайдаа Морин хуур наадмын тайзан дээр дуулж, өөрийгөө үзэгчдэд таниулж байсан бол энэ хугацаанд Монгол улсын гавьяат жүжигчин хэмээх эрхэм цолыг хүртжээ. Өнөөдөр Тэнгэрийн тамга дуулагдсаар...”Хар сарнай” хамтлагын дуучин С.Амармэнд энэ дууг шинэчлэн дуулж, “Тэнгэрийн тамга” нэртэй цомгоо хүртэл гаргажээ. Монгол улсын соёлын тэргүүний ажилтан, “Морин хуур” наадмын тэргүүн шагналт, Хөгжмийн зохиолч агсан Жигжидийн Жаргалсайханы дуунууд цаанаа л нэг өөрийн гэсэн утга уянгатай, хүний сэтгэлийг хөвсөлзүүлж, хөнгөн гуниг дагуулсан өвөрмөц нарийн аялгуутай байдаг. Тиймээс ч дуу болгон нь урт удаан хугацааг туулж, ардын дуу мэт аманд аялагддаг байдаг.

Орчлонд хавар ирэх цагт нь хө

Оргил хангай нь цэцэглэнээ найз минь

Хангайн цэцэгсийн цэцэглэхийг харахаараа

Хайрын сэтгэл уярнаа анд минь хэмээн уярал, ухаарал хайрласан хөнгөн аялгуу “Гэнэн сэтгэл” киноны дуунаас эгшиглэж,

Хархүү чамдаа дурлаад байна

Хайрлана уу байна уу өөрөө мэддээ

Ханилж л суухыг хүсээд байна

Өрөвдөнө үү байна уу өөрөө л мэддээ гэсэн гэгэлгэн шад мөртэй, ардын дуу шиг л сэтгэл сэртхийлгэсэн намуухан эгшиг “Тунирхалын дуу”-наас бороо адил зүсэрч, хүний нүднээ нулимс болон тогтох нь бий.

Их л залуухан санагдана даа бодогдоно доо хө

Элээсэн оймсоо тоолох уу даа байх уу да хө

Намрын навчис гандана даа гундана даа хө

Нартын жамыг тойрох уу даа дайрах уу даа гэсэн үгтэй “Уйлж дуулах хорвоо” нэртэй Зундуйн Доржийн шүлгийг тэрээр дуу болгон олондоо хүргэсэн. Нар өргөсөн найрын хаяанаас эгшиглэх, нас нэмсэн намрын өдрүүд шиг л санагдах энэ шаргал аялгуу бас л зүрх сэтгэл хөвсөлзүүлсэн нарийн хөгтэй. Түүний дуунууд ард түмнийхээ дунд ардын дуу шиг аялагдсаар... Жигжидийн Жаргалсайхан гэгч энэ хүн дуугаараа, айзам яруу хөгжмүүдээрээ уйлж дуулах хорвоод удаан амьдарна...



## 55 ЖИЛ ДАРГА ХИЙСЭН ХҮН

“Д.Батаа гуай бол бүхэл бүтэн ном юм. Түүхэн үнэнийг цаг цагийн урсгалыг, бас өнөөдрийг энэ боть номноос уншиж болно. Эргүүлж тойруулж, эрт эдүгээг эргэцүүлж, их юм сонсоно, ухаарна, мэднэ, тунгаан бодох юм ч их гарна. Хүний сайхан дотроосоо гэрэлтэж, гадагшаа цацарч байдаг жамтайг Д.Батаа гуай гүнээ ухаарч, хүнтэй жаргал зовлонг нь хуваалцахыг бодно. Эх орныхоо ачааны хүндээс өргөлцөж, явсан эгэл даруухан түүхэн хүн гэж байдаг. Ноён нурууны хаттай тийм л түүхэн хүмүүсийн нэг нь Дуламжавын Батаа яах аргагүй мөн” хэмээн зохиолч, сэтгүүлч, яруу найрагч Д.Сүрэнжав бичжээ.Олноо Батаа дарга гэж хүндлэгдсэн энэ хүн 1926 онд Засагт хан аймгийн Далай гүний хошуу, одоогийн Төмөрбулаг сумын



9-р багийн нутаг, Хэцүүгийн амны дунд өвөлжөөнд мэндэлжээ. Гэрээр хуучин, шинэ бичиг заалгасан хүү 1943 оны эхээр 17 настайдаа Төмөрбулаг сумын зарлага, бичээчээр томилогдож байжээ. Эх орны дайнд зөвлөлтийн улаан армид туслах бэлэг цуглуулж, Төмөрбулаг суманд хашаа барих, худаг гаргах, хадлан тэжээл бэлтгэх ноос ноолуурын төлөвлөгөө биелүүлэх ажилд хүчин зүтгэж, залуучуудаа манлайлан оролцож байсан энэ хүн 1944 онд сумын эвлэлийн үүрийн даргаар ажиллаж байжээ. 1947 онд Төмөрбулаг сумын ноосны төлөвлөгөөг хоёр сарын дотор биелүүлэх хатуухан үүрэг авч, өгсөн үүрэг даалгаварыг нь биелүүлсэн ч алдаа завхрал гаргасан хэрэгт буруудаж, Намын төв хороонд хүртэл шалгагдаж, гэм буруугүй гэдэг нь тогтоогдсон ч МАХН-ын 11-р их хурал дээр Маршил Х.Чойбалсангийн илтгэлд хүртэл тэмдэглэгдэж явсан түүхтэй. Хөвсгөл аймгийн Залуучуудын эвлэл, аймгийн бага хурал, аймгийн гар үйлдвэрийн холбоонд ажиллаж байсан Д.Батаа 1950 онд цэргийн албанд татагдаж, Улсыг батлан хамгаалах яамны эмнэлгийн хэлтэст бичээч, Сөгнөгөр, Баянголын амралтанд эх зохиогч, жагсаалын даргын үүргийг гүйцэтгэж, 1953 онд цэргээс халагджээ. Тэрээр 1956 оны наймдугаар сараас Цагааннуурын Загсны үйлдвэрийн даргаар томилогдож, 1964 он хүртэл ажиллаж байжээ.Хоймор нутгийн хойд хил хязгаар болсон Цагааннуур суманд загасны үйлдвэр байгуулах шийдвэр гарч, Д.Батаа дарга газар хэмжин гадас зоож, монголын анхны загас агнуурын үйлдвэрийн суурийг тавьсан түүхтэй. Өвлийн улиралд цельсийн хасах 29-53 хэм хүртэл хүйтэрч, зуны улиралд цельсийн нэмэх 12-23 хэм хүртэл дулаардаг, жилийн дундаж хур тунадас нь 320 мм хүрдэг. Хойд талаараа Их Саяны салбар уул 2100-2900 м өргөгдсөн сарьдагуудтай,

хамгийн өндөр цэг нь Холбонтой уул далайн түвшнээс дээш 2339.6 метр өргөгдсөн энэ нутагт үйлдвэр байгуулна гэдэг амар байгаагүй нь лавтай. 1956 онд Ренчинлхүмбэ сумын хоёрдугаар багийн нутаг Хогорогын аманд загасны үйлдвэр барих үеэр цаатан ардуудыг суурьшуулах ажил давхар хийгдэж байжээ. Уул тайгад амьдардаг цаатан иргэдийг энэхүү загасны үйлдвэрт ажиллуулах, гол ажилчдыг цаатангуудаас бүрдүүлэх дээд газрын шийдвэр иржээ. Д.Батаа дарга суртал ухуулгын ажил хийж, тайга руу мацан цаатангуудтай уулзаж, хараалгаж загнуулж, хөөгдөх шахам явжээ. Тэр тухайгаа тэрээр “...тэр үед цаатангуудыг загасны үйлдвэрт авч ирж ажиллуулах гэж машинд ачих гэж бөөн ажил болдог байсан”. Анхны өрх бол Намжилсүрэн гэдэг дөрвөн хүүхэдтэй цаатан эмэгтэй үйлдвэрт ажил хийх болсон. Тэрнээс хойш ихэвчлэн залуучууд нь ажиллах болсон хэмээн дурсаж байжээ. Д.Батаа даргын энэхүү дурсамж “МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ИЛТГЭЛ 2009”-д хадгалагдан үлдсэн байна. Д.Батаа дарга цаатангуудыг зөвхөн загасны үйлдвэрт ажиллуулаад зогссонгүй. Тэдэнд зориулж тус бүр нь хоёр өрөө бүхий 30 байшин барьж, жижиг цахилгаан станц, радио, хүүхдийн цэцэрлэг, ясли, бага сургууль зэргийг Цагааннуурт байгуулж өгч, аймгийнхаа төв ч орж үзээгүй цаатан иргэдийн төлөөлийг 1967 онд Улаанбаатарт авчирч, нам засгийн удирдлагуудтай уулзуулж байжээ. Тэрээр Цагааннуурт Дархад, цаатнуудын аж амьдралыг харуулсан музей хүртэл байгуулж, билгүүн номч Б.Ренчингээс магтаалын үг сонсож явсан ховорхон хүмүүсийн нэг нь. Хэдийгээр мориор загас агнуур явуулж байсан ч гэсэн 1956 онд л гэхэд 60.3 тн загас агнаж, агнасан загасаа Орос руу экспортонд гаргаж байжээ. Тэрээр Буйр нуураас загасны мэргэжилтэн, хятад, казак загасчдыг ч урьж авчиран загас барих арга техникийг нутгийн олонд зааж өгч, биологийн шинжлэх ухааны эрдэмтэн А.Дашдорж, А.Дулмаа зэрэг эрдэмтэн мэргэдтэй хамтран ажиллаж байсан аж. Гэвч 1964 онд Хөвсгөл аймгийн Гурил тэжээлийн үйлдвэрийн даргаар томилогджээ. Энэ л байгууллагад тэрээр 27 жил ажилласан юм.Тэрээр Гурил тэжээлийн үйлдвэрийн анхны дарга нарын нэг. Тэрээр ажлаа хүлээж аваад гурилын үйлдвэрийн дэргэд малын хүчит тэжээлийн үйлдвэр байгуулж, багсармал болон хивэг үйлдвэрлэж, Хөвсгөл аймгийн гурилын үйлдвэрт гурван удаа их өргөтгөлийн ажил хийж байсан байх юм. Д.Батаа даргын үед энэ үйлдвэр бүтээгдэхүүнээрээ Хөвсгөл Завхан аймгийг бүрэн хангаад зогсохгүй илүү гурил, тэжээлээ Орос, Вьетнам, Солонгост гаргаж байсан гэж бодохоор энд ямар их бүтээн байгуулалт, басхүү нөр их хөдөлмөр өрнөж байсан нь тодорхой. Мөн Хөвсгөлийн гурилын үйлдвэрийн харьяа аюулаас хамгаалах тэжээлийн улсын фондыг дөрвөн суманд байгуулж байжээ. Тэрээр энэ үйлдвэрийг удирдаж байхдаа хөдөө аж ахуйн нэгдлүүдийн зам даваа засах, хашаа саравч барих, хадлан тэжээл бэлтгэх, усан сан байгуулах зэрэг томоохон ажлуудад хүн хүч, хөрөнгө мөнгөний туслалцаа үзүүлж, Улсын баатар Л.Даваадоржийн хөшөөний эргэн тойрныг хатуу хучилттай болгож, хүүхэд залуучуудын соёл спортын хүрээлэн, “Уран дөш” пионерийн зуслан, цэцэрлэг, ясли, Айргийн эмнэлэгт өргөтгөл хийхэд мөн л сэтгэл, зүтгэл, хувь нэмрээ оруулж байсан юм. Бүхий л амьдралаа бүтээн



байгуулалтын их ажилд зориулж явсан хүний хөдөлмөр бүтээлийг төрөөс үнэлж, “Алтан гадас”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ. Бүтээсэн ажилтай, байгуулсан гавьяатай ийм нэгэн ахмад нам, олон нийтийн байгууллагад 12 жил, улсын үйлдвэрт 33 жил, нийтдээ 45 жил ажиллаад тэтгэвэртээ гарсан ч гар хумхин зүгээр суусангүй. Ахмадын хоршооны даргаар таван жил ажиллаж, 1996-1998 онуудад Говь” хувьцаат компанийн Мөрөн дэх жуулчдын үйлчилгээний цогцолборын ашиглалтын өмнөх захиргааны даргаар гурван жил ажиллаж, ашиглалтанд оруулан хүлээлгэж өгчээ. Тэрээр 1943-1998 он хүртэл 55 жил даргын алба хашиж явсан байх юм. Хөдөлмөр бүтээлээрээ хөвсгөлчүүдийн дунд тодоос тод намтар мөрөө үлдээсэн энэ хүн төрж өссөн Төмөрбулаг сумандаа сэтгэл зүрнээсээ хайртай хүн байсан юм. Тэрээр “Сэтгэлд дотно Төмөрбулаг” хэмээх фото альбом хэвлүүлж, өөрийнхөө дурсамжийнхаа номыг “Алаг хорвоо-Алтан нутаг” хэмээн нэрлэжээ. Д.Батаа гуай өөрийнхөө дурсамж тэмдэглэлд “Би улсад 50-иад жил ажиллахдаа бэрхшээл, зовлон жаргал бишгүй үзлээ. 1947 онд алдаа завхрал гаргасан хэргээр шоронгийн хаалга татаж, намын 11-р Их хурал дээр Маршил Х.Чойбалсангийн илтгэлд “халуун толгой” нэр зүүж байсан бол 1976 онд хуралдсан Намын Их хуралд төлөөлөгчөөр сонгогдож, “Алтангадас” одонгоор энгэрээ мялааж байлаа. Найман жил загасны үйлдвэрийн дарга хийж, олон сая загас бариулж “нүгэл үйлдсэн бол 28 жил олон зуун хүн малыг хүнс тэжээлээр хангаж явлаа” хэмээн дурсан бичжээ. Цагааннуурын загасны үйлдвэр, Хөвсгөлийн гурил тэжээлийн үйлдвэр, Говь жуулчин компанийн Хөвсгөл аймаг дахь салбар гэсэн гурван том байгууллагын улаан шугам тавихаас эхлэж, улаан тууз хайчлах хүртэлх бүхий л ажлыг хариуцаж, бүтээж босгож явсан энэ хүний намтар түүхээс цухасхан өгүүлэхэд ийм байна. Тэрээр 1960 онд Ц.Сольхүүтэй ханилж, хоёр хүү төрүүлжээ. Түүний том хүү Хөвсгөл аймгийн Засаг дарга Б.Батхүү. Аав шиг нутаг орноо гэсэн халуун дулаан сэтгэлтэй, хийж бүтээх урам зориг, хүсэл тэмүүлэл дүүрэн энэ залуугийн тухай бид дараагийнхаа хуудсанд дэлгэрэнгүй өгүүлэх болно.

## ЭРДЭНЭСИЙН ХАЙГУУЛЧ

Төмөрбулаг суманд төрж өссөн олон залуус Монгол орны өнцөг булан бүрт, бүр тив дэлхийн олон улс, оронд ажиллаж амьдарч байгаа. Эзэмшсэн мэргэжил, эрхлэж буй ажил өөр, өөр ч гэсэн эдгээр залуучууд Монгол хүн хэмээн угсаа гарвалаараа, Хөвсгөлийн хүүхэд хэмээн төрсөн нутгаараа, Төмөрбулагын уугуул гэж унасан газар, угаасан усаараа бахархаж явдаг. Тэдний нэг нь Аюуржавын Дандар. Төмөрбулаг суманд төрж өсөж, зургадугаар ангид байхдаа л аймгийн төвд анх удаа ирж үзэж байсан энэ хүн “Манай Төмөрбулаг сум олон Аюушжавтай. Манай аав даравгар Аюушжав нь. Аав маань Бадгийн амных, харин ээж Цагаан бургасны амны хүн шүү дээ” хэмээн хээ шаагүйхэн инээж суусан юм. Ах дүү арвуулаа өссөн энэ залуу 1979 онд 10 дугаар ангиа төгсөөд тухайн үеийн Политехникийн дээд сургуулийг Геологи хайгуулын инженер мэргэжлээр төгссөн. Геологийн шинэхэн инженер анх Баянхонгор аймагт томилолт өвөртлөн очиж, тэнд ажиллаж байгаад Хөвсгөлийн Геологийн ангид иржээ. Геологи хэмээх их айлын ам бүлд багтаж, 20 гаруй жил энэ салбарт ажиллаж байгаа А.Дандар дарга Архангай аймгийн Их байцын уурхайн геологийн нөөцийг тогтоож, Заамарын алтны уурхайд ажиллаж, Хөвсгөл далай дээр жуулчны бааз байгуулж, 2003 онд Хөвсгөл геологи компани аймгийн УСНАК-н газрыг менежментийн хувьчлалаар авахад менежерээр ажиллаж байжээ. Харин өнөөдөр тэрээр Хөвсгөл геологи компанийн ерөнхий инженерээр ажиллаж байна. Геологич хүн өдөртөө доод тал нь 20 орчим км алхдаг. Зүгээр гар хоосон явдаггүй. Р. Бямбажав судлан шинжилж буй чулуу, хайгуул, шинжилгээний багаж хэрэгслээ үүрээд явах хэрэгтэй болно. Тиймээс зориг, тэвчээр, хатуужил, зорьсон зүйлээсээ буцахгүй зүтгэх тийм л тууштай шинж чанар геологич хүнд аяндаа төлөвшдөг. Голдуу ганцаараа явган явдаг учир аюулгүй байдлаа хангах гэж ухаан шаардана. Гярхай, ажигч байх хэрэгтэй болно. Мөн геологич хүн археологи, сансар, биологи, шашин гээд шинжлэх ухааны бүхий л чиглэлийн өргөн мэдлэгтэй байх шаардлагатай хэмээн Дандар дарга ярьж байсан юм. Нэгэнт Монгол улсын зөвлөх инженер, асар олон хайгуул судлагааны ажил дээр ажилласан туршлагатай хүнтэй уулзсан учраас Төмөрбулаг суманд хайгуул судлагааны ажил хэр хийгдсэн, хаана, ямар байгалийн баялаг байгаа вэ гэсэн асуулт өөрийн эрхгүй амнаас уначихлаа. Дандар дарга миний асуултанд хариулахдаа огтхон ч татгалзсангүй. Энэ л нутагт төрж өссөн хүний хувьд байгаль орчныг байнга ажиглаж, басхүү харьцуулан үзэж байдгаа ч тэр нуусангүй. Харамсалтай нь Төмөрбулаг суманд геологи судлагааны ажил тун



бага хийгдсэн байдаг аж. Төмөрбулаг сумын хойд тал Бадаг Донхорын хойгуур улсын төсвийн хөрөнгөөр 50000-ын зураг хийж байсан удаатай гэнэ. Гэхдээ нарийн судлагаа хийгдээгүй байгаа хэмээн тэрээр ярьж байсан. Д.Дандар дарга Тариатын эх, Тээлийн төвийн урдуур нүүрсны орд газар байх боломжтой гэж үзэж, Тээл, Шар хөндийд нарийвчилсан судлагаа хийх саналаа холбогдох байгууллагуудад гаргаж өгчээ. Гэвч геологи хайгуулын судалгаа хийхэд асар их хөрөнгө мөнгө шаарддаг. Улсын төсвөөс л санхүүжилт авахгүй болхэн нэгэн хүн сайн дураараа хийх боломж тун хомс байдаг тухай тэрээр дурьдаж байсан юм. Төмөрбулаг суманд төмрийн хүдэр бий, эрт цагт ашиглаж байсан аман яриа байдаг ч гэсэн геологийн мэдээнд энэ тухай ямар ч баримт, мэдээлэл байдаггүй юм байна. Харин вольфром, болор гэх мэт байгалийн баялгийн илэрц байгаа гэдгийг тогтоогоод байгаа ч ашиглах хэмжээний агуулга бага, нарийн судалгаа бас л хийгдээгүй байгаа аж. Геологич хүний хувьд А.Дандар дарга өөрөө ажиглалт хийж, “Эрчмийн нуруунаас Олон голын бэлчир, Шар хөндий, Бүгдгээн гээд судлаж үзэх газар цөөнгүй байгаа. Билүүгийн ам, Шар хөндий, Бүгсийн голын ай сав газруудад нарийн судлагаа хийвэл том орд биш юмаа гэхэд орон нутгийнхаа хэрэгцээг хангах хэмжээний нүүрсний бичил уурхай байгуулах боломжтой. Бүгсийн гол дагасан хөндийгөөс нүүрс, хүлэр занар гарах боржин чулуу ихтэй байх магадлалтай” хэмээж байлаа. Түүнтэй ярилцаж суухад “Цаашид нарийн судалгаа хийж, судлагдаагүй үлдсэн газар нутгаас асар их баялаг илрэн гарч ирж, ард түмний амьдрал ч өөдлөн дэвжих магадлалтай л юм байна гэсэн өөдрөг бодол өөрийн эрхгүй сэтгэл хөглөж байлаа. Учир нь Төмөрбулаг сумын уугуул энэ хүн геологи хайгуулын ажилд гаршсан, бас нутгаа гэх халуун дулаан сэтгэлтэй залуучуудын нэг. Тэрээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1х50,000-ын хайгуулын ажилд оролцож 10 гаруй тайлан бичиж байсан туршлагатай геологич. Өнөөдөр түүний удирдлага дор ажиллаж байгаа Хөвсгөл геологи компанийн ажилчид Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Өмнөговь аймгийн Ноён сэврэй, Дорноговь аймгийн Хөвсгөл, Хатанбулаг сумдад улсын төсвийн хөрөнгөөр 1х50,000-тын судлагааны ажил хийхээр гурван анги болон гарчээ. Өөрөөр хэлбэл нэг анги 3500 км квадрат талбайд ерөнхий судлагаа хийж, ашигт малтмал байх магадлалтай газруудыг тогтоохоор ажиллаж байгаа гэсэн. Үүний дараа тайлан бичиж, дахин судлагаа хийх шаардлагатай газруудыг тогтоодог аж. Үүнээс гадна А.Дандар даргын удирдсан хайгуулын ангийнхан Завхан аймгийн Ургамал суманд хоёр жил гаруй хайгуул хийж, Эрдэнэтийн дараа орох зэс, молбидены том орд нээж, ирэх онд нөөцөө тогтоохоор ажиллаж байна. Түүний хувьд Монголын толгой болсон том геологичид эрдэмтэдтэй хамтран ажиллаж байсан асар их туршлагатай энэ хайгуульч удахгүй төрж өссөн нутгийн олондоо чих баясаж, сэтгэл тэнийлгэх өөдрөг мэдээ дуулганаа гэдэгт эргэлзэхгүй байна. Тэрээр геологи хайгуулын ажлаас гадна улс төрийн ажилд ч идэвхтэй оролцдог нэгэн. МАН-ын хорооны гишүүн, Тэргүүлэгч гишүүнээр ажиллаж байсан бөгөөд 2009 онд Мөрөн сумын ИТХ-д сууж байсан. Харин 2012 онд Орон нутгийн сонгуульд нэр дэвшиж аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна. Түүний эхнэр Туяа Шинэ-Идэр сумын уугуул бөгөөд Хөвсгөл аймгийн мэргэжлийн хяналтын газарт байгаль орчны байцаагчаар ажилладаг аж. А.Дандар дарга 2013 онд Алтангадас одонгоор шагнагджээ.

## СҮҮЛЧИЙН УЛААЧ

Пөөжийн Дорлигжав хэмээх энэ буурал нутгийнхны ярилцаж хэвшснээр эсэргүүний жил буюу 1932 оны өвөл Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Гурван Гүвээгийн Сайр /улаан нүдэн Данзангийн сайр, хожмоо Ёндонгийн сайр, одоо Балжирийн эсвэл Бааяан сайр гэж нэрлэдэг/-ын Худагийн өтөг гэдэг газар малчин ард Самдангийн төржээ. Тэрээр тун гарын дүйтэй уран хүүхэд байсан бөгөөд 12-13 наснаасаа маш сайн хийцтэй, гараар гардаггүй монгол цоож, гурав гурваараа дотор дотроо ордог бургасан араг хийдэг байжээ. Хотогойдуудын үе дамжин хийдэг байсан уран нарийн хийцтэй эмээлийн мод хийж, харганалдаг байсан гэнэ. Тухайн үед эмээлийн модонд алтан харгана, хүрэн модны хальснаас будаг гаргаж авч өлзий хээ бусад хээ тавьж зурж чимэглэдэг байжээ. Ер нь тэр үеийн нутгийн хүүхдүүд 13-14 наснаасаа эмээл, төмрийн дарх хийдэг, Завхан, Баянхонгороос хот руу явдаг жинчид өвөл дайрч явахдаа тэдний хийсэн зүйлийг худалдаж авдаг байжээ. Тиймээс хүүхэд бүр л эмээл, ташуур, сүхний иш гээд хангай нутагт модоор хийж болох бүгдийг л хийдэг байжээ. П.Дорлигжав 16 настайгаасаа сумын өртөөнд улаач хийж, Эрчмийн нурууг Жилчигээр даван алба залгуулж явсан бөгөөд 1949 онд Монгол улсад өртөөний албыг халах шийдвэр гарсны дараа хамгийн сүүлчийн өртөөг хийж явжээ. Төмөрбулаг сумын сүүлчийн улаач нарын нэг энэ хүний намтар Төмөрбулаг сумын түүхтэй салшгүй холбоотой. Тариатын аманд, 1947 онд “Давшилт” нэгдэлийг анх их авга ах га Ёндон, Цог түүний хүү Дорж, Дамбаравжаа болон хүү Ламжав, ногоон Галсан, Дандиа, луглаа Даваа Д.Түдэвванчиг, Тугнуу Амбаа, Цамбын Цагаажав, Жамьянрагчаа, Ёндонгийн Шагдар, нэгдлийн дарга бугар Рагчаа зэрэг улсуудын хамт байгуулж, нэгдлийн тариа тарьж, ууланд мод бэлдэн, малын хашаа барих, дээр дурдсан эмээл, сүхний иш, ташуурын яргай зэрэг бүтээгдэхүүн хийж байжээ. Нэгдлийн гишүүдийн хийсэн бүтээгдэхүүнийг Баянхонгор, Завхан зэрэг газруудаар аваачиж зардаг настайчууд ч байсан гэнэ. Бага насандаа ээж ааваасаа өнчирч хоцорсон хүү, өргөмөл эгч Дэжид, ах Жамсранжав нарын амьдарч байгаад 1951-1953 онд Замын-Үүдийн хилийн цэргийн 12-р отрядад цэргийн алба хаажээ. Цэргээс халагдсаныхаа дараа мөн оны




9 сараас Төмөрбулаг сумын бага сургуулийн комендантаар ажиллаж явсан гэнэ. Тэрээр 1954 оны 9 сараас Улаанбаатар хотод Санхүүгийн Техникумд нягтлангийн курст сууж нягтлан болоод 1955 онд нутагтаа буцаж очоод аймгийн Хоршоодын холбоонд ажиллаж эхэлжээ. Хөвсгөлийн Эрхэл нуур дээр мал сүрэглэх баазын нягтлангаар Ханхаар гаргах Хөвсгөлөөс болон баруун аймгаас орж ирж байгаа мал, арьс шир, ноос ноолуурын тоо бүртгэлийг хариуцан баазын дарга Ядамжав /Арбулагийн/ гэдэг хүнтэй цуг ажиллаж байсан байна. Энэ малыг хөлөөр нь Бор бургасны даваагаар давуулаад тууж эсвэл усан онгоцоор явуулдаг байжээ. Тухайн үед манаачаар тарган Пүрвээ, хөгшин нь Халтар гэж хоёр хүн байсан хэмээн тэрээр дурсан ярьж байна.

1955 оноос барилгын хэрэг эрхлэх ерөнхий газар, барилгын нэгдсэн үйлдвэрт нягтлан бодогчоор, Дундговь аймгийн авто баазын ерөнхий нягтлангаар, Улаанбаатар хотын Худалдааны трестэд нягтлангаар ажиллаж байгаад 1968-1991 он хүрч тэтгэвэрт гартлаа Худалдаа Бэлтгэлийн Яамны харьяа Худалдааны Засвар Зарлал Чимэглэлийн газарт тоног төхөөрөмжийн засварчин, цехийн дарга зэрэг ажлуудыг хийж байсны хажуугаар намын үүрийн дарга зэрэг сонгуульт ажлуудыг ч хариуцлагатайгаар хийж гүйцэтгэж байсан аж. Одоо Улаанбаатар хотод үр хүүхэд, ач, гучаа хүмүүжүүлэн өндөр насыг наслан амьдарч сууна.

## ЦАГ ХУГАЦААНЫ ГЭРЧ

Санж-Ёндонгийн Бат-Очир. Улиран өнгөрч одсон цаг хугацааны гэрч болсон энэ ахмад буурал 1927 онд Бүгсийн голд төржээ. Цаг хугацаа түүнд хамаг ачааг үүрүүлж, нурууг нь бөхийлгөн, өдөр хоногууд өөрийнхөө дураар нүүрийг нь сараачиж, үрчлээ нэмж орхио юу гэмээр... Нуруу нь бөгтийж, нүүрэнд нь үрчлээ суусан ч гэсэн түүний ой ухаан гайхалтай саруулхан. Цаг хугацааг сөхөн, өнгөрсөн түүхийг сэтгэлд зуртал хуучилж суусан юм. Түүний аав Санж-Ёндон сумын нарийн бичгийн даргаар олон жил ажиллаж байсан гэнэ. Харин С.Бат-Очир гуай 12 настай жаахан хүү байхдаа л бригадын ухуулагчаар томилогджээ. Сонин хэвлэл зөөж, захидал бичиг зар түгээж, багийнхаа айл өрх бүрт шинэ сонин мэдээ дуулгах, үүрэг даалгавар хүргэх ажилтай, морин дэл дээр дарцаг шиг намирч явсан жаахан хүү Бүгсийн хүрээг буулган мод чулууг нь зөөж, лам нарыг барьж хорьж байхыг ч өөрийн нүдээрээ харж байсан гэнэ. Морин өртөө халагдаж, машин тэрэг Төмөрбулаг суманд анх ирж, адуу мал үргэж, хүүхэд багачууд дагаж хошуурч, явдаг төмрийг харсан олон хүн гайхаж шагшиж байх үеийг ч тэр сайн мэднэ. Маршалын анхдугаар таван жилийн төлөвлөгөөний тухай анхны мэдээг олонд хүргэж, ноос ноолуурын төлөвлөгөө биелүүлэх үүрэг даалгаврыг сурталчлан таниулах их ажилд тэрээр оролцож явжээ. Анхдугаар таван жилийн төлөвлөгөө, нугалаа завхрал гарч, элдэв цуу дэгдэж, ардын сэтгэл үймж байсан үеийг ч сайн мэдэх хүмүүсийн нэг нь С.Бат-Очир гуай. Эх орны дайны хүнд хэцүү тэр үед агт цуглуулж, мөнгө төгрөг бэлэг цуглуулах их ажилд оролцож, багийн хурал хийж, фронтод илгээх бэлэг ганзагалан давхиж явсан залуу, нэгдлийн дарга нарын тушаалаар өнөөгийн сумын төв дээр агтны хашаа барилцаж, адуу малиндаж явсан гэнэ. Тухайн үед адууг хашиж байгаад нүдэнд нь эм дусаадаг. Ямар нэг өөрчлөлт гарахгүй бол шууд фронтын бэлэг хэмээн бүртгэж авдаг байжээ. Төмөрбулаг суманд адуу малиндах ажлыг хэд, хэдэн удаа зохион байгуулж, тэнцсэн адууг Баян-Өлгий аймагт хүргэж өгч байсан тухай тэрээр хуучилж байсан юм. Өөрөө бие даан бичиг үсэг сурсан хүүд ухуулагч гэсэн үнэмлэх олгож, сургуульд сурах ч завгүй давхисаар 1948 онд цэрэгт татагджээ. Тэрээр Өмнөговь аймагт гурван жил цэргийн алба хааж, цэргээс халагдаж ирснийхээ дараа намын 10 хоногийн сургууль дүүргэжээ.



Бригадын намын үүрийн дарга, ахлах ухуулагч гэдэг албатай залуу 1955 онд Тээлийн голын 10 гаруй айлыг нэгтгэж, “Давшилт” нэгдлийг байгуулж байсан түүхтэй. Цөөн хэдэн малаа “Давшилт” нэгдэлд нийгэмчилсэн залуу эр мал нийгэмчлэх ажлыг зохион байгуулж, нэгдэл нийгмийн ач тусыг олонд ухуулан таниулах үүргийг намаас авч, айл бүрт очиж, заримд нь хөөгдөж, туугдаж явсан ч удаатай. Олон жижиг нэгдлүүдийг нийлүүлж байх үед тэрээр 10 ухуулагч ахлан ажиллаж, 1958 онд аймгийн тэргүүний ухуулагч болон мандаж, зураг нь аймгийн захиргааны үүдэнд хадагдаж, Ухуулагч нарын Улсын хоёрдугаар зөвлөгөөнд төлөөлөгч болон оролцож явжээ. Ухуулга сурталчилгааны ажлын хажуугаар аймгийн “Эрх чөлөө” сонинд сум орон нутгийнхаа тухай мэдээ бичих үүрэгтэй байсан тэрээр Улсын тэргүүний ухуулагч болж, Лодонгийн Түдэвийн гарын үсэгтэй багламж хүртэл авч байжээ. 1950-1960 оны үед Майдар сайд Төмөрбулагт ирж, анхны сонгууль зохион байгуулах их ажил өрнөж, Жаргалантын голын хөвөөн дээр өнөөгийн Төмөрбулаг сумын төв байгуулагдах үндэс суурь тавигдаж, сумын контор, улаан булан барих ажилд ч мөн л дайчлагдаж, мод чулуу зөөж явжээ. Одоогоос жар гаруй жилийн тэртээ 1950 оны үед эрүүлжүүлэх аян өрнөж, улаан, цагаан тарианы үзлэг сум даяар явагдаж, насанд хүрсэн хүн бүр цусны шинжилгээнд хамрагдаж байх үед орос эмч нарын үзлэгт орохыг уриалж, ухуулж, заримыг нь бүр айлгаж байж сумын эмнэлэг дээр аваачиж байсан хүмүүсийн нэг нь мөн С.Бат-Очир гуай. Цусны шинжилгээ нь хэрээстэй гарсан хүмүүсийг сумын эмнэлэгт дуудаж, тариа хийлгэх үүрэг өнөөх ухуулагч нарт давхар оногджээ. Гэвч зарим хүмүүс долоо хоногийн хугацаатай хийлгэх ёстой хоёр тариагаа нэг дор хийлгэхийг халуурч бүлээрч, ухуулагч нарыг сандаргадаг байсан гэнэ. 1960-аад оны атар газар эзэмших хөдөлгөөн улс даяар гарч байх үед Саруул зам нэгдлийнхэн буудай тарих ажил өрнүүлж, Жаргалантын ам, Мухарын аманд хар буудайны үр суулгаж байх үед бригадын ухуулагч “Атар газар эзэмшиж байгаа шинэ баатруудын тухай мэдээ”-г иргэддээ түгээж явсан гэнэ. Соёлын довтолгоо газар сайгүй өрнөж, ариун цэвэрч байдлыг дээдлэх, аяга таваг, шүд ам, үс гэзгээ угаахын ашиг тусыг сурталчилж явснаа яриад инээж байсан. Тухайн үед айлууд зуух, яндангүй. Гэрийн мод нь тас хар, утаа тортог... Гэрээ цэвэрлэж, унь тооноо угаах үүрэг даалгавар өгөхөөр хутга заазуураар хусаж, цавчиж, унь, тооноо хугалсан айл ч цөөнгүй гардаг байжээ. Аймгаас ирсэн ариун цэврийн, эрүүл мэндийн ухуулагч нарыг дагуулан айлуудаар орно, үзлэг шинжилгээ хийх бүхий л ажилд оролцож, “Хүн мал хоёрыг салгах ажил” гэгчид аанай л дайчлагдаж явжээ. Тухайн үед айлууд малаа гэртээ төллүүлдэг, хонь малын хэвтэр, хүний ор, гудас нэг дороо байна гэдэг шүүмжлэл гарч, төлийн хашаа саравч барьж байсныг ч дурсаж байлаа. Тэр үед л монголчууд саван угаалгын нунтаг сам сойзтой танилцсан юм шүү дээ гээд С.Бат-Очир гуай инээж байсан. 1960-аад оны сүүлээр сүү тосны заводууд Төмөрбулаг суманд байгуулагдаж, асар майханыг цагаан давуугаар хийж эхэлсэн. Удалгүй энэ цагаан даавуу Монгол гэрт нэвтэрч, 1970 оны эхээр л айлууд гэрийн цагаан бүрээс цаваг даавууг хэрэглэж эхэлсэн гэнэ. Тэрээр нэгдүгээр багийн намын үүрийн даргаар ажиллаж байгаад Ардын хянан шалгах хороо байгуулагдах үед хянан шалгах постын дарга гэдэг ажилд томилогджээ. Хийхгүй ажилгүй, шалгахгүй ч юмгүй хэцүү цаг байсан даа хэмээн ярихдаа С.Бат-Очир гуай

толгойгоо сэгсэрч суусан юм. Тухайн үед мал маллах цагийн хуваарь гаргаж, цагаар малаа бэлчээдэг болжээ. Үүнд хяналт тавина, хэн мал үхүүлсэн байна. Хэн хэдэн цагт босож, орой хэдэн цагт малаа хурааж ирсэн гээд нарийн данс хөтлөх үүрэгтэй байжээ. Мал төллөх үед гэртээ орж унтах зав ч олдоггүй. Төлчид унтаж байгаа эсэхийг шалга. Эргүүлд гар. Мал төллөж байхад шөнө унтаж болохгүй хэмээн дарга нар нь үүрэг өгнө. Хянан шалгах постын дарга баахан эргүүл гаргаж, өнөөх эргүүлүүд нь малчдаа манаж, постын дарга эргүүлүүдээ манасаар үүр цайлгадаг байсан нь саяхан мэт санагдавч он цаг нисэн өнгөрч, тэртээ хол үлджээ. “Цаг ч хэцүү байсан юм шүү. Өнөөгийн залуучууд бол дураараа сайхан амьдарч байна. Ийм амьдралыг бид зүгээр нэг туулаад авч ирээгүй юм шүү. Малаа үхүүлсэн, улсын төлөвлөгөө тасалсан хэргээр цөөнгүй хүн ял сонсож, сүүний албан журмын төлөвлөгөө гарсны дараа шийтгэл амссан хүмүүс шагнагдснаасаа олон байсан юм шүү” хэмээн ярихдаа тэрээр санаа алдаж суусан. Төмөрбулагчуудын хувьд хамгийн хүнд хэцүү цаг 1960-аад он байсан хэмээн тэрээр дурсан ярьж байлаа. Асар их төлөвлөгөө норм, дээд газрын хяналт шалгалт, торгууль шийтгэл, хатуу хууль дүрэм олон хүний амьдралд бараан толбо авчирч байжээ. Харин энэ бүхэн 1970 оноос арай суларч зөөлөрсөн, 1980 он гэхэд ард олон яаж төлөвлөгөө биелүүлэх, яаж элдэв асуудалд уналгүй амь, амьдралаа зохицуулах вэ гэдэгт суралцсан байсан гэнэ. Хэдий цаг хатуу, захиргаад алт ихтэй үе байсан ч гэсэн энэ цаг үе монголчуудыг хамтын хөдөлмөрт сургаж чадсан. Ажилгүй хүнийг ажилд оруулсан. Монгол хүн өөрийнхөө гараар хийж бүтээж сурсан цаг үе байсан юм шүү” хэмээн тэр хэлж байсан. Бүх таван жилийн гавшгайч, бүхий л ойн медалиудын эзэн, МАН-ын бүхий л шагналыг хүртсэн ахмад ухуулагч С.Бат-Очир гуай 2013 онд “Алтангадас” одонгоор шагнуулжээ. Нэгэн сумын бүү хэл нэгэн улс орны сүүлийн 80 орчим жилийн амьдрал тэмцлийг гэрчлэх ахмад бууралтай ярилцаж суухад түүхийн зузаанаас зузаан ном уншиж байх шиг санагдаж байсныг нуугаад яахав.

## САЙН ЭЦГИЙН САЙН ХҮҮ

Аймаг орон нутагт 55 жил удирдах ажил хийж, бүтээн байгуулалт өрнүүлж, Хөвсгөлийн түүхэнд өөрийн гэсэн зам мөрөө үлдээсэн Дуламжавын Батаа хэмээх энэ хүний том хүү, Батаагийн Батхүү 1963 оны өвөл Улаанбаатар хотод төржээ. Түүнийг төрөх үед Цагааннуур сумын загасны үйлдвэрт ажилладаг аав нь удирдах ажилтны дээд сургуульд сурч байхдаа эхнэртэйгээ танилцаж, анхныхаа үрийн зулай үнэрлэжээ. Аав нь балчирхан хүүдээ “Чи бол Батаа гэдэг хүний хүү юм шүү, аливаад цөхөрч нугардаггүй, баг найдвартай басхүү итгэл даах, зовлонг сөрөх тэнхээтэй явах учиртай эр хүн юм шүү” хэмээн бодож зүүн чихэнд нь энэ нэрийг шивнэсэн байж таараа. Үнэхээр ч тэрээр асар их хөдөлмөрч, бас хүнлэг, хатуу үедээ хатуу, халирч нугарахгүй урагш тэмүүлсээр ирсэн, аливаа зүйлд нухацтай, нягт нямбай хандаж чаддаг асар их итгэл, сэтгэлийн тэнхээтэй аавын хүү гэдгээ олонд харуулж чадсан. Түүний бага нас Мөрөнгийн төвд өнгөрчээ. Батхүүгийн ээж гуравдугаар цэцэрлэгийн тогооч, аав нь Гурилын үйлдвэрийн даргын аалба хашиж байсан үед тэрээр 1971 онд Мөрөнгийн нэгдүгээр 8 жилийн сургуульд элсэн орж сурагч болжээ. Аливаа зүйлд нягт нямбай ханддаг аав нь хүүгээ үргэлж дэмжинэ, түүний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, аливаа зүйлд хариуцлагатай байхыг шаардана. Хатуу шаардлага тавьдаг аав нь хүүгээ бас сайн эрхлүүлнэ. Батаа гуай хүүгээ долдугаар ангид байхад нь зургийн аппарат авч өгчээ. Өөрөө зураг авна, бас авсан зургаа гэртээ угаана. Түүнээс гадна Б.Батхүү тооны хичээлдээ маш сайн сурагч байжээ. Дунд сургуульд байхдаа дууны хичээлээс өөр хичээлд сайн авч байгаагүй хүү тавдугаар ангиасаа л аймаг болон улсын олимпиадад оролцож 9,10 дугаар ангидаа аймагтаа түрүүлж, улмаар улсад 11 дүгээр байранд орж, Олон улсын олимпиадын багт шалгарч байжээ. Тэрээр 10 дугаар ангиа алтан медальтай төгсөж, аймагт дүнгээрээ нэгт зогсож, Тюмень хотын инженер геофизикийн их сургуулийн оюутан болжээ. Сибирийн оюутан залуу геофизикийн инженерийн мэргэжлээр зургаан сжил суралцаж байхдаа Тюмень хотын бүхий л арга хэмжээнд томчуудтай оролцдог байсан гэнэ. Оросын олон хотуудаар аялж, 1985 онд дэлхийн Залуучууд оюутны 12-р их наадамд төлөөлөгчөөр сонгогдон оролцож байжээ. Дипломынхоо ажлыг фосфоритын ордоор бичиж байсан залуу инженер 1987 онд сургуулиа төгсөөд нутагтаа ирж, Хөвсгөл аймгийн экспедицэд Залуучуудын эвлэлийн хорооны даргаар томилогдож байлаа. Нэг жилийн дараа Хөвсгөл аймгийн экспедицэд анх геофизикийг бий болгоход ажиллаж, ганц хүнтэй энэ багийг 180 гаруй хүний багтай бүхэл бүтэн отряд болтол томруулж, багажаар эрдэс баялгийг хайх шинэ нээлт хийж байлаа. Хөвсгөл аймгийн зураглалын экспедиц “Хөвсгөл геологи” ХК болж, өөрчлөгдөх үед Б.Батхүү гадаад харилцаа хариуцсан дэд захирлаар томилогджээ. 1990 онд нэгэн өдөр үдийн цайндаа явж байгаад Орост хамт оюутан байсан Батцэнгэл гэгч залуутай тааралджээ. Олон жил уулзаагүй оюутан найз нь Хөвсгөл аймагт Монголын Ардчилсан холбооны салбар байгуулах, үйл ажиллагаагаа сурталчлах зорилготой ирснийг сонссон залуу шууд л дэмжиж, тэр өдрөө л аймгийн төв, Мөрөн хотын даргатай уулзуулжээ. Мөрөн хотын дарга Төмөр залуучуудыг хүлээж авсан ч жагсаал цуглаан хийж болохгүй гэдгийг анхааруулж байжээ.

Тэрээр Хөвсгөл аймагт Монголын Ардчилсан холбооны уулзалтыг Геологи дээр зохион байгуулж, анхны салбарынх нь даргаар томилогджээ. Мөрөн хотод Монголын Ардчилсан холбооны төлөөлөгч ирсэн, Б.Батхүүтэй хамт Геологи дээр уулзалт хийж байна гэсэн мэдээлэл тэр дороо л жижигхэн хотод түгж, залуучууд, дэмжигчид Геологи дээр ар араасаа цуглаж эхэлсэн гэнэ. Мэдээж энэ тухай мэдээлэл аав, ээжийнх нь чихэнд ч хүрчээ.



Хар багаасаа л тухайн үеийн МАХН-ын суртал ухуулга хийж, гишүүнээр элсэж, намын ажилд олон жил зүтгэсэн аав нь түүнийг орой гэртээ дуудаж, юу болоод байгааг асуужээ. “Батаа даргын хүү ардчиллынхантай нийлсэн, хотын дарга нар дээр орж ирсэн” хэмээн бөөн асуудал үүсгэж, цагдаа сэргийлэхийнхэн хүртэл бэлэн байдал зарлаж, аймгийн МАХН-ын дарга нар хөл толгойгоо олохгүй бужигнаж эхэлсэн байжээ. Хамгийн сонирхолтой нь аав нь хүүгээ хориглосонгүй. Харин ээж нь уйлж, хүүгээ аргадаж, айлгаж, Ардчилсан холбооны ажилд оролцохгүй байхыг гуйж байсан гэдэг. Гэхдээ л өөрчлөн байгуулалт хийх цаг болсон гэдгийг мэдэрч байсан залуу ардчиллаас ухраагүй. Монголын ардчилсан холбооны анхны Их хурлын бичлэгийг үзэхээр гэрээсээ зурагтаа тэврээд, найзуудтайгаа хамт явж байсан залуу Хөвсгөл аймагт Монголын ардчилсан холбоог байгуулахад хүчин зүтгэсэн цөөхөн хүмүүсийн нэг. Үргэлж шинийг хайж, басхүү өөрийгөө хөгжүүлж байдаг энэ залуу олон зүйлийн анхдагч болж чадсан. Тэрээр Хөвсгөл аймагт анх ирсэн 286 маркийн компьютерыг сонирхон хотод ирж, Анагаах ухааны хүрээлэнд ажилладаг найзаараа компьютер заалгаж байжээ. Монголчууд дөнгөж л компьютерийг тухай мэдээлэлтэй болж байсан энэ цагт Б.Батхүү цаашид бүх хүмүүсийн хэрэглээ компьютер болохыг мэдэрч байсан юм. Тийм ч учраас тухайн үед “Хөвсгөл геологи” компанийг удирдаж байсан Л.Цэрэнжав даргад компьютерийн төв байгуулах санал тавьж, төсөл бичин, Хөвсгөл аймагт төдийгүй хөдөө орон нутагт анхны компьютерийн төв нээгдэж байсан түүхтэй. Мөрөнгийн залуус Геологийн компьютерийн дамжаанд суралцаж, Б.Батхүү 300 гаруй шавьтай болжээ. Түүний шавь нар одоо хүртэл аймаг, орон нутагт ажиллаж, сурсан зүйлээ амьдрал ахуйдаа хэрэглэж байгаа. 1998 онд тэрээр “Момент” нэртэй хэвлэх үйлдвэр нээж, хувийн бизнесээ эхлүүлжээ. “Эрх чөлөө” хэвлэх үйлдвэр үйл ажиллагаагаа зогсоож, Хөвсгөлд хэвлэлтийн ажил үндсэндээ зогсчихоод байсан үед тэр Хөвсгөл аймагт анхны хэвлэх үйлдвэрийг байгуулсан юм. 1998 онд тэрээр аймгийн Залуучуудын холбооны даргаар томилогдож, 2000 онд таван нам нэгдэж, МҮАН-ыг байгуулах Их хуралд

оролцож, Хөвсгөл аймгийн МҮАН-ын дэд даргаар томилогдож байжээ. 2000 оны Орон нутгийн сонгуульд Хөвсгөл аймгийн АН ялагдаж, аймгийн ИТХ-ын 35 гишүүний 33 нь МАХН-аас томилогдож байсан тэр цагт Б.Батхүү нөхөн сонгуулиар ялалт байгуулан иргэдийн төлөөлөл болон орж иржээ. Хэдийгээр хүч илт дутмаг, аймаг орон нутгийн бүх эрх мэдэл нэг намд төвлөрчихсөн байсан ч гэсэн хэлэх гэсэн үгээ хэлдэг, шүүмжлэлтэй ханддаг, асуудлын үнэн мөнийг олох гэж байнга зүтгэдэг учраас Б.Батхүү хүн гэдэг тухайн үеийн удирдлагуудын “шүдний өвчин” болж ч байсан удаатай. Харин 2004 онд тэрээр Хөвсгөл аймгийн засаг даргаар томилогдсон. Түүнийг Засаг даргаар томилогдсон энэ үеийг Төмөрбулагчууд “Түүхэнд үлдэх үе” хэмээн нэрлэдэг. Энэ нь ч учиртай. 2004 оны сонгуулийн дараа Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул Санжаагийн Баяр Ерөнхий сайд болж, аймгийн Засаг даргаар бас л Төмөрбулаг сумын уугуул Батаагийн хүү Батхүү томилогдож, Төмөрбулаг сумын засаг дарга нь ч тус сумын хүн байсан юм. Нөгөө талаар Б.Батхүү дарга Төмөрбулаг сумаас төрсөн анхны аймгийн дарга. Б.Батхүү Хөвсгөл аймгийг удирдсан дөрвөн жилийн хугацаа үнэхээр бүтээн байгуулалтын их он жилүүд байсан гэхэд болно. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай социализмын үед “Хөвсгөлд фосфоритын орд байгуулна. Тэр үед тог цахилгаан, дэд бүтцийнх нь асуудлыг шийднэ” гэсэн шалтгаар Хөвсгөл аймагт дэд бүтэц байгуулах асуудал үндсэндээ орхигдож, нутгийн иргэд лаа барин, харанхуйд тэмтчин амьдарч байгааг Б.Батхүү дарга төрийн чихэнд хүргэж, хөрөнгө мөнгөний асуудлыг шийдэж чадсан. Түүнийг анх Засаг даргын ажил хүлээж авахад 24 сумын зургаан нь л эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон байжээ. Харин түүнийг Засаг даргын ажлаа өгөх үед гуравхан сум эрчим хүчний асуудлаа шийдэж чадалгүй үлдэж байсан гэдэг. Хөвсгөл аймаг эрчим хүчтэй болсноор гар утасны сүлжээ нэвтэрч, харилцаа холбоо сайжирч, жижиг дунд үйлдвэрүүд байгуулагдаж, амралт сувилалын газрууд ч олноороо үүд хаалгаа нээсэн юм. Б.Батхүү Засаг даргаар ажиллаж байхдаа Хөвсгөл аймагт 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг УИХ-аар батлуулж чаджээ. Мөрөн-Хатгалын зам, Хатгалаас Тойлогт орох зам, Жаргалын төвөөс Мөрөн орох зам гээд бүтээн байгуулалтын асуудлыг шийдэхээр 50 тэрбум төгрөг батлуулсан. Тэрээр АН-ын аймгийн удирдлагуудын нэг ч гэсэн намчирхаж, аливаа зүйлд туйлшраад байдаггүй. Нутаг орноо гэсэн халуун дулаан сэтгэлээр бүх асуудалд ханддаг. Түүний энэ зан чанарыг ч тухайн үед Ерөнхий сайдаар ажиллаж байсан С.Баяр анзаарч үнэлж, хамт нэг баг болон ажиллаж, нутаг орныхоо төлөө их зүйл хийсэн юм. Нэг нь Монголын төрийг удирдаж, нөгөө нь аймгийн удирдлагыг тэргүүлж байсан Төмөрбулаг сумын хүүхдүүд эцэг өвгөдийнхөө нутагт ч гэсэн их зүйл хийж үлдээсэн. Төмөрбулаг сумыг төвийн эрчим хүчинд холбуулж, сургуулийн спорт заал, эмнэлгийн шинэ байр гэх мэт асуудлуудын хөрөнгө мөнгийг шийдвэрлэж өгсөн. Магадгүй өөр бусдад хэтэрхий нутгархсан мэт санагдаж болох ч энэ бүхэн Төмөрбулагын түүхэнд үлдэх бас нэг бахархал юм. Тэрээр 2008 онд Орон нутгийн сонгуулиар Төмөрбулаг сумын иргэдийн итгэлийг хүлээж, аймгийн ИТХ-д сонгогдож байсан ч Улаанбаатарт ирж, мэргэжлээрээ ажиллах шийдвэр гаргасан юм. Б.Батхүү төрийн албаны шалгалтанд орж, нэгээр гарч ирж, 2009 оны дөрөвдүгээр сард тухайн үеийн Эрдэс баялгийн яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга хэмээх хариуцлагатай

албанд томилогджээ. Уул уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгохын төлөө ажиллаж, олон судлагаа хийж, том, том үйлдвэрүүд байгуулах шийдвэр гаргахад гар бие оролцож байсан хүмүүсийн нэг нь Батхүү. 2009-2012 оны хугацаанд тэрээр Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, өсөн нэмэгдэх роялтийн татварын хуулийг боловсруулж батлуулах ажлын хэсэгт ажиллаж байлаа. Үүний үр дүнд Монгол улс дэлхийн зах зээлд зарим бүтээгдэхүүний үнэ өсөх үед авах татварын хэмжээ нэмэгдэж байх хуулийн заалттай болсон юм. Оюутолгойн гэрээ хэлэлцээр байгуулагдах үед тус орд газрыг Эрдэнэт үйлдвэртэй харьцуулан судлагаа хийж, төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” компанийг байгуулахад тус компанийн мэдэлд байгаа ордуудыг эргэлтэнд оруулах судлагааны ажлуудыг мөн Б.Батхүү дарга удирдаж, хийж байжээ. Мөн хүнд үйлдвэр байгуулах маш олон судлагааны ажил хийж, татварын орчинг боловсронгуй болгох, олборлох үйлдвэрийн ил тод байдлын тухай хуулийн төслүүд дээр ажиллаж байсан. 2012 оны сонгуулийн дараа Уул уурхайн яам байгуулагдах үед тэрээр Бодлогын хэрэгжилтийн газрын даргаар томилогдсон юм. Уул уурхайтай холбоотой хууль тогтоомж, дүрэм зааврыг хэрэгжүүлэх, хуулийн алдаа мадагтай зүйлийг засч залруулах гээд түүний хариуцах ажил их. Тэрээр геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, ашигт малтмал, нүүрс, газрын тос гээд уул уурхайн бүхий л агентлагуудыг хариуцаж, тэдний үйл ажиллагааг яамтай холбох, төрийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Дээрээс нь Монголд 3000 гаруй ашигт малтмалын лиценз эзэмшигч, уул уурхайн салбарт ажиллаж байгаа 40 гаруй мянган хүн бий. Монголын эдийн засгийн нуруундаа үүрч байгаа уул уурхайн салбарын хувь заяа түүний ажилтай салшгүй холбоотой гээд бодохоор бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрж байсныг нуугаад яахав. Ажил хийнэ гэдэг нэг хэрэг. Харин ажилдаа эзэн байна гэдэг өөр хэрэг. Төмөрбулагчуудын бахархал болсон Батаа даргын хүү эцгийнхээ нэрийг төдийгүй, нутгийнхаа нэрийг өндөрт өргөж яваа.

## ТҮМЭЭ ДАРГА

Төмөрбулаг сумын түүхийн хуудсуудыг сөхөж, хуучин баримт сэлтүүдийг сөхөж харвал Доржийн Түмэндэмбэрэл гэсэн нэр маш олон тааралдана. Сумын худалдаа бэлтгэлийн анги, тооцооны төв, намын удирдах ажилтнуудын бүртгэл, эмэгтэйчүүдийн холбоо, ахмадын байгууллага гээд олон зүйл энэ хүнтэй холбоотой. Олноо Түмээ дарга гэж нэрлэгдсэн энэ эрхэм 1943 онд Төмөрбулаг сумын Жаргалантын голд төржээ. Түүний аав Гэлэг тавнан гэдэг хүн байсан бөгөөд Гомбосүрэн дүүрэгчийн том охинтой ханилсан, ноёны хүргэн байж. Тавнан гэдэг ноёд дээдсийн охидтой худ ураг болсон хүмүүст өгдөг нэг ёсны цол гуншин юм. Түмээ даргын өвөө Гомбосүрэн дүүрэгч 1930-аад оны эхээр хар шар феодал гэж ад үзэгдэж, баривчлагдан Хатгал руу ачигдаж, тэнд цаазаар авахуулж байсан гэдэг. Гомбосүрэн дүүрэгчийг баривчилсныхаа дараа хөрөнгийг нь хурааж, малыг нь Тэлээгийн аманд амьдарч байсан нэгдлийн гишүүдэд тарааж өгч байжээ. Д.Түмэндэмбэрэлийг төрснийх нь дараа ээж нь төрсөн дүүдээ үрчлүүлж, тэрээр Доржийнх гэдэг айлд өсөж торнижээ. Зузаанаас зузаан намтар түүхтэй энэ хүн 1957 онд бага сургуулиа төгсөөд мал маллаж байгаад 1959 онд оройгоор долдугаар анги төгсчээ. Түүнийг арван хэдхэн настай жаахан охин байхад Төмөрбулаг суманд соёлын үрийг тарьсан хэдэн сайхан багш бүсгүйчүүд байсан гэдэг. Улаанбаатар хотод багшийн сургууль дүүргэсэн Цэрэнбалжир, Лхагваа, Должинсүрэн гэх мэт залуухан бүсгүйчүүд өнгө зүс, өмссөн зүүсэн хувцас, үйл хэрэг, яриа хөөрөөгөөрөө хүртэл олны анхаарлыг татдаг, яг л тэд шиг гоё хүн болохыг битүүхэн мөрөөддөг байсан охид олон байжээ. Түмэндэмбэрэл хэдий нас бага ч гэсэн нийгмийн ажилд идэвхтэй, дуулж бүжиглэдэг, олон нийтийн ажилд ч байнга оролцоно. Энэ хүн насаа нэмж, 14-хэн насандаа эвлэлийн үүрийн гишүүн болж, 18 нас хүрээд сумын эмэгтэйчүүдийн холбоог тэргүүлж явсан адтай бүсгүй. Соёлын довтолгоо ид хүчээ авч байх үед үлгэр жишээч хот айл болж, Төмөрбулаг сумын ханын самбарт бичигдэж, “Соёлч өрх” гэсэн төмөр пайз хашаан дээрээ хадах эрх авсан анхны айлуудын нэг нь тэднийх. “Соёлын довтолгоо Монголчуудын амьдралыг өөрчилж, өвчин хууч, элдэв халдвараас салах боломж олгосон” гээд тэрээр инээмсэглэж байсан. Үнэндээ ч сумын төв дээр долоо хоногийн гурав дахь өдөр болгон бүх айл ариун цэврийн үзлэгт хамрагддаг байсан гэнэ. Тэр үед усанд орсон



эсэхийг хүртэл бүртгэдэг, хүн бүрт кино үзэх, ном унших даалгавар өгч, хоёр сарын хугацаанд 40 ном уншсан хүнд номын нөхөр тэмдэг өгдөг байсан үе. Соёлын довтолгооны сурталчилгаа хийж явсан Эвлэлийн үүрийн гишүүн жаахан охин долдугаар ангиа төгсөөд л сумын Худалдаа бэлтгэлийн ангид ажиллаж эхэлжээ. Түүний амьдралтай салшгүй холбоотой газар бол Төмөрбулаг сумын худалдаа бэлтгэлийн анги. Төлөвлөгөөт эдийн засагтай тэр үед бүх ажил төлөвлөгөөний дагуу хийгдэх учиртай. Төрөөс хийх ажлыг нь тав, таван жилээр төлөвлөж гаргадаг байсан учраас хүн бүр л төлөвлөгөө биелүүлэх ажилд оролцоно. Үнэндээ төлөвлөгөө нормгүй зүйл гэж бараг л байхгүй. Үхрийн эвэр, туурайны төлөвлөгөө биелүүлэх гэдэг бүүр том ажил болно. Нядалсан малын эвэр туурай цуглуулаад хүрэхгүй болохоор жалга, дов хэсэж, үхсэн малын сэг зэмнээс хүртэл эвэр туурайг нь авдаг байжээ. Зурам тарвага, зэрлэг гахайнаас эхлээд уртын ноос, ноолуур, ямааны хялгас, бугын эвэр, ямааны сахал хүртэл төлөвлөгөөтэй. Худалдаа бэлтгэлийн анги 42-49 төрлийн төлөвлөгөө биелүүлэх болдог байжээ. Авах юм төлөвлөгөөтэй адил зарах зүйл ч бас төлөвлөгөөтэй. Тэр үеийн худалдаа бэлтгэлийн ангийн худалдагч нар ажлаас тараад шууд гэртээ харих эрхгүй. Жижиг цаасан хайрцаганд лаа шүдэнз сам сойз хүртэл аваад явна. Түүнийгээ айлуудаар явж зарна. Үүргийн худалдаа гэж нэрлэгддэг энэ төрлийн наймааг хөдөөний агентууд хүртэл хийдэг, мориндоо бараагаа ганзагалж явж байж зардаг, төлөвлөгөөгөө биелүүлдэг байжээ. Тэрээр худалдаа бэлтгэлийн ангид худалдагч, тоо бүртгэгч, нярав, нягтлан хийж байгаад 1974 онд Намын сургуульд явжээ. Намын түүх, Маркс, Энгельс, Ленины онолуудыг орос хэл дээр уншиж, хатуу шалгалт шүүлэг өгч байж төгсдөг энэ сургуулийг улаан дипломтой төгссөн залуухан бүсгүйг нутагтаа ирэхэд тухайн үеийн аймгийн намын хороо Цэцэрлэг сумын намын хорооны даргаар томилжээ. Цэцэрлэг сумын намын хорооны орлогч даргаар гурван жил ажиллаад тэрээр нутагтаа иржээ. Энэ цагаас хойш Төмөрбулаг сумын намын орлогчоор найман жил ажилласан байх юм. Тухайн үед Төмөрбулаг сумын намын хороо 60 гаруй гишүүнтэй. Жилдээ 4-5 хүнийг л намын гишүүнээр элсүүлдэг. Намын гишүүн хүн асар их үүрэг хариуцлага хүлээдэг байсан үед ухуулга сурталчилгаа хийх, үзэл суртлын ажлыг орлогч дарга нар хариуцдаг байжээ. Д.Түмэндэмбэрэл даргын санаачилгаар Төмөрбулаг сумын Намын хороо ухуулгын нээлттэй товчоо, түшиц газар байгуулж, Улсаас тэргүүн туршлагын гэрчилгээ авч байжээ. Үүнээс гадна түүний удирдаж байсан Төмөрбулаг сумын эмэгтэйчүүдийн холбоо 1978 онд Улсын тэргүүний зөвлөл болж, мандат авч байсан түүхтэй. Түмээ дарга бас Төмөрбулаг сумын банкны анхны ажилчдын нэг. Төлбөр тооцоог нэг бүрчлэн хийнэ. Төлөвлөгөөний дагуу цуглуулсан бүхий л бараа үнэтэй. Нэг ямааны сахал гэхэд 12 мөнгө, үхрийн духны арьс гэхэд л 50 мөнгөний үнэтэй. Бүх барааг нэг бүрчлэн падаан бичиж, мөнгийг нь бодож олгох нүсэр их ажлын хажуугаар тайлан тооцоо гаргах, судалгаа шинжилгээ хийх үүрэг дээд газраас өдөр өнжилгүй ирнэ. Энэ бүхэнд Түмээ дарга түүртэж байсан удаагүй. Хэдийгээр төлөвлөгөө хүнд ч гэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг бүрэн ашигладаг, ямааныхаа сахлаас эхлээд яс үсийг нэг бүрчлэн авч, үнэлж мөнгө болгож чаддаг сайхан үе байсан хэмээн тэрээр ярьж байсан юм. Үнэндээ сүүлийн үед малынхаа ашиг



шимийг бид хэтэрхий муу ашиглаж байна хэмээн харамсаж явдгаа ч гэсэн дурьдаж байлаа. Ямааны сахал, үхрийн эвэр туурайгаар юу хийдэг байсан юм бол гэж асуухад “Мэдэхгүй дээ. Эвэр товч гэж ирдэг байсныг бодоход товч, бэлэг дурсгалын зүйл хийдэг байсан байх. Харин ямааны сахлаар бийр багс хийдэг байсан байж магадгүй. Ямааны сахал хялгаснаас өөр. Нарийн ширхэгтэй, бас их уян үстэй байдаг юм билээ” хэмээн тэрээр хуучилж суусан. Түмээ дарга Төмөрбулаг сумын банкинд ороод ажиллаж байгаа салбараа бас л мандуулж чадсан. Төмөрбулаг сумын тооцооны төв хожим ХААН банк болон шинэчлэгдэж, Д.Түмээ даргыг захирлаар нь ажиллаж байх үед буюу 1992 онд улсад ажил үйлсээрээ шалгарч, гуравдугаар байранд орж байжээ. Аливаа зүйлийг хийсэн шиг хийдэг, хийсэн ажлынхаа үр шимийг хүртэж чаддаг, чадалтай дайчин энэ эмэгтэй улсад 38 жил 7 сар ажиллаад тэтгэвэртээ гарчээ. Гэвч тэрээр зүгээр суусангүй. Сумын ИТХ-ын тэргүүлэгчээр сонгогдож, Төмөрбулаг сумын Ахмадын хорооны даргын үүрэгт албыг хашиж байна. Үүнийхээр хажуугаар Ариусахуйн бясалгалын төвд явж, Рейки холбоонд нэгдэж Гранд мастер цол авчээ. Төмөрбулаг сумын ахмадуудад бясалгал заахын хажуугаар “Ахмадууд эрүүл урт наслах боломж” нэртэй төсөл хэрэгжүүлжээ. Нутаг орныхоо хөгжил дэвшлийн төлөө зүтгэж хэзээ ч гар хумхин зүгээр сууж байгаагүй энэ ахмад нэгэн мөр цагаан замтай явсан. Тиймээс ч төр засаг түүний хөдөлмөр бүтээлийг үнэлж, “Алтангадас” одон, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнажээ. Өнгөрсөн түүхийг гэрчлэх, ирээдүйн амьдралыг тэтгэж чадах сайхан буурлуудын нэг, олноо Түмээ дарга хэмээн нэрлэгдсэн нэгэн ахмад эдүгээ Төмөрбулаг сумандаа энх тунх амьдарч байна.

## ШАВИЙН ЭРДЭМ БАГШААС...

Энэхүү тэмдэглэлийн маань гол баатар Ганжууржавын Долгорсүрэн. Түүний аав Батын Ганжууржав Матадын наймдугаар дивиз, 23-р морьт хороонд Дандар баатрын командад Ардын жүжигчин Цагааны Цэгмидийн хамт байлдаж явсан ахмад дайчин. Төмөрбулаг сумын Бүгдгээний голд төрж өссөн Б.Ганжууржав гуай 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайн гээд хоёр том дайнд оролцож явсан гавьяатан. Олноо алаг морьт Дандар баатар гэж алдаршсан Улсын баатар Л.Дандарын хайртай цэргүүдийн нэг явсан бололтой. Учир нь 1980 оны үед Б.Ганжууржав гуайн бие чилээрхэж байгаа мэдээ сонссон Дандар баатар өөрийн биеэр түүнийг эргэж ирж байсан гэнэ. Хуучин андаа эргэхээр Улсын баатар алдартай дайчин энэ эр Төмөрбулаг суманд хоёр ч удаа ирж, сум орон нутгийн удирдлагууд түүнийг ёслол төгөлдөр угтан авч, 1987 онд Дандар баатрын нэрэмжит анги Төмөрбулаг сумын сургуульд бий болж байсан түүхтэй. Б.Ганжууржав гуай их бууны наводчик байсан. Дайнаас ирэхдээ хөлдөө жадны том хөх соривтой ирж байсан ч ямар тулаанд хаана яаж оролцож байсан тухайгаа ярьдаггүй, “Байлдааны нууц” гэхээс өөр олон зүйл хэлдэггүй ам хатуу хүн байжээ. Халхын голын дайнаас байлдааны гавьяаны улаан тугийн одон хүртсэн бөгөөд 1945 оны чөлөөлөх дайнд оролцсных нь дараа мөн байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор дахин шагнажээ. Гэвч энэхүү шагналаа Ховдоос ирсэн нэгэн цэрэгт өгсөн хэмээх ам дамжсан яриа байдаг юм билээ. Түүнийг байлдаж, тулалдаж явсан тухайг нь яриулахаар аймгийн Намын хорооноос дарга нар хүртэл ирж, цөөхөн үг унагаж аваад буцсан гэдэг. Ийм баялаг зузаан түүх намтартай ч гэсэн түүнийгээ өөрөө өөртөө хадгалсаар буцсан ахмад дайчны охин Долгорсүрэн багш 1940 онд төржээ. Түүний ээж уран гартан гэж хавь ойртоо гайхагдсан уран хүн байжээ. Долгорсүрэн багшийн том ах нь цаны спортын нэгдүгээр зэрэгтэй, спортын мастер хүн байсан. Харин бага дүү Отгонбаяр нь аймгийн хоёр удаагийн аварга малчин болж байсан гэнэ. Г.Долгоржав багш 1953 онд Төмөрбулаг сумын бага сургуульд орж, аравдугаар ангиа




төгсөөд Багшийн дээд сургуулийн биеийн тамирын багшийн ангийг төгсжээ. Тэрээр 1972 оноос хойш хорь гаруй жил биеийн тамирын багшаар ажилласан буурал багшийн шавь нар улс аймагт нэр алдраа гаргасан олон тамирчид бий. Тэшүүрийн спортын нэгдүгээр зэрэгтэй Цэдэндамбаа, улсын начин Эрдэнэбат, хөнгөн атлетикийн нэгдүгээр зэрэгтэй, волейболын хоёрдугаар зэрэгтэй, чөлөөт бөхийн гуравдугаар зэрэгтэй Лувсангийн Бат-Эрдэнэ, Шатрын мастер Дашзэвэг гээд олон сайхан шавь нараа тэрээр бахархан дурсаж байсан юм. Түүнийг багшилж байх үед спортын уралдаан тэмцээнийг бүсчилж явуулдаг байжээ. Долгорсүрэн багшийн олон шавь бүсийн уралдаан тэмцээнд түрүүлж, аймаг улсад уралдаан тэмцээнд оролцож нутаг усныхаа нэрийг дуурсгаж явсан түүхтэй. Г.Долгорсүрэн багш өөрөө сагс, волейбол, хөнгөн атлетик, байт харвааны хоёрдугаар зэргийн тамирчин. Тиймээс шавь нар нь ч волейбол, хөнгөн атлетикаар багагүй амжилт үзүүлдэг байжээ. Г.Долгорсүрэн багшийн дасгалжуулсан волейболын баг 1984 онд бүсийн аварга болж, 1984 онд аймгийн аваргаар шалгарч, бүх ард түмний спартакиадаас алтан медаль хүртэж байсан байх юм. Үүнээс гадна Ардын хувьсгалын 40 жилийн ойгоор түүний удирдсан сагсан бөмбөгийн эмэгтэй баг улсад дээгүүр байранд орж байсан, түүний даасан анги Улсын тавдугаар спартакиадын аварга болж байсан гээд олон олон амжилт Г.Долгорсүрэн багштай салшгүй холбоотой. Хөвсгөл аймгийн аварга багшаар шалгарч байсан Г.Долгорсүрэн багш 1992 онд гавьяаныхаа амралтанд гарчээ. Тэрээр “Намайг багшилж байхад Төмөрбулаг сумын хүүхдүүд жижгэвтэр биетэй, гүйж харайхдаа их сайн байсан. Харин сүүлийн үед хүүхдүүд өсгөлүүн, өндөр болж байна” хэмээн ярьж байсан юм. Бүхий л амьдралаа ардын хүүхдийг сургаж хүмүүжүүлэхэд зориулсан ахмад багшийн шавь нар өнөөдөр шавиа бэлтгэж байгаа. Шавийн эрдэм багшаас гэсэн сайхан үг бий. Тиймээс Төмөрбулаг сумаас Монгол гэдэг нэрийг дэлхийн чихэнд цуурайтуулах алдартай тамирчид төрөн гарч, төрийнхөө алтан соёмбот далбааг мандуулж, төрсөн нутгийнхаа зон олныг баярлуулах цаг удахгүй ирэх бизээ.

## ШАНТАРЧ НУГАРААГҮЙ ЗОРИГ, ТҮҮХЭНД БИЧИГДЭХ АЛДАР

Амьдрал хэмээх их урсгалыг дагаж бус сөрж, тэмцэж, ялж чадсан нь түүхийн хуудсанд бичигдэж үлддэг гэнэм. Тэгвэл тэдний нэг нь С.Цэрмаа хэмээх энэ эмэгтэй. Шантарч нугараагүй зориг, эргэж буцаагүй тэсвэр тэвчээр, няцаж орхиогүй хүсэл тэмүүлэл, басхүү хөдөлмөрч дайчин чанар нь энэ эмэгтэйд Төмөрбулаг сумын түүхийн хуудсанд мөнхлөж үлдээсэн юм. Чимэдбазарын Цэрмаа 1942 онд төржээ. Тэрээр эхээсээ 15-уулаа, нэгэн гэрт бужигаж өссөн гэнэ. Ч.Цэрмаа 16 настайдаа тулгаа тулж, тооноо өргөөд удаагүй байсан “Шинэ амьдрал” нэгдэлд анх элсэн орж, үхэрт анжис хөллөж, Тариатын аманд тариа тарьж явжээ. Тухайн үед Шинэ амьдрал нэгдэл тариа буудай, төмс хүнсний ногоо, халтар арвай, эрдэнэшиш тарьдаг, ургацаа гараар хурааж авдаг байжээ. Тээрмийн чулуунд үхэр хөллөж, тарьсан тариагаа цайруулдаг, халтар арвай, тариагаа гишүүддээ хувааж өгдөг, эрдэнэшишийг малын тэжээлд нийлүүлдэг байжээ. Үүнээс гадна тэрээр тус сумын цөөхөн тэмээчдын нэг. Тухайн үед Төмөрбулаг сум овоо олон тэмээтэй, нэг суурьт л гэхэд 50 гаруй тэмээ хариуцуулдаг байжээ. Түүний гэр бүлийн хүн Чимэд морин хашлагаар өвс хаддаг байсан бөгөөд Аймгийн аварга болж байжээ. Хадлан тэжээлийн норм төлөвлөгөө их өгдөг байсан тэр цагт Ч.Цэрмаа гар хадуураар хадлан бэлтгэж эхэлжээ. “Чи бие муутай, олон хүүхэдтэй хүн. Өвс хадлангийн ажил гэж өөрийгөө зовоож яах гэсэн юм” хэмээн олон хүн хорьж байсан ч тэрээр эргэж буцаагүй. Үнэндээ эмэгтэй хүн шимээсэг бариад хадлан хийнэ гэдэг тухайн үед олон хүний санаанд багтахгүй байсан хэрэг. Гэвч нэгдлийн 400 гаруй хонь, ямаа маллахын хажуугаар хадлан хийж, эхний жилд Цоорхойн ар тал гэдэг газраас 10 тонн өвс хадаж, сумын аварга болжээ. Ганцхан зун 10 тонн хадлан бэлтгэсэн нь олон хүнийг гайхшруулж, тэрээр улсын амралтанд явах эрхээр шагнуулж, басхүү Эмэгтэйчүүдийн тавдугаар их хуралд төлөөлөгчөөр сонгогджээ. Гэхдээ энэ бол Ч.Цэрмаагийн амжилтын




зөвхөн эхлэл байсан юм. Үүний дараа тэрээр 54 тонн өвс хадаж Аймгийн аварга хадланч гэсэн цол, улаан туузаар шагнуулжээ. Гар хадуур өөрөө хүнд, анх хадлан хийхэд гар хөл өвддөг хүнд хэцүү байсан ч сүүлдээ түүнээс сайхан зүйлгүй болсон гэж тэрээр ярьж байлаа. Ч.Цэрмаа гуай хадлангийнхаа талбайг урьдчилан хашиж, хамгаалж, чулууг нь түүж бэлтгэдэг, үүр хагаслан хадландаа гардаг. Өдөрт ганц цаг амарч, хоол цай идэх зуураа бүх шимээсгээ ирлэж, давтаж тавьдаг байсан гэнэ. Гурван шимээсгээр ээлжлэн өвс хаддаг. Хадсан өвсөө 4-5 тонноор нь нуруу хийдэг байжээ. Цаг хатуу байсан тэр үед хадсан өвсийг нь тун нарийн хэмждэг хэрнээ туслах хүн бараг гарахгүй. Өвсийг нь ачихаар жолоочоос өөр хүн ирэхгүй. Тиймээс хадсан өвсөө өөрсдөө бухалдаж, нуруулдаж, машинд хүртэл ачиж явуулах үүрэг хүлээнэ. Гэлээ гээд тэр шантраагүй. Тэрээр хоёр бүсгүйтэй нийлэн бригад байгуулан хадланд гарч, хоёр сар хүрэхгүй хугацаанд 74 тонн өвс хадаж 1984 онд Улсын аварга хадланч болсон. БНМАУ-ын аварга хадланч болж байсан энэ эмэгтэй аймгийн хоёр, сумын дөрвөн удаагийн



аварга хадланч цолтой. Тухайн үед Улсын аварга хадланч цолыг “Ургацын аварга” гэсэн тэмдэг, 2000 төгрөгийн шагнал дагалдан ирж байсан гэнэ. Нэгдлийн гишүүд бүтэн сар ажиллаж, хөдөлмөр өдрийн хөлс гэж сардаа 200 орчим төгрөг авдаг байсан үед 2000 төгрөг гэдэг том шагнал байсан нь тодорхой. Бороо орж байсан ч өвс хаддаж л байдаг энэ хүний тухай сурвалжлага хийхээр тэр үеийн төр засгийн төв хэвлэл Үнэн сонины сэтгүүлчид Төмөрбулаг суманд ирж, аймгийн “Эрх чөлөө” сонин дээр “Гурван бүсгүй” нэртэй хөрөг найруулал гарч, гар хадуураар хадлан хийх туршлага нь улс орон даяар түгж, тэргүүн туршлага судлахаар аймаг сумдуудаас олон хүн ирдэг байжээ. Хадсан бүхий л өвсөө нэгдэлд тушаадаг байсан энэ хөдөлмөрч эмэгтэй Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдаж, хожим “Алтан гадас” одон авчээ. Арван нэгэн хүүхэд өсгөж хүмүүжүүлсэн энэ эмэгтэй хүүхдүүдээ асрахын зэрэгцээ малаа маллаж, хоол ундаа бэлтгэж, хажуугаар нь хадлан тэжээл авч, цаг наргүй ажиллаж явсан гэдгийг нь түүнд олгосон олон цол тэмдэг, шагнал урамшуулал бэлхнээ гэрчилнэ.

## АМЬДРАЛААС УРГАСАН УХААН

Ил цагаан хэрнээ ёжтой, гашуун үгтэй, эрс шийдэмгий төрхтэй, бас аливаа зүйлийн эв дүйг олж сурсан, амьдралын их ухаантай, ямар нэгэн зүйлд бууж өгч, эргэж буцдаггүй зантай энэ хүнтэй ярилцаж суухдаа “Хотогойд эрчүүд ийм л байдаг байх даа” гэсэн бодол төрж байсан юм. Энэ бол Төмөрбулаг сумын уугуул Баян-Энх-Айраг ХХК-ны захирал Д.Цэрэндорж. Түүний аав Дугаржав Бүгсийн хүрэн дээр шавилж байсан лам хүн. Шар цэргүүдэд туугдаж, Тээлийн ар талын Арслантай хадны ард нуугдаж, гэр рүүгээ оргож буцаж, эсэргүү бослогоос амь мэнд гарсан тухайгаа тэрээр хожим хүүдээ ярьж байсан гэдэг. С.Готов хамбатай хамт шавилж явсан Дугаржав хэмээх энэ хүн хожим хар болж, Гар үйлдвэрийн артельд мужаан хийж байжээ. 1932 онд эсэргүү бослого хөдөлгөөн гарсны



дараа лам нарыг зохион байгуулалтанд оруулж, тэднийг нэг ёсондоо хянаж байхын тулд гар үйлдвэрийн артель гэгчийг байгуулж, баахан лам нарт алх хөрөө, бариулан хөдөлмөрийн хувиар гаргаж өгчээ. Мужаан хийх нь байтугай морио аргамжих гадас ч үзүүлэж үзээгүй Дугаржав гуай артельд орж, авдар сав, цагаан ултай гутлаас эхлээд нарийн ур ухаан шаардсан мужааны ажилд суралцаж, бүүр “Ударник” гэдэг цол авч, олонд хэрэгтэй сайн мужаан болсон гэнэ. Тэрээр 1961 он хүртэл мужаан хийж байгаад өөд болохоосоо өмнө нэгдлийн мал маллаж байжээ. Ийм л намтар түүхтэй хүний хүү болж, Д.Цэрэндорж 1948 онд төржээ. Дэлгэрмөрөн нэгдэл анх байгуулагдах үед азарга адуу, 40 гаруй хонь ямаагаа тууж аваачиж өгөн 1959 онд нэгдлийн гишүүн болж байсан бөгөөд нэгдэлд мал маллаж, байгаад цэрэгт явжээ. Цэргээс ирснийхээ дараа хоёр өнчин дүүгээ тэжээж тэтгэх үүрэг хүлээсэн хүний том ах Дэлгэрмөрөн нэгдэлд мужаанаар ажиллаж эхэлжээ. Хар багаасаа аавыхаа ажилд туслаж, алх хадаасыг нь дөхүүлэн тусад орсон хүүд эцгээсээ сурсан зүйл хэрэг болсон нь тэр. Нэгдэлд гайгүй сайн мужаан хэмээн үнэлэгдэж, удалгүй тушаал дэвшин сургуульд аж ахуйн ажил хийж байгаад нягтлан бодох курст явсан нь түүнийг амьдралыг

орвонгоор нь өөрчилсөн гэхэд болно. Тэрээр 1982 онд Цагаан-Уул сумын Санхүү тасгийн даргаар томилогджээ. Хийсэн ажилдаа зүтгэлтэй, аливаа зүйлийг дуустал нь хийж байж санаа нь амардаг, нягт нямбай энэ хүн Цагаан-Уул сумын Санхүү тасгийг удирдаж, таван жил дараалан ажлаараа аймагт түрүүлж байсан гэдэг. Баруун таван аймгийн Санхүү тасгийн дарга нар Цагаан-Уул суманд ирж, түүнээс туршлага судлаад буцаж байжээ. Тэр үед Цагаан-Уул сумыг удирдаж байсан хүн бол монголд зартай нэгдлийн дарга нарын нэг, Хөдөлмөрийн баатар Ү.Аварзэд. Ү.Аварзэд баатар санхүү тасгийн даргаа Худалдаа бэлтгэлийн ангийн даргаар томилуулах саналыг Аймгийн намын хороонд гаргаснаар Д.Цэрэндорж тус сумын Худалдаа бэлтгэлийн ангийн даргаар томилогдож, энэ албыг зургаан жил хашсан байх юм. Тэрээр Улсын худалдаа бэлтгэлийн бүхий л ангиудыг уриалан үүрэг авч, социалист уралдаан зарлан бужигнуулж явсан эр. Цагаан-Уул сумын ноос, ноолуурыг Улаанбаатарт аваачиж, шинжлүүлж, задлуулж, үйлдвэрт тушааж, алтан медаль авчрах хатуу үүргийг Ү.Аварзэд даргаас аваад Улаанбаатарыг зорино. Хэрвээ тус сумын бэлтгэсэн түүхий эд алтан медаль авбал үнэ нь өндөр, сум орон нутгийн нэр хүндэд ч сайн байдаг учраас хашир дарга жил бүр алтан медаль авч ирэх үүрэг өгдөг байсан хэрэг. Энэ үүргийг нь Д.Цэрэндорж гуай ч сайн биелүүлдэг байсан гэнэ. Хөдөлмөрийн баатар Ү.Аварзэдийн удирдлага дор 10 жил ажиллаж байсан тухайгаа тэрээр “Хүнд юм ухааруулдаг, хүнийг хамт олонтой болгож, хүмүүжүүлэх гэж зорьдог хүн байсан. Архичин ч бай, хулгайч ч бай итгэл хүлээлгэж, ажил төрөлд оруулж, амьдрал ахуйг нь өөд нь татаж чаддаг сайн хүнээс ах нь их юм сурсан” хэмээн ярьж байсан юм. Өөрчлөлт шинэчлэлт гарч, нэгдэл тарсны дараа 1992 онд Төмөрбулаг суманд Жаргалант хоршоо байгуулагдаж, нутгийн ахан дүүсийнхээ саналаар тэрээр хоршооны даргаар ажиллаж эхэлжээ. Төмөрбулаг сумын Худалдаа бэлтгэлийн анги тухайн үед Жаргалант хоршоо болон өөрчлөгдөж шинэ зохион байгуулалтанд ороод байсан хэрэг. Түүнийг анх ирэхэд хоршоо дөрвөн сая төгрөгийн зээлтэй байж. Ямартай ч хоршоогоо өр зээлээс нь салгаж, гурван сая төгрөгийн хөрөнгөтэй болгож өгөөд ажлаа өгчээ. Цэрэндорж гуай 1995 онд ажлаа өгөөд хувийн бизнест хөл тавьсан гэнэ. Гэхдээ ганзагын наймаанаас илүүтэйгээр үйлдвэр үйлчилгээний чиглэлээр ажиллахаар сэтгэл шулуудаж, гурил ховор үед Эрдэнэтэд хувийн жижиг гурилын үйлдвэр байгуулжээ. Архангайн Цэцэрлэгт мөн л гурилын үйлдвэр байгуулж, гурил тээрэмдэж, малын тэжээл хийж, “гурилын өвгөн” гэдэг нэртэй болтлоо ажилласан энэ хүн хожим нутагтаа ирж суурьшсан юм. Түүнийг нутагтаа ирэх үед Төмөрбулаг суманд тос, тослох материал, шатахуун тун ховор байжээ. Төрийн байгууллага мөнгө төсөв багатай, тэтгэвэр тэтгэмжээ ч тавьж чадахгүй шахам байсан учраас шатахууныхаа мөнгийг төлж чаддаггүй. Сумын төвд байсан ганц шатахуун түгээх станц нь хэнд ч зээл өгдөггүй, өөрөө ч бүтээгдэхүүнээ борлуулж чаддаггүй, сумын төвийн бизнесмэнүүд аймгийн төвөөс поошигоор бензин авчирч зардаг байсан тийм л үед Д.Цэрэндорж захирал “Баян-Энх-Айраг” нэртэй компаниа 2005 онд байгуулж, шатахуун түгээх станц шинээр нээжээ. Өнөөдөр тус компани бүх төрлийн шатахуун борлуулах станцтай, шатахуун тээвэрлэх зориулалтын

машин техник тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаа нь жигдэрсэн компани болж чаджээ. Татвар нийгмийн даатгал гээд төрийн өмнө хүлээсэн үүргээ яг таг биелүүлж, тайлан тооцоогоо цаг тухай бүрт нь гаргаж өгдөг энэ компани нутгийнхныхаа өмнө нийгмийн хариуцлага хүлээж, хандив ивээн тэтгэлэг, тусламж үзүүлэхээс хэзээ ч гар татдаггүй. Ганцхан жишээ хэлэхэд Төмөрбулаг суманд шинэ эмнэлэг байгуулахад тус компани хоёр өрөөг өөрийнхөө хөрөнгөөр засаж тохижуулан хүлээлгэн өгчээ. “Эцэг өвгөд, хань ижил маань Баян-Айрагт бий. Тиймээс Баян айраг гэдэг нэр миний амьдралтай салшгүй холбоотой. Ах чинь Эрдэнэт, Архангайд гурилын үйлдвэр байгуулж явахдаа ч энэ нэрийг компанидаа өгч байсан хүн” гэсээр бидний яриа өндөрлөсөн юм. Амьдралын их сургуулийг төгсөж, амжилт бүтээл гэдэг “диплом”-ыг өөртөө хадгалж үлдсэн эглээс эгэл энэ хүний намтар түүхээс сөхөж танд хүргэлээ.

## ОЙН ЭЗЭН

Төмөрбулаг суманд ирж суурьшин ажиллаж амьдарч, энэ л нутаг усанд өөрийнхөө мөрийг тодоос тод үлдээсэн олон арван хүмүүс бий. Тэдний төлөөлөл болгон тус сумын ахмад байгаль хамгаалагч Цогзол гуайг номынхоо хойморт урин залж байна. Тэрээр 1935 онд Жаргал суманд төржээ. Жаргал суманд 16 настайдаа Улаан туг нэгдлийг байгуулж явсан түүхтэй энэ ахмад буурал 1950 онд Ногоо бригадын 15 хоногийн курст шагналаар сурч, Ногоо бригадын даргаар Жаргал суманд томилогдож байсан удаатай. Нэгдэлд ногоо тарьж явсан залуу 1960 онд аймагт Барилга контор байгуулагдах үед, Мөрөн суманд очиж ажиллан Гурил, тэжээлийн үйлдвэрийн суурийг ухаж, шавыг тавьж явсан гэнэ. Улаанбаатар хот руу барилгын гурван сарын курст сууж, өрлөгчин, шаварчин, пийшинчин гэсэн үнэмлэхтэй ирж, Хөгжимт драмын театрыг барьж, Бүрэнтогтох сумын бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцож явсан ч гэсэн хувь тавилан түүнийг Төмөрбулаг сум руу хөглөсөн байх юм. Хөвсгөл аймгийн Ойн аж ахуйн даргын томилолт өвөрлөн 1967 онд Төмөрбулагт ой хамгаалагчаар томилогдож ирсэн Цогзол гуай ганц цүнх, хөнжил гудаснаас өөр өөрийн гэх хогшил хөрөнгөгүй, шуудангийн машинаас бууж байжээ. Гэхдээ тэр үед мань эр энэ л нутаг ус, ард олонтой амь, амьдралаараа холбогдож, 28 жил ой хамгаалагчийн ажлыг хийнэ, басхүү Төмөрбулаг сумаас гэр бүлтэй болж, найман хүүхэдтэй өнөр өтгөн гэр бүлийн тэргүүн болно гэж зүүдэлж байгаагүй нь лавтай. Тэрээр 28 жил Төмөрбулаг сумыг мориор тойрч, ой, ан амьтан усыг хамгаалж, Гал түймрийн тухай хуулийг хариуцаж, энэ л нутгийн дов жалга бүрийг андахгүй сайн мэдэх цөөхөн хүмүүсийн нэг болжээ. Түүнийг анх Төмөрбулаг суманд ирж байхад Төмөрбулаг сум өвөлдөө цас их ордог, хүйтэвтэр, зун өвс ногоо ихтэй тун баян хангай байжээ. Асар их ан амь амьтантай. Буга, зэрлэг гахай сүрэг, сүргээрээ нийт нутгаараа тархсан. Эрчмийн нуруу, Бүгдгээний нуруунд хүдэр, шогшоорой, бор гөрөөс тарвага ихтэй. Гол мөрөнд нь загас жараахай сүлжилдсэн үнэхээр л сэтгэл баясгамаар баян хангай байжээ. Бүхэл бүтэн сумын нутаг дэвсгэрийг ганцаараа хариуцах, хууль сурталчлах үүрэг хүлээсэн байгаль хамгаалагч маань олон нийтийг байгалиа хамгаалах



ажилд татан оролцуулж, жижүүрийн дэвтэр нээж, аж ахуй байгууллагуудад газруудыг хуваан өгч, байгалийг эзэнтэй, эзэн нь байгалиа гэх сэтгэлтэй болгохыг хичээж ажилласан. Түүнийг байгаль хамгаалагчаар ажиллаж байх үед 1977-1978 оныг хамарсан их гал Эрчмийн нуруунд гарч, гурван сайхан залуу амиа алджээ. Эрчмийн нуруунд түймэр унтрааж амиа алдсан гурван залуугийн нэг нь Төмөрбулаг сумын харьяат багш байсан гэнэ. Бүх нийтээрээ түймэр унтраах ажилд дайчлагдаж, бүтэн жил дамнаж ассан их түймэр гурван хүний аминд хүрч, ан амьтадыг ч хөнөөж, газар нутгийг хуйхалж өнгөрсөн. Энэ аймшигт түймрийн утаа, харуусал гашуудал тухайн үед олон хүнд хатуухан сануулга болон үлджээ. Энэ түймрийн дараа Цогзол гуай галын аюулаас хамгаалах талаар лекц, ухуулга таниулга хийхийн зэрэгцээ Төмөрбулаг сумын Бугатын хяр, гуравдугаар баг зэрэг газруудад түймрийн өндөрлөг барьж, галын аюул ихтэй, хуурайшилттай хавар, намар ээлжээр жижүүр хийдэг болжээ. Үүнээс гадна тэрээр Эрчмийн нуруу, Баянзүрх ууланд ан амьтанд зориулан хужир мараа тавьж, бороо хүйтэнд хоргодох байр хүртэл барьж байжээ. Жил бүрийн намар ан амьтандаа зориулан 30-40 тонн өвс хаддаг, 40 га газрыг хашиж хамгаалж, цэвэрлэж хадлангаа авдаг байсан энэ л хөдөлмөрч хүний тухай сонссон аймгийн дарга нар ирж, ан амьтан тэжээдэг хашаа хороо, хоргоддог байруудыг нь үзэж, тэргүүн туршлага нэвтрүүлсэн байна хэмээн магтаж байсан гэнэ. Амьдралынхаа ихэнх хугацааг Төмөрбулаг сумтай холбож, байгаль ан амьтанг хайрлан хамгаалах энэ л үйлсэд 28 жил зүтгэсэн ахмад буурал “Төмөрбулаг сумын буга үхрээсээ олон байсан юм шүү. Харамсалтай нь 1990 оны үед Төмөрбулагт ан амьтны эсрэг дайн зарласан. Энэ дайнд ан амьтан устаж алга болсон доо” хэмээн ярихдаа санаа алдаж байсан. Тэрээр “Алтангадас” одон, “Тусгаар тогтнолын одон”, Ардын хувьсгалын ойн медалиудтай бөгөөд Монголын ахмадын холбооноос энэ хүнд Дээд шагналаа гардуулан өгчээ.

## МИНИЙ НУТГИЙН БАХАРХАХ ҮЙЛСТНҮҮДИЙН НЭГ

**Х**амаг зүйл шороо болон замхардаг, харин гэрэл зураг түүх болон үлддэг гэсэн гашуун үг бий. Тиймээс ч энэхүү хөрөг тэмдэглэлдээ Чулууны Жаргалсайхан хэмээх хүнийг онцолж байна. Төмөрбулаг сумын уугуул Чулууны Жаргалсайхан хэмээх олондоо түшигтэй, хань ижилдээ халамжтой, үр хүүхэддээ ачлалтай эгэлгүй нэгэн саяхан болтол энэ нутагт амьдарч байжээ. Түүний аав Донойн Чулуун цаг хатуу үед цэргийн албанд татагдаж, найман жилийн дараа эргэж ирсэн гэдэг. Д.Чулуун гуайн тухай ахмадууд Тагнуул, тусгай алба гүйцэтгэж явсан” хэмээн ярилцдаг ч үүнийг батлах баримт сэлт бидний үед үлдсэнгүй. Харин түүний хүү Ч.Жаргалсайхан дунд сургуулиа төгсөөд “Давшилт” нэгдлийн адуучин болж, Эвлэлийн төв хорооны жуухаар шагнагдаж явжээ.



Адуучин залуу нэг л өдөр ажлаа орхин сумын эмнлэгт галчаар ажиллаж эхэлжээ. Өөрийгөө их хөгжүүлдэг, цаг зав бүхнээ ашиглаж ном уншдаг, зүгээр суухыг тэвчиж чаддаггүй байсан энэ хүн зургаан сарын санхүүгийн курс төгссөн. Гэхдээ богино хугацаанд олж авсан мэдлэгээ бататгаж чадсан учраас Санхүүгийн тасагт нягтлангаар орж, санхүүгийн тасагт эрхлэгч хийж, 1994 онд тус сумын орлогч даргаар ажиллаж байжээ. Боловсрол төгссөн сургуулиас гадна амьдралын ухаантай тэрээр Сумын орлогч, санхүүгийн тасгийн эрхлэгч байхдаа ажлаараа аймагтаа тэргүүлдэг байсан тухай нөхөд нь өнөөдөр ч дурсан ярьж байсан юм. Юмыг мартдаггүй, нэг тааралдсан хүнээ хэзээ ч анддаггүй тун гярхай Ч.Жаргалсайхан гуай фото зураг авах сонирхолтой, басхүү түүх сонирхон судалдаг нэгэн байжээ. Тэрээр сумынхаа түүхийг өгүүлэх фото зураг бүхий. “Миний нутгийн бахархал Төмөрбулаг түүхэн цомгоос...” альбом хийхээр олон жил бодож, мөрөөдсний эцэст ахмадуудын талаар судлаж, бүтэн жил айлуудаар явж гэрэл зураг цуглуулж, сумынхаа тухай анхны фото альбом хийж, ном гаргаж үлдээсэн нь өнөөдөр бидэнд хадгалагдан үлджээ. Ахмадуудын яриа, хууч домог, басхүү түүх намтар

сонсож цуглуулж байсан энэ хүн харамсалтай нь бидний дунд алга. Гэхдээ он цагийн түүхийг цухасхан ч гэлээ өгүүлэх фото зургууд нь энэхүү номыг бүтээхэд ч гэсэн баримт болон орж байгаа юм. Сумынхаа газар нутгийг сайн мэддэг энэ хүн Төмөрбулаг сумын уул усны тухай олон шүлэг, магтаал бичиж үлдээж. Их түүхийн шарласан хуудсыг, эглээс эгэлхэн ард түмнийхээ намтар бүтэээлийг судлаж явсан Ч.Жаргалсайханыг тухай Төмөрбулагчууд одоо ч гэсэн өгүүлэн дурссаар байна. Нутаг усныхаа бахархах үйлстнүүдийг номын хуудсанд мөнхлөхөөр зүтгэж явсан Чулууны Жаргалсайхан гуай өнөөдөр өөрөө миний нутгийн бахархал болон үлджээ.

## АМЬДРАЛЫГ ТУЛАХ ХОС БАГАНА

Өнгөрсөн түүхийг эргүүлж үзэхэд 1980-аад он бол Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ид мандан бадарч явсан он жилүүд байж дээ гэсэн бодол үлдээдэг. Эрчмийн хар ямааны үржлийн ферм байгуулагдаж, төлөвлөгөө нормоо сумаараа давуулан биелүүлж, нэгдлийн мал аж ахуйн мэргэжилтнүүд бүгд л шагнал сайшаал хүртэж, сум нэгдлийн дарга Батбаяр “Алтан гадас” одонгоор шагнагдаж, малаа таван толгойгоор өсгөсөн Төмөрбулаг сумын иргэд сумаараа гавшгайч сум болж түүхтэй. Тэдний нэг Гэндэнгийн Дашбямба 1946 онд Донхорын голд төржээ. Тэрээр долдугаар анги төгсөөд Архангай аймгийн техникум төгсөж, зоотехникч мэргэжил эзэмшиж ирээд Ринченлхүмбэ сумын Загасны үйлдвэр буюу одоогийн Цагааннуур суманд томилолт өвөртлөн очиж байсан гэнэ. Тэрээр Цагааннуурт ажиллаж байгаад төрж өссөн Төмөрбулаг сумандаа ирж, сумын нарийн бичгийн даргаар 1980-1988 оны 10 сар хүртэл ажилласан түүхтэй. Үнэхээр 1980-аад оны үеийн Төмөрбулагчуудын түүхийг хамгийн сайн мэдэх хүмүүсийн нэг. Найман жил сумын удирдлагад ажилласан Г.Дашбямба гуайг одоо ч нуггийнх нь олон түмэн “Дарга” хэмээн хүндэтгэн дуудах нь бий. Тухайн үед сайн ажилласан хүмүүсийг ажил сайжруулах нэрээр өөр газарт томилдог бичигдээгүй хууль үйлчилж байсан гэдэг. Сумын даргаар ажиллаж байсан Батбаяр өөр сум руу шилжиж, нарийн бичгийн дарга Г.Дашбямба ч бас Шинэ-Идэр суманд сумын орлогч даргаар томилогдож байжээ. Г.Дашбямба хэмээх энэ хүн 1990 оны эхээр Төмөрбулаг сумын Худалдаа бэлтгэлийн ангиас үүсэж гарсан Жаргалант хэрэглээний хоршоонд ажиллаж байжээ. Гэвч удалгүй мал дээр гарах шийдвэр гаргаж, малчин болсон гэнэ. Өмч хувьчлалаар 30 гаруй толгой мал авч, анх 100 гаруй толгой малтай мал дээр гарч байсан энэ хүн хувийн малаа маллахын зэрэгцээ нэгдүгээр багийн даргаар ажиллаж байсан байх юм. Гэвч үүнээс хойш хэдхэн жилийн дараа малаа өсгөж, Хөвсгөл аймгийн “Сайн малчин” гэдэг цол тэмдэгний эзэн болжээ. Тухайн үед тэрээр 1000 гаруй толгой мал тоолуулж байсан гэдэг. Анх 100 хүрэхгүй малтай мал дээр гарч байсан энэ хүн хэдхэн жилийн дотор малаа 2000 гаруй толгой мал өсгөж, хүүхдүүдээ өмч тасалж өгч, одоо 600 гаруй толгой малтай. Цаг хэцүү, мөнгө төгрөг хомс байх үед өглөг авлага нэхэж, бариа зөрөөн дээр солио хийнэ гэж айлгаж тунирхалгүйгээр сургуулийнхаа цагаан идээг бүрэн хангаж, дотуур байрны хүүхдүүдийн хоолны мах нийлүүлдэг байсан энэ хүнээс “мал өсгөх амархан уу” хэмээн асуухад Г.Дашбямба гуай “Нэр нь минийх болохоос биш нэдэр дээрээ энэ хэдэн малыг манай хөгшин л малладаг юм шүү дээ” хэмээн инээд алдаж суух. Амьдралыг нэгэн их том дээвэр хэмээн зүйрлэвэл тэрээр энэ хүндхэн ачааг гэргийтэйгээ хамт 48 жил үүрч байгаа. Үнэхээр ч түүний гэргий мал өсгөх үржүүлэх асарч сувилах ажилд гаршсан хүн гэнэ. Г.Дашбямба гуайн гэргий ..... мөн



л Архангай аймгийн техникум төгссөн, мал аж ахуйн мэргэжилтэн хүн. Төмөрбулаг сумын малын эмчилгээ тэжээлийн цэг дээр ажиллаж, жилдээ ядарсан сульдсан бэртэж гэмтсэн 3000 гаруй малыг тэжээдэг байсан энэ хүн Мал эмнэлэгийн аптект ч мөн ажиллаж байсан. Тухайн үед малын тоо толгой эрс өссөн ч үүлдэр угсаа, малын чанар муудаж, мал жилбэгүй төллөж, төл малыг угжих их ажил ундарчээ. Тэр үед мал эмнэлэгийн эмийн санд ажиллаж байсан Л.Данаажав гуай малын сүү орлуулах тэжээл хийж туршсан нь аймаг даяар тэргүүн туршлага болон нэвтэрч байлаа. Төлөвлөгөө норм шахагдаж байсан тэр цаг үед Төмөрбулаг сум жилдээ 50 гаруй мянган мал төлүүлдэг. Гарсан төл болгоныг мал болгох үүрэг хүлээдэг байсан цаг. Хуурай сүү, ус, хуурай өндөг, давс, загасны тос, элсэн чихрийг зохистой хэмжээгээр хольж, багсарч, 10 литр сүү найруулахаар бэлтгэсэн түүний зургаан найрлагат бэлдмэл малчин бүрийн хотонд хүрч, хавар мал төллөх үед сүүндээ цадахгүй байгаа төлийг угжиж, олон мянган төл амьд мэнд үлдсэн гэдэг. Хийсэн бүтээсэн зүйлээрээ олондоо хүндлэгдсэн энэ хоёр хүн 48 жил ханилжээ. Тэднийх 14 ач зээтэй. Гэвч сүүлийн үед мал маллах хүн ховордож байгаад Г.Дашбямба дарга сэтгэл дундуур явдаг гэнэ. Аймгийн аварга малчин маань “Маниус төрийн бодлогыг мэдэх биш. Гэхдээ хүүхдийг 6 настайгаас нь сургуульд авдаг болсноос хойш малчдын тоо цөөрөөд л байна. Хөхнөөсөө гараагүй шахам жаахан хүүхдээ дагаж залуучууд малаа орхин төв суурин газар барааддаг, эсвэл нэг гэрийн хоёр тарж бутарч амьдрахаас өөр аргагүй л байна шүү дээ” хэмээн тэрээр бухимдангүй ярьж байсан. Нээрээ л үе дамнаж малаа маллаж ирсэн нүүдэлчин монголчууд малаасаа хөндийрч, ёс уламжлалаа гээж, хэзээ нэгэн цагт төрсөн нутаг ус минь эзэнгүйдэж үлдэх вий гэсэн болгоомжлол Г.Дашбямба тэргүүтэй ахмадуудын сэтгэлийг эмзэглүүлж байдаг юм шүү гэдгийг залуучууддаа сануулах нь зүйд нийцэх буй заа.

## АВАРГУУД ТӨРҮҮЛСЭН “АВАРГА”

Монгол хүний малч чанар цусанд нь оршиж байдаг гэж “Монгол мал” хөтөлбөрийг санаачлагч УИХ-ын гишүүн Д.Балдан-Очир нэгэнтээ өгүүлж байж билээ. Үнэхээр монгол хүний цусанд шингэсэн малч чанар, мал эмнэлэг анагаах ухааны эрдэмтэй хослоод ирэхээр монгол түмнийг хэдэн мянган жил тэжээж, тэтгэж ирсэн мал аж ахуй өөдлөн дэвжиж, Монгол мал дэлхийг тэтгэх цаг ирэх л юм байна гэсэн өөдрөг бодлыг надад шингээж үлдээсэн хүн бол Санжжавын Давааням. Социализмын үед мал маллах залуучуудыг ятган сэхрүүлэх үүрэг хүлээж бүтэн шөнөжин “лекц” уншиж, “Унтуулдаггүй Давааням” гэдэг хоч хүртэл авч байсан энэ ахмад 1943 онд төржээ. Тэрээр удам дамжсан малчин ардын хүү. Төмөрбулаг сумын бага сургууль төгсөж, Архангай аймгийн техникумд сурч, 1964 онд малын бага эмчийн



мэргэжил эзэмшсэн С.Давааням гуай ажлынхаа гарааг Улаан-Уул сумаас эхэлсэн ч удалгүй нутагтаа ирж, нэгдэлд ажиллаж эхэлжээ. Төмөрбулаг суманд бригадын малын эмчээр 18 жил ажилласан тэрээр Эмчилгээ тэжээлийн цэгт малын эмчээр ажиллаж дараа нь Мал аж ахуйн үржлийн фермд даргаар 10 гаруй жил ажилласан туршлагатай мэргэжилтнүүдийн нэг юм. Эрчмийн хар ямааны үүлдэр, угсааг сайжруулахаар Баян-Өлгийгөөс ухна авчирч, хөдөө аж ахуйн дээд сургуулиас ирсэн эрдэмтэдтэй хамтран ямаагаа ангилж, ялгах ажлыг эхлүүлжээ. Тэрээр 1985 оноос ямаанд ангилалт хийж, хоёрдугаар багт ямааны суурь зохион байгуулах ажлыг гардан хариуцаж байж. Тухайн үед эм ямаа, борлонг нэг бүрчлэн үзэж, элит анги, нэг хоёрдугаар анги болгон ялгаж, гуравдугаар ангийн ямааг ахуйд хэрэглэхээр тусгаарладаг байжээ. Ямаа бэлчээрлэх хамгийн тохиромжтой газар нутгийг сонгож, таван төрлийн малтай байсан хорёдугаар багийг ямааны суурь бригад болгон өөрчлөн зохион байгуулж, ямаагаа ч ялгаж, малчдаа ч шигшиж байсан гэдэг. Төмөрбулаг суманд үржлийн ямааны суурь зохион байгуулж байгааг Хөдөө аж ахуйн яам дэмжиж 1985 онд тус суманд Ямааны үржлийн улсын ферм байгуулагдаж

байсан түүхтэй. Энэхүү ямааны фермийн үр шимийг Төмөрбулагчууд хүртсэн. Одоо ч хүртсээр л байгаа. Учир нь 1985 оноос эхлэн ямааны үржлийн фермд улсаас арай илүү төсөв санхүү олгож, улсын төсвөөс хөрөнгө мөнгө гаргаж, хоёрдугаар бригадад контор, улаан булан барьж, эмчилгээ тэжээлийн цэг байгуулж, хоёрдугаар багийн төвийг тохижуулж, мэргэжлийн зоо техникчээр хангасан аж. Харин өнөөдөр С.Давааням тэргүүтэй олон хүний хүч хөдөлмөр шингэсэн ямааны үржлийн ферм тарж бутарсан ч гэсэн энэ ферм дээр өсгөж үржүүлж байсан Эрчим омгийн хар ямааны ашиг шим нутгийн олонд өгөөжөө өгч жилдээ 3,2 тэрбумын ашиг орлого олсоор байгаа. Энэ бол мартах учиргүй бас түүхүүдийн нэг гэдэгтэй хэн ч маргахгүй нь лавтай. Шаардлага өндөр, ажлын ачаалал ихтэй, төсөв төлөвлөгөөнд шахагдсан тэр үед хүнд хэцүү үед С.Давааням гуай сумын депутат, аймгийн депутатаар сонгогдож байсан нэгэн. Асар их хөдөлмөрч, басхүү бусдыг үргэлж, уриалан дуудаж, дэмжиж ажиллаж чаддаг энэ хүнтэй уулзаж суухад өөрийнхөө намтар түүхийг ярихаас цааргалах мөртлөө харин манай баг, манай сум, манай тэр гэж ярих нь олонтаа. Гэхдээ түүний удирдаж байсан бригад ажил үйлсээрээ шалгарч, дөрвөн жил дараалан эхний тавд багтаж байсан байх юм. Үүнээс гадна бригадаараа 6-р таван жилийн гавшгайч болж байжээ. С.Давааням гуай П.Цагаач малчны ямаануудыг жигнэж, эм ямааны амьдын жин дунджаар 54 кг хүрч байгааг тогтоожээ. Гэвч “Нутгийн уугуул ямааны амьдын жин яагаад ч 54 кг хүрэхгүй” гэдэг маргаан гарч, матаас бичиг хүртэл очиж тухайн үед Хөдөө аж ахуйн яам, Ардын хянан шалгах хорооноос хамтарсан шалгалт ирж байжээ. Шалгалтын комиссынхон ямааны жин алдагдсан өвлийн хахир цагаар буюу нэгдүгээр сард ирсэн аж. Тэд хяналтын жин хийж “Аргагүй үнэн” байна хэмээн тогтоож П.Цагаачид Улсын аварга цол олгосон юм. Туслах малчин хийж байсан П.Цагаач С.Давааням даргын бригадад ямаа маллаж, сумын аваргаас улсын хошой аварга болж, хожим Монгол Улсын Хөдөлмөрийн баатар болсон түүхтэй. Мөн тус бригадын малчин Батмөнх 720 борлон хариуцан маллаж, үйлдвэрлэлийнхээ даалгаврыг биелүүлж улсын аварга гэдэг эрхэм цолыг хүртжээ. Үүнээс гадна Улсын аварга хадланч Ч.Цэрмаа мөн л түүний бригадаас төрсөн.Түүнийг бригадын дарга байх 12 жилийн хугацаанд Төмөрбулаг сумын хоёрдугаар бригадаас гурван хүн дөрвөн удаа Улсын аварга болж байсан түүхтэй. Үүнээс гадна Аймгийн аварга Ням-Очир, Бат-Очирын Алтанцэцэг, дөрвөн удаагийн аймгийн аварга П.Лунхаан зэрэг олон аваргууд түүний бригадад ажиллаж амьдарч байсан байх юм. Мөн хоёрдугаар багаас гурван малчин АИХ-ын депутатаар ээлж дараалан сонгогдож байжээ. Аваргуудыг төрүүлсэн “аварга маань 1988 оноос эхлэн нэгдүгээр багийн Эмчилгээ тэжээлийн цэгт малын эмчээр ажиллаж байжээ. Тэр үед сумын хэмжээнд ганцхан Эмчилгээ тэжээлийн цэгтэй, сульдсан доройтсон ядарсан бэртсэн, халдварт өвчингүй бүхий л малыг энэ цэгт эдгээж, тэнхүүлж, сувилж байсан гэдэг. Эмчилгээ тэжээлийн цэг жилдээ 3000 гаруй мал хүлээж авдаг. Ихэнх нь төл мал байдаг учраас ачаалал ихтэй байгааг нь харгалзан үзэж сумын удирдлагууд туслах төлчид ажиллуулах шийдвэр гаргажээ. Гэвч С.Давааням дарга мал төлүүлэхээр ирсэн туслах төлчдөөр гурван жил хэрэглэх



түлшний нөөцөө бэлтгэж, шонгийн мод татуулж авчээ. Тэрээр эмчилгээ тэжээлийн цэгт ажиллаж байсан хүмүүстэйгээ хамтран сумын төвөөс 2.5 км газарт цахилгаан татжээ. Одоогийн ханшаар тооцвол хэдэн зуун саяар яригдах хэмжээний том бүтээн байгуулалтын ажлыг С.Давааням хэдхэн сарын дотор өөрсдийнхөө хүчээр хийж, эмчилгээ, тэжээлийн цэгийг гэрэл цахилгаантай болгож байсан хүн. Харамсалтай нь зах зээл эхэлсний дараа энэ цахилгааны шонгууд устаж алга болжээ. Түүнийг эмчилгээ, тэжээлийн дарга байхад тус цэгт хүргэгдэж ирсэн малын эдгэрэлт 95-аас дээш, тэнхрэлт 98-аас дээш хувьтай байсан гэдэг. С.Давааням гуай 1990 он гарсны дараа нэгдүгээр багт малын эмч хийж байгаад 1994 онд гавьяаныхаа амралтыг аваад зүгээр суусангүй, ахмад буурал маань 1994 оноос хойш 20 гаруй жил мал маллаж байна. Тэрээр 1000 гаруй толгой малтай. 2007 онд мянгат малчны болзол биелүүлсэн. Тэрээр есөн айлд өмч тасалж өгсөн ч гэсэн эдүгээ 500 гаруй толгой ямаа, 800 гаруй хоньтой, 100 гаруй үхэр, 30 гаруй адуутай, ямааныхаа ноолуураас жилдээ 13 орчим сая төгрөг авдаг гэнэ. Тэрээр 2013 онд Улсын сайн малчин болжээ.

## СУМЫН НААДАМД 50 ЖИЛ ТООСОО ӨРГӨСӨН УЯАЧ

Хотгойд түмэн хурдаараа алдартай. Хошуу нутгынхаа нэрийг цуурайтуулж, хүн зоноо баярлуулсан зартай хурдан хүлгийн тухай “Хотогойдын унага” хэмээх дуу хэдэн зуун дамнан өнөөдөр ч дуулагдсаар байна. Морио магтан дуулсан хэн гээч уяач Хотгойд газар шороон дээр альхан цаг үед амьдарч, ямархан хувь тавиланг туулж явсныг өнөөдөр хэн ч мэдэхгүй. Харин Хотогойд түмний үр сад болсон төмөрбулагчууд ч гэсэн хурдан морь, сайн уяачдаараа бас л зартай. Тэдний нэг нь Гэндэнгийн Раххэт хэмээх хэмээх энэ буурал Бүгдгээний голд 1939 онд төржээ. Нэгдэлд адуу маллаж байгаад 1965 оноос хойш хонь ямаа маллаж байсан аж. Гэвч тэрээр морь мал уяж, сумынхаа наадамд 50 жил морь уясан ахмад уяач. Эдүгээ наян насны босгыг алахсан буурал уяач сумын 50 наадамд тоосоо өргөж явсан гэж бодохоор нэг л бахарахмаар... Тэрээр 2000 онд аймгийн “Алдарт уяач” гэдэг цол хүртжээ. Г.Раххэт уяачийн хүрэн морь, хээр морь, хээр азарга гээд зартай хурдан хүлгүүд цагтаа наадамчин олноо баясгаж, сумынхаа баяр наадмын дэвжээнээс дандаа л айрыг түрүү хүртэж явсан гэнэ. Сумын наадамдаа 50 жил тоосоо өргөсөн ахмад уяачийн үр хүүхэд, ач зээ нар одоо ч морь уяж байгаа. Сүүлийн үед морины бай шагнал өндөр болсон. Та яагаад морь уяхгүй байна вэ? гэсэн саваагүй асуулт маань угийн яриа хөөрөө багатай, би гэж хэзээ ч цээжээ дэлдэж, басхүү шагнал урамшууллын хойноос хөөцөлдөж яваагүй ахмадын уцааргы хөдөлгөж орхив. Тэрээр “Би бэлчээрээр л морь уяж байснаас биш тэжээл, эм тариагаар морь уяж байгаагүй” хэмээн сэтгэл дундуурхан өгүүлж байсан. Сүүлийн үед монгол морийг хэт их эрлийзүүлж, басхүү эм тариа хэрэглэж, хүчтэй тэжээл өгч, морь уях эрдэм ухаан арга заль болон хувирч байгаад тэр бүхимдаж суудаг буурлуудын нэг. Үүнээс гадна Г.Раххэт гуай бага залуудаа явдал хийцтэй, жороо морь их унадаг, морийг тун ч сайхан эдэлдэг байсан хэмээн ахмадууд ярьж байна. Жороо морь унасан, уясан хүнээсээ шалтгаалдаг. Тиймээс учир мэдэх ахмадууд түүнийг морины явдал сайжруулдаг эрдэмтэй хүн гэж үнэлдэг юм билээ. Сулын жороо морь ч байдаг. Ер нь жороо морийг яг л хурдан морьтой адил уяж, сойж, өглөө, оройны сэрүүнд унаж, жороо оруулдаг юм шүү дээ хэмээн тэрээр захиж байсан. Харамсалтай нь Г.Раххэт уяачийн морины явдал сайжруулах эрдмийг өнөөгийн бид хайхралгүй гээж орхисон байж магадгүй л юм.



## ТАВАН ҮЕЭ ҮЗСЭН БУУРАЛ

Төмөрбулаг сумын өндөр настнуудын нэг Т.Цагва гуайтай уулзахаар намрын дунд сарын шинийн 16-ны өдөр зорьж очиж билээ. Эдүгээ 86 насны сүүдэр алхаж байгаа Цагва гуай биднийг очиход үйл үртэс урлаад завгүй. Зээ охиных нь хүү хурим хийхээр бэлтгэж, зочид гийчдийг угтан хоол унд бэлтгэж, харин Т.Цагва гуай зээ охиныхоо хүүд гутал урлаж суух юм. Зээ охин нь ачаа тэвэрч, Т.Цагва гуай тав дахь үеэ үзээд удаагүй байгаа гэнэ. Таван үеэ үзсэн энэ буянтай буурал 1928 онд төржээ. Түүний аав Бүгсийн хүрээнд шавилж суусан, лам оточ хүн байжээ. Гэхдээ л түүний удамд оёдол



эсгүүр хийдэг уран хүн байсангүй. Харин ээжийнхээ зааж зааварласнаар Т.Цагва гуай 14 наснаасаа оож, шидэж эхэлжээ. Ах дүү олуулаа, даавуу даалимба ховор үед хүн бүр л цагаан хөдсөн дээл, хөдсөн өмдтэй. Хөдсөн хувцас харгана, бургасанд их урагддаг, нөхөөс зүйдэл тавихаар үзэмж муутай харагддаг учраас жаахан охин урагдсан дээл өмдний эв тааруулж оёсоор гарын дүйтэй болсон гэнэ. Т.Цагва гуайг жаахан байхад үед утас тун ховор байжээ. Үхрийн шөрмөс хатааж, томж утас хийдэг байсан гэнэ. Тэрээр одоо ч гэсэн үхрийн шөрмөс боловсруулан утас томж, гутал хувцсаа шөрмөсөөр л оёдог аж. Т.Цагва гуайн зээ охин эдүгээ тавь гарсан эмэгтэй “Эмээ нарийн, хэврэг утас бол бүүр үзэхгүй шүү дээ. Муу гуйлгачингийн эд л ийм байдаг байх гэж уурладаг юм. Юм оёж байхад нь утас нь тасарвал бүүр их уурлана” хэмээн яриад инээд алдаж байлаа. Үнэхээр ч үхрийн шөрмөсийг томж нийтгэсэн утас бат бөх, тасарч, эргэж хөвөрдөггүй болохоор юм оёход урамтай байдаг тухай Т.Цагва гуай ярьж, өөрийнхөө хийсэн утаснуудыг үзүүлж билээ. Магадгүй Т.Цагва гуайгаас өөр хүн “Энэ утас биш, үхрийн шөрмөс” гэж хэлсэн бол сэтгүүлч миний бие итгэхгүй ч байсан байж магадгүй. Нарийнхан цагаан утаснууд... Шөрмөсийг хатааж, сэмлэж, утас болгон томжээ. Богинохон л болохоос биш үйлдвэрийн утаснаас ялгагдахгүй нарийн цагаан утаснууд... Үүнээс

гадна Т.Цагва гуай сарлагын хөөвөр томж утас ээрч суудаг гэнэ. Мань шиг хүн маань унших гэж цаг алдаж сууснаас утас ээрч, хүүхдүүдийнхээ хагархай цоорхойг оёж суусан нь илүү амьдралд хэрэгтэй юм даа хэмээн хуучилж байсан Т.Цагва гуайн чихний сонсгол сайн, ухаан саруул, нүдний хараа тун хурц. Таван үеэ үзсэн буурал гурван хүүхэдтэй. Том охин нь эдүгээ 60 насны босго алхжээ. Тэрээр “Ээж надаас сайн хараатай шүү” хэмээн ярьж суусан. Тэрээр 70 гарсан хойноо нүдний эмчид үзүүлэхэд шил тааруулахыг зөвлөсөн ч Т.Цагва гуай үхэхийн хооронд нүүрэн дээрээ бас нэг юм наагаад яахав хэмээн зөрүүдлээд зүүлгүй орхижээ. Үүнээс хойш хориод жил өнгөрч байна. Одооч тэрээр нүдний шил хэрэглэдэггүй. 1990 оны үед Т.Цагва гуай буриад гутал урлаж, нутгийнхандаа арилжиж, амьдарал ахуйдаа нэмэрлэдэг байжээ. Сэтгэл гаргаж, хийсэн гутлууд нь яс чанар сайтай байсныг ч олон хүн ярьж байсан. Т.Цагва гуайн бэрүүд бүгд өөрсдөө гутал хувцсаа оёж сурчээ. “Манай бэрүүд уран. Хүн гуйхгүйгээр дээл хувцсаа оёдог хүмүүс болсон” хэмээн ярьж байгаа энэ буурал залуудаа цагаан хөдсөн дээл урлаж байжээ. Хөдсөн дээл эсгүүр, оёдол нарийн шаарддаг, одоогийн бид нарын өмсдөг дээлнээс илүүтэй уран чамин хийцтэй эд байсан аж. Т.Цагва гуай залуудаа хийж байсан хөдсөн дээл оёж үр хүүхэддээ үлдээх юмсан хэмээн боддог гэнэ. Гэвч одоо цагт арьс, нэхий элддэг, торго шиг зөөлөн болтол боловсруулдаг хүмүүс ховорджээ. Таван үеэ үзэж, 90 насны босго руу алхаж яваа ийм нэгэн буянтай буурал Төмөрбулаг суманд утас нийтгэн үйл урлаж үр ач нараа тойруулан энх тунх амьдарч сууна.


## НЭГ НАСААРАА ХОНЬЧИН

**Н**эг насыг дуустал хонь маллаж байгаа хүн дээ би хэмээн Даваахүү гуай өөрөө хэлсэн юм. Тэрээр 1951 онд Төмөрбулаг суманд төржээ. Даваахүү гуай бага сургуулиа төгсөж, Цэргийн алба хаагаад 1973 онд нутагтаа ирж, үржлийн хонь хариулж эхэлжээ. Нэгдэлд үржлийн төллөх хонь л маллаж байсан энэ буурал өдгөө 1600 гаруй хоньтой, 2008 онд Мянгат малчны болзол хангаж байжээ. Тэрээр нэгдэл ажиллаж байхдаа сум нэгдлийн аваргаар шалгарч байсан аж. Үржлийн хонь маллаж байхдаа жилд 300-500 хонь төлүүлдэг байжээ. Тэр үед 100 хониноос 95 төл бойжуулах үүрэгтэй. Энэ үүргээ ч жил бүр биелүүлж байжээ. Сурсан зүйл гэдэг хүний амьдралд үргэлж л хэрэг болж байдаг гэсэн үг бий. Үнэхээр ч Даваахүү хоньчин хувийн мал дээр гарч, дөрвөн хүүхэдтэйгээ мал маллаж байгаа ч гэсэн 100 хониноос доод тал нь 95 төл бойжуулах ёстой гэсэн бодол цээжнийх нь мухарт хадгалагдан үлджээ. Та тэр төлөвлөгөөг одоо ч гэсэн биелүүлсээр байгаа юм уу гэхэд Даваахүү гуай тачигнатал инээд алдаж “Сүүлийн хориод жил үүргээ таслаагүй яваа” хэмээн хариулсан. Энэхүү хичээл зүтгэл нь ч эзэндээ амжилт авчирчээ. Тэрээр Төмөрбулаг сумын мянгат малчдын нэг. Тэднийг 40-50 адуу, 40 гаруй үхэр, 1600 гаруй хоньтой. Малыг бэлчээрээр таргалуулж, оторлуулж сурсан энэ ахмад 1700 шахам малд зориулж намартаа хоёрхон тэвш л өвс хаддаг. Гэвч нэг тэвш өвс нь өнждөг гэсэн. Бэлчээрээр мал маллаж, малаа таргалуулж өвөлжүүлж сургасан учраас түүний хонь яс чанар сайтай. Даваахүү гуай 2013 онд Аймгийн аварга малчин болжээ. Төмөрбулагчууд ямаа дагнан маллах сонирхолтой. Гэвч Даваахүү гуай хонь дагнан малладаг. Хүүхдүүд нь өсөж томорч, хонин сүрэгтээ бүтцийн өөрчлөлт хийж ямаа өсгөхийг аавдаа санал болгодог ч тэрээр эрс дургүйцдэг гэнэ. Хонь гэдэг буянтай мал. Хонинд явах гэдэг хамгийн жаргалтай ажил шүү дээ. Малыг хайрлахгүй бол түүнийг хамгаалах маллах ухаан төрхгүй. Ер нь юмыг хийе бүтээе гэсэн үнэн сэтгэл байсан цагт хүний зүтгэл санаачлага ундрана. Зүтгэл санаачлага байсан цагт ажлын арга дүйг олно. Жишээ нь өвс ургамалыг танина. Газар орон нутаг бэлчээрийн байдлыг мэднэ. Малынхаа тарга тэвээргийг бүр зүс зүсээр нь мэддэг болно. Ингэхгүйгээр мал нэг бүрд тохирсон арчилгаа хийж чадахгүй. Мал ер эзнийхээ сэтгэлийг л дагаж өсдөг юм шүү дээ хэмээн хуучилсан Даваахүү гуай саяхан хөлөө гэмтээгээд хониндоо явж чадахгүй болохоор уцаар төрөөд байх юм гэсээр биднийг үдэж өгсөн. Малын ашиг шимийг хүртэж, малынхаа төлөө ажиллаж амьдарч ирсэн буянтай буурал нэг насаа дуустал хонио л хариулах нь дамжиггүй бизээ.



## АВАРГА ТУУВАРЧИН

**М**алын хөлийн их тоосонд дарагдаж, хүн малыг чилээсэн их аялалд гардаг байсан олон олон тууварчдын нэг эгэл даруухан энэ хүнийг И. Ганболд гэдэг. Тэрээр 1957 онд төрсөн, Бүгдгээний голын хүн. Түүний аав үйлдвэр бригадад ажиллаж багийн даргын алба хашиж явсан Ичинхорлоо гэж хүн байжээ. И. Ганболд 1969 онд бага сургуулиа төгсөөд малчин болжээ. Нэгдүгээр бригадад холбоочин хийж, Тариат руу сонин зөөж явж байгаад 1975 онд цэргийн алба хаасан аж. Цэргээс ирсэн шижигнэсэн залуу тухайн үеийн Давшилт нэгдлийн туслах үйлдвэрлэлийн бригадад орж, барилга байшин барьж байгаад 1981 оноос эхлэн туувар тууж эхэлжээ. Тухайн үед Давшилт нэгдлийнхэн Дарханд малаа тушаадаг байсан гэнэ. Нэг жилд л гэхэд 10 гаруй суурь Дархан хотын зүг туугдаж явдаг байжээ. И. Ганболд гуай 18 жил туувар туусан. Жилдээ 240-400 үхэр тууж, Хөвсгөл аймгийн тарга хүчний аваргаар тодорч байсан удаатай. Монгол үхрийн амьдын жинг 92 кг-аар нэмэгдүүлж, Хөвсгөл аймгийн аварга тууварчны болзол хангаж байсан байх юм. Тэрээр Төмөрбулаг сумын иргэдийг төлөөлөн Улаанбаатар хотод болсон Тууварч малчдын зургадугаар зөвлөгөөнд оролцож байжээ. Урт хөлийн мал тууна гэдэг амаргүй. Бороо хур элбэгтэй үед хуурай хувцасгүй болтлоо шалба норж, бүхэл бүтэн дөрвөн сарыг хээр гадаа хонож явж байж авсан малаа хүлээлгэж өгнө. Жил бүрийн тавдугаар сарын 15-нд малаа хүлээж аваад 11 сарын 20 хүртэл нэг жилийн зургаан сарыг гадаа хонож, халуунд халж, хүйтэнд хөрч явсан үеэ тэрээр хамгийн сайхан өдрүүдийн нэг хэмээн дурсан ярьж байсан. Үнэхээр ч залуу халуун нас, хөдөлмөрийн үр шим, байгаль дэлхийн ааш аяг сайхан дурсамжуудыг түүнд үлдээсэн нь лавтай. Монгол үхрийн амьдын жинг 92 кг-аар нэмэгдүүлж, Хөвсгөл аймгийн аварга тууварчин болж явсан энэ хүн дараа нь нэг үхрийг жинг 105 клограммаар нэмэгдүүлж, 1991 онд “Алтан гадас” одон авч, “Тэргүүний залуу” алтан медалиар шагнуулж байжээ. Тухайн үед сайн тууварчдаас зөвлөгөө авч, Чандмань-Өндөр сумын гавьяат нэгдэлчин Цэрэннямаа гуай дээр очин туршлага судлаж, малынхаа жинг нэмэгдүүлэхийн төлөө хичээж явсан энэ хүн уг нь Улсын аваргын болзол хангасан тууварчин. Даанч “аз дутсан” хэмээн үеийнхэн нь хуучилж байсан юм. Тухайн жил Төмөрбулагын тууварчдыг малаа жинлүүлэх гэж байтал Сэлэнгээс ирсэн машин дүүрэн гахайг түрүүлж жигнэж, хөдөө хээр бэлчээрлэж явсаар ирсэн үхэр сүрэг гахайн үнэр танараас болон пүүний хашаа руу орохгүй сандарган, нарийн тооцоо бодуулж чадалгүй цаг алджээ. Хэрвээ тэр машинтай гахайг түрүүлж жинлээгүй бол манай төмөрбулаг чинь Улсын аварга тууварчинтай сум байх



байлаа тэд ярьж суусан. Үнэхээр ч И.Ганболд гуай аймагтаа толгой цохих сайн тууварчдын нэгт зүй ёсоор бичигддэг нэгэн байж. 1988 онд Москва, Армин, Твисс рүү Монголын сайн малчид явж амрахад Төмөрбулаг сумаас Махдиваа, И.Ганболд гуай хоёр явж амарчээ. Цаг хатуу үед гадаадад явуулах малчдыг тун нарийн сонгож шалгаруулж, сумын намын хороо, аймгийн намын хорооны хурлаар хүртэл хэлэлцэж байж шийдвэр гаргаж байсан гээд бодохоор И.Ганболд гуай үнэхээр л сум орноо хошуучилсан сайн малчдын нэг байсан хэрэг. Том том дээл, монгол гуталтай малчид улаан талбай дээр хөлхөлдөж, тэр үед оросууд гайхаж, сонирхон зураг хөрөг авч, үзмэр үзэж байгаа юм шиг л шуугилдаж байсан хэмээн яриад инээд алдаж байлаа. Түүний гэргий Н.Бямбаа байрын багш, сургуулийн ахлах тогооч хийж байгаад гавьяаныхаа амралтанд гарчээ. И.Ганболд гуай гэргийтэйгээ хамт одоо ч малаа маллаж байна. Биднийг замчилж очсон охин нь “Тууварт явж, малаа өвсний шим дагуулж бэлчээсээр байгаад сурчихсан байдаг юм байлгүй. Манай аав дандаа л ганц гэрээр захлаж бууж, хэдэн малаа өөрөө л өдөр шөнөгүй дагадаг хүн дээ” хэмээн хуучилж байлаа.

## УДАМ ДАМЖСАН БАРИАЧ

**Ш**атарбалын Цэдэв гуай Төмөрбулаг сумын Нарийний голд төрсөн. Түүний аав Шатарбал нутаг усандаа гайхагдсан бариач байж, олон түмэнд тус хүргэж байжээ. Цаг хатуу, лам оточ бариач нарыг баривчилж хорих шахдаг байсан тэр цаг үед Шатарбал гуай олон түмэнд тус хүргэсээр иржээ. Гарын гайхалтай мэдрэмжтэй, хугарсан яс, тасарсан махыг тун сайн эвлүүлж боодог энэ хүн социализмын тэр хүн цаг үед үргэлж нууц байдлаар яс барьдаг байжээ. Хүний яс барихаар явах үедээ Цэдэв гуайг дагуулж явдаг байсан хэрнээ хэзээ ч “ингэж браадаг, тэгж боодог. Хугарсан яс ийм байдаг” гэж хүүдээ зааж зөвлөж байсангүй. Аавынхаа бариа хийхийг багаасаа харж байсан хүү барих илэх сонирхолтой байсан ч аав нь тас хориглож, “Цаг хатуу болж байна. Та нар бүрэн дүүрэн сураагүй байж хүнийг тахир дутуу болгох гэмтэй. Хүний хугарсан яс, тасарсан мах гэдэг тоглоом биш. Хэдий сайн барьсан ч бүрэн эдгэрэхээс нь нааш сэтгэл амардаггүй хэцүү ажил. Тиймээс хүний гар хөл битгий барьж бай” хэмээн захиж байсан гэдэг. Ш.Цэдэв гуай аавынхаа энэ үгэнд орж, бариа хийхээс цааргалж байсан аж. Гэвч түүний аавыг сайн бариач гэдгийг мэдэх нутгийн түмэн гуйж, зарим нь бүүр ам тангараг өгч хугарсан гар, хөлөө барьж өгөхийг шалсаар нэг л мэдэхэд тэрээр бариач нэртэй болж хувирчээ. Үе дамжсан бариач Цэдэв гуай 1970 оноос эхлэн хүний хугарсан гар хөлийн яс эвлүүлж, олон түмэндээ буян болж иржээ. Ургаа мод хөрөөдөж байгаад дарагдаж, хөлөө хоёр ч газар хугалж, яс нь үйрсэн залуугийн ар гэрийнхэн түүн дээр ирж, Цэдэв гуай барьж, хугарсан, цуурсан яснуудыг нь эвлүүлэн боож өгч, тэр залуу удалгүй эдгэрсэн юм гэнэлээ. Хүний гар хөлний далд ясыг хугарсан, цуурсан гэдгийг бариад шууд мэдэх боломжтой юу гэсэн саваагүй асуултанд маань тэрээр “Мэдрэгдэлгүй яахав. Гарын үзүүрээр тэмтрэхэд ясанд ямар өөрчлөлт орсон нь шууд мэдэгдэж байдаг. Хүний мах тасарсан, салсан, судас шөрмөс гэмтсэн эсэх нь ч мэдэгддэг. Яс цуурсан бол хүний махны ширхэг өөрчлөгдсөн байдаг” хэмээн хариулж байсан юм. Хүний гар гэдэг маш их мэдрэмжтэй эрхтэн. Ялангуяа хурууны өндөг гэдэг тун нарийн мэдрэмжтэй байдаг гэнэ. Ш.Цэдэв гуай өнгөрсөн хугацаанд 100 гаруй хүний хугарсан гар, хөлийг эвлүүлж, барьж илж, эмчилж эдгээж олондоо буян үйлджээ. Тэрээр түүнийг зорьж ирсэн хүмүүсийн тухай тэмдэглэл хөтлөж, хэн эдгэрч байна, яаж байна гэдгийг нарийн тэмдэглэдэг байсан ч



сүүлдээ төвөгшөөгөөд тэмдэглэл хөглөхөө байжээ. “Хүн хүнд тус хүргэе гэж бодвол хүргэсэн шиг хүргэх ёстой. Чадахгүй зүйлээрээ оролдох гэмтэй. Хүний ясыг буруу барьвал тэр хүн насаараа эрэмдэг болох аюултай” хэмээн сургамж үгээ хойч үеийнхээ залууст захиж байсан. Түүнийг зорьж ирэх хүмүүсийн тоо өнөөдөр ч буурсангүй. Хөлөө гэмтээсэн босож чадахгүй байгаа хэвтрийн хүмүүс түүнийг залж аваачихаар унаа машин явуулна. Тэр бүрийд цааргалж, дургүйцэж байсан удаа түүнд байхгүй. Олондоо тус хүргэсэн удам дамжсан бариачийн гарын зөөлхөнийг нутгийн олон шагшин ярьцгаадаг. Монголчуудын бариа засал, анаагаах чадюар өнөөдөр гадаадынхны ч анхаарлыг татаж, олон зууны турш өвлөгдөн үлдэж, үе дамжин хадгалагдаж ирсэн энэхүү соёл, уламжлал, увдисыг олон хүн сонирхон судладаг. Гэхдээ гарын үзүүрээр тэмтэрч, хугарсан яс, тасарсан мах, хөндөгдсөн судас шөрмөсийг ч андахгүй сайн мэддэг бариач нарын энэхүү увидас, мэдрэмжийн нууцыг өнөөдөр хэн ч тайлж чадаагүй. Ямартай ч сэтгэл зөвтэй, гартаа шидтэй, басхүү олны төлөө гэсэн чин үнэнч сэтгэлтэй ийм нэгэн сайхан буурал төмөрбулагчууддаа ач тусаа хүргэсээр явна.

## ҮЛ ТАЙЛАГДАХ ЕРТӨНЦ

**Х**үн ертөнцийг өөрчилж, техник технологийн агуу том хувьсгал хийж, сансар ертөнцийг судлаж, шинэ гариг эрхэс нээж, саран дээр очиж, газрын гүнийг ч өрөмдөж, агаар мандлыг шинжилж, хүрээлэн байгаа бүхий л зүйлсийг судлаж чадсан. Харин өөрөө өөрийгөө, хүнд байх агуу тэр хүч чадлыг, хүний оюун ухааныг, увидас чадлыг харин судлаж, нээж, учир утгыг нь тайлбарлаж чадаагүй. Бүрэн дүүрэн нээгдээгүй ертөнц хүмүүн бидний дунд л оршиж байдаг. Гайхалтай сонин хүч чадалтай, басхүү ид шидийн гэмээр увидастай олон арван хүмүүс бидэнтэй мөр зэрэгцэн амьдардаг. Үзсэн хүн харсан зүйлдээ үл итгэмээр, сонссон хүн чихэндээ ч эргэлзмээр адармаатай хачирхалтай зан үйлийн эзэд бидний дунд байсаар л байдаг.



Тэдний нэг нь Дүвчингийн Рагчаа хэмээх хүмүүн. Аараа хувилгаан гэдэг энэ нэр аль социализмын үеэс олны дунд сэм яригдаж, үлгэр домог мэт өгүүлэгдсээр өдгөө цагтай золгосон. Аараа хувилгаан буюу Дүвчингийн Рагчаа хэмээх энэ хүн Төмөрбулаг сумын уугуул. Тэрээр Тариатын эхэнд төржээ. Дөнгөж төрсөн жаахан хүү гараа тас атгаж төрсөн. Гарыг нь нээж үзэхэд алганых нь хонхорхойд чигчий хурууны чинээ улаан ургацаг байсан гэж ээж нь бидэнд хуучилж байсан юм. Эхийнхээ сүүг хөхдөггүй байсан жаахан хүү том болсон хойноо айлд ороод ямар нэг идээ ундаа амсдаггүй, алга болсон эд малыг зүсээр нь нэрлэж, хаана байгааг нь зааж өгдөг, бага байхын их онцгой содон хүүхэд хэмээн яригддаг байж. Тэдний удамд Нойноо лам, Дэндээрээ гүртэн зэрэг арга чаргатай хүмүүс олон байсан гэнэ. Аараа дүвчин гэж нэрлэгдсэн энэ хүн бага наснаасаа нутгаасаа гарч, Хөвсгөлийн хойд сумдаар нутаглаж, хожим Архангай аймагт амьдарч байжээ. Хүүхдэд их сайн хэмээн олон хүн түүнийг биширч хүндэлдэг. Хүүхэд тогтдоггүй айл Аараа хувилгаанаар засал ном хийлгэсэн, тэрээр өвдөж сандаргасан хүүхдийг буудсан. Дахиж өвдөөгүй, одоо том эр болж, Их сургууль төгссөн гэдэг ч яриа бий. Цаг цөвүүн үед шашин номын ажил дэлгэрүүлсэн хэргээр баригдаж, Архангайн шоронд хорьсон боловч шоронгийн үүд хаалганы цоож түгжээ байнга онгойчихоод байж. Тухайн үед айж сандарсан сэргийлэхийн ажилчид “Дахиад гүрэм дором” хийхгүй гэсэн ам тангараг авч суллаж байсан гэдэг. Түүний тухай ам дамжсан яриа бишгүй олон. Зоос үзэж, эрхи татаж, мэрэг төлөг хийдэг энэ хүн сүүтэй цайг үлээж, ус сүү ялгасан гэдэг ам дамжсан яриа хүртэл бий. Хэдийгээр сургуульд сууж, боловсрол эзэмшээгүй ч олонд танигдаж, домог мэт яригдсан ийм нэгэн буурал өдгөө Төмөрбулаг суманд амьдарч байна. Олон жил өөр аймаг сум дамнан амьдарч явсан Д.Рагчаа гуай саяхан нутагтаа ирж, өндөр настай ээжийгээ түшин амьдрахаар төвхнөжээ. Тэрээр Дашдэрчин уулаа тахиж, Тээлийн хүрээгээ байнга хурал ном хурдаг газар болгох санаатай хэмээн ярьж байсан юм.

## ХУВЬ ТАВИЛАНГИЙН ЭЗЭН

Хүн хувь тавиланг бүтээдэг, эсвэл хүний амьдралыг хувь тавилан бүтээдэг үү гэсэн асуултанд хэн ч хариулт өгч чадаагүй. Харин миний хувьд хийсэн ажилдаа эзэн нь болж, амжилтанд хүрч чадсан хүмүүс л өөрөө өөрийнхөө амьдралын зургийг зурж, хувь тавилангийн эзэн нь байж чаддаг гэж боддог юм. Гиймээс ч “Эзэн хичээвэл заяа хичээнэ” гэсэн үгэнд итгэдэг. Хичээнгүй, хөдөлмөрч, зорьсон зүйлээсээ ухарч няцдаггүй нэгэн хүнтэй Төмөрбулаг сумын дөрөвдүгээр багийн нутагт уулзсан юм. Төмөрбулаг сумын анхны мянгат малчин, басхүү Хөвсгөл аймгийн анхны хоёр мянгат малчин Ендонгийн Магсар гуайн гэрийн гадаа очоод л үнэхээр ажилсаг хүмүүс юм даа гэсэн бодол өөрийн эрхгүй төрж байлаа. Гурван мянга гаруй малтай энэ айлын хот хороо цэвэр цэмцгэр гэж жигтэйхэн. Хоёр мянга гаруй хоньтой ч гадаа нь хонины ганц ноос үл харагдана. Хоёр зуу гаруй үхэртэй ч гэрийнх нь гадаа үхрийн баас алга. Бүгдийг нь цэмцийтэл хурааж, түлш болгон хатаахаар овоолж бэлтгэжээ. Төмөрбулаг сумын алдартай малчдын нэг Ё.Магсар гуай 1937 онд Тал булагт нутагтай Дамдингийн Ёндон хэмээх хүний долдугаар хүү болон мэндэлжээ. Түүний төрсөн эцэг их малч, ажилсаг хүн байсан гэдэг. Ё.Магсар гуай 4-р анги төгсөж, 1955 онд Цэргийн хүндэт харуулын тусгай ангид хувиарлагдан очжээ. 1955 онд Хөвсгөл аймгаас 300 цэрэг татагдаж очиход хөдөлгөөний эвсэл сайтай, нуруу өндөр, хөл гар тэгш 17 цэргийг шилж Цэргийн хүндэт харуулын тусгай ангид авч байсны нэг нь Ё.Магсар. Дунд офицер хувцастай, байнга л жагсаалын бэлтгэл хийдэг, цэргийн ерөнхий сургууль хийж, гадаадын зочид төлөөлөгч угтаж, үдэж, работ Ендон хэмээх хүний захиргаан дор гурван жил цэргийн алба хашжээ. Гурван жил цэргийн алба хүндэт харуулд зогссон залуухан эр 1958 онд Түнэлийн амралтын газрыг анх байгуулж, хот руу амралт сувилалын курст сурч, тогоочийн эзэмшээд 1962- оноос гавьяаныхаа амралтанд гартлаа Түнэлийн амралтанд Ерөнхий тогоочоор ажиллажээ. Тэнд ажиллаж байх үедээ Жамьяндагвын Оюунтөгс гэгч танилцаж, гэр бүл болж, 33 жилийг Түнэлийн амралтанд хамтдаа элээсэн гэнэ. Эрэгтэй хүн Ерөнхий тогооч хийх нь бүү хэл орон гэртээ ч хоол унд хийдэггүй шахам байсан тэр үед Ё.Магсар гуай Түнэлийн амралтанд ажиллаж, сайн тогооч хэмээн үнэлэгдэж, Болгарт амарч, Үйлдвэрчний байгууллагын 60 жилийн ойгоор “Алтан гадас” одонгоор шагнуулж явжээ. Тэрээр 1970-аад оны дундуур “Мастер тогооч”-ын болзол хангаж, цолоо авч байсан гэнэ. Магадгүй тэрээр Төмөрбулаг сумаас төрсөн анхны мастер эрэгтэй тогооч ч байж болох юм. Ямартай ч Ё.Магсар гуайг Түнэлийн амралтанд ажиллаж байх үед



тус амралтын газар хоёр жил дараалан ажил үйлсээрээ улсад тэргүүн байранд шалгарч байсан удаатай. тэргүүлж байсан удаатай. Хоолны элдэв амтлагч ховор давс, сонгиноос өөр амтлагч гэхээр зүйлгүй. Нарийн ногоо ч элбэг биш, мах гурил будаа, давс, төмс, байцаа лууван гээд л хоолны ерөнхий орц бүрддэг байсан тэр үед Ё.Магсар гуай амт чанартай, тэжээллэг хоол хийдэг гэдгээрээ олондоо хүндлэгдэж, басхүү амралт сувиллын хоолны жоруудыг өөрөө боловсруулж, дарга даамлуудаас сайшаал шагнал хүртэж явжээ. Түнэлийн амралтын газраас гавьяаныхаа амралтанд гарсан Ерөнхий тогооч маань “Уран дөш” хүүхдийн зусланд ажиллаж байсан гэнэ. Олон жил нийтийн хоолны салбарт ажилласан энэ хүн 1993 онд Төмөрбулаг сумандаа ирж, мал маллаж эхэлжээ. Үнэндээ мал маллана гэдэг түүний хувьд тун амаргүй санагдаж байсан гэдгээ ч тэр нуусангүй. Өвөлдөө амардаг, зундаа хоол цай бэлтгэхээс илүүтэйгээр хүнд хүчир ажил хийж үзээгүй, даарч хөрч яваагүй энэ хүн нэг л өдөр малчин болж, өдөржин хонь мал хариулах их ажилд түүртэж, шантарч байсан ч удаатай. Гэлээ гээд тэр эргэж буцаагүй. Эцэг өвгөдөөс мал маллах ухааныг өвлөсөн аавынхаа захиж хэлсэн, хийж бүтээж явсан бүхнийг цээжиндээ хадгалж үлдсэн учраас төд удалгүй л ээлж наргүй ажилдаа дасаж, мал нь өсөж урамшиж эхэлжээ. Тэрээр мал дээр гараад зургаахан жилийн дараа Төмөрбулаг сумын анхны мянгат малчин болжээ. Ё.Магсар гуай 2000 онд Төмөрбулаг сумын төдийгүй, аймгийн анхны 2000-т малчин болсон юм. Таван зуу гаруй малтай мал дээр гарч байсан Ё.Магсар гуай 2001 онд 3000 мал тоолуулахын зэрэгцээ 14 хүнийг малжуулж, 2006 онд Улсын сайн малчин болжээ. Түүнээс хөрөнгө тасалж авсан 14 айлаас 13 нь өнөөдөр бүгд л малаа өсгөж, сайн сайхан амьдарч яваа хэмээн Ё.Магсар гуай сэтгэл хангалуун ярьж байлаа. Ё.Магсар гуай 2000 гаруй толгой хоньтой. Хонины тоо толгой, адуу, үхрийнхээ тоо толгойгоор Төмөрбулагтаа тэргүүлдэг. Хөвсгөл аймагт хониороо нэгдүгээрт бичигддэг аж. Тэднийг 200 гаруй тоо толгой үхэр, 200 гаруй адуу, 400 гаруй ямаатай энэ хүн Улсын аварга авах үедээ малынхаа тоогоор аймагтаа тэргүүлж байсан түүхтэй. Гэхдээ энэ бүх амжилт түүнд зүгээр олдоогүй. 2000 оны их зуд Ё.Магсар гуайд хатуухан сургамж амсуулж, 150 гаруй үхрийнхээ талыг зуданд өргөчихөөд ч тэр шантраагүй. Харин ч “зуд үзэж байж мал өсдөг, хүн өөрөө ч өлжирждөг юм билээ. Хүн малдаа элэгтэй өөрөө ажилсаг байж гэмээнэ л мал өсдөг” хэмээн Ё.Магсар гуай ярьж байлаа. Хот хүрээ цэвэрлэх гээд нүсэр их ажилд түүртэж үзээгүй энэ хүн 2000 хониныхоо хотыг өдөр бүр цэвэрлэнэ. Өдөр бүр нэг машин хоргол зөөж асгана. Хоёр зуу гаруй үхрийн хэвтрийг цэвэрлэж, бүр хуурай байлгах хэрэг болно. Үүнээс гадна сүү цагаан идээгээ боловсруулна. Энэ бүхий л ажлыг С.Магсар гуай хоёр хүүхдийнхээ хамт амжуулсаар иржээ. Эднийх цагаан идээгээ байнга нийлүүлдэг хүмүүстэй. Гэхдээ л цаг өөр болж, малын ашиг шимийг бүрэн ашиглаж чадахгүй байгаад Мастер тогооч маань жаахан сэтгэл дундуур байдаг гэнэ. Сүүлийн үед өөхөн тосыг хэрэглэдэг хүнгүй болж, ааруулыг заавал чихэртэй л хийх хэрэгтэй болж юм юм өөрчлөгдөж байна даа хэмээн ярьж байлаа. Одоо хоол хийж байна уу хэмээн асуутал “Хийлгүй яахав. Хүүхдүүддээ өөрийн гараар сайхан хоол хийж өгөхийг бодно. Бас цагаан сарынхаа бууз баншийг өөрөө амтална. Хийж сурсан зүйл гэдэг чинь сайхан шүү дээ хүү минь” хэмээн ярьж байлаа. Үнэхээр ч хувь тавилангийн эзэн нь болж чадсан ажилсаг хичээнгүй, хэзээ ч гар хумхин зүгээр суудаггүй, хойч үеийнхэндээ үлгэр дуурайлал болохуйц ийм нэгэн хүнтэй уулзахад сайхан байлаа.

## ГУРВАН КГ ЧУЛУУНЫ ХЭРЭГ БҮЮУ ДОЛОО ДАХЬ ҮЕИЙН ДАРХАН

...Хүмүүний амьдралыг бүхлээр нь багтаасан буурал түүхийн шаргал хуудсуудыг эргүүлж, түүх бүтээж яваа төмөрбулагчуудтай уулзаж явахад алдаа оноо, амжилт бүтээл, басхүү, цөхрөл шаналал, сэтгэл сэмлэж, харуусал дагуулах гунигтай өдрүүдийг ч эргэж харах хэрэгтэй болно. Ийм нэгэн түүх өгүүлсэн хүн бол Бандийн Доржгочоо... Түүний аав нутаг олондоо хүндлэгдсэн уран дархан хүн байжээ. Өөрөөсөө дээшхи таван үеийн дархчуудын талаар сайн мэддэг энэ хүн хүүдээ “Чи бол манай долоо дахь үеийн дархан юм шүү. Манай удамд Лигдэн, Гомбожав гэх мэт зартай дархчууд олон байсан” хэмээн захиж байсан гэнэ. Түүний аав Д. Банди гэж алт мөнгөн эдлэл хийдэг, тун гарын ур, ухааны ур сайтай байжээ. Дархан хүн бурхан ухаантай гэдэг үг бий. Тэрээр эрүүл мэндийн шинжлэх ухааны талаар ямар нэгэн боловсрол эзэмшиж, диплом, сертификат авч байгаагүй. Гэхдээ л нутаг орныхондоо алт, мөнгөн шүд хүртэл хийж өгч байсан байх юм. Д.Банди гуайгаар Бүгдгээний голын нэгэн хүн дөрвөн алтан шүд хийлгэжээ. Шүдтэй болсондоо баярласан тэр хүн ацаг хөлсөнд нь нэг тэмээ өгсөн гэнэ. Гэвч энэ тухай мэдээлэл тэр дороо л хууль хяналтынханд хүрчээ. Сэргийлэхийнхэн Д.Банди гуайг дуудан байцаалт, мэдүүлэг авч

-Чи алтаар шүд хийсэн байна. Алтыг яаж жигнэсэн юм гэхэд тэрээр бүхий л дэнсээ гаргаж ирж үзүүлж, нэг шүдэнд хэдэн грамм алт орсон. Яаж алтаар шүд хийснээ дэлгэрэнгүй ярьж өгчөө. Түүнийг буруутгаж хэрэгт унагахыг оролдож байсан сэргийлэхийн ажилтан

-Хүний шүд хийхэд эрүүл ахуй хэрэгтэй. Энэ шүдийг яаж тааруулж яаж суулгасан юм гэхэд тэрээр шүд тааруулдаг нарийн багаж хэрэгслээ үзүүлж байж хэрэгт оролгүй мултарч байсан гэдэг. Б.Банди дархан 1939 онд Баянтүмэнгийн цэргийн ангид алба хааж байсан түүхтэй. Дайны гал дүрэлзэж байсан халуун өдрүүдэд хил давж 50 гаруй онгоц орж ирлээ гэдэг мэдээ авсан цэргийн дарга нар тушаал өгч, цэргүүд гучхан минутын дотор



хар лакаар бүхий л байшингийн дээврийг будаж, дайснуудын сөнөөгч онгоцнуудын халдлагаас хохиролгүй гарч байсан гэдэг. Халх голын дайны дараа 1000 гаруй цэрэг барилдах үед түрүүлж, Цэргийн заан цол авч байсан Д.Банди гуай хатуу ширүүн амьдралыг туулж гарсан буурлуудын нэг. Гарын уртай, алт мөнгөөр эдлэл хийдгийнхээ төлөө байнга хавчигдаж гадуурхагдаж явсан энэ хүн цэргээс халагдаж ирснийхээ нутаг орондоо иржээ. Төмөрбулагт сүү тосны тасагт ажиллаж сүүгээ машиндаж цөцгий тушаадаг байж. Гэтэл цөцгийний саван дотроос 3 кг орчим жинтэй чулуу гарч ирэн том хэрэг үүсчээ. Б.Банди гуайн аав эсэргүүний хэрэгт холбогдсон, хоёр ах нь ч бас ял шийтгүүлж байсныг мэдэх хүмүүс түүнийг “Нам төрийн бодлогын эсрэг эсэргүү үйлдэл гаргасан” хэмээн буруутгаж, Мөрөн рүү ачиж, 90 хоног хоригджээ. Түүний бүхий л хөрөнгө, алдар цолыг хүртэл хурааж, “Хэргээ хүлээгүй” хэмээн буруутгаж, тулган тасалж, шоронд суулгах шүүхийн тогтоол хүртэл гарсан гэнэ. Гэвч тэр үед хамаатных нь дүү орой тоглож байгаад цөцгий рүү чулуу унагаасан гэдгээ сумын хэсгийн төлөөлөгчид мэдэгдэж, энэ талаархи баримтуудыг аймаг руу хүргэснээр Б.Банди гуайг цагаатгажээ. Харамсалтай нь гурван кг чулуунаас болж бүх өмч хөрөнгөө хураалгасан энэ хүнийг цагаадаж гарч ирснийх дараа орон гэрийг нь буцааж олгосонгүй. Тэрээр Мөрөнгийн артельтай гэрээ хийж, хог дээрээс хөнгөн цагаан, гууль түүж, авдарны 500 цүү цутгаж өгч байж өөрийн гэсэн орон гэртэй болж байсан гашуун түүхийг түүний хүү бидэнтэй хуваалцсан юм. Эгчийнх нь өгсөн ганц мориноос өөр малгүй, цүү цутгаж байж авсан жижиг гэрээс өөр хогшил хөрөнгөгүй энэ хүмүүн өөрийн амьдралаа өөрийнхөө гараар босгож, үр хүүхдээ өсгөж, хүмүүжүүлж, хатуу цаг, хууль хяналтынхны хараан дор дарх хийж, түмэнд тус хүргэж явсаар 71 настайдаа 1993 онд таалал төгсжээ. Аавынхаа намтар түүхийг бидэнтэй хуваалцсан Бандийн Доржгочоо 1966 онд төрсөн. Тэрээр 1985 онд аравдугаар ангид байхдаа аймгийн Идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж явсан удаатай. Аавынхаа гарын урыг өвлөж төрсөн долоодахь үеийн дархан залуу цэргээс халагдаж ирээд мөн л авдарны цүү хийж, нэгдэлд тушааж байсан гэдэг. Тэрээр 300 гаруй цүү хийж тушаасан. Том модон хайрцгаар дүргэж тавьсан цүүнээс төмөрбулагчууд авч авдар саваа бэхлэдэг байсан гэнэ. 1993 онд нэгдэл тарсний дараа аав, ээж хоёрыгоо бурхны оронд хоёрхон сарын зайтай илгээсэн Доржгочоо гурван өнчин дүүгээ тэжээхийн эрхэнд аавынхаа үлдээсэн алх, дөшийг барьж, хувиараа дарх хийж эхэлжээ дарх хийж эхэлжээ. Өдөрт 80 лан мөнгө цуглуулж, эмээл хазаарын мөнгөн тоног урлаж, Баянзүрх, Улаан-Уул руу хийж арилжиж байсан удам дамжсан дархан эр 50 гаруй хазаар, мөнгөн эмээл хийж зарж байсан гэдэг. Өнөөдөр ч түүний хийсэн мөнгөн тоноглолууд Хөвсгөл даяар зартай. Төмөрбулагын Доржгочоо дархны хийц хэмээн яригддаг гэнэ. Гэвч тэрээр эрүүл мэндийн байдлаас болж алх дөшөө хойш тавьжээ. Удам дамжсан дамжсан долоо дахь үеийн уран дархан, хэлмэгдэж, ад үзэгдэж, хавчигдаж гадуурхагдаж явсан Банди дархны хүү өдгөө Тээлийн төвд хувийн бизнес эрхлэн амьдарч байна. Тэрээр эцэг өвгөдийнхөө түүхийг өгүүлэх гурван үе дамжсан дөшийг өдгөө ч гэсэн хадгалж байгаа.

## НУТАГ АМЬТАЙ ХҮН

Төмөрбулаг сумын нутаг, ард түмний амьдралыг хамгийн сайн мэдэх хүн бол Бат-Очирын Ганзориг. Энэ сумын түүхэнд хамгийн олон жил Засаг даргаар ажиллаж байгаа Б.Ганзориг даргын аав Жамьянжавын Бат-Очир Тариат багт 1944 онд төржээ. Тэрээр 1965 онд Холбооны курст явж, сумандаа холбооны эрхлэгчээр ажиллаж байгаад Түнэл сумын ой аж ахуйн ангид нормчин хийж, 1972 онд нутагтаа ирж, Үйлдвэр бригадад ажиллаж эхэлжээ. Бат-Очир гуайн төрсөн ах Ж.Дамдинжав Сумын нарийн бичгийн дарга, бага сургуулийн багш, сумын намын хорооны даргаар ажиллаж байсан, энэ сумын түүхийг бичилцсэн ахмадуудын нэг. Харин Б.Ганзориг даргын ээж Цэрэнгийн Хараамижид гэж сайхан буурлуудын нэг байжээ. Эмээл харганадаж, жин тээж явсан энэ эмэгтэй нэгдэлд бичээчээр ажиллаж байгаад 1969 онд сумын сургуульд тогоочоор ажилд орж, 1991 он хүртэл хорь гаруй жил сургуулийн ахлах тогоочоор ажиллаж байсан гэнэ. Ж.Бат-Очир гуай долоон хүүхэдтэй. Энэхүү хөрөг тэмдэглэлийн маань гол баатар Б.Бат-Очир 1967 онд төржээ. Тэрээр 1985 онд аравдугаар ангиа төгсөж, тухайн үеийн ЗХУ-д Цэргийн дээд сургуулийн Командын ангид сурах хуваарь авч байж. Гадаадад цэргийн дээд сургуульд сурах хүүхдүүдийг 9-р ангид байхаас нь шалгаруулдаг, орон гэр, хүмүүжил сахилга бат, нийгмийн идэвхи, сурлаг гээд олон шалгуур тавьдаг байсан үед 1985 онд Хөвсгөл аймгаас нийт 7 хүүхэд шалгарч байсны нэг нь Б.Ганзориг. Гэвч Улаанбаатар хотод очиж, цэргийн бэлтгэл хийх үед түүнийг эрүүл мэндээр тэнцэхгүй, нүдний хараа муу хэмээн орос руу Цэргийн дээд сургуульд явах хүмүүсийн жагсаалтаас хасч орхих нь тэр. Үнэндээ сайд дарга нар өөрсдийнхөө хүүхдийг явуулахаар ар өврийн хаалга хэрэглэж, хөдөө сумаас ирсэн, араас нь хэл ам хийх ах дүү байхгүй хэмээн зөөлчилж, түүнийг шалтаг заан хассан гэдгийг Ганзориг хүү мэдэж байсан ч ямар нэг хэл ам хийсэнгүй. Хамгийн сонирхолтой нь хараа муу байна хэмээн цэргийн сургуулиас хассан хэрнээ түүнийг хараа сайн байна хэмээн Ардын армийн 107-р ангид цэргийн алба хаалгахаар явуулжээ. Тэрээр Улаанбаатар хотод 107-р ангид очин жолооч болж Зүүн баянгийн 0132-р ангид байлдагч болж, цэргийн прокурорт жолоочоор ажиллах болжээ. Хээрийн цэргийн прокурор онцгой нөхцөлд ажилладаг, шүүн таслах үйл ажиллагаа явуулдаг, цэргийн анги нэгтгэл дээр очин шүүх хурал хийдэг, цэргээс оргосон зодоон цохион хийсэн цэргүүдийн асуудлыг хэлэлцдэг том байгууллага. Ийм л газарт тэр сардаа 1000 литр шатахууны нормтой жолоочийн ажил хийж, Дорноговь, Сүхбаатар гээд зүүн аймгуудыг тойрон цэргийн бүхий л анги нэгтгэлүүд дээр очиж байжээ. Энд өнгөрөөсөн цэргийн гурван жил түүнд хууль тогтоомж гэж ямар байдгийг хүн ёс зүй, хууль эрх зүйн хэм хэмжээг яаж баримтлах ёстой юм бэ гэдгийг сайн ойлгуулж өгсөн хэрэг. Б.Ганзориг 1988 онд цэргээс халагдаж, төрлөх сумандаа ирж, сумын төвийг хариуцсан байгаль хамгаалагчаар ажиллаж эхэлжээ. Үнэндээ цэргээс ирсэн залууд хийх ажил олдохгүй хүний оронд



түр хугацаагаар ажиллах боломж олдож байсан хэрэг. Тэрээр байгаль хамгаалагч хийж, сумын цаг уурт ажиллаж байхдаа элсэлтийн шалгалтанд бэлтгэж эхэлжээ. Хөдөө аж ахуйн дээд сургуульд сурч, сумандаа ажиллах хүсэлтэй залуу 1989 онд дөрвөн газрын тодорхойлолт авч, шалгалт өгөх эрхээ олж авсан гэнэ. Гэвч тэр жил Хөдөө аж ахуйн дээд сургуулийн хувиар ирсэнгүй. Хими, биологийн хичээлээр элсэлтийн шалгалтанд

бэлтгэсэн залуу нэг бол анагаахад орох, эсвэл биологийн багш болох хоёр замын нэгийг сонгох хэрэгтэй болж. Тэрээр ээргэлзэж тээнэгэлзэлгүйгээр Ховдын багшийн дээд сургуулийн биологи, газар зүйн багшийн ангийг сонгожээ. Өмнө нь цэрэгт яваад ирсэн, бас ажиллаж байсан “хөгшин” оюутан ангийн даргаар сонгогдож, хээрийн дадлагат ангийнхнаа удирдаж, Тува, Увсын Хяргас руу хүртэл дадлага хийж байсан гэнэ. Хүсэл мөрөөдөл, хайр, итгэл, сурч мэдэх асар их тэмүүлээр дүүрэн оюутны он цагууд түүний амьдралд арилшгүй мөрөө тодоос тод үлдээж, сайхан дурсамжуудыг сэтгэлд нь шигтгэж өгсөн гэхэд болно. Дотуур байранд цуг амьдарсаар нэгэн эцэг эхийн хүүхдүүд, төрсөн ах дүү шиг л элгэмсэн дассан хөөрүү дэвэргэн залуучууд өрөөнийхөө ханыг сэтгүүлийн зургаар чимэглэнэ. Хэн гоё зураг ханан дээрээ олж хадна, тэр хамгийн гоё байранд амьдарна... Нэг удаа үеийн хөвгүүд сэтгүүлийн зураг хайчлан хаалган дээрээ наажээ. Дэггүй нэг нь “Энэ бүсгүйн уруул их гоё юм байна” хэмээн дуу алдаж, өнөөх зургаа дахин хайчлан уруулын зургийг нааж, нэг тасгийн хөвгүүд өөр, өөрсдийнхөө төсөөллөөр тэр зургийг нэмж зуржээ. Гэвч тэдний тасагт орж ирсэн хүн бүр

-Холбооны охинтой ямар адилхан зураг бэ?

-Энэ бүсгүй чинь холбоонд ажилладаг билүү? хэмээн асуух нь залуухан оюутны сэтгэлийг хөвсөлзүүлж орхих нь тэр. Өөрсдийнхөө төсөөллөөр зурсан тэр зурагтай усны дусал шиг ижилхэн бүсгүйг харахаар холбооны салбар руу очиж, тэнд Б.Ганзориг заяаныхаа ханьтай учирчээ. Монгол улс зах зээлд шилжээд удаагүй тэр цагт Ховдод амьдардаг найзуудынхаа аав ээжийг ятган бэр гуйлгуулж, залуу хосууд 1992 онд анхныхаа хүүхдийг өлгийдөж авч байж. Ховдын Багшийн дээд сургуулийг тэрээр 1994 онд төгсжээ. Хот хүрээ газар чиглэсэн их нүүдэл өрнөж, залуучууд арилжаа наймаа хийхээр ганзага үүрэн хилийн дээс алхаж, бүгд л Улаанбаатар



руу хошуурч байх үед Б.Ганзориг энэ их нүүдлийг сөрж, эхнэр хүүхдээ дагуулан нутагтаа ирсэн. 1995 оноос байрны багш хийж, одоогийн 5-р багийн даргаар ажиллаж, Жаргал суманд найз нартайгаа нийлж, гар урлалын бүтээгдэхүүн, гэрийн мод тавилга хийж байжээ. Монголын улс төр, бизнесийн ертөнцөд “Барууны бүлэг” гэж нэрлэгддэг Ховдын багшийн дээд сургуулийн төгсөгчид том, том компани байгуулж, улс төрд ч амжилт олж чадсан. Тиймээс ч найзууд нь дуудаж, хотод ирэх, хамтран бизнес хийх янз бүрийн санал тавьж байсан ч тэрээр нутаг усаа сахин үлдэхийг чухалчилсан гэдэг. Түүнийг 2000 онд Ховдод хадамчилж явах хойгуур УИХ-ын сонгуульд МАН-аас нэр дэвшсэн УИХ-ын гишүүн Цэрэнжавын менежерээр томилсон гэдэг мэдээ ирж, сонгуулийн ажилдаа яаралтай орох хэрэгтэйг сануулжээ. Эндээс л түүний улс төрийн амьдрал эхэлсэн гэхэд болно. Б.Ганзориг УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийн менежерээр ажиллаж, намар нь орон нутгийн сонгуульд нэр дэвшиж, Их эмч Мэнджаргалтай өрсөлдөн, сумын 5-р тойрогт ялалт байгуулж Засаг даргаар томилогджээ. Төмөрбулаг сумын засаг даргаар тэр 2004 онд улиран сонгогдож ажилласан юм. 2008 оны сонгуулийн дараа түүнийг Жаргал сумын сургуулийн захирлаар томилжээ. Гэвч тэрээр Жаргал суманд удаан ажилласангүй, 1200 гаруй хүүхэдтэй, 100 гаруй багш ажилчидтай том сургуулийн захирлын ажлыг өөрийнхөө хүсэлтээр өгчээ. Мөн 2011 онд Төрийн албаны шалгалтанд орж, том өрсөлдөөн дундаас гарч ирж, Аймгийн мэргэжлийн хяналтын дэд дарга болсон. Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л байгууллагад хяналт шалгалт хийх эрхтэй, төрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг энэ том албыг тэрээр Төмөрбулаг сумын Засаг дарга гэсэн ажлаар эргэлзэх юмгүйгээр сольж орхисон. Учир нь түүнийг Мэргэжлийн хяналтын орлогч дарга байх үед буюу 2012 онд Төмөрбулаг сумын ИТХ-ынхан сумандаа ирж ажиллахыг санал болгосон хэрэг. Мэргэжлийн хяналтын орлогч даргын ажлаа сумын Засаг даргын ажлаар солих гэж байгааг нь сонссон найз нөхөд, хамтран ажиллагсад нь түүний тэнэгийг гайхаж байсан ч тэрээр нутаг руугаа ирсэн. Б.Ганзориг 2008-2010 онд аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчөөр сонгогдож байсан. Мөн Сумын ИТХ-ын төлөөлөгчөөр хоёр удаагаа сонгогдсон. Түүнийг Засаг дарга байх үед Төмөрбулаг сум өндөр хүчдлийн шугамд холбогдож, хоёр давхар шинэ эмэнэлэг, сургуулийн спорт заал шинээр баригдаж, сургууль, дотуур байранд их засвар хийгдэж, сумын төвийн гэрэлтүүлгийн ажил шийдэгдэж, шинэ Соёлын төв сууриа тавьж бүтээн байгуулалтын олон ажлууд өрнөсөн. Төмөрбулагчуудын амьдралыг гарын таван хуруу шигээ мэдэх ийм л нэгэн хүн Төмөрбулаг сумын Засаг даргаар гурав дахь удаагаа сонгогдон ажиллаж байна. Үнэндээ Засаг дарга гэдэг нэргүй зарцын ажил байдаг гэнэ. Бүхий л санал гомдол, бүхий л хүсэлт Засаг даргын нэр дээр ирнэ. Тэр бүхнийг зохицуулах шаардлагатай болно. Шагнал урамшуулал, сайшаал магтаалаас эхлээд ял шийтгэлтэй холбоотой асуудлууд байнга урган гарна. Намайг Б.Ганзориг даргатай ярилцаж суухад үүд байн, байн онголзуулсаар нэгэн залуу орж ирээд гартаа барьсан цаасыг зориг муутайхан ширээн дээр нь тавиад толгойгоо илээд зогсчихлоо.

-Чи яагаад архи уугаад байдаг юм. Дахиж архи уухгүй биз дээ. Би

эхнэрийг чинь дуудаад ирж болно. Дахиад бүсгүй хүн зовоож зодож нүдвэл хэн хариуцлагыг нь хүлээх юм бэ. Сайн бод. Архинаас хол бай... Тэдний хооронд ийм учир битүүлэг яриа өрнөж, Б.Ганзориг дарга хүүтэйгээ, дүүтэйгээ ярилцаж байгаа юм шиг өнөөх залууд баахан учирлав. Тэр залуу ч архи уухгүй гэж ам тангараг өргөсөөр Засаг даргын өрөөнөөс хөлсөө арчсаар гарлаа.

-Энэ юун хүн бэ хэмээн сониучирхан асуувал Б.Ганзориг дарга

-Уг нь сайн залуу байгаа юм. Архи уухаараа болдоггүй нөхөр. Мань эр агсам тавиад, эхнэр нь сална гээд төрхөмдөө буцсан байна. Туслаач гэж өргөдөл бичжээ гээд санаа алдав.

-Та тэгээд салсан эхнэрийг нь яаж авчирах юм гэвэл

-Эгч нь манай тамгын газарт ажилладаг юм. Эгчтэй нь уулзахаас...

Болохгүй бол өөрөө очиж уулзаж ярилцаж үзнэ дээ гээд инээд алдах...Б.Ганзориг даргын сэтгэлийг хамгийн их чилээдэг зүйл бол ажлын байр. Жилд 30 гаруй залуучууд сургууль төгсөж, мэргэжил боловсрол эзэмшиж төрж өссөн нутагтаа ирдэг ч гэсэн ажлын байр ганц хоёрхон л гардаг гэнэ. Хүн болгоныг ажилтай болгох юмсан, сум орон нутагтаа сайхан ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлэх юмсан гэсэн бодол байвч гачаал их. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах гээд тэрээр олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байгаа ч хүн бүрийн амьдралд тус нэмэр болж чадахгүй байна хэмээн бухимдаж байсан юм. Ургаа модоо хэмнэх гамнах, байгаль орчноо хамгаалж үлдэхийн тулд нэгдсэн халаалттай болох, айл өрхүүдийг нүүрсний хэрэглээнд сургах гээд том, том хөрөнгө мөнгө шаардсан ажлууд Төмөрбулаг сумынхны хувьд хамгийн түрүүнд шийдвэрлэх асуудал болж хувирч байгааг ч тэр өгүүлж байлаа. Харамсалтай нь Засаг даргын хүч хүрэхгүй олон асуудал бий. Намайг тус суманд ажиллаж байхад сумын Засаг даргыг бухимдуулсан нэгэн том асуудал мандав. Цагтаа сум орон нутгийнхаа нэрийг өндөрт мандуулж явсан нэгэн ахмад одоо ядруухан амьдарч байгаа аж. Түүний бага охиныг үйлчлэгчийн ажилд ав хэмээн нэгэн байгууллагын дарга бүсгүйг ятгаж, өнөөх нь “Хэнийг ажилд авахаа би мэднэ” хэмээн зөрүүдлэх. Аргаа барсан Засаг дарга “Хэн ядруу байгаадаа бид туслах ёстой. Тэдний гэрт очсон. Хоол унд муутай тав, зургаан жаал нүдээ бүлтэлзүүлээд сууж байна шүү дээ” хэмээн өнөөх дарга бүсгүйг аргадаж, гуйж байж арай гэж нааштай хариу сонсоод сэтгэл нь амрав боллоотой. Арав гаруй жил энэ сумын засаг даргаар ажиллаж, бүхий л амьдралаа сум орон нутагтаагаа холбосон учраас тэрээр хэн нь хэн бэ гэдгийг, хэн яаж амьдарч, ямаршуухан явааг сайн мэднэ. Тиймээс ч олон хүн түүнийг Төмөрбулагын Ганзориг хэмээн нэрлэж, Бат-Очир гэх аавынх нь нэр зөвхөн албан бичг баримт дээр л тодоос тод үлджээ. Нутаг орноо гэх халуун дулаан сэтгэлтэй, элдэв хээцэрлэл, чимэг маягнаас ангид, хээ шаагүй монгол араншингаа гээж үлдээгүй ийм л нэг хүн өнөөдөр төрсөн нутагтаа ажиллаж амьдарч байна. Тиймээ. Төмөрбулагын Ганзориг Төмөрбулагтаа л байгаа.

## ХОЁР УДАА ТАНГАРАГ ӨРГӨСӨН ЭМЧ

Одоогоос хоёр жилийн өмнө Төмөрбулаг суманд нэгэн бүлийн ах дүү нар цуглаж, ургийн баяр хийжээ. Энэ баярт 250 гаруй хүн оролцсон байх юм. Зөвхөн Чойжоо хэмээх хүний үр ач ах дүүс гэхэд л 150 гаруй хүн цуглаж олныг гайхшруулж байсан удаатай. Ах дүү олуулаа, өнөр өтгөн энэ хүмүүсийн төлөөлөл болгон Чойжоогийн Цэцэгмаа эмчийг “Түүх бүтээсэн 90 жил” номынхоо хойморт урин ярилцлаа. Ч.Цэцэгмаа эмч 1959 онд төржээ. Аливаа юманд авахаалжтай, байнга л олон нийтийн ажилд оролцож явдаг, сурлагаар ч сайн жаахан охин олон хүүхэд төрүүлсэн, байн байн ухаан алдаж унадаг ээжийгээ эмчилнэ, үүний төлөө заавал эмч болно хэмээн өөрөө өөртөө амлаж байсан гэдэг. Тэрээр санасандаа хүрч, 1983 онд Анагаах Ухааны Их сургуулийн хүүхдийн эмчилгээний анги төгссөн. Эмчийн ёс зүй, төрийн хуулийг чандлан сахиж, эрдэнэт хүний амь нас, эрүүл мэндийн төлөө, эрдэм чадал, энэрэх сэтгэлээ харамгүй зориулахаа тангарагласан цэл залуухан эмч 1983 онд Сэлэнгэ аймгийн Түнхэл дэхь Ардын армийн 072-р ангид эмнэлгийн албаны даргаар томилогдож очжээ. Хүн зоны эрүүл мэндийг хамгаалж явахаа тангарагласан залуу эмч Сэлэнгэ аймагт очоод дэслэгч цолтойгоор эх орноо хамгаалах тангараг өргөсөн. Үнэндээ цэргийн том анги нэгтгэлд ажиллах гэдэг амар байсангүй. Тэрээр цэргийн хувцас өмсөж, ёсолж сурах гэж бүтэн гурван сарын турш орой бүр гэртээ бэлтгэл хийдэг байжээ. Тариа ч хийж үзээгүй шахам шинэхэн эмчийг ажлаа хүлээж аваад удаагүй байхад барилга дээрээс унаж хүнд гэмтсэн цэрэг эмнэлэгт хүргэгдэн иржээ. Тархиндаа гэмтэл авч, 7-8 хавирга, дунд чөмөг нь хугарсан. Нуруу нугас нь тасарсан, маш олон ясны хугаралтай цэргийг харсан эмч бүсгүй ганц тариа хийгээд л номоо уншдаг, нэг эм уулгаад л номоо шагайж харан яахаа мэдэхгүй сандарчээ. Сувилагч байхгүй, хүнд өвчтөнтэй, сандарсан бүсгүй “Баахан орос эмч нар гол дээр загас барих гээд ирсэн” байна гэж сонсоод тэднээс тусламж хүсэн очиж байсан гэдэг. “Хүний л амь аврах хэрэгтэй” гэдэг ганцхан бодолд хөтлөгдсөн залуу эмч хэн нэгнээс




айж, бас ичиж нэрэлэхсэн ч үгүй. Үнэхээр ч Сайд нарын 2-р эмнэлгийн эмч нар амралтаараа загас барьж явсантай таарчээ. Орос эмч нар гэмтэл авсан залууд анхны тусламж үзүүлж, сувилагч бүү хэл шарх боох вент ч үгүй шахам байсан залуухан бүсгүйг хараад өхөөрдөж, “Чи эмч биш. Чи сувилагч” хэмээн шоолж байсан гэдэг. Үнэндээ Түнхэлийн цэргийн анги Цэцэгмаа гэдэг хүнийг эмч болгосон. Тэнд хууль дүрэм мөрдөж, захирч, захирагдаж, нойр хоолгүй явж, бас хүнд нөхцөлд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж сурсан хэмээн тэрээр ярьж байсан юм. Түнхэлийн 072-р анги аж ахуйн анги байсан учраас осол гэмтэл их гардаг, тэр бүрийг эмчилж эдгээх үүрэг хүлээдэг байж. Гэтэл удалгүй дээд газрын шийдвэрээр цэргийн анги нь Сахилгажуулах баталионд болон өргөжээ. БХЯ, Ардын арми, Хилийн цэрэг, Барилгын цэрэгт татагдаж очсон, оргосон, зодсон, зодуулсан олон цэргийг Сахилгажуулах баталионд авчирна. Эндээс тэр оношилгооны тун сайн эмч болжээ. Элдэв өвчин гачигдал зовлон ярьсан цэргүүдийг хүлээж авч, оношилж, баашилж байна уу, бие нь өвдөж байна уу гэдгийг нэг бүрчлэн тогтоох гэдэг амаргүй ажил. Гэхдээ л тэр энэ бүхнийг нэр төртэйгээр гүйцэтгэж ирсэн юм. Ч.Цэцэгмаа эмч 1987-1989 онд Орхон аймгийн АА-н 208-р ангид эмнэлгийн албаны даргаар ахлах дэслэгч цолтой томилогдож очжээ. АА-н 208-р анги 1000 гаруй цэрэгтэй, найман баталионтой 160 гаруй офицертэй том газар. Ийм л том ангийн эмнэлэгийн албыг тэрээр 28 настайдаа удирдаж байсан юм. Цэргийн албанд өнгөрүүлсэн он жилүүд түүнд асар их тэвчээр, хатуужил басхүү мэргэжлийн ур чадвар олгосон хэмээн тэрээр бахархан ярьж байсан юм. Зах зээл эхлэхийн өмнө 1989 цэргийн анги нэгтгэлүүд дээр цомхтгол болох үед Ч.Цэцэгмаа эмч өөрийнхөө хүсэлтээр ажлаа өгчээ. Цэргийн ангийг хувийн бизнес болгон харж байсан эрх мэдэл бүхий генералтай ажиллах нь түүнд таалагдаагүй учраас ажлаасаа гарах шийдвэр гаргасан хэрэг. Ажлаасаа гарах өргөдлөө өгчихөөд 1994 онд Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмчээр ажиллаж эхэлжээ. Энэ газраас шинжилгээ, хийх халдвартай хүмүүстэй харьцах, эмнэлэг эрүүл мэндийн байгууллагын нарийн нягт байдлыг эзэмшиж авсан гэдэг. Гэвч 1995 онд түүнийг Орхон аймгийн Нэгдсэн эмнэлэгт шүүх эмнэлэг эмгэг судлалын тасгийн эрхлэгчээр томилжээ. Шүүхийн шинжилгээ хийнэ гэдэг амар биш, хүнд хэцүү ажил. Тэрээр энэ байгууллагад ажиллаж байхдаа 150 гаруй хүнд эмгэг анотомийн шинжилгээ хийж байсан байх юм. Амьд хүний өвчний онош тогтоох, үхсэн хүний амь насаа алдсан шалтгааныг судлаж гаргаж ирнэ гэдэг амаргүй. Шүүх эмнэлэгт ажиллахдаа тэрээр хүний биеийн бүтэц, анотомии, амьд байх үе, нас барсны дараах үеийн өөрчлөлтүүд гээд асар их мэдлэг туршлага хуримтлуулсан. Бас хүний амьдрал ганцхан үгээр тодорхойлогдож, хувь заяа нь хаашаа ч эргэж болдгийг тэр яс махандаа шингэтэл ойлгосон. Хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон хэрэгт шүүх эмнэлэгийн дүгнэлт чухал. Тиймээс хүн чанар зөв шударга байх тэр л арга барилыг Ч.Цэцэгмаа эмч тэндээс олж авсан. Хэргээ замхруулах гэсэн гэмт этгээд тор дүүрэн мөнгө барьж ирээд түүний өрөөнөөс хөөгдөөд гарч байсан ч түүх бий. Эрх мэдлээрээ шударга ёсыг худалдаж авахыг санаарахсан дарга нарын шахалтанд орж, бүлэг хэрэг илрүүлснийхээ төлөө

хуулийнханд хүртэл дарамтлуулж, хөөгдөж, зугатааж ч явсан удаатай. Гэвч нэг л өдөр нас өндөр болсон ээж аав нь төрж өссөн нутагтаа ирж ажиллах “үүрэг” өгч, тэрээр нутагтаа иржээ. Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын дарга түүнд гурван ажил санал болгож, Ч.Цэцэгмаа эмч халдвар судлалын эмч, улсын байцаагчаар ажиллах шийдвэр гаргажээ. Үнэндээ тэрээр хүн эмчилдэг биш торгодог эмчийн ажил сонгож байгаагаар сайн мэдээгүй хэрэг. Халдвар судлалын эмч, улсын байцаагч сард доод тал нь 500 мянган төгрөгийн торгууль тавих ёстой. Гэтэл тэрээр дөнгөж 20,000 төгрөгийн орлого оруулсан хэмээн зэмлүүлж, цалингаа хүртэл хасуулж байсан. Сахуугийн 27 голомтонд ажиллаж сахуу өвчинг тасалан зогсоож, аймгийн Сүрьеэгийн эмнэлэгт үүрлэсэн жоом устгасан явсан ч торгуулийн норм биелүүлээгүй гэдэг муу нэртэй. Нэг удаа Могойн голын ажилтны хүүхэд шарын ком болсон байхтай таарч хаяад явж чадалгүй эмчилгээ хийснийхээ төлөө машин унаж зугаалсан хэмээн буруутгагдаж, бас л цалин мөнгөө хасуулах гэж байхад нь Төмөрбулаг сумын дарга Шарбанди таарч нутагтаа ирж ажиллахыг санал болгожээ. Ийнхүү Ч.Цэцэгмаа эмч 2006 оноос одоог хүртэл Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн даргаар ажиллаж байна. Тухайн үед ажлаараа аймагтаа 22 дугаар байранд ордог байсан Төмөрбулаг сумын эмнэлэг өнөөдөр эхний наймдугаар байранд тасралтгүй ордог, 2004 онд л гэхэд аймгийн шилдэг эмнэлэг болж байжээ. Анх түүнийг ирж байхад жилд 750 алсын дуудлагатай байдаг байсан бол энэ тоо хочр дахин буурчээ. Гэрийн төрөлтийг үгүй болгож чадсан учраас сүүлийн 14 жил эхийн эндэгдэл гараагүй гээд олон баримт бий. Эмч болно, ээжийгээ эмчилнэ гэж мөрөөдөж байсан охин мөрөөдлөө биелүүлжээ. Тэрээр дан ганц ээжийгээ ч биш их олон хүний амийг аварсан алтан гартай эмч болж чадсан юм. 2004-2008 онд аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байсан Ч.Цэцэгмаа эмч Сумын Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн гэсэн албатай. Ч.Цэцэгмаа эмч “Миний оншилгоо эмчилгээнээс болж ямар нэг гомдол гарч байгаагүй. Би хэн нэгнийг хохироож, онош зөрүүлж гомдоож яваагүй. Манай ганц малгүй. Гэхдээ олон түмнийхээ буянаар юугаарч дутаагүй” хэмээн ам бардам ярьж байсан. Ажилласан газар болгоноосоо анагаах ухааны асар их туршлага мэдлэг хуримтлуулж, байнга сурч мэдэж, сурсан мэдснээ олондоо түгээхийг эрмэлздэг энэ хүн эх орондоо өргөсөн хоёр тангарагтаа насаараа үнэнч яваа.

## ТАШУУР БАРЬСАН ДАРГА

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын түүхэнд Паньджунай гэдэг энэ нэр яалт ч үгүй дээр бичигдэнэ. Тэрээр Бүгсийн хүрээнд шавилан сууж, түвд бичиг үсэг үзсэн лам хүн байжээ. Гэвч хожим олны жишгээр хар болж, мал маллаж, Тариатын аманд “Шинэ-Оч” нэгдлийг байгуулж явсан нэгдлийн анхны гишүүдийн нэг. Ан гөрөө хийдэг, мод чулуугаар юм урладаг, амьдралын ухаантай, асар их хөдөлмөрч энэ хүний нэр алдрыг хөвгүүд нь өргөж өгч, өөд нь мандуулсан, басхүү Төмөрбулаг сумын түүхийн хуудсанд бататгаж үлдээжээ. Паньджунай гуай дөрвөн хүүтэй. Түүний хүү Паньджунай Лунхаан аймгийн дөрвөн удаагийн аварга малчин, Намын их хурлын төлөөлөгч, АИХ-депутатаар хоёр удаа сонгогдож байжээ. Тэгвэл Паньджунай Цагаач Улсын хошой аварга, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, харин хүү Паньджунай Банзрагч сумын бригадын дарга, орлогч даргын албыг олон жил хашиж, сум орон нутагтаа багагүй зүйл хийж бүтээсэн хөөдлөрч хүн. Энэ удаа бид Паньджунай Банзрагчийг онцлон танилцуулж байна. П.Банзрагч Паньджунай гуайн бага хүү болон 1942 онд төржээ. Цэрэгт алба хашиж, 1000 гаруй цэргээс анхны орон нутгийн чөлөөгөөр шагнагдаж, онгоцоор нутагтаа ирж, ээжийгээ сандаргаж байсан энэ хүн Барилгын арматорчин, өрлөгчин, шаварчин гэсэн мэргэжил эзэмшиж цэргээс ирээд бригадын аж ахуй, сэлбэгийн нярав хийж байжээ. Тэрээр 1975 онд Хөдөө аж ахуйн дээд сургуулийн зургаан сарын курст сураад нутагтаа иржээ. Тухайн үед Тээл бригад Бүрэнтогтох сумаас тасарч, Төмөрбулаг сумтай нийлээд ирээд удаагүй байсан үе. Номын дуу сонсоод удаагүй залууг сумын удирдлагууд Тээл бригадын даргаар томилох шийдвэр гаргажээ. П.Банзрагчийг ажлаа хүлээж аваад гурван сар ч болоогүй байхад жилийн ажил дүгнэж, түүний хариуцсан бригад ажил үйлсээрээ хамгийн сүүлийн байранд оржээ. Сумын удирдлагууд Тээл бригадын залуу даргыг индэр дээр дуудаж авчиргаад гарт нь том хар ташуур бариулж байсан гэдэг. “Би энэ бригадын даргаар гурван сар ч ажиллаж амжаагүй байна” хэмээн учир байдлаа хэлэх гэтэл ямар ч тайлбар сонсохыг тэд хүссэнгүй. Том хар ташуур бариад, олны дунд нүүрээ улалзуулан зогсохдоо залуугийн хор шар буцалж, “Би энэ ташуураар ташуурдахад урагш явж л таараа” хэмээн бодож зогссон гэдэг. Үнэндээ удалгүй Тээл бригад ажил үйлсээрээ сумынхнаа манлайлж



эхэлжээ. П.Банзрагч гадны сум орон нутгийнхны мал төлүүлэх туршлага судлаж, Тээл бригад гэхэд л 40 гаруй хашаа барьжээ. Сумын нийт цэцгийн төлөвлөгөөний 80 орчим хувийг бэлтгэдэг, хүн ам ч олонтой, таваарлаг сайн малтай том бригадын даргаар найман жил ажиллаж, шилжин явах туг авч, шагнагдаж, сайшаагдаж явсан гэдэг. Сумын тэргүүний бригад болсныхоо дараа тэр “Би тэр ташуурыг ямар ч



байсан хөдөлгөж чадсан л юм байна” хэмээн цээж тэнэгэр бодож суусан гэдэг. Тэрээр сум орон нутгийнхаа төлөө хичээнгүйлэн зүтгэж, малын хашаа саравч барьж, поошигон услууруу хийж, “Захиргааддаг Банзрагч” гэдэг нэртэй болтлоо зүтгэсэн. Гэвч нэг өдөр түүнийг аймгийн МАХН-ын хорооноос дуудуулжээ. Аймгийн намын хорооны дарга дээр ортол намын хорооны товчооны гишүүд цуглачихсан байж. Тэд “Сайн ажиллаж байгаа. Мал аж ахуй дээр ажиллах туршлагатай нөхөр Банзрагчийг Төмөрбулаг сумын нэгдлийн орлогч даргаар томилохоор шийдвэрлэсэнээ танилцуулж. “Үгүй чадахгүй” гэтэл “Тэгвэл Чандмань-Өндөр эсвэл Рашаант сум руу явж ажил” гэдэг шахалт үзүүлж, сандаргажээ. Ингэж л тэрээр “Давшилт” нэгдлийн орлогч даргын ажлыг Базарраднаа гэгч хүнээс хүлээж авч байсан гэнэ. Сумын орлогч дарга гэдэг дөрвөн баг, үйлдвэр бригад, халуун ус, сургууль, цэцэрлэгээс эхлээд бүхий л ажлыг хариуцаж ажиллах ярвигтай хүнд ажилд томилогдон ачааны хүндийг үүрэлцэж явсан нэгэн. “Давшилт нэгдлийн төвд 50 тоннын тэжээлийн чулуун агуулах барьж, хашаа саравч бариулж, багагүй зүйл хийсэн. Гэвч сумын орлогч даргаар хоёр жил гаруй ажиллаад өөрөө халагдах өргөдлөө бичиж байжээ. Тухайн үед нэгдлийн дарга байсан Мижиддорж түүний хүсэлтийг хүлээн авч, хоёрдугаар бригадын даргаар томилжээ. Хоёрдугаар баг ямааны үржлийн фермтэй, гаднаас ирэх зочид төөлөгч, сэтгүүлч, туршлага судлах хүмүүсийн хөлд дарагдсан том газрыг удирдахаар 1989 онд очжээ. Гэвч удалгүй нэгдэл задарч, өмч хувьчлал эхэлсэн байна. Тэртээ 1991 оны 12 сард Төмөрбулаг сумын захиргаа, багуудын дарга нарын өрөөний үүдэнд элдэв зураг хөрөг нааж, “Хүнд сурталтангуудыг устга” гэсэн бичиг хадаж, Үржлийн улсын фермийн ямааг тарааж хувьчил хэмээн шаардаж эхэлжээ. Өмнө нь П.Банзрагч даргаа гээд гүйж явсан залуучууд том том хавтас сугавчлан өрөөнд нь дайрч орж ирж, “Засгийн эрх шилжээд байхад та өрөөндөө суугаад байна. Цаана чинь төв хороо хүртэл бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсныг мэдэж байгаа биз дээ” хэмээн эсэргүүцэж эхэлж. П.Банзрагч “Улсын хөрөнгө оруулалтаар

бий болсон хоёрдугаар багийн төв, байшин барилга, Эрчмийн хар ямаа, торгон сүргийг хувьчлахгүй” хэмээн зүтгэж олон сар хэрэлдэж, хэлэлцэж явсны эцэст ажлаа өгчээ. Энэ цагаас хойш хувиараа мал маллаж ногоо тарьж, үр хүүхдээ тойруулан амьдарч сууна. Түүний гэргий Шагдарын Авид мөн л Төмөрбулаг сумын уугуул. П.Банзрагчийнх гэдэг айл есөн хүүхэдтэй. Ач гуч нийлсэн 50 гаруй хүүхэд өнөөдөр П.Банзрагч гуайг “Өвөө” гэж дуудаг. Сум орондоо гайхагдсан ажилсаг энэ хүний хүүхдүүд “Аймгийн сайн малчин”, “Сумын сайн малчин”, сумын “аварга тогооч” болж, Б.Отгонбаяр, Б.Дашдондог хоёр мянгат малчны болзол хангажээ. П.Банзрагч гуай Сумын заан цолтой. Тэрээр Төмөрбулаг усманд хоёр түрүүлж, хоёр үзүүрлэж, дөрвөн удаа шөвгөрч байжээ. Паньджунай гэдэг хүний ажилсаг чанар, басхүү ан ав сайн хийдэг байсан нь үр хүүхдүүдэд нь ч өвлөгдөн үлдсэн байх юм. П.Банзрагч гуайн хоёр ах “Улсын тэргүүний анчид байсан гэнэ. Тэрээр ч бас ан ав хийдэг, сумын ангийн арьс үсний төлөвлөгөө биелүүлэхэд гар бие оролцож явсан хүмүүсийн нэг. Өнөөдөр тэрээр Мөрөн суманд амьдарч байна. Гэвч төмөрбулагчуудын хөл тэднийхээс тасрахгүй. Ихэнх нь нэгдэлд ажиллаж байснаа гэрчлүүлэх бичиг баримт бүрдүүлэхээр П.Банзрагч гуайг зорьж ирнэ. 1990 оны эхээр сумын архивт байсан баримтууд устаж, шатаж алга болжээ. Тиймээс сум нэгдэлд ажиллаж байсан ахмадууд тэтгэвэрээ тогтоолгохын тулд шүүхээр ордог, ажилласан жилээ тооцуулдаг, П.Банзрагч гуай тэднийг нэгдэлд ажиллаж байсныг нь гэрчилж, шүүхэд өргөдөл бичиж өгдөг гэнэ. “Таныг яагаад захиргааддаг Банзрагч гэж нэрлээд байдаг юм” гэсэн саваагүй асуултанд маань тэр “Би үүрэг даалгавар биелүүлж явсан. Хатуу шаардлага л тавьдаг байсан байж магадгүй” гээд инээж суусан. Төмөрбулаг суманд хариуцлагатай алба хашиж, 10 гаруй нэгдлийн даргын нүүр үзсэн энэ хүний хөдөлмөр алдрийг саяхан Хөвсгөл аймагт тэмдэглэжээ.

## АНД НӨХДӨӨ ДУРСАХ АДУУЧИН

**Х**үглийж дүнхийгээд  
гэрийнхээ хойморьт  
ханхайж суух өвгөдтэй байх  
сайхан

Хүрэнтэж бараантаад нутгийнхаа талыг эзэгнэн дүүргэх өвгөдтэй байх сайхан

Хүрэн толгойн сүүдрийг хүүшлэн хүүшлүүлэн дуулах хөгшидтэй байх сайхан

Хөндийн салхийг нөмөрлөдөг хүдэр чийрэг хөх өвгөдтэй байх сайхан гэсэн шүлгийг хаа нэгтээгээс уншиж байж билээ. Энэ л нутгийн эзэн нь болж, эрх чөлөө тусгаар тогтнолын элч нь байж, хөдөлмөр бүтээл итгэл зүтгэлийн хөлс, хүч нь болж явсан хөх өвгөдөө дурсаж, Төмөрбулаг сумын уугуул Дашцэрэн гуайтай уулзаж ярилцлаа. Олноо “Адуучин Дашцэрэн” гэж алдаршсан энэ азай

буурал 1937 онд төржээ. Тэрээр бага сургууль төгсөөд нэгдэлд орж, 16 настай Саруул зам нэгдэлд адуучнаар ажилд орсон гэдэг. Тухайн үед 16 хүн нэгдэж нийлэн Бадарч гэдэг хүнийг даргаар томилж Саруул зам нэгдлийг байгуулж байхад Баян Пунцаг, Бадамхүү гэгч хоёр хүн тус бүр 1000 гаруй мал нийгэмчилж байжээ. Дашцэрэн гуай 100 гаруй мал нийлүүлж, “Саруул зам” нэгдлийн адуучнаар тохоон томилогджээ. Хорь гаруй жил адуу маллаж, сүүн заводын эрхлэгчээр ажиллаж, улсад 37 жил хөдөлмөрлөсөн Дашцэрэн гуай Тээл бригадын түүхийг сайн мэдэх цөөхөн хүмүүсийн нэг. Тээл сум байгуулагдаад удаагүй байтал 1959 онд шинэ дарга ирж, сумыг татан буулгана хэмээн хурал зарлаж, нутгийн иргэд эсэргүүцээд дийлээгүй гэнэ. Удалгүй даргын шийдвэрийг дээд газар батлаж, 1959 оны өвлийн эхээр Бүрэнтогтох сумруу Тээл сумыг нийлүүлжээ. 1973 онд Бүрэнтогтох сумын төв Боомын эхэнд байрлаж байгаад Улаан хошуу руу нүүхэд Тээл бригадынхан Төмөрбулагт шилжиж ирсэн гэнэ. “Манай бригад Төмөрбулаг сумтай нийлэхдээ 1000 гаруй хүнтэй, хонь үхэр ихтэй, үхрийнх нь дийлэнх хэсэг сарлагнаас бүрддэг, 4000 гаруй адуутай их товарлаг малтай байсан” хэмээн Дашцэрэн гуай хуучилж байсан юм. Сүү тосны төлөвлөгөө чанга байх тэр үед Төмөрбулаг сум 10 гаруй үнээний фермтэй байжээ. Нэг ферм 150 үхэртэй, 15 саальчинтай. Тээл бригадад



гэхэд ийм дөрвөн ферм ажиллаж, сумын цөцгийн төлөвлөгөөний 80 орчим хувийг биелүүлдэг байсан аж. Дашцэрэн гуайн хариуцаж байсан ферм хоёр тонн гаруй цөцгийн төлөвлөгөөтэй. “Саальчид төлөвлөгөө нормоо биелүүлэх гэж өдөр шөнөгүй ажиллана. Хар цай ууж, идээ цагаа, ааруул хурууд авна, хэрэглэнэ гэдгийг ч мартаж шахтлаа зүтгэнэ. Тасаг бууснаас хойш жаахан сүү тарагтай золгоно. Сүү саалийн ажил дундрангуут хадлан, тэжээлийн цагтай золгоно. Хөөрхий хэдэн саальчид гэж үнэндээ зовсон хүмүүс байсан даа” хэмээн тэрээр өгүүлж байсан юм. 1960-аад оноос эхлэж саальчдын хар хурууг шалгаж, хувин савыг үзэж, цагаан халаад өмсүүлэх гэж хөөрхөн бужигнаан үүсдэг байж. Гэхдээ л бүхий л нутгийг хамарсан соёлийн довтолгоонд саальчид хамгийн түрүүнд нэгдсэн юм шүү” хэмээн тэрээр дурсаж байлаа. Хорь гаруй жил адуу малласан Дашцэрэн гуай бид хоёрын яриа үнээний фермнээс хальж, адуу айрагний тухай яриагаар үргэлжлэв. Тэрээр 400-500 адуу малладаг. Жилдээ 2-3 тонн айраг нийлүүлэх төлөвлөгөөтэй ч төлөвлөгөөгөө өлхөн биелүүлдэг байжээ. Багаасаа морь уяж явсан ахмад адуучин малын хулгай чанга байх үед хэдэн сайхан адуугаа алдаад урам хугарч морь уяхаа больсон хэмээн ярьж байлаа. Түүний шарга азарга аймагт ч шөвгөрч, уясан эзэн, унасан хүүхэд нутгийн олноо баясгаж явжээ. “Сайхан морь унаж, сайхан нааддаг байлаа” гэсээр бидний яриа нэг л мэдэхэд хууч домог руу хальтирч оров. Дашцэдэн гуай “Ер нь манай Далай гүний хошууныхан их бярттай, тэнхээтэй хүмүүс олонтой байсан юм гэнэлээ. Тэр хошуу ноёны үед Асгадад Жигжид гэж том бөх байсан гэдэг юм. Хошуу наадам хийхэд гадны сайн бөхчүүд ирж барилдахад Жигжид гэдэг тэр бөх ганцхан мушиад л бүгдийг нь давж байсан гэдэг. Мушгихаас өөр мэх мэддэггүй л хүн байсан гэж хөгшчүүд хуучилдаг байсан. Манай хошуунд “Өргөөний өндөр бор” гэж цуутай хурдан хүлэг байсан юм гэдэг. Айхтар хадуурдаг, морьд зурхайгаас хөдлөхөд өндөр бор зэрэг гардаг. Гэвч замаасаа гарч, хашаа хороо, юу л байна дайрч, хаа хамаагүй давхидаг. Гэхдээ л морьд бариан дээр ирэхээс өмнө түрүүлээд очдог хурдаг буян байсан гэдэг. Хошуу ноёны наадамд ирсэн хүмүүс “За яахав. Танай Далай гүний хошуу амаа мэддэггүй бор даагатай, барилдахаа мэддэггүй бор бандитай л юм байна даа” гэж үг хаяж байсан гэдэг гээд инээд алдав. Төмөрбулаг суманд оньгүй худлаа ярьдаг хүмүүс цөөнгүй байсан гэдэг. Та тийм хүмүүсийн тухай сонсож байсан уу? хэмээн үг өдвөл тэрээр дахиад л инээд алдаж, “Зарим нь худлаа ярьдаг л гээд байдаг юм. Гэхдээ цайлган цагаан сэтгэлтэй, хар буруу санаагүй, санасан бодсноо шүүж тунгаалгүйгээр ярьдаг сайхан хөгшчүүд байсан юм. Тэдний нэг нь гөрөөчин Сүхзагдаа гэдэг хүн. Уг нь сайн гөрөөчин л дөө. Ам нь болдоггүй хүн. Тэрээр бага залуу байхдаа нэг гөрөөс буудаж гэнэ. Гэтэл өнөөх гөрөөснийхөө гэдсийг оночихож. “Гөрөөс гэдэс дотроо хаяад давхиад явчихсан. Сүүлд цэргээс ирснийхээ дараа нэг гөрөөс буудаад, арьсыг нь өвчтөл өнөөх гэдсээ хаяад явсан гөрөөсөө дахиад буудчихсан байсан. Арьсыг нь өвчөөд, гэдэс дотрыг нь салгах гээд хартал хошноого, улаан хоолой хоёр нь нийлээд эдгэчихсэн, гэдэс дотор байхгүй, бөөн өөх л байсан” гэж ярьсан байгаа юм. Манай Тээлд Гунгаа баатарын хамаатан, жанжин Лхагваа гэж эр байлаа. Гунгаа ах гэж их ярина. Нэг удаа мань эр “Ноён хошууны бэлд явж байгаад чөдрөө

хаячихлаа. Ноён хошууны орой дээр гараад Гунгаа ахын өгсөн дурангаар харахаар чөдөр маань гурайгаад л харагдах юм. Яваад очихоор олохгүй юм” гэж ярьсан гэдэг. Бас нэг удаа “Гунгаа ах ирээд, бид хоёр Зил-130 машинтай наашаагаа ирлээ. Мөрөнгийн гол үертэй гэж жигтэйхэн. Цагаан олмын тэрүүгээр ганцхан ухасхийгээд гартал цагаан манан татаад, машин гараад явсны дараа шалхийгээд л хоёр ус нийлж байсан” гэж яриад бөөн инээд болж байсан. Хунчаан гэж бас л бэлэн зэлэн үгтэй, жаахан дэгсдүү ярьдаг хүн байлаа. Нэг удаа Хунчаан гуайнд адууны эрэлчин ирж, “Гурван морь үзэгдэв үү?” гэтэл “Үзээгүй л дээ хө. Гэхдээ урьд шөнө хүрэн, бор, цайвар гурван адуу ирээд явсан байна лээ” гэж. “Та шөнө адуу ирэхийг хараагүй юм бол зүсийг нь яаж мэдэж байгаа юм? гэж асуутал Хунчаан гуай “Нэг нь хөлбөөсөн байсан. Хөлбөөсөн газарт нь цайвар үс үлдсэн байна лээ. Нэг нь хашаа шөргөөгөөд явсан байсан. Тэнд хүрэн бараан үс үлдсэн л байсан даа. Нэг нь баасан байна лээ. Адууны баасан дээр бор хялгас байсан” тэгээд л зүсийг нь мэдчихгүй юу гэж хэлсэн гэдэг юм хэмээн биднийг хөгжөөв. Нэгэн цаг үед хамтдаа бужигнаж, инээж, хөхөрч, ажиллаж амьдарч явсан үеийнх нь хүмүүс бурханы оронд заларч, түүний үеийнхэн тун цөөхөн үлджээ. Гэхдээ л дурсамжаа сөхөн, халуун залуу насныхаа тухай, үеийн олны тухай тэрээр хууч хөөрч суухдаа нүд нь гэрэлтэж байх шиг л санагдаж байсан юм. Дашцэрэн гуайн багш “Буль” гэж нэрлэгдсэн Лханаажав хэмээх сайхан эр байжээ. Долгорын Лханаажав хэмээх энэ хүн өндөр нуруутай, яралзсан сайхан шүдтэй, хурдан шалмаг хөдөлгөөнтэй, ёстой л адуучин хүн байсан гэнэ. 1959 онд Бүх ард түмний спартакиадад эмнэг сургалтын тэмцээн болжээ. Энэ тэмцээнд Дашцэрэн гуай Д.Лханаажав багштайгаа цуг очжээ. Одоогийн аймгийн төвд Бүрэн сумын адууг ярайтал бөөгнүүлээд туугаад ирчихсэн байж. Д.Лханаажав гэдэг энэ хүн эмээлтэй морины олом, жирмийг чангалалгүй мордож, хоёр хөлөөрөө хавчиж булгиулан олныг гайхшруулжээ. Түүнийг мориноос унахгүй болохоор зайдан морь унуулж, эцэст нь ногт ч үгүй морин дээр мордуулжээ. Өөд уруугүй цахдаж булгих эмнэг хангал морины нуруун дээр тэрийгээд хэвтчихдэг, том шүд гарган яралзтал инээдэг, мөн ч эртэй, бяртай, бас хөдөлгөөний эвсэл сайтай, уян хатан, моринд үнэхээр гарамгай хүн байсан гэнэ. Д.Лханаажав нэг өдрийн дотор 64 эмнэг сургаж, шалгарч байжээ. Буль гэдэг хоч гэхээсээ илүү цол юм шүү дээ. Саяхан энэ хүнд спортын мастер цол өгсөн сураг байсан” хэмээн Дашцэрэн гуай хуучны андаа дурсаж байлаа. Өвгөдөө дурсаж, үеийнхээ нөхдийг үгүйлэн санаж яваа энэ л хүнтэй уулзаж суухад

Судар шиг их амьдралын харгуйд

Сур шиг харваад эргэн ирээгүй

Суу алдарт залуу нас чамайг

Санаж дурсахгүй хэн байх вэ гэсэн Билгүүн номч Бямбын Ринченгийн шүлгийн мөрүүд өөрийн эрхгүй санаанд орж байлаа.

## ХОСГҮЙ ҮНЭТ БҮТЭЭЛИЙН ЭЗЭД

Хотогойд түмний түүх намтрыг сөхөж харахад эртнээсээ гарын ур сайтай, гяраг бүс нэхэж, нийслэл хүрээ хүртэл арилждаг, гэрийн унь тооно хийж, эмээл урладаг байсан гэсэн баримтууд тодхон үлджээ. Үнэхээр ч хотогойд таван хошууны нэг Далай гүний хошууны урчуудын тухай олон зүйлийг өгүүлж болно. Энэ удаа Уран гартан хэмээн олноо хүндлэгдсэн хоёр хүнийг нэгэн дор онцлохыг сэтгүүлч миний бие хүссэн юм. Энэ бол Төмөрбулаг сумын уугуул Сономын Дамдинжав, Дамдинжавын Дорлиг нар.

Бидний аз жаргал түрүү үеийнхний урсгасан хөлс ажээ. Авьяас төгөлдөр хийгээд хүн ёсны үлгэр дуурайл болсон тэр л хүмүүс нэг насны амьдралаа зөвхөн хойч үеийнхээ төлөө л үрсэн юм шиг санагддаг. Нэрт барималч Сономын Дамдинжавын амьдрал ч гэсэн Монголд шавыг нь тавьж, эхийг нь зохиосон олон зүйлтэй холбогддог юм билээ. Тэрээр анхнаасаа л урлагт “зориулагдчихсан” хүн байсан гэдэг. Тэрээр олон бүтээн байгуулалтын анхдагч байж, хийж бүтээж явсан ахмадуудын нэг. Аль ч ажил үйлс амар хялбар байх нь ховор. Тэр тусмаа дүрслэх урлагт хамгийн хэцүү нь чулуу, мод, төмөр баримал цутгуур аж. Урлах арга, олох материал, хийх техникийн багаж хэрэгсэл, сэтгэн бүтээх оюун санааны хувьд хүнд хүчир баримлын урлагт хүч авьяасаа сорьж амжилтад хүрсэн цөөхөн хүмүүсийн нэг нь Сономын Дамдинжав. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул Сономын Дамдинжав хэмээх уран гартан Монголын дүрслэх урлагт 50 гаруй жил бүтээл туурвил, бие сэтгэлээ зориулсан юм. Тэрбээр авьяас, билэг танхай нэгэн байсан гэдгийг уран бүтээлчид бүгд хүлээн зөвшөрдөг. С.Дамдинжав уран зураг, сийлбэр, баримал, хөөмөл, уран дархан зэрэг урлан бүтээх олон талын авьяастай уран бүтээлч.Тэрээр 1959 онд гар ажиллагаатай, бага оврын хүрэл цутгуурын урлан санаачлан байгуулж, 1000 шахам хүрэл цутгуур хийж байсан гэдэг. Түүний хийсэн олон бүтээл Монголын дүрслэх урлагийн эрдэнэсийн санд өнөөдөр хадгалагдаж байна. С.Дамдинжавын 1959 онд бүтээсэн “Аавын малгай” хэмээх алдартай бүтээлийг Монголын уран зургийн галерей зүгээс Монголын уран зургийн галерейн баримлын сан хөмрөгт хадгалагдаж буй хосгүй үнэт бүтээл хэмээн үнэлжээ. Томдсон малгайтай жаахан хүү. Харсан хүн бүрийн хайрыг булаах энэхүү хүрэл цутгуур энгийн хэрнээ монгол ахуй, монгол хүүхдийн бие бялдарын онцлогыг хүртэл тод тусгаж чадсан дахин давтагдашгүй хосгүй бүтээл хэмээн мэргэжилтнүүдээс өндөр үнэлгээ авч байж. Тийм ч учраас энэ бүтээлийг хосгүй үнэт бүтээлийн жагсаалтанд албан ёсоор оруулжээ. С.Дамдинжав цул төмрийг цоолборлон сийлж, утга төгөлдөр зохиомж, үйл хөдлөл, эрчимтэй хурц хөдөлгөөнийг дүрслэн үзүүлж чаддаг байсан гэдэг. Харамсалтай нь энэхүү нэртэй уран бүтээлчийн намтар түүх бүрхэг. Гэхдээ түүний хийж бүтээсэн зүйлээр Монголын ард түмэн бахархаж, урлагт нэрийг нь мөнхлөн үлдээсэн байх юм. С.Дамдинжав “Карл Маркс”, “В.И.Ленин” зэрэг ган сийлбэрүүд хийж байж. Үүнээс гадна 1859 онд Засагт хан аймгийн Дархан гүний хошуунд Манжийн колончлогчидын эсрэг гарсан бослогыг

удирдаж байсан Ард Аюушийн хөшөөг түүнийг мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан 1959 онд Ховд аймгийн төвд босгожээ. Монголын анхны хүрэл цутгамал хөшөөнүүдийн нэг Ард Аюушийн хөшөө олон он өнгөрөвч элэгдэж, гэмтэж ганхаагүй. Түүний хийсэн хуйлаастай бичиг барьж зогсоо Ард Аюушийн хөшөө өнөөдөр ч сүндэрлэж байна. Үүнээс гадна тэрээр Монголын утга зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдоржийн хөшөөг хүрлээр цутган, их зохиолчийн гэгээн дүрийг хойч үеийнхэндээ мөнхлөн үлдээсэн гавьяатай уран гартнуудын нэг юм.

Харин энэхүү хөрөг тэмдэглэлийн маань дараагийн баатар бол тус сумын уугуул Агт, Бадагаар нутаглаж байсан ловон Дамдинжавын хүү Дорлиг. Тэрээр 1903 онд Төмөрбулаг суманд төржээ. Бага наснаасаа сэргэлэн цовоо гарын дүйтэй хүүхэд байсан бөгөөд маш богино хугацаанд модны ураар янз бүрийн амьтан сийлж чаддаг, тун ч авхаалжтай нэгэн байсан гэнэ. Модны ураар бух голио урлаж, түүнийг түлхүүрдэн хөдлөдөг, нялх хүүхдийг дуурайлган модоор сийлсэн нь амьд юм шиг харагддаг байжээ. Уран Дорлиг хэмээх энэ хүн аливаа юмны учрыг тун сайн олдог. Техник сэтгэлгээ сайтай хүн байжээ. Хэнээр онол заалгаагүй, техник, технологийн тухай ном судар уншиж байгаагүй энэ хүн 30x20 см хэмжээтэй ширээний цаг хийжээ. Гэхдээ энэхүү цагны бүхий л эд ангийг өөрийн гараар хийсэн бөгөөд 30 минут тутамд хөгжим эгшиглэж, хөхөө дуугаран, голд нь байгаа уурга барьсан морьтой хүн давхих хөдөлгөөн хийдэг гайхамшигтай нарийн ур хийцтэй цаг бүтээж байсан тухай өнөөдөр Төмөрбулагчууд дурсан ярьж байна. Энэхүү хосгүй ховор бүтээлийн тухай мэдээ тухайн үед “Пионерийн үнэн” сонинд нийтлэгдэж байсан түүхтэй. Түүний бүтээсэн энэхүү цагийг 1951 онд Ардын хувьсгалын 30 жилийн ойгоор улсын үзэсгэлэнд тавихаар авч явсан бөгөөд маршил Чойбалсанд бэлэглэнэ хэмээн дарга нар ярьж байсан гэнэ. Гэвч энэ цаг хожим бүтэлгүй хүмүүсийн гараар орж, бэлэг маршалд очоогүй юм гэнэлээ. Ямар нэг техникийн сургууль төгсөөгүй ч гэсэн техник сэтгэлгээгээ маш өргөн хүрээнд хөгжүүлж чадсан энэ уран гартан цахиур бууг хойноос нь сумлаж бууддаг болгон өөрчилж, үүнийхээ төлөө хэсгийн төлөөлөгчид дуудагдаж, байцаагдаж явсан гэдэг. Мөн 20 кг даах чадалтай гар жин хийж, өөрийн гараар сүүний машин бүтээж, сүүгээ машиндаж, авсан цөцгийгөө өөрийн гараар хийсэн килогоор жинлэж тушаадаг байсан байх юм. Олноо уран Дорлиг хэмээн хүндлэгдсэн энэ л буурлын охин Д.Цэрмаа Д. Сэрчмаа Д. Нямаа нар өнөөдөр энх тунх амьдарч байна. Харамсалтай нь түүхэнд бичигдэж үлдэх энэ уран хүний хийж бүтээж байсан зүйл устаж үгүй болжээ. Алдартай уран гартан энэ хүн насны эцэс хүртлээ цаг засаж, олон түмэнд ач тусаа түгээж байсан гэдэг.

## АЛТАН ИШИГНИЙ ЭЗЭН

Төмөрбулаг суманд халуун залуу насаа үдэж, ажиллаж, хөдөлмөрлөж явсан мянга, мянган хүмүүсийн нэг нь Ж.Чулуунсүрэн. “Монгол Улсын Хөдөлмөрийн баатар П. Цагаачийн гэргий энэ хүний намтар түүх улсын баатрын сүрд дарагдаж, түүх намтраас гээгдэж, үлдээд байх юм. Энэ хүн 450 ямаанаас 670 ишиг бойжуулж байсан гавьяатай. Энэ амжилтыг нь ажилласан жилтэй нь харьцуулаад бодох юм бол нэг суурь ямааг 20 мянга болгосон хөдөлмөрч хүн шүү” хэмээн нутгийн нэгэн буурал надад хатуухан сануулж билээ. Тиймээс Ж.Чулуунсүрэн хэмээх, энгийн даруухан нэгэн эмэгтэйтэй хэрэг болгон уулзсан юм. Тэрээр Монголын үндэсний олон нийтийн радиогийн “Таван эрдэнэ” нэвтрүүлгийн нэрэмжит Алтан төлийн эзэн хэмээх нэр хүндтэй шагналыг Төмөрбулаг сумаас анх удаа хүртжээ. “Алтан төлийн эзэн” шагналд нэр дэвшигчдийн тодорхойлолтуудыг таван хошуу малын төрөл тус бүр дээр хүлээн авч ҮХААЯ-тай хамтран дүгнэж шалгаруулдаг уламжлалтай. Таван төрөл тус бүр дээр тухайн жилдээ хамгийн олон төл хүлээн авсан, нутаг орондоо шинэ залуу малчин бэлтгэх хувь нэмрээ оруулсан, малынхаа ашиг шимийг боловсруулж зах зээлд гаргаж өрхийн үйлдвэрлэлээр бусдад үлгэр жишээ болохуйц ажилласан, малчдын бүлэг хоршоо, нөхөрлөл хамтын ажиллагаанд санаачлагатай ажилласан зэрэг олон шалгуур үзүүлэлтийг харж энэ шагналыг өгдөг гэнэ. Тиймээс хүссэн хүн бүр “Алтан төлийн эзэн” гэдэг хүндтэй нэрийг олж авч чаддаггүй бололтой. Эдүгээ 45 дахь жилдээ Монголын радио “Алтан төл”-ийн эзнээ шалгаруулсан ч Хөвсгөл аймгаас тун цөөхөн хүн энэ болзлыг биелүүлжээ. Ж.Чулуунсүрэн Төмөрбулаг сумын Бүгсийн голд төржээ. Дөрөвдүгээр ангиа төгсөөд л 14 настай илгээлт өвөртлөн мал дээр гарсан энэ хүний эцэг сум нэгдэл байгуулагдахаас өмнө эх адаг нь олдохгүй их олон малтай, зартай баян, басхүү их ажилсаг хүн байсан бөгөөд “Дашилт” нэгдэлд малаа нийгэмчлэн, гишүүнээр элсэж байсан гэдэг. П.Цагаач баатар Ж.Чулуунсүрэн гуай хоёр 1964 онд хамтын амьдралаа зохиожээ. Залуу хосууд П.Лунхаан ахынхаа туслах малчнаар долоон жил ажиллаад дараа нь бие даан ямааны суурь авч, 400 ямаа маллаж эхэлжээ. “Нарийний голд ямаа маллахгүй, нутаг орноо би өөрөө сонгоно” хэмээн зөрүүдэлж байсан П.Цагаач “Олддоггүй П.Цагаач” гэж нэрлэдэг, өдөр шөнөгүй нүүдэл хийж, малаа оторлуулна.



Гэрийн бүхий л ажил Ж.Чулуунсүрэн гуайн нуруун дээр ирнэ. Нүүдэл хийж, олон жаахан хүүхдүүдээ асарч сувилна. Үүний хажуугаар сурвалжлагч сэтгүүлчид, дарга даамлууд, туршлага судлах гэсэн хүмүүс өдөр өнжилгүй шахам тэднийхийг зорьж ирнэ. Олон зочдыг хоол ундтай, аятай тухтай байлгах хэрэгтэй болно. Отор нүүдэл их хийдэг учраас малын жилбэ сайн. Ямааны дэлэн сэрийчихээд нялх ишиг хөхөө хөхөж чадахгүй сандаргана. Ж.Чулуунсүрэн гуай ямааныхаа дэлэнг нойтон алчуураар арчиж, бөглөөг нь гаргаж, сүүг нь сааж, угждаг байсан гэнэ. 500 гаруй ямааны 700 гаруй ишгийг нэг бүрчлэн хөхүүлж, заримыг нь байнга угжиж, мал болгох гэдэг амаргүй ажилтай. Үүний зэрэгцээ нэг ямаанаас долоон литр сүү саах нормтой. Зун сүүгээ сааж тушаана. Архийг хүртэл дахиж нэрж, арз хийх төлөвлөгөө биелүүлнэ. П.Цагаач баатарын хөдөлмөр алдрыг тэмдэглэх үед нийтдээ 10 тонн сүү сааж улсад нийлүүлсэн гэдэг тооцоо гарч байжээ. Хажуугаар нь хадлан гэжээ бэлтгэх их ажил ундарна. Жилдээ 20-25 тонн өвс гар шимээсгээр хадаж бэлтгэдэг байж. Энэ л их ажлыг гардан хийж, ар гэрээ өргөж тэтгэж, эр нөхрийнхөө тулах багана нь болж Ж.Чулуунсүрэн гуай 1994 онд 540-710 ишиг бойжуулж, “Алтан ишигний эзэн” болж байсан юм.

## ҮЛ БҮДГЭРЭХ СУДАР

Цагаан бургасны даваа өгсөж явахад Төмөрбулагын тухай сайхан бодол сэтгэл баясгана. Учир нь он цагийг холбож, олон олон хүмүүсийг угтаж үдсэн буурал давааны орой дээрээс Төмөрбулаг сумын газар нутаг эхэлнэ. Эх нутаг, ээжийн тухай сайхан бодлууд цааш хөвөрнө...Өнгийн цэцэг дэвссэн Шар хөндий, үржил шимт Бүгдгээний гол, холын зочдыг урин залсан Олон голын хөндий, зуун зууныг илээсэн буган чулууд, Дашдэрчин, Баянзүрх хайрханы хараа булаам ноён оргилууд хоймор нутгийн бахархал болсон өвгөдийн тухай уртаас урт намтар түүх өгүүлнэ. Энэ л нутгаас төрж гарсан олон олон эрдэмт буурлуудын нэг Сүхийн Готов хэмээх сайхнаас сайхан буурал саяхан болтол бидний дунд амьдарч байсныг



нэхэн дурсав. Тэрээр Төмөрбулаг сумын Жаргалантын голд 1916 онд төржээ. Долоон настайдаа тэр үеийн эрдэмтэй маарамба лам Лувсангэндэн хэмээх хүнд хадаг барин шавь орсон хүү 12 настайдаа “Чогсон уншлага” хангалыг Тэлээгийн амны хүрээ хийдэд уншиж, 13 настайгаасаа Чойрын дацанд гүн ухаан заалгаж байсан гэдэг. Хичээнгүй, ой тогтоол сайтай, эрдэм номонд үнэнхүү дуртай жаахан хүү 23 нас хүртлээ Чойрын ном үзэж, домын дамжааг Бүгсийн хүрээний Дашгэндэнжамбаалин дацангийн Чой даржаалин дацанд барьж байжээ. Гэвч 1932 оны зэвсэгт бослого гарч, үүнийг залган их хэлмэгдүүлэлт өрнөж, сүм хийд нурааж, лам нарыг ад шоо үзэж эхэлсэн бараан өдрүүдэд С.Готов олны жишгийг даган хар болж, мал дээр гарчээ. Гэвч сурч мэдэхийг эрмэлзэж байсан залуу зүгээр суухыг хүссэнгүй, кирилл үсэг бие даан сурч, Улаанбаатар хотод санхүүгийн техникумд сурахаар хөлгийн жолоо залжээ. Тэрээр санхүүгийн техникум төгсөөд Улаанбаатар хотын 9-р артельд нягтлан бодогчоор ажиллаж байсан гэнэ. Халх голын дайнд оролцож, нисэх дивизийн хангах салаанд бичээч, бензин түгээгчийн ажил хийж явсан энэ хүн Хөвсгөл аймгийн цэргийн хэлтэст бичээч, туслахаар ажиллан тушаал дэвшиж, Цэргийн хэлтсийн дарга болж явжээ. 1953-1956 онд тэрээр банкны даргын ажилд томилогдож, хожим Улаанбаатар хотын Төмөр замын хэвлэх үйлдвэрт төлөвлөгч, аймгийн “Эрх чөлөө” сонины хэвлэх үйлдвэрт мастер хийж, 1974 онд гавьяаныхаа амралтанд гарчээ. Шинэ цагийн боловсрол эзэмшиж, төрийн албанд зүтгэж явсан ч гэсэн С.Готов гуай багадаа сурсан мэдсэн зүйл, багш нарынхаа хэлж ярьсан захиас зааварыг мартсангүй. Тэрээр 1990



оны дараа сүсэгтэн олны дэмжлэгтэйгээр устаж мөхсөн Бүгсийн хүрээг сэргээж, анхны хурлыг хурж, Жаргалантын голын хөвөөнөө тасраад удаж байсан хурал номыг дахин эхлүүлсэн удаатай. Бүгсийн хүрээний түүх, лам нар, 1930 оноос өмнөх байдлыг сайн мэдэх энэ буурал Монголын шарын шашины томоохон төвүүдийн нэг Бүгсийн хүрээний тухай ном бичиж, басхүү ам зургийг гаргаж, хойч үеийнхэндээ хадгалан үлдээжээ. 23 насандаа Бүгсийн хүрээ дээр Чойрын дамжаа барьж байсан боловч 1991 онд Монголын бурхан шашинтны төв Гандантэгчилэн хийд дээр Чойрын дацан байгуулах үед дахин ном судраа сэргээж, 1993 онд дахин домын дамжаа барьжээ. Тэрээр ном хурахын зэрэгцээ судас барьж, эмийн ургамал түүж, эм тан барьж, олон зуун хүнд ач буянаа түгээсэн маарамба хүн байсан юм. Сайн хүний буян гэдэг цаглашгүй. 70 гаруй жилийн тэртээ устаж үгүй болсон Бүгсийн хүрээ, Мөрөнгийн хүрээг дахин сэргээж, Гандандаржаалин хийдийн их хамбаар өргөмжлөгдөж байсан Готов гуай лам хар нийлсэн 80 гаруй хүнд мэдэх чадах бүхнээ зааж сургаж, түүний шавь нар чойрын болон, уламжлалт анагаахын эрдэм номд өнөөдөрч шамдан суралцж, басхүү зовсон зүдэрсэн олонд ерөөл буянаа хайрлаж, ач тусаа үзүүлсээр байна. Тэрээр Монголын бурхан шашны төв Гандантэгчинлин хийдэд 2006 оны “Барагдашгүй” хэмээх гал нохой жилийн шинийн тавнаас 15 хүртэл найм хоног гавжийн дамжаа барьж дуусган их хамба, гавж хэмээх эрхэм цолыг хүртэж явжээ. Буддын гүн ухааны гол судлагдахуун болсон таван ботийг гүйцэд үзэн, нийт лам хуврагуудын өмнө дамжаа барьж хамгаалснаар гавж цолыг хүртэнэ. Гавж гэдэг нь арван бэрхийг мэдэгч гэсэн үг бөгөөд 15-16 жил чойрын номыг судлаж байж энэхүү цолыг авдаг байна. Гандантэгчинлэн хийдийн Дашчоймпэл дацанд 1992 оноос гавжийн дамжаа барих ёс эргэн сэргэсэн бөгөөд энэ үед хөдөө орон нутгаас гавжийн дамжаа барьсан анхны хүнээр тодорч, түүний нэр Гандандаржаалин хийдийн түүхэнд бичигдэн үлджээ. Хүний амьдрал төгсөвч, номын хуудас шарлавч үл бүдгэрэх дурсамж гэдэг байдаг. Тийм л дурсамжуудыг олны сэтгэлд, номын үйлсэд буяны ачлалд үлдээсэн хүн бол Сүхийн Готов хэмээх буурал байлаа.

## УДАМ ДАМЖСАН УР УХААН

Төмөрбулаг сумын бахархах үйлстнүүдийн нэг бол яахын аргагүй Навааны Лувсанцэрэн хэмээх энэ хүн. Уран сийлбэрч Н.Лувсанцэрэн 1914 онд Засагт хан аймгийн Мэргэн гүний хошуу өнөөгийн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын “Тариатын асгат” хэмээх Идэрийн голын зах дээрх үзэсгэлэнт газар тайж Навааны ууган хүү болон мэндэлжээ. Хүүхэд ахуй насандаа Бүгдгээний хүрээнд шавилан сууж VIII-жалханз хутагт С.Дамдинбазарын шанзов Бүгсий, Бүгдгээний хүрээний хамба Агвааны Лхасүрэн шанзовт шавь орж, бурхны номонд суралцаж байгаад цаг төрийн эрхээр хүрээ хийд тархад бусдын адил малчин ард болжээ. Уран сийлбэрч Н.Лувсанцэрэн шашин номын томоохон зүтгэлтэн байсан нь тухайн социалист нийгмийн шашиныг хааж хавчиж байсан он жилүүдэд олон түмэнд буяныг үйлдэж уламжлалт эм тан барьж, хатгуур хануур хийхээс өгсүүлээд Бүгдгээний хүрээний хурлын дэг жаягийг хадгалан ном уншлагыг таслахгүй байсаар цаг төр уярсан ардчилсан хувьсгалын цагаан морин жил буюу 1990 оны зун Бүгдгээний хүрээний гол цогчин дуганы буурин дээр түүний санаачлагаар Бүгдгээн, Бүгсийн хүрээнд шавилан сууж байсан лам Д.Цагаан, н.Дамдинжав, н.Чойжоо, С.Готов, Г.Мятав болон нутгийн сүсэгтэн Х.Намсрай, Н.Буянхишиг, Г.Батдорж, Ч.Доржпалам нарын хагас зуу шахам хүн цугларч хоёр бүтэн өдөр нэг шөнийн турш маань ерөөл авч, мандал өргөсөн ёслол болжээ. Уг хуралд уншигдсан номыг Н.Лувсанцэрэн дан ганцаар ном харалгүй цээжээр уншиж байсныг Ч.Доржпалам нарын хүмүүс хожим бахархан дурсаж ярьж байснаас үзэхэд ямар эгэл даруу мөртөө ур ухаан, эрдэм чадал хосолсон нэгэн байсныг илтгэнэ.



Энэ хүмүүн 1938 онд Төмөрбулаг сумын гар урлалын артелд орж монгол эмээл хийхийн зэрэгцээ уран сийлбэрийг урлаж БНМАУ-ын маршал Х.Чойбалсангийн нэр дээр засгийн газарт бэлэг болгон явуулсан “Онъсон түлхүүр” бүхий хөхөө шувууны сийлбэрийг тухайн үед Монголын засгийн газраас ЗСБНХУ-ын их удирдагч И.В.Сталинд бэлэглэсэн байдаг. Сталин уг сийлбэрийг ихэд үнэлж чулуун соруултай янжуур тамхийг өөрийн гарын бэлэг болгож явуулсныг мөн маршал Х.Чойбалсангаас

угалзтай монгол гутал, дээлийн торгоны хамт ирүүлж байжээ.

Уран сийлбэрч Н.Лувсанцэрэн Хөвсгөл аймагт Дүрслэх урлагийн байгууллагыг үүсгэн байгуулагдахад гар бие оролцон 1947 онд Хөвсгөл аймгийн Урчуудын Эвлэлийн Салбарыг анх байгуулалцаж тулгын чулууг нь тавилцаж, анхны сийлбэрч, уран бүтээлчээр ажиллаж байсан юм. Түүний урласан “Арслан”, “Бүргэд”, “Тул загас”, “Фронтод”, “Агент”, “Монголын бух” зэрэг олон арван шилдэг бүтээлүүд нь Монгол улсын Дүрслэх урлагийн музей, уран зургийн Галерей, Хөвсгөл аймгийн музейн сан хөмрөгт өдгөө ч хадгалагдаж байна. Монголын Урчуудын Эвлэлийн гишүүн, МУЭ-ийн тэргүүний ажилтан Н.Лувсанцэрэн 1973 онд Унгар улсад болсон олон улсын уран баримлын үзэсгэлэнгээс “Гранпри” шагнал, Ардын хувьсгалын 40, 45 жилүүдийн ойн нэрэмжит дүрслэх урлагийн бүтээлийн уралдааны “тэргүүн байр”, 1986 онд болсон бүх ард түмний урлагийн их наадмын “Алтан медаль”, БНМАУ-ын “тэргүүний уран сайханч” цол хүртжээ.

Уран сийлбэрч хийхийн зэрэгцээ тэрээр морь сайн таньдаг, сайн уяач байсан гэдэг. Энэ хүн 1930-1940-өөд оны үед уяж түүний цагаан зүсмийн азарга нь аймаг сумандаа олон удаа түрүүлж айрагдаж байжээ. Мөн Гал шарын угшилтай сартай хээр азарга нь аймаг сумандаа 10 гаруй удаа түрүүлсэн “Түмний эх” цолтой хурдан хүлэг байжээ. Энэ азарганы үр төл болох сартай хээр азарга нь мөн л аймаг сумандаа торгон жолоо өргүүлсэн ажнай байсан бөгөөд түүний үр төл нь нэг наадамд таван насанд тавуулаа айраг түрүү авч байжээ.

Түүний хүү Л.Бат-Өлзий “1956 оноос 1960-аад оны дунд үе хүртэлх хугацаанд завсаргүй түрүүлсэн олондоо “Шувуун саарал” нэртэй гайхамшгийн хурдан хүлэг нь аавыг минь морь хэр таньдаг, уядаг, уралдуулдаг байсны нэгэн гэрч болох бизээ. 1959 онд орон даяар анх удаа Монголын Залуучууд Оюутны анхдугаар Их наадам зохиогдож, энэ наадмын аймгийн их насны моринд шувуун саарал морио би унаж саахалт айлын зайнд тасархай хол түрүүлж ирж билээ. Үзүүрийн удаах морь нь Галт зүрхийн Пөмбөөн Банзрагч гэдэг хүний саарал зүсмийн морь ирж байсныг санаж байна. 1959 оны 6-р сарын 2-нд энэ наадам болж олон ч хурдан хүлэг уралдаж, улс аймгийн хүчтэнгүүд барилдаж Дашзэгвэ гэдэг сайхан шумбаж дэлдэг залуу бөх түрүүлсэн юмдаг. Энэ наадамд түрүүлсэн морь, бөхийг улсад явуулна гэхэд манай морь машин ч бараг үзээгүй тул машинд ачиж явж боломгүй гээд яваагүй юм” хэмээн өгүүлжээ.

Уран сийлбэрч Н.Лувсанцэрэн хэмээх хосгүй уран, авьяас билэгтэй малч энэ хүнийг мал хөрөнгөтэй, бурхан тахилтай, лам хүн, тайж угсаатай юм байна гэсэн атаа жөтөө байнга дагаж, “Гавьяат” цолноос удаа дараа буцаагдаж байсан ч тэрээр ард олныхоо дунд “Уран” хэмээх нэрээрээ мөнхрөн үлдсэн юм. Түүнийг 1991 онд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор шагнасан байна.

Уран сийлбэрч Н.Лувсанцэрэн нь 1990 онд Улаанбаатар хотноо Монголын Урчуудын Эвлэлийн үзэсгэлэнгийн танхимд бие даасан уран бүтээлийнхээ тайлан үзэсгэлэнг далан зургаан насандаа гарган үзэгч олондоо толилуулж байжээ. Авьяас гэдэг алдар цолоор хэмжигддэггүй.

Харин хийж бүтээсэн зүйл нь хэр удаан насалж байгаагаар үнэлэгддэг эд. Тэгвэл “Уран” Лувсанцэрэнгийн энэ их авьяас билэг үр хүүхэдэд нь өвлөгдөн ирж, өдгөө ч Хөвсгөлчүүд гурван үе дамжсан уран гартнуудаар бахархаж байна. “Уран” Лувсанцэрэнгийн хүү

Л.Бат-Өлзий нь 1944 оны 01 сарын 05-нд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын “Бүгдгээний гол”-д малчин ард Лувсанцэрэнгийн ууган хүү болон төржээ. 1964 онд Мөрөн 8 жилийн сургуулийг төгсөөд өөрийн сонирхлын дагуу Хөвсгөл аймгийн Урчуудын Эвлэлийн салбарт дагалдан зураачаар ажиллаж байгаад 1971 онд УБДС-ийн Уран зургийн ангид элсэн суралцаж,



1975 онд Уран зураач мэргэжлээр төгсжээ. Тэрээр УБДС-ийг төгсөх дипломын ажлаа “БНМАУ-ын баатар нисгэгч Дэмбэрэл” уран зургаар онц дүнтэй хамгаалсан бөгөөд Улсын Уран сайхны Фондын Хорооны тэргүүлэгчдийн 1977 оны 12-р

сарын 16-ны өдрийн хурлын 38/20 тоот шийдвэрээр Уран зураачийн мэргэжлээр 6-р зэрэг /1-р зэрэг/ авсан байна. 1975 оноос Хөвсгөл аймгийн Урчуудын Эвлэлийн салбарын эрхлэгч, 1995 оноос Зураач Урчуудын Холбооны зураач /чөлөөт уран бүтээлч/, 2002 оноос Зураач Урчуудын Холбооны даргаар ажиллаж байжээ. Л.Бат-Өлзий Монголын Урчуудын Эвлэлийн гишүүнд 1968 онд элссэн бөгөөд 1978 онд орон нутгийн АДХ-ын депутатаар сонгогдож улмаар Монголын Урчуудын Эвлэлийн Хорооны V, VI, VII, VIII-р их хуралд төлөөлөгчөөр оролцож, V, VI таван жилийн болон ардын хувьсгалын 60 жилийн ойн гавшгайч, соёл урлагийн байгууллагуудын хошой аваргаар шалгаран ажиллаж байжээ. Түүний бүтээлүүдээс “Морьтон”, “Хилэнтийн гарам”, “Уран дөш”, “Ирээдүйн Капитан нар”, “Уран мандал”, “Капитан Чадраабал”, “Шинэ ургац”, “Буурийн ноцолдоон”, “Хавар”, “Байгаль”, “Буга согоо”, “Пионерууд аялалд”, “Эвийн хүч фашизмыг ялсан нь”, “Мөрөнгийн захад”, “Бүгдгээний цутгалан”, “Монгол улсын баатар Л.Даваадорж” “Цаатан”, “Их уул”, “Чингүнжавын нутаг”, “Хөвсгөл далай” зэрэг бүтээлүүд нь улс, аймгийн үзэсгэлэн уралдаанд шалгарч, байсан бөгөөд тэрээр Орос, Польш, Япон, Герман зэрэг орнуудын Уран зургийн үзэсгэлэнд уран бүтээлээрээ амжилттай оролцож байжээ.

2011 онд Хөвсгөл аймгийн 80-н жилийн ойгоор “Нутгийн өнгө” уран зургийн бие даасан үзэсгэлэн, Улаанбаатар хотноо Монголын Урчуудын Эвлэлийн хорооны үзэсгэлэнгийн танхимд “Мөрөөдлийн өнгө” уран

зургийн хамтарсан үзэсгэлэнг тус тус гарган үзэгч түмэндээ толилуулсан. Түүний хөдөлмөр бүтээлийг төр засаг, олон нийтээс өндрөөр үнэлж Ардын хувьсгалын 60, 70, 80 жилийн ойн хүндэт медалиуд, 1982 онд Засгийн газрын хүндэт жуух бичиг, 1991 онд Хөдөлмөрийн хүндэт медаль”, 2002 онд “Алтан гадас одон”, 2011 онд МУЭ-ийн “тэргүүний ажилтан”, Хөвсгөл аймгийн “тэргүүний ажилтан”, “Хөвсгөлийн бахархал” одонгоор тус тус шагнасан байна.

Тэгвэл зураач Бат-Өлзийгийн хүү, уран гартан Н.Лувсанцэрэнгийн ач хүү уран барималч Б.Ганхөлөг нь 1974 онд Улаанбаатар хотноо Л.Бат-Өлзийн гуравдугаар хүү болон төржээ. 1981 онд Мөрөн I-р 8 жилийн сургуульд орсон бөгөөд энэ үеэс уран бүтээлч болох гараагаа эхлэж улс, аймгийн хүүхдүүдийн “Мөнгөн харандаа” гар зургийн уралдаануудын тэргүүн байруудыг эзэлсэн байна. 1990-1993 онд Дүрслэх урлагийн коллежийг уран барималч мэргэжлээр суралцаж дипломын ажлаа “Айраг” уран баримлаар онц дүнтэй, 1999- 2001 онд Дүрслэх урлагийн дээд сургуулийг уран дархан мэргэжлээр суралцаж дипломын ажлаа “Хийморийн таван аймаг”



уран дархны бүтээлээр онц дүнтэй хамгаалан мэргэжлийн уран бүтээлч болсон байна. 1993 оноос Хөвсгөл аймгийн Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвд уран баримал, уран дархны багш, 2012 оноос мэргэжлийн боловсрол сургалтын менежерээр ажиллаж олон арван шавь бэлтгэж мэргэжлийн боловсролын салбарт үр бүтээлтэй ажиллаж байна. 2003 оноос Хөвсгөл аймгийн Зураач Урчуудын Холбооны уран барималчаар, 2006 оноос мэргэжлийн залуу уран бүтээлчдийн “Мөнх тэнгэр” нэгдлийн ахлагч, 2012 оноос Хөвсгөл аймгийн Зураач Урчуудын Холбооны тэргүүнээр сонгогдон дүрслэх урлагийн салбарт ажиллаж байна.

Уран барималч, уран дархан Б.Ганхөлөгийн уран бүтээлээс дурьдвал “Айраг”, “Галт шувуу”, “Бадрангуй”, “Сүрлэг”, “Зэрэглээ”, “Хэмнэл”, “Галбирс” уран баримлууд, “Хийморийн таван аймаг”, “Монгол шатар”, “эртний Монгол хутга, эвэр хундганы ком”- загварууд зэрэг уран дархны ажлуудаар улс, аймгийн уран бүтээлийн үзэсгэлэнгүүдэд амжилттай оролцсон байна. Мөн мэргэжлийн уран бүтээлчийн хувьд Мөрөн хотод “Гурван аварга хөшөө цогцолбор”, “Монгол улсын баатруудын цогцолбор”, “Хөвсгөлчүүдийн арван бахархал цогцолбор”, “Нэг үе “-усан оргилуур, Мөрөнгийн Гандандаржаалин хийд, Төмөрбулаг, Цагаан-үүр сумуудад “Суварга” зэрэг монументаль сүрлэг чимэглэлийн бүтээлүүдийг

хийж урлажээ. 2006 онд мэргэжлийн залуу уран бүтээлчдийн “Мөнх тэнгэр” уран бүтээлийн хамтарсан үзэсгэлэн, 2011 онд Хөвсгөл аймгийн 80 жилийн ойгоор “Гурван үеийн уран бүтээлчид” үзэсгэлэн 2012-2014 онуудад Хөвсгөл аймгийн Зураач урчуудын холбооны мэргэжлийн уран бүтээлчдийн үзэсгэлэн – I, II, III, 2013 онд Мэргэжлийн сургуулийн 40 жилийн ойгоор “Багш шавь” хамтарсан үзэсгэлэнгүүдийг гарган үзэгч түмэндээ толилуулсан.

Уран бүтээлч Б.Ганхөлөг 2006 онд Хөвсгөл аймгийн засаг даргын “Хүндэт жуух”, 2007 онд Мөрөн сумын хүндэт иргэн, 2007-2008 онуудын АЗХ-ны “NEXT STOP” наадмын шилдэг уран бүтээлч шагнал, 2009 онд “Аялал жуулчлалын тэргүүний ажилтан” цол тэмдэг, 2010 онд НАМЗХ-ны дээд шагнал “Алтан од” медаль, 2011 онд МУСТА цол тэмдэг, 2012 онд “Боловсрол-90” медаль, 2013 онд “Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан”-аар тус тус шагнагдсан байна.



## НУТАГ ОРНОО ХАМГААЛЖ ҮЛДСЭН ХҮН

Нутаг орондоо ажиллаж амьдарч, сумынхаа нэрийг олонд гаргаж яваа Төмөрбулагын олон залуучуудын нэг нь Бүгдгээний уугуул Ганжууржавын хүү Цэнд-Аюуш. Түүний аав Ганжууржав гуай багийн агент хийж, малын санитарчаар ажиллаж байжээ. Г.Цэнд-Аюуш 1976 онд сургуульд орж, 10-р ангиа төгсөөд цэрэгт явжээ. Зах зээл дөнгөж эхлэж, хөлтэй болгон хөлхөж, арилжаа наймаа хөөж, бүгд л мөнгө төгрөг хөөцөлдөж байх тэр үед Г.Цэнд-Аюуш олны их урсгалыг дагасангүй. Тэрээр цэргээс халагдаж ирснийхээ дараа Хөдөө аж ахуйн их сургуулийн газар зохион байгуулагчийн ангид элсэж, 1993 онд төгсөн аймгийн Хөдөө аж ахуйн хэлтэст газар зохион байгуулагчаар ажилд орж байлаа. Газар зохион байгуулагч гэдэг мэргэжилдээ эзэн болж, эмшсэн мэргэжлээрээ 24 жил ажиллаж байгаа Г.Цэнд-Аюуш эдүгээ Хөвсгөл аймгийн газрын харилцаа, барилга зохион байгуулалтын газрын даргаар ажиллаж байна. Сүүлийн үед хөдөө орон нутагт ажиллаж байгаа залуучууд “Сурах боломж алга, аймаг суманд амьдарч, гандаж зэвэрч байна” гэдэг уруу үг унагаадаг. Тэгвэл Г.Цэнд-Аюуш хөдөө орон нутагт мэргэжлээрээ ажиллахын зэрэгцээ сурч боловсорч, өөрөө өөрийгөө хөгжүүлж болдог юм гэдгийг олон залууст батлаж өгсөн. Тэрээр Улс төр эдийн засгийн дээд сургуулийг улс төр судлаач мэргэжлээр, Санхүү эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгсөж, 2013 онд ХААИС-д мэргэжлээрээ магистер хамгаалжээ. Тэрээр Мэргэжлийн хяналтын албанд газар байгаль орчний улсын байцаагчаар ажиллаж, барилга захиалагчийн алба газрын алба нэгдэх үед Хөвсгөл аймгийн газрын харилцаа, барилга зохион байгуулалтын газрын даргаар томилогдсон юм. 1994 оноос хойш Хөвсгөл аймгийн хэмжээнд хийгдэж байгаа газрын шинэтгэлийн бодлогын бүхий л асуудал энэ хүнтэй холбоотой. Тэрээр 109,6 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 24 сумтай, өргөн уудам нутагтай, улсын хэмжээнд гадрагын усны нөөцөөрөө тэргүүлдэг, байгалийн унаган төрхөөрөө нүд баясгаж сэтгэл сэргээсэн газрын цэнхэр нүдэн Хөвсгөл нуур, Дархадын цэнхэр



хотгор, Даян дээрхийн агуй, Улаан тайга, Уушигийн өвөр, Уран дөш уул, Эг, Шишгэд, Дэлгэрмөрөн, Идэр, Чулуут, Тэнгисийн гол бидний бахархал төдийгүй дэлхийн аялагчдын анхаарлыг татсан бүс нутагт газрын харилцааг зов зохистой байлгах, энэ л дүр төрхөөр нь хамгаалж үлдэхийн төлөө багагүй зүйл хийсэн. Хөвсгөл аймаг 50-р өргөргөөс хойшхи нутагт хамаарах газар нутгийг аймгийн тусгай хэрэгцээнд авах тухай ИТХ-ын 2009 оны 06 сарын 01-ны өдрийн №01-р дугаарт тогтоол гаргах ажлыг зохион байгуулсан. Таван жилийн өмнө гарсан энэ тогтоолыг 2014 онд дахин аймгийн ИТХ-аар дахин хэлэлцэж, 25 жилээр сунгасан юм. Ингэснээр уг бүс нутагт түгээмэл олдоцтойгоос бусад байгалийн баялгийг ашиглах боломжгүй болж байгаа бөгөөд уул уурхай, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах боломжгүй болж, Хөвсгөлийн унаган байгаль, байгалийн баялагт шунаж байсан олон хүний санаархал бүтэлгүйтэж, тус бүс нутагт хамаарч буй Цагаан нуур суман дахь Бярангийн хаш чулууны орд, Улаан-Уул сумын нутагт байх Мангушийн нүүрсний ордыг уг хамгаалалтын бүсээс салгаж, ухаж, малтах сонирхолтой байсан цөөнгүй хүмүүст боломж олдоогүй юм. Дэлхийн эко системд чухал үүрэг гүйцэтгэдэг Алтай Саяны салбар уулсын нэг хэсэг болсон энэхүү бүс нутаг нь цэвэр усны нөөцийн эх ундаргыг бүрдүүлж, байгалийн өвөрмөц тогтоц, ан амьтан бүхий уг 50-р өргөрөг нь нийт 14 сумын нутгийг хамарч байгаа бөгөөд аялал жуулчлалын тулгуур төв болсон гэдгийг энэхүү тогтоолоор баталгаажуулж чадсан. Урьд цагт газар нутгаа хамгаалах гэж зэвсэг барин босдог байсан бол өнөө цагт эрх зүйн бичиг баримт боловсруулж, гаргаж батлаж байж нутаг орноо элдэв шуналтнуудаас өмгөөлдөг болсон үе. Нутаг усаа хамгаалж үлдэх их ажилд гар бие оролцсон энэ залуу Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын нэг баг болж олон жил болсон Ханх сумыг бие даасан статустай сум болгох ажилд тэрээр гар бие оролцож, тус сумын хил хязгаарыг тэмдэглэж, хууль эрх зүйн бичиг баримт боловсруулах ажилд гар бие оролцжээ. Үүний үр дүнд алслагдсан том суурин сум болж, ажлын байр нэмэгдэж олон хүн илүү явдал, зардлаас ангижирсан. Энэ мэтчилэн түүний хийсэн ажил, бүтээсэн зүйлүүдийг дурьдаад байвал олон зүйл өгүүлэх хэрэгтэй болно. Тиймч учраас Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн газрын харилцаа, барилга зохион байгуулалтын ажил 2009 онд системийн байгууллагадаа тэргүүлж, сүүлийн хэдэн жил дараалан эхний гурван байранд орж байгаа. Нутаг оронтойгоо байнгын холбоотой явдаг энэ залуу Төмөрбулаг сумын гаррын даамалд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тус суманд кадастрийн зураг зураглал хийж эхэлжээ. Ингэснээр иргэд газраа өмчилж, үнэлэх боломж бүрдэж, эрх зүйн хувьд баталгаажиж, улсын бүртгэлд хамрагдах боломжтой болж байгаа юм. Г.Цэнд-Аюуш төрийн байгуулллагад 24 жил мэргэжлээрээ ажиллах хугацаандаа Хөвсгөл аймгийн тэргүүний ажилтан болж, Байгаль орчны яамны жуухаар шагнуулж, Газрын харилцааны тэргүүний ажилтан гэдэг цол хүртэж, 2012 онд Алтангадас одон хүртжээ. Төмөрбулаг сумын уугуул, Ганжууржавын Цэнд-Аюуш хэмээх энэ залуугийн хийж бүтээх зүйл, амжилт ялалт бидний өмнө байгаа учраас олон зүйлийг нурших нь илүүц бизээ.

## ТӨГСӨШГҮЙ МӨНХИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

**Х**үний амьдрал гэдэг төгсөшгүй үргэлжилдэг. Үр хүүхэд гэдэг бидний үргэлжлэл болж, амьдралыг нуруундаа үүрч, хойч үедээ хүлээлгэн өгдөг. Тиймээс ч хорвоо дэлхий бүрэн бүтэн оршин байх цагт хүний амьдрал гэдэг төгсөшгүй үргэлжилсээр л байх болно гэдэгтэй хэн ч маргахгүй нь лавтай. Одоогоос 49 жилийн тэртээ Анагаахын дээд сургуулийн оюутан Агваан, Навчаа хоёр анхныхаа үрийн зулайг үнэрлэж, дөнгөж нэг сартай улаан нялзрай жаахан хүүгээ Төмөрбулаг суманд ээж дээрээ аваачиж өгч байжээ. Өнгөрсөн 49 жилийн тэд олон олон түүхийг бүтээсэн. Анагаахын оюутан Агваан Монголын хүүхдийн нэртэй эмч болж, анагаах ухаанд өөрийн гэсэн зам мөрөө тодоос тод үлдээжээ. Харин Төмөрбулаг сум руу хүргэгдэж байсан жаахан хүү өнөөдөр аавынхаа нэрийг өндөрт өргөж, монголын анагаах ухааны салбарт мөн л нэр алдраа дуурсгаж, олондоо ач тусаа хүргэж явна. Агвааны Буяндэлгэр хэмээх энэ хүн 1965 онд төржээ. Тэрээр аав, ээж хоёрыгоо сургууль төгсгөл Төмөрбулаг суманд өсөж, эмээгийн гар дээр хүмүүжсэн гэнэ. Харин аав нь Шинэ-Идэр сумын эмнэлэгт хувиарлагдах үед тэрээр Шинэ-Идэр суманд нэгдүгээр ангид орж байжээ. 1976 онд Агваан эмч хотод дуудагдаж, Анагаахын дээд сургуульд багшлах болсноор тэрээр 24-р сургуулийн сурагч болжээ. Багаасаа сурлага сайтай, тоо сайн боддог, математикийн олимпиадад байнга дээгүүр байранд ордог хүү багаасаа Венгерт суралцана, оюутан болно” хэмээн мөрөөдөж явсан ч 10-р ангиа төгсөж, сургуулийн хуваарь авахаар орохдоо гэнэтхэн бодлоо орхиж, Анагаахын дээдийн анги сонгосон гэдэг. Гэхдээ түүний энэ гэнэтийн сонголт алдаагүй байсан гэдгийг өнгөрсөн он жилүүд түүнд хангалттай батлаж өгсөн юм. Тэрээр Анагаахын дээдэд нэг жил, Москвагийн анагаахад хоёр жил, Эрхүүгийн анагаахад дөрвөн жил төгсөөд нүдний эмчийн мэргэжил эзэмшижээ. А.Буяндэлгэр эмч 1989-2001 он хүртэл одоогийн Эх нялхасын эрдэм шинжилгээний төвд нүдний эмчээр ажиллаж байжээ. Эрхүүгийн Феодоровын эмнэлэгт мэргэжил дээшлүүлж, “Болор мэлмий” эмнэлэгт долоон жил ажилласан А.Буяндэлгэр эмч Монголд анх удаа хараа засах лазерын мэс ажилбарыг мэргэжил нэгтнүүдтэйгээ хамтран хийж байсан түүхтэй. 2008 оноос эхлэн

“Сайт” нэртэй хувийн эмнэлэг байгуулан өдий хүртэл ажиллаж байна. Тэрээр Монголоос ганцаараа Америкийн хүүхдийн нүдний эмч, хяларын эмчийн нийгэмлэгийн Олон улсын гишүүнээр сонгогджээ. Америкийн эмч нарын энэ нийгэмлэгт гишүүн болохын тулд гурван америк эмчийн “Энэ хүн манай нийгэмлэгт байх эрхтэй хүн” гэсэн тодорхойлолт авдаг гэнэ. Түүний хувьд харааны бэрхшээлтэй хүмүүст туслах, эмч нарыг сургах гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд тун идэвхитэй оролцдог. Түүний гэргий мөн л нүдний эмч мэргэжилтэй, Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн нарийн бичгийн даргаар ажилладаг Чимгээ хэмээх бүсгүй бий. Тэрээр Орбис Олон улсын байгууллага, Брайн Холдины сан гээд олон төсөл хөтөлбөрийн Монгол дахь зохицуулагчаар ажилладаг. Нүдний анагаах ухааны чиглэлээр хэрэгжиж байгаа Олон улсын төсөл хөтөлбөрт Хөвсгөл аймгийг хамруулах тал дээр анхаарч ажилладаг энэ бүсгүй “Чимгээ Хөвсгөлийн бэр учраас тус аймаг руу хэтэрхий их төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна” гэсэн хэл аманд хүртэл орж байсан удаатай. Гэхдээ л олны хэл амнаас тэд ухарч буцаагүй. Хөвсгөлийн иргэдэд хэрэгтэй, өгөөжтэй төсөл хөтөлбөрт хамруулж ажиллахыг байнга зорьсоор ирсэн. А.Буяндэлгэр эмч өөрийн төрсөн нутаг Хөвсгөл аймгийг энэ хөтөлбөрт хамруулсан гавьяатай. Түүнд Хөвсгөлөө гэсэн бодол, нутаг орноо гэсэн халуун дулаан сэтгэл бий. Одоогоос арваад жилийн тэртээ олон улсын төслөөр ирсэн 10 гаруй мянган ам долларын үнэтэй үзлэгийн микроскопийг дур мэдэн авч, тав дахь өдөр онгоцонд сууж, аймгийн нүдний эмч нарт хүлээлгэж өгчихөөд хагас сайн өдөр машинд сууж, нэг дэхийн өглөө ажил дээрээ зогсож байсан түүх ч түүнд бий. Тэрээр Австралид төвтэй Брайн Холдины нэрэмжит нүдний олон улсын сургалтын төвөөс санхүүждэг олон улсын хөтөлбөр дээр 2008 оноос эхлэн ажиллаж байна. Түүний ажиллаж байгаа Брайн Холдины төсөл орон нутгийн эмч нарыг тасралтгүй сургах, нүдний шилийг зөв тааруулах, харааны бэрхшээлтэй иргэдэд туслах, нүдний шилний зөв хэрэглээг бий болгох зорилготой. Үүний үр дүнд Хөвсгөл аймгийн 22 сумын иргэд нүдний нарийн мэргэжлийн эмч нарт үнэ төлбөргүй үзүүлж, оношлуулж, төлбөрийн чадвар муутай олон мянган иргэд харааны шилтэй болжээ. Хамгийн гол нь энэ төслийн хүрээнд аймгийн төв дээр байх нүдний эмч нарыг сургалтанд хамруулж, мэргэжил, арга зүйн тусламж дэмжлэг, заавар зөвөлгөө өгдөг. Мөн нүдний эмч нарыг өөрийн гэсэн нүдний шилний жижиг цехтэй болгоход дэмжлэг үзүүлж ажиллахын зэрэгцээ хөдөө орон нутагт ажиллаж байгаа иргэдийн нүдний хугарлын гажигийг судлах ажил хийгдэж байна. А.Буяндэлгэр эмч Хөвсгөлийн бүх сумаар дөрвөн жил дараалан явж, судлагаа хийж, үзлэг оношилгоонд иргэдийг хамруулжээ. Нэг суманд л гэхэд 450 хүнд үзлэг хийдэг гээд бодохоор энэ төсөлд ямар олон хүн хамрагдаж, хичнээн хүнд үр дүнгээ өгсөн бэ гэдэг нь тодорхой. Энэхүү судалгааныхаа дараа төслийн хүрээнд нүдний шилний эмч, техникч бэлтгэх ажил эхэлжээ. Мөн тэрээр Хөвсгөлийн залуу эмчийг Орбисын төсөлд хамруулж, Энэтхэгт нүдний хиймэл болор суулгах сургалтанд явуулахаар бэлтгэж байна. А.Буяндэлгэр эмч 1989 оноос эхлэн нүдний мэс засал хийж эхэлжээ. Жилдээ 500 орчим нүдний мэс засалд ордог энэ хүн өнгөрсөн хугацаанд 13 гаруй мянга орчим

хүнд хагалгаа хийсэн гэсэн тооцоо гарсан байх юм. Мөн Солонгосын мэс заслын Олон улсын байгууллагын эмч нарыг дагуулан Хөвсгөлд аваачиж, наян хүнд болор суулгах, 40 хүнд хялар суулгах мэс заслыг үнэ төлбөргүй хийж өгчээ. Түүний аав Агваан эмч АНУ-ын тэргүүн хатагтай Хиллари Килинтоны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Хүүхдийн өвчний цогц менежмент” төсөл дээр мөн ажиллаж байжээ. Энэ төслийг амжилттай хэрэгжүүлж мянган хүүхдээс 65 энддэг байсныг 25 хүртэл буулгаж, олон мянган хүүхдийн эмч нар бэлтгэсэн гавьяатай. Аавынхаа мэргэжлийг өвлөсөн, удам залгасан эмч өнөөдөр бас л ард түмнийхээ эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд зүтгэж явна. Хүнд хэрэггүй эд эрхтэн гэж байхгүй. Гэхдээ мэдээллийн 70 хувийг хангаж байдаг учир нүд бол хүний хамгийн чухал эрхтэн гэж тооцогддог. Тиймээс ч тэрээр илүү олон хүнд тус хүргэхийн төлөө ажиллаж байгаа.

## АНХНЫ ЭМЭГТЭЙ ЗАСАГ ДАРГА

**Т.**Энхтуяа Хөвсгөл аймийн Төмөрбулаг сумын 34 дэх Засаг даргаар томилогдон ажиллахдаа энэ сумын анхны эмэгтэй Засаг дарга төдийгүй Хөвсгөл аймгийн түүхэн дэх цөөхөн эмэгтэй Засаг даргын нэг гэдгээрээ онцлогтой. Төмөрбулаг сумын үе үеийн засаг дарга нарын түүх, өөрийн удирдах, зохион байгуулах, өөр өөрийн онцлогтой ч 2008-2012 оны дөрвөн жилд сум орон нутаг илүү өнгөлөг, ЗДТГ болон албан байгууллагууд хамт олонсог, баг болж ажиллаж чаддаг болсон нь эмэгтэй хүний нарийн мэдрэмж ур ухаан удирдах ажилд ч нарийн нандин зүйлээрээ ялгардаг гэдгийг харуулж чадсан. Хамгийн гол нь Т.Энхтуяа ажлыг дороос нь эхэлж гардан хийж байсан олон жилийн ажлын туршлага, салбар бүрийнхээ онцлогийг мэддэг, ойлгодог хүний хувьд гар нийлэн ажиллаж сурсан мэргэшсэн баг хамт олон нь байсан болохоор түүнд Засаг даргын ажил хүнд хэцүү байсангүй. Түүнийг Засаг дарга байх 4 жилийн хугацаанд орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан гэж сумын мэдэлд зарцуулах мөнгө аль аль нь байгаагүй. Засаг даргын ажлаа аваад байгууллагын удирдлагууд, багийн Засаг дарга нартайгаа хамтран нутаг орноо гэсэн иргэдийнхээ хүчийг нэгтгэж Мөрөн, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын нутгийн зөвлөлөө шинэчлэн байгуулж, тэднийхээ хүчийг орон нутаг руугаа татаж ажилласан нь ихээхэн үр дүнгээ өгчээ.



Мөн “Дэлхийн зөн ОУБ”, ТА-2, ” Вансэмбэрүү”, “Өвсний үндэс” зэрэг төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах тал дээр гол анхаарлаа хандуулж байсан нь орон нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд их түлхэц болж байжээ. Түүний ажилласан дөрвөн жилд 15 ортой хүн эмнэлгийн барилга, Спорт зал, 4 айлын орон сууц, багш ажилчдын цайны газар, 3-р багийн төв, Ерөнхий сайд асан С.Баярын санаачлага, хөрөнгө оруулалтаар 2-р багийн төв эрчим хүчинд холбогдож, “Нарлаг” эко хүүхдийн зуслан, Ахмадын амралт сувиллын газрыг шинээр байгуулж, 320

хүүхдийн суудалтай хичээлийн байр,бага сургуулийн хичээлийн байр, Цэцэрлэгийн барилгыг засварлаж ,ЗДТГ, Хүн эмнэлгийн автомашинуудыг шинэчлэн, бүх багийн эмч нарыг мотоциклоор ханган унаажуулж , төсөл хөтөлбөрүүдээс төсөвт байгууллагуудад багаж, тоног төхөөрөмж, эд хогшил нийт 180,0 гаруй сая төгрөг, сумын өрхүүдэд 40 гаруй сая төгрөгийн мал, гэр зэргийг олгосон байна. Соёлын төвд БСШУЯ-ны санхүүжилтээр ёочин, ятга, шанз, хуучир зэрэг 1583,0 мян төгрөгийн үндэсний хөгжим авч ,үзэгчдийн танхим болон номын сангийн өрөөг тохижуулан ширээ, сандал, 1800,0 төгрөгийн орчин үеийн шинэ номоор фонд баяжилт хийсэн. МИКОМ –ийн өндөр хурдны интернет тавигдаж,NG корпорацийн сүлжээний утас 703853-тай дугаарыг хэрэглэх боломжоор хангагдсан. УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн санаачлага Юнитель компаний 100 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хөдөөгийн багийг холбоожуулах чиглэлээр сумын төвөөс Мухарын чиглэлд 3,5 км өндөр хүчдэлийн шугам татаж, Мухар ,Урандөш хайрхан дээр Юнительн дахин дамжуулах станц баригдсанаар 4-р багийн нийт өрх, 1-р багийн 100-аад өрх харилцаа холбоогоор хангагдсан.

УБ хот дахь нутгийн зөвлөлийн дарга Л.Энх-Амгалангийн хөрөнгө захиалгаар ишгэн ухна 610-г бэлтгэн сумдад өгч Ренчинлхүмбэ сумын ууцан сүүлт, илүү нугаламт 100-н хурган хуц өгсөнийг малчиддаа тарааж, багуудад худаг уст цэг гаргах , хадлангийн талбай хөцөөлөх, мал угаалгын ванн барих зэрэг хөөцөлдөж хийж хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг дурдаж болно. Мөн иргэдийн өөрсдийн санал санаачлага, хүч хөрөнгөөр олон бүтээн байгуулалтын ажил хийгдэж, ЖДҮ хөгжих эхлэл тавигдаж хийсэн бүтээсэн ажлаар арвин, сум орны хувьд онцлох үйл явдлаар дүүрэн он жилүүд байлаа. МУ-ын гавьяат нисгэгч Дугарын Гунгаа МУ-ын баатар цол хүртэж, сумын түүхэнд анх удаа улсын цолтой бөх төрж, улсын М.Эрдэнэбат, Гунгаа баатар нарынхаа амжилтыг хамтран тэмдэглэж, Улсын сайн малчнаар Ё.Магсар,Г.Төөчөө нар, Аймгийн сайн малчнаар Б.Баттулга, С.Давааням, Д.Зоригоо, Г.Дашбямба нар тодорч өсвөрийн хүүхэд багачууд мини волейболоор улсын аварга болж байлаа.

Т.Энхтуяа 1998 онд УНДЕГ-ын баярын бичиг, 2005 онд бүртгэл статистикийн тэргүүний ажилтан,2006 онд Төрийн сангийн шилдэг төлөөлөгч , 2007 онд АЗДТГ, Монголын эмэгтэйчүүдийн академаас “ Шилдэг удирдагч” цом өргөмжлөл, Хөдөлмөрийн хүндэт тэмдэг, 2010 онд Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулж байлаа. Эмэгтэй хүний ур ухаан нарийн мэдрэмж түүнийг чадварлаг удирдагч болгосон төдийгүй амьдралын нь хамгийн завгүй 4 жил түүний засаг дарга байсан тэр 4 жилийг гэж хэлж болно. Сайн удирдагч гэхээсээ илүү сайн хамт олон минь намайг ийм амжилтанд хүргэсэн гэж тэрээр сонинд өгсөн ярилцлагандаа итгэл дүүрэн хэлж байсан. Санхүүгийн сургуулиа төгсөж очсон годгор охин төрж өссөн нутагтаа, энэ л хамт олон дотроо 20 гаруй жил ажиллахдаа олон сайхан ахмадуудаас суралцаж , шижигнэсэн эрч хүчтэй залуучуудтай гар сэтгэл нийлэн ажиллаж байсан үеийнхээ олон сайхан дурсамжуудыг дурсан ярих дуртай. Тиймээ Т.Энхтуяа Төмөрбулаг сумын түүхэн дэх Анхны эмэгтэй засаг дарга. Дөрвөн жил хэлэхэд ойрхон

сонсогдох ч хийж бүтээж, хөдөө нутгаар хөндлөн гулд явж айл айлын гэрээр орж амьдрал ахуйтай нь танилцаж, засаг даргын зүгээс тэдний амьдралд чадах яадахаараа тусалж явахад тийм ч богинохон байгаагүй. Гэхдээ л тэрээр хүмүүсийн хайрыг татсан, элгэмсэг өөриймсөг дарга байж Би-биш Бид гэсэн сэтгэлээр ажиллаж байсиймаа. Эгэл энгийн бүхэн хүний амьдралд байсаар л ирсэн. Харин эгэл энгийн зүйлээс л гайхамшиг , бахархал төрдөг аж. Чин сэтгэлээсээ хийсэн ажил бүр чин үнэн бахархал байдаг ажээ. Т.Энхтуяа 4 сонгууль дамжиж 16 жил сумын иргэдийн хурлын төлөөлөгчөөр сонгогдож, 12 жил сумын иргэдийн хурлын тэргүүлэгчээр ажиллаж байсан. Түүний Засаг даргаар ажилласан 4 жил сумын ИТХ-Д Ардчилсан нам олонхи болж байсан үе. Эмэгтэй хүн тэр тусмаа сөрөг нам олонхи болсон үед засаг дарга болж сөрөг хүчинтэй эвсэн ажилласан нь өөрөө чухал зүйлийн нэг болсон төдийгүй айл гэр, төр түвшитгэх үйл хэрэгт эмэгтэйчүүдийн үүрэг хариулагын чухлыг харуулж чаджээ. Харин тэр үед очоод буцсан төлөөлөгч, дарга нар эмэгтэй засаг даргатай суманд очиход цаанаа л дулаахан , хийж өгсөн хоол цай нь хүртэл арай л өөр хэмээж байсан.

Т.Энхтуяа одоо Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст ажиллаж байна. Тэрээр эдийн засгийн ухааны магистр, Мэргэшсэн нягтлан бодогч цолтой. Ахиж дэвшиж өөдөлж явна гэдэг сайн яваагийн хамгийн том жишээ. Хэдийгээр аймаг орон нутаг ажиллаж байгаа ч нутгийн иргэд одоо хир нь аймагт ирэхээрээ ажил төрлөө хөөцөлдүүлж,зарим нь утсаар захиж, Энхтуяад байнга итгэж найдаж байдаг.

Эмэгтэй хүн айлын гэргий байх, ээж байх үүргээс гадна төрийн алба хашиж явна гэдэг сайхан зүйл. Тэрээр их зүйлийг хийсэн цаашид ч хийсээр л байх болно. Төрийг төвхөнүүлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг зайлшгүй хэрэгтэй аж...

Амьдрал хэмээх хөлөг онгоцны нэгэн жигүүр болсон ийм эмэгтэй ажиллаж хийж, бүтээж явна. Маргааш шинэ өдөр эхэлнэ.



## ДӨЧИН НЭГЭН ТҮРҮҮНИЙ ЭЗЭН

Нарыг бөхтэй, морьтой, суртай нь айлсуулж, нэрийг улстай, устай, нутагтай нь ижилсүүлж, хурыг мэхтэй, цэцтэй, хурдтай нь хайрлаж, хуурыг хөгтэй, аялгуутай, чавхдастай нь эгшиглүүлдэг Монгол наадмын дэвжээн дээр Төмөрбулаг сумаар овоглосон хүчит бөхчүүд, хүн олноо баясгасан эрдэмт уяачид, шандас юугаа гайхуулсан хурдан хөлгүүд, цэц мэргэнээ батласан мэргэн харваачид цөөнгүй бий. Тэдний нэг нь Бандгайн Бямбасүрэн хэмээх энэ ахмад настан. Давшилт нэгдлийг Тариатад байгуулцаж, Эрчмийн оргил, Саруул зам нэгдлийн үндэс суурийг тавилцаж явсан энэ хүн 1937 онд төржээ. Нэгдлийн гишүүн болж, анхны адуучнаар таван жил ажиллаж байсан Бандгайн Бямбасүрэн гуай



1959 онд цэрэгт татагдаж, Хужирбуланд алба хааж, 1962 онд Дарханы цагдаад ажиллаж эхэлжээ. Тэрээр 1969 он хүртэл цагдаагийн албанд зүтгэж байгаад Сэлэнгэ аймгийн Номгон суманд ирж адуучин болжээ. Түүний амьдралын намтар, адуу хоёр салшгүй холбоотой. Магадгүй энэ уяачийг Төмөрбулаг сумынхан сайн мэдэхгүй байж болох. Харин Сэлэнгэ, Дархан, Эрдэнэтийнхэн Б.Бямбасүрэн уяачийн тухай үлгэр домог мэт зүйл ярих нь бий. Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн аварга адуучнаар удаа дараа шалгарч явсан энэ хүн Номгон сангийн аж ахуйн 700-100 адуу маллаж, жилдээ 7-10 тонн айраг бэлтгэж, Улсын баяр наадмын түрүү магнайг уяан дээрээсээ хөдөлгөж, бариан дээрээ тоссоор 30 гаруй оныг үдсэн байх юм. Монголчууд эртнээс морин эрдэнийн хийморь далласан, адуунд эртэй чадалтай, уях шинжихийн эрдэм ухаанд бусдаас илүү, аливаад шударга тулхтай эр хүнийг уяач хэмээн төсөөлж, хүндэлж дээдэлсээр ирсэн. Уяач хүний мөн чанар нь хурдан сайн молор эрдэнэ шигээ үнэнч сэтгэлтэй, худал ярих, хулгай хийхийг бүрэн цээрлэсэн, өөрийн гэсэн ёс суртахуунтай, цагаан мөртэй хүмүүс байсан нь бусдаас онцлогтой. Ийм л монгол сайхан уяачдийн нэг нь Б.Бямбасүрэн. Монгол үндэстний гайхамшигт соёл, үндэсний морин уралдааны их соёлыг дээдлэн хойд үедээ уламжлуулан, өргөж явах жам ёсны их үйлсэд үнэнч зүтгэж, үүнийхээ ч үр шимийг хүртсэн буянтай буурал. Алдартай энэ л уяач айргийн үнэр нэвт сэнгэнэсэн гэрээ төрт ёсны

их баяр цэнгэл наадамд түрүүлж айрагдсан хурдан хүлгүүдийнхээ авсан медалиудаар гоёжээ. Сэлэнгэ аймгийн аварга адуучин Д.Бямбасүрэн гуай Номгоны сангийн аж ахуйд адуу хариулахын зэрэгцээ Төмөрзамын мал маллаж байсан гэнэ. Гиймээс түүнд Төмөрзамын аварга ажилчнаар тодорч шагнуулж байсан баярын бичгүүд ч олон байх юм. 1962 оноос эхлэн морь уяж байсан энэ хүн зөвхөн Сэлэнгэ аймагаас л гэхэд 41 түрүү авсан байх юм. Түүний морьд Эрдэнэтийн наадамд шандас сорьж бас л найман түрүү, Дархан-Уул аймгийн баяр наадмаас нийтдээ хорь гаруй түрүү авчээ. Эцэг өвгөдийнхөө морь мал шинжих ухааныг өвлөж авсан энэ буурал өнгөрсөн дөчөөд жилийн хугацаанд Улсын баяр наадамд 200 гаруй морьдоо сойж, түүний морьд эзэндээ 103 медаль авчирсан. 103 морьд нь нэгээс гуравт хурдалж байсан гэдэг ганцхан тоо баримт л энэ хүнийг ямаршуухан уяач вэ гэдгийг батлаад өгнө. Одоо цагийнх шиг улирал болгон наадам хийж, морь уралдуулж, бүсийн тэмцээн уралдаан зохион байгуулдаггүй. Улсынхаа баяр наадмаар л морьдоо уралдуулдаг байсан тэр цагт Б.Бямбасүрэн уяачийн морьд 1976-1997 он хүртэл 21 жил Дархан-Уул аймагт тасралтгүй түрүүлж байсан байх юм. 1986 оны долдугаарын сарын 13-ны өдөр хэвлэгдсэн “Найрамдлын Дархан” сонин дээр “Салхит хорооны Бямбасүрэн 5 насны 9 морь уяж, түүний уясан морьд бүгд айрагдлаа. Хурдан хээр азарга азарганы уралдаанд шандас сорьж, хол тасархай түрүүлж ирлээ” хэмээн бичжээ. Мөн “Хөдөлмөр” сонин дээр “Адуучин Б.Бямбасүрэн, саальчин Цэен-Ойдов нарын зураг “Судалбар зураг” буланд түүх болон үлджээ. Б.Бямбасүрэн уяачийн Хээр азарга, Хурдан Зээрд, “Дөл”, “Сарт” гээд алдартай хурдан хүлгүүд Эрдэнэт, Сэлэнгэ, Дархан-Уул аймагт алдартай. Мөн түүний уяанаас олон алдартай хурдан хүлгүүд гарсны нэг нь Говь-Алтай аймгийн харьяат Гантулгын нэр дээр уралдаж байгаа Халиун үрээ. Нийслэлийн тэргүүн магнай хүлэг” шалгаруулах уламжлалт уралдаанд дөрөвт ирж, Улсынхаа баяр наадамд гурваар давхиж, уясан эзэн, унасан хүүхэд, уугуул нутгийн олноо баярлуулсан хурдан ажнай Б.Бямбасүрэн уяачийн унаган адууны нэг нь. Олон олон шинэ залуу уяачдыг төрүүлж, олон ухрдан хүлгийнхөө тоосыг баяр наадамд өргөж, түмнээ баярлуулсан Б.Бямбасүрэн уяач 2006 онд Сэлэнгийн алдарт уяач, 1997 онд Дархан-Уул аймгийн Манлай уяачаар шалгарч цол тэмдгээ авчээ. Дөч гаруй жил морь уяж, хоёр ч аймгийн алдарт, манлай уяач цол хүртэж, 100 гаруй морио айрагдуулсан энэ хүн уг нь Улсын алдарт уяачийн болзлыг аль хэдийнээ биелүүлсэн байх юм. Гэвч шагнал урамшуулал, нэр алдар, цол хэргэмд шүтдэггүй өвгөн буурал өнөөдөр ч малаа маллан, адуугаа дээдлэн амьдарч явна.

## ЭЦГИЙН ЗАХИАС

Энэ хүнтэй ярилцаж суухад “Эцгийн захиас гэдэг үр хүүхдийн хувьд хэзээ ч гээж боломжгүй нандин, чухал зүйлийн нэг байдаг юм байна” гэсэн бодол төрж байсныг нуугаад яахав. Түүний аав Бүгсийн хүрээний отгон шавь, Улсын баатар Гунгаатай цуг шавилж явсан гэнэ. Шашин номын үйлсэд зүтгэж, Бүгсийн хүрээ хэмээх 15-н сүм дуган, 3 суварга, маанийн 20 гаруй том хүрд, 16 жасын байшин,



ном барлах бархан, лам хуваргуудын суух 200 гаруй хашаа байшин бүхий томхон хүрээ бүхий том суурин газарт номын дуу сонсож явсан энэ хүн нас эцэслэхээсээ өмнө “Энэ хүрээг босгох учиртай юм шүү” хэмээн хүү П.Цэвээнлхазолдоо захиж үлдээжээ. Он цаг өнгөрч, нурж сүйрсэн сүм хийдийн шавийг тавих цагт Бүгсийн хүрээг сэргээн засахад мод, чулуу зөөж, шавийг нь тавилцаж явжээ. Гэвч үүгээр түүний үйл хэрэг дууссангүй. 1992 оны 8-р сарын 12-нд хуучин Бүгсийн хүрээний Цогчин дуганы туурин дээр шинэ Цогчин Дашгэндунжамбалин сүм нээгдэж, хурал ном хурж эхэлсэн ч гэсэн байнга суудаг ламгүй, хориод жилийн нүүрийг үзэж байна. Тиймээс Бүгсийн хүрээг эзэнтэй, байнгын ном уншдаг лам нартай болж, хүрээ хийд сэргэж, аавынх нь захисан захиас нэг мөр биелэгдэх тэр сайхан цагийг хүлээж, хүрээгээ тойрч нүүдэлсээр хориод жил болжээ. Хэдийгээр Бүгсийн хүрээ Мөрөнгийн ганданд харьяалагддаг ч гэсэн нэг хувь түлхүүр нь П.Цэвээнлхазолд хадгалагдаж байх. Сүм хийдээр орох, мөргөж, залбирах, ном унших гэсэн олон хүмүүст тэр замчилж, Бүгсийн хүрээ эзэнтэй юм шүү, эзэн нь итгэл бишрэл дүүрэн энэ нутгийн хүмүүс юм шүү гэдгийг сануулсаар байгаа. П.Цэвээнлхазол хэмээх энэ хүн 1948 онд төржээ. 1971 онд цэргээс халагдаж ирээд сувай үхэр маллаж, сумын Худалдаа бэлтгэлийн ангид агент хийж, худалдааны тэргүүний ажилтан болж байсан. 1991 онд Тээл бригад нэгдэл болгох санал санаачлага гаргаж, “Давшилт” нэгдлийн дарга нарт өргөх бичиг барьж хүмүүсийн нэг нь. Хожим “Саруул зам” нэртэй компани байгуулахад ч гар бие оролцож явжээ. Удалгүй “Саруул зам” компани хоршоолол болж, эцэст нь малаа хувьчилж авсан гэнэ. Түүний эхнэр Д.Дулмаа нэгдлийн сальчнаар ажиллаж, “Мянгат саальчин”-ы болзол биелүүлж явжээ. Эрийн нэрээр орж, эмийн нэрээр гардаг гэсэн зүйр бий. Төмөрбулаг сумын мянга, мянган гэрийн эзэгтэй нарын дотроос тэрээр цай идээ элэгтэйгээрээ зартай. Мөн түүний бэлтгэсэн цагаан идээний сайхныг нутгийн олон ч хүлээн зөвшөөрдөг

юм билээ. 2014 оны намар Төмөрбулаг суманд анх удаа “Намрын ногоон өдрүүд” сэдэвт өдөрлөг зохион байгуулагдаж, цагаан идээний үзэсгэлэн худалдаа гарах үеэр Д.Дулмаа гэдэг хүний бэлтгэсэн цагаан идээ, өнгө үзэмж, амт чанар, шимээрээ шалгарч байжээ. Эцэг өвгөдийн захиасыг марталгүй цээжиндээ хадгалж, орсон гарсан бүхнийг ундалж, олныхоо дунд нэр бүтэн амьдарч яваа жирийн нэгэн өрхийн тэргүүн энэ хүний тухай цухасхан дурьдахад ийм буюу.

## ЭРДМИЙН ОРГИЛД ТЭМҮҮЛЭХ ИХ ХҮСЭЛ

**Б**огдын даншигт түрүүлж, “Хүнд” хэмээх цол хүртэж явсан Чадраабал мэргэний ач охин, Мандширын Должин захирлыг номынхоо хойморьт урин заллаа. МУИС-ийн бизнесийн сургуулийн дэд захирал, Монголын шинэ залуу эрдэмтэн докторуудын нэг, орчин цагийн дээд боловсролын салбарт өөрийн гэсэн зам мөрөө тодоос тод үлдээсэн М.Должин захирал бид хоёрын яриа ээж, аавынх нь тухай сайхан дурсамж, эгэл амьдралын түүхээс эхэлсэн юм. Түүний аав Ч.Мандшир Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Бадгийн амны уугуул. Харин ээж Найнгаагийн Шаарий Агтын голын эхэнд Ширээ хадны дэргэд төрсөн хүн. Уран Найнгаа хэмээх энэ хүнд Мөрөнгийн

хүрээ, Богдын хүрээнээс хүртэл захиалга өгч, түүгээр дээл хувцас хийлгэдэг байжээ. Чадраабал хүнд Богдын даншигт түрүүлж ирснийхээ дараахан нас барж, түүний хүү Ч.Мандшир бага насандаа өнчирч үлдсэн аж. Сайхан барилддаг, сум орондоо нэртэй хүндтэй явсан Ч.Мандшир гуай цэрэгт явахаасаа өмнөхөн гэргий авч, өрх гэр тусгаарлаад 20 гаруйхан хоногийн дараа цэрэгт явжээ. Цэргийн албанд яваад гурван жил болоход ганцхан удаа захидал ирүүлж байсан гэдэг. Удалгүй дайн болж, зургаан жил болоод халагдаж ирж байжээ. Ч.Мандшир гуай цэргээс халагдаж ирснийхээ дараа санхүүгийн түр курсст сурч, тус сумаас төрсөн анхны нягтлан бодогч нарын нэг. Төмөрбулаг, Рашаант суманд нягтлан хийж байгаад Мөрөн суманд Шүүхийн нягтлангаар томилогдож, тэтгэвэрт гартлаа нягтлан бодогчоор ажиллажээ. Ч.Мандшир гуайн том хүү Балдандорж аавынхаа санхүүгийн мэрэгжлийг эзэмшиж, аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн даргаар олон жил ажилласан. Тэгвэл Ч.Мандшир агсны ач хүү өвөөгийнхөө мэргэжлийг эзэмшихээр Монгол улсын Их сургуульд элсэн оржээ. Улсын олимпиадад олон удаа оролцож, Элсэлтийн Ерөнхий шалгалтанд аймагтаа хоёрт жагссан Балданамбын Мягмар хэмээх энэ хүү гурван үе дамжсан санхүүч болохоор сурч байна.

Ч.Мандшир, Н.Шаарий хэмээх энэ хоёр хүн туурга тусгаарлаж, өрх сунгаж, хоёр хүү, долоон охин төрүүлж өсгөсний хамгийн бага нь

М.Должин захирал. Хүний орчлонд хүн бүр өөрийнхөө хувь тавиланг өөрийнхөө түүх намтраар зурж үлдээхээр ирдэг гэдэг үг бий. Түүний ээж 47 настай, найман хүүхэдтэй байхдаа отгон охиноо гэдсэндээ олжээ. Олон хүүхэдтэй нас ахисан хойноо жирэмсэн боллоо хэмээн бусдын хэл аманд өртөхөөс эмээж, басхүү олноос санаа зовсон ээж нь хөл хүнд болсноо хэнд ч хэлсэнгүй. Цэцэрлэгт ажиллаж, ажлаа хийсээр явсан гэнэ. Нэг өдөр цэцэрлэгийнх нь эрхлэгч Цэнд-Аюуш гэгч эмэгтэй түүнийг өрөөндөө дуудаж “Та хөл хүндтэй юмаа даа. Ичиж санаа зовох хэрэггүй. Маргааш эмчид үзүүлээрэй. Би цаг авсан байгаа. Өглөө эмчид үзүүлээд ажилдаа ирээрэй” хэмээн хэлсэн гэдэг. Ийнхүү Мандширын Должин хэмээх энэ бүсгүй 1963 онд Мөрөн суманд төржээ. Хувь тавилангийн нэгэн сэжүүрт багтаж, хүн болон хорвоод мэндлэх гэж байхад нь хамгийн түрүүнд өөрт нь элгэмсүү сэтгэл гаргаж, ээжийг нь эмчид үзүүлж, сэтгэл санааг нь засаж байсан энэ тэр нэгэн эмэгтэйд М.Должин Их сургуулийн оюутан болсон хойноо хадаг барин золгож байсан гэдэг. Сайхан сэтгэлийн тус хэзээ ч багаддаггүй гэдэг энэ буюу.

Хөнгөн хүнсний үйлдвэрийн яамны орлогч сайд байсан Г.Гарамжав түүний ээжтэй ойрхон хамаатан. Түүнийг бага байхад Г.Гарамжав эгч нь зуныхаа амралтаар тэднийд ирж амарна. Тухайн үед Их сургуульд багшилж, философийн хичээл зааж байсан Г.Гарамжав гуайг хүн бүхэн хүндэлнэ. Аймгийн дарга хүртэл Гарамжав эгчтэй нь уулзахаар хар машинтайгаа ирж байгааг харсан жаахан охин бүр багаасаа л “Их сургуулийн багш болно. Багш багшдаа Философийн багш болно” хэмээн эргэлт буцалтгүйгээр шийдсэн гэнэ. М.Должин 1982 Мөрөн хотын арван жилийн нэгдүгээр сургуулийг төгсжээ. Тэр жил 10-р ангийг 300 гаруй хүүхэд төгсч байсан бөгөөд тэднээс ердөө л долоон хүүхэд онц дүнтэй сургуулиа төгссөний нэг нь М.Должин. Тэрээр багын мөрөөдлөө биелүүлж чадсан азтай, одтой хүмүүсийн нэг. Учир нь М.Должин аравдугаар ангиа төгсөж, Монгол Улсын Их сургуулийн философийн ангид элсэн оржээ. Их сургуулийн философийн ангид суралцаж, онц сурч, нэмэлт цалин авдаг байсан охин сургуулиа төгсөж, Хөдөө аж ахуйн их сургуульд багшлах томилолт авч байсан гэнэ. Тэрээр хөдөө аж ахуйн сургуульд гурван жил философийн хичээл зааж байгаад Зах зээлийн коллежид Ерөнхий эрдмийн тэнхмийн эрхлэгчээр ажиллах урилга авчээ. Зах зээлийн коллеж хожим Худалдаа аж үйлдвэрлэлийн дээд сургууль, Худалдааны сургууль, Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургууль болон өөрчлөгдөж, шинэчлэгдэн зохион байгуулагдсан. Энэ л сургуультай тэрээр 24 жилийнхээ амьдралыг холбож, тэнхмийн эрхлэгчээс захирал болтлоо дэвшжээ. Өнөөдөр тэрээр Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн дэд захирлаар ажиллаж байна. Зах зээлийн коллежийн анхны докторын нэг нь М.Должин. Тэрээр 2001 онд шалгалтанд орж, Ельциний тэтгэлэгт хамрагдаж, аспирантурт сурч, “Иргэншил бол философийн анторфлогийн асуудал мөн” сэдвээр Москвад докторын зэрэг хамгаалжээ. Түүний үеийнхнээс ихэнх нь арилжаа наймаа хийж, зах зээлд хөл тавьж хувийн бизнес эрхлэж, компани байгуулсан. Харин М.Должин хэмээх энэ хүн багынхаа мөрөөдлийг орхиогүй. Олон олон шавь нартаа, тэднээрээ хүндлүүлж тэдэндээ зааж сургасан эрдэм

мэдлэг ихтэй, их сургуулийн багш болох мөрөөдлөө тэр биелүүлж, үүндээ ч үнэнч үлдсэн юм. М.Должин захирал Германчуудтай хамтран Монголын дээд боловсролын чанарын менежмент төслийн зохицуулагчаар ажиллаж, сургалтын шинэ модуль бий болгох сургалтын шинэ ангиуд бий болгох судлагааны ажлуудыг багш нартайгаа хамтран хийжээ. Боловсролын болон худалдааны тэргүүний ажилтан цолтой энэ бүсгүй 2014 онд “Алтан гадас” одонгоор шагнуулсан юм. Эрдэм мэдлэгт орой үгүй. Гэхдээ энэ л оргилд гарах гарц, хөтлөх хөтөч нь багш нар байдаг. Мянган, мянган эрдэмтэдийг бэлтгэж, олон зуун залуусыг амьдарлын их аянд хөтлөж яваа эрдэмтэн, багш нарын нэг М.Должин захиралтай ярилцаж суухад эрч хүч, басхүү хийж бүтээх асар их зориг тэмүүлэл нэвт мэдрэгдэж байсан юм. Тэрээр 90 жилийн түүхтэй, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн хоолны салбарын 40 мянга гаруй боловсон хүчнийг Монголд бэлтгэсэн арвин баялаг туршлагатай Монголын худалдааны сургуулийг хэвээр нь авч үлдэхийн төлөө эрх мэдэлтэн, албан тушаалтан сайд дарга нартай ч сөргөлдөж, гашуун ч гэсэн үнэн үгээ Монголын төрд хүргэхийн төлөө тууштай тэмцээр ирсэн. Үнэн хэзээд ялдаг. Монголын боловсролын шинэчлэлтийг бодитойгоор хийхийг эрмэлзэж байгаа М.Должин захирлын үг төрд хүрч, түмэнд тус болно гэдэг нь дамжиггүй.

## ИХ ТАЙГЫН ЭЗЭН

Үүл нөмөрсөн уулсын орон, үлгэр шивнэсэн домгийн өлгий, тэнгэрт ойрхон ургадаг цэцэгсийн нутаг, Төмөрбулаг сумаас бизнесийн олон алдартнууд төрж гарсны нэг нь “Хөвсгөл Их тайга” компанийн захирал Шагдарын Сувд. Түүний эцэг өвгөд тус сумын Тээлийн хүмүүс. Ш.Сувд гуайн аав Л.Шагдар цэрэгт татагдаж, эх орныхоо төлөө тангараг өргөн, батлан хамгаалах салбарт зүтгэж эхэлжээ. Тэрээр эх орны дайны үед Батлан хамгаалах яаманд арын албаны дарга хийж, хошууч цолтой болтлоо зүтгэж байжээ. Батлан хамгаалах яамны арын албаны дарга байсан энэ хүн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд чийчаан хөлөглөн анх очиж, тус сумын нутаг дээр хөнгөн тэрэгний мөрийг анх гаргаж явсан гэдэг. Л.Шагдар гуай хожим Завханы Тосонцэнгэлд ажиллаж, Хөвсгөл аймгийн сэргийлэхэд алба хааж байжээ. Түүний охин Ш.Сувд 1956 онд Мөрөнд төржээ. Аравдугаар ангиа Мөрөнд төгсөж, Багшийн дээд сургуульд сурах хуваарь авч, орос хэлний багшийн мэргэжил эзэмшээд Хүнсний технологийн сургуульд 1995 он хүртэл багшилжээ. Монгол улс зах зээлд шилжээд удаагүй, картын бараанаас дөнгөж л гарч, хаа сайгүй хүнсний хомсдол бий болж байсан цагт Ш.Сувд зүгээр гар хумхих суухыг хүссэнгүй. Нөхөртэйгээ ярилцаж тохирч, цаашид хийх ажлаа төлөвлөсөн гэнэ. Түүний нөхөр Эрхүүгийн хөдөө аж ахуйн дээд сургууль төгссөн агротехникч, биологич мэргэжилтэй учраас хийх ажил ч ихтэй, яаманд шаггүй өндөр алба хашиж байжээ. Гэвч гэргийгийнхээ хийж бүтээх ажлыг дэмжсэн нөхөр нь Байгаль орчны яамны эрдэм шинжилгээний газарт, Агнуурын секторын эрхлэгчийн алба хашиж байснаа орхижээ. Ш.Сувд захирал арав гаруй жил зүтгэсэн багшийн ажлаа орхиж, 1997 онд унаж байсан жижиг тэргээ зарж, “Газ-66” машин худалдаж аваад л төрж өссөн Хөвсгөл нутгаа зорьжээ. Бэлэн ажил, өндөр цалин, басхүү дулаан байр орон, үр хүүхдээ ч хаяад энэ хоёр хүн ууланд гарахдаа орос хэл дээр бичигдсэн хэдэн номтой л байсан гэдэг. Монголд ургаж байгаа ургамлуудыг судлах, Монгол цайг бий болгохыг зорьсон тэдний ажил тийм ч амар хялбар байгаагүй. Хөвсгөлийн Улаан-Уул суманд очиж, бүхий л тайгаар явж ургамал судлаж байжээ. Ахмадуудтай уулзана, ямар ургамал хаана байгааг асууж лавлана, орос номонд бичигдсэн ургамлын нэр монгол нэршлүүд нь зөрөөтэй байна. Энэ бүхний учрыг олох гэж асар их судлагааны ажил хийжээ. Ургамлуудаа таньж мэдээд зогссонгүй. Ямар ургамал ямар чанартайг судлах, хоорондынх нь нийлэмж чанарыг тогтоох, хүний биед хэр зохимжтойг шинжлэх асар их эрэл





## БОГД ХААНААС ОТОГ ЖИНС ХҮРТСЭН ЭРХИЙ МЭРГЭН

Төв ази, түүний дотор Монголын өргөн уудам нутагт оршин амьдарч байсан хүмүүс нум сумыг амьдрал ахуйдаа олон мянган жилийн тэртээгээс эхлэн хэрэглэж иржээ. Нум сумыг амьдрал ахуйдаа ч, дайн тулалдаанд ч монгол эр тэр ч байтугай бүсгүй хүн ч чадамгай эзэмшдэг байсан гэнэ. Монгол үндэсний сурын харвааны түүх нь үндсэндээ монголчуудын дунд Булцуут сумаар арьс шир болон суран бай харваснаас эхлэлтэй гэж болох юм. Өөрөөр хэлбэл нум сумыг ан агнуур, цэрэг дайны, зэвсгийн зориулалтаас гадуур хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх, цэрэг эрсийн харваж намнах, ур чадварыг хөгжүүлэх, шалгаруулах зорилготойгоор бай харваж наадах, тэмцэх үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн түүхтэй. Манжаас тусгаарлах хүртэлх хугацаанд Монголчууд нум сумыг зэвсгийн чанартай хэрэглэхийг больсон бөгөөд 1911 онд манжийн төрөөс сурын харвааг өргөнөөр зохион байгуулахыг хориглож зөвхөн баяд, ноёдын найр наадам, овоо тахилгад сур харвахыг зөвшөөрч ирсэн учир эрдэмтэн зохиолч О.Намнандорж “Манж улсад дагаар орсноос хойш үндэсний биеийн тамирын чухал сурлага бүрэн унтрав” гэж тэмдэглэсэн байдаг. Манжийн хааны ноёрхолыг эсэргүүцэн тэмцэж, хэдэн зууны турш тусгаар тогтнолынхоо төлөө амь насаа зольж явсан баатарлаг Хотогойд түмний үр сад Далай гүний хошуу эрхий мэргэн харваачид олонтой байжээ. Тэдний нэг нь Гүнсэнгийн Чадраабал хэмээх хүн түүхийн шар хуудсанд өөрийнхөө нэрийг мөнхлөн үлдээжээ. Г.Чадраабал нь зэргэлдээ аймаг, хошуудын наадамд олон удаа түрүүлж байсан алдартай мэргэн харваач байсан учраас хошууны ноён 1921 онд Даншиг наадамд авч явсан байна. Даншигт очоод олон аймаг, хошуудын мэргэчүүлтэй цэц булаалдан харвасаар төрүүлж, халх даяар нэр нь алдаршжээ. Ингээд Богд эзэн хаанаас Г.Чадраабалд “Гэрэлт цагаан одтой” отог жинс, “Хүнд” гэдэг хэргэм зэрэг шагнаж, Улсын мэргэн цол олгож дээлийн үүлэн хээтэй торго дагалдуулж байсан гэдэг. Энэ цагаас хойш мэргэн харваач Чадраабалыг “Хүнд” гэж өргөмжилдөг болжээ. Харснаа харвадаг, харваснаа алддаггүй түүнийг нум сумаа татаж зогсохыг үзсэн хэний ч сэтгэлд үлгэрийн жинхэнэ баатар эрийн бодит дүр амилан бууж, жинхэнэ монгол эрийн баатарлаг сүр жавхааг бишрэн бахдах сэтгэл төрдөг байсан тухай номын шар хуудаснаа тэмдэглэгдэн үлджээ. Тооно шүргэх шахам өндөр гуалиг нуруутай бахиад том эр алган дээрээ мөнгөн аягатай дарс тогтоон барьж “Хүрэн толгойн сүүдэр” хэмээх алдарт дууг цээл хоолойгоороо уянгалуулан өрх гэр ам бүл нэмж нутаг хошуунд бороо элбэгшихийг ерөөж байсан тухай дурсамж яриа Өвөр зүүн багийнханд өдгөө хүртэл уламжлагдан иржээ. 1923 онд засаг ноён нь хүч бярааг омог нь ид жагссан түүнийг Богдын даншиг наадамд дагуулж явахаар дуудахуйд сайхь эр олдож өгөхгүй байсаар, наадамчид мордохоос хоёрхон хоногийн өмнө морилж, банга хүртсэн ч гэсэн шөнө зулын гэрэлд

хорин сумнаас арван ес онож ид бахаа гайхуулан засаг ноёныхоо магнайн үрчлээг тэнийлгэн, хийморийг нь сэргээж бардам зангийг нь хөдөлгөж байсан гэдэг. Тэр жилдээ Их хүрээнээ болсон Даншиг наадамд олон аймаг хошуудын мэргэчүүлтэй цэц булаалдан наадаж, магнайдаа тоос буулгалгүй харвасаар түрүүлж, Халх даяар алдар суугаа түгээжээ. Гэвч даншиг наадамд явж ирээд удалгүй ид залуу насандаа өөд болсон тухай өнөөдөр түүний ач, зээ нар дурсан ярьж байна. Эвэр нумаа эвшээлгэн татаж, эрхий мэргэнээ халх даяар гайхуулж явсан энэ хүний тухай

Хувьтай төрсөн “ХҮНД” нь хө

Хошуу дамжин шагшигдаваа хө

Заяатай төрсөн “ХҮНД” нь хө

Засаг дамжин шагшигдаваа хө гэсэн дуу хүртэл гарч, хотол даяар нэр алдар нь түгж байжээ.

## ЭРТ БУЦСАН ЗАЛУУ ЭРДЭМТЭН

**М**онголд загас судлалаар мэргэшсэн, басхүү эрдмийн зэрэг цол хамгаалсан хүн хуруу дарам цөөхөн гээд хэлчихэд нэг их буруудахгүй. Тэдний нэг нь Төмөрбулаг сумын бэр “загасны” хэмээн олондоо танигдсан эрдэмтэн доктор А.Дулмаа. 1958 он ЗХУ-ын Байгал нуурын загас үржүүлгийн үйлдвэрээс 14 сая орчим омуль загасны авгалдай авчирч Хөвсгөл нуурт нутагшуулснаас эхлээд загасгүй байсан 21 нуурыг загасжуулах ажлыг биечлэн хийсэн. ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Загас үржүүлгийн эрдэм шинжилгээний төвийн судлаач, академич, шинжлэх ухааны гавьяат ажилтан, доктор, профессор Аюурын Дулмаа гуайг мэдэхгүй, танихгүй хүн ховор биз ээ. Түүнийг Ерөнхий сайд асан С.Баярын ээж гэдгээс нь илүү “загасны” Дулмаа гэдгээр нь андахгүй. Шинжлэх ухаанд 50 гаруй жил чин сэтгэлээр зүтгэж яваа энэ хүний шавь нарынх нь нэг, биологийн ухааны доктор М.Эрдэнэбат тэгвэл бас л Төмөрбулаг сумын уугуул. Манчингийн Эрдэнэбат хэмээх энэ хүн 1964 онд Мөрөн суманд төржээ. 1983 онд Мөрөнгийн арван жилийн нэгдүгээр сургуулийг төгссөн хүү тэр үеийн ЗХУ-д онд Загас судлалын дээд сургуульд загас судлаач, үржүүлэгчийн ангид суралцжээ. А.Дулмаа докторын загас үржүүлгийн ажил үр дүнтэй, басхүү Монголд загас үржүүлж, үр шимийг нь хүртэж болох юм байна гэдэг тооцоо судлагаа гарсан учраас тухайн үед Загас үржүүлгийн чиглэлээр хүн нэмж сургах, загаснаас олох үр ашгаа нэмэгдүүлэх гэж төлөвлөж байсан учраас бодлогоор энэ ангид хүүхэд сургаж байсан хэрэг. М.Эрдэнэбат ЗХУ-ын загас судлалын дээд сургуулийг 1989 онд төгсөж ирсэн байна. Тэрээр сургуулиа төгсөж ирээд Дархадын хотгорт таван жил ажиллажээ. Тул зэвэг болон агнуурын загас үржүүлэх боломжийг судлах, техник технологи боловсруулж байсан энэ залуу Байгаль орчны яамны ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэн, Ой ан судлалын хүрээлэн, Шинжлэх ухааны академийн эзобиологийн хүрээлэнд хориод жил ажиллаж, 2006 онд ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Москва дахь Экологи ба түүхэн хөгжлийн хүрээлэнд “Монгол орны Сэлэнгийн сав газрын зохицол бүрдлэл хүний үйл ажиллагаа байгальд хэрхэн нөлөөлж буй нь” гэсэн сэдвээр докторын зэрэг хамгаалсан юм. Загас судлаачаар



хорь шахам жил ажиллаж, Орос Монголын биологийн хамтарсан экспедиц, АНУ-ын Их сургуулийн эрдэмтэдийн загасны чиглэлээр хийж байгаа судлагааны ажилд хамтран оролцож байжээ. Энэ залуухан эрдэмтэн Монголд байгаа тул загасны нөөцийг тогтоож, Идэр гол, Эг, Үүрийн гол, Дэлгэрмөрөн, Чандмань-Өндөр сумын гол мөрнүүдэд ажиглалт судалгаа хийж, тул загаснуудад



радио тэмдэгт тавьж, мэдрэгчийн тусламжтайгаар энэ загасны шилжилт хөдөлгөөн, нүүдлийг тогтоож байжээ. Монголын усны амьтан судлалд хүч, оюун ухаанаа зарцуулсан цөөн тооны эрдэмтдийн нэг М.Эрдэнэбат мэргэжил нэгтнүүдтэйгээ хамтран Дэлхийн банкнаас Хүрээлэн буй орчны шинэчлэлд зориулсан Нидерланд-Монголын Итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр Монголд анх удаа “Монгол орны загасны улаан данс” номыг хэвлэн олны хүртээл болгожээ. Энэ бүтээл монголд тархсан загасны 64 унаган зүйлд тулгараад байгаа бэрхшээл болон газар зүйн тархалтын талаарх боломжит бүх мэдээлэлийг багтаасан бөгөөд эдгээр загасны талаар сонирхолтой баримт тайлбар, зураг сэлтийг оруулж, цаашид өсгөж үржүүлэхийн тулд ямар арга хэмжээ авахыг хүртэл нарийн тооцоолж, судлагаа шинжилгээ хийх шаардлагатай гол мөрнүүдийн нэр, хамгаалахгүй л бол устаж үгүй болоход ойрхон байгаа загаснуудын талаарх мэдээлэлүүдийг багтааснаараа онцлогтой юм. Түүний энэ ном загасны талаарх ойлголтыг олон хүнд өгч, басхүү энэ салбарт зайлшгүй хамгаалалт тусламж дэмжлэг хэрэгтэй байгааг ч сануулсан бүтээл болж чаджээ. Үүнээс гадна тэрээр загас агнуурын нөөц бүхий гол нууруудад судлагаа шинжилгээ хийж, агнуурын хэмжээг тогтоож, үйлдвэрлэлийн зориулалтаар загас олборлох заламгайн тор зэргийн судлаж, Стандартчилал хэмжил зүйн газарт өгч байжээ. М.Эрдэнэбатын боловсруулсан энэхүү стандартын дагуу загас агнавал монголын нууруудын загас устаж алга болохгүй. Харин энэ хэм хэмжээг зөрчөөд хэлбэл нуур загасгүй болно гэдгийг ч мэргэжил нэгт нөхөд нь ярьж байсан юм. Монгол орны загас хамгааллын төлөвлөгөө боловсруулж, хорь гаруй жилийнхээ хөдөлмөрийг загас судлалд зориулж, олон тооны эрдэм шинжилгээний өгүүллэг, ном бүтээл гаргаж, гадаадын эрдэмтэдтэй хамтран ажиллаж явсан энэ хүн харамсалтай нв өнөөдөр бидний дунд алга. Цэл залуугаараа ертөнцөөс буцсан эрдэмтэн докторын нөхдийн хамт бичсэн “Монгол орны загасны улаан данс” харин өнөөдөр олон хүний ширээний ном болон үлджээ.

## ТАВАН БААТРЫН ЭЭЖ

Төмөрбулаг сумын нутаг ус, энэ нутгийн ард түмний амьдрал ахуйг түүхийн хуудснаас эргэн харахад Бүгсийн хүрээ гэсэн нэр тодоос тод гарч ирдэг. Билгүүн номч Б.Ринчений судалгааны жагсаалтанд Бүрэнтогтох сумын Бүгсийн хүрээ нэрээр бичигдэн үлдсэн энэ хүрээг зарим ном сурвалжид Төмөрбулаг сумын Тээлийн хурал нэрээр тэмдэглэсэн байх нь бий. 1735 оноос 1938 оныг хүртэл 203 жилийн дотор 20 хамба залгамжлан суусан энэ том хүрээ хийд 1931 оны намар хаагдаж, 1932 онд дахин нээгдэж үйл ажиллагаагаа сэргээн явуулж байгаад 1937 оны сүүлчээс хаагдаж 1938 онд бүрэн шатаагдаж мөхсөн түүхтэй. Нартан барын Ганжуур



108 боть, Данжуур 242 боть, Цанидын таван гүн ухааны судрууд Жүдийн дацанд агь тарнийн, Мамбын дацанд анагаах ухааны олон ном судрууд залагдагдаж, сүсэгтэн олны хөлд дарагдаж явсан энэ хүрээ хийдтэй амь, амьдралаа холбосон олон мянган хүн бий. Тэдний нэг нь М.Норжмаа хэмээх эглээс эгэл ээж. Тэрээр 1942 онд Төмөрбулаг сумын нутаг, Донхор гэдэг газар Мятав гэдэг хүний том охин болон мэндэлжээ. Түүний аав Мятав бага залуудаа Бүгсийн хүрээнд шавилан сууж байсан бөгөөд хүрээ хийдийг шатааж, лам нарыг нь хөнөөж байх тэр л хатуу цагийн гэрч болж үлдсэн нэгэн. Мятав гуай насаараа холбооны салбарт ажиллажээ. Харин ээжийнх нь төрсөн ах С.Готов, дүү С.Сэнгээ хэмээх Бүгсийн хүрээнд шавилж байсан ном эрдэмтэй олон буурлууд байжээ. Харин М.Норжмаа гуай 1960 онд Анагаахын дээд сургуулийг эм найруулагч мэргэжлээр төгсөж, нутагтаа иржээ. Тэрээр Хөвсгөл аймгийн анхны мэргэжлийн эм найруулагчдын нэг. Тухайн цагт анагаах ухааны салбар хөгжлийнхөө гараанаас хөдөлсөн ч гэсэн сум дундын эмнэлэгүүд бэхжих төдий байж, хөдөөгийн малчдад хүрч үйлчлэх үүд хаалга нээгдээд удаагүй байсан үе. Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хомс, эм тариа ховор үед

М.Норжмаа гуай Хөвсгөл аймгийн эмийн конторт ажиллахаар томилолт өвөртлөж иржээ. Тухайн үед Эмийн конторт ажиллах мэргэжлийн хүн ховор учраас ажил ихтэй. Эм тан өнөөгийнх шиг сав баглаа боодолгүй, том том хайрцаг савтай ирдэг байсан гэнэ. Тиймээс эмийг жижиглэн боож, бэлтгэнэ. Өдөрт нэг хүн хэдэн мянган эм боох ч энүүхэнд байж. Үүнээс гадна усан эм байнга найруулах хэрэгтэй болно. Усаа өөрсдөө нэрж, хуурай эмүүдийг гараар хэмжин найруулна. Шилээ мөн л гараар угаах ариутгаад савлах шаардлагатай болно. Бүхий л зүйлийг гараар хийж, аймаг сумын эмнэлэг, эмийн сангуудыг эмээр хангах ажлыг тухайн үед эм хангах контор хариуцан ажиллаж байх үед тэрээр ид ажиллаж байжээ. 1979 онд аймгийн эмийн сангуудыг удирдах конторын дэргэд байгалийн түүхий эдээр эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гален цех байгуулагдав. Энэ цехэд чацаргана, алтан гагнуурын ханд, хусны шүүс зэрэг эмийн болоод витаминт шүүс бэлтгэх ажилд ч гар бие оролцсон ахмадуудын нэг нь М.Норжмаа гуай. Тэрээр өвгөнтэйгээ ханилаад 50 гаруй жилийн нүүрийг үзжээ. Энэ хооронд таван сайхан хүү төрүүлж өсгөсөн буянтай ээж. Т.Болдбаатар, Т. Нямбаатар, Т.Хүчитбаатар, Т.Батбаатар, Т.Хадбаатар гээд таван “баатар” эр өдгөө бүгд баялаг үйлдвэрлэдэг барилга, зам анги, тээврийн салбарт ажиллаж байна. М.Норжмаа гуай 18 ачтай, 18 ачаа бүгдийг нь өсгөлцөж өгсөн ачтай эмээ. Ач нараа дагуулаад зуслангийн байшин руу явж байхад нь тааралдсан хүн “Та цэцэрлэгт ажиллаж байгаа юм уу” хэмээн асууж байсан ч удаатай гэнэ. Ийм л нэг буянтай ээж өнөөдөр үр ач нараа тойруулан энх тунх амьдарч сууна. Түүний аав С.Мятав, ээжийнх нь ах Мөрөнгийн хүрээний хамба лам С.Готов тэргүүтэй лам ах нар нь 1990 оны эхээр сүсэгтэн олны дэмжлэгтэйгээр анх Бүгсийн хүрээг сэргээн байгуулсан түүхтэй. Шинэ сүмийн зүүн урд 30 орчим метр зайд 1,5 метр өндөр пайлуур чулуун дээр Бүгсийн хүрээг сэргээсэн тухай 1992 оны 08-р сарын 12-ны үйл явдлыг худам монгол бичгээр тэмдэглэн үлдээсэн байна.



М.Норжмаа гуай алдарт эхийн одонтой, мөн бүх таван жилийн гавшгайч цолтой, Эрүүл хамгаалахын тэргүүний ажилтан.

## САЙХАН ДУРСАМЖ БҮТЭЭГЧ

**А**ялал жуулчлал дэлхийн эдийн засагт тэргүүлэх байр суурь эзэлдэг гол салбар. Харин Монголчууд аялал жуулчлалын гол бүс нутгаа Хөвсгөл аймаг хэмээн тодорхойлоод удаж байна. Гэвч дэд бүтэц сул хөгжсөн, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал хязгаарлагдмал, үйлчилгээний чанар, түвшин сул, үзвэр, үйлчилгээний хөгжил муу зэрэг олон шалтгаанаас үүдэн энэ салбар Монголд тэргүүлэх салбар болон хөгжиж чадахгүй байгаа. Энэ салбарт олон арван бизнесменүүд хүч үзэхээр зориг шулуудан орж ирдэг ч хүнд хэцүүг нь гайхан эргэж буцаж шантрах нь бий. Тиймээс ч өнөөдөр аялал жуулчлалын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа цөөхөн бизнесменүүд хөл дээрээ зогсож чадсан юм. Тэдний нэг Мятавын Амаржаргал. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул энэ бүсгүй 1958 онд төржээ. Мөрөнд 10 жилийн сургуулийн төгсөөд Чехэд Химийн технологийн инженер мэргэжил эзэмшсэн М.Амаржаргал Арьс ширний үйлдвэрээс ажлын гараагаа эхэлж байсан гэнэ. Чехийн тоног төхөөрөмжтэй байгуулагдсан арьс ширний том үйлдвэрт мастераас эхлээд технологич инженер Химийн тасгийн инженер, цехийн даргаар ажиллаж байсан энэ бүсгүй арьс шир боловсруулах, өнгө будагт оруулах туршилтууд, эрдэм шинжилгээний ажил хийж явсан түүхтэй. Гэвч Монгол улс зах зээлд шилжиж, 1990 он гэхэд 17 үндсэн үйлдвэр 13000 ажиллагсадтайгаар жилд тухайн үеийн ханшаар 800,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг гаргадаг байсан том салбар тарж бутарч эхэлжээ. Тиймээс М.Амаржаргал хувийн хэвшилд ажиллахаар зориг шулуудаж, 1992 оноос эхлээд “Хөвсгөл жуулчин” компанийг нөхөртэйгээ хамт үүсгэн байгуулжээ. Хөвсгөл аймагт анхны аялал жуулчлалын бизнесийг эхлүүлж байсан М.Амаржаргал Аялал жуулчлалын яаманд Аялал жуулчлалын мэргэжилтнээр ажиллаж аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого шийдвэрийг тодорхойлох үйлсэд ч гар бие оролцож байсан удаатай.

Тэрээр өнөөдөр Чех Монголын хамтарсан “Эн гол зооот” компанийн захирлын алба хашиж байна. Жуулчны компани байгуулна гэдэг амар бус. Монгол орны нүүр царай болон зочдоо угтаж, үдэж, дайлж цайлж амраана гэдэг тун ч ярвигтай. Хүний амь нас эрүүл мэндийг хариуцаж ажиллана. Жуулчны компаниудын үйл ажиллагаанаас Монгол оны нэр төр хамаарна. Үүнийг л яс махандаа шингэтэл ойлгож чадсан хүн энэ бизнест амжилт олж чаддаг. Тэдний нэг нь Мятавын Амаржаргал хэмээх энэ бүсгүй. Хэдэн жилийн өмнө жуулчид нар, элс, ус буюу далайн эргүүдээр Хавай гэх мэт газруудыг зоридог байлаа. Харин 2000 оноос хойш дэлхийн жуулчлалын хандлага хүний гар хүрээгүй, онгон зэлүүд байгалтай газрууд руу чиглэх болсон. Ийм газруудын тоонд Монгол орон зүй ёсоор орж байгаа. Дээрээс нь Аялал жуулчлал гэдэг маш энэрэнгүй бизнес. Хэзээ ч үзүүлдэг харуулдаг зүйлээ муухай болгодоггүй. Аль болох мод, цэцэг маань ургаасай, гол горхи маань битгий дундраасай, музей маань улам баялаг үзмэртэй болоосой гэж сайн сайхныг л хүсдэг. Үүнийгээ л харуулж мөнгө олж байгаа учраас ингэж хүсэхээс арга байхгүй. Нэг жуулчинд үйлчлээд тур оператор 100 доллар авлаа гэж бодоход 30 нь ресторанд, 20 нь баазад, 20 нь хөтөчид, 10 нь морь, тэмээгээ унуулсан хүнд, 20 гандан хийдийн хандив, музей, урлагын тоглолт гээд маш олон зүйлд тардаг. Дээр нь байр, цахилгааны мөнгөө, татвараа төлдөг. Тиймээс ч нэг жуулчин ирэхэд 20 хүн ажлын байртай болдог гэсэн дэлхийн аялал жуулчлалын байгууллагын судалгаа байдаг аж. Тийм ч учраас дэлхийн улс орнууд аялал жуулчлалын бизнесийг тэргүүлэх зэрэгт тавьдаг. Харин манай орны хувьд аялал жуулчлалын бизнес хөгжиж эхлээд удаагүй, хүндрэл бэрхшээл ихтэй. Гэхдээ энэ бүгдээс М.Амаржаргал няцаж шантарсан нь үгүй. Түүний Чехүүдтэй хамтран байгуулсан компани Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэд хоёр, Рашаантад нэг жуулчны баазтай. Жилдээ 150 гаруй жуулчин хүлээж авдаг аж. Морин аялал, явган аялал, спорт аялал гээд олон хөтөлбөртэй. Жуулчдын амь нас, аюулгүй байдлыг хангах, ая тухтай нөхцөл байдал бүрдүүлэхийг тус компанийнхан юу юунаас илүүтэй эрхэмлэж ажилладаг. Тиймээс ч нэг ирсэн жуулчин заавал эргэж ирдэг гэнэ. Сүүлийн 10 гаруй жилийнхээ амралтыг тус компанитай хамт өнгөрүүлж байгаа жуулчид ч олон аж. Аялал, амралт гэдэг хүний сэтгэлд дурсамж болон үлддэг. Тийм учраас Монголын тухай, монголчуудын тухай тэр л сайхан дурсамжийг гадныхны сэтгэл зүрхэнд шигтгэн үлдээхийн төлөө тэрээр бүхий л анхаарлаа хандуулж ажилладаг гэнэ.

## ТАВИН ЖИЛИЙН ХҮЛЭЭЛТ

**А**лдуурч одсон цаг хугацааны мөрөөр алхаж, өнгөрсөн 90 жилийн түүхийг сөхөж, өчигдөр өнөөдрийн тухай дурдатгал цуглуулан олон, олон хүнтэй уулзаж явахад инээд хөөр, гуниг харуусал, басхүү алдаа онооны тухай олон, олон намтар түүх сонсож байсан юм. Надтай уулзсан хүн бүхэн нутаг усаа, ижий ааваа дурсан өгүүлнэ. Үнэхээр ч хүний нутаг гэдэг эцэг эхийнх нь адил зүрх сэтгэлд нь хоногшин үлддэг аж. Тэдний нэг нь Лувсангэндэнгийн Шагдарсүрэн. Тэрээр 1925 онд төржээ. Түүний аав Лувсангэндэн маарамба хэмээх нутаг орондоо хүндлэгдсэн энгийн нэгэн байжээ. Судас барьдаг, эм тан өгдөг, зовсон зүдэрсэн ядарсан олонд ач буянаа түгээсэн энэ хүн олон хүүхэдтэй, нам төрийн бодлоготой зохицож, хувьсгал ялсны дараа хүрээнээс хол хөндийхөн сууж, үр хүүхдээ өсгөж явсан нэгэн. Тэрээр хүүгээ 10 нас хүрэхэд Мөрөнгийн хүрээ рүү ном эрдэм сургахаар өөрийн биеэр хүргэж өгчээ. Арваадхан настай жаахан хүү аавыгаа дагаж Цагаан бургасны даваагаар давж байхдаа чонотой тааралдсан гэнэ. Аав нь



-Хүү минь чоно уу, үнэг үү? Чоно таарвал уг нь зүгээр. Үнэг бол муу даа гэхэд дүрсгүй жаахан хүү

-Үнэг л байна. Үнэг тааралдсан хэмээн хэлж. Аав нь нэг их зүйл ч хэлсэнгүй. Энэ бол аавтайгаа өнгөрүүлж байгаа хамгийн сүүлчийн өдрүүд гэдгийг тухайн үед балчирхан хүү яаж ч мэдэх билээ. Хүүгээ Мөрөнгийн тэнхимд оруулж өгснөөс хойш аав нь удалгүй баригджээ. Эсэргүүний хэрэгт холбогдон сураг алдарч, ээж нь найман хүүхдээ ганцаараа өсгөж, Шагдарсүрэн эрдэм номын мөр хөөжээ. Тэрээр долдугаар ангиа 1943 онд төгсөж, Их сургуульд орж, багш болжээ. Шаггүй сайн сурч, Сүхбаатар аймагт багшаар томилогдож байсан гэнэ. Тэнд ажиллаж байтал Боловсролын яамны Шаравнямбуу сайд Сүхбаатар аймагт томилолтоор очихдоо түүнийг дуудаж, “Чи яагаад яаман дээр дуудаад байхад ирдэггүй хүн бэ” хэмээн загнаж, буцахдаа залуу багшийг машиндаа суулгаад хотод дагуулж ирж байсан гэнэ. Багш нарын гэрт төмөр орноос өөр эд хогшилгүй, ямааны арьс дэвсээд л шинэ амьдрал эхэлжээ. Боловсролын яаманд байцаагчаар ажиллах томилолт авсан ч гэсэн тэрээр “Байцаагч нар байнга хөдөө явдаг юм байна. Надад сольж өмсөх хувцас ч алга” хэмээн сайдаасаа гуйж байж Улаанбаатар хотын 2-р 10 жилд багшлаж эхэлжээ. Гэвч удалгүй тун муу мэдээ дуулж, залуухан багш нутаг буцахаас өөр аргагүйд хүрсэн гэнэ. Эсэргүүний ар гэрийнхэн гэж захчилдаг нутгийн танхай этгээд дээрэм хийж, хоёр ч дүүгийнх нь амийг хөнөөсөн аймшигт хэрэг гарчээ. Тэрээр ар гэрийн гачигдалтай тул Мөрөнд ажиллах боломж олгооч гэдэг хүсэлт гаргаж, Хөвсгөл аймагт багшилж, Боловсролын хэлтэст зааварлагч хийж байжээ. Гэвч 1962 онд Боловсролын яамнаас дахин дуудаж, тэр үеийн Намын төв хороонд Хянан шалгах комисст соёл гэгээрэл, эмнэлэг хариуцсан байцаагчаар томилжээ. Ийнхүү тэрээр 1962

оноос эхлэн тэтгэвэртээ гартлаа Намын төв хороонд байцаагч, ахлах хянан байцаагчийн алба хашжээ. Намын төв хорооноос 1965 онд улс төрийн хэрэгт холбогдсон хүмүүсийн хэргийг эргэн шалгах шийдвэр гарч, комисс байгуулахад тэрээр комиссын гишүүнд сонгогдсон гэнэ. Хорь гаруй жилийн тэртээ сураг алдарсан аавыгаа эрж хайх боломж олдсонд баярласан залуу Дунбүрээ генерал дээр өөрийн биеэр орж учир байдлаа хэлж, аавыгаа хайж байгаагаа дуулгахад генерал

-Архивт байгаа материалуудыг үзэж болно. Гэхдээ нэг ч материал хуулж авч болохгүй, зөвхөн тархи толгойдоо л хадгал гэж хэлжээ. Тэрээр олон өдөр олон янзын материал ухаж байж аавынхаа нэрийг олжээ. Мөрөнгийн хүрээний Жигжид хамбатай үгсэн хуйвалдсан. Хувьсгалын эсэргүү зүйл хийсэн гэсэн хэдхэн мөр өгүүлбэр доор цаазаар авах хүмүүсийн нэрийг хэдэн хуудас дамнуулан жагсаан бичсэн байж. Энэ жагсаалтанд аавынх нь нь нэр байж, баривчлагдснаасаа хойш ганцхан сарын дараа буудуулсан гэдгийг тэрээр хорь гаруй жилийн дараа л мэджээ. Эр нөхрөө хэцүүхэн хэрэгт холбогдож сураг алдарсны дараа аргаа барсан ээж нь лам хар бөө удган, үздэг хардаг, мэргэлдэг гэсэн бүхэнд хандаж байжээ.

-Нөхөр чинь сайн байна. Амьд мэнд явна. Хэзээ нэгэн цагт уулзна гэсэн үгэнд итгэж, хүлээж суусан ээждээ тэр энэ үнэнийг хэлж чадсангүй. Нас дээр гарсан ээж нь хүүгээ байн, байн шахна. Чи том газарт ажилладаг хүн. Аавыгаа сураглаад үзээч гэж аргадна, гуйна, заримдаа зэмлэнэ.

-Ээж минь надад мэдэх, мэдэхгүй зүйл гэж байна. Хамаагүй асууж сураглаж болохгүй байна хэмээн арга саам хэлсээр тэрээр 1989 онтой золгожээ. Улс төрийн хилс хэрэгт холбогдосдыг цагаатгах ажил орон даяар эхэлсэн тэр үед л Л.Шагдарсүрэн ээждээ нөхөр нь буудуулж нас барсан гэдгийг хэлсэн гэнэ. Эхлээд ээжийнхээ тэр их хүлээлт, итгэл найдварыг тасалж орхихыг хүсээгүй, хожим настай хүн хямарч бие нь чилээрхэнэ хэмээн бодож үнэнийг хэлж чадаагүйдээ Л.Шагдарсүрэн гуай өнөөдөр харамсаж явдаг гэнэ. Тавин жил гэдэг урт хугацаа... Тавин жил хүн хүлээж, санаж, бэтгэрч, үгүйлж шаналж амьдарна гэдэг ямархан хүнд даваа болохыг тэр сүүлд л ухаж ойлгосон доо хэмээн ярьж байсан юм. Хэрвээ би аавыгаа цаазлагдсан гэдгийг мэдсэн тэр үедээ л хэлсэн бол муу ээжийнхээ сэтгэлийг зовоосон 50 жилийн хүлээлтээс ядаж л талыг нь хасах байж дээ гэхдээ энэ азай буурлын хоолой чичирч байлаа. Ямартай ч түүний ээж нөхрөө 50 жил хүлээж, үр хүүхдийнхээ сайн сайхныг үзэж, нөхрөө цагаатгагдсан тогтоолыг хүлээж авчээ. Гэхдээ Монгол улсын дээд шүүх гэсэн толгойтой тэр алга дарам цаасан дээр бичсэн Цагаатгах тогтоол гэсэн гарчигтай цөөн хэдхэн өгүүлбэр бүхэл бүтэн айл гэрийг, найман хүүхдийн хувь заяа, тавин жилийн хүлээлт, хүний амьдралыг орвонгоор нь эргүүлсэн хэлмэгдүүлэлтийн төлөөс болон үлджээ гэж бодохоор нэг л гунигтай. Л.Шагдарсүрэн гуай 30 гаруй жил Намын төв хороонд ажиллаж, тухайн үедээ нам засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, таниулах ажилд хүчин зүтгэж явжээ. 1990 онд намын төв хороо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч байх үед тэрээр ээлжийн амралтаа авсан байсан гэнэ. Ээлжийн амралтын хугацаа дуусаж, ажилдаа орох гэтэл Төв хороо огцорсон байжээ. Ингээд л гавьяаныхаа амралтыг авч монгол бичиг заах ажилд оржээ. Улаанбаатар хотын захиргаа, Сүлжмэлийн үйлдвэр, Шинжлэх ухааны акдеми, Савхин үйлдвэрийн ажилчдад монгол бичиг зааж явсан гэнэ. Улсад 38 жил ажиллаж, төр нийгмийн ажилд зүтгэж явсан энэ хүн “Алтан гадас” одонгоор хоёр удаа, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор хоёр удаа шагнагджээ.

## ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ХОХИРОГЧ

**Н**эгэн хүний намтар нэгэн үеийн түүхийг өгүүлж, ахмад буурлууд маань өнгөрсөн цаг хугацаанд хэрхэн ажиллаж амьдарч, алдаж онож, улс төр нийгмийн амьдралд хэрхэн нөлөөлж байсан бэ гэдэг сонирхолтой мэдээллүүдийг энэ номноос олж хараасай хэмээн зохиогчийн хувьд хүссэн. Харамсалтай нь их олон хүний намтар түүх бүдэгрэн зарим нь устаж, алга болжээ. Гэхдээ зарим ахмадууд маань туулсан зам, өнгөрсөн амьдрал, хийж бүтээсэн үйл, нийгмийн амьдрал, ард түмний аж байдлын тухай дэлгэрэнгүй бичиж үлдээсэн байхтай таарч, олзуурхан хүлээж авч байсан юм. Тэдний нэг нь анагаах ухааны дэд доктор, Монголд хүүхдийн сэтгэцийн эмгэгийн шинжлэх ухааныг үндэслэгчдийн нэг, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул Боовонгийн Чойдог. Миний өмнө Боовонгийн



Чойдог гэдэг энэ хүмүүний дурсамж, гар бичмэл дурайж байна. Тэрээр 1937 онд Төмөрбулаг сумын нутаг Бадгийн аманд төржээ. Түүний аав Гэлэг-Очир хэлмэгдэн амиа алдаж, ээж нь өөд болж, хагацал зовлон үзсэн жаахан хүү ах дүү нараа бараадан амьдарч байжээ. Энэ хүн Төмөрбулаг сумын дунд сургуулийн анхны 60 сурагчийн нэг. Төмөрбулаг сумын сургууль тухайн үед Сампильн сайр гэдэг толгойн урд, шургааган хатгамал хашаатай, дотроо хичээлийн байр гэсэн том нэртэй хоёр жижигхэн гэртэй, захирал багшийнх, гал тогооны гэр гэсэн хэдэн гэр, жижиг цагаан байшинтай л байсан гэнэ. Эсэргүүний бослогын үеэр хоршоо шатаж, удалгүй их орны дайн эхэлсэн учраас бараа таваар тун ховор. Харандаа, дэвтэр гачигдалтай учраас шатсан хоршооны үнсийг ухаж, харандааны бал түүж, түүнийгээ модны голд хийн хичээлээ бичдэг байсан хүү сурлага сайтай нэгэн байжээ. Тэрээр дөрөвдүгээр ангиа онц төгсөж, дотуур цагаан өмд, шөөмөг гутлаар шагнуулж явсан байх юм. 1943 онд Төмөрбулаг суманд хүүхдийн халдварт өвчин гарч, олон хүүхэд нас барсан, үүний дараахан сумын дотуур байрны гадуур үнэг шиг юм гүйгээд байна. Дотуур байр шуламтай болсон гэдэг цуу тарж, сургуулийн багш нар чөтгөр шулам гэж байхгүй гэдэг ухуулга сурталчилгаа хийх ажилд гарч байсныг ч тэрээр дурсамж тэмдэглэлдээ бичиж үлдээжээ. Тэрээр 4-р анги төгсөхдөө мондалин хөгжим сайн тоглодог, Төмөрбулаг сумын иргэд түүний дарсан хөгжим дээр танц эргэдэг байж. Б.Чойдог Төмөрбулаг сумын бага сургуулийг төгсөж, Мөрөнд 10-р ангиа төгсөөд Улсын Их сургуульд

суралцах хуваарь авчээ. Хатуу хөтүү амьдрал, ядуу даржин байдал, хагацал зовлон түүний хүсэл тэмүүллийг мохоогоогүй юм. Харж хандах хүн цөөнтэй, өнчин хүү сургуульд явах зардал олох, ганц ч гэсэн шинэ хувцас авахын тулд туслах нябо хийж, сампин цохин, ачаа бараа зөөлцөж, гурван сар ажлаад 300 гаруй төгрөгтэй болж, ээжээсээ үлдсэн ганц морины мөнгөөр гутал авч өмсөөд Нийслэл Улаанбаатар хотыг зорьж байсан гэдэг. Тэрээр 1950 онд МУИС-ийн хүн эмнэлэгийн факультетад суралцаж 1955 онд төгсөөд Шинэ-Идэр суманд томилолт өвөртлөн очжээ. Тухайн үед Төмөрбулаг сум хүний бага эмчийн салбартай учраас Идэр, Зүрх, Бүрэнтогтох, Төмөрбулаг сумын эмнэлгүүдийг Шинэ-Идэр сумын хүн эмнэлэг хамаарч ажилладаг байж. Анагаах ухааны анхны мэргэжлийн эмч нарын нэг энэ хүн намтар түүхэндээ “Манай сумын эмнэлэг 1956 он гэхэд нилээд бэхжиж, Газ-66 машинтай болж, эм тариа ч овоо хангалттай байсан. Гэвч эмнэлэгт итгэх ард иргэдийн итгэл сул. Өөрийгөө хувилгаан эмч гэж нэрлэсэн Зундуй-Ендон гэгч хүн байнга айлуудаар явж, элдэв сурталчилгаа хийнэ. Араас нь явахаар зугатаад баригддаггүй байлаа. Мөн нутгийн олон Дуламжав бариач гэдэг хүнийг их сүсэглэнэ. Тэднийхээр байнга очино. Тиймээс орчин цагийн анагаах ухааны талаар суртал ухуулга их хийдэг байлаа” хэмээн бичиж үлдээжээ. Монголд мэргэжлийн эмч нар цөөн. Хэдэн эмч нар нь Эрүүлийг хамгаалах яамны харьяанд байдаг байсан тэр үед Б.Чойдог эмчийг Хатгал хотын хүн эмнэлгийн салбарын эрхлэгчээр томилох сайдын тушаал гарч, тэрээр Хатгалд томилогдон ажиллаж байжээ. Тэрээр 1959 онд Сүрьеэ өвчний рентген оношлогооны курст суух аймгийн дарга нарын шийдвэрээр хотод ирсэн ч хичээл нь эхлээгүй байжээ. Хичээл эхэлтэл Мэдрэлийн эмнэлэгт ажил гэсэн сайдын тушаал гарч, Б.Чойдог эмчийн ажил амьдрал Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагатай салшгүй холбогдсон юм. Ийнхүү Б.Чойдог эмч 1959 оноос Ардын уран зохиолч Сэнгийн Эрдэнэтэй хамт Туул голын хөвөөн дээр байрлах мэдрэлийн эмнэлэгт ажиллаж эхэлсэн байна. Б.Чойдог эмч 1964 онд тухайн үеийн ЗХУ-д хүүхдийн сэтгэл мэдрэлийн эмчийн нарийн мэргэжил олгох курст сурах томилолт авч, СССР-ын Эрүүлийг хамгаалах яамны харьяа, Снежевскийн клиникийн сэтгэл мэдрэлийн эмнэлэгт очин, оросын алдартай эмч нараар хичээл заалгаж, Монголын хамгийн анхны мэргэжлийн сэтгэл мэдрэлийн эмч болж байсан түүхтэй. Тэрээр сургуулиа төгсөж ирээд Мэдрэлийн больницын эмчилгээ эрхэлсэн орлогчоор томилогджээ. Эмнэлэг дээрээ анх сэтгэцийн өвчтэй хүүхдүүдэд зориулсан тасаг нээж, ЗХУ-ын мэргэжилтэн Гуктэй хамтран сэтгэцийн өвчтэй хүүхдүүдэд үзлэг хийж эхэлснээр Монголд хүүхдийн сэтгэцийн анагаах ухааны үндэс суурийг тэрээр тавьж байсан түүхтэй. Бидний “Шар хадны эмнэлэг” гэж нэрлэдэг Сэтгэл судлалын үндэсний төвийн байр шинээр ашиглалтанд ороход Б.Чойдог эмч 25 ортой хүүхдийн тасаг нээж, 1973 онд сэтгэл мэдрэлийн диспансер байгуулахад ажиллаж, хүүхдийн үзлэгийн кабинет анх байгуулж байжээ. Тэрээр эмчийн ажлын хажуугаар 1963-1977 Анагаах ухааны Их сургуульд багшилж, олон шавьтай болжээ. Үүний зэрэгцээ хангай бүсүүдийн хүүхэд, хүн амын дотор таталт өгч, ухаан балартах өвчин их байгааг ажиглан судлагаа хийж, 1978 онд “БНМАУ улс дахь хүүхэд өсвөр насныхны эпилепси, клиник, тархалт, судлагаа гэсэн

сэдвээр дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Сэтгэцийн эрүүл мэндийн талаар 20 орчим өгүүлэл бичиж, “Хүүхдийг сэтгэцийн өвнөөс сэргийлье” нэртэй номоо хэвлүүлж явсан энэ алдартай эмч 1978 оноос эхлэн Сэтгэц мэдрэлийн больницын зөвлөх эмчээр ажиллаж, 1981 онд “Алтан гадас” одонгоор шагнагдаж байжээ. Гэвч бүхий л амьдралаа хүн амын эрүүл мэндийн төлөө зориулж явсан энэ ахмад бас л хэлмэгдэн зовж, хилс хэрэг хүлээж, ял сонсож явсан байх юм. 1980-аад оны сүүлээр прокурор Л.Отгонбаяр “Шар хадны эмч нарын хэрэг” гэдгийг гаргаж ирж, арваад хүнийг ялласан. Энэ хэргийн бараан сүүдэр Боовонгийн Чойдог эмчийг тойрсонгүй дайрчээ. “Шар хадны эмнэлгийн эмч нар хулгай дээрэм, хүчин хийж, хүн алсан гэмт хэрэгтнүүдэд “Хэрэг хүлээх чадваргүй” гэсэн онош тавьдаг” хэмээн Л. Отгонбаяр прокурор буруутгаж, энэ магадлагаан дээр зөвлөх эмч тамга дардаг байсан гэж түүнийг гурван жилийн хорих ялаар хүртэл шийтгэж байсан байх юм. Хамгийн харамсалтай нь Б.Чойдог эмчийг 10 жилийн өмнө Доржбат гэгч хүний магадлан дээр гарын үсэг зурсан хэмээн буруутгаж ял оноожээ. Тэрээр Төв аймгийн Мөнгөн морьт суманд хоригдож, бүтэн жил модны ажил хийж, магадлангаар суллагдсан ч дахин нэг сар хоригдож байжээ. Хожим прокурор Л.Отгонбаярын хэрэг гэж нэрлэгдсэн энэ хэрэг хуурамч байсныг, хуулийнхан том хэрэг илрүүлсэн баатрууд болж албан тушаал ахиж дэвшихийн төлөө гэм зэмгүй олон эмч нарыг хэлмэгдүүлэн зовоож байсныг тогтоож, Б.Чойдог тэргүүтэй эмч нарыг Монголын төр цагаатгасан. Гэхдээ хийж бүтээх урам зориг, асар их тэмүүлэл, судалгаа шинжилгээний ажлууд хөсөр орхигдож, Монголын анагаах ухааны салбарт зүтгэж явсан олон эмч нар сэтгэлдээ ч, бие махбодидоо ч хүнд шархтай үлдсэн юм. Тэдний нэг нь Б.Чойдог эмч. Тэрээр амьд сэрүүн ахуйдаа өөрийн гараар бичиж үлдээсэн дурсамждаа “Хэдийгээр цагаатгагдсан ч гэсэн энэ хэргээс хойш миний биеийн байдал доройтож, ажлын чадвар ч алдагдсан байна. Тиймээс хүнд нөхцлөөр тэтгэвэртэй гарч, гэртээ суусан. “Оюуны хомсдол”, “Хүүхэд өсвөр наснуудын сэтгэц эмгэг, ерөнхий шинж тэмдгүүд, оношилгоо” сэдэвт хоёр ном бичлээ. Гэвч хэвлүүлж чадсангүй” хэмээн бичиж үлдээжээ. Өсвөр насныхны эрүүл мэнд сэтгэцийн өөрчлөлт олны санааг зовоож байгаа энэ үед түүний бүтээл, судалгааны ажлууд ямар их олон хүнд тус нэмэр болох байсан бол гэж бодохоор нэг л харамсмаар...Амь амьдралын төлөө зүтгэж, амжилтанд хүрч, хоёргүй сэтгэлээр хүн олныхоо төлөө ажиллаж явсан ийм л нэгэн эрдэмтэн шинэ цагийн хэлмэгдүүлэлтийн золиос болж, хийж бүтээх насан дээрээ бурхны оронд заларчээ. Аав нь эсэргүүний хэрэгт холбогдож, өөрийг нь эмч нарын хэрэгт буруутгаж, асар их зовлон шаналал, хагацал гуниг туулж, хэлмэгдүүлэлтийн хохирогч болж явсан ч түүний хийж бүтээсэн зүйл Монголын анагаах ухааны шинжлэх ухаанд тодоос тод зам мөрөө үлдээжээ. Тиймээс ч 2011 онд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн тасгийг Боовонгийн Чойдог хэмээн энэ хүний нэрэмжит болгон алдаршуулжээ. Үнэндээ энэ хэлмэгдүүлэлт дан ганц Б.Чойдог эмчийг ч бус түүний судлагаа шинжилгээний ажлын үр дүнг амсах байсан олон олон хүнийг хохироож үлдээжээ гэж бодохоор Цоодолын Хулангийн “Цэцгийн толгой авдаггүй төртэй, цэцгийн толгой тасалтай үртэй байхыг хүснэ” гэсэн шүлгийн шад санаанд орж байсан юм.

## НУТАГ МИНЬ НАМАЙГ ЯРУУ НАЙРАГЧ БОЛГОСОН

**Б** и ингэж бодож биширч залбирч ирсэн, нутгийн минь уул ус булаг шанд толгод бүрт нэг тийм нууцлаг бас уянгалаг нандин зүйл бий. Би Бүгсийн голынхоо эргээр тоглон гүйж шавар тохойн мэлхийдтэй чуулж үгсэж байж хөлд орсон, хүн болсон.Тиймээс л нутгийн минь тэр их хүч энерги миний уран бүтээлийг түшиж намайг хөглөж явдаг гэж би сүслэн боддог оо. Сэргэлэн цовоо мөрөөдөмтгий анхны хайр, анхны шүлэг, ариун нандин дурсамж бүрийг өлгийдөж авсан нутаг бол Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум.



Аав ээжийнхээ аз жаргал дүүрэн хүүхэд нас минь нутагт минь бий. Тиймээс ч би гүйгүүл морь шиг нутгийнхаа зүг жолоо залах даанч дуртай. Тэнд миний бага нас ... аз жаргал... залуу нас шүлэг найргийн минь хөг аялгуу бий...

Нутаг минь нуугдаж хайрласан эх орон минь

Нугын чинь цэцэгстэй үгсэн байж хөлд орлоо

Нурсан цайрын чинь чулуун дунд

Бүдчин байж хөлд орлоо .

Нар тоссон ууссан сэтгэлээ тээсээр ээж болсон

Намагт тохойнхоо мэлхийдтэй хүртэл байж шүлэг боллоо ижий нутаг минь хэмээх шүлэг бий.

Хүнд байгаа эрч хүч энерги, сайхан сэтгэл бүрийн үндэс нь нутаг байдаг.

Тиймээс л би сэтгэл уран бүтээлийнхээ хөг аялгууг нутгаасаа хайдаг байх. Эргэн дурсахад сайхан байна.

### Уран уншигч охин

**Б** и сургуульд байхдаа их сайн бас уран гоё шүлэг уншдаг охин байлаа. Хамгийн харамсалтай нь тухайн үеийн социализмийнүзэл суртлаар даргын хүүхдийг түрүүлүүлээд намайг хоёрдугаар байранд оруулчихна. Би их шартай хүүхэд байсан болохоор сургуулийн шинэ жил дээр шүлгээ уншиж илүү гэдгээ бүгдэд харуулдагсан. Бас дуулиан страд дууны тэмцээнд түрүүлж бүр “Алтан медаль” авч байсан шүү. Харин

багадаа кино жүжигчин болохын мөрөөддөг, мөрөөдөмтгий бас романтик охин байсан. 4-7 дугаар ангидаа Мөрөнгийн 10 жилд сурч байгаад 8-р ангид Төмөрбулагт төгсөөд 9-12 дугаар ангидаа Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд сурч төгссөн. Шинэ-Идэр суманд очоод ёстой л илүүрхэж очсон доо. Ангийнхан урлагийн үзлэгийг найруулан тоглуулж 2 жил Манай ангийнхан их авьяастай хүүхдүүд байсан Ц.Доржготов, Ц.Сүхбаатар Р.Пунцаг Ч.Мөнхтуяа Д.Оюунчимэг С.Сарантуяа Энхтуяа гээд л мундгууд чинь манай ангийнх шүү дээ.

### *Хувь заяа минь намайг Сэтгүүлч болгосон*

**Б**и шүлэг бичдэг гэхдээ нууж бичдэг байлаа. Тухайн үед намайг шүлэг бичиж байхад бичсэн гэхэд нэг их ойлгох ч хүнгүй бас ойшоох ч хүнгүй байлаа. Тэр үед нөхөр маань цагдаагийн академид суралцахаар явж надад шүлэг бичих бүр их цаг зав гарч билээ. Тэгээд л бичээд л байсан. Гэтэл 2001 онд Аймгийн утга зохиолын нэгдлийн 50 жилийн ой болж төрийн соёрхолт Дармын Батбаяр Дамдинсүрэнгийн Урианхай Монголруу гэсэн зохиолчид ирж Бид ойгоо хийж шүлэг яруу найргаа уншиж бөөн юм боллоо. Яруу найргийн наадамд түрүүлэн “Бэрс” кино урлагийн дээд сургуулийн радио телевизийн ангид элсэх уриалга авч бөөн юм боллоо. Дарма Батбаяр багш онгоцоор нисэхийнхээ өмнө надад “Амрагийн тэнгэр” номоо бэлэглээд намайг нисэхээр нээж уншаараа гэж хэллээ. Номоо дэлгэн уншмаар байдаг, онгоц нисдэггүй ээ. / их л удах шиг санагдсан/. Тэгээд л хүмүүсээ гаргаж очоод онгоц газраас хөндийрөнгүүт номоо дэлгэн унштал

“ Зөвхөн хувь заяандаа итгэ ”

Хувь заяа чинь чамайг яруу найрагч болгоно. Дарма Батбаяр” гэсэн байлаа. Би яг тэгэхэд л жигүүртэй болж утга зохиолын амьдрал руу өөрийн эрхгүй татагдаж орсон. Хэрэв цагийг нь олвол ганцхан өгүүлбэр хүнийг жигүүртэй болгодог юм билээ. Хотод сурч байхдаа би Утга зохиол сонин, Хонгор зул сонинд сэтгүүлчээр ажиллаж бас сурч байлаа. Батмөнхийн Чулуунцэцэг, Базарсадын Баттулга бид 3 бие биедээ шүлгээ уншиж өгнө бас хөглөгдөнө сайхан байж дээ. 2005 онд “Их монголын хийморь” яруу найргийн наадамд Тангадын Галсан 1-р байр, Бавуугийн Лхагвасүрэн 2-р байр хөдөөний хэнд ч танигдаагүй яруу найрагч Буяндэлгэрийн Сарантуяа гурав дугаар байрт орж Монголын яруу найргийн ертөнц рүү зөвшөөрөл авалгүйгээр алхаад орчихсон. Ингэж л би Хөвсгөлийн Сарантуяа гэдэг нэрийг Монголын тайзнаа дуудуулах болсон.

2006 онд Хайрын дууны Гранпри шилдэг яруу найргийг “Цээжинд нуугдсан амраг” дуугаараа хүртэв. 2006 он миний амьдралын бас уран бүтээлийн хамгийн эрч хүчтэй жил байсан.

Би 2006 онд “Би чиний” шүлгийн ном. Амьдрал ухаанаас ургасан мөнхийн бүтээл сэтгүүл зүйн хөрөг нийтлэлийн номоо өлгийдөн авсан.

2006 онд “Болор цом” наадамд айргийн 5-р байранд орж байсан гээд олон сайхан бүтээл амжилтын минь 2006 он өлгийдөж авсиймаа.

2006 онд “Би чиний” шүлгийн түүвэр Амьдрал ухаанаас урган гарсан мөнхийн бүтээл Сэтгүүл зүйн хөрөг нийтлэлийн ном

2007 онд “Шөнө дунд” яруу найргийн сиди

2009 онд “Зүрхний залбирал” яруу найргийн сиди

2010 онд “Сэтгэл шувуу” яруу найргийн түүвэр

2012 “Бүсгүй” номоо тус тус гаргалаа.

2006 онд “Ган үзэгтэн”

2007 онд “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан”

2009 онд “Сонин хэвлэлийн тэргүүний ажилтан”

2012 онд Сэр-Одын нэрэмжит шагнал

2012 онд Улсын хэмжээний шилдэг нийтлэлээрээ “Болор үзэг”

2013 онд МЗЭ-ийн шагналт зохиолч яруу найрагч, улсын хэмжээний “Орон нутгийн оны шилдгийн шилдэг сэтгүүлч”

2013 онд Монгол Улсын Засгийн Газрын шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль” хүртлээ.

Яруу найраг сэтгүүл зүйн талбарт өөрийн мөртэй, нэртэй яваа минь нутгийн минь өглөг гэж би сүслэн залбирсаар л явах болно.

Б.Сарантуяа

## УЛСЫН АВАРГА ЯМААЧИН

**М**онгол Улсын Засгийн газрын 8 дугаар хуралдаанаас 2010 онд 32 малчныг Улсын сайн малчнаар шалгаруулан өргөмжилжээ. Тэдний нэг нь Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын иргэн Гомбожавын Төөчөө. Тэрээр 1936 оны зун Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг Бүгдгээний голд малчин Гомбожавын гурав дахь хүү болон мэндэлжээ. Малчны гэрт мэндэлсэн малч хүү багаасаа л малд нүдтэй ажилч, морь малд эргэмгийнэгэн болон өсөж торнижээ. Тэрээр 1946 онд Төмөрбулаг сумын дөрвөн жилийн сургуульд элсэн орж сурагч болжээ. Гэвч суурин газрын амьдрал, сургууль соёл хэмээх олон хөлийн газар Г.Төөчөө хүүг тогтоон барьж чадсангүй. Хүү 1950 онд 4-р анги төгсөж гэртээ хариад эргэж сургуульдаа очсонгүй. Аав, ээжийнхээ дэргэд мал маллаж, өөрийн гэсэн амьдралынхаа зураг төөргийг өөрийнхөө гараар бичиж үлдээхийг хүссэн дураараа омголон хүү санасандаа хүрч, 19-хөн насандаа нэгдлийн гишүүн болж нэгдлийн мал өсгөж маллаж хариулж эхэлсэн байна. Олон зуунаар хурааж хуримтлуулсан амьдралын ухааныг эцэг өвгөдөөсөө өвлөж авсан залуу хүү халуунд халж, хүйтэнд хөрч, ган зудан дунд сөхөрч байсангүй. Хадлан гэжээл, төлөвлөгөө норм, байнгын үүрэг даалгавар хүлээсэн тэр цаг үедэд тэрээр Засгийн газрын жуух бичгээр хоёр ч удаа шагнуулж, байжээ. Намын төв хорооноос зарласан болзолт уралдаануудад түрүүлж, аймаг сумынхаа нэрийг улсад гаргаж явсан энэхүү хашир малчин 1954 онд Шашжав овогтой Балжинтай гэр бүл болон 12 хүүхэд төрүүлж өсгөсөн буянтай аав. Тэрээр баг орон нутагтаа мал маллах арга туршлага болон бусад үзүүлэлтээрээ тогтмолд тэргүүн эгнээнд явж залуу үедээ үлгэр дууриал болон зааж, зөвлөж яваа ахмад малчин юм. Г.Төөчөө нь жилийн дөрвөн улирал бэлчээрийг хуваарьтай ашиглан хадлан гэжээл давс хужир гэх мэт зүйлсийг жил болгон сайтар бэлтгэн нөөцөлдөг хашаа саравчаа байнга засаж сэлбэн малдаа тогтмол тарилга, туулга, угаалгад хамруулдаг үлгэр жишээч малчин иргэн юм.Тэрээр Давшилт нэгдэлд 1991 хүртэл ажлаад түүнээс хойш хувийн мал аж ахуйгаа эрхлэн 2002 онд мал сүргээ 1000-с дээш тоолуулан сумын мянгат малчины болзол хангажээ. Тэрээр 2003 онд “Аймгийн сайн малчин” 2010 онд “Улсын сайн малчин” цолоор шагнагдаж, Ардын хувьсгалын 60 жилийн ойгоор “Гавшгайч” гэдэг цол хүртэж, Ардын хувсгалын 50,60,70,80,90 жилийн ойн медаль Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Хөвсгөлийн Алдартан одон, Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнагдаж явсан энэ хүний мал маллах арга ухааныг хүүхдүүд нь бас өвлөж хүү Пүрэвдорж нь сумын мянгат малчин болжээ. Төмөрбулаг сумын Эрчмийн хар ямаа улс даяараа алдартай. Яг л түүн шиг тус сумын ямаачид ч бас орон даяар зартай. Тэдний нэг нь Монгол улсын сайн малчин Г.Төөчөө. Ухаад аваад явчихдаг ашигт матмал биш ургуулж, төлжүүлж, арвижуулдаг хэдэн арван сая мал, түүнийг нь төвөггүй малладаг эгэл жирийн олон зуун малчны нэг энэ хүмүүн цагийн саад, байгалийн их шалгарлын өмнө бууж өгөөгүй нутаг усныхандаа үлгэр дуурайл болон амьдарч байна.

## СЭТГЭЛИЙН ХОЙМОРТ ЗАЛАГДСАН ИЖИЙ БУРХАН

**Х**үмүүний сэтгэл гэдэг асар том архив. Энэ л архивт баяр гуниг, жаргал зовлон, инээд хөөр, басхүү уйтгар гуниг, нулимс хүртэл хавчуулаастай дурсамж дүүрэн байгаа. Гэхдээ энэ бүхий л дурсамжууд дундаас хамгийн тод, хамгийн гэрэл гэгээтэй нь ээжийн тухай бодол л байгаа гэдэгт би итгэдэг. Хүнийг бурхан дагаж төрдөг. Тэрхүү бурхан нь ээж нь юм гэдэг сайхан бодол сэтгэлийг минь үргэлж хөглөж байдаг. Тиймээ. Авралын дээд аврал, ачлалын дээд ачлалыг хүмүүн зөвхөн ээжээс л хүртэж чаддаг. Тийм л сая сая сайхан ээжүүдийн нэг нь Төмөрбулаг сумын уугуул Сономжамцын Гачилмаа хэмээх эгэл хэрнээ эгэлгүй нэгэн байлаа. Түүний аав Өлзийбаярын Сономжамц Бадгийн амнаа төрж, 1939 онд Халхын голын дайнд эх орноо өмгөөлөн босч, “Алтангадас” одонгоор шагнуулан ялалтын дуутай хамт төрсөн нутагтаа эргэн ирж байсан гэдэг.




Сономжамцын Гачилмаа 1955 онд төржээ.Тэрээр бага, дунд сургууль, Барилгын тцхник мэргэжлийн сургуулийн суурь машины анги төгсөөд сургуульдаа хөдөлмөрийн багшаар үлдэж, ажлын гараагаа эхлэжээ. Энэ л хүний намтрын хуудсыг сөхөж харахад тун энгийн. Хөвсгөл аймгийн ТМС-д багшилж, оюутнуудаа үйлдвэрлэлийн дадлагат гаргаж, хөдөө хээр ажиллаж, төлөвлөгөө норм биелүүлж, бүтээн байгуулалтын ажилд дайчлагдаж, үр хүүхдээ өсгөж өндийлгөх гэж зүтгэж явсан.Гэхдээ түүнд хүнд бүгдэд заяадаггүй, ховор нууцлагдмал нэгэн авьяас байлаа. Түүний аавын талд Төмөрбулаг сумандаа төдийгүй хотгойд хошуундаа зартай, олондоо хүндлэгдсэн удган хүн байж. Энэ л далд авьяас, зөн билэг жаахан охинд уламжлагдан ирж, адуу малын эрэлчид, алдсан гэсэн юмны эзэд түүнээс янз бүрийн зүйл асууж, амнаас ам дамжин яригдаж эхэлжээ. Шинжлэх ухаан ч нууцыг нь үл тайлж чадах ховор авьяастай энэ л хүмүүн багаасаа л бусдаас содон нэгэн гэдэг нь мэдэгдэж байсан ч аав нь охиныхоо энэ бүхий л авьяас чадварыг бусдаас нууж өгсгөжээ. Үнэндээ шашин номын үйл хийх нь бүү хэл ном судар ч сөхөж харахад төвөгтэй

цөвүүн цагт нуухаас ч өөр аргагүй байсан хэрэг. Тэрээр Улаанбаатар хотод сурч байхдаа эцэг эх, үр хүүхэд хань ижлээсээ хол, орон гэрээ санасан оюутнуудад мэргэлж өгдөг, үүнээсээ болж хэл аманд ч өртөж явсан гэдэг. Хотгойдын зартай удганаас үе дамжуулан ирсэн Даян дээрхийн шүтээнийг хоймортоо нууцлан залж, олон жил цай сүүнийхээ дээжийг өргөж явсан энэ хүн 1990 он гарч, шашин шүтэх эрх чөлөө нээгдэж, сүм дуганы хаалга үүд онгойсон сайхан цагтай золгож байсан юм. Монголын, Монголчуудын эртний дээдсийн жаяг ёс болох бөө мөргөлийн ёс заншил цаг хугацааны хувьд нэгэн үе сэргэн мандаж, нэгэн үе мөхөн сүйрч, нэгэн үе далд нууцлагдмал байдалд орж, нэгэн үе түркжиж, нэгэн үе шашинжиж байсан ч гэсэн тэрээр Хотгойд бөөгийн дуудлага, зан үйл, ёс заншлийг хадгалан үлдсэн цөөхөн хүмүүсийн нэг байлаа. Өрөвч зөөлөн сэтгэл, элдэв хар хор, эдийн шунал хүсэлгүй энэ л хүмүүн өөрөөс нь аврал, энэрэл гуйн ирсэн олон зуун хүмүүнд ач ивээлээ өгч, ордонд залардаг төрийн тэргүүнээс эхлээд орон гэргүй ядууст ч тус хүргэж явсан түүхтэй. Хөвсгөлчүүд түүнийг “Даян дээрхийг тахидаг удган” хэмээн сүсэглэж, Монголын зурхай, сүнс судлалын ухааны академиас түүнд “Хүндэт доктор” цол олгож, Монголын зурхай судлалын хүрээлэнгээс 2002 онд Сономжамцын Гачилмаа хэмээх энэ хүнийг “Дээрхийн дагина” хэмээн өргөмжилж байжээ. Хотогойд судлаач С.Пүрэвжав энэ л ястнуудын тухай нарийвчлан судлаж, Даян дээрх бол хотогойдуудын эртний шүтээн хэмээн онцолсон байдаг. Үүнийг ч өдөө цагийн эрдэмтэд батлаж, Монголын зурхай судлалын хүрээлэнгээс түүнийг Хотогойдын “Дээрхийн дагина” хэмээн өргөмжилсөн хэрэг. Чулуу нь хүртэл үлгэр домог хүүрнэх энэ л нутгаас хэзээ ч бидний тайлбарлаж, таниулж үл чадах олон олон авьяастан, зөн билэгтнүүд төрж гарсны нэг нь Сономжамцын Гачилмаа хэмээх энэ хүн. Олон түмнийхээ сэтгэлийн хойморт бурхан мэт залагдсан эжий бурхадын нэг энэ хүнийг өнөөдөр үр хүүхдүүдтэй нь адилхан санан дурсаж, үгүйдлэг хүмүүс цөөнгүй бий. Уулс лус савдаг, эх нутаг, газар шороотойгоо амин холбоотой байж, бусдын итгэлийг хүлээж, сайхан сэтгэлээр хүмүүн бүрийг энэрч явсан эгэлгүй хэрнээ эглийн эгэл ийм л хүмүүс өчигдөр бидний дунд амьдарч, өнөөдөр үгүйдлэгдэн дурсагдаж, хожим үлгэр домог мэт яригдсаар байна.

## БУЯНЫ ЭЗЭН

Агтын голын унаган хүү Дашийн Чимэдрэгзэн хэмээх энэ л хүний тухай түүх домог мэт зүйлс ам дамжин яригдсаар байдаг. Монгол улсын Ерөнхийлөгчийн шашины зөвлөхөөр



ажиллаж, буян номыг түгээх үйлсэд хичээнгүйлэн зүтгэж явсан энэ хүн алдартай маарамба байсан юм. Түүнийг Төвдөд очин нэртэй том хувилгаадын судас барьж, эм тан өгч байсныг өнөө цагийн залуухан лам нар гэрчлэн ярих нь бий. Түүнийг аав Дашийг Торгууд хэмээн авгайлдаг байжээ. Д.Чимэдрэгзэн хэмээх энэ хүмүүн Бүгсийн хүрээний Жамсран шанзовын хойд дүрээр нууцаар тодорч байсан аж. Гэвч бурхан номын үйлийг хуулиар хориглодог, эсэргүү хэмээн адладаг, буруу номын суртал тараасан гэж ял хүртэл оноодог байсан хүнд хэцүү

үед тэрбээр цагийн аясыг дагаж цэргийн алба хааж, курст суралцан нягтлан бодох мэргэжил эзэмшиж, эрүүлийг хамгаалах хэлтэст ажиллаж байжээ. Гэвч түүнийг зорин очих аврал эрсэн олны хөлийг хэн ч хориглож дийлж байсангүй. Олноо “Телевизийн ах”, “Халзан ах” гэж нэрлэгдэж байсан Дашийн Чимэдрэгзэн хэмээх энэ хүн их эрдэм номтой хувилгаан, оточ маарамба төдийгүй, энэргүй үйлстэн, басхүү номын буян хишгийг нэвтэрхий мэддэг хүн байлаа. Олон зуун хүнд авралын гараа сунгаж, эмчилж эдгэрүүлсэн Д.Чимэдрэгзэн олон арван шавьтай. Түүгээр судас барьж, эм тан бэлтгэх аргыг заалгасан олон шавь нар нь өдгөө уламжлалт ангаах ухааны салбарт зүтгэж явна. Тэрбээр зон олныхоо сайн сайхны төлөө 1000 Аюуш бурхан бүтээлгэж Зүүн хүрээ “Дайчойлин” хийдэд залжээ. Гандантэгчэнлин хийдийн Дүйнхор дацанд жил бүр сүсэгтэн олондоо зориулан ном хуруулж байжээ. Д.Чимэдрэгзэн багштан Бүгсийн хүрээний Дашгэндүнжамбаалин хийдийг сэргээхэд өөрийн биеэр оролцож, Миеэгомбо, Ямандаг бурхад бүтээн залж, Явсрай сүмийн сүм бүнгийн 20 гаруй боть ховор чухал ном судрыг өргөсөн байна. Өвдөж зовсон, өлсөж цангасан олныхоо гачаал зүдэргээг нимгэлэх гэж бие сэтгэлээ чилээж явсан, бодь сэтгэлтэй, амгалан төрхтэй номч мэргэн, оточ маарамба энэ хүний эрдэм чадлыг Монголын төр ч тухайн үедээ зөв үнэлэн таньж Ерөнхийлөгч өөрийнхөө дэргэдэх шашны зөвлөлд ажиллуулж байв. Эмийн ургамал түүж, эм тан хийн, элдвийн өвчнийг анагаах увьдистай багшийгаа сүсэгтэн олон нэрээр нь дуудахаас ч эмээдэг байсан гэдэг. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул ийм нэгэн буянтан саяхан болтол бидний дунд амьдарч байлаа.

*НАЙМДУГААР БҮЛЭГ*

# НУТГИЙН ТҮМНИЙХЭЭ ХҮНДЭТГЭЛ ХҮЛЭЭСЭН ЭРХМҮҮД

**ПАНЬДЖУНАЙН ЛЯНХУА**

Бага наснаасаа мал маллаж, ан гөрөө хөөж өссөн тэрбээр 1958 оноос нэгдлийн ямаан сүргийг өсгөн үржүүлэх, залуу малчдыг халамжлан хүмүүжүүлэхэд бие, сэтгэлээ зориулсан нэгэн билээ.

П.Лянхуа 480 эм ямаанаас 520 ишиг бойжуулан, ашиг шимийн даалгаврыг 101-110 хувиар биелүүлсэн амжилтаар алдрын гараагаа эхэлж, сум, аймгийн аварга малчнаар дөрвөн удаа шалгарч, АИХ-ын депутатаар сонгогдон, МАХН-ын XV их хуралд төлөөлөгчөөр оролцож байжээ. Тэрээр “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт” болон ойн медалиудаар шагнуулж байжээ.

**БАДМААН БАТМӨНХ**

Б.Батмөнх нь “Давшилт” нэгдлийн ямаан сүргийг гурван түм болтол өсгөхөд жинтэй хувь нэмэр оруулсан хүн билээ. Тэрбээр “Залуу аварга малчин” цол авсныхаа дараа тун удалгүй “БНМАУ-ын аварга малчин” гэсэн эрхэм хүндтэй цолыг хүртжээ. Тэрбээр мал маллахын хажуугаар АИХ-ын депутатаар сонгогдон ажиллаж байв.

**НОМПЭЙН ЛОСОЛ (1914-1976)**

Н.Лосол Бүрэнтогтох, Төмөрбулаг, Цэцэрлэг, Чандмань-Өндөр сумын дарга, “Эрчмийн оргил” нэгдлийн дарга, “Давшилт” нэгдэлд бригадын намын хэсгийн ахлагч зэрэг хариуцлагатай албан тушаалд томилогдон, нэр төртэй ажиллаж байв. Тэрбээр дайны хүнд жилүүдэд нэгдлийн даргаар ажиллахдаа фронтод нийлүүлэх бэлтгэл зүйлийг хангах, малчдынхаа ахуйамьдралыг доройтуулахгүй байх чухал ажлыг зөв хослуулж, чадамгай удирдан зохицуулж байжээ.

Н.Лосолын ажил үйлсийг төр, засаг Засгийн газрын хүндэт жуух, Хөдөлмөрийн хүндэт болон ойн медалиудаараа шагнаан урамшуулжээ.

**ДАМЧААГИЙН ДАРАМЖАВ**

“Улсын сайн малчин” Д.Дарамжав малынхаа тоо толгойг 1099 тоод хүргэж, мянгат малчин болсон, Улсын тэргүүний малчдын IV зөвлөгөөнд орлоцож байсан бөгөөд “Алтан гадас” одонгоор шагнуулж байжээ.

**ЯДАМЖАВЫН СОСОРБАРАМ**

Тэрбээр сумын төр захиргаа, нам, аж ахуйн салбар, нэгдлийг үүсгэн байгуулахад хүчин зүтгэсэн ахмад билээ. Я.Сосорбарам 1940,50-иад онуудад намын үүрийн дарга, нэгдлийн дарга, бригад, фермийн эрхлэгч зэрэг албыг хашиж байв.

**ЖҮГДЭРНАМЖИЛЫН ЦЭВЭГДОРЖ**

Ж.Цэвэгдорж 1956-1957 онд сумын нарийн бичгийн дарга, 1963-1982 онд сумын орлогч даргаар тасралтгүй 19, нийтдээ 21 жил төр захиргааны хариуцлагатай албанд хүчин зүтгэсэн ахмад зүтгэлтэн билээ.

**ГОМБЫН ЗАМБАЛ**

Шинэ тутам үүссэн нэгдлийг айлын дайтай айл болтол нь хөгжин



дэвжихэд хүчин зүтгэсэн Г.Замбал баг, бригадын даргаар 18 жил тасралтгүй ажилласан төр захиргааны туршлагатай ахмад ажилтан билээ.

### ЦОГЗОЛЫН ЛОСОЛ

1924 онд төрсөн. Малын санитараас эхлээд багийн даргаар олон жил ажилласан, нэгдэлжих хөдөлгөөнд идэвхтэй оролцож хамтын шинэ аж ахуйн давуу талыг олонд ойлгуулах гэж хүчин зүтгэж явсан, аж ахуйн ажлын туршлагатай ахмад дайчин юм.

### НОМПЭЙН ШАНЖ

1926 онд төрсөн тэрбээр сумын худалдааны агент, тасгийн эрхлэгчээс ажлын гараагаа эхэлж, 8 дугаар багийн даргаар 7 жил, нэгдэлд бригадын дарга, тоо бүртгэгч, хэсгийн ахлагч, аж ахуйн дарга зэрэг албанд 26 жил хүчин зүтгэж байжээ.

### ДАНЬДГАЙСҮРЭНГИЙН ЦАГААНБААТАР

1944 онд төрсөн тэрбээр мал зүйч, хуульч мэргэжилтэй, хурандаа цолтой нэгэн байв. Д.Цагаанбаатар төрөлх сумандаа малын эмчээр ажилласнаар хөдөлмөрийн гараагаа эхэлж, дараа нь Ардын армид хүчин зүтгэхээр сонголтоо хийж, амьдралынхаа дийлэнх жилийг армитай холбон аймгийн цэргийн хэлтсийн штабын офицер, даргаар ажиллажээ. Түүнийг төр, засаг “Улаан тугийн болон байлдааны гавьяа”-ны, мөн “Алтан гадас” одонгоороо шагнажээ.

### ЕРӨӨЛТИЙН ЦЭВЭГМИД (1909-1985)

Хоршоо, худалдааны байгууллагад худалдагчаас ня-бо, хэлтсийн дарга зэрэг ажлыг 40 шахам жил хашсан энэ хүнд төр, засаг “Алтан гадас”, Хөдөлмөрийн хүндэт медаль болон бусад ойн медалиудаар шагнуулж байлаа.

### БАТ-ОЧИРЫН ЭРДЭНЭ

1963 онд төрсөн. 1983 он цэргээс халагдаж ирээд гуравдугаар бригад мал маллаж эхэлжээ. 1990 оны эхээр тус бригад Саруул зам нэртэй компани болж, тус компанийн гишүүнээр ажиллаж мал маллаж байжээ. 2004 онд гэр бүлийнх нь хүн өөд болж, таван өнчин хүүхэдтэйгээ үлдсэн ч амьдралын хүнд хэцүүд нугарч, шантраагүй нэгэн. 2007 онд мянгат малчин болжээ 800 гаруй хоньтой. 70 гаруй үхэртэй. Хөдөлмөрийн хүндэт медалийг 2009 онд авчээ. Засгийн газрын жуух бичигээр шагнагдаж байжээ. Сайн малчдын зөвлөгөөнд төлөөлөгчөөр оролцож байсан.

### ЕРӨӨЛТИЙН ЖҮГДЭР (1914-1995)

Олондоо “Жүүгээ эмч” хэмээн алдаршсан энэ хүн “Саруул зам” нэгдэлд гишүүнээр элсэн барилга барилцах, мужаан хийх, хонь маллах, фермийн эрхлэгч, сумын малын эмчээр ажиллаж байжээ. Эх орны дайны хүнд жилүүдэд гахай, гөрөөс агнаж бэлтгэх ажилд хүчин зүтгэж, “Улсын тэргүүний анчин” цол хүртээсэн гэдэг. Е.Жүгдэрийн хөдөлмөр, зүтгэлийг


төр засаг өндөр үнэлж “Хөдөлмөрийн хүндэт” медаль, “Улсын сайн малчин” цол тэмдгээр шагнажээ.

### ООЖООН ЧОГСОМ

О.Чогсом гуай Улиастай, Улаангом, Тагна, Тува, Хатгал зэрэгт жин тээж явсан бөгөөд арьс хөмийг даавуу торго шиг болтол элддэг байсан тэрбээр худалдааны салбар үүсэхэд худалдааны төлөөлөгч, агент байсан бөгөөд 1956 онд сумын 5, 6, 7-р багийн ардууд тэднийд хуралдаж “Эрчмийн оргил” нэртэй нэгдэл байгуулж байжээ. Түүний хүү Ч.Бавуу нь төр захиргааны байгууллагад олон жил хариуцлагатай алба хашиж явсан, хүү Ч.Дамдинжав агсан нь урлагийн байгууллагад 30 гаруй жил бүжигчин, бүжгийн багшаар ажилласан. Охин Ч.Дашдаваа оёдлын мастер, нөхөр Хасбазар нь Сэлэнгэ аймгийн намын хорооны 1 дүгээр даргаар 16 жил ажилласан, хүү Ч.Эрдэнэбилэг нь автотээврийн байгууллагад олон жил тогтвортой ажиллаж байсан гээд үр хүүхдүүдийнх нь ажил үйлс өнөөдөр нутгийн зох олны бахархал болсоор байна.

### ЛХАСҮРЭНГИЙН МАНЧИН

Тэрээр 1946 онд төрсөн. Аймгийн Худалдаа бэлтгэлийн удирдах газар, Эмийн сангуудыг удирдах газар, Усны аж ахуйн контор зэрэг байгууллагуудад 24 жил нягтлан бодогчоор ажилласан. Хөвсгөл аймгийн мал эмнэлэгт бичиг хэрэг, бичээчээр ажиллаж байгаад өндөр насныхаа тэтгэвэрт гарчээ.





**Г.БОЛД**

Төмөрбулаг сумын уугуул Гунгаа овогтой Болд нь 1957 онд Давшилт нэгдэл орж, 1963 оноос адуу маллаж байжээ. Адуу бүрээс 550 грамм дэл, 450 грамм хөөвөр авч, Тэрээр аймаг сумын аварга малчнаар шалгарч байсан, нэгдлийн ууган гишүүдийн нэг юм.

**Ц.ДУЛМАА**

Д.Дулмаа нь 1954 онд Төмөрбулаг сумын нутаг Дөшийн голд төрсөн. Тэрээр 1970 онд Давшилт нэгдэлд гишүүнээр орж, эр сувай үхэр хариулж, 1983 оноос тус нэгдэлд саальчнаар ажиллаж байсан. 1986 онд 7-р таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх ажилд идэвхитэй оролцож, 1987 онд 17 үнээнээс 17 тугал бойжуулж, үнээ бүрээс 8112 литр сүү сааж, Мянгат саалчнаар шалгарч байжээ. Мөн 1987 онд Төмөрбулаг сумын “Ашиг шимийн аварга” цол хүртсэн. 1988 онд аймгийн даргын тушаалаар 1-р зэргийн саальчин гэдэг үнэмлэх авч, Мянгат саальчны болзолыг дөрвөн жил дараалан биелүүлсэн байна.



**Д.БАНЗРАГЧ**

Тэрээр 1919 онд одоогийн Төмөрбулаг сумын Тэлээгийн голд төрсөн. 1939 онд Халх голын байлдаанд оролцож явсан ахмад дайчин. Таван жил цэргийн цэргийн албаа хааж нутагтаа ирж, Чогсомын Цэнд-Аюуштай гэр бүл болж, мал маллах болсон байна. Дөшийн Банзрагч Хөвсгөл аймгийн аварга малчнаар дөрвөн удаа шалгарч АИХ-ын депутатаар сонгогдож байжээ. 1975 онд Бог малын сууриудын дунд зарласан уралдаанд амжилттай оролцож, “Энх сүрэгтэн” цол өргөмжлөлөөр шагнагдаж байжээ.



**Е.БАТМӨНХ**

Тэрээр 1952 онд төрсөн. 1966 онд Давшилт нэгдэлд элсэж, мал маллаж байгаад 1970 онд ХБ-гийн цэргийн тусгай хороонд алба хаажээ. Ендонжамцын Батмөнх нь Сэлэнгэ аймгийн Шаамарт трактор комбайны курст сурч, 1975-1990 он хүртэл Төмөрбулаг сумын Давшилт нэгдлийн тракторын жолоочоор ажилласан байна. Давшилт нэгдлийн хадлангийн механикжсан бригадад 15 жил ажиллаж, 1985, 1986 онд сумын аварга тээвэрчин болж байжээ.



**Ч.ЧИМЭДДОРЖ**

ХААДС-ийг нямбо, эдийн засагч мэргэжлээр төгссөн. 1972 онд сургуулиа төгсөөд Давшилт нэгдэлд тооцооны нябоггоор томилогдон ирж ажиллаж байжээ. Тэрээр 1982 оноос тус нэгдлийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан байна. Түүнийг Ерөнхий нягтлан байх үед “Давшилт” нэгдэл 1987 онд “Өр авлагагүй хамт олон”-оор шалгарч, касс харилцахдаа тогтмол 1,5-2 сая төгрөгийн хэвийн үлдэгдэлтэй байсан бөгөөд 1987 онд МУИС-ийн оюутнуудын хүчээр Гахайн давааг засуулж, 1988 онд 900 мянган төгрөгөөр сумын конторын 2 давхар байшинг бариулж байжээ. Тэрээр Давшилт нэгдэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, ойн медалиуд, Санхүүгийн салбарын тэргүүний ажилтан цол хүртэж “Алтан гадас” одонгоор шагнагдаж байсан юм.



**Ш.ГЭРЭЛСАЙХАН**



Ш.Гэрэлсайхан нь 1968-1978 онд Мөрөн хотын нэгдүгээр 10 жилийн дунд сургууль, 1978-1982 онд УБДС-д суралцан математикийн багшийн мэргэжил эзэмшиж, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд математикийн багшаар тогтвор сурьшилтай, тасралтгүй 36 жил ажиллаж байна. Монголын Математикийн багш нарын академийн гишүүн, тэргүүлэх зэрэгтэй. 1979-2000 он хүртэл Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ерөнхий боловсролын сургуульд математикийн багш, 2000-2001 онд Төмөрбулаг сумын Тээлийн бага сургуулийн эрхлэгч, 2001-2002 онд Төмөрбулаг сумын 10 жилийн сургуульд нийгмийн ажилтан, математикийн багш, 2002 оноос одоог хүртэл тус сургуульд математикийн багшаар ажиллаж байна.

Тээлийн бага сургуулийн эрхлэгчээр ажиллаж байхдаа сурагчдын суралцах таатай орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллан бага оврын цахилгааны эх үүсвэртэй болгож, сургуулийн барилгыг их засварт оруулсан. Тэрээр

2011 онд “Алтан гадас” одонгоор тус тус шагнагджээ.

Ш.Гэрэлсайхан нь заах аргын ур чадвартай, бүтээлч тэргүүний ахмад багш юм.

**Т.ИЧИНХОРЛОО**

1934 онд төрсөн, бага наснаасаа эцэг эхийн хамт мал маллан амьдарч байгаад 1950 онд бичиг үсгийн бүлгэмээр бичигтэн болж улмаар бага боловсрол эзэмшсэн ба 1953 онд Г.Сундуйжавтай гэр бүл болж 1954 онд “Эрчмийн оргил” нэгдэлд



элсэн ажилласнаас хойш нэгдэл нийгэмдээ тасралтгүй 37 жил ажиллажээ. Эрчмийн оргил давшилт нэгдэлд төллөх малын 500-н суурь дагнан маллаж байгаад 1976 оноос Дагвадорж фермд 14 жил саальчнаар ажиллажээ. Энэ хугацаанд 6-р таван жилийн гавшгайч 1979 онд сумын аварга саальчин цол хүртэж байжээ.



### М.МАГСАРЖАЛАМ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд 1956 онд төрсөн. Сэлэнгэ аймгийн Шаамарт трактор комбайны курст сурч, Төмөрбулаг суманд тракторын жолооч, багийн даргаар ажиллаж байсан. М.Магсаржалам нь ойн медалиуд болон “Алтан гадас” одонгоор шагнуулж байсан бөгөөд эдүгээ Төмөрбулаг сумын Тээл багийн ахмадын хорооны даргаар ажиллаж, О.Н.З-ийн даргын сонгууль ажил хашиж байна.

### Д.ЛХАМСҮРЭН

Тэрээр Төмөрбулаг сумын уугуул. 1969 онд цэргийн албанд явж, 1975 оноос Давшилт нэгдэлд Худалдаа бэлтгэлийн анги, Хүн эмнэлэгт, Сумын захиргаа, Нийтийн ахуй үйлчилгээ зэрэг газруудад 35 жил тасралтгүй жолоочоор ажиллаж байжээ. Жолоочоор ажиллахын зэрэгцээ модон эдлэл хийдэг уран гартан байжээ.



### Ж.ДОВДОН

Тэрээр 1932 онд төрсөн 1954-1955 онд бригадын дарга, 1955-1958 онд сүү тасгийн эрхлэгч 1958-1963 онд фермийн эрхлэгч, 1963-1969 онд бригадын тоо бүртгэгч, 1969-1975 онд худалдаа бэлтгэлийн ангийн агент, 1975-1978 онд бригадын хэсгийн ахлагч зэрэг ажлуудыг хийж байсан.



### Б.ДАШМЯГМАР

1944 онд төрсөн. 1962 оноос эхлэн нэгдэлд элсэж, адуу үхэр маллаж, хонь хариулж, агент хийж явсан. Нэгдэлд 31 жил тасралтгүй ажилласан. Ойн медалиудаар шагнуулж явсан.

### Р.ГЭНДЭНСҮРЭН

Бүгдгээний голд төрсөн тэрбээр 1955-1958 онд Ардын цэргийн алба хааж, 1968 оноос Мөрөнгийн МАА-н машинт станцад жолоочоор ажиллан ажил хөдөлмөрийнхөө гарааг эхэлжээ. Тэрбээр 1968-1995 он хүртэл

аймгийн нэгдэл дундын үйлдвэрт жолоочоор ажиллаж байгаад гавьяаныхаа амралтанд суужээ.

Улс орондоо тасралтгүй 37 жил ажилласан хөдөлмөр, зүтгэл нь түүнийг “Аймгийн аварга” жолооч, аймгийн АДХ-ын депутат, “Осолгүй манлай” жолооч гэсэн алдар хүндэд хөтөлжээ.

Р.Гэндэнсүрэн 1982 онд Тэргүүний тээвэрчдийн анхдугаар зөвлөгөөнд төлөөлөгчөөр оролцож явжээ. Төр засаг түүний хөдөлмөр, зүтгэлийг 5 жилүүдийн гавшгайч цол тэмдэг, “Хөдөлмөрийн хүндэт” болон ойн медалиудаараа шагнаан урамшуулсан байна.



### М.БЯМБАЧУЛУУН

1959 онд төрсөн. Бага наснаасаа мал маллан аав ээждээ тусалж байгаад 1969 онд сумын бага сургуульд элсэн орж 1975 онд илгээлтийн эзнээр томилогдон хөдөө аж ахуйд ажиллахаар гарсан анхны илгээлтийн эзэн юм. 1976 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотод илгээлтийн эздийн чуулга уулзалт зохион байгуулагдаж уг уулзалтанд сумаа төлөөлөн Р.Долгорсүрэнгийн хамт оролцож байсан. 1977 онд хадлан тэжээл бэлтгэх ажилд залуучуудыг тэргүүлж аварга хадланч

болон Улаанбаатар хотод зохиогдсон “Сайн малчдын зөвлөгөөнд оролцох эрхээр шагнагдаж байлаа.

### М.ЛХАМЖАВ

Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд ямаачнаар ажиллаж байсан. Төрсөн дүү Дэжидийнхээ хамт 450-500 эм ямаа маллаж, Сангийн далай, Ачмаг нуурт оторлон, ямаанаасаа жил бүр 530 ишиг бойжуулж, төлөвлөгөөгөө 110-150 хувиар биелүүлж аймгийн гурван удаагийн аварга болж байжээ. М.Лхамжав нь найман хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд бүүний охин Л.Долгорсүрэн нь Завхан аймгийн харьяат Хөдөлмөрийн баатар хоньчин Очиртой уулзан туршлага судлаж, нэгдлийн гишүүдэд түүнийгээ танилцуулж байжээ. Хүү Л.Наранчулуун нь Архангай аймгийнхантай шефийн холбоо тогтоож, ажлаараа уралдах болзол авч тавьж явжээ. Өдгөө түүний хүү Л.Бат-Өлзий нь сумынхаа мянгат малчин болж, ажил үйлсээрээ ээжийнхээ үйл хэргийг залгамжилж байна.



### Г.НАНСАЛДУЛАМ


Г.Нансалдулам 1948 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Тэлээгийн голын Сайрын аманд төрсөн. 1962 онд Мөрөн хотын 10-н жилийн сургуулийн 6-р ангид сурч байгаад мал маллах хүсэлдээ хөтлөгдөн “Давшилт нэгдэлд 120 төллөх мал аав, ээжийн хамт авч малчин болох анхны



гараагаа эхэлжээ. “СУМЫН АВАРГА” малчнаар дөрвөн удаа, сумын АДХ-ыг сонгох 12,13,14,16 дахь удаагийн сонгуулиар 11,13, 6, 8-р тойргийн депутатаар дөрвөн удаа, Нэгдэлжих хөдөлгөөн ялсны 30-н жилийн ойн хүндэт төлөөлөгч, Аймгийн МАХН-ын 21-р бага хурлын төлөөлөгчөөр тус тус сонгогдож байсан. АХ-ын 50, 60, 70, 80, 90-н жилийн ойн медаль, Нэгдэлжих хөдөлгөөн ялсны 30-н жилийн ойн медаль, V, VI, VII, VIII таван жилийн гавшгайч цол, тэмдэг, 8-н хүүхэд төрүүлж Алдарт эхийн 1, 2-р одон, “ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ” медалиар шагнагдсан.


### Д.БААСГАЙ

Төмөрбулаг сумын Тээл багийн харьяат. Тэрээр анх сум нэгдлийг үүсэн байгуулагдах үед гишүүнээр орж, мал маллаж байжээ. Сумын заан цолтой. Тэрээр Даншвайгийн Дашцэрэнтэй гэр бүл болж, Б.Алтанхуяг, Б.Мөнгөнхуяг, Б.Эрдэнэцэцэг, Б.Отгонбаяр, Б.Ганхуяг, Б.Төмөрхуяг, Б.Эрдэнэчимэг, Б.Батхуяг, Б.Болдхуяг, Б.Ганболд, Б.Энхтуяа, Б.Оюунгэрэл, Б.Амаржаргал, Б.Чаминчулуун нарын 14 хүүхэд төрүүлж өсгөжээ. Өдгээ Б.Баасгайн үр ач 120 гаруй хүн амьдарч байна.



### Ц.НЯМБААТАР

Цагаач овогтой Нямбаатар Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн. 1977 онд санхүү эдийн засгийн сургууль төгсөж, тус сумын санхүү тасгийн байцаагч аар ажиллаж байсан. Тэрээр 1985-1998 онд Хөвсгөл аймгийн Тээврийг удирдах газрын байцаагч, нябо, 1998-2006 онд “Хөвсгөл тээврийн газар” ХХК-ны захирал, 2006 оноос одоог хүртэл “Нөхөрлөл зам” хоршооны нябо-гоор ажиллаж байна.



### Д.ЗАГДСАМБАР

Тэрээр 1905 онд Бадгийн аманд төржээ. 1959 онд нэгдэлжих хөдөлгөөн өрнөж эхэлсэн үед тэрээр Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд бүх малаа нийгэмчлэн гишүүнээр элсэн орж байжээ. 1959-1983 он хүртэл нэгдэлд эхнэр Долгорын хамт мал маллаж байсан энэ хүн удаа дараа “Нэгдлийн сайн малчин, аварга төлчин гэдэг цол., Ардын хувьсгалын 40, 50 жилийн ойн медалиар шагнуулж байжээ.

### Г.ДАМДИНДОРЖ

Гомбожав овогтой Дамдиндорж нь 1939 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн .Тэрээр 1956 онд нэгдэлийн гишүүнээр элсэн нэгдэлд тоосго цохин ажлын гараагаа эхэлж байсан бол 1958 оноос 1961 он хүртэл “Давшилт” нэгдэлд адуу маллаж байгаад, 1961-1969 он хүртэл үхэр сүрэг маллан 1965-1968 онуудад мах бэлтгэлээр жингийн сумын аварга болж ажилч хөдөлмөрч малд нүдтэй болохоо харуулж байв. Мөн 1969 оноос нэгдэлийн эр сувай малыг маллан түүнээс гарах уртын ноос, ноолуурын гарцыг 120% давуулан биелүүлж 1970 онд сумын аварга, 1971 онд Аймгийн аварга болж 1975 онд мотоциклоор шагнуулсан. Мөн 1985 онд сумын аварга болж байжээ. Ардын хувьсгалын 60,70,80,90 жилийн ойн медалиар 2005 онд Ахмад зүтгэлтэн медалиар шагнаж урамшуулсан байна.



### Б.БЯМБА

Сумын анхны гар бичээчдийн нэг багийн дарга асан Батдэмбэрэл овогтой Бямба 1931 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын нутаг “Гахайн гол” гэдэг газарт Батдэмбэрэлийн 5 дахь хүү болон төрсөн. Тэрээр 1949-1952 оны хооронд сумандаа анхны гар бичээч, 9-р багийн анхны бүлгэмийн багш зэрэг ажлыг хийж байгаад 20 настайдаа цэргийн албанд татагдсан. Улаанбаатар хотод АЦ-н хамгаалах хорооны авто колонь арнизонд бичээч хийж байгаад халагдан ирж, улмаар сумандаа багийн даргын албыг хашиж байжээ.

### Н.НАНДИНБИЛЭГ

Н.Нандинбилэг 1989 онд төрсөн. Төмөрбулаг сумын 10 жилийн дунд сургуулийг 2007 онд төгсөж “Аварга” биеийн тамирын дээд сургуульд орж суралцан 2011 онд төгсөөд 2006 онд аймгийн аваргын самбо жү до-гоос хүрэл, 2007 онд аймгийн аваргын самбо жү до-гоос мөнгө медаль, алт медаль, улсын аваргын самбо жү до-гоос хүрэл медаль, баруун бүсийн аваргын самбо жү до-гоос мөнгөн медаль, Баянхонгор аймгийн самбо жү до-гоос мөнгөн медаль, 2008 онд улсын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах самбо жү до-гоос 2 удаа хүрэл медаль, 2010 онд Улаанбаатар хотын чөлөөт бөхийн аваргаас мөнгөн медаль, залуучуудын чөлөөт бөхийн аваргаас хүрэл , насанд хүрэгчдийн чөлөөт бөхийн аваргаас хүрэл медаль тус тус авсан байна. Н.Нандинбилэг чөлөөт бөхийн дэд мастер болон мастер, самбо жү до бөхийн 1-р зэрэгтэй, 2009 онд Олс таталтын улсын аваргаар багаараа дэд мастер, 2010 онд олон улсын хэмжээний мастер цол авсан.





**Д.БАТ-ЭРДЭНЭ**

Д.Бат-Эрдэнэ 1961 онд төрсөн. 1982-1986 онд Бүрэнтогтох суманд сахиул, галч, мужаан, 1986-1993 онд “Давшилт” нэгдэлд дизельчин, 1993-2014 онд эхнэр Ш.Сумъяатай хамтран хувиараа гутал хийж 2013 онд сумын аварга өрхийн үйлдвэрлэгч, 2014 онд аймгийн шилдэг өрхийн үйлдвэрлэгчээр удаа дараалан

шалгарч байгаа шилдэг өрхийн үйлдвэрлэгч юм.

**Ч.МӨНХ-ЭРДЭНЭ**

Ч.Мөнх-Эрдэнэ 1967 онд төрсөн. 1983 онд Төмөрбулаг сумын 8 жилийн сургуулийг төгсөж, 1987 онд Орхон аймгийн ардийн армийн 208-р ангид цэргийн алба хаах хугацаандаа түрүүч цолтой нууцын бичээчийн үүрэг гүйцэтгэж байгаад УБ хотын ардийн армийн 107-р ангид шилжин салаан орлогч, ахлах түрүүч цолтой, жолооч мэргэжил эзэмшиж 1989 онд хугацаат цэргийн албанаас халагдсан.



Тэрээр хувийн бизнес эрхлэж, 2007 онд Аймгийн засаг даргын жуух бичгээр шагнагдсан. 2010 онд МУЗН-н шилдэг залуу алтан медалиар шагнагдаж, 2007 онд сумын мянгат малчин болсон. Хайрхан дэлгүүрийг ажиллуулах хугацаандаа хамтран ажиллаж байгаа байгууллагуудтайгаа идэвхтэй хамтран ажиллаж 2007 онд Гоёо ХХК-ны өргөмжлөлөөр, мөн 2007 онд Хөвсгөл Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгчийн хүндэт өрөмжлөлөөр, 2008 онд Хөвсгөл аймгийн Хаан банкны Хүндэт харилцагч өргөмжлөлөөр, Хөвсгөл аймгийн татварын хэлтсээс Тэргүүний татвар төлөгч өргөмжлөлөөр, 2011 онд Хөвсгөл хүнс ХХК-ны өргөмжлөлөөр тус тус шагнагдсан.

2008 онд Хөвсгөл аймгийн хэрэглэгчдийн найдвартай түнш цол, өргөмжлөлөөр шагнагдсан.

2004, 2005, 2006, 2007 онуудад сумын шилдэг бизнесмэн. 2009 онд Шилдэг агент, худалдагчаар тус тус шалгарсан.

2012 онд Худалдаа аж үйлдвэрлэлийн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.

**Д.ДАНДАР**

Д.Дандар 1967 онд төрсөн. 1984 онд Төмөрбулаг сумын 8 жилийн сургуулийг төгсөөд 1984-1986 онд Шаамарын ТМС-ийг тракторын жолооч мэргэжлээр төгсөж 1986-1989 онд Эрдэнэт хотын АА-ийн 186-р ангид цэргийн алба хааж 1989-1991 онд “Давшилт” нэгдэлд малчин, 1991-2014 он хүртэл ХАА-н салбарт мал маллаж мал сүргээ жилээс жилд өсгөж 2014 онд мянгат малчны болзол хангасан шилдэг тэргүүний залуу малчин юм. 2004

оноос эхлэн Тэнгэр ХХК-ийн төлөөлөгчөөр ажиллаж байгаа. Д.Дандар 2001 онд АХ-ын 80 жилийн ойн медаль, 2006 онд сумын шилдэг жолооч, 2008 онд Тэнгэр ХХК-ийн тэргүүний ажилтан, 2010 оны сумын шилдэг бизнесмэн, 2014 онд сумын мянгат малчин цол тэмдгээр шагнагдсан байна.

**Д.АЛТАНТӨГС**

Д.Алтантөгс 1968 онд төрсөн. 1986 онд Мөрөн хотын 1-р 10 жилийн сургуулийг төгсөж 1990 онд Дархан хотын УАА-н техникум, 1998 онд УБИС-ийг төгссөн байна. 1990 оноос одоог хүртэл ЕБС-ийн Биеийн тамирын багшаар ажиллаж байна. 1980 оноос спортоор хичээллэж 1981 онд хөнгөн атлетикаар алтан медаль, 1982 онд хөнгөн атлетикаар 2 мөнгөн медаль, 2 хүрэл медаль, 1984 онд хөнгөн атлетикаар 1 мөнгөн медаль, 1 хүрэл медаль, 1986 онд 2 хүрэл медаль, 1988 онд Болгар улсад болсон олон улсын тэмцээнээс мөнгөн медаль, 1990 онд 1 мөнгө, 1 хүрэл медаль, 2003 онд Хөнгөн атлетикийн спортын мастер цолоор шагнагдсан байна. 1998 онд БСШУЯ-ны арга зүйч багш, 2000 онд багшийн алдар, 2002 онд ахлах багш, 2005 онд МЗХ-ны Тэргүүний залуу алтан медаль, 2007 онд Тэргүүлэх багш, 1990 онд Олимпын зүтгэлтэн тэмдэг, 2006 онд хүүхдэд ээлтэй багш, 1995 онд Авьяас мөнгөн медаль, 2007 онд МУ-ын биеийн тамир спортын Тэргүүний ажилтан цол тэмдэг, 2014 онд МУ-ын Волейволын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан байна. Д.Алтантөгс сагсан бөмбөгийн спортын 1-р зэрэгтэй, шүүгчийн 3-р зэрэгтэй тэргүүний багш юм.



**Л.ДАМДИНЖАВ**

Төмөрбулаг сумын 3-р багийн иргэн Луузай овогтой Дамдинжав 1928 онд төрсөн.

Хүндэт жуух бичгээр 2 удаа, Шилжин явах улаан тугаар 2 удаа, 1963 онд АДХГЗахиргааны “Сайшаалын үнэмлэх”, 1964 онд Нэгдлийн ерөнхий хорооны “Баярын бичиг”, 1971 онд АХ-ын 50 жилийн ойн медаль, 1984 онд V-р Таван жилийн гашгайч, 1991 онд



АХ-ын 70 жилийн ойн медаль, 2001 онд АХ-ын 80 жилийн ойн медаль, 2006 онд Их монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүндэт медаль, 2007 онд Хөвсгөлийн бахархал медаль, 2013 онд сумын тэргүүний ахмадаар шалгаран шагнагдаж байсан ба бусад баярын бичиг дурсамжаар олон удаа шагнагдаж байсан байна.



### Ж.ТҮМЭН-ӨЛЗИЙ

1954 онд Төмөрбулаг сумын 3-р багийн нутаг Бүгдгээнд төрсөн. Бага наснаасаа мал маллаж, хурдан морь унаж, уяж өссөн. Ж.Түмэн-Өлзий Ч.Долгорсүрэнгэй ханилан сууж 8 хүүхэд төрүүлж өсгөсөн. Бага залуугаасаа нэгдэл нийгмийн малчин, саальчнаар ажиллахын зэрэгцээ өөрийн угшлын морь уяж сум нэгдлийн олон баяр наадамд түрүү шөвөг авч явсан Аймгийн аварга малчин, уяач хүн юм. Ж.Түмэн-Өлзий нь ажиллаж байх хугацаандаа 1982 онд сумын Нэгдлийн зөвлөлөөс баярын бичиг, 1982 ондоо Аймгийн Нэгдлийн зөвлөлийн баярын бичиг, БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн хүндэт жуух бичиг, 1983 онд Ж.Түмэн-Өлзий ахлагчтай суурийн хамт олонд Сайд нарын зөвлөлийн Хүндэт жуух, 1985 онд Давшилт нэгдлийн зөвлөлөөс Диплом, 1985 онд Хөвсгөл аймгийн Хөдөлмөрийн аварга медаль, Давшилт нэгдлийн ойн медаль, 2009 онд Аймгийн алдарт уяач цол тэмдэг зэргээр шагнуулж хөдөлмөрийнхөө үр шимийг үзсэн байна.

### С.ДОРЖОО

Сангаа овогтой Доржоо нь 1944 онд Бүгдгээнд төрсөн. Тэрээр 1968-1972 он хүртэл нэгдлийн хоньчин, 1973-1977 он хүртэл нэгдлийн адуучин, 1977-1980 он хүртэл хэсгийн ахлагч, 1981-1988 он хүртэл агент, 1989-1990 он хүртэл аж ахуй аймгийн нэгдлийн хорооны бүгд хурлын гишүүнээр ажиллаж байсан.



### Н.ЧУЛУУН

Н.Чулуун 1960 онд төрсөн. 1976-1978 онд 2-р бригад малчин, 1978-1981 онд АА-ийн 036-р анги, 138-р анги танкийн хороонд байлдагч бага түрүүч, 1981-1983 онд “Давшилт” нэгдэлд малчин, 1983-1987 онд “Давшилт” нэгдлийн сүү тосны заводод лаборант, заводын туслах мастер, 1987-1989 онд МАА-н Тээл хэсгийн ахлагч, 1990-1991 онд сүү тосны заводын мастер, 1983-1989 онд бригадын ардын хянан шалгах группын гишүүн, ахлагч, 1991-1995 онд 5-р багийн засаг дарга, 1995-1996 онд эсгийний үйлдвэрийн эрхлэгч, 1996-1998 онд “Давшилт” хоршооны захирал, 2006-2007 онд ЕБС-д



дотуур байрын багш, 2008-2009 онд МАХН-ын улс төрийн ажилтан хийж байсан байна. Ийнхүү ажиллах хугацаандаа 1985 онд улс ардын хянан шалгах хорооны баярын бичиг, 1977 онд МХЗЭ-ийн хорооны хүндэт үнэмлэх 1991, 2001, 2011 онд АХ-ын 70,80,90 жилийн ойн медалиуд, 2008 онд МАХН-ын хүндэт тэмдэг, 2012 онд МАН-ын тэргүүний ажилтан, МАН-ын эх орны төлөө медалиудаар тус тус шагнагдаж байсан.

### Ө.БАЛЖИННЯМ

Ө.Балжинням 1955 онд төрсөн. 1972 онд Хөвсгөл аймгийн Батлан хамгаалах нийгэмлэгийн жолооны курс төгөж жолооч мэргэжил эзэмшсэн байна. 1973-1976 онд Хилийн цэргийн 014-р ангид цэргийн алба хааж ирээд 1976-1990 онд Аймгийн НААҮ-нд жолооч 1990-2014 он хүртэл Төмөрбулаг суманд жолооч, засварчин хийж байна. Нэн хугацаандаа 6,7-р 5 жилийн гавшгайч, 1980,1985 онд байгууллагын аварга жолооч, 1991,2001,2011 онуудад АХ-ын 70,80,90 жилийн ойн медаль, 2014 оны Төмөрбулаг сумын аварга жолооч, засварчинаар шалгарч шагнагдаж байсан байна.



### Т.ДАМДИНСҮРЭН



Т.Дамдинсүрэн 1951 онд төрсөн. 16 наснаас эхлэн мал маллаж эхэлсэн. “Давшилт” нэгдэлд 1965-1990 онд мал маллаж байх хугацаандаа 1980 онд бригадын аварга малчин болж байсан байна. Эхнэр С.Ичинхорлоо 1952 онд төрсөн 1974-1990 он хүртэл “Давшилт” нэгдэлд малчин, суурийн ахлагчаар ажиллах хугацаандаа 6,7-р 5 жилийн гавшгайч, сумын хадлангийн аваргаар шалгарч байсан. Ажиллах хугацаандаа Засгийн газрын жуух бичиг, АХ-ын 70,80 жилийн ойн медалиудаар шагнагдаж байсан байна. Т.Дамдинсүрэн багийн соёлч өрхөөр удаа дараа шалгарч байгаа тэргүүний өрх юм.

**Ж.ХӨРӨНГӨӨ**

Аймгийн алдарт уяач Жамбын Хөрөнгөө нь 1947 онд төрсөн. Тэрээр 1997 онд Төмөрбулаг сумынхаа баяр наадмын их насны уралдаанд 4-р байр

\* 1998 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт анх удаа зохиогдсон шигшмэл хурд “Их хурд-98” хэмээх 21 аймгийн шилмэл морьдын уралдаанд 7-р байр

\* 1999 онд сумынхаа наадамд түрүү

\* 1999 онд Хөвсгөл аймгийн Галт суманд зохиогдсон Монгол улсын заан Хүрэлбаатарын мялаалганы баярт 2-байр /3

аймгийн 10 гаруй сумын уяач, хурдан хүлэг оролцсон/

\* 1999 онд Архангай аймгийн Цахир суманд зохиогдсон Буур Жамъян аваргын мэндэлсний 100 жилийн ойн наадамд 10-р байр /хэд хэдэн аймаг олон сумыг хамруулсан тэр үедээ томоохон наадам байлаа./


\* 2003 онд Шинэ-Идэр суманд зохиогдсон “Идэрийн голын гүүр”-ний нээлтийн баярт 3-р байр

\* 2003 онд Мөрөн 1-р 10 жилийн түүхт 80 жилийн ойн уралдаанд 5-р байр

\* 2003 онд Хөвсгөл аймгийн Их-Уул суманд зохиогдсон “Өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам” барих нээлтийн уралдаанд 5-р байр

\* 2005 онд Төрөлх сумынхаа түүхт 80 жилийн ойн уралдаанд 5-р байрт хурдалж байсан.

\* 2004 онд сумынхаа 79 жилийн хязгаалан насны уралдаанд 4-р байрт хурдалж байсан. 1999 онд Хөвсгөл аймгийн “Оны шилдэг уяач”, 2000 онд “Аймгийн алдарт уяач” цолыг хүртсэн.




**Ж.АМАРАА**

Тэрээр 1959-1963 онд Төмөрбулаг сумын бага сургууль, 1969-1972 онд 3 жилийн хугацаатай цэргийн алба хаасан. Аймгийн аварга адуучин, БНМАУ-ын эмнэг сургалтын спортын мастер, Сумын аварга малчингаар шалгарч, Засгийн газрын хүндэт жуухаар шагнуулсан. 2007-2010 онд мянгат малчны болзол биелүүлж, 2009 онд аймгийн сайн малчин болсон. 2011 онд Адуучин тэмцээнийг сумын Монголын морин спорт уяачдын холбоотой хамтран анх удаа Төмөрбулаг суманд зохион байгуулж байсан.

**Б.ДАШДОНДОГ**

Тус сумын 2-р багийн малчин ИТХ-ын төлөөлөгч, Банзрагчийн Дашдондог 1990-2004 онд Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд болон Нарантолгой компанид малчнаар ажиллаж, 2004-2012 онд багийн Засаг даргаар тошмилогдож байсан. 2000-2008 онд ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж, мөн 2012 оноос ИТХ-ын төлөөлөгчөөр дахин сонгогдон ажиллаж байна. Б.Дашдондог нь улсад 24 ажиллаж байгаа бөгөөд малчнаар 16 жил, төрийн албанд 8 жил, Нутгийн удирдлагын байгууллагад 12 жил, ИТХ-ын төлөөлөгч 3 удаа сонгогдон ажилласан байна. Тэрээр Аймгийн алдарт уяач цолоор шагнагдаж, МУЗН-ийн нигүүлсэл мөнгөн медаль, “Хөвсгөлийн бахархал” медаль, МУЗН-ийн Тэргүүний ажилтан цол тэмдэг, МНУХ-ны хүндэт өргөмжлөл, Аймгийн сайн малчин цол тэмдэг, МНУХ-ны дээд шагнал Соёмбо одонгоор тус, тус шагнагдаж байсан.



**АЙМГИЙН САЙН МАЛЧИН Л.ТЭГШБАЯР**

Лунхай овогтой Тэгшбаяр нь 1962 онд Төмөрбулаг малчин ард Лунхайн ууган хүү болон мэндэлсэн. Бага насаа эцэг эхдээ тусалж өнгөрүүлсэн бөгөөд 1971 онд Төмөрбулаг сумын бага сургуульд элсэн бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн. 1984 оноос мал дээр гарч Аймгийн 4-удаагийн аварга аав Лунхайгаас мал маллах арга ухаанаас суралцаж мал маллаж эхэлсэн. 2007, 2008, 2010, 2012, 2013, 2014 онуудад Мянгат малчны болзол хангасан. Тэрээр 2009 онд Аймгийн алдарт уяач, 2013 онд Аймгийн сайн малчин цол тэмдгээр шагнуулсан.



**Б.ЦАГААЧ**

Банзайн Цагаач нь олон жил мал тууварт хамт явж, мөн “Давшилт” нэгдэлд саалчин малчнаар ажиллаж байсан. Эхийн алдар 1, 2-р зэргийн одонтой. 5, 6-р таван жилийн гавшгайч, АХ-ын 60, 70 жилийн ойн медалиар шагнуулж байсан.





**Б.ЛУВСМАА**

“Давшилт” нэгдэлд саалчин малчнаар ажиллаж байсан. Эхийн алдар 1, 2-р зэргийн одонтой. 5, 6-р таван жилийн гавьшгайч, АХ-ын 60, 70 жилийн ойн медалиар шагнуулж байсан.

**Г.МӨНХБАЯР**

Тэрээр 1948 онд төрсөн. 1967-1969 онд “Давшилт” нэгдлийн буудлын үйлчлэгчээр 1969-1992 онд тус сумын худалдаа бэлтгэлийн ангид хүнс барааны дэлгүүрийн худалдагчаар 23 жил тасралтгүй ажилласан. АХ-ын 60, 70, 80 жилийн ойн медаль, 5, 6, 7, 8 жилийн гавьшгайч, Эхийн алдар 1, 2-р зэргийн одонтой. 1986 онд Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулж байсан.



**Г.СОСОРБАРАМ**

Тэрээр 1952 онд төрсөн. 1970-1989 онд “Давшилт” нэгдэлд төлчин, саальчин, малчнаар ажиллаж байсан. АХ-ын 60, 70 жилийн ойн медаль, 5, 6 жилийн гавьшгайч, Эхийн алдар 1, 2-р зэргийн одонтой.

**Д.СОДНОМБАЛЖИР**

“Давшилт” нэгдэлд саальчин, малчнаар ажиллаж байсан. АХ-ын 60, 70, 80 жилийн ойн медальтай, 5, 6 жилийн гавьшгайч, Эхийн алдар 1, 2-р зэргийн одонтой.



**Л.СОДНОМЦЭРЭН**

Тэрээр 1949 онд төрсөн. “Давшилт” нэгдэлд үхэр, хонь маллаж сахиул, дархан хийж байсан. “Давшилт” нэгдлийн 50 жилийн ойд зориулан 5 түлхүүртэй 12 өргөстэй цоож хийж шилдэг ажилтан болж байсан. Мөн 4 түлхүүртэй 10 өргөстэй цоож хийж байжээ. Эхнэр

Даньдгайн Сосорбарам нь 1952 онд төрсөн. “Давшилт” нэгдэлд саальчин, хоньчноор ажиллаж байсан. АХ-ын 60, 70 жилийн ойн медальтай, 5, 6 жилийн гавьшгайч, Эхийн алдар 1, 2-р зэргийн одонтой.



**Л.ХАНДСҮРЭН**

Тэрээр 1960 оноос “Давшилт” нэгдэлд мал маллаж, 1975 оноос улсын бэлтгэлийн малыг 14 жил тууварлаж, төлөвлөгөөт даалгаварыг давуулан биелүүлж байсан.

**Н.ПҮРЭВСҮРЭН**

Тэрээр “Давшилт” нэгдэлд тракторын жолоочоор ажиллаж байсан. Эвлэлийн төв хорооны залуу гавшгайч, шинийг санаачлагч гэрчилгээ, “Давшилт” нэгдлийн баярын бичгээр шагнуулж байсан байна.



**П.ЦЭЦЭГЭЭ**



П.Цэцэгээ 1946 онд төрсөн. 1978-1997 онд Хөвсгөл аймгийн Биеийн тамирын хороонд биеийн тамирын арга зүйч, заалны зохион байгуулагчаар ажиллаж, МУЗН-ийн 90 жилийн ойн медаль, Биеийн тамир спортын 80 жилийн ойн медаль, гүйлтийн спортын дэд мастер, МУЗН-ийн хүндэт донор цол тэмдгээр тус тус шагнуулж байсан.

**С.АЮУШЖАВ**

Тэрээр 1944 онд төрсөн. 1962 оноос “Давшилт” нэгдэлд саальчин, малчнаар ажиллаж байсан. АХ-ын 60, 70 жилийн ойн медальтай, 5, 6 жилийн гавьшгайч цол тэмдгээр шагнуулсан.



**С.ХАЛТАР**



1974 оноос “Давшилт” нэгдэлд хонь маллаж, 1979-1992 онд мал тууварласан. АХ-ын 60, 70, 80 жилийн ойн медальтай, 5, 6, 7 жилийн гавьшгайч цолтой. Эхнэр Лувсмаагийн Даваахүү 1956 онд төрсөн. “Давшилт” нэгдэлд саальчин, малчнаар ажиллаж байсан. АХ-ын 60, 70, 80 жилийн ойн медальтай 5, 6, 7 жилийн



гавьшгайч цол тэмдэгээр, Эхийн алдар 2-р зэргийн одонгоо шагнуулсан.

**М.ДОРЖ**

Тэрээр 1937 онд төрсөн. 1964-1968 онд “Давшилт” нэгдэлд ЗИЛ-130 машины жолоочоор ажиллаж, авто тээврийн байгууллагад 26 жил ажилласан ахмад тээвэрчин юм. Тэрээр 5, 6-р таван жилийн гавшгайч, осолгүй манлай жолооч цол тэмдэгтэй. Эхнэр Алтангэрэлийн Дугаржав нь 1935 онд төрсөн. “Давшилт” нэгдэлд малчин саальчинаар ажиллаж байсан. Эхийн алдар 1, 2-р одонтой.



**И.ЦАГААЧ**

Тэрээр 1932 онд төрсөн. “Давшилт” нэгдэлд малчин саальчинаар ажиллаж байсан. Эхийн алдар 1, 2-р одонтой. 5, 6-р таван жилийн гавшгайч цол тэмдгээр шагнуулж байжээ.




**Д.ЗОРИГОО**

Д.Зоригоо нь 1976 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төрсөн 37 настай ам бүл-5 эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг. 2009 оноос одоог хүртэл 1000-с дээш толгой мал тоолуулж байгаа манай сумын тэргүүний малчин юм. Тэрээр малыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор жил болгон чонын ав зохион байгуулдаг бөгөөд 2010 онд сумын аварга анчин болсон. Сумандаа 2010 оноос хойш ямааны тоогоор тэргүүлж байгаа. Сумын мянгат малчин, Сумын ямаан сүргээр тэргүүлэгч, Аймгийн ‘Тэргүүний малчин залуу’ алтан медаль, Хөвсгөл Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн оны шилдэг малчин зэрэг шагналуудаар шагнуулж байсан.

**Ж.ДОРЖХАНД**

Тэрээр 1938 онд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд төржээ. 1958 оноос хойш 1993он хүртэл тасралтгүй Давшилт нэгдэлд амл маллаж байсан энэ ахмад буурал 1981 онд сумын депутатаар сонгогдож, Ардын хувьсгалын 1960, 1970, 1980-н жилийн ойн медалиар шагнуулж, 2014 онд Хөвсгөл аймгийн өргөмжит ээжээр шалгарчээ.



**Д.АГВААН**

Тэрээр 1962- 1964 онуудад Төмөрбулаг сумын “Давшилт” нэгдэлд киномеханикч ,1969-1975 онд Бүрэнтогтох сумын “Лениний алдар” нэгдэлд кино механикч хийж хүүхэд багачууд, залуучуудад соёлын үрийг тарих ажилд өөрийн зохих хувь нэмрээ оруулан ажиллаж байсан. 1975-1980 онуудад Бүрэнтогтох сумын Худалдаа бэдтгэлийн ангид нярав, 1980-1983 онуудад Үйлдвэр бригадын дарга, 1983-1995 онуудад Бүрэнтогтох сумын 8-н жилийн дунд сургуулийн аж ахуйн эрхлэгчийн ажлыг хийж байгаад гавьяаныхаа амралтанд гарсан. Ажиллах хугацаандаа баг хамт олныг удирдах арга барилыг бүрэн эзэмшин, отор саалийн нөхөрлөл, залуучуудын гавшгай бригад, өсвөр үе, хүүхэд залуучууд, багш ажилчид хамт олныг мал маллагаа, мал аж ахуйн мэдлэг боловсролыг эзэмших үйлст чармайн идэвх зүтгэл гарган ажиллаж гавшгайч хамт олон бүрдүүлэн удаа дараа сайшаагдан шагнагдаж, сумын депутатаар удаа дараа сонгогдон ахмад халамжлан хүмүүжүүлэгч нэр алдрыг хүртэж байсан.

Ажил хөдөлмөрөө үнэлүүлэн “Аймгийн аварга кино механикч”-аар шалгарч байсан ба V, VI, VII таван жилийн гавшгайч, баярын бичиг, дипломоор, Ардын хувьсгалын 60, 70, 80, жилийн ойн медалиудаар шагнагдаж байсан.

**Ц.ПАГМА (1946-2008)**

1946 онд Төмөрбулаг сумын 2 дугаар багийн нутаг “Хавчуугийн гол”-д малчин ард Цагааны гэр бүлд төржээ. Бага насаа эцэг эхийн гар дээр өнгөрөөгөөд 8 насандаа эрдмийн аянд морджээ. 8 дугаар анги төгсөөд тогоочийн мэргэжил эзэмшин 1962-1964 онуудад Төмөрбулаг сумын “Давшилт” нэгдлийн буудалд, 1964-1996 онуудад Бүрэнтогтох сумын “Дэлгэрмөрөн” нэгдэл, сургууль, эмнэлэг, зочид буудал, ясли, цэцэрлэгийн байгууллагуудад тасралтгүй 32 жил тогоочийн ажил хөдөлмөрийг эрхэлж, улс орондоо хөдөлмөрлөж байжээ. Улсад ажил хөдөлмөрөө үнэлүүлэн V, VI таван жилийн гавшгайч цол тэмдгээр шагнуулж байсан.Зургаан хүүхэд төрүүлж, тэднийгээ төлөв төвшин хүн болгон хүмүүжүүлсэн ачит сайн ээж, халамжит сайн хань, “Алдарт эх” байсан.

**Т.ДОЛЖИНСҮРЭН**

Тавхай овогтой Должинсүрэн нь 1946 онд төрсөн. 1695-1972 онд Бүрэнтогтох суманд бичэг хэрэг. 1972-1990 онуудад Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд МАА-н салбарт ажиллахдаа 6-7 таван жилийн гавшгайч 1980-1985 онд Тэргүүний малчин 1989 онд АХ-ын 70-80жилийн ойн медаль Хүнс хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан 2011онд Ардын тэргүүний авьястан 2012 онд Цээрэнцэг бөөрөнцөгөөр



Улсын 2-р зэрэгтэй. 1972-1980 онуудад Урлагын их наадамд амжилттай оролцож байсан байна. Алдарт эхийн 1-2 одонтой 4-р багийн өндөр настан билээ. 1990-1995 онд Саруул зам ХХК-нд 1995-аас одоог хүртэл МАА салбарт ажиллаж амьдарч байна. Нямсүрэн нь мал аж ахуй эрхэлсэн арвин туршлагаа залуу малчиддаа өвлүүлэн мал маллах арга ухааныг зааж сургадаг нутаг усандаа нэр хүндтэй ажилсаг хөдөлмөрч иргэн юм.

### Д.ЦЭНД-АЮУШ

Даваа овогтой Цэнд-Аюуш 1965 оноос Бүрэнтогтох сумын Тээл бригадад суваа үхэр маллаж байгаад 1969-1972 онд цэргын алба хааж ирээд 1975-1990 онуудад Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд адуу маллах хугацаанд Нэгдэл нийгмийн мал сүргийг өсгөх ажилд өндөр амжилт гаргаж байсан. 1990-1995 онд Төмөрбулаг сумын 4-р багийн Саруул зам ХХК-ны мал маллаж байгаад 1995 оноос одоог хүртэл МАА-н салбарт ажиллаж амьдарч байна.



Д.Цэнд-Аюуш нь мал аж ахуй эрхэлсэн арвин туршлагаа залуу малчиддаа өвлүүлэн мал маллах арга ухааныг зааж сургадаг нутаг усандаа нэр хүндтэй ажилсаг хөдөлмөрч иргэн юм.

### Б.ЖАМЪЯНЖАВ

Бадарч овогтой Жамъянжав нь 1943 төрсөн. Бага наснаасаа өөрийн хурдан морь унахдаа олон түрүү айраг авч хурдан морь уяж сойх арга ухаан сурчээ. 1975-оос 2000 он хүртэл хугацаанд хурдан морь уяж сойхдоо Төмөрбулаг сумандаа болон бусад зэргэлдээ сумдаас цоохор зүсний хурдан азаргаар 5 түрий 7 айраг бага насны адуугаар 2 түрүү 4 шөвөг нийт 7 түрүү 11 айраг авч байжээ.

Б.Жамъянжав нь хурдан морь уяж сойх арвин туршлагаа залуу уяачиддаа өвлүүлэн морь уяж арга ухааныг зааж сургадаг нутаг усандаа нэр хүндтэй ажилсаг хөдөлмөрч иргэн юм.

### Н.ДОРЖ

Нордов овогтой Дорж нь 1953 онд төрсөн 1969-1972 онд цэргын алба хааж ирээд 1973 онд хань 3.Цэвэлмаатай гэр бүл болсон. Тэрээр улс нийгэмд тасралтгүй 36 жил хөдөлмөрлөсөн. Н. Дорж нь залуу наснаасаа эхлэн хөдөө өж ахуйн салбарт адуу, үхэр, хонь, ямаа зэрэг мал маллан ажлын бүтээмж үр дүн өндөртэй б ажиллаж байсан үүнийг нь үнэлэж 1976 онд Алтан унаганы эзэн 500 төгрөгөөр шагнаж байсан. 17 жил нь завсаргүй дараалан мал тууж малын



тарга хүчийг сайн авахуулан мал махыг жил бүр давуулан биелүүлэн тушааж байсан зэргийг нь өндрөөр үнэлэж 1983 онд “Онц тууварчин” цол 600 төгрөг баярын бичиг 1987 онд Социалист уралдааны шахуу төлөвлөгөөт уралдаанд “Ашиг шим ашиглалтын аврага” Жил бүр тууварын мах бэлтгэлийг 100% давуулан биелүүлэн доод тал нь 6,тн оос 13тн хүртэл давуулж байсанаас гадна шинэ залуу илгээлтийн эзэн болж мал аж ахуйн салбарт ажиллахаар гарч байсан залуу тууварчидыг халамжлан хүмүүжүүлэгчээр олон жил хамт мал тууварлан 1988 онд “Шилдэг халамжлан хүмүүжүүлэгч” гэрчилгээгээр шагнагдаж байжээ.

Н.Дорж нь мал аж ахуй эрхэлсэн арвин туршлагаа залуу малчиддаа өвлүүлэн мал маллах арга ухааныг зааж сургадаг нутаг усандаа нэр хүндтэй ажилсаг хөдөлмөрч иргэн юм.



### Д.НЯМСҮРЭН


Д.Нямсүрэн нь 1976 онд Давшилт нэгдэлд элсэж ороод 1976-1990 онуудад саальчнаар ажиллаж байхдаа МАА-н бүтээгдхүүн үйлдвэрлэлийн даалгаварыг 100-120% биелүүлэн 18 үнээнээс 18 тугал бойжуулан сүүний нормыг давуулан МЯНГАТ СААЛЧИН гэрчилгээ олгож 1988 онд социалист уралдаанд шахуу тооцоот үүрэг авч Ашиг шим ашиглалтын аврага цол 600 төгрөгөөр шагнагдаж байсан. 1979, 1984, 1989 онд 6, 7, 8-р таван жилийн гавшгайч, 1980 онд Эвлэлийн төв хорооны хүндэт жуух бичиг, 1984 онд БНМАУ-ын 1-р зэргийн үнэмлэхээр шагнуулж, аймгийн аврага саальчин, Мянгат саальчны болзолыг хоёр удаа биелүүлж байсан.

### Б.ДАШМЯГМАР

Бадарч овогтой Дашмягмар нь 1944 онд төрсөн. 1962 онд Давшилт нэгдэлд гишүүнээр элсэж орж 1963-1976 онуудад нэгдлийн адуу, үхэр, хонин сүргийг маллаж энэ хугацаанд мал онд оролт, төл бойжилт, ашиг шимийн төлөвлөгөөг жил бүр байнга давуулан биелүүлж сайшаалын үнэмлэх, диплом, баярын бичгээр удаа дараа шагнагдаж байсан.

1976-1986 он хүртэл 10 жил тасралтгүй Тээл багт Агент хийсэн. 1986-1990 он хүртэл нэгдлийн 450-550 толгой хонь, ямаа хариулан маллаж малын онд оролт хурга ишгийг хорогдолгүй бойжуулан тухайн үедээ нэгдэл нийгэмдээ ажил хөдөлмөрөө үнэлүүлэн диплом, баярын бичиг, ойн медалуудаар шагнагдаж байв.

Б.Дашмягмар нь мал аж ахуй эрхэлсэн арвин туршлагаа залуу малчиддаа өвлүүлэн мал маллах арга ухааныг зааж сургадаг нутаг усандаа нэр хүндтэй ажилсаг хөдөлмөрч иргэн юм.





### Ч.УЛААНХҮҮ

Чулуун овогтой Улаанхүү нь 1953 онд төрсөн. Тэрээр 1969-1973 онд Бүрэнтогтох сумын Давшилт нэгдэлд саальчин хийж байгаад 1973-1983 онд Төмөрбулаг сумын Давшилт нэгдэлд төлчинөөр ажиллаж 1980 онд Тэргүүний төлчин, Алтан хайрцагны эзэн болж байв. 1984, 1989 онд 7, 8-р таван жилийн гавшгайч, 1989 онд хөдөлмөрийн хүндэт медалиар 2002 онд Хөвсгөлийн бахархал 1-2 Алтарт эхийн одон медалиудаар тус тус шагнагдсан. 1990-1995 онд Саруул зам ХХК-ны мал маллаж байгаад 1995-аас одоог хүртэл МАА-н салбарт ажиллаж амьдарч байна.

### Б.ОЮУН

Б.Оюун 1958 онд төрсөн. 1974 онд 8-р анги төгсөөд 1976-1979 онд цэргийн алба хаасан байна. 1980-1990 он хүртэл худалдаа бэлтгэлийн ангид талхчин, манаач, гуталчин зэрэг ажлуудыг хийж байгаад 1990-2014 он хүртэл ХАА-н салбарт мал маллаж байна. 2014 онд өөрийн хадлангийн талбайгаас 60 тн өвс бэлдэж өндөр амжилт гаргасан. Б.Оюун АХ-ын 70,80,90 жилийн ойн медалиудаар, 1985 онд байгууллагын аварга, 2011 онд аймгийн засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнагдаж 2012, 2013, 2014 онуудад сумын аварга хадланчаар шалгарч байгаа тэргүүний малчин юм.

### Д.НЯМСҮРЭН

Д.Нямсүрэн 1976 онд төрсөн. 1992 онд 8-р анги төгсөөд 1992-1995 онд мал маллаж байгаад 1995 оноос эхлэн хувиараа хөдөлмөр эрхэлж “Сутай” дэлгүүрээр ард иргэддээ хүнсний өргөн хэрэглээний бараа, сэлбэг хэрэгсэл болон бүх төрлийн түүхий эдийг зах зээлийн үнээр худалдан авч борлуулалт хийдэг. 2012 онд “Хур бороо” хоршоог байгуулж, 2010 оноос “Мон италь” ХХК-тай хамтран ажиллаж байна. Мөн 2005 оноос “Гоёо” ХХК-ийн гэрээт борлуулагч хийж байна. 2000-2014 он хүртэл хүн тээвэрт жолооч, 2007 онд мянгат малчин, 2013 онд орон нутгийн тендэр шалгаруулалтанд орж Чандмань хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн хоол хүнсийг мах, сүүгээр тасралтгүй ханган үйлчилж байна. 2011 онд МУ-ын начин М.Эрдэнэбатын цолны мялаалганд 1 сая төгрөг хандивласан байна. Д.Нямсүрэн АХ-ын 80 жилийн ойн медаль, 2007 онд Буман ямааны баяраар Өргөмжлөл, 2008 онд Ардчилсан социалист залуучуудын холбооны “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнагдсан. 2012 оны ИТХ-ын сонгуулиар 3-р багаас сонгогдон хурлын төлөөлөгчөөр ажиллаж байна.

### Б.АМАРЖАРГАЛ

Б.Амаржаргал 1968 онд төрсөн. 1986 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн сургуулийг “Алтан медаль”-тай төгссөн байна. 1995 оноос эхлэн хувиараа хөдөлмөр эрхэлж “Баян зүрх” дэлгүүрээр ард иргэддээ хүнсний өргөн хэрэглээний бараагаар үйлчилж байна. 2010 онд Баянзүрх-Амар ХХК-г байгуулж бүх төрлийн түүхий эдийг зах зээлийн өндөр үнээр худалдан авч борлуулалт хийж иргэд хөдөлмөрчдийнхээ хэрэгцээг байнга ханган ажилладаг тэргүүний бизнесмэн юм. 2011-2014 онд орон нутгийн тендэр шалгаруулалтанд орж Чандмань хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн хоол хүнсийг мах, сүүгээр тасралтгүй ханган үйлчилж байна. Б.Амаржаргал 2008 онд мянгат малчны болзол хангасан. Мөн 2008 онд Хэрэглэгчийг хаанд өргөмжилсөн хамт олон, 2002, 2006 онуудад сумын шилдэг бизнесмэн, АХ-ын 80 жилийн ойн медаль, 2012 онд ардчиллын “Алтан од” медаль, 2008 онд Ардчилсан социалист залуучуудын холбооны “Алтан медаль”-аар шагнагдсан. Сагс, волейволын 1-р зэрэг, тэшүүрийн 1-р зэрэгтэй тамирчин, шилдэг бизнесмэн юм.



### Л.МӨНХБАЯР



Л.Мөнхбаяр 1971 онд төрсөн. 1987 онд Төмөрбулаг сумын 8 жилийн сургууль, 1989 онд Шинэ-Идэр сумын 10 жилийн дунд сургуулийг төгсөж, 1990-1992 онд Улаанбаатар хотод цэргийн алба хааж ирээд 1995 оноос эхлэн хувиараа хөдөлмөр эрхэлж “Инерци” дэлгүүрээр ард иргэддээ хүнсний болон өргөн хэрэглээний бараагаар үйлчилж байна. 2000-2014 он хүртэл хүн тээвэрт жолоочоор ажиллаж байгаа. 2007 онд мянгат малчны болзол хангаж байсан. 2013 онд “Нутгийн үүдэнтэй” ХХК-г байгуулж бүх төрлийн түүхий эдийг зах зээлийн үнээр худалдан авч борлуулалт хийж иргэд хөдөлмөрчдийнхээ хэрэгцээг байнга ханган ажилладаг тэргүүний бизнесмэн юм. Л.Мөнхбаяр АХ-ын 80 жилийн ойн медаль, “Хөвсгөлийн бахархал” медалиудаар шагнагдаж байсан байна.

*ЕСДҮГЭЭР БҮЛЭГ*


# ЭЭЛЭЭ ӨГСӨН ЭХ НУТАГ

*Үүлс хоноглосон уулсын орон  
Үлгэр шивнэсэн  
домгийн өлгий  
Түүх бүтээсэн түмний нутаг  
Төмөрбулаг сум мину...*

*Фотог Баянмөнхийн ЦООЖЧУЛУУНЦЭЦЭГ  
Чулуун-Янжингийн ЦЭДЭВСҮРЭН*



**Дөш хайрхан**



**Баянзүрх хайрхан**



**Арслан хад**



**Агтын гол**



**Бадгийн эх**

456



**Бүгдгээний уул**

457




**Бүгдгээний цагаан бургас**



**Бүрт Дамдины чулуу**



**Бүгдгээний цутгалан**



**Чулуутын гол**



**Могой хад**



**Эрчимийн нуруу**



**Донхорын эх**

460



461



**Нүхэн чулууны агуй**



**Дуут уул**



**Дунд даваа**

462



**Элстэй солгой**

463





**МУ-ын баатар Д.Гунгаагийн гэрийн буйр**



**Хангарьд хад**



**Хаахаан сайр**



**Хавчуугийн ам**



Хавчуугийн даваа



Хэцүүгийн эх



Хавчуугийн гол мод

466



Бүгсийн хүрээ

467



**Хойд чулуут**



**Зуна голын буган чулуу**



**Хулганатай харз**



**469**

**468**



**Их булан цагаан цайр**



**Жаргалантын гол**



**Даваат**

470



**Нарийн өгөөмөр**

471



**Ноён хад**



**Олон голын бэлчир**



**Урд цагаан**

472



**Мээлийн овоо**

473



**Шивэрт Дашдэрчин Хайрхан**



**Ноён хошуу**



**Шар хөндий**

474



**Номт**

475



**Нүхэн чулуу**



**Дунд даваа**



**Тээл баг Жаргалантын гол**

476



**Жаргалантын голын суварга**

477



**Тариат дэрст булан**



**Тэлээ, Мээлийн овоо**



**Торцын рашаан**

478



**Олон голын бэлчир, Үзүүрийн хад**

479





**Тариат зост**



**Цэнхэр Бөгсий**



**Цог өндөр**

480



**Төмрийн булаг**

481



Урд чулуут




Урд цагаан



Урд чулуутын овооны салаа



Зун гол



**Зун голын ам**

Хавсралт мэдээлэл

## Төмөрбулаг сумаас төрж гарсан шашны нэрт зүтгэлтнүүд

### ЖАЛХАНЗ ХУТАГТЫН VI ДҮР ЛУВСАНЦҮЛТЭМЧОЙМБОЛЖАЛЦАН

Эрчимийн нурууны ар, өвөр талд “Жалханз” хутагтын олон дүр тодорч, төрсөн тухай түүхэн баримт байдаг.

...“Жалханз” гэдэг нь угтаа “Ялгуусны байшингийн орой үзүүр” гэсэн төвд үг бөгөөд өндөр орд, харшийн үзүүр оройд сууж номыг болгоон бясалгадаг, тэр чанараараа ном эрдмийн оройд гарсан Төвдийн Галдан хийдийн XXV ширээт Балжиржамцыг тийнхүү “Жалханз” хэмээн нэрийджээ. Хожим тэр их эрдэмтэн ламын хойд дүр болох “Жалханз” хутагтуудыг Монгол газраа залах болсны найм дахь нь Дамдинбазар болой. Монгол газраа тодорсон “Жалханз” хутагтын дүрүүдийг ар таван Хотгойдын нутаг газрыг тал хуваан урссан их уст Дэлгэр мөрний урд хойд биенд эргэж төрсөөр ирсэн гэдэг. Үнэндээ “Жалханз” хутагтын IY-YIII дүрүүд нь Хотгойд нутагт төрж тодорсны YI дүр Лувсанцүлтэмчоймболжалцан нь “Эрчим” хэмээх уулын өмнөд бие “Талбулаг” гэдэг газар эцэг Зоригтхан хэмээхийнд төрсөн гэж “Жалханз гэгээний Монгол оронд дараалан залагдсан дүрүүдийн намтрыг товчлон хурааж зохиосон хэмээх” төвд сударт өгүүлсэн байна.

Жалханз хутагтын VI дүр Лувсанцүлтэмчоймболжалцан гэдэг эрдэмт мэргэн ламын төрсөн нутаг нь тус сумын Талбулагийн Асгат Овгорын энгэрийн бууц бөгөөд нутгийн ахмадууд “Зоригийн бууц” гэж нэрлэсээр ирсэн төдийгүй гэгээн хүний хүйс дарсан ариун чулуу гэж орчин тойронд нь хог, үнс асгахыг цээрлэдэг байжээ. Жалханз хутагт Лувсанцүлтэмчоймболжалцанын номын багш нь Агтын эхний Жамьян цорж ламтан байсан гэдэг.

### АГВААНЫ ЛХАСҮРЭН

Энэ нутгаас тодорч гарсан номч мэргэн ухаантны нэг бол VIII Жалханз хутагт Дамдинбазарын дэргэд шанзавоор олон жил шадарласан Төвд-Монгол бичгийн эрдэм боловсролтой Агвааны Лхасүрэн шанзов болно. Бүгдгээний уугуул, Бүгсийн хүрээний 14 дэх хамба байсан А.Лхасүрэн шанзов нь Жалханз хутагт Дамдинбазарын хүүхэд нас, хутагтаар тодорсон үе, хоёр төрд алба хашиж байсан болон амьдралын сүүлчийн мөч хүртэлх түүхэн замналыг багтаасан “Цагаан лянхуаны баглаа сайн чуулганы хаалгыг нээгч” хэмээх судрыг XIV жарны шороон луу жил (1928)-ийн хаврын эхэн сарын 17- ны өдөр Бүгсийн хүрээний Дашгэндүнжамбаалин хийдэд төвд хэлээр бичиж дуусгажээ.

## Төмөрбулаг сумаас төрсөн төр нийгмийн зүтгэлтэнгүүд

### САНЖААГИЙН БАЯР

1956 онд Улаанбаатар хотод төрсөн. Улаанбаатар хот дахь Зөвлөлтийн 10 жилийн 3 дугаар дунд сургууль, Москвагийн Улсын их сургуулийг хуульч мэргэжлээр төгсгөсөн. Монгол улсын Ерөнхий сайдаар хоёр удаагаа томилогдон ажиллаж байсан.

### ДУГАРЫН ДАРАМЖАВ

Д.Дарамжав нь 20 гаруй жил Ардын цэргийн аж ахуйн арын албанд хариуцлагатай алба хашиж, дэд хурандаа цолтой болсныхоо дараа тухайн үеийн намын даалгавраар Төв аймгийн Батсүмбэрийн САА- н даргаар томилогдон ажиллажээ. Аж ахуйг зөв удирдаж, улс орны эдийн засгийн хөгжилд оруулсан хүчин зүтгэлийг нь төр, засаг үнэлж, БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цол олгож, “Сүхбаатарын одон”, “Алтан соёмбо” медалиар шагнажээ.

### ШАГДАРЫН ХАСБАЗАР (1921-2003)

Агтын голын унаган хүү Ш.Хасбазар нь нийгэм, төрийн зүтгэлтэн хүн байв.

Хөдөө аж ахуйн техникумыг зоо техникч мэргэжлээр төгссөнийхөө дараа Мал аж ахуйн яам, Улсын төлөвлөгөөний комисст ажиллаж байжээ. Тэрбээр зоотехникч мэргэжлээ агрономчоор сольж ОХУ-ын Эрхүү мужийн Хөдөө аж ахуйн дээд сургуулийг дүүргэсэн байна. Орос улсад дээд боловсрол эзэмшсэн Ш.Хасбазар Сэлэнгэ аймгийн Ерөөгийн сангийн аж ахуйд ерөнхий агрономчоор ажиллаж байхдаа ажил үйлсээрээ улс даяар алдаршиж, тэргүүний цолыг олон удаа авч, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, ойн медалиудаар шагнасан байна.

### СОНИНХҮҮГИЙН ДАМБАДАРЖАА

1920 онд Зуна голын эхэнд мэндэлжээ. 19 настайдаа буюу 1939 оноос Монголын төмөр замтай ажил амьдралаа холбож, нарийн төмөр замд машинист, техникч, депогийн ашиглалт хариуцсан орлогч даргаас эхлэн УБТЗ-ын 1 дүгээр орлогч дарга хүртэл хариуцлагатай албан тушаалыг хашиж байв. “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, ойн медалиудаа зүүн өгч, Төмөр зам нь “Монгол-Оросын хүндэт төмөр замчин” цол, тэмдгээрээ шагнажээ.

### ГЭНДЭНГИЙН ТӨРТӨГТОХ

Г.Төртогтох нь 1948 онд төрсөн. Москвад Комсомольскийн дээд сургууль дүүргэн, Нийгмийн ухааны академийн аспирантурт суралцан түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. МХЗЭ-ийн Төв Хороо, “Залуучуудын үнэн” сонины нэгдсэн редакци, МАХН-ын Төв Хороонд сурвалжлагч, тасгийн эрхлэгч, зохион байгуулагчаар, 1991 оноо “Үнэн”

сонины нэгдүгээр орлогч эрхлэгч, Сэтгүүлүүдийн нэгдсэн редакцийн эрхлэгчээр тус тус ажиллаж байжээ. Г.Төртогтох нь 1990 оноос улс төрд хүч чадлаа сорьж, улмаар 1992-1996, 2000-2004 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан

### **ЛУВСАНГЭНДЭНГИЙН ШАГДАРСҮРЭН**

1928 онд төрсөн. Багш мэргэжилтэй. Улс төрийн дээд боловсролтой. Улсын багшийн дээд сургууль, ЗХУ-д Коммунист намын дээд сургууль тус тус дүүргэсэн. МАХН-ын Т өв Хорооны Хянан шалгах хороонд зааварлагч, ахлах зааварлагч, хянан шалгагч зэрэг хариуцлагатай албыг олон жил тун чадварлаг хашиж байсан аж. Энэ бүхний баталгаа нь түүнд төр засгаас өгсөн “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, мөн ойн медалиудаар шагнагдаж байсан.

### **ЧОГСОМЫН БАВУУ**

Тэрээр 1933 онд төрсөн. Сэтгүүлч, багш мэргэжилтэй Аймгийн намын хороо, Намын Төв Хороо, “Үнэн” сонины газар зааварлагч, сурвалжлагч, Улсын ардын хянан шалгах хороонд хэлтсийн дарга, орлогч дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн газар тасгийн дарга, Улсын Бага Хурлын Тамгын газарт хэлтсийн орлогч дарга, УИХ-ын Тамгын газарт хэсгийн ахлагч зэрэг хариуцлагатай алба хашиж байжээ. “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, ойн медалиудаар шагнагдаж байсан.

### **МААМЫН БАДАРЧ**

1942 онд Төмөрбулаг суманд төрсөн М.Бадарч нь 1960 онд ЗХУ-ын Төмөр замын дээд сургууль төгссөн, вагоны инженер мэргэжилтэй хүн юм. УБТЗ-ын техникумд тэнхимийн эрхлэгч, УБТЗ-ийн удирдах газарт суудлын вагон хариуцсан орлогч даргаар ажиллаж байв. М.Бадарч нь төмөр замд 30 шахам жил зүтгэхдээ “Герман- Монголын төмөр замын холбоо”-ны гишүүн, байсан төдийгүй тус салбарын боловсон хүчнийг бэлтгэн сургахад ихээхэн чармайлт гаргаж, хэд хэдэн гарын авлага, схем зураг бичиж, оюутны дипломын ажлын удирдагчаар ажиллаж байв.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас үнэлж “Төмөр замын тэргүүний ажилтан”, “Хөдөлмөрийн хүндэт медаль”, Засгийн газрын жуух бичиг, ойн медалиудаараа шагнаан урамшуулжээ.

### **БАТААГИЙН БАТХҮҮ**

ЗХУ-д Аж Үйлдвэрийн дээд сургууль дүүргэж, инженер-технологич мэргэжил эзэмшсэн. Хөвсгөл аймгийн Ардчилсан Намын Дэд дарга. Хөвсгөл аймгийн Засаг даргаар ажиллаж байсан. Одоо Уул уурхайн яамны Уул уурхайн яамны Бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргаар ажиллаж байна.

### **ГАЛЫН ЖАМСРАН**

Санхүү-эдийн засгийн техникум, МУИС-ийн эдийн засгийн салбарыг дүүргэсэн Г.Жамсран Хөвсгөл аймгийн АДХГЗ-ны санхүүгийн хэлтэст ня-

бо, аймгийн гүйцэтгэх захиргааны 1 дүгээр орлогч дарга, төлөвлөгөөний комиссийн даргаар тасралтгүй 16 жил ажилласан төрийн захиргаа, удирдлага, төлөвлөлтийн туршлагатай ажилтан байсан юм.

### **ДУЛАМЖАВЫН БАТАА**

1926 онд төрсөн. 1943 оноос сумын бичээч- зарлагаар ажлын гараагаа эхэлж, сумын эвлэлийн үүрийн дарга, аймгийн ХЗЭ-ийн хороонд хэлтсийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, аймгийн МАА-н хэлтэс, Гар үйлдвэрийн холбоо, ҮЭ-ийн зөвлөл, намын хороонд хариуцлагатай алба хашиж байв.

Д.Батаа сүүлийн 36 жилд Цагаан нуурын загасны үйлдвэр, Мөрөнгийн Гурил тэжээлийн үйлдвэр, “Говь жуулчин” үйлчилгээний төвийн барилга захиалагчийн товчооны даргын албыг нэр төртэй гүйцэтгэж иржээ. “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт”, “Атарчны алдар” болон ойн медалиудаараа энгэрийг нь мялаажээ. Тэрбээр мөн олон нийтийн 12 байгууллагын тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнуулжээ.

### **ЖАМЬАНЖАВЫН ДАМДИНДОРЖ**

Тэрбээр 1955-1956 онд “Залуучуудын үнэн”, “Үнэн” сонинд сурвалжлагчаар ажиллаж байгаад 1956 оны сүүлчээр сумын орлогч дарга, 1963 оноос аймгийн намын хороонд зааварлагчаар ажиллаж байжээ. Үндсэн ажлынхаа хажуугаар Ж.Дамдиндорж Төмөрбулаг сумын намын үүрийн товчооны гишүүн, Төмөрбулаг, Зүрх, Бүрэнтогтох нэгдсэн сумын нарийн бичгийн дарга, Төмөрбулаг, Жаргалант сумын намын үүрийн дарга зэрэг сонгуульт ажлыг нэр төртэй гүйцэтгэж байв.

### **БАТДЭМБЭРЭЛИЙН ДАМБА**

Б.Дамба багшийн мэргэжилтэй. УБДС 1946 онд сумын бичээч, бага сургуулийн багш, Тариатын бага сургуулийн захирлын алба хашиж байв. 1966 оноос Их-Уул сумын дунд сургуульд хичээлийн эрхлэгч, Аймгийн гэгээрлийн хэлтэст байцаагч, Галт сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч, 1972-1975 онд Төмөрбулаг сумын анхны бүрэн бус дунд сургуулийн захирал хийж байгаад өвчний учир чөлөөлөгдсөн байна. Б.Дамба нь залуу үеийг сурган хүмүүжүүлэх ажилд бие сэтгэл, мэдлэг оюунаа зориулсан жинхэнэ багш хүн байсан бөгөөд түүнийг төр, засгаас “Хөдөлмөрийн хүндэт” болон ойн медалиудаар шагнажээ. Мөн тэрбээр сумын Ардын Их Хурлын депутатаар удаа дараа сонгогдож байсан төр , нийгмийн зүтгэлтэн билээ.

### **ДЭМЧИГИЙН ГАРАМЖАВ**

Тэрээр 1922 онд Агтын голд төрсөн. Төр, нийгмийн зүтгэлтэн, зохиолч. 1939-1940 онд Москва хотноо Монголын элчин сайдын яаманд ажиллаж байсан. Намын Т өв Хорооны нарийн бичгийн дарга С.Янжмаагийн туслах, Булган аймгийн намын хорооны 2 дугаар нарийн бичгийн дарга, Хүнсний үйлдвэрийн яамны орлогч сайд зэрэг хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй алба хашиж байсан.

**ДОНШАВАГИЙН ЦЭРМАА (1922-1960)**

Төмөрбулаг сумын уугуул энэ эмэгтэй аймгийн Эмэгтэйчүүдийн төв зөвлөлийн даргаар ажиллаж, 1952 онд аймгийн анхны депутатаар сонгогдож байв. Тэрбээр Мөрөн хотын намын хорооны, Бүрэн сумын намын үүрийн дарга зэрэг тухайн үеийн хариуцлагатай албыг нэр төртэй гүйцэтгэж байжээ.

**ЧОЙНДОНГИЙН БАДАМСҮРЭН**

Тэрээр 1920 онд төрсөн. Хүний их эмчийн мэргэжилтэй. МАХН-ын үүрийн даргаар 16 жил ажиллаж, МХЗЭ-ийн Төв Хороонд хэлтсийн эрхлэгч, МАХН-ын Төв Хороонд зааварлагч, Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонины эрхлэгч, аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга зэрэг удирдах албан тушаал хашиж байжээ. “Алтан гадас” одонгоор хоёр удаа шагнуулсан ЗХУ-ын шагнал “Москваг хамгаалсны төлөө” медалиар шагнагдаж байжээ.

**ГАЛИНДЭВИЙН ИЧИННОРОВ**

1930 онд төрсөн. Улс төрийн дээд боловсролтой. Төмөрбулаг сумын бага сургуулийн анхны 60 сурагчийн нэг.

Г.Ичинноров сумын эвлэлийн үүрийн даргаар сонгогдон ажлынхаа гарааг эхэлсэн бөгөөд улмаар аймгийн эмнэлгийн ажилчдын Хувьсгалт залуучуудын эвлэлийн хорооны дарга, аймгийн ХЗЭ-ийн хороонд хэлтсийн эрхлэгч зэрэг алба хашиж байхдаа МХЗЭ-ийн 12, 13-р их хуралд төлөөлөгчөөр оролцжээ. Тэрбээр 1957 оноос Улаанбаатар хотын Гадаад худалдааны баазуудын ХЗЭ-ийн хорооны дарга, СнЗ-ийн Эдийн засгийн улсын хорооны даргын туслах зэрэг алба хашиж байсан, 1967 онд Намын дээд сургууль төгсөөд “Ард” кинотеатрын даргаар томилогдон тасралтгүй 25 жил ажиллажээ.

**НАМЖИЛЫН ДИВААГИЛ**

Худалдааны эдийн засагч мэргэжилтэй. Тэрбээр Төмөрбулаг сумын анхны 60 сурагчийн нэг бөгөөд МУИС-ийг худалдааны эдийн засагч мэргэжлээр төгсчээ. Тэрбээр Хөвсгөл аймгийн Төлөвлөгөөний комиссийн орлогч дарга, Улаанбаатар хотын Худалдаа бэлтгэлийн удирдах газарт эдийн засагч, орлогч дарга, аймгийн ХБУГ-т боловсон хүчний тасгийн эрхлэгч зэрэг алба хашиж байжээ. Түүний хөдөлмөр бүтээлийг төр, засаг Ардын хувьсгалын ойн медалиуд, “Худалдааны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнасан байна.

**ГЭНДЭНГИЙН ДАШ**

1926 онд төрсөн. Монгол хэл, уранзохиолын багш мэргэжилтэй. Гэрээр монгол бичиг, тоо, латин, Төвд үсэг заалгаж, анхан шатны боловсролтой болсон тэрбээр Багшийн сургууль, УБДС-ийг тус тус төгсчээ. Г.Даш 1946 оноос Санхүү-эдийн засгийн техникум, Хөвсгөл аймгийн дунд сургууль, Архангайн Багшийн сургуульд багш, хичээлийн эрхлэгч, УБДС -д тасгийн эрхлэт, багш, 1967-1978 он хүртэл Улаанбаатар хотын холбооны газар, Оёдлын үйлдвэрийн нэгдэл, Сүхбаатар дүүргийн намын хороонд үүр,

хорооны дарга, тасгийн эрхлэгч зэрэг алба хашиж байсан ахмад багш, сурган хүмүүжүүлэгч, улс төрийн ажилтан юм.

**ОРШИХЫН ГУНАА**

1930 онд төрсөн тэрбээр Санхүү-эдийн засгийн техникум, Намын дээд сургууль төгссөн нябо- эдийн засагч, улс төрийн дээд боловсрол эзэмшжээ. Төмөрбулаг сумын бага сургуулийн анхны сурагч О.Гун-Аа сургуульдаа багшилснаар ажил амьдралын анхныхаа гарааг эхэлсэн билээ.

Дараа нь О. Гун -Аа аймаг, хотын ерөнхий боловсролын сургуульд багш, лектор, улс төрийн ажилтан, МХЗЭ-ийн хорооны дарга, Налайх хотын АХШХ-ны дарга, Улсын ардын хянан шалгах хороонд нууцын дарга, УБХТН-ийн Т өв Зөвлөл, УИХГ-тгасгийн дарга зэрэг хариуцлагатай алба хашиж байв.

***Төмөрбулаг сумаас  
төрсөн эрдэмтэд*****ЛУВСАНГИЙН САНЖАА (1921-19)**

МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институтэд шилжин ирж олон жил багшлах хугацаандаа ЗХУ-д түүхийн ухааны Дэд эрдэмтний зэрэг хамгаалж, улмаар МАХН-ын түүхийг иж бүрнээр нь бүтээн туурвихад дорвитой хувь нэмрээ оруулжээ.

**ЛУВСАНГИЙН ХҮРЭЛБААТАР**

Эм зүйч мэргэжилтэй. ОХУ-д эм зүйн академи төгссөн. Эм зүйн ухааны доктор профессор.

“Шилдэг зохион бүтээгч”, “Шилдэг үйлдвэрлэгч” зэрэг цол, хүндэтгэлийг авчирсан байна.

**БАТААГИЙН ДОЛГОРСҮРЭН**

Барилгын зураг төслийн инженер мэргэжилтэй. ЗХУ-д Барилгын архитектурын дээд сургууль төгссөн. Б.Долгорсүрэн Улсын барилгын зургийн институтын ерөнхий инженер, Барилга, уул техникийн байцаан шалгах газрын дарга зэрэг хариуцлагатай алба хашиж, олон барилга, байгууламжийн зураг төсөл зохиолцсон салбарынхаа нэр хүндтэй инженер байсан юм. Тэрбээр АИХ-ын депутатаар сонгогдож байжээ.

**САНДУЙН ПҮРЭВЖАВ (1923-1991)**

Бүгдгээний Тал булагт төрсөн. Түүхийн багш мэргэжилтэй. Доктор, профессор. С.Пүрэв МУИС-ийг түүхийн багшийн мэргэжлээр төгссөн улмаар сургуульдаа багшаар үлдэж ажилласан түүхийн ухааны томоохон эрдэмтэн хүн юм. Тэрбээр ЗХУ-д Түүхийн ухааны Дэд эрдэмтний, 1984 онд “ХI\/-XX зууны үеийн Монгол дахь шарын шашин, хүрээ хийдийн үеийн түүх” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг тус, тус хамгаалжээ. С.Пүрэвийн бичсэн түүхийн 10 гаруй нэгсэдэвт бүтээл, олон

арван сурах бичиг, Хотгойд, шашин судлалын бүтээлүүд нь өнөөдөр эрдэмтэн, судлаачид, багш, оюутны үнэ цэнэтэй гарын авлага, судалгааны хэрэглэгдхүүн болж байна.

### **БООВОНГИЙН ЧОЙДОГ**

Төрөлх сумаасаа төрсөн анхны хүний эмч. Б.Чойдог Төмөрбулаг сумын бага сургуулийн анхны 60 сурагчийн нэг бөгөөд дунд сургууль, МУИС-ийн Анагаах ухааны салбарыг 1955 онд төгсч, Шинэ-Идэр сумын хүний их эмчийн салбарын анхны эрхлэгчээр томилогдон ажиллаж байжээ. Тэрээр Анагаах ухааны Дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

### **ДЭМБЭЭГИЙН АГВААНДОРЖ**

Анагаах ухааны дээд сургуулийг хүүхдийн эмчийн мэргэжлээр 1965 онд дүүргэсэн Д.Агваандорж Хөвсгөл аймагт 10 гаруй жил ажилласан юм. Нийслэлд шилжин ирж АУДС-даа багш лан, улмаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд өөрийн цаг зав, хүч хөдөлмөрийг зориулж хүүхэд, нялхасын эрүүл мэндийн чиглэлээр анагаах ухааны докторын зэрэг хамгаалжээ. Өнөөдөр Д.Агваандорж зохиогчтой олон арван ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл, зөвлөмж анагаах ухааны чиглэлийн судлаач, шинжээч, багш, оюутны төдийгүй жирийн хүмүүсийн үнэтэй гарын авлага болон хэрэглэгдэж байна.

### **ХҮДЭРИЙН ГЭНДАРАМ**

1934 онд төрсөн. Мал зүйч мэргэжилтэй. Хөдөө аж ахуйн дээд сургууль төгссөн Х.Гэндарам 1960 оноос ХААИС-д багш, декан, тэнхимийн эрхлэгчээр олон жил тасралтгүй ажилласан, профессор цолтой, Монгол улсын гавьяат багш юм. Бэлчээрийн ургамлын тэжээллэг чанарыг анх удаа иж бүрнээр нь судалсан нэртэй эрдэмтэн юм.

### **МАНДШИРЫН ДОЛЖИН**

1964 онд төрсөн. Философич, философийн багш мэргэжилтэй. Профессор. Энэ сумын уугуул иргэн, цөөхөн эмэгтэй эрдэмтдийн нэг билээ. ОХУ-ын Москва хотноо ШУА-ийн философийн хүрээлэнгийн аспирантурт суралцаж, “Иргэншилт бол философийн антропологийн асуудал мөн” сэдвээр докторын зэрэг хамгаалж, улмар нэг сэдэвт зохиол болон сурах бичиг, гарын авлага, зөвлөмжийг бие даан болон бусадтай хамтран бичиж хэвлүүлжээ. Мөн эрдэм шинжилгээний хэд хэдэн өгүүлэл нийтлүүлснээс зарим нь орос, англи хэл дээр хэвлэгдэн гарсан байна.

### **БАДАРЧИЙН БААСАНХҮҮ**

1967 онд төрсөн. Б.Баасанхүү 1996 онд “Бүтээгдхүүний үйлдвэрлэлийн оновчтой хэмжээ ба төрөлжилт” сэдвээр эдийн засгийн ухааны магистр, 2001 онд “Бизнесийн байгууллагын стратеги төлөвлөлтийн үндсэн асуудлууд” сэдвээр эдийн засгийн ухааны докторын зэрэг хамгаалжээ. Доктор Б.Баасанхүү 10 гаруй сурах бичиг зохиоход оролцож, эрдэм шинжилгээний 30 гаруй өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.

### **ШАРАВЫН ТҮМЭНДЭМБЭРЭЛ**

1955 онд төрсөн.Хэвлэлийн мэргэжилтэй. Ш.Түмэндэмбэрэл ЗХУ-д Хэвлэлийн дээд сургуулийг төгссөний дараа Улсын хэвлэлийн комбинат, Цэргийн ерөнхий сургууль, Батлан хамгаалах их сургуулийн хэвлэх үйлдвэрт даргаар ажиллаж байна. Тэрбээр Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байлаа.

### **ОРШИХЫН ЦЭДЭВ**

1932 онд төрсөн. Ня-бо мэргэжилтэй. О.Цэдэв барилгын үйлдвэрлэлийн салбар, МБТ-ын Төв зөвлөл зэрэг салбарт ня-бо, тасгийн эрхлэгчийн алба хашиж байв. Тэрбээр Үндэсний бөхийн шүүгч, тайлбарлагчаар 30 гаруй жил ажилласан спортод элэгтэй нэгэн.

Төмөрбулаг сумаас төрсөн бизнесменүүд

## **ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАХИРГААНЫ ДАРГА, ОРЛОГЧ ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, НАМЫН ҮҮРИЙН ДАРГА НАР СУМЫН ЗАСАГ ДАРГА НАР**

- \* Донжоогийн Товуу Хошууны захирагч 1925 он
- \* Дамдингийн Мээрэн Уранхайрхан сумын дарга 1925 -1926
- \* Батын Ядамсүрэн Уранхайрхан сумын дарга 1930
- \* Хангинаагийн Ядамжав

### **Төмөрбулаг сумын дарга**

- \* Жамбалын Пүрэвжав
- \* Готовын Дамдинсүрэн
- \* Жанцангийн Рагчаа

### **тодорхой бус**

- \* Олзвойн Дамба
- \* н.Дамдинсүрэн
- \* Жанцангийн Рагчаа
- \* Номпэйн Лосол
- \* н.Наваан
- \* н.Чойжилсүрэн
- \* н. Далхаа
- \* Номпэйн Лосол
- \* Түмэнгийн Юлжээ
- \* Дамдины Лувсандорж
- \* Жамсрангийн Цэрэндорж
- \* Намдаг, О.Нямаа
- \* Пүрэвцэрэнгийн Дашмягмар
- \* н.Бадрах
- \* Магсарын Давааням
- \* Р.Хүрэлбаатар
- \* н.Чулуун
- \* Цогийн Дорж
- \* Р.Нанжийсүрэн
- \* Ч.Лхамсүрэн
- \* С.Чимэддорж
- \* Түмэнбаярын Батбаяр
- \* Бямбажавын Шарбанди
- \* Наваанжамьянгийн Мижиддорж
- \* Чимэддоржийн Сандагдорж
- \* Лосолын Цэрэнсодном
- \* Бямбажавын Шарбанди
- \* Энхтуяа

- \* Бат-Очирын Ганзориг

### **Нарийн бичгийн дарга нар**

- \* Жигмэдийн Санжмятав

### **Хошууны түшмэл**

- \* Дамдинсүрэнгийн Лүндэгжамц
- \* Дамдины Пэрэнлэй
- \* Пүрэвжалын Шагдар
- \* Дагвын Санжёндон
- \* Номпэйн Лосол
- \* Жамсран 8-Дамдинсүрэн
- \* н.Дашзэвэг
- \* н.Минжүүр
- \* Цолмонгийн Батмөнх
- \* Лувсангийн Баадай
- \* Чойжилсүрэнгийн Доржпалам
- \* Навааны Гэлэгпил
- \* Дандгайсүрэнгийн Дуйнхаржав
- \* н.Зэстбалжир
- \* Жүгдэрнамжилын Цэвэгдорж
- \* Балжиннямын Далхсүрэн
- \* Жамьянжавын Дамдиндорж
- \* Бахимбор
- \* н.Арьяажав
- \* Ч.Доржпалам
- \* Дарийн Цагаач
- \* Г.Халтар
- \* Дашдаваагийн Цагаач
- \* Шугарын Лхагваа
- \* Гэндэнгийн Дашбямба
- \* Цэдэнсамбуугийн Батбаяр
- \* Цэдэнсамбуугийн Батбаяр ИТХТ-ийн дарга
- \* Самбуугийн Данаажав
- \* Доржийн Түмэндэмбэрэл
- \* Цэцэгмаагийн Бямбадорж

## **СУМЫН ОРЛОГЧ ДАРГА НАР**

Албан ёсоор орлогч даргын орон тоог 1951 оноос бий болгосон боловч 1943-1950 оны үед сумын зарим баримт бичигт П.Дагва, Ц.Батмөнх нар орлогч дарга гэж гарын үсэг зурсан байсан аж. Мөн 1959 оны 2 дугаар сараас 1961 он дуустал орлогч дарга сонгоогүй байна.

- |                        |            |
|------------------------|------------|
| 1. Цолмонгийн Батмөнх  | 1951 -1952 |
| 2. Хишигтийн Шагдаржав | 1952-1953  |
| 3. Гунаа-жав           | 1953-1954  |
| 4. Ч.Даваа             | 1956       |



- 5. Сэдэд 1957-1958
- 6. Лувсандоржийн Дорж 1958- 1959
- 7. Шаравын Цэдэн-Иш 1962
- 8. Жүгдэрнамжилын Цэвэгдорж 1963-1982
- 9. Чойжоогийн Лхагвасүрэн 1982
- 10. Баадайн Балдандорж 1991 онд 6 сар болсон

- \* Г.Нямцэцэг
- \* Шагдарын Хүрэлбаатар
- \* Чулууны Жаргалсайхан
- \* С.Халбаатар
- \* Ж.Энэбиш
- \* Түмэнжаргалын Энхтуяа

### Сумын намын үүрийн дарга нар

- \* Рэнжавын Даваа
  - \* Жамцын Дадьхүү
  - \* Цумбайн Даньдгайсүрэн
  - \* Лувсангийн Түмэн
  - \* Л.Очирбат
  - \* Ц.Даньдгайсүрэн
  - \* Лхамсүрэнгийн Гүнчин-Иш 8-Долгорсүрэн
  - \* Далхаа
  - \* Балганы Сэнгээ
  - \* Гэндээрээгийн Дамба
  - \* Ядамжавын Сосорбарам
  - \* Пүрэвийн Дагва
  - \* Чойжилсүрэнгийн Лхамсүрэн
  - \* Баянжаргал
  - \* Я.Сосорбарам
  - \* Дашбалын Жамба
  - \* Гомбын Жалцав
  - \* Лувсандоржийн Дорж
  - \* Цүлтэм
  - \* Дагважамц
  - \* Жамьянжавын Дамдиндорж
  - \* З.Доржготов
  - \* Р.Очирхүү
  - \* Н.Чимэд
  - \* Б.Чугнай
  - \* С.Аюуш
  - \* Ойдов
- 1992 оноос орон тооны бус намын үүрийн даргатай болжээ.

### Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Улс төрийн хэлмэгдэгсэд

№	Овог	Нэр	Хэлмэгдсэн он сар өдөр	Цагаатгагдсан он сар өдөр
1	Амгалан	Авирмэд	1938-05-06	1992-04-03
2	Гончиг	Алтангэрэл	1938-05-27	1991-09-19
3	Пүрэвжал	Алтангэрэл	1938-03-25	1992-04-04
4	Норжин	Аюуш	1938-05-27	1993-08-06
5	Өлзий	Баатар	1938-05-27	1993-08-06
6	Гомбожав	Бавуу	1938-06-24	1993-05-13
7	Ванчинжав	Бадамсэд	1938-05-27	1993-08-06
8	Лүндэнцэрэн	Байхүү	1938-09-19	1993-05-19
9	Жамбал	Балган	1938-01-28	1993-04-09
10	Даш	Балдан	1938-01-28	1993-04-09
11	Хаймчиг	Балдан	1938-01-28	1993-04-09
12	Яринпил	Балжир	1938-01-28	1995-04-09
13	Пунцаг	Балин	1938-05-06	1992-04-03
14	Доной	Барамсай	1938-01-28	1993-04-09
15	Жамсран	Барамсай	1938-06-24	1993-05-13
16	Донгоо	Батаж	1938-03-04	1993-03-04
17	Дамба	Батмөнх	1938-05-27	1993-08-06
18	Нямаа	Батсүх	1938-05-06	1992-04-03
19	Жигмэд	Галай	1937-11-16	1991-11-12
20	Луузан	Галиндэв	1938-03-04	1993-03-04
21	Дандан	Галт	1938-03-04	1993-03-04
22	Балган	Гомбо	1939-07-01	1991-03-25
23	Вангайнямаа	Гомбо	1938-03-04	1993-03-04
24	Жигмэд	Гомбо	1938-03-04	1993-03-04
25	Цагаан	Гомбожав	1939-07-01	1991-03-25
26	Жамц	Гомбороо	1939-09-19	1993-05-19
27	Магнай	Гомбосүрэн	1938-05-27	1993-08-06
28	Бунь	Гомпил	1938-05-27	1993-08-06
29	Жигмэд	Гончиг	1938-05-27	1990-08-04
30	Шовоо	Гончигжав	1938-03-04	1993-03-04
31	Шахай	Гэцог	1938-05-06	1992-04-03
32	Гомбожав	Даваа	1938-09-19	1993-05-19
33	Пунцаг	Дагва	1938-07-23	1993-05-26
34	Очир	Дагва	1938-09-19	1993-04-24
35	Лүндэг	Дагдан	1938-05-27	1991-09-19

## ТҮҮХ БҮТЭЭСЭН 90 ЖИЛ

36	Жамц	Дадаахүү	1938-05-27	1993-08-06
37	Гонгор	Дамба	1938-03-04	1993-03-04
38	Насан	Дамба	1938-01-28	1993-04-09
39	Балжаа	Дамдин	1938-05-06	1992-04-03
40	Ядам	Дамдин	1938-06-24	1993-05-13
41	Жамсран	Дамдинжав	1938-09-19	1993-05-19
42	Жамьян	Дамдинжав	1938-05-27	1993-08-06
43	Төгс	Дамдинжав	1938-07-23	1993-05-31
44	Мөнх	Дамцог	1938-05-27	1993-08-06
45	Эрэнчин	Дангаа	1938-05-27	1993-07-05
46	Жамсран	Данзан	1938-05-27	1993-08-06
47	Мижгээ	Данзан	1938-03-04	1993-03-04
48	Мөнх	Дансүрэн	1938-03-04	1993-03-04
49	Шагдар	Дашдоной	1938-05-27	1993-08-06
50	Сүрэн	Дашлхүндэн	1938-03-04	1993-03-04
51	Гэрэл	Дугарсүрэн	1938-09-19	1993-05-19
52	Дамдинжав	Дэлгэр-Очир	1938-05-27	1993-08-06
53	Жигжид	Ёндон	1938-03-04	1993-03-04
54	Буудай	Ёндонгомпил	1938-05-27	1993-08-06
55	Бүргэд	Жав	1938-03-04	1993-03-04
56	Ишжав	Жамба	1938-07-01	1992-10-29
57	Олзод	Жамган	1939-07-01	1991-03-25
58	Долгор	Жамсран	1938-05-27	1993-08-06
59	Жамьян	Жамсран	1938-05-27	1990-08-04
60	Пүрэв	Жамц	1938-05-27	1993-08-06
61	Жамсран	Жамьянжав	1938-05-27	1993-08-06
62	Эрэнчин	Жамьянжав	1938-05-27	1993-08-06
63	Хаймчиг	Жанжаа	1938-03-04	1993-03-04
64	Гомбо	Жанцан	1938-05-27	1990-08-04
65	Ажбуу	Жигжид	1938-05-27	1993-07-05
66	Бонбойдой	Жигжид	1938-03-04	1993-03-04
67	Сандаг	Жигжид	1937-11-16	1991-11-12
68	Жалцав	Загд	1938-05-27	1993-08-06
69	Зэгвэ	Загд	1938-05-27	1990-08-04
70	Нампил	Загд	1937-11-16	1991-11-12
71	Бизьяа	Зундуй	1938-05-06	1992-04-03
72	Дондог	Зууннасан	1938-05-27	1993-08-06
73	Осор	Ишжамц	1938-05-27	1993-08-06
74	Сүрэн	Ишсэнгээ	1938-05-27	1993-08-06
75	Баяр	Лодон	1938-01-28	1993-04-09

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨМӨРБУЛАГ СУМ

76	Хаймчиг	Ломбо	1938-05-27	1993-08-06
77	Дамбийн	Лосол	1938-01-28	1993-04-09
78	Бат	Лувсан	1938-05-27	1991-09-19
79	Гэндэнжамц	Лувсан	1938-05-27	1991-09-19
80	Сугар	Лувсан	1938-09-19	1993-05-19
81	Үзээ	Лувсан	1938-05-06	1992-04-03
82	Жигмид	Лувсангончиг	1938-01-28	1993-04-09
83	Зундуй	Лувсангэндэн	1938-05-27	1990-08-04
84	Бадмаа	Лувсандаваа	1938-05-06	1992-04-03
85	Найдан	Лувсандорж	1938-09-19	1993-05-19
86	Ням	Лувсанжамц	1938-05-27	1993-08-06
87	Мягмар	Лувсанжамц	1938-05-27	1990-08-04
88	Бямбажав	Лүндэв	1938-07-01	1992-10-29
89	Мягмар	Лүндэн	1938-06-24	1993-05-19
90	Билэгт	Лхагважав	1938-06-03	1993-04-19
91	Банзрагч	Лхамсүрэн	1938-05-27	1993-08-06
92	Намсрай	Лхамсүрэн	1938-06-24	1993-05-19
93	Жамьян	Лхүмбэ	1938-07-01	1992-10-29
94	Тамчин	Мажаа	1938-05-27	1990-08-04
95	Пүрэв	Мигдаваа	1939-07-01	1991-03-25
96	Шөнө	Наваанжамба	1938-05-27	1990-08-04
97	Мөнх	Наваацэрэн	1942-01-30	1959-08-27
98	Гэрэл	Найдан	1938-09-19	1993-04-24
99	Цэрэнпил	Найнчүлтэм	1938-03-04	1993-03-04
100	Содов	Намжил	1938-05-27	1993-08-06
101	Сойв	Намжил	1938-05-27	1993-08-06
102	Бань	Намсрай	1938-05-27	1993-08-06
103	Дамчай	Намсрай	1938-06-10	1941-02-01
104	Цэрэн	Намсрай	1938-05-27	1993-08-06
105	Дүгэр	Нанжиджав	1938-04-27	1993-08-06
106	Лхамжав	Норов	1939-07-01	1991-03-25
107	Гомбожав	Палай	1938-09-26	1993-08-03
108	Дамба	Пунцаг	1938-05-27	1993-08-06
109	Мөнх	Пунцаг	1938-05-27	1993-08-06
110	Данзан	Пэрэнлэйжамц	1938-03-04	1993-03-04
111	Баяр	Раднаа	1938-05-27	1993-08-06
112	Шадай	Сад	1938-05-27	1993-08-06
113	Өлзийбаяр	Сайнбуян	1938-03-04	1993-03-04
114	Равдан	Самбуу	1938-06-24	1993-05-19
115	Эрэнчин	Самбуу	1938-05-27	1993-08-06

116	Бужин	Самдан	1938-09-19	1993-05-19
117	Мэнд	Самдан	1937-11-16	1991-11-12
118	Сандаг	Самдан	1938-05-27	1993-08-06
119	Түмэннасан	Самдан	1938-03-04	1993-03-04
120	Цамба	Сампил	1937-11-16	1991-11-12
121	Өлзий	Санж	1938-05-27	1993-08-06
122	Пунцаг	Санж	1938-03-04	1993-03-04
123	Цэнджав	Санжаапэрэнлэй	1938-05-27	1993-08-06
124	Цогт	Содов	1938-01-28	1993-04-09
125	Цэрэнлхам	Содов	1938-05-27	1990-08-04
126	Гомбосүрэн	Соном	1938-05-06	1992-04-03
127	Равдан	Соном	1938-05-27	1990-08-04
128	Бор	Сосор	1938-01-28	1993-04-09
129	Даш	Түвдэн	1938-05-06	1992-04-03
130	Банди	Уваа	1938-05-27	1990-08-04
131	Наваан	Халзан	1938-09-26	1993-07-05
132	Бутач	Хас	1937-07-01	1991-03-25
133	Лүндэг	Цоомоо	1938-05-06	1992-04-03
134	Гэндэн	Цэдэнсодном	1938-05-27	1993-08-06
135	Дандагай	Чагдар	1938-03-04	1993-03-04
136	Наваан	Чадарбал	1938-06-10	1993-05-31
137	Дэндэв	Чадраабал	1938-09-19	1993-04-24
138	Лхамсүрэн	Чойжин	1938-05-27	1993-08-06
139	Равдан	Чүлтэм	1938-03-04	1993-03-04
140	Хайдав	Чүлтэм	1938-05-06	1992-04-03
141	Тогтох	Шагдар	1937-12-17	1992-06-20
142	Очир	Шарав	1938-05-09	1992-04-03
143	Гүр	Шордой	1938-07-23	1993-05-31
144	Лүндэнсүрэн	Ядамсүрэн	1938-05-27	1993-08-06
145	Гомбосүрэн	Яйчил	1938-05-27	1993-08-04

## Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын алдартнууд

### Ардын хувьсгалын партизан

- \* Цэгмидийн Жамьян
- \* Дугарын Даваажав

### Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн

- \* Жанцангийн Рагчаа
- \* Дугарын Гунгаа
- \* Шагдарын Гаваа
- \* Гэндэнгийн Дамдин

### Монгол улсын баатар

- \* Лхүнрэвийн Даваадорж
- \* Дугарын Гунгаа

### Монгол улсын Хөдөлмөрийн баатар

- \* Дугарын Дарамжав
- \* Паньджунайн Цагаач

### Монгол улсын Ардын жүжигчин

- \* Чинзаяагийн Мөнхшүр
- \* Монгол улсын гавьяат цолтон
- \* Дугарын Гунгаа - нисгэгч
- \* Чинзаяагийн Мөнхшүр - дуучин
- \* Найдангийн Цагаач - номын санч
- \* Бадарчийн Ёндонжамц - инженер

### Төрийн одон медальтнууд

#### А. Сүхбаатарын одонт

- \* Дугарын Гунгаа
- \* Дугарын Дарамжав
- \* Лхүнрэвийн Даваадорж
- \* Паньджунайн Цагаач

#### Б. Байлдааны гавьяаны улаан тугийн одонт

- \* Билэгтийн Галсан
- \* Цэгмидийн Жамьян
- \* Шагдарын Гаваа
- \* Батын Ганжууржав
- \* Дугарын Даваажав
- \* Очирын Дуйнхаржав
- \* Даньдгайсүрэнгийн Цагаанбаатар
- \* Дамбын Намсрай Э.Ч.Даяндорж
- \* Бямбажав

#### В. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт

- \* Дугарын Гарамжав
- \* Шагдарын Хасбазар
- \* Сонинхүүгийн Дамбадаржаа
- \* Чогсомын Бавуу
- \* Чогсомын Дамдинжав

- \* Навааны Лувсанцэрэн
- \* Лувсангэндэнгийн Шагдарсүрэн
- \* Дуламжавын Батаа
- \* А.Хишигдорж
- \* Түмэнгийн Дэмчигдорж
- \* Доржийн Түмэндэмбэрэл
- \* Жүгдэрнамжилын Үржгэр
- Алтан гадас одон***
- \* Донийн Банзрагч
- \* Монхорын Ишзана
- \* Өлзийбаярын Сономжамц
- \* Дамбын Намсрай
- \* Дугарын Гун-Аа - 2 удаа
- \* Дугарын Дарамжав - 2 удаа
- \* Паньджунайн Цагаач
- \* Сонинхүүгийн Дамбадаржаа
- \* Чогсомын Бавуу
- \* Галын Жамсран
- \* Лувсангийн Санжаа
- \* Сундуйн Пүрэвжав
- \* Дэмбээн Агваандорж
- \* Дуламжавын Батаа
- \* Паньджунайн Лунхай
- \* Бадарчийн Ёндонжамц
- \* Дамдиндоржийн Эрдэнэбат
- \* Цэдэнгийн Цэрэнсүрэн
- \* Жүгдэрийн Цэрэнсүрэн
- \* Дамчаан Дарамжав
- \* Даньдгайсүрэнгийн Цагаанбаатар
- \* Шаравын Сандаг
- \* Гомбожавын Балдан
- \* Манкын Баадай
- \* Дамдины Дашхүү
- \* Дэжидийн Дэнсээхүү
- \* Дэлэгийн Жүгдэрхүү
- \* Ерөөлтийн Цэвэгмид
- \* Чинзаяагийн Мөнхшүр
- \* Бадарчийн Түмэндэмбэрэл
- \* Ишзанын Хорчин
- \* Гэндэнгийн Даш
- \* Ичинхорлоогийн Ганболд
- \* Доржийн Түмэндэмбэрэл
- \* Яндагийн Надмид
- \* Даньдгайн Бүжлхам
- \* Чойжилсүрэнгийн Лхамсүрэн
- \* Жүгдэрнамжилын Үржгэр

- \* Лувсанцэрэнгийн Бат-Өлзий
- \* Түмэнгийн Дэмчигдорж
- \* Шагдарын Хасбазар
- \* Жасрангийн Гэлэгжамц
- \* Жанцангийн Рагчаа
- \* Дэмчигийн Гарамжав
- \* Дансранжавын Мишингээ
- \* Дамбасүрэнгийн Нарантуяа
- \* Оршихын Гун-Аа
- \* Рагчаагийн Гэндэнсүрэн
- \* Ө.Зундуй
- \* Лувсангийн Хүрэлбаатар
- \* Чойндонгийн Бадамсүрэн - 2 удаа
- \* Түмэнгийн Дэмчигдорж
- \* Бадарчийн Чулуундаваа
- \* Мандширын Должин
- \* Доржпаламын Батчулуун
- \* Маналжавын Магсаржалам
- \* Чимэдбазарын Цэрмаа
- \* Чойжоон Цэцэгмаа
- \* Ренчинжүгдэрийн Цагаанхүү
- \* Дамдины Шаравдорж
- \* Баасансүх
- \* Бямбажав
- \* Самдангийн Цогзол
- \* Ганжууржавын Цэнд-Аюуш
- \* Дамдинсүрэнгийн Түмэнжаргал
- \* Бат-Очирын Алтанхуяг
- \* Шагдарын Гэрэлсайхан
- Д. Байлдааны гавьяаны одонт***
- \* Дамбын Намсрай
- \* Дугарын Гунгаа
- \* Очирын Дуйнхаржав
- \* Гомбожавын Балдан
- \* Даньдгайсүрэнгийн Цагаанбаатар
- \* Загдсамбарын Батбаатар
- \* Б.Цэдэндорж
- \* Б.Данаа
- Доржпагмын Батчулуун
- Мандширын Должин
- Е. Хөдөлмөрийн хүндэт медальтан***
- \* Гомбын Замбал
- \* Чойжилсүрэнгийн Доржпалам
- \* Чойжилсүрэнгийн Лхамсүрэн
- \* Дөшийн Банзрагч
- \* Ерөөлтийн Жүгдэр

- \* Паньджунайн Лянхуа - 2 удаа-
- \* Дугарын Дарамжав
- \* Шагдарын Хасбазар
- \* Чогсомын Бавуу
- \* Далхаан Далай
- \* Галын Жамсран
- \* Сандуйн Пүрэвжав
- \* Дуламжавын Батаа
- \* Бадмаан Батмөнх
- \* Загдын Ланжуу
- \* Дандгайсүрэнгийн Дуйнхаржав - 2 удаа
- \* Шаравын Сандаг
- \* Манкын Баадай
- \* Ерөөлтийн Цэвэгмэд - 2 удаа
- \* Бадарчийн Түмэндэмбэрэл
- \* Гэндэнгийн Даш
- \* С.Долгорсүрэн
- \* Готовын Нансалдулам
- \* Гончигийн Мөнхбаяр
- \* Чимэдбазарын Цэрмаа
- \* Пүрэвийн Жамц
- \* Бүргэдээгийн Диваарагчаа
- \* Цэдэнсодномын Мишигдорж
- \* Пүрэвжавын Чулуунбаатар
- \* Жүгдэрнамжилын Үржгэр
- \* Дарьдуламын Цагаач
- \* Чойндонгийн Бадамсүрэн
- \* Нөмпэйн Лосол
- \* Чадраабалын Мандшир
- \* Доржпаламын Цагаач
- \* Жамъяаншаравын Жаргалсайхан
- \* Пүрэвдорж Оюунчимэг
- \* Бат-Очирын Эрдэнэ
- \* Жамцын Батбаяр
- \* Чогсомын Бадраа

### ***АИХ-ын депутатаар сонгогдогсод***

- \* Дугарын Дарамжав
- \* Дугарын Гунгаа
- \* Шагдарын Хасбазар - 4 удаа
- \* Түмэнгийн Дэмчигдорж - 3 удаа
- \* Батаан Долгорсүрэн
- \* Дөшийн Банзрагч
- \* Бадмаан Батмөнх
- \* Паньджунайн Лунхай
- \* Чойжилсүрэнгийн Лхамсүрэн

### ***УИХ-ын гишүүнээр сонгогдогсод***

- \* Гэндэнгийн Төртогтох

### ***Цэргийн том цолтон***

- \* Д.Гунгаа - хошууч генерал
- \* Д.Намсрай - хурандаа
- \* О.Дуйнхаржав - хурандаа
- \* Б.Цэрэндорж-хурандаа
- \* Б. Дан-аа - хурандаа
- \* Д. Цагаанбаатар - хурандаа

### **Ашигласан ном зохиол**

1. С.ЧУЛУУН ХОТГОЙД СУДЛАЛ
2. Ж.Үржгэр “ Бүтээлч үйл-баатарлаг үйлстэн хэзээ ч мартагдахгүй
3. С.Нямжав Хөвсгөлчүүдийн лавлах
4. М.Нямаа “Хөвсгөл аймгийн лавлах товчоо”
5. О.Цолоо “Хотгойд буриад судлалын асуудал
6. Банзрагч Хөвсгөл аймгийн товч түүх
7. Ж.Сэржээ, А.Очир Хөвсгөл, Завхан аймгийн овгийн товч
8. Хөвсгөл аймгийн байгаль орчны төлөв эмхтгэл
9. Хөвсгөл аймгийн ХАА-н нэгдлийн түүхэн замнал
10. Ч.Жаргалсайхан “Миний нутгийн бахархал Төмөрбулаг түүхэн цомгоос...”
11. С.Пүрэвжав “Хотогойд судлалын зарим асуудал
11. Ч.Банзрагч Хөвсгөл аймгийн түүх